

Итгэлийн Суурь

Пастор Дру Фриймэн

Хад болох Есүс Христ дээр Суурь тавих нь
Лук 6:48

байгууллагын бүтээл



VILLAGE
MINISTRIES
INTERNATIONAL

VillageMinistries.org

© 2001 by
Village Ministries International, Inc. (VMI)

VMI authorizes any individual to copy and distribute these materials and use them for the purpose of teaching others about Christ and the Word of God; however, no one may alter, amend or make any changes to the text (regardless of how minor such changes may be). No one may charge any individual or groups of individuals for the use of these materials, it being understood that VMI has a policy of grace and does not charge for the use of its materials.

Any copying, retransmission, distribution, printing, or other use of Foundations must set forth the following credit line, in full, at the conclusion of the portion of Foundations that is used:

Copyright © 2001 Village Ministries International, Inc. Reprinted with permission.
Foundations is a publication of Village Ministries International, Inc.
VillageMinistries.org

All Scripture quotations from the *New American Standard Bible®*, Copyright © 1960, 1962, 1963, 1968, 1971, 1972, 1973, 1975, 1977, 1994 by:

The Lockman Foundation
A Corporation Not for Profit
La Habra, CA

© 2001, Village Ministries International, Inc

Энэ материалыг ямар ч хүн бусдад Бурханы Үг ба Христийн тухай заах зорилгоор олшруулах, тараах, ашиглах эрхтэй. Гэхдээ эх текстэд ямар нэгэн нэмж хасах өөрчлөхийг хориглоно. Энэхүү материалыг ашигласны төлөө хэн ч төлбөр нэхэх ёсгүй. Village Ministries International байгууллага энэ номыг үнэгүй тараах бодлого баримтална.

Итгэлийн суурь номыг ямар нэгэн хэлбэрээр дахин хэвлэх, олшруулах, тараах тохиолдолд уг номоос ашигласан хэсгийн төгсгөлд дараах байдлаар тавьсан байх ёстой:

Хэвлэлийн эрх © 2001 Village Ministries International, Inc. Зөвшөөрлөөр дахин хэвлэв.
Итгэлийн суурь ном бол Village Ministries International, Inc-ийн бүтээл.
VillageMinistries.org

Монгол орчуулгын Библийн бүх ишлэлүүдийг Ариун Библиэс авсан. Эрх нь *Ариун Бичээс Библийн Нийгэмлэг* © 2004.

ГАРЧИГ

Талархал	8
Өмнөх үг	8
Нэгдүгээр бүлэг: Гараа	9
1-р хэсэг	Хувийн бэлтгэл	10
2-р хэсэг	Библи	13
3-р хэсэг	Түүхийн тойм	15
4-р хэсэг	Түүхэн он дарааллын тойм	19
5-р хэсэг	Библи судлах бэлтгэл	23
Хоёрдугаар бүлэг: Хуучин гэрээний тойм	27
	Танилцуулга	28
1-р хэсэг	Хууль: Эхний таван ном	29
	Эхлэл	29
	Египетээс гарсан нь	31
	Левит	33
	Тооллого	34
	Дэд хууль	35
2-р хэсэг	Түүхэн номууд	38
	Иошуа	38
	Шүүгчид	39
	Рут	41
	Нэгдүгээр Самуел	42
	Хоёрдугаар Самуел.....	44
	Хаадын дээд	45
	Хаадын дэд	47
	Шастирын дээд	49
	Шастирын дэд	51
	Езра	53
	Нехемия	55
	Естер	56
3-р хэсэг	Яруу найргийн номууд	58
	Еврей яруу найраг	59
	Иов	60
	Дуулал	63
	Сургаалт үгс	68
	Номлогчийн үгс	70
	Соломоны дуун	72
4-р хэсэг	Их эш үзүүлэгчид	74
	Исаиа	76
	Иеремия	79
	Гашуудал	81
	Езекиел	82
	Даниел	84
5-р хэсэг	Бага эш үзүүлэгчид	86
	Хосеа	87
	Иоел	89
	Амос	90
	Обадиа	91

	Иона	92
	Мика	93
	Нахум	95
	Хабаккук	96
	Зефания	97
	Хаггай	98
	Зехария	100
	Малахи	101
Гуравдугаар бүлэг: Шинэ гэрээний тойм	103	
	Танилцуулга	104
1-р хэсэг	Түүхийн номууд	109
	Матай	110
	Марк	113
	Лук	115
	Иохан	118
	Үйлс.....	121
2-р хэсэг	Паулын захидлууд	124
	Ром	127
	1 Коринт	130
	2 Коринт	132
	Галат	134
	Ефес	135
	Филиппой	137
	Колоссай	138
	1 Тесалоник	138
	2 Тесалоник	139
	1 Тимот	140
	2 Тимот	142
	Тит	143
	Филемон	144
3-р хэсэг	Ерөнхий захидлууд	146
	Еврей	146
	Иаков	149
	1 Петр	150
	2 Петр	152
	1 Иохан	154
	2 Иохан	155
	3 Иохан	156
	Иуда	157
4-р хэсэг	Эш үзүүлэгийн ном	159
	Илчлэлт	159
Дөрөвдүгээр бүлэг: Тайллын үндсэн зарчмууд	163	
	Танилцуулга	164
1-р хэсэг	Нэгдүгээр дүрэм: Бодит үнэнийг эрж хайх	165
	Зарчим 1: Бурханы төгс мөн чанарыг судлах	165
	Зарчим 2: Христийн илчлэгдсэн арга замыг эрж хайх	166
2-р хэсэг	Хоёрдугаар дүрэм: Бодит үнэнийг ойлгохыг хичээх	169
	Зарчим 3: Илчлэлт алгуур өрнөлттэй явагддаг үйл явц гэдгийг ойлгох..	169
	Зарчим 4: Шууд утгаар нь тайлж ойлгох	170
	Зарчим 5: Онцгой шинжүүдийг авч үзэх	171

	Зарчим 6: Гол багцлалуудыг судлах	172
	Зарчим 7: Хүний хүслийг таньж мэдэх	173
	Зарчим 8: Гэрээнүүдийг санах	174
3-р хэсэг	Гуравдугаар дүрэм: Судрыг Судартай нь харьцуулахыг хичээх	178
	Зарчим 9: Ялгаатай зүйлсийг олж харах	178
	Зарчим 10: Хам сэдвийг нь авч үзэх	180
	Зарчим 11: Харьцуулан тайлбарлах	181
	Зарчим 12: Зохиццолдолгоог эрэлхийлэх	183
	Зарчим 13: Диспенсацийг анхаарч үзэх	184
	Зарчим 14: Эш үзүүлэгт болгоомжтой хандах	186
4-р хэсэг	Дөрөвдүгээр дүрэм: Христэч амьдралаар амьдрахыг хичээх	189
	Зарчим 15: Зөв хэрэгжүүлэлт	189
Тавдугаар бүлэг:	Бурханы бодгалийн талаарх үзэл баримтлал	195
1-р хэсэг	Гурвал	196
2-р хэсэг	Бурханы нэрс	201
3-р хэсэг	Бурхан Эцэг	204
4-р хэсэг	Хүү Бурхан	211
5-р хэсэг	Бурхан Ариун Сүнс	223
Зургаадугаар бүлэг:	Бурханы бүтээлийн тухай онол	233
1-р хэсэг	Бүтээл	234
2-р хэсэг	Тэнгэр элчүүд	235
3-р хэсэг	Хүн	242
4-р хэсэг	Тэнгэр элч нарын зөрчилдөөн	254
Долдугаар бүлэг:	Бурханы төловлөгөөний тухай онол	255
1-р хэсэг	Илчлэлт: Библи	256
2-р хэсэг	Асуудал: Нүгэл	257
3-р хэсэг	Шийдэл: Аврал	260
4-р бүлэг	Аюулгүй байдал: Бурханы амлалтууд	264
5-р бүлэг	Ирээдүй: Эш үзүүллэг	267
Наймдугаар:	Бурханы зорилгын тухай онол	271
1-р хэсэг	Итгэгч хүний хувийн амьдрал	272
2-р хэсэг	Христитгэгчдийн нэгдмэл амьдрал	283
Есдүгээр бүлэг:	Хэрэгжүүлэлт	289
	Танилцуулга	290
1-р хэсэг	Номтой танилцах нь	291
2-р хэсэг	Номыг тоймлох нь	293
3-р хэсэг	Судалгаагаа улам бүх гүнзгийрүүлэх нь	295
4-р хэсэг	Хоорондох уялдааг нь гаргаж ирэх нь	297
5-р хэсэг	Шууд бус хам сэдэвт задлан шинжилгээ хийх	300
6-р хэсэг	Судалгаагаа өргөжүүлэх нь	303
7-р хэсэг	Гол санааг гаргах нь	306
Эрхлэн гаргагчдын зүгээс	307	
Хариулт	308	
Номзүй	325	
Зүүвэр	326	

Талархал

Итгэлийн суурь сурах бичгийг Виллэж Министрис Интэрнешнл байгууллагын захиалгаар бичсэн болно. ВМИ байгууллага анх байгуулагдсан цагаасаа эхлэн энэ дэлхийн алслагдсан өнцөг буланд, тосгод хот айлуудад Есүс Христийн сайн мэдээг хүргэх зорилго тавьсан билээ. Гол төлөв илгээлтийн эздийн үйл ажиллагаа тодорхой хугацаанд үргэлжлээд буцах ёстай болдог. Харин манай байгууллагын зорилго бол энэхүү гадаадын илгээлтийн эздийн оролцоо өндөрлөсний дараа ч, тухайн нутгийн бэлэг авьяастай хүмүүсийг гарган ирж, тэднийг Библийн зөв сургаалыг дамжуулахад нь сурган бэлтгэхэд оршдог. Ийм замаар бид манай Эзэн Аврагчаас бидэнд тушаасан Агуу захирамжийг биелүүлэн “дагалдагч бэлтгэх” болно.

2, 3-р бүлгүүдийг Ж. Хэмптон Кэйтлийн зөвшөөрснөөр “*The Concise Old and New Testament Survey*” номоос авлаа. Эрхэм Кэйтлийн уг номтой бүхлээр нь www.bible.org вэбсайтаас танилцаж болно.

Виллэж Министрис Интэрнешнл байгууллага эрхэм Кэйтлид уг номоо ашиглуулсанд талархаж байна. Энэ ном бол Библи судлахад зориулсан маш сайн ном билээ. Библийн холбогдолтой огноон дээр зарим нэг засвар хийсэн нь Итгэлийн суурь номын өмнөх хэвлэлтэй тааруулсан талтай.

Виллэж Министрис Интэрнешнл байгууллага Библийн сургалтууд нэн шаардлагатай боловч тэр бүр хүртээмжтэй биш газар нутагт энэхүү сургалтуудаа хүргэх зорилготой бөгөөд энэ үйлчлэлээр дамжуулан өсөн нэмэгдэж буй нутгийн пастор удирдагч багш нарт Библийн зөв сургалт, сургаалыг үр өгөөжтэйгөөр хүргэх боломжтой болж байгаа юм.

Энэ сурах бичгийг гаргахад туслалцаа үзүүлсэн олон хүмүүст бид талархлаа илэрхийлж байна. Юуны түрүүнд, бидний Эзэн Есүс Христэд талархал нь байг. Тэр бол өршөөлөөрөө бидэнд агуу авралаа хайлрлаж, бидний амьрал ба бурханлаг байдалд хэрэгтэй болноор хангагч юм (2 Петр 1:3). Үүний дараа бид энэ бүтээлийг гаргахад оролцсон, цаг зав, авьяас чадвар, хөрөнгө мөнгөөр харамгүй тусалсан олон хүнд талархлаа илэрхийлэе. Тэд бол хөшигний ар тал дахь баатрууд билээ.

Өмнөх үг

“Виллэж Министрис Интэрнешнл”-ийн *Сурга хөтөлбөрийн* энэ хэсэг Итгэлийн суурь гэж нэрлэгддэг бөгөөд Бурханы Угийг судалж эхэлж буй шинэхэн оюутныг “*Эзэн ба Аврагч Есүс Христийн нигүүлсэл ба мэдлэг дотор осох*”-өд (2 Петр 3:18) нь тусlamж болгон бичигдсэн юм. Тиймийн тул энэ номын туршид Бурханы Угийг хэр гүн гүнзгий чухал болохыг онцлоод зогсоогүй, бүр ч Угийг суралцаж буй хүнд сүнсний амьдралдаа хөгжин дэвжихийн чухлыг онцолж тус болох зорилгыг тавьсан байгаа.

Итгэлийн суурь ном бол суралцагч хүн өөрөө мэдээд зогсохгүй мөн бусдад заахад чадвартай болгохоор бичигдсэн гэж ойлгож болно. Агуу Захирамжийг (Матай 28:18-20) биелүүлж, “дагалдагч бэлдэхэд” тань энэ ном үнэлж баршгүй тус болно.

Бурханы Угээс суралцаж буй оюутанд мэдвэл зохих үндсэн мэдээллүүдийг багтаасан агаад 1-р бүлэг, “Гараа”-нд хувийн сүнслэг бэлтгэл хэрхэн хангах талаар, Бурханы Угийн талаар ерөнхий зураглал өгнө.

2, 3-р бүлгүүдэд Библийн ном тус бүрийг ерөнхийд нь танилцаж, зохиогч нь болон агуулгыг нь үзнэ. 4-р бүлэгт Судрыг хэрхэн ойлгож тайлах талаар үндсэн зарчмуудыг гаргаж танилцуулна.

5, 8-р бүлгүүдэд теологийн үндсэн ойлголтуудтай танилцаж, Библийн нэр томъёо, ухагдахууны талаар мэдээлэл өгнө. 9-р бүлэгт Библийн хичээл бэлтгэх замаар сурсан зүйлээ амьдралд яаж хэрэгжүүлэх вэ гэсэн тухай үзнэ.

Итгэлийн суурь сурах бичгийг судалснаар та Эзэн Есүс Христтэй улам бүр дотно нөхөрлөж, Түүний Угэнд бичигдсэн тэрхүү итгэлээр амьдрах сүнслэг амьдал чинь ивээгдэх болтугай хэмээн залбирч байна.

Бурханы Угийг баходан судлах аянд таныг урья.

Нэгдүгээр Бүлэг

Гараа

1-р ХЭСЭГ

Хувийн Бэлтгэл

A. Библи судлалд өөрийгөө бэлтгэх зургаан зарчим

1. Есүс Христэд итгэ

Судрыг судлахад тухайн судлагчийн хувийн бэлтгэл маш чухал бөгөөд үүнийг хэрхэвч дутуу үнэлж болохгүй. Юуны түрүүнд тэрээр Есүс Христийг өөрийн Аврагч хэмээн итгэх ёстай. Учир нь “төрөлх хүн” (1 Коринт 2:14) (Христэд итгэдэггүй хүн) Бурханы зүйлсийг хүлээн авч, ойлгож чаддаггүй. Тэгэхээр, аврал нь зөвхөн Христэд итгэх итгэлээр л ирдэг аж (Ефес 2:8-9). Угийг судалж буй хүнд сүнслэг зүйлсийг ялгаж салгах чадварыг Бурханы Сүнс л өгдөг.

2. Библи Бурханы онгodoор бичигдсэн \амьсгалснаар байгаа\ гэдгийг хүлээн зөвшөөр

Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа гэдгийг Бурханы Уг өөрөө баталдаг (2 Тимот 3:16-17). Угийн аливаа судлалыг эхлэхээс өмнө энэхүү бодит үнэнийг хүлээн зөвшөөрсөн байх хэрэгтэй. Энд итгэлийн ямар ч “үсрэлт” хэрэггүй, харин Библи үнэн зөв бөгөөд алдаа мадагтүй гэдгийг хүлээн зөвшөөрөхөд л хангалттай юм.

3. Залбир

Судрыг ойлгоход залбирал зайлшгүй хэрэгтэй. Хэрэв хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал Бурханаас гуй, тэгвэл Тэр өгөх болно гэж Бурханы Үгэнд хэлсэн байдаг (Иаков 1:5). Зөв мэдлэг, аливааг ялгаж салгах мэргэн ухааныг чин сэтгэлээсээ гүйн залбирах аваас энэ бүхэн танд өгөгднө. Учир нь эдгээр нь Бурханы хүслийн дагуух зүйлс гэдэг нь тодорхой юм (1 Иохан 5:14-ыг Матай 7:7-8-тай харьцуул).

4. Тэвчээртэйгээр хичээнгүйлэн суралц

Бурханы Үгэн дотор ойлгоход төвөгтэй ишилэл олон байдаг учраас судалгааны явцад танаас нэлээдгүй тэвчээр, хичээнгүй байдал шаардагдана (2 Тимот 2:15). Хязгаарлагдмал оюун ухаантай хүмүүн бид Бурханы хязгааргүй оюун ухааныг ойлгохсон хэмээн бэдрэн явахдаа өчүүхэн төдий ойлголтыг олж авахад хүртэл нэлээд цаг хугацаа шаардлагатай болдог гэдгийг ойлгох учиртай.

5. Гэм нүглээ байнга улайж бай

Бидний амьдралыг цэвэрлэх боломжийг Бурханд олгохын тулд гэм нүглээ байнга улайж байх нь чухал. Тэгснээр Бурхантай нөхөрлөх бидний нөхөрлөл илүү агуу байх болно (1 Иохан 1:6-10). Өөрийнхөө гэм нүглийг байнга улайж хэрэгтэй гэдгийг ухаарснаар бид Бурханы хүслээс гадуурх аливаа бодол санаа, уг хэл, үйлдэлд мэдрэмжтэй байж чаддаг.

6. Бурханы хүслийн дагуу амьдрах хүсэлтэй бай

“Хэрэв хэн нэгэн нь Түүний [Бурханы] хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаалыг ... мэднэ” (Иохан 7:17) гэж Эзэн Есүс Христ хэлсэн. Хэрэв та амьд Бурхантай харилцаагаа хөгжүүлэхийг зорьж байгаа бол таны олж авсан аливаа мэдлэг тэрхүү харилцааг тэтгэн дэмжиж, улам тодорхой болгох ёстай. Хайр үгүй мэдлэг нь хүнийг ихэрхэг болгодог (1 Коринт 8:1). Хэрэв та амьд Бурхантай харилцаатай байхыг бус, харин зүгээр л мэдлэгтэй болохыг зорьж байгаа бол таны олж авсан мэдлэг хангалтгүй байх болно.

B. Бурханы Уг болох Библийг хувьчлан судалснаар бидэнд өгөгдөх таван үр өгөөж

1. Агуу итгэл

Чуулганы хамгийн агуу теологич, элч Паул “үзэгдээж байгаагаар бус, харин итгэлээр алхсан” (2 Коринт 5:7) хэмээн өөрийнхөө тухай өгүүлсэн байдаг. Бид бүгдээрээ нигүүлслээр итгэлээрээ аврагдсан (Ефес 2:8-9); Паулын хэлсэнчлэн, бид авралыг хүлээн авсан даруйдаа Түүн дотор алхах хэрэгтэй байдаг (Колоссай 2:6-7).

2. Шинэ мэдлэг

“Бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор өсөх” (2 Петр 3:14-18) явцдаа бид Бурханы Үгээс шинэ мэдлэгийг олж авдаг байх хэрэгтэй. Энэ мэдлэгийг олж авснаар бид Бурханы нигүүлслийг илүү үнэлж цэгнэдэг болдог. Тийнхүү бид мэдлэгээр өсөхийн сацуу Судраар дамжуулан Бурханы Үгийг “сонсож” итгэлээрээ өсөж (Ром 10:17), бүх зүйлд Түүнд найддаг.

3. Ариусгагдсан амьдрал

Бурханы Үг нь бидний амьдралыг ариусгахад зайлшгүй хэрэгтэй. Учир нь Түүний Үг бол Үнэн билээ (Иохан 17:17). Хэдийгээр бид итгэгч ч гэсэн бидний амьдралд гэм нүгэлтэй холбоотой асуудлууд байсаар байдаг (1 Иохан 1:6-10). Тиймээс бид өөрсдөдөө байгаа гэм нүглийг илрүүлэхийн тулд Бурханы Үгээс суралцах ёстой юм. Тэгснээр бид ариусгал хийгээд эдгэрлийн төлөө ухамсартайгаар залбирах боломжтой болно (Дуулал 51). Христитгэгчид Бурханы Үгэнд өөрсдийнхөө үзэл бодлыг нэмж, түүнийгээ зөвт байдлын үндэс суурь болгох явдал байнга гарч байсан гэдгийг бүү мартаарай. Энэ үзэгдлийг “легализм” (үгч. хуульчлах үзэл) гэж нэрлэдэг бөгөөд өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдөө зөвт байдлын жишигийг тогтоосон хууль дүрмүүдийг гаргаж мөрдөж байсан гэсэн үг юм. Энэ асуудлыг Эзэн Есүс Христ маш тодорхой буруутгасан байдаг (Марк 7:1-13). Тиймээс бид Бурханы тогтоосон жишигт анхаарлаа хандуулахад анхаарах учиртай.

4. Үйлчлэлийн хүч

“Христийн оюун ухаан”-ыг (1 Коринт 2:14-16) судалж байхад Ариун Сүнс бидний амьдралд ажиллаж, бидний үйлчлэл хүчтэй байдаг (Ефес 2:10). Бид Сатан болон түүний хүчинчүүдтэй эсрэг тэмцэл дунд байдаг учраас бидэнд өөрсдийн маань хүч чадал, чадвараас илүү агуу хүч хэрэгтэй байдаг (Ефес 6:10-18). Бурханы хүсэлд дуулгавартай байснаар бидэнд энэ хүч ирдэг. Учир нь **“Өөрийн сайн тааллын дагуух зүйлсийг үйлдүүлж, хүсүүлэхийн тулд”** (Филиппой 2:13) бидний дотор ажиллаж буй нь Бурхан юм.

5. Үйлчлэлийн бэлтгэл

Хэрэв бидэнд Бурханы Үгийн мэдлэг байвал Эзэн Есүсийн нэрээр бид үнэнийг амьдралдаа хэрэгжүүлж (Колоссай 3:16-17), төөрсөн хүмүүст болон мөхөж буй энэ ертөнцөд тунхаглаж чадна (Иохан 17:17-19; Еврей 5:12). Бурханы Үгийг дамжуулах эн тэргүүний зорилт бол **“арийн хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэж, Христийн биеийг байгуулах”** (Ефес 4:11-13) явдал юм. Бусдыг “бэлтгэхийн” тулд бид эхлээд өөрсдөө бэлтгэгдсэн байх ёстой.

Хувийн Судлал: 1-р бүлэг, 1-р хэсэг

- 1. 1 Коринт 2:14-д “төрөлх” (PSUCHNIKOS) хэмээн орчуулагдсан грек үг 1 Коринт 15:44, 46; Иаков 3:15; Иуда 1:19-д (“зөн, энэ дэлхийн оюун ухаан” гэсэн утгаар орчуулагдсан) бас гардаг. Эдгээр багцлалыг уншаад, “төрөлх” гэдэг үгийг тайлбарла.**
- 2 Тимот 3:16-17 ишлэлийг унш. Бурханы Үгээс ямар дөрвөн төрлийн үр өгөөжийг олж авах вэ?**
- 3. Мэргэн ухаанаар дутаж байгаа хүмүүст Иаков 1:5 ямар амлалт өгсөн бэ?**
- 4. 2 Тимот 2:15-ыг унш. Бурханы Үгийг судалж байгаагийн хувьд бид юунд хичээнгүй байх ёстой вэ? Бид юуг зорилгоо болгох ёстой вэ?**
- 5. 1 Иохан 1:6-10 ишлэлийг унш. Гэм нүглээ улайсны маань төлөө бидэнд ямар хоёр амлалт өгөгдсөн байна вэ?**
- 6. Иохан 7:17-д Бурханы хүслийг тодорхойлох нөхцөлийн талаар өгүүлжээ. Энэ ямар нөхцөл вэ?**

7. **Колоссай 2:6-7, Ефес 2:8-9 ишлэлийг унш. Бидний христэч амьдралыг тодорхойлох хоёр зүйл юу вэ?**
8. **2 Петр 3:14-18 ишлэлийг унш. 14-р ишлэлд ямар христэч зорилгын тухай өгүүлсэн бэ? 18-р ишлэлд биднийг ямар хоёр зүйлд өсөх ёстой гэсэн бэ?**
9. **1 Иохан 1:6-10 ишлэлийг дахин хар. Итгэгчид гэм нүглээсээ ариусгагдахын тулд ямар хоёр зүйлийг хийх шаардлагатай вэ?**
10. **Ефес 6:10-18 ишлэлийг унш. Бидний жинхэнэ дайсан хэн бэ, түүнтэй хэрхэн тэмцэх вэ?**
11. **Ефес 4:11-13 ишлэлийг унш. “Христийн биеийг байгуулах” нь ямар гурван зорилготой вэ?**

2-р хэсэг

Библи

A. Библи гэж юу вэ?

1. Бурханы бичигдсэн уг

Библи бол жирийн нэг ном биш юм. Библийг 1500 гаруй жилийн турш дөч гаруй хүн бичжээ. Есүс Христ түүнийг “хуйлмал ном” (Еврей 10:7) гэж нэрлэсэн байдаг. Энэ номгүйгээр хүмүүс зөвт байдлын үнэмлэхгүй жишиг гэж юу болохыг ч, өөрсдийнх нь амьдралд нигүүлсэл хэрэгтэй гэдгийг ч ойлгож чадахгүй. Бурхан Өөрийнхөө жишигийг тодорхой байлгахын тулд Өөрийн үгийг бичиж үлдээхээр шийджээ. Энэхүү бичигдсэн Үг нь итгэлээр хүлээн авагдаж, түүхээр (болж өнгөрсөн үйл явдлууд) нотлогдсон юм. Хүмүүс залбирлаар дамжуулан Бурхантай ярьдаг бол Бурхан бичигдсэн Үгээрээ дамжуулан хүмүүстэй ярьдаг.

Ихэнх хүмүүс Судрыг анх бичсэн хэлнээс нь орчуулсан Библийг хэрэглэдэг. Хуучин гэрээний дийлэнх хэсэг еврей хэлээр бичигдсэн байдаг. Харин Даниел номын 2-7 бүлэг, Езра номын 4-7 бүлэг еврей хэлтэй төстэй арамей хэлээр бичигдээ. Эдгээр ном бичигдэж байх үед иудейчүүдийн ихэнх нь арамей хэлээр ярьдаг байсан аж. Шинэ гэрээ бүхэлдээ грек хэлээр бичигдсэн байдаг.

Библи дэх янз бүрийн багцлалуудыг олоход хялбар болгоор хүмүүс дараа нь Библийн номуудыг бүлэг ба ишлэлд хуваан дугаарлажээ. Хэдийгээр энэ нь Бурханы амьсгалснаар хийгдсэн ажил биш ч тухайн бүлэг, хэсгүүдийг уламжлал ёсоор хэрхэн ойлгож ирснийг ойлгоход маань бидэнд туслах хосгүй зорилготой хийгдсэн юм.

2. Бурханы амьсгалснаар бичигдсэн Үг

Судар бүр Бурханы амьсгалснаар байдаг (2 Тимот 3:16-17) учраас ашиг тустай юм. Бурханы онгод буюу “амьсгал” нь хүний ген, хүний тайлбар болон илчлэлтээс хавьгүй агуу зүйл аж. Яагаад гэвэл энэ нь Бурханаас эхтэй юм. “Бурханы амьсгал” нь хүмүүний мөн чанараар дамжуулан өөрийгөө илэрхийлж буй нь энэ ажээ.

3. Бурханы амьд Үгийн илчлэлт

Библи бол бидний Эзэн Бурхан, Есүс Христийн амьд Үгийн бичгээр илэрхийлэгдсэн илчлэлт юм. “Илчлэлт” гэдэг нь шинэ мэдээ дамжуулах гэсэн утгатай. Ариун Сүнс бидний дотор ажиллах үед “тайлбар” хийгдэж, Үгийг судалж буй оюутанд “илчлэлтийг” ойлгомжтой болгож өгдөг. Бичигдсэн Үг нь өөрөө амьд биш агаад харин Эзэн Есүс Христийн тухай бурханлаг дүрслэл юм (Еврей 4:12 уд.харьц. Иохан 5:39-47).

Цаас, бэх хоёрт ямар ч хүч, эрх мэдэл байхгүй. Харин тэдгээрийн цаана Бурханы Сүнс ажиллаж, хүмүүсийн амьдралыг өөрчилж байдаг. Энэ чухал ялгааг бид ойлгох хэрэгтэй юм. Итгэлийг Эхлүүлэгчийг (Еврей 12:2) хүндлэн бишрэлгүйгээр, зөвхөн үгийг хүчтэй, эрх мэдэлтэй гэж үзэх нь түүний жинхэнэ санааг олж харахгүй байх аюултай.

B. Библийн бүтэц, зохион байгуулалт

1. Үндсэн хоёр хэсэг

Библи нь Шинэ ба Хуучин гэрээ гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваагддаг.

Библид нийт 66 ном байдгийн 39 нь Хуучин, 27 нь Шинэ гэрээний номууд юм. Хуучин гэрээний номуудыг 30 гаруй хүн, Шинэ гэрээний номуудыг 10 хүн бичсэн байдаг. Библи нийт 1189 бүлэгтэйгээс 929 нь Хуучин гэрээнд, 260 нь Шинэ гэрээнд бий. Түүнчлэн Хуучин гэрээнд 23214 ишлэл, Шинэ гэрээнд 7959 ишлэл байдаг (нийт 31173 ишлэлтэй).

“Гэрээ” гэдэг нь ямар нэг үнэ цэнэтэй зүйлийг нэг хүн нөгөөдөө санал болгож, харин нөгөөх нь энэхүү саналыг нь хүлээн зөвшөөрч буй зөвшилцэл буюу хэлэлцээр юм. Жишээ нь, хэн нэг хүн

ямар нэг бүтээгдэхүүнийг худалдаж авахыг хүсэж байна гэж бодьё. Тэрээр өөрт нь санал болгож байгаа бүтээгдэхүүнийг худалдаж авах эсэхээ өөрөө шийддэг. Хэрэв саналыг хүлээн авахаар шийдсэн бол үүнийгээ баталгаажуулан гэрээ буюу хэлэлцээр байгуулдаг. Хоёр талын харилцааг захиран зохицуулах амлалтууд гэрээнд тусгагдсан байдаг. Гэрлэж буй хосуудын бие биедээ өгдөг ам тангараг нь гэрээний нэг тод жишээ юм. Энэхүү амлалт нь сүйт бүсгүй, сүйт залуу хоёрын хооронд хийгдэж буй гэрээ бөгөөд үүн дээр тэдний харилцаа үндэслэгддэг.

Ирэх Мессиагийн талаар хүнтэй байгуулсан Бурханы эх гэрээнүүд Хуучин гэрээнд өгөгдсөн байдаг. Дараа нь бид энэ сургалтаараа эдгээр гэрээний талаар үзэх болно.

2. Хуучин гэрээг тав ангилдаг

Хуучин гэрээг дараах байдлаар ангилдаг:

- a. *Хууль*: Үүнийг “Тора” (еврейгээр) буюу “Пентатух” (грекээр “таван ном” гэсэн утгатай) гэдэг. Энэ хэсэгт дараах таван ном багтдаг: Эхлэл, Египетээс гарсан нь, Левит, Тооллого, Дэд хууль.
- b. *Түүхийн номууд* (арван хоёр): Иошуа, Шүүгчид, Рут, 1 Самуел, 2 Самуел, Хаадын дээд, Хаадын дээд, Шастирын дээд, Шастирын дэд, Езра, Нехемиа, Естер.
- v. *Яруу найргийн номууд* (тав): Иов, Дуулал, Сургаалт үгс, Номлогчийн үгс, Соломоны дуун.
Г. *Их эш үзүүллэгүүд* (тав): Исаиа, Иеремиа, Иеремиагийн гашуудал, Езекиел, Даниел.
- d. *Бага эш үзүүллэгүүд* (арван хоёр): Хосеа, Иоел, Амос, Обадиа, Иона, Мика, Нахум, Хабаккук, Зефания, Хаггай, Зехария, Малахи.

3. Шинэ гэрээг гурав ангилдаг

Шинэ гэрээнд Мессия ирсэн тухай бичиж үлдээснээс гадна түүний дараа хийгдсэн шинэ гэрээ өгөгдсөн байдаг.

Мэдээж, эдгээр номуудад янз бүрийн сэдвийг хөндсөн байдаг. Жишээ нь, түүхийн номуудад зарим нэг эш үзүүллэг (Матай 24, Марк 13, Лук 21) байдаг бол эш үзүүллэгийн номуудад захидалууд орсон байдаг (Илчлэлт 2-3). Аль ч номын ерөнхий нэр нь түүний үндсэн агуулга дээр үндэслэгдсэн байдаг. Шинэ гэрээг дараах гурван хэсэгт хуваадаг:

- a. Түүхийн ном (тав): Матай, Марк, Лук, Иохан, Ййлс.
- b. Түүхийн номуудын ард захидалууд орсон байдаг (хорин нэг): Ром, 1 Коринт, 2 Коринт, Галат, Ефес, Филиппой, Колоссай, 1Тессалоник, 2Тессалоник, 1 Тимот, 2 Тимот, Тит, Филемон, 1 Иохан, 2 Иохан, 3 Иохан, 1 Петр, 2 Петр, Еврей, Иаков, Иуда.
- v. Эш үзүүллэгийн ном (нэг): Илчлэлт.

Хувийн Судлал: 1-р бүлэг, 2-р хэсэг

1. Еврей 10:1-7 ишлэлийг унш. Бичигдсэн Үг юуг хийж чадахгүй вэ?
2. Еврей 10:1-7 ишлэлээс үзвэл, бичигдсэн Үг ямар зорилготой вэ?
3. 2 Тимот 3:16-17 ишлэлийг унш. Бурханы амьсгалснаар байдаг Үг нь юунд тустай вэ?
4. 2 Тимот 3:17-д өгүүлсэнчлэн, Судар ямар хоёр зорилготой вэ?
5. Иохан 5:39-47 ишлэлийг унш. Судрыг судалж байгаа хүнд Есүс юуг анхааруулсан бэ?
6. “Гэрээ” буюу “хэлэлцээр”-ийн хамгийн чухал зүйл нь юу вэ?
7. Хуучин гэрээг ямар таван хэсэгт ангилдаг вэ?
8. Их болон Бага эш үзүүллэгийг зүгээр л “Эш үзүүллэг” гэж нэрлэж болох уу?
9. Шинэ гэрээг ямар гурван хэсэгт хуваадаг вэ?

З-р хэсэг

Түүхийн Тойм

Бурханы Үг түүхийн урт хугацааны туршид маш олон хүнээр бичигдсэн атлаа хоорондоо ямар ч зөрөөгүй, алдаа мадаггүй байдагт түүний гоо үзэсгэлэнгийн нэг хэсэг оршдог. Түүх нь өнгөрсөн үйл явдлуудыг авч үздэг.

Дор тоймлон харуулсан үйл явдлын дэс дараалал нь хүн төрөлхтний түүхийн гайхамшигт өрнөлийг харуулдаг. Эдгээр гол үйл явдлыг хараад бид ийм гайхамшигтай түүхийн эхлэл болон төгсгөлийг тодорхой харах боломжтой болно. Түүнчлэн гүн ухаантнуудын хэдэн зууны турш асуусаар ирсэн “Бид яагаад энд байгаагийн учир юу вэ?” гэсэн асуултын хариултыг олж харах болно.

Дараах үйл явдлуудыг зөвхөн тойм төдий дүрслэн өгүүллээ. Илүү дэлгэрэнгүй зүйлсийг олж мэдэхэд бид үлдсэн амьдралаа зориулах болно. Харин одоо хүн төрөлхтний түүхэнд Бурханы үйлдсэн түүхэн чухал үйл явдлуудтай танилцацгаая. Хичээлийн явцад бид Бурханы хувиршгүй, гайхамшигт төлөвлөгөөтэй танилцах болно.

A. Үйл явдлуудын тухайд

1. Бүтээл

Тэнгэр газрыг анх бүтээсэн тухай Библийн эхэнд, Эхлэл номд тэмдэглэсэн байdag (Эхлэл 1:1; 2 Петр 3:6). Харин Илчлэлт номд “Шинэ тэнгэр, шинэ газрыг” (Илчлэлт 21–22) бүтээхээр энэхүү эхний бүтээлийг устгаж байгаа тухай өгүүлдэг.

2. Сатаны эсэргүүцэл

Хүнийг бүтээхээс өмнө Сatan Бурханыг эсэргүүцсэн байdag (Исаиа 14:12-14; Езекиел 28). Энэхүү эхний эсэргүүцлийн зорилго Сударт тодорхойгүй бөгөөд энэ зөрчилдөөний үр дагаврыг ойлгоход хялбар биш юм. Ямар ч л байсан хүн төрөлхтөн үсэж бий болохоос өмнө Бурхан, Сатан хоёр хоорондоо тулалсаар ирсэн (Илчлэлт 12) бөгөөд шинэ тэнгэр, шинэ газар бий болохын өмнөхөн (Илчлэлт 20:7-10) буюу Есүс Христ энэ дэлхийд 1000 жил хаанчилсны дараа Сатан Түүнийг сүүлчийн удаа эсэргүүцэх нь тодорхой юм.

3. Хуурай газар ба хүн

Бурхан дэлхий өртөнцийг хүн оршин суухаар болгож бэлдсэн (Эхлэл 1:2–2:3 ишлэлд өгүүлсэнчлэн, “хэлбэр дүрсгүй” [еврей, ТОНУ], “эзгүй хоосон” [еврей ВОНУ] гэсэн үгнүүд нь тус бүрдээ “хүн амьдран суух боломжгүй”, “хүнгүй хоосон” гэсэн утгыг илрхийлдэг). Бурхантай тэрсэлдэх арга замыг үргэлж сүвэгчилсээр ирсэн, Сатан хэмээгч нэгэн эзэрхийлэгч байв. Эзэн Сатаныг Мянган жилийн Хаанчлалын турш хорьж түгжихдээ (Есүс Христийн 1000 жилийн хаанчлалын тухай Илчлэлт 20:1-3 ишлэлээс үз), дэлхий өртөнцийг хүмүүний төлөө дахин нэг удаа төгс болгоно (Исаиа 60–66).

4. Анхны болон сүүлчийн Адам

Анхны хүн Адамыг бүх бүтээлийн тэргүүн байхаар бүтээсэн (Эхлэл 1:28; 2:4-25). Бурхан Еден цэцэрлэгийг арчилж тордуулахаар түүнийг энд авчирч тавьжээ. “Сүүлчийн Адам” буюу Эзэн Есүс Христ (1 Коринт 15:45) 1000 жилийн (Илчлэлт 20:4) турш бодитоор хаанчлах болно. Түүнээс өөр төгс Нэгэн байхгүй учраас Түүнийг ийнхүү “сүүлчийн” хэмээн хэлжээ.

5. Хүн Сатантай тэмцсэн нь

Еден цэцэрлэгт Адам “унасан”-аар Сатан буюу “өртөнцийн захирагч”-ийн эрхшээлд орсон юм (Эхлэл 3; Иохан 12:31; 16:11). Хожим Мянган жилийн Хаанчлал эхлэхийн өмнө Бурхан Сатаныг Христийн эрхшээлд тушаах болно (Илчлэлт 20:1-3).

6. Хүн төрөлхтөн бүхэлдээ шүүгдсэн

Бурхан хүнийг бузар муутай хутгалдахыг зөвшөөрдөг. Гэхдээ эцсийн эцэст Тэр бүх хүн төрөлхтөнтэй тооцоо бodoх болно. Хүн төрөлхтний дуулгаваргүй байдалд Бурханы урам хугарч, улмаар Их үерт автуулахад хүргэсэн нөхцөл байдлыг бид Эхлэл 4–10 бүлгээс олж харна (Эхлэл 6:1-13). Зовлонгийн долоон жил өнгөрсний дараа Есүс Христийг хоёр дахь удаагаа ирэх үед Бурхан хүн төрөлхтөнтэй дахин тооцоо бodoх болно. Тэр үед Бурхан энэ дэлхийд үлдсэн бүх хүнийг “хонь” (итгэгчид), “ямаа”-гаар нь (ул итгэгчид) тусгаарлан ялгана (Матай 25:31-46).

7. Вавилон

Ноагийн дараа газар дэлхийд хүмүүс дахин оршин суух болсон авч тэд дахин Бурханаас холдож, төөрөлдөж эхэлсэн. Тэд Вавилонд Бабел цамхгийг байгуулав (Эхлэл 11). Тэд өөрсдийгөө аврах гэж хэрхэн хичээж байсныг энэ цамхаг гэрчлэн харуулдаг. Хэрэв маш өндөр цамхаг босгож чадвал түүн уруу авиран, тэнгэрт ойртоноор Бурханы уур хилэнгээс (Үер гэх мэт) зугтаж чадна гэж тэд бодсон. Шашин шүтлэг, эдийн засгийн арга хэрэгслээр хүн өөрийгөө аврах боломжтой гэж үздэг “хюманизм” дээр үндэслэн тэд энэхүү цамхгийг барьж байгуулжээ. Иймэрхүү итгэл үнэмшил нь дэлхийн бүх шашны системийн үндэс суурь юм. Хүн өөрийгөө аварч чадахгүй учраас Аврагч хэрэгтэй гэдгийг христитгэгчид л зөвхөн ойлгодог. Амьд Бурханыг эсэргүүцдэг хүмүүсийн хюманистик хандлагыг Библид дүрслэн өгүүлсэн байдаг. Вавилон (Иасаиа 47), Тир (Езекиел 26–27) зэрэгт байсан ийм хандлага өнөөдрийг хүртэл бидний дунд байсаар байна. Хүн хэд хэдэн үе шаттайгаар бурхны төрөлд ойртон очдог гэж итгэдэг шашны хувьд ч гэсэн үүнтэй ижил хандлага ажиглагддаг. Вавилонд босгосон байгууламжуудыг Бурхан зовлонгийн жилүүдийн үеэр устгах болно (Илчлэлт 17–18).

8. Израиль

Эзэн Бабелаас хүмүүсийг бүх дэлхий даяар тарааж, үндэстнүүдэд янз бүрийн хэлийг өгснийхөө дараа Абрахамыг Израиль хэмээх нэгэн шинэ үндэстний үндэслэгч болгохоор дуудсан (Эхлэл 12). Мессиагийн талаар Абрахамд өгөгдсөн амлалт нь түүний хүү Исаак, ач хүү Иаков нарын гайхамшигт төрөлтөөр дамжин үргэлжилсэн юм (Эхлэл 22:1-18; 28:14). Эцэст нь, Эзэн Израилийн ард түмнийг бузар муу үйлдлээс нь болж дэлхий даяар тараан бутаргасан боловч амлалтаа хэвээр үлдээсэн юм. Зовлонгийн жилүүдийн дараа Израиль ер бусын байдлаар дахин нэгдэж, Мянган жилийн хаанчлалын үеэр ерөөгдөх болно (Матай 24:29-31).

9. Есүс Христийн ирэлт

Хүн төрөлхтний түүхэн дэх Бурханы төлөвлөгөөний төгс цагт Есүс Христийн анхны ирэлт тохиосон (1 Тимот 2:6). Сайн мэдээний Матай, Марк, Лук, Иохан номуудад Есүсийн төрөлт, үйлчлэл, үхэл, оршуулга болон амилалтын тухай гайхамшигт түүхийг өгүүлдэг. Исаиа 53-р бүлэгт Түүний талаар урьдаас хэлсэнчлэн, Есүс Христ бол “Зовлонт зарц” байсан нь тодорхой байдаг. Есүс Христ хоёр дахь удаагаа, Зовлонгийн жилийн дараа ирэх ба тэр үед Христ газар дэлхий дээр дахин хөл тавьж, дайснуудаа булаан эзлэх болно (Зехария 14:1-8; Илчлэлт 19:11-19). Ийнхүү Мянган жилийн хаанчлал эхэлнэ. Энэ удаа Тэр “Ялагч хаан” адил ирэх болно.

10. Эсрэг үйлчлэлүүд

Түүнчлэн, Сайн мэдээний номуудад Эзэн Есүс Христийн олон нийтийн дундах үйлчлэлийн талаар гайхалтай дүрслэн өгүүлдэг (Матай, Марк, Лук, Иохан). Христийн үйлчлэл бол бусдын төлөөх үйлчлэл байсан (Матай 20:28). Энэ бол өөртөө бүх анхаарлыг татаж, бүх мөргөлийг төвлөрүүлэхийг хичээн, амин хувийнхаа төлөө үйлчилдэг Антихристийн “үйлчлэлээс” (түүнийг “ёс бус нэгэн” гэдгээр нь хүмүүс бас мэддэг) эрс ялгаатай юм (2 Тесалоник 2:1-12; Илчлэлт 6–16).

11. Чуулган

Есүс Христ амилж, Бурхан Эцэгийнхээ баруун сэntийд залрахаар дээш өргөгдсөний дараа Есүс Христийн тахилаар дамжуулан гэм нүүглээсээ учлагдах тухай сайн мэдээг түгээх үйлсэд Чуулганыг “дуудсан” юм (Элч нарын Үйлс). Чуулган өөрийн Эзэн, Сүйт залуутайгаа гэрлэхээр дуудагдах (1 Тесалоник 4:13-18; 1 Коринт 15:50-58; Илчлэлт 19:7-10) хүртлээ “бүх үндэстнийг дагалдагч” (Матай 28:18-20) болгох хариуцлагыг үүрнэ.

Б. Дүгнэлт

Дээр дүрслэн өгүүлсэн үйл явдлуудын дэс дарааллыг задлан шинжилж үзэх аваас дараах дүр зураг харагдах болно. Энэхүү гайхалтай, тэгш хэмтэй дүрслэл нь хүн төрөлхтний түүхийг дэлгэн үзүүлээд, эцэст нь түүнийг нэгтгэн дүгнэдэг. Хэрэв та ижил дугаар бүхий хэсгүүдийг хооронд нь харьцуулан харвал Бурханы төлөвлөгөөг өрөнхийд нь харах болно.¹

1. Аихны тэнгэр газрыг бүтээсэн. Эхлэл 1:1; 2 Петр 3:6
2. Сатаны эхний эсэргүүцэл. Исаиа 14:12-14; Езекиел 28
3. Хүнд зориулан бэлтгэсэн газар. Эхлэл 1:2–2:3
4. Аихны Адам тэргүүн болсон. Эхлэл 2:4-25
5. Хүн Сатаны эрхшээлд орсон. Эхлэл 3
6. Хүн төрөлхтөн бүхэлдээ шүүгдсэн. Эхлэл 4–10
7. Бабел цамхгийг байгуулсан. Эхлэл 11
8. Израилийг үндэстэн хэмээн нэрлэв. Эхлэл 12
9. Есүс Христийн аихны ирэлт. Матай, Марк, Лук, Иохан
10. Есүс Христийн үйлчлэл. Матай, Марк, Лук, Иохан
11. Чуулган дуудагдсан. Үйлс
12. Чуулган дуудагдсан. 1 Тесалоник 4:13-18; 1 Коринт 15:50-58
13. Антихристийн үйлчлэл. 2 Тесалоник 2:1-12; Илчлэлт 6–16
9. Есүс Христийн хоёр дахь ирэлт. Илчлэлт 19:11-19
8. Израиль үндэстэн болон дахин цугласан. Матай 24:29-31
7. Вавилоны сүйрэл. Илчлэлт 17–18
6. Хүн төрөлхтөн бүхэлдээ шүүгдсэн. Матай 25:31-46
5. Сатан Христийн эрхшээлд орсон. Илчлэлт 20:1-3
4. Сүүлчийн Адам тэргүүн болсон. Илчлэлт 20:4
3. Хүнд зориулан төгс болгосон газар. Исаиа 60–66
2. Сатаны сүүлчийн эсэргүүцэл. Илчлэлт 20:7-10
1. Шинэ тэнгэр, шинэ газрыг бүтээсэн. Илчлэлт 21–22

Хувийн Судлал: 1-р бүлэг, 3-р хэсэг

1. Эхлэл 1–2, Илчлэлт 21–22 ишлэлийг унш. Эдгээр нь юуг илчлэн харуулж байна вэ?
2. Исаиа 14:12-14, Илчлэлт 20:7-10 ишлэлүүдийг унш. Сатаны аихны гэм нүгэл юу байв? Түүний эцсийн хувь тавилан юу вэ?
3. Эхлэл 1:2–2:3 ишлэлийг дахин унш. Мөн Исаиа 60–66 бүлгийг унш. Бурхан газар дэлхийг төгс бүтээсэн боловч Адам нүгэлд унааснаар энэ дэлхий төгс бус болсон тухай Эхлэл номд өгүүлдэг. Тэгвэл Исаиа номын энэхүү багцлалд юун тухай өгүүлж байна вэ?
4. Эхлэл 3-р бүлэг, 1 Коринт 15:45 болон 1 Петр 2:22-24 ишлэлийг унш. Аихны хүн Адам болон “Сүүлчийн Адам” болох Есүс Христийн хооронд ямар ялгаа байна вэ?
5. Ефес 6:10-18 ишлэлийг унш. Бидний жинхэнэ дайснууд хэн бэ? Бид тэдэнтэй хэрхэн тэмцэх ёстой вэ?
6. Эхлэл 6:1-13 ба Матай 25:31-46 ишлэлүүдийг унш. Хоёуланд нь ямар сэдвийг хөндсөн байна вэ?
7. Илчлэлт 17–18 бүлгийг унш. Вавилончууд гуманизмыг шүтэн биширдэг байсан. Өөрөөр хэлбэл, тэд хүн төрөлхтөн өөрийгөө аварч чадна гэж итгэдэг байлаа. Эдгээр бүлэгт буй бэлгэ тэмдгүүдийг бүгдийг нь тодорхойлохыг хичээлгүйгээр гуманизм илэрхий харагдаж буй хоёр зүйлийг олж харахыг оролд (сэжүүр: нэг нь 17-р бүлэгт, нөгөө нь 18-р бүлэгт бий).

8. Эхлэл 12:1-3, Еврей 11:8-12 болон Илчлэлт 21:10-27 ишлэлүүдийг унш. Абрахамд өгөгдсөн амлалт хэзээ бүрэн дүүрэн биелэх вэ?
9. Исааи 53, Зехария 14:1-8 ба Илчлэлт 19:11-19 ишлэлийг унш. Есүс Христийн эхний болон сүүлчийн ирэлтийн ялгааг дүрслэн хэл.
10. 2 Тесалоник 2:1-12 ба Матай 20:28-р ишлэлийг унш. Есүс Христ болон “Антихристийн” үйлчлэлийн гол ялгаа юу вэ?
11. Матай 28:18-20, Үйлс 1:8 болон 1 Тесалоник 4:13-18 ишлэлийг унш. Эзэнтэй уулзахаар дуудагдах хүртэл Чуулганы гол үүрэг юу вэ?

4-р хэсэг

Түүхэн Он Дарааллын Тойм

Библи судлалын оюутнууд түүхэн чухал үйл явдлуудын дэс дараалал, цаг хугацаа, харилцан хамаарлыг мэддэг байх ёстой. Энэ хэсэгт бид гурван чухал он дарааллыг өгөх болно. Эхнийхэд нь Библид гардаг арван гол үйл явдлыг цаг хугацаатай нь жагсааж, тус бүрийн нь ач холбогдлыг дүгнэнэ. Он дарааллын хоёр дахь хэсэгт Хуучин гэрээний гол үйл явдлуудыг онцолж, Библийн Хуучин гэрээний номуудын талаар өгүүлнэ. Харин гурав дахь хэсэгт Шинэ гэрээний номуудыг дэс дарааллаар нь тайлбарлах болно.

Тухайн оны өмнө буй “МЭӨ” гэсэн үсгүүд нь “Манай Эзэний Өмнөх” (англи. “B.C.” - “before Christ” буюу “Христийн Өмнөх”), харин “МЭ” гэсэн нь “Манай Эзэний” (англи. “A.D.” – латин. “Anno Domini” гэсэн үгээс гаралтай, “Манай Эзэний үе” гэсэн утгатай) үеийн он жилүүдийг заадаг.

Өгөгдсөн он цаг нь Бурханы Үгийн шууд тайлбар дээр үндэслэгдсэн бөгөөд энэхүү Үгийг судалсан олон хүн энд дурдахын аргагүй маш олон шалтгааны улмаас янз бүрийн он цагийг гаргаж ирсэн байдаг. Гэхдээ үүнээс болж та сатаараах хэрэггүй. Харин энэ хэсгээс таны сурах ёстой хамгийн чухал зүйл бол үйл явдлуудын дэс дарааллыг ойлгох явдал юм.

Энэ номын өмнөх хэвлэлтэд Үйлс номын 7:4-д дурдагдсан хэрнээ Эхлэл 11:26–12:5 ишлэлд дурдагдаагүй 60 жилийн талаар ямар нэг тайлбар хийгдээгүй. Абрахам Тераг нас барсны дараа Харанаас явсан гэж Үйлс номд хэлсэн байдаг. Тера 205 настайдаа Харанд нас барсан (Эхлэл 11:32) бөгөөд Абрахам түүнийг нас барсны дараа (Үйлс 7:4), 75 настайдаа Харанаас гарч явжээ. Эндээс хараход, Абрахамын төрөхөд Тера 130 настай байсан аж. Эхлэл 11:26-д гарч буй 70 жил гэдэг нь Нахор, Харан хоёрын аль нэгнийх нь (Хараных бололтой) төрсөн оныг хэлсэн байж таарна (Эхлэл 11:28). Оюутан бүр Судрыг Судартай нь харьцуулж, Судар өөрөө өөрийгөө хэрхэн тайлахыг нь харах хэрэгтэй гэсэн зарчмыг энэ жишээ улам бататгах байх гэж найдаж байна.

A. Арван гол үйл явдал ба тэдгээрийн он тоолол

1. Адамын уналт (МЭӨ 3958 он)

Бурханы Үгэнд өгөгдсөн угийн (терсөн дараалал) бичгийн тайлан нь Адамын уналт МЭӨ 3958 онд болсон гэсэн дүгнэлтэд биднийг хүргэдэг. Харин Библийн он дарааллын дагуу авч үзвэл, бид Адамаас эхлээд Соломоны хаанчлалын дөрөв дэх жил хүртэлх цаг үеийг авч үзэх хэрэгтэй болдог (1 Хаад 6:1). Гол үйл явдлуудын хоорондох цаг хугацаатай холбоотой мэдээллийг Библи бидэнд өгдөг. Библийн үйл явдлуудыг хүн төрөлхтний түүхийн тодорхой он цагуудтай холбосноор бид Библийн түүхийг шашны бусад түүхтэй холбож чадна.

2. Ноагийн үер (МЭӨ 2302 он)

Эхлэл 5-р бүлэгт гардаг угийн бичгээс үзвэл, Адамаас Ноагийн үер хүртэл 1656 жилийн хугацаа байгааг харж болно. Тэгэхлээр энэ үер МЭӨ 2302 онд болсон гэсэн үг байх нь.

3. Абрахамд өгөгдсөн амлалт (МЭӨ 1875 он)

Эхлэл 11:10-26 ишлэлд буй угийн бичгээс үзвэл, Абрахам Ноагийн үерээс хойш 352 жилийн дараа, Адамаас 2008 жилийн хойно төрсөн болох нь тодорхой байна. Тэгэхлээр Абрахам МЭӨ 1950 онд төрсөн аж. Абрахам Бурханаас амлалтыг хүлээн авахдаа 75 настай байсан гэдгийг Эхлэл 12:4-р ишлэлээс бид мэдэх билээ. Энэхүү гэрээ нь Абрахамын гэрээ гэгдэх болсон. Эндээс харвал, Бурхан уг амлалтыг МЭӨ 1875 онд Абрахамд өгсөн аж.

4. Израиль Египетээс гарсан нь (МЭӨ 1445 он)

Эхлэл 12–50 бүлэгт Абрахамын шууд удамтай холбоотой мэдээллийг бидэнд өгсөн байдаг. Иаковын (Абрахамын ач хүү) хүүхдүүд Египетэд очиж, эцэстээ тэдний боол болсон (Египетээс гарсан нь 1). Харин Бурхан Мосегийн удирдлага дор тэднийг Египетийн боолчлолоос чөлөөлсөн. Абрахамын амлалтаас хойш Хууль өгөгдөх (Галат 3:17) хүртэл 430 жил өнгөрсөн гэж элч Паул

хэлсэн байдаг. Тэгэхлээр Израиль нь МЭӨ 1445 онд буюу Адамаас хойш 2438 жилийн дараа Египетээс гарсан байна.

5. Соломоны хаанчлалын дөрөв дэх жил (МЭӨ 965 он)

Израилийн гурав дахь хаан Соломон нь эцэг Давидаасаа хаан ширээг залгамжлан авсан. Харин Давидын өмнө Израилийг Саул хаан захирч байв. Израилийн хөвгүүд Египетээс гарснаас хойш Соломоны хаанчлалын дөрөв дэх жилд Эзэний Өргөөг барьж эхлэх хүртэл 480 жил өнгөрсөн гэж 1 Хаад 6:1-д тэмдэглэсэн байдаг. Эндээс тооцоолж үзвэл энэ нь МЭӨ 965 он буюу Адамаас хойш 2918 жилийн дараа аж.

Соломоны хаанчлалын дөрөв дэх жилийг бид түүхийн өөр баримтуудаас тогтоох боломжтой. Ингэснээр бид хөдөлбөргүй цаг хугацааг тогтоож, түүнийгээ ашиглан өмнө дурдсан үйл явдууд буюу Израилийн хөвгүүд Египетээс гарсан, Абрахамд амлалт өгөгдсөн, Адам болон Ноагийн үер болсон цаг хугацааг тогтоож болох юм. Сүүлийн 100 жилд хийгдсэн археологийн нээлтүүд нь хүн төрөлхтний түүхийн МЭӨ он тооллуудад зарим нэг засвар хийхэд хүргэсэн байна. Он тооллыг тооцох өөр өөр тогтолцоонд ялгаа гардаг нэг шалтгаан энэ юм .

6. Умард хаант улс задран унасан (МЭӨ 721 он)

Соломон хааныг нас барсны дараа Израиль нь хойд Израиль, өмнөд Иуда гэсэн хоёр хаант улсад хуваагдсан. Хойд Израиль МЭӨ 721 онд Ассирид эзлэгдэж, цаашид хаант улс байхаа болив.

7. Өмнөд хаант улс задран унасан (МЭӨ 586 он)

МЭӨ 586 онд Өмнөд хаант улс Вавилонд эзлэгдэж, 70 жилийн турш цөлөгдсөний эцэст МЭӨ 516 онд эх нутагтаа буцахаар болжээ.

8. Есүс Христ мэндэлсэн (МЭӨ 1 он)

Бидний Эзэнийг ирснээс хойш 6 зуун жилийн дараа Түүнийг төрөх хүртэлх бүхий л түүхэн он дарааллыг тогтоохын тулд “МЭӨ”, “МЭ” гэсэн он тооллын системийг боловсруулжээ. Чуулган анх энэ системийг боловсруулахдаа Херод хааны амьдарч байсан цаг хугацааг буруу тооцоолсон байдаг (Есүсийг төрөх үед энэ хаан агуу эрх мэдэлтэй байсан тухай Библид дурдсан байдаг. Лук 1:5). Нэлээд хожуу энэхүү тооцоололд 1-2 жилийн зөрүү гарсан нь тогтоогдсон боловч нэгэнт мөрдөж эхэлсэн системд өөрчлөлт хийж, өмнөх бүх огноог шинэчлэхийн оронд Есүсийг МЭӨ 1-2 онд мэндэлсэн гэж үзэх нь дээр хэмээн шийдвэрээ.

Нэгдүгээр сараас эхэлдэг Өрнийн хуанли болон есдүгээр сараас эхэлдэг Иудейн хуанли хоёр хоорондоо ялгаатай учраас “МЭӨ 1-2 он”, “МЭӨ 966-965 он” гэж хоёр өөрөөр бичигддэг аж.

9. Есүс Христийн үхэл, оршуулга, амилалт (МЭ 32–33 он)

Ихэнх Библи судлаачид Есүс Христийг МЭ 32-33 онд нас барж, оршуулагдаж, мөн амилсан гэж үздэг.

10. Библийн сүүлчийн ном (МЭ 96 он)

Энэ үе нь Ромын эзэн хаан Домитаны хаанчлалын үед элч Иохан Патм хэмээх арал дээр цөлөгдж (Илчлэлт 1:9) байсан үетэй холбоотой. Библи энэ арал дээр бүрэн гүйцэд бичигдэж дуусжээ (Илчлэлт 22:18-19).

Б. Хуучин гэрээний номуудын он дараалал

1. Адамаас Их үер хүртэл (МЭӨ 3898–2202 он)

Эхлэл 1–5

2. Их үерээс Абрахамд өгөгдсөн амлалт хүртэл (МЭӨ 2302–1875 он)

Эхлэл 6–12

3. Абрахамын амлалтаас израильчууд Египетээс гарсан үе хүртэл (**МЭӨ 1875–1445 он**)
Эхлэл 12–50; Иов ном
4. Египетээс гарсан үеэс Соломоны хаанчлалын 4 дэх жил хүртэл (**МЭӨ 1445–965 он**)

а. Египетээс гарсан нь	д. Иошуа	з. 2 Самуел
б. Левит	е. Иуда	и. 1 Хаад 1–5
в. Тооллого	ё. Рут	й. Дуулал
г. Дэд хууль	ж. 1 Самуел	к. 1 Шастир
5. Соломоны хаанчлалын 4 дэх жилээс Иудагийн уналт хүртэл (**МЭӨ 965–586 он**)

а. 1 Хаад 6–22	ё. Обадиа	л. Исаиа
б. 2 Хаад	ж. Иоел	м. Нахум
в. 2 Шастир	к. Иона	н. Зефания
г. Сургаалт уг	и. Амос	о. Хабаккук
д. Номлогчийн уг	й. Хосеа	
е. Соломоны дуун	к. Мика	
6. Вавилоны цөллөгийн үе (**МЭӨ 586–516 он**)

а. Иеремия	в. Езекиел
б. Иеремиагийн гашуудал	г. Даниел
7. Вавилоны цөллөгөөс Хуучин гэрээний төгсгөл үе хүртэл (**МЭӨ 516–400 он**)

а. Езра	в. Зехария	д. Малахи
б. Нехемия	г. Хагтаи	

B. Шинэ гэрээний номуудын он дараалал

Шинэ гэрээний номуудыг (эдгээр нь Бурханы онгodoор бичигдсэн) ерөнхийдөө дараах дарааллаар бичсэн гэж үздэг:

1. Христийн амьдрал болон анхны Чуулганы түүх (**МЭ 55–85 он**)

а. Матай	в. Марк	д. Уйлс
б. Лук	г. Иохан	
2. Чуулганд хандсан захидлууд (**МЭ 46–85 он**)

а. Иаков	ж. Филемон	н. Еврей
б. Галат	з. Ефес	о. 1 Петр
в. 1 Тесалоник	и. Колоссай	ө. 2 Петр
г. 2 Тесалоник	й. Филиппой	п. Иуда
д. 1 Коринт	к. 1 Тимот	р. 1 Иохан
е. 2 Коринт	л. Тит	с. 2 Иохан
ё. Ром	м. 2 Тимот	т. 3 Иохан
3. Эш үзүүллэг (**МЭ 96 он**)

Илчлэлт

Хувийн Судлал: 1-р бүлэг, 4-р хэсэг

1. Дараах үйл явдлуудыг зөв дарааллаар байрлуул:

Умард хаант улс задран унасан
Ноагийн үер
Өмнөд хаант улс задран унасан
Абрахамд амлалт өгөгдсөн
Есүс Христийн үхэл, оршуулга ба амилалт
Израильчууд Египетээс гарсан
Соломоны хаанчлалын дөрөв дэх жил

Есүс Христ төрсөн
Адамын уналт
Библийн сүүлийн ном

2. Хуучин гэрээний ямар хоёр номд Бүтээлээс эхлээд Египетээс гарсан ўе хүртэлх ўйл явдлыг дүрслэн өгүүлдэг вэ?
3. Судрын дараах хэсгүүдийг бичигдсэн он дарааллаар нь байрлуул:
- | | | |
|------------|-----------|---------------------|
| 1 Самуел | Иошуа | 2 Самуел |
| 1 Хаад 1-5 | Дэд хууль | Левит |
| Тооллого | Рут | Дуулал |
| Иуда | 1Шастир | Египетээс гарсан нь |
4. Хуучин гэрээний дараах хэсгүүдийг бичигдсэн он дарааллаар нь байрлуул:
- | | | |
|----------------|-------|----------|
| 2 Шастир | Исаиа | Обадиа |
| 1 Хаад 6-22 | Нахум | Хосеа |
| Сургаалт үгс | Амос | Иоел |
| Номлогчийн үгс | Мика | Зефания |
| Соломоны дуун | Иона | Хабаккук |
5. Хуучин гэрээний дараах номуудыг бичигдсэн он дарааллаар нь байрлуул:
- | | | |
|---------|---------|-------------|
| Нехемиа | Малахи | Иеремиагийн |
| Даниел | Езра | гашуудал |
| Иеремиа | Зехария | Хаггаи |
| Езекиел | | |
6. Дараах Шинэ гэрээний түүхийн номуудыг бичигдсэн он дарааллаар нь байрлуул:
- | | | |
|-------|-------|------|
| Матай | Лук | Үйлс |
| Марк | Иохан | |
7. Дараах Шинэ гэрээний номуудыг бичигдсэн он дарааллаар нь:
- | | | |
|-------------|-------------|---------|
| Ром | 2 Тесalonик | 2 Петр |
| 1 Коринт | 1 Тимот | 1 Иохан |
| 2 Коринт | 2 Тимот | 2 Иохан |
| Галат | Тит | 3 Иохан |
| Ефес | Филемон | Иуда |
| Филиппой | Еврей | Илчлэлт |
| Колоссай | Иаков | |
| 1 Тесалоник | 1 Петр | |

5-р хэсэг

Библи Судлах Бэлтгэл

Хүн төрөлхтний түүхэнд болж өнгөрсөн томоохон үйл явдлуудыг мэдэх (3-р хэсэг), тэгэхдээ тэдгээрийг он дарааллаар нь (4-р хэсэг) мэдэх нь ямар чухал болох талаар бид өнгөрсөн хоёр хэсэгт танилцууллаа. Библийг судлах явцдаа хэн бүхний тавих ёстой нэг чухал асуулт бол “Хэзээ?” гэсэн асуулт юм. Энэ асуултад хариулахад тус болохуйц үндэс суурийг бид тавьж байна. Бид Библийг ойлгохын төлөө тэмүүлж явахдаа “унэний угийг зөв заах”-д (2 Тимот 2:15) тустай асуултуудын хариултыг байнга эрж хайж яваагаа олж хардаг. Бүх эргэлзээ, асуултаа Өөр уруу нь авч ирэхийг Бурхан биднээс хүсдэг билээ (Матай 7:7-8).

Библийн ишлэл тус бүрийн тухайд бидний тавих ёстой үндсэн асуултууд бол: **хэн, юу, хэзээ, хаана, яагаад, яаж?** гэсэн тун энгийн асуултууд байдаг. Харин эдгээр асуултын хариулт нь: Эзэн Есүс Христтэй илүү дотно, хувьчилсан харилцаатай болоход энэ асуулт ямар тустай вэ? (Филиппой 3:10), тэгснээр бид хэрхэн амьдрах вэ? (Иохан 7:17) гэсэн христэч амьдралтай холбоотой наад захын хоёр асуултыг заавал тооцоолсон байх ёстой.

A. Ишлэл бүрд тавих ёстой зургаан асуулт

1. Хэн?

Хэн, хэнд хандан ярьж байгааг мэдэх зорилгоор “хэн” гэсэн асуултыг бид тавьдаг. Үүний нэг жишээг бид Эхлэл 22:2-д Бурхан Абрахамаас цорын ганц хүүг нь Өөртөө тахил болгуулахаар шаардаж буй явдлаас харж болно. Энэ тохиолдолд Бурхан өөр хэн нэгэнд биш, зөвхөн Абрахамд хандаж ярьсан. Тиймээс, Үгийг сонсож байгаа бидний хувьд, Түүний энэ тушаалыг дагах шаардлагагүй юм.

2. Юу?

“Юу” гэсэн асуулт нь тухайн зүйлийн бодит байдлыг тодруулахад тустай байдаг. Илчлэлт 5-р бүлэгт Есүс Христийг “Хурга” гэсэн нь Түүнийг дөрвөн хөлтэй, сэгсгэр үстэй амьтан гэж хэлж буй хэрэг биш, харин Тэрээр нүглийг үүрэгч тахил болсон (Иохан 1:29) гэсэн “бодит байдлыг” хүүрнэж байна.

3. Хэзээ?

Тухайн багцлал чухам ямар цаг үеийн тухай өгүүлж байж болохыг “хэзээ” гэсэн асуулт бидэнд тодруулж өгдөг. Жишээ нь, Абрахам эцэг нэгтгэй, эх өөртэй дүү охинтойгоо (Сара) Мосегийн Хууль (ийм явдлыг хориглосон) өгөгдөхөөс өмнө гэрлэсэн гэдгийг уншигчид мэдэхээс нааш энэ гэрлэлтийг ёс бус явдал гэж тайлбарлах байсан байх. Хууль үгүй байхад (Ром 4:15) хувь хүний гэм нүглийн тухай асуудал яригддаггүй байсан учраас энэ тохиолдолд Абрахамын гэрлэлтийг нүгэл гэж үзэхгүй гэсэн дүгнэлтэд бид хүрдэг. “Хэзээ” гэсэн асуултын хариулт нь бидний ойлголтыг бүрэн гүйцэд болгоход маш чухал юм.

4. Хаана?

Тухайн багцлал ямар газар оронд, ямар соёл заншил дундаас бичигдсэн болохыг “хаана” гэсэн асуулт тодруулж өгдөг. Жишээ нь, “Иерусалим өөд” гэсэн хэллэг Библид олонтаа гардаг. Зарим улсад “өөд” гэсэн хэллэг нь хойд зүгт явах гэсэн санааг илэрхийлдэг аж. Харин Библид энэ нь зүг чигийг биш, харин дээшлэх гэсэн утгаар ордог. Есүс Галилаас “Иерусалим өөд” явахдаа үнэндээ өмнө зүгт явж байсан авч Тэрээр дээш, Эцэг уруугаа ойртож явсан юм.

5. Яагаад?

Хариулахад хамгийн хэцүү асуулт бол “яагаад” гэсэн асуулт байдаг. Бусад ишлэлүүдийг судлах явцад энэ асуултын хариулт тодорхой болох нь их байдаг. Исаиа 7:14-өөс “Үзэгтүн, Нэгэн онгон бүсгүй хүүхэдтэй болж, хүү төрүүлээд, Түүнийгээ ‘Иммануел’ гэж нэрлэнэ” гэж уншсан хэн боловч “яагаад онгон бүсгүйгээс” гэсэн асуултыг заавал тавьдаг. Ингэж асуусан хүмүүст хандан

“энэ бол Бурханы хүссэн арга зам” гэж хариулж болох ч энэ нь бүрэн гүйцэд хариулт болж чадахгүй.

Энэ асуултын хариултыг Ром 5-р бүлгээс олж харах боломжтой бөгөөд Адамын нүгэл хүн төрөлхтөнд нөлөөлсөн тухай энд өгүүлдэг. Анхны хүн Адамын гэм нүглээс болж бүх хүн нүгэлт мөн чанартай болсныг бид энэ бүлгээс уншдаг. Хэрэв эцэг нь жирийн хүн байсан бол Есүс ч бас нүгэлт мөн чанартай байх байсан. Энэ тохиолдолд “яагаад” гэсэн асуулт нь нүглийн золиос болсон Есүсийн мөн чанарыг харуулахад шийдвэрлэх ач холбогдолтой юм.

6. Яаж?

Энэ асуултад хариулах ч бас амаргүй. “Есүс усан дээгүүр яаж алхсан юм бол?” гэсэн асуултыг бид тавьж болох юм. Есүс Ариун Сүнсэнд найдсан учраас тийнхүү алхаж чадсан хэмээн хялбархан хариулчихаж болно (Лук 4:18). Түүнчлэн бид “Хүн төрөлхтөн сонголтоо өөрсдөө хийх эрх чөлөөтэй атал Бурхан түүхийг яаж хянадаг юм бол?” гэсэн асуулт гарч ирж болно. Энэ асуултад дээрхийн адил хялбархан хариулах боломжгүй бөгөөд энэ талаар бид дараа нь судалж үзэх болно.

Б. Mash чухал хоёр хувьчилсан асуулт

1. Эзэн Есүс Христгэй илүү ойр, хувьчилсан харилцаатай болоход энэ зүйл бидэнд хэрхэн туслах бол?

Бидний тавьж болох хамгийн чухал асуултуудын нэг нь энэ. Бурханы Үгийг судалж, түүгээр дамжуулан олж авсан мэдлэг маань итгэлтэй нэгдмэл байх ёстой (Еврей 11:6). Тэгснээр Эзэнтэй харилцах бидний харилцаа өсөх болно. Бурханы Үг алдаа мадаггүй бөгөөд түүнд найдаж болно гэдэгт бид итгэх ёстой. Үүний дүнд Эзэнтэй харилцах бидний харилцаа Түүний хайр дотор үндэслэж суурилагдах болно. Ийнхүү Эзэн ба бидний хоорондох харилцаа хүмүүний ойлгож мэдхээргүй тийм хэмжээнд хүрдэг. Ефес 3:14-19 ишлэлд элч Паул энэ тухай маш тодорхой бичсэн байdag:

Иймд би Эцэгийн өмнө өвдөг сөгдөжс, тэнгэр болон газар дахь бүхэл гэр бүлийг нэрлэдэг Түүнд залбирч байна. Тэр Өөрийн алдрын баялагийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглааж, та нар хайр дотор үндэслэж суурилаад, бүх ариун хүмүүсийн хамт тэр хайрын ямар өргөн, урт, ондор хийгээд гүн болохыг ойлгох болтугай. Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрэнд хүртэл бялхсан байх болтугай.

Хэрэв бид Бурханы Үгийг судлаадаа Түүнийг болон бусдыг хайрлах хайраар өсөхийн тулд биш (Mark 12:29-31), харин зүгээр л мэдлэг олж авахыг зорилгоо болгох аваас бид ихэрхүү нэгэн болж хувирна (1 Коринт 8:1). Теологийг хэнээс ч илүү мэддэг (2 Коринт 12:1-4) байсан элч Паул өөрийнхөө хамгийн агуу хүслийг “Түүнийг таньж мэдэх” (Филиппой 3:10) явдал гэж хэлсэн байдаг. Паул өмнө нь фарисай байхдаа эрдэм мэдлэгийг чухалчлан, түүнийг олж авахын төлөө явдаг байсан. Харин Христэд итгэснийхээ дараа тэрээр Амьд Бурхантай амьд харилцаатай байхыг эрхэмлэн, түүний төлөө амьдралаа зориулж эхэлсэн.

“Бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор осох”-ийн (2 Петр 3:18) тулд Бурханы амлалтуудыг эрэлхийлж, тэдгээрт найдах хэрэгтэй.

2. Тэгвэл бид хэрхэн амьдрах вэ?

Хэрэв бид судалж буй ишлэлүүдийнхээ утга санааг нэгэнт ойлгосон бол түүнийг бидний өдөр тутмын амьдралд хэрхэн хандуулж байгааг олж мэдэхийг хичээх ёстой. Үүний нэг гайхалтай жишээг Еврей 12:1-3 ишлэлээс харж болно. 1, 2-р ишлэлд:

Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй гэрчлэлийн үлэмж агуу үүлтэй тул аливаа саад тогтор ба биднийг тун амархан урхидааг нүглийг хажуу тийши нь тавьж,

өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе. Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглуулье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшигийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарти заларсан юм.

Еврей номыг бичигч энэ хоёр ишлэлд гүйлтийн уралдааныг дүрслэл болгон сонгон авчээ. Үзэгчдийн суудлаас хүмүүс тэрхүү уралдааныг үзэж байна (11-р бүлэгт гарч буй итгэлийн баатрууд). Хурд хүч шаардсан холын зайн энэхүү уралдаанд түрүүлэгчийг хүндэтгэлийн суудал хүлээж байна. Хурдыг нь сааруулж буй нэмэлт ачаагаа уралдаанд оролцогч авч хаяад, замдаа таарах саадыг зайлцуулна. Тэрээр хараагаа зөвхөн барианы зурvas уруу, өөрөөр хэлбэл, Өөрийнхөө замыг хэдийнээ дуусгаад, уралдаанд түрүүлсэн Нэгний (Есүс Христ) зогсож байгаа тэр газар уруу чиглүүлнэ. Уралдаанд түрүүлэгчийн хувьд, энэ бүхний эцэст амсах баяр баясгалан нь түүний туулсан ямар ч зовлонгоос илүү чухал байх болно.

Дараа нь 3-р ишлэлд бичигч дээрх хоёр ишлэлийг бидний амьдралд хандуулж байна:

Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Түүнийг санагтуун. Тэрээр Өөрийнх нь эсрэг нүгэлтийнүүдээс тийм эсэргүүцлийг тэвчсэн ажээ.

Христийн төлөө зовлон зүдгүүр туулж, өвдөж шаналж, ичгүүрт орж доромжлогдох үедээ Эзэний тухай бодож, Түүнээс урам зоригийг авах хэрэгтэй! *“Бидэнд байгаа нь бидний мөхөс байдлыг хуваалцааж чаддаггүй тэргүүн тахилч бус, харин нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн”* (Еврей 4:15) гэдгийг бид ухаарах учиртай.

В. Бид бүх асуултад хариулж чадахгүй бол яах вэ?

Асуултууд болон тэдгээрийн хариултууд мэдээж чухал. Гэхдээ Амьд Бурхантай харилцах бидний харилцаа итгэл дотор суурилагдсан гэдгийг бид мартах учиргүй (Ефес 2:8-9; Колоссай 2:6), тиймээс бид насан туршдаа эрж хайсан хариултаа бүгдийг нь олж авч чадахгүй. Гэвч, эцэст нь Бурхан бидний бүх асуултад хариулна гэж амласан (1 Коринт 13:12). Бүхий л амьдралын маань туршид биднийг хөтлөн дагуулах хангалттай мэдээлэл Сударт байдаг.

Хувийн Судлалд: 1-р бүлэг, 5-р хэсэг

- 1. Иеремиа 39:1-2 ишлэлийг уншаад, ишлэл тус бүр дээр тавих ёстой дараах зургаан үндсэн асуултад хариул.**

Хэн? =

Юй? =

Хэзээ? =

Хаана? =

Яагаад? =

Хэрхэн? =

- 2. Марк 12:29-31 ишлэлийг унш. Бид ямар дөрвөн зүйлээрээ Эзэнийг хайрлах ёстой вэ?**
- 3. Еврей 11:6 ба 1 Иохан 2:7-11 ишлэлийг унш. Христэч амьдралын хувьд хамгийн чухал хоёр зүйл юу вэ?**

Хоёрдугаар Бүлэг

Хуучин Гэрээний Тойм

Танилцуулга

Энэ хэсэг нь Хуучин болон Шинэ гэрээний номуудын товч тойм юм. Энэ нь зохиогчийн тухай, мөн бичигдсэн огноо, гол хүмүүс, сэдэв болон зорилго, тухайн номд Христийг хэрхэн дүрсэлсэн талаарх мэдээллийг уншигчдад өгөх зорилготой. Номын танилцуулга бүрд мөн номын агуулга багтсан.

Библийн ном тус бүрийн тойм нь Бурханы Угийг судалж буй оюутанд маш чухал бөгөөд оюутан Библийн гол үйл явдууд болон сэдвүүдийн талаар ерөнхий ойлголттой болж авна. Бид Бурханы Угийг судлахад илүү их цаг зарцуулах тусам энэ талаар улам илүү их мэддэг болох нь ойлгомжтой. Энэхүү судлалыг хийж буй арга барилын дагуу, илүү нарийвчилсан зүйлсийг зөв ойлгохын тулд бид эхлээд ерөнхий зураглалыг нь харах болно. Нэгдүгээр бүлэгт Библийг бүхэлд нь тоймчлон авч үзсэн. Харин энэ бүлгээс эхлээд бид судалгаагаа илүү нарийвчилж, ном тус бүрийг тоймчлон үзнэ.

Хуучин болон Шинэ гэрээг харьцуулах нь

Христ бол Библийн бүхий л номуудын далд утга болон найдвар юм. Бичээсийн бүх сэдэв нь Христ Өөрөө байсан гэдгийг Христ хэд хэдэн удаа онцлон хэлсэн байдаг:

1. Матай 5:17-д Тэрээр **“(Бичээсийг) хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин гүйцэлдүүлэхийн тулд Би ирсэн”** гэж хэлсэн.
2. Еммау орох замд дагалдагчидтайгаа алхаж явахдаа **“Тэр Мосгээс эхлэн бүх эш үзүүлэгчид, бүх Судар Өөрийнх нь тухай юу хэлснийг тэдэнд тайлбарлав”** хэмээн Лук бичсэн байдаг.
3. Тэр өдрийн орой, Эзэн арван дагалдагчтайгаа дараах зүйлийг ярьсныг Лук 24:44-47-д бичиж үлдээсэн байдаг: **“Тэгээд Тэр тэдэнд ингээж айлдас. Та нартай хамт байхдаа Миний ярьж байсан үг ийм болой. Энэ нь Мосгийн Хууль, Эш үзүүлэгчид болоод Дуулал дахь Миний тухай бичигдсэн бүхэн биелэгдэх ёстой’ гээд Судрыг ухааруулахын тулд тэдний оюун ухааныг нээв. Есүс тэдэнд хандаж, “Христ зөвлөн эдэлжс, гурав дахь одроо үхэгсдээс амилах болно. Иерусалимаас эхлээд бүх үндэстэнд Түүний нэрээр нүглийн училалын гэмшил тунхаглагдах ёстой” гэж бичигдсэн юм.”**
4. Иохан 5:39-40-д Есүс иудейчүүдтэй ярилцах үедээ **“Та нар Судруудыг судалдаг. Учир нь тэдгээрийн дотор мөнх амь бий гэж та нар боддог. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ. Та нар амьтай болохын тулд Над уруу ирэхийг хүсдэггүй”** хэмээн хэлсэн байдаг.

Үүн дээр нэмээд, Илчлэлт 19:10-д **“Есүсийн гэрчлэл бол эш үзүүлэгчийн сүns мөn”** гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эш үзүүлэгийн жинхэнэ мөн чанар, зорилго нь (энэ утгаар Бичээс бүхэлдээ) Есүс Христийг илчлэх явдал юм. Мэдээж хэрэг, хүмүүний уналт болон хэрэгцээнээс болж, Хуучин болон Шинэ гэрээний хоёулангийнх нь сэдэв нь Христ бөгөөд учир нь зөвхөн Түүгээр дамжуулан бид мөнхийн амийг болон бялхсан амьдралыг хоёуланг нь авч чадна (Иохан 10:10).

Хуучин гэрээ		
Хууль –Христийн төлөөх үндэс суурь Түүх –Христийн төлөөх бэлтгэл Яруу найраг–Христийн төлөөх хүсэл тэмүүлэл Эш үзүүлэл –Христийг хүлээх хүлээлт	Бэлтгэл болон Үндэс суурь	Хуучин Гэрээ нь Аврагч Мессия ирнэ, Тэрээр эш үзүүлэгч, тахилч, хаан бөгөөд хаанчлаасаа өмнө хүмүүний гэм нүглийн төлөө үхэх ёстой зовлонт Аврагч гэдгийг урьдаас харуулж, суурийг тавьсан.
Шинэ гэрээ		
Сайн мэдээний номууд	Илрэл	Удаан хүлээгдсэн Аврагч ирсэн тухай, Түүний бодгаль болон ажил үйлсийн тухай түүхийг өгүүлдэг
Үйлс	Өргөжилт	Ариун Сүнсний ажлаар дамжуулан, Үйлс ном нь Аврагчийн мэдээг тунхагладаг.
Захидлууд	Тайлбар болон Хэрэгжүүлэлт	Христийн ажил болон бодгалийн бүрэн утга учир, энэ нь дэлхий дээр Христийн элчин сайд болох Христитгэгчдийн амьдралд энэ нь хэрхэн нөлөөлөх тухай өгүүлдэг.
Илчлэлт	Төгсгөл	Эцсийн цаг үед болох үйт явдал, Эзэний буцан ирэх тухай, Түүний эцсийн цаг үед хаанчлал болон мөнхийн төлөв байдлын тухай урьдчилан өгүүлдэг.

1-р ХЭСЭГ

Хууль: Эхний Таван Ном

Библийн эхний таван номыг заримдаа Пентатух гэж нэрлэдэг бөгөөд энэ нь “таван ном” гэсэн утгатай. Эдгээрийг мөн хуулийн номууд гэж нэрлэдэг, учир нь Эзэн Мосегээр дамжуулан Израилийн ард түмэнд өгсөн хууль заавруудыг уг номд өгүүлсэн байдаг юм. Эдгээр номыг буюу Мосегийн үхлийн тухай өгүүлдэг Дэд хууль номын сүүлийн хэсгээс бусдыг нь Мose бичсэн. Энэ таван ном нь Бурханы сонгон авч, бий болгосон Израиль үндэстэнд Христ ирэх үндэс суурийг тавьдаг. Бурханы сонгогдсон ард түмний хувьд, Израиль нь Хуучин гэрээг сахигчид, амлалтын гэрээг хүлээн авагчид, Мессиагийн удам угсаа болсон юм (Ром 3:2, 9:1-5).

ЭХЛЭЛ

(Эхлэлүүдийн тухай ном)

Номын нэр болон зохиогч: Энэ номыг Мose бичсэн. Эхлэл гэдэг нэрийг Еврей Хуучин Гэрээний Грек орчуулга буюу Септуагинт (LXX)-аас авсан.

Бичигдсэн огноо: МЭӨ 1450–1410

Сэдэв болон зорилго: Эхлэл номыг өнгөцхөн уншихад л уг номын гол сэдэв нь ерөөл ба хараал гэдгийг харж болно. Итгэлтэй, мөн дуулгавартай байх аваас Еден цэцэрлэгт байсан шиг ерөөл хүргэж, харин дуулгаваргүй байвал хараалыг авах болно. Ном бүхэлдээ энэ сэдэвтэй холбоотой өрнөдөг. Гэхдээ өөр нэг үндсэн сэдэв бол Абрахам болон Абрахамын гэрээгээр дамжуулан, нэгэн үндэстнийг сонгосон сонголт юм. Абрахамаар дамжуулан Бурхан үндэстнүүдийг ерөөнө хэмээн амласан (Эхлэл 12:1-3, 15:1-21).

Эхлэл ном нь зөвхөн ганц эхлэлийн тухай өгүүлдэггүй, энэ бол эхлэлүүдийн тухай ном юм. Эхлэл номоос дараа дараагийн бүх илчлэлтүүдийн түүхэн эхлэлийг бид эндээс харж болно. Эхлэл номд Библийн бүхий л гол сэдвүүдийн эх үндэс тавигдсан. Энэ бол олон олон эхлэлүүдийн тухай ном. Эндээс бид хорвоо өртөнцийн болон эрэгтэй эмэгтэй хүний үүсэл, хүмүүний гэм нүглийн болон хүн төрөлхтний уналтын эхлэл, Бурханы авралын амлалтын эхлэл, Бурхан Израиль үндэстнийг Мессия Аврагчийн үндэс угсаа болгох онцгой зорилгынхоо төлөө сонгосон бөгөөд Бурханы сонгогдсон ард түмэн болох Израиль үндэстний үүсэл гарлыг ч гэсэн харж болно. Эхлэл номоос бид Адам, Ева хоёрын тухай, мөн соригч Сатаны тухай, Ноа болон Уерийн тухай, Абрахам, Исаак, Иаков, Иосеф болон түүний ах дүү нарын тухай сурч болно. Түүнчлэн гэрлэлт, гэр бүл, ажил хөдөлмөр, гэм нүгэл, аллага, цаазаар авах ял, өргөл тахил, үндэс язгуур, хэл яриа, иргэншил, Саббат, нэг дэлхийн засаглалын анхны оролдлого, Бабилонизм (Бабелийн цамхгийн үед үүсэж хөгжсөн шашин) зэргийн эхлэл ч мөн энд бий. Библи бол түүхэн илчлэлт юм. Энэ бол түүхэн дэх Бурханы ажил үйлсийн тэмдэглэл юм.

Эхлэл номд “эдгээр нь түүний үр удам болой” гэсэн хэлц үг хамгийн нийтлэг байдаг. Энэ хэлц нь тэнгэр газрын үүслээс эхлээд Израилийн бүх эзгүүдийн үеийг хүртэлх чухал хүмүүс болон үйл явдлуудын хооронд юу тохиолдсоныг уншигчдад мэдээлж, дараагийн хэсгийг танилцуулах зорилгоор нийт арван нэгэн удаа хэрэглэгдсэн.

Гол хүмүүс: Адам, Ева, Ноа, Абрахам, Сара, Исаак, Ребека, Есав, Иаков, Рахел, Иосеф

Эхлэл номд Христ эш үзүүлэгийн байдлаар илчлэгдсэн нь: Уналтын яг дараа, авралын амлалт эмэгтэйн үрд өгөгдсөн (3:15), гэхдээ үүний дараа Эхлэл номын туршид Мессиагийн харилцаа улам тодорхой гардаг: Сетийн үр удам (4:25), Шемийн удам угсаа (9:26), Абрахамын гэр бүл (12:3), Исаакийн үр (26:3), Иаковын хөвгүүд (46:3), Иудагийн овог (49:10).

Эхлэл номд Аврагчийг харуулдаг хэд хэдэн “билэгдэл” байдаг. **Адам** бол Христийн билэгдэл юм (Ром 5:14). Адам бол хуучин бүтээлийн тэргүүн, харин Христ бол шинэ сүнслэг бүтээлийн тэргүүн юм.

Абелын цусан өргөл нь Христ бидний төлөө нас барах болно гэдгийг хэлдэг. Кайн Абелыг алсан нь бас Христийн үхлийг дүрсэлсэн байж болох юм.

Хаан, тахилч **Мелхизедек** ч гэсэн бас Христийн билэгдэл байсан (Еврей 7:3).

Эцгийнхээ хамгийн хайртай хүү болох **Иосеф** ч гэсэн Христийг билэгдэж байв. Хэдийгээр ах дүү нар нь түүнээс урvasан хэдий ч тэр тэдний чөлөөлөлтийн эх сурвалж болсон юм.

Хувийн Судлалд: Агуулга

Гарчиг өгөөгүй байгаа хэсгүүдэд гарчиг өгөөрэй. Нэг хэсгийн нөгөө хэсэгтэйгээ холбогдох харилцааг өгч буй гарчигтаа харуулахыг хичээ. Жишээ нь: В хэсэгт дараах маягаар гарчиг өгч болох юм:

- 1) *Noa Yerit бэлтгэсэн нь*
- 2) *Noa Yerийн үед*
- 3) *Yer татарсан нь*
- 4) *Noatai хийсэн гэрээ*
- 5) *Noagийн гэр бүл*

1. Дөрвөн үйл явдал (1:1–11:32)

A.	Дэлхий болон хүн бүтээгдсэн нь (1:1–2:25)	
	1:1–2:3	2:4–25
B.	Хүний завхрал, Уналт (3:1–5:32)	
	3:1–24	4:1–24
B.	Хүний сүйрэл, Yep (6:1–9:29)	4:25–5:32
	6:1–22	8:1–22
	7:1–24	9:1–17
G.	Хүний тархалт, Улс үндэстнүүд (10:1–11:32)	
	10:1–32	11:1–9
		11:10–32

2. Дөрвөн хүн: Үндэстнийг сонгосон нь ба Чөлөөлөгчийг бэлтгэсэн нь (12:1–50:26)

A.	Абрахам (Израиль үндэстний болон итгэлийн эцэг) (12:1–23:20)	
	12:1–20	17:1–27
	13:1–18	18:1–33
	14:1–16	19:1–29
	14:17–21	19:30–38
	16:1–16	20:1–18
B.	Исаак (Амлалтын хайрт хүү) (24:1–26:35)	
	24:1–67	25:19–34
	25:1–11	26:1–17
	25:12–18	26:18–25
B.	Иаков (Башир арга ба ухаажсан нь) (27:1–36:43)	
	27:1–46	31:1–55
	28:1–22	32:1–23
	29:1–35	32:24–32
	30:1–43	33:1–20
G.	Иосеф (Зовлон ба Алдар хүнд) (37:1–50:26)	
	37:1–36	40:1–41:57
	38:1–30	42:1–45:28
	39:1–23	46:1–48:22
		49:1–50:21
		50:22–26

Египетээс Гарсан Нь

(Чөлөөлөлтийн ном)

Номын нэр болон зохиогч: Энэ номыг Моисе бичсэн. “Египетээс гарсан нь” гэдэг нь Грек Септуагинтын (LXX) орчуулагчдын өгсөн нэр бөгөөд *Ексадос* гэдэг грек үгээс гаралтай бөгөөд энэ үг нь “тарах” гэсэн утгатай.

Бичигдсэн огноо: МЭӨ 1450–1410

Сэдэв болон зорилго: Египетээс гарсан номд хоёр сэдэв зонхилдог: (1) Дээгүүр өнгөрөх баяр нь Чөлөөлөлтийн дүр зураг болох нь, мөн (2) Египетийн боолчлолоос чөлөөлөгдж, Египетээс гарсан болон Улаан тэнгисийг гаталсан нь.

Египетээс гарсан нь номд Бурханы сонгогдсон ард түмний Египетэд хоёр зуун жилийн турш өсөж үржсэний дараах түүх үргэлжилдэг бөгөөд тэднийг Египетээс чөлөөлөгдсөн үйл явдлыг болон Хууль өгөгдсөн тухай өгүүлдэг. Энд мөн Мосегийн мэндэлсэн тухай болон түүний түүх, ард түмнээ Египетийн боолчлолоос гарган, Амлагдсан газар буюу Канаан нутаг уруу удирдан дагуулуулахаар Бурханы Мосег дуудсан дуудлагын тухай гардаг. Арван гамшигийн гайхамшиг болон Дээгүүр өнгөрөх баярын хургаар ууган хүүхдүүдийг зольж авсан, мөн Улаан тэнгисийг гаталсан зэргээр дамжуулан Бурхан Өөрийн ард түмэндээ Тэр бол зөвхөн Египетийн Фараонаас илүү хүчирхэг нэгэн бус харин Хамгийн дээд Эзэн, ЯАВЭ, илчлэлт болон чөлөөлөлтийн Бурхан гэдгээ харуулсан юм.

Ард түмэн Улаан тэнгисийг гатлан, цөлд ирсний дараа Бурхан тэдэнд Өөрийн зөвт хуулийг өгч, тэднийг бүх ард түмний дундах Өөрийн эзэмшил, тахилчдын хаанчлал, бусад үндэстнүүдэд гэрчлэл болох ариун үндэстэн хэмээн тунхагласан (Египетээс гарсан нь 19:4-7). Энэ ариун хууль болон Арван хууль нь Бурханы ариун байдлыг илэрхийлж, тэдэнд Бурханыг болон бие биенээ хэрхэн хайрлахыг заасан, гэхдээ үүний зэрэгцээ, энэ нь ямар ч хүн Бурханы ариун байдалд хүрч чадахгүй, иймээс Бурханд ойртох арга зам хэрэгтэй бөгөөд энэ нь уччал юм гэдгийг бас харуулсан. Үүнийг хангахын тулд Асар, тахилууд болон Леви овгийн тахилчлал зэрэг нь өгөгдсөн.

Гол хүмүүс: Моисе, Аарон, Мириам, Фарао.

Египетээс гарсан ном дахь Христ: Хэдийгээр Египетээс гарсан нь номд Христийн талаарх шууд эш үзүүллэг байдаггүй боловч Аврагчийг билэгдсэн хэд хэдэн гайхалтай билэгдэл байдаг. Олон талаараа Моисе бол Христийн билэгдэл байсан. Дэд хууль 18:15-д Мосег эш үзүүлэгч гэдгийг хэлдэг бөгөөд энэ нь мөн л Христийг урьдаас билэгдэж байв. Тэр хоёрыг хоёуланг нь нялях байхад амь насанд нь аюул учирч байсан, мөн тэд бусдад үйлчлэх эрх мэдэлтэй гэдгийг тунхагласан, зуучлагч, хууль өгөгч, чөлөөлөгчийн ажил үүргийг гүйцэтгэсэн.

Дээгүүр өнгөрөх баяр нь Христийг Бурханы гэм зэмгүй Хурга гэдгийг билэгддэг тун онцгой билэгдэл юм (Иохан 1:29, 36; 1 Коринт 5:7).

Долоон баяр, баяр тус бүр Аврагчийн зарим талыг харуулдаг.

Египетээс гарсан үйл явдлыг Паул баптисмтай холбосон байдаг бөгөөд Христтэй хамт Түүний үхэл, оршуулга болон амилалт дотор бид хамт байдаг гэдгийг дүрслэн харуулдаг (1 Коринт 10:1-2; Ром 6:2-3).

Манина болон Ус нь хоёулаа Христийн дур зургийг харуулдаг (Иохан 6:31-35, 48-63; 1 Коринт 10:3-4).

Асар нь хийгдсэн материал, эдгээрийн өнгө, эд хогшил, байрлал, тэнд өргөгдөж буй тахилуудаараа Аврагчийг дүрслэн харуулдаг (Еврей 9:1–10:18).

Тэргүүн Тахилч нь Христийн бодгаль болон үйлчлэлийн сүүдэр зургийг хангалттай тодорхой харуулдаг (Еврей 4:14-16; 9:11-12, 24-28).

Хувийн Судлалд: Агуулга

1. Египетээс чөлөөлөгдсөн нь (1:1–18:27)

A. Боолчлолд (Хараат байдал) (1:1–12:32)

1:1-7	5:1-23	9:8-17
1:8-14	6:1-13	9:18-35
1:15-22	6:14-30	10:1-20
2:1-14	7:1-7	10:21-29
2:15-25	7:8-13	11:1-10
3:1-9	7:14-25	12:1-13
3:10-22	8:1-15	12:14-22
4:1-13	8:16-32	12:23-32
4:14-31	9:1-7	
Б. Боолчлороос гарсан нь (Цус болон Хүч чадлаар чөлөөлсөн нь) (12:33–14:31)		
12:33-41	13:1-16	14:1-12
12:42-51	13:17-22	14:13-31
В. Синаи хүртэл аялсан нь (Сургасан нь) (15:1–18:27)		
15:1-21	16:8-21	17:8-16
15:22-27	16:22-36	18:1-16
16:1-7	17:1-7	18:17-27

2. Бурханаас ирсэн илчлэлт (19:1–40:38)

A. Хууль өгөгдсөн нь (19:1–24:18)

19:1-17	22:1-15	23:20-33
19:18-25	22:16-31	24:1-18
20:1-26	23:1-9	
21:1-36	23:10-19	

Б. Асарын тогтолцоо (25:1–31:18)

25:1-9	26:31-37	29:31-46
25:10-22	27:1-8	30:1-21
25:23-30	27:9-21	30:22-33
25:31-40	28:1-43	30:34-38
26:1-14	29:1-9	31:1-11
26:15-30	29:10-30	31:12-18


В. Хуулийг зөрчсөн нь (32:1–34:35)

32:1-10	33:1-11	34:10-28
32:11-18	33:12-23	34:29-35
32:19-35	34:1-9	

Г. Асар барьсан нь (35:1–40:38)

35:1-9	36:8-38	39:1-43
35:10-19	37:1-29	40:1-33
35:20-35	38:1-20	40:34-38
36:1-7	38:21-31	

Асарын тойм зураг (нарийн хэмжээс биш)



Левит (Ариун байдлын тухай ном)

Номын нэр болон зохиогч: Энэ номыг Моисе бичсэн. Левит гэдэг нэрийг Септуагинтаас авсан бөгөөд “Левичүүдтэй холбоотой” гэсэн утгатай. Левичүүд нь ард түмэндээ үйлчлэхээр Бурханаар сонгогдсон тахилч нар байв. Левит ном нь Бурханд мөргөхөд зориулж, тахилч хүний хийх ёстой ажил үүргийн заавар бүхий Бурханаас өгөгдсөн олон хуулиуд багтсан байдаг.

Бичигдсэн огноо: МЭӨ 1450–1410

Сэдэв болон зорилго: Левит 11:45-д, “*Би ариун учир та нар ариун байх ёстой*” гэсэн байдаг. Левит номд гардаг удирдамж зааварчилгаа нь Израильчууд ариун ард түмнийхээ хувьд Бурханы өмнө хэрхэн алхахыг харуулж байв. Левичүүд нь Израильд (1) Бурханд хэрхэн мөргөж, Түүнтэй хамт хэрхэн алхах талаар, (2) тахилчдын хаанчлал байхаар дуудагдсан дуудлагаа Израиль үндэстэн хэрхэн биелүүлэхийг заах үүрэгтэй байсан. Левит номын хамгийн гол сэдэв бол **арийн байдал** юм. Ариусгал бол хүнийг ариун болгож буй үйл явц билээ. Тахилчийн зуучлалаар дамжуулан, тахилын үндсэн дээр л ариун Бурханд ойртон очих боломжтой.

Гол хүмүүс: Моисе болон Аарон

Левит ном дахь Христ: Египетээс гарсан нь номтой адил Левит номд ч гэсэн Христийг билэгдсэн хэд хэдэн билэгдэл байдаг.

Таван өргөлүүд, эдгээр нь бүгд Христийн Эцэгтээ бүрэн захирагддаг, гэм нүгэлгүй амьдрал дахь Түүний бодгаль болон ажлыг билэгддэг бөгөөд бид Бурхантай нөхөрлөх боломжтой гэдгийг харуулдаг.

Тэргүүн тахилч бол Левит ном дахь Христийн хамгийн тод билэгдэл юм.

Долоон баяр нь бас Аврагчийг билэгддэг бөгөөд Түүний төгс бодгаль, орлуулгын тахил болсныг, үхлээс амилсныг, мөн Түүний эвлэрүүлийн ажлын тухай бидэнд заадаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Тахилын хуулиуд (1:1–17:16)

A. Бурханд ойртон очиход зориулж (1:1–7:38)

1:1-17	4:1-35	6:8-30
2:1-16	5:1-19	7:1-38
3:1-17	6:1-7	

Б.	Тахилчдад зориулж (8:1–10:20)	
	8:1-36	9:15-24
	9:1-14	10:1-20
В.	Цэвэр зүйлсийн талаар (11:1–15:33)	
	11:1-12	13:1-59
	11:13-47	14:1-32
	12:1-8	14:33-57
Г.	Үндэсний Эвлэрүүллийн талаар (16:1–17:16)	
	16:1-28	16:29-34
		17:1-16

2. Ариусгалын хуулиуд (18:1–27:34)

A.	Бурханы ард түмэнд зориулж (18:1–20:27)	
	18:1-30	19:9-37
	19:1-8	20:1-27
B.	Бурханы тахилчдад зориулж (21:1–22:33)	
	21:1-24	22:1-16
		22:17-33
B.	Мөргөлд (23:1–24:23)	
	23:1-25	24:1-16
	23:26-44	24:17-23
G.	Канаан газарт (25:1–26:46)	
	25:1-22	25:35-46
	25:23-34	25:47-55
D.	Тангаргийн талаар (27:1-34)	
	27:1-13	27:14-34

Тооллого (Цөлд тэнүүчилсэн нь)

Номын нэр болон зохиогч: Үүнийг Мосе бичсэн. Тооллого гэдэг нэр нь 1 болон 26-р бүлэгт Израилийн ард түмнийг тоолсон хоёр удаагийн тооллогоор нэрлэсэн бөгөөд эхний удаад Синаи уландаа, хоёр дахь нь Моабын талд тоолсон.

Бичигдсэн огноо: МЭӨ 1450–1410

Сэдэв болон зорилго: Хэдийгээр Тооллого номыг ард түмнийг тоолсон тооллого дээр үндэслэн нэрлэсэн боловч дөчөөд жил цөлд тэнүүчилсэн түүхийг голлон өгүүлдэг. Арван нэгхэн өдөр үргэлжлэх ёстой байсан аялал хүмүүсийн дуулгаваргүй, мөн итгэлгүй байдлаас болж зовлон зүдгүүрийн 38 жил болон хувирсан. Бурханы амлалтад итгэх итгэлийг итгэлгүй байдалтай хослуулахын үр дагаврыг Тооллого номд харуулдаг (Еврей 3:16-4:2). Түүнчлэн Тооллого ном нь амьдрал “цөл” шиг байсан ч гэсэн Бурханы хүмүүс тэр нөхцөл байдалдаа үлдэх ёсгүй гэдгийг бидэнд заадаг. Бидний хийсэн сонголтоос шалтгаалан амьдралын маань чиг хандлага тодорхойлогдож байдаг. Хожим Иошуа номд үүнийг тайлбарлах болно.

Тооллого номын турш гардаг өөр нэг чухал сэдэв бол Бурхан ард түмнээ үргэлж харж халамжилж байгаа явдал юм. Тэдний урвалт, итгэлгүй байдлыг үл харгалзан Бурхан хэрэгцээг нь дахин дахин гайхамшигтайгаар хангаж байсан. Тэр тэднийг ус, манна, бөднөөр хангасан. Хэдийгээр хүмүүс Түүний эсрэг тэрсэлж, гомдоллож, углэж байсан боловч Тэр училж, үргэлж хайрласаар байсан юм.

Гол хүмүүс: Мосе, Аарон, Мириам, Иошуа, Калеб, Балак

Тооллого ном дахь Христ: Христийг болон Түүний цовдлогдолтыг хамгийн тодорхой дүрсэлсэн зүйл бол дээш өргөсөн мөгий гэж хэлж болох юм (Тооллого 21:4-9-ийг Иохан 3:14-тэй харьцуул).

Хүмүүсийн цангааг тайлагч хад нь Христийн билэгдэл юм (1 Коринт 10:4).

Өдөр бүрийн **манна** нь Христ тэнгэрээс доош бууж ирсэн талх гэдгийг зураглан харуулдаг (Иохан 6:31-33).

Үүлэн болон галан багана нь Христийн удирдамжийг, хорогдох хотууд нь Христ бол шүүлтээс бидний хоргодах газар гэдгийг харуулдаг. Эцэст нь, **улаан охин бяруу** нь Христийн билэгдэл юм (Тооллого 19).

Хувийн Судлалд: Агуулга

1. Синаи ууланд бэлтгэгдсэн нь (Анхны үе) (1:1–10:36)

A. Байршил ба ард түмнийг тоолсон нь (1:1–4:49)

1:1-46	3:1-24	4:1-20
1:47-54	3:25-39	4:21-28
2:1-34	3:40-51	4:29-49
Б. Бурханы горимууд ба ард түмнийг ариутгасан нь (5:1–9:14)		
5:1-10	6:22-27	8:5-22
5:11-31	7:1-89	8:23-26
6:1-21	8:1-4	9:1-14
В. Амласан газар уруу аялсан нь (9:15–10:36)		
9:15-23	10:1-10	10:11-36

2. Анхны үеийнхний уналт (11:1–25:18)

A. Замд явж байхдаа сэтгэл дундуур байсан нь (11:1–12:16)

11:1-9	11:16-30	12:1-16
11:10-15	11:31-35	

B. Кадеш-Барнеад итгэлгүй байдал гаргасан нь (13:1–14:45)

13:1-24	14:1-10	14:20-38
13:25-33	14:11-19	14:39-45

B. Эзэний сахилгажуулалт (15:1–25:18)

15:1-13	18:8-32	21:21-35
15:14-31	19:1-22	22:1-21
15:32-41	20:1-7	22:22-41
16:1-40	20:8-22	23:1-30
16:41-50	20:23-29	24:1-25
17:1-13	21:1-5	25:1-9
18:1-7	21:6-20	25:10-18

3. Шинэ үеийг бэлтгэсэн нь (26:1–36:13)

A. Израилийг дахин зохион байгуулсан нь (26:1–27:23)

26:1-65	27:1-14	27:15-23
---------	---------	----------

B. Өргөл болон тангараг өргөх журам (28:1–30:16)

28:1-31	29:1-40	30:1-16
---------	---------	---------

B. Газар нутгийг бүсчилсэн нь (31:1–36:13)

31:1-24	33:1-49	35:1-5
31:25-54	33:50-56	35:6-34
32:1-42	34:1-29	36:1-13

ДЭД ХУУЛЬ (Хуулийг давтсан нь)

Номын нэр болон зохиогч: Энэ номыг Мосе бичсэн. Англи нэрийг Септуагинтаас авсан бөгөөд “хоёр дахь удаа хууль өгөгдсөн нь” гэсэн утгатай. Энэ нь 17:18-ын буруу орчуулгаас үүдэлтэй бөгөөд уг нь “энэ хуулийн хуулбар” гэж орчуулагдах ёстой байсан. Дэд хууль нь үнэндээ хоёр дахь хууль биш харин Синаи ууланд анх өгөгдсөн тэр хуулийг давтаж, мөн өргөжүүлсэн юм.

Бичигдсэн огноо: МЭӨ 1410

Сэдэв болон зорилго: *Та нар мартахгүйн тулд өөрсдийгөө анхааралтай хар.* Цөлд дөчин жил тэнүүчилсний дараа Израильчууд амласан газар нутагт орохын өмнөхөн ирээд байв. Тийш орохоос нь өмнө бусад үндэстнүүдийн хувьд тахилчдын хаанчлал, Бурханы ариун үндэстэн гэсэн үргээ билүүлж, амласан нутагт үлдэх нь нэн чухал зүйл болох Бурханы ариун хуулийн талаар, мөн тэдний төлөө Бурханы хийсэн бүгдийн тухай тэдэнд дахин сануулах (Бурхан юу хийснийг болон тэд хэн байсан гэдгээ мартахгүйн тулд) шаардлагатай байв. (Дэд хууль 4:1-8). Энэ сэдэв буюу зорилгын нэг хэсэг нь Бурханыг хайлаж, дуулгавартай дагахыг үр хүүхдүүдээ зааж сургах нь чухал шаардлагатай гэдгийг онцолсон явдал юм.

Дэд хууль ном нь Израильчуудтай хийсэн Бурханы гэрээний шинэчлэлт (29-р бүлэг), Иошуаг шинэ удирдагчаар томилсон (31-р бүлэг) болон Мосегийн үхлээр (34-р бүлэг) төгсдөг.

Гол хүмүүс: Моше болон Иошуа

Дэд хууль ном дахь Христ: 18:15-д Мосегийн тухай хэлсэн үг нь Христийн хамгийн тодорхой дүр зургуудын нэг юм. Энд “**ЭЗЭН Бурхан чинь чиний төлөө та нарын дундаас, ах дүү нарын чинь дотроос над шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргаж ирнэ. Та нар түүнийг сонсогтун.**” хэмээн хэлсэн. Түүнчлэн Моше Христийн билэгдэл байсан бөгөөд Христээс гадна эш үзүүлэгч (34:10-12), тахилч (Египетээс гарсан нь 32:31-35), хааны (хэдийгээр Моше хаан байгаагүй боловч Израилийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байсан 33:4-5) үүргийг гурвууланг нь хийж байсан цорын ганц хүн юм.²

Хувийн Судлалд: Агуулга

1. Танилцуулга (1:1-5)

2. Түүхийг давтан өгүүлсэн нь (1:6-4:43)

1:6-18	2:26-37	4:1-43
1:19-46	3:1-17	
2:1-25	3:18-29	

3. Хуулийг давтан өгүүлсэн нь (4:44-5:33)

4:44-49	5:1-21	5:22-33
---------	--------	---------

4. Хуулийн хэрэгжилт (6:1-11:32)

6:1-25	9:1-29	11:1-32
7:1-26	10:1-11	
8:1-20	10:12-22	

5. Нэмэлт хуулиуд (12:1-26:19)

12:1-32	18:9-22	23:1-25
13:1-18	19:1-13	24:1-5
14:1-29	19:14-21	24:6-22
15:1-23	20:1-20	25:1-19
16:1-22	21:1-23	26:1-19
17:1-20	22:1-12	
18:1-8	22:13-20	

6. Гэрээг хүлээн авсан нь (27:1-30:20)

27:1-26	28:15-68	30:1-14
28:1-14	29:1-29	30:15-20

7. Удирдагч солигдсон нь (31:1-34:12)

31:1-13
31:14-30

32:1-52
33:1-29

34:1-12

Дүгнэлт: Цээжлэх сэдвүүд

Эхлэл	Үндэстнийг сонгосон нь
Египетээс гарсан нь	Үндэстнийг чөлөөлсөн нь
Левит	Үндэстнийг ариусгасан нь
Тооллого	Үндэстнийг чиглүүлсэн нь
Дэд хууль	Үндэстэнд зааж сургасан нь

2-р хэсэг

Түүхэн Номууд

Хуучин гэрээний хэсэг тус бүр Христийн бодгалийн талаар онцгойлон анхаарсан байдаг. Иошуагаас Естер ном хүртэл бид Израилийн ард түмний түүхтэй холбоотой хоёр дахь бүлэг номыг үзэх гэж байна. Эдгээр ном нь газар нутгийг эзэмшиж авахаас эхлээд итгэлгүй, дуулгаваргүй байдлаасаа болж хоёр ч удаа цөллөгт явж, газар нутгаа алдсан үеийг хүртэлх Израиль үндэстний амьдралыг хамардаг. Израилийн түүхийн 800-гаад жилийг хамарсан эдгээр арван хоёр ном нь Канааныг булаан авч эзэмшсэн тухай, мөн шүүгчдийн захирагаа, хаант улс бий болсон, Израиль Умард болон Өмнөд хаант улс болон хуваагдсан, Умард хаант улс Ассирид эзлэгдэж, Өмнөд хаант улс Вавилон уруу цөлөгдсөн, мөн Нехемиа болон Езра зэрэг хүмүүсийн удирдлага дор Иерусалимд буцаж ирсэн тухай өгүүлдэг.

Эдгээр номууд Мессия Христийн ирэлтэд биднийг бэлтгэдэг бөгөөд дараах зүйлсийг өгүүлдэг:

Түүхэн номууд: Христийн төлөөх бэлтгэл ³		
Иошуа Шүүгчид Рут	Үндэстэн газар нутгийг эзлэн авч, эзэмшсэн нь	Бурханаар удирдуулсан нь: Эдгээр ном нь Израиль Бурханаар удирдуулж байсан үеийг хамардаг (МЭӨ 1405 - 1043)
1 Самуел 2 Самуел 1 Хаад 1-10 1 Хаад 11-22 2 Хаад 1-17 2 Хаад 18-25 1 Шастир 2 Шастир	Үндэстэн тогтвожсон нь Үндэстэн өргөжсөн нь Үндэстэн алдаршсан нь Үндэстэн хуваагдсан нь Хойд хаант улсын доройтол Өмнөд хаант улсыг албадан гаргасан нь Сүмийн бэлтгэл Сүмийг устгасан нь	Хаант улс: Эдгээр ном нь Израилийн хаант улс байгуулагдсанаас эхлээд МЭӨ 586 онд үндэстэн нуран унасан хүртэлх түүхийг өгүүлдэг.
Езра Нехемиа Естер	Сүмийг дахин босгосон нь Иерусалим дахин барьсан нь Ард түмнээ хамгаалсан нь	Сэргээн босголт: Эдгээр ном нь цөллөгт 70 жилийг өнгөрүүлсний дараа үлдэгсэд өөрсдийн газар нутагт эргэн ирж байгаа тухай өгүүлдэг. (МЭӨ 605 - 536)

Иошуа (Эзэмшил ба булаан эзлэлт)

Номын нэр болон зохиогч: Энэ номыг Иошуа бичсэн. Хуучин гэрээний эхний таван номоос ялгаатай нь уг номын гол баатар Мосегийн зарц Иошуагийн нэрээр энэ номыг нэрлэсэн нь ихээхэн тохиромжтой нэр болсон. Иошуагийн жинхэнэ нэр нь Хосеа (Тооллого 13:8, Дэд хууль 32:44) бөгөөд энэ нь “аврал” гэсэн утгатай. Харин цөлд тэнүүчилж байх үед Моис түүний нэрийг ЕХОШУА буюу “ЭЗЭН бол аврал” гэсэн утгатай нэр болгож өөрчилсөн (Тооллого 13:16). Иошуа гэдэг нь Ехошуагийн товчилсон хэлбэр юм. Энэ нь Иошуад, туршуулуудад, дайснаа ялж, газар нутгийг нь эзэмшин авсан ард түмэнд энэ бүх зүйлс хүний хүч чадал, мэргэн ухаан эсвэл ур чадвараар болж бус, харин Эзэний хүч чадлаар хийгдэж байгаа юм гэдгийг сануулж, эш үзүүллэгийн хэлбэрээр урьдчилан хэлсэн хэрэг юм. Иошуа хэдийгээр дэлхийн түүхэн дэх цэргийн агуу стратегичдын нэг байсан боловч түүний мэргэн ухаан, амжилт зэрэг нь Эзэнээс ирсэн бөгөөд зөвхөн Эзэн л бидний Аврал гэсэн утгаар энэ номыг Иошуа гэж нэрлэсэн. Израильд ялалтыг өгч, тэдний дайснуудыг эзлэн, газар нутгийг нь израильчуудад өгөгч нь зөвхөн Эзэн Өөрөө билээ.

Бичигдсэн огноо: МЭӨ 1400–1370

Сэдэв болон зорилго: Амлагдсан газрыг булаан авч, хуваан эзэмшсэн зэрэг нь Иошуа номын гол зорилго болон сэдэв юм. Иошуа ном нь Бурхан Өөрийнхөө амлалтад итгэмжтэй гэдгийг, Тэрээр амласан зүйл

Израилийн төлөө гарцаагүй үйлддэг гэдгийг харуулдаг (Эхлэл 15:18-ыг Иошуа 1:2-6; 21:43-45-тай харьцуул). Боломжгүй бүхий л зүйлсийн эсрэг Бурхан Өөрийн ард түмнийхээ төлөө хөндлөнгөөс оролцсон гэдгийг харуулахаар тусгайлан сонгож авсан үйл явдлуудыг Иошуа номд бичсэн байдаг. Бурханы амлалтын биелэлт буюу Абрахам Сара нарт Исаак төрсөн үйл явдлаас эхлээд амлагдсан газар нутгийг бэхлэгдсэн дөчин хотын хамт эзлэн авсан зэрэг нь Бурханы ажил байсан бөгөөд хүн хичнээн хичээгээд ч хийж үл чадах зүйлс байсан юм (Ром 4).

Гол хүмүүс: Иошуа, Рахаб, Калеб

Иошуа ном дахь Христ: Хэдийгээр энд Христийн Мессиатай холбоотой шууд эш үзүүллэг байдаггүй боловч Аврагчийг билэгдсэн хэд хэдэн зүйлс байдаг. Иошуа маш чухал хоёр байдлаар Христийн билэгдэл болдог. Нэгд, түүний нэр Ешуа нь, “ЭЗЭН бол аврал” гэсэн утга бүхий Ехошуа гэдгийн товчилсон хэлбэр бөгөөд энэ нь грекээр Есүс гэдэгтэй адилах юм. Үйлс 7:45-д Иошуаг Есүс гэдэг нэрээр нэрлэсэн байдаг. Хоёрд, Иошуа нь Израилийг удирдан Канаан газар уруу буюу амлагдсан эзэмшил болох “амралт” уруу удирдан орсноороо Христийн билэгдэл болдог (Еврей 4:8-тай харьцуул). Энэ нь бид Христ дотор итгэлээр орж амрах тэрхүү амралтын зураглал юм. Иошуа нь үнэхээр “олон хөвгүүдийг алдар уруу” (Еврей 2:9-10) удирдан дагуулах Аврагчийн урьдчилсан дүр зураг болдог. Иошуа бас 5:13-15-д Эзэний дайчдын жанжинтай уулсан. Энэ нь хүн болж мэндлэхээс нь өмнөх Христийн дүр төрх (үүнийг “Христофани” гэж нэрлэдэг) байсан нь гарцаагүй бөгөөд Тэрээр Иошуад аль нэг талд нь орох гэж биш, харин жанжин нь болж удирдахаар ирсэн гэдгээ хэлсэн. Эцэст нь, Рахабын час улаан уяа нь (2:21) Христийн үхэл болон цусаар дамжуулан аврал ирэх болно гэдгийг дүрслэн өгүүлдэг (Еврей 9:19-22-той харьцуул). Энэ харь үндэстний янхан эмэгтэй Бурханы агуу ажлуудыг сонсоод, туршуулуудыг нууж, ингэснээрээ Иерихо хотыг устахад аврагдаж үлдсэн бөгөөд Христийн утийн бичигт нэр нь бичигдсэн юм (Матай 1:5).

Хувийн Судлалд: Агуулга

1. Канаан уруу довтолсон нь (1:1–5:12)

1:1-9	2:1-24	4:1-24
1:10-18	3:1-17	5:1-12

2. Канааныг эзэлж авсан нь (5:13–12:24)

5:13-15	8:1-35	10:29-43
6:1-27	9:1-27	11:1-23
7:1-15	10:1-15	12:1-24
7:16-26	10:16-28	

3. Канааныг хуваарилсан нь (13:1–21:45)

13:1-33	17:1-18	20:1-9
14:1-15	18:1-10	21:1-45
15:1-63	18:11-28	
16:1-10	19:1-51	

4. Дүгнэлт (22:1–24:33)

22:1-34	24:1-28
23:1-16	24:29-33

Шүүгчид

(Урвалт, шүүлт болон чөлөөлөлтийн тойрог)

Номын нэр болон зохиогч: Уламжлалт үзлээр бол энэ номыг Самуел бичсэн гэж үздэг, гэхдээ үнэндээ бол зохиогч нь тодорхойгүй. Шүүгчдийн үеийн тэмдэглэл бүртгэлээс заримыг нь нэгтгэн үүнийг бичсэн байж болох юм. Натан, Гад нар шиг эш үзүүлэгчид уг материалыг хянахад оролцсон бололтой (1 Шастир 29:29).

Еврей нэр нь Шофетим бөгөөд “шүүгчид, захирагчид, чөлөөлөгчид эсвэл аврагчид” гэсэн утгатай. Шофет нь зөвхөн шударга ёсыг авч явах, зөрчил маргааныг шийдвэрлэх гэсэн утгатай биш, энэ нь бас “чөлөөлж, аврах” гэсэн утгатай. Шүүгчид нь эхлээд ард түмнээ чөлөөлж, дараа нь тэднийг удирдан захиrch, шударга ёсыг тогтоодог.⁴

Уг номыг шүүгчид гэж нэрлэгддэг удирдагчдын нэрээр нэрлэгдсэн бөгөөд Бурхан Израилийг дарлагчдаас нь чөлөөлөхийн тулд тэднийг босгосон юм. 2:16-д “*Тэгээд Эзэн шүүгчдийг босгож, тэднийг тонуулчдын гарас аврав*” гэсэн нь номын нэрийг хамгийн тод илэрхийлдэг. Гэхдээ, үнэндээ Бурхан Израилийн Шүүгч, Чөлөөлөгч байсан, учир нь Бурхан Өөрөө эхлээд Израилийн удаа дараагийн (итгэлээсээ урвах) урвалтаас болж тэнгэрлэг дасгалжуулалт болгон өөр үндэстэнд дарлагдахыг зөвшөөрч, дараа нь Израиль үндэстэн гэмшиж, тусламж гүйн хашхирсаны дараа тэднийг чөлөөлөхийн тулд шүүгчдийг босгодог байсан юм (11:27; 8:23-тай харьцуул).

Бичигдсэн огноо: МЭӨ 1050–1000

Сэдэв болон зорилго: Иошуа болон шүүгчид номууд нь хоорондоо маш их ялгаатай. Израиль ялалтын баяр хөөрөөс ялагдлын зовлон шаналал уруу, эрх чөлөөнөөс дарлал уруу, хөгжил дэвшлээс амралт уруу шилжсэн. Тэгвэл яагаад энэ номыг бичих болов?

Түүхийн хувьд, Шүүгчид ном нь Иошуагийн цаг үеэс эш үзүүлэгч Самуелын цаг үе болон Саул, Давид нарын удирдлага дор хаант улс эхлэх үе хүртэлх хугацааны хооронд гүүр болдог. Энд доройтол, дарлал, залбирал болон чөлөөлөлт гэсэн түүхэн тойргуудыг бичсэн. Үүнийг бичсэнээр, энэ нь Израильд хаант улс хэрэгтэй болсны тайлбар, учир шалтгааныг гаргаж өгдөг. Хүн бүр өөрийн нүдэнд зөв хэмээн үзсэнээ үйлдэж байсан тул (21:25), үндэстэнд зөвт хаан хэрэгтэй байлаа.

Онолын хувьд, Шүүгчид ном нь хэд хэдэн чухал үнэнд бидний анхаарлыг хандуулдаг. Бурхан Дэд хууль номд сануулсанчлан, дуулгавартай байдал ерөөлийг авчирдаг, харин дуулгаваргүй байдлын үр дагаварт Бурханы сахилгажуулалт болон дарлал зовлон ирдэг. Гэхдээ Шүүгчид ном нь бас хүмүүс Бурхан уруу эргэж, Түүнд хашхирч гэмших үед энэрэлт нигүүлсэнгүй Бурхан тэдэнд хариулж, чөлөөлдөг гэдгийг хэлдэг. Хүмүүс Бурханаас хөндийрч, үүнээс болж тэнгэрлэг сахилгажуулалтын үр дүн болох дарлал хавчлага ирэн, үүний дараа хүмүүс гэмшин залбирч, дараа нь Бурхан ард түмнийг чөлөөлөх шүүгчдийг босгож байгаа энэхүү тойргийг тайлбарлах маягаар Шүүгчид номын сэдэв өрнөдөг.

Гол хүмүүс: Шүүгч Отниел, Ехүд, Шамгар, Дебора ба Барак, Гидеон, Тола ба Жаир, Иефта, Ибзан, Елон ба Абдон, Самсон. Хамгийн алдартай нь Дебора, Гидеон, Самсон.

Шүүгчид ном дахь Христ: Шүүгч нэг бүр захирагч-чөлөөлөгчийн үүрэгтэй байсан бөгөөд тэд Христийн ажлын Аврагч ба Эзэн, Зөвт бөгөөд Чөлөөлөгч Хaan гэдэг дүр зургийг харуулдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Доройтол – Оршил: Шүүгчдийн үеийн учир шалтгаан (1:1–3:8)

1:1-26	2:1-5	2:11-23
1:27-36	2:6-10	3:1-8

2. Чөлөөлөлт – Шүүгчдийн үеийн түүх болон удирдлага (3:9–16:31)

3:9-14	7:19-25	12:8-10
3:15-30	8:1-27	12:11-12
3:31	8:28-35	12:13-15
4:1-24	9:1-22	13:1-25
5:1-31	9:23-57	14:1-11
6:1-8	10:1-2	14:12-20
6:9-27	10:3-18	15:1-20

6:28-35	11:1-28	16:1-17
6:36-40	11:29-40	16:18-27
7:1-18	12:1-7	16:28-31
3. Хорон муу байдал – Итгэлээсээ урвах ба эмх замбараагүй байдал: Шүүгчийн үеийн сүйрэл (17:1-21:25)		
17:1-13	20:1-17	21:8-25
18:1-31	20:18-48	
19:1-30	21:1-7	

Рут (Шүүгчид номын нэмэлт)

Номын нэр болон зохиогч: Шүүгчид номын нэгэн адил энэ номын зохиогч нь тодорхой биш, гэхдээ иудейн уламжлалаар бол Самуэлыг бичсэн гэж үздэг. Рут номын нэрийг номын гол дүрийн баатар, Аврагчийн угийн бичигт бичигдсэн (Матай 1:5), Давидын элэнц эх болох залуухан Моаб эмэгтэйн нэрээр нэрлэсэн. Библи дэх эмэгтэй хүний нэрээр нэрлэгдсэн өөр нэг ном нь Естер ном юм.

Бичигдсэн огноо: МЭӨ 1050

Сэдэв болон зорилго: Рут ном нь өлсгөлөнгийн үед Израилиас Моаб уруу нүүсэн нэгэн гэр бүлийн түүх юм. Тэнд байх үед нөхөр, хоёр хүү нь нас барж, эмэгтэй (Наоми) хоёр бэрийн (Орфа, Рут) хамт үлддэг. Наоми Израиль уруу буцаж явахаар шийдэхэд Рут түүнтэй хамт явахаар болов. Тэднийг Израильд буцаж ирэх үед тэдний хамаатны хүн болох Бааз тэдэнд тусалдаг. Эцэст нь Рут Баазтай гэрлэдэг.

Шүүгчид номын харанхуй өдрүүдийн дунд Рут гялалзах эрдэнэ мэт гэрэлтдэг. Рут ном бол эмх замбараагүй, хувшинаасан байдал, завхрал ноёлсон өдрүүдэд дэх чин үнэнч сэтгэл болон хайрын түүх юм. Үүгээрээ Рут нь итгэлээсээ урваж, завхарсан хүмүүсийн дунд итгэл, дуулгавартай байдлын зэрэг талыг харуулдаг бөгөөд ийм итгэл нь хэрхэн ереөгддөг болохыг харуулдаг. Түүнчлэн Рут нь Мессиагийн угийн бичигт дурдагдаг Давид хааны өвөг дээдсийн дундах нэгэн чухал холбоос болдог. Рут номын өөр нэг зорилго бол Хамаатан - Золин авагчийн талаарх үнэнийг болон иймэрхүү доройтол завхралын үед ч гэсэн бурханлаг хүмүүс үлдсэн гэдгийг, итгэлээрээ Бурхантай хамт алхагч тэдгээр хүмүүст хандах Бурханы итгэмжтэй байдал зэргийг зураглан харуулах явдал байв. Рут харь үндэстэн байсан бөгөөд уг ном харь үндэстнүүдийг Бурханы гэр бүлд авчрах гэсэн Бурханы хүслийг харуулдаг.

Бурханы хайр Моаб эмэгтэй дээр ингэж илэрхий харагдаж байгаа нь үнэхээр гайхалтай санагдаж байж болох юм. Гэхдээ Рут Израиль хүнтэй гэрлэж, ганцаардсан хадам эхдээ өөрийгөө бүрэн зориулах зэргээр Израиль гэр бүлд чин сэтгэлээсээ үнэнч хандаж байсан нь түүнийг Израилийн жинхэнэ охин, Давидын өвөг дээдэс байх зохистой нэгэн гэдгийг харуулж байна. Тэрээр хүн цусан төрлөөр бус, харин “итгэлийн дуулгавартай байдлаар” (Ром 1:5) дамжуулан Бурханы хүсэлд өөрийн амьдралыг зориулснаар Бурханы ирэх хаанчлалыг хуваалцагч болдог гэсэн үнэний жишээ юм. Рут Давидын угийн бичигт бичигдсэн нь Давидын удмын Хүүгийн хаанчлалд бүх үндэстэн байх болно гэсэн утгыг илэрхийлдэг.⁵

Гол хүмүүс: Рут, Наоми, Бааз

Рут ном дахь Христ: Хуучин гэрээнд, ямар нэг эзэмшил газрыг юмуу хүний бол болгон худалдсан бол Золин авагчийн тодорхой шаардлагуудыг хангаж байгаа тохиолдолд тэд чөлөөлөгдөх боломжтой байв. Энэ чөлөөлөгчийг еврейгээр *ГОЕЛ* гэдэг бөгөөд “ойрын хамаатан” гэсэн утгатай. Энэ бол Аврагчийн чөлөөлөлтийн ажлын төгс зураглал юм.

ГОЕЛ нь тухайн чөлөөлөгдөж байгаа хүний цусан төрөл (хамаатан) байх (Дэд хууль 25:5, 7-10; Иохан 1:14; Ром 1:3; Филиппой 2:5-8; Еврей 2:14-15), чөлөөлөлтийн үнийг төлөх чадвартай байх (2:1-ыг 1 Петр 1:18-19-тэй харьцуул), тухайн үнийг төлөх буюу чөлөөлөх хүсэлтэй байх (3:11-ийг Матай 20:28; Иохан

10:15, 19; Еврей 10:7-той харьцуул), Христ гэм нүгэлгүй, нүглийн хараалаас чөлөөтэй байсан шиг чөлөөлөгч нь өөрөө эрх чөлөөт хүн байх ёстой (2 Коринт 5:21; 1 Петр 2:22; 1 Иохан 3:5).

Хувийн Судлалд: Агуулга

- | | | |
|---|---------|---------|
| 1. Рутын шийдвэр ба Израильд ирсэн нь (1:1-22) | | |
| 1:1-5 | 1:6-18 | 1:9-22 |
| 2. Рутын эрх ашиг (2:1-23) | | |
| 2:1-3 | 2:4-17 | 2:17-23 |
| 3. Рутын хүсэлт (3:1-18) | | |
| 3:1-4 | 3:5-9 | 3:10-18 |
| 4. Рутын шагнал (4:1-22) | | |
| 4:1-12 | 4:13-17 | 4:18-22 |

Нэгдүгээр Самуел (Шүүгчдээс Хаант засаглал уруу шилжсэн нь)

Номын нэр болон зохиогч: 1 ба 2-р Самуэлыг хэн бичсэн нь тодорхойгүй. Иудейн Талмуд уламжлалд Самуэлыг бичсэн гэж үздэг. Хэдийгээр 1 ба 2-р Самуел ном нь эш үзүүлэгч Самуэлын нэрээр нэрлэгддэг боловч түүнийг нас барсан тухай 25-р бүлэгт дурддаг учир тэрээр 1 Самуел номын талыг л бичсэн байх боломжтой. 1 Самуел 10:25 дээр Самеул нэгэн ном бичсэн тухай өгүүлдэг. Түүнчлэн, 1 Шастир 29:29-д Натаан, Гад нар Самеул номд бичигдсэн зарим үйл явдлын талаар бас бичсэн гэсэн санааг хэлдэг.

1 ба 2-р Самуел номыг Еврей Библид нэг ном гэж үзэн нэгтгэсэн байдаг. Энэ хоёр ном нь Израилийн хаант улсын эхэн үеийн түүхийг өгүүлдэг. Үнэндээ 1 Самуел ном нь Саул хааны тухай, 2 Самуел нь Давид хааны тухай юм. Хэдийгээр анхандаа нэг ном байсан боловч Септуагинтын (Хуучин гэрээний грек орчуулга) орчуулагчид уг номыг хоёр ном болгон хуваасан аж. Ингэж хоёр ном болгож хуваасныг хожим нь Жероме латин Вулгэйтдээ (Библийн латин орчуулга), мөн орчин үеийн орчуулгын хувилбарууд дагасан байна.

Бичигдсэн огноо: МЭӨ 1010 (болон үүнээс хойш)

Сэдэв болон Зорилго: Самуэлын төрөлтөөс болон сүмд сургагдсанаас нь эхлээд энэхүү Бурханы агуу хүн эш үзүүлэгч, тахилч, сүүлчийн шүүгчийн хувьд Израилийг хэрхэн удирдаж байсныг 1 Самуел ном өгүүлдэг. Самуэлыг удирдаж байх үед Израиль ард түмэн бусад үндэстнүүдтэй адилхан болохыг хүсэж, хаантай болохыг шаардаж эхэлсэн. Бурханы удирдамж дор Самуел Саулыг анхны хаанаар тосолсон. Гэхдээ дуулгаваргүй байдлаас нь болж Бурханы Саулыг эсэргүүцсэн. Тиймээс Саулын оронд, мөн л Бурханы удирдамжийн дор, Самуел Бурханы зүрх сэтгэлийг дагагч Давидыг Израилийн хаанаар тосолсон.

Номын үлдсэн хэсэг нь атаархаж хорссон Саул болон бурханлаг Давид нарын хоорондох зөрчилдөөнийг өгүүлдэг. Нэгдүгээр Самуел номд Самсоны дараа Самуелаар шүүгчид дуусаж байгаа үеэс Израилийн түүх үргэлжилдэг (Шүүгчид 16:31-тэй харьцуул). Уг ном нь Израиль үндэстний удирдлага шүүгчдээс хаад уруу, Бурханы хаанчлалаас хаадынх уруу шилжиж байгаа шилжилтийг өгүүлдэг. Шүүгчдийн цаг үед, Израилийн ард түмэн өөрсдийн амьдралыг ЭЗЭН-д удирдуулахаас татгалзаж, хүн бүр өөрийн нүдэнд зөв гэж харагдсаныг үйлдэх болсон (Шүүгчид 17:6; 21:25). Хүмүүс дэлхий дээрх хааныг дагахыг илүү хүсэж байсан учир хаант засаглал нь илүү тогтвортой байдлыг авчирсан. ЭЗЭН Самуелд “*Ард олны чамд өгүүлэх бүхний талаар тэдний дуу хоолойг сонсогтун. Учир нь тэд чамайг үл хэрэгсэж байгаа юм биш, харин тэднийг захирах хаан байхаас Намайг эсэргүүцэж байгаа хэрэг юм*” (8:7) хэмээн айлдсан байдаг.

Бурхан Израильд хааныг өгөхөөр төлөвлөсөн байсан (Эхлэл 49:10; Дэд хууль 17:14-20), гэхдээ ард түмэн Бурханы өгөх хааныг хүлээхийн оронд өөрсдөө хааныг сонгохоор шаардаж байлаа. Саул “*дүүлгавартай дагах нь тахил өргөхөөс илүү*” (15:22) гэдэг үнэнийг сурч чадаагүй учир Эзэн түүнээс татгалзсан юм. Тэр ёс суртахуунгүй байдал, тэнэглэл, уурссан атаархал, оюуны хямрал зэргээр тодорхойлогдох болсон. Харин Давид “*Бурхан хүнтэй адил хардаггүй*” (16:7) гэдэг зарчмыг харуулсан. Давидын дуулгавартай байдал, мэргэн ухаан, Бурханд түшиглэдэг зэргээс болж Эзэн Давидын хаанчлалыг байгуулж өгсөн.⁶

Түүхийн хувьд, 1 Самуел номын гол зорилгын нэг нь Давидын хаанчлалын тэнгэрлэг үүсэл гарлыг бичиж тэмдэглэх явдал байжээ.

Гол хүмүүс: Эш үзүүлэгч Самуел, дуулгаваргүй хаан Саул, хоньчин Давид

1 Самуел ном дахь Христ: Самуел эш үзүүлэгч, тахилч байсан бөгөөд тэр хэдийгээр хаан биш байсан боловч хаадын захиргааны шинэ эринийг эхлүүлэхэд Бурханы ашигласан шүүгч байсан бөгөөд энэ бүгдээрээ тэр Христийн дүр зургийг маш сонирхолтой байдлаар харуулдаг.

Мессия гэдэг нь үгчилбэл “тослогдсон нэгэн” гэсэн утгатай бөгөөд Библийн номуудаас анх удаа Самуел номд “тослох” гэдэг үгийг хэрэглэсэн (2:10). Мессиагийн гол тодорхойлолтуудын нэгийг Давидын амьдралаас харж болно. Тэр Бетлеменд мэндэлсэн, хоньчны ажил хийж байсан, Израилийн удирдагч байсан, мөн Давидын династиар дамжуулан Мессия Хааны өвөг дээдэс болсон юм. Шинэ гэрээнд, Христийг “*махан биеэр Давидын удмаас төрсөн*” (Ром 1:3) гэж хэлсэн байдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Сүүлчийн шүүгч Самуел (1:1–8:22)

A. Самуелын дуудлага (1:1–3:21)

1:1-18	2:12-17	3:1-21
1:19-28	2:18-21	
2:1-11	2:22-36	

B. Самуелын ажил үүрэг (4:1–7:17)

4:1-22	6:1-21
5:1-12	7:1-17

B. Самуелын сэтгэл зовнил (8:1-22)

8:1-9	8:10-22
-------	---------

2. Анхны хаан Саул (9:1–15:35)

A. Саулыг сонгосон нь (9:1–12:25)

9:1-14	10:17-27	12:12-25
9:15-27	11:1-15	
10:1-16	12:1-11	

B. Саулаас татгалзсан нь (13:1–15:35)

13:1-23	14:24-46	15:1-9
14:1-23	14:47-52	15:10-35

3. Удаах хаан Давид (16:1–19:24)

A. Сонгогдож, тослогдсон хоньчин Давид (16:1-23)

16:1-11	16:12-23
---------	----------

B. Аварга биет хүнийг алж, Саулын талархлыг хүлээсэн Давид (17:1-58)

17:1-19	17:20-30	17:31-58
---------	----------	----------

B. Ионатаныг найз боловч Саулын эсэргүүцдэг Давид (18:1–19:24)

18:1-9	18:20-30
18:10-19	19:1-24

4. Саулын мөшгилтөөс зугтаж буй Давид (20:1–26:25)

A. Давидыг Ионатан хамгаалсан нь (20:1-42)		
20:1-29	20:30-42	
B. Давидыг Ахимелех хамгаалсан нь (21:1-9)		
C. Давидыг Ахиш хамгаалсан нь (21:10-15)		
D. Давид болон Түүний залуус (22:1–26:25)		
22:1-23	24:1-22	25:18-38
23:1-14	25:1	25:39-44
23:15-29	25:2-17	26:1-25

5. Давид Филистийн нутагт дэвсгэрт хоргодсон нь (27:1–31:13)

- A. Давид Филист хүний боол болсон нь (27:1–28:2)
- B. Саул Ен-Дорд сүнс дуудагчаас зөвлөгөө авсан нь (28:3-25)
- C. Давид Филистчүүдэд хөөгдсөн нь (29:1-11)
- D. Давид Амалекчүүдийг устгасан нь (30:1-31)
- E. Саулын үхэл ба Филистчүүд (31:1-13)

Хоёрдугаар Самуел

(Давидын хаанчлал – Үндэстэн өргөжсөн нь)

Номын иэр болон зохиогч: 1 ба 2-р Самуел ном нь анхандаа нэг ном байсан тул урьд өгүүлсэн 1 Самуел номын зохиогчтой холбоотой хэсгийг үзэ үү.

Бичигдсэн огноо: МЭӨ 1010 (болон үүнээс хойш)

Сэдэв болон зорилго: Израилийн хаант улсын түүхэнд илэрхий тасалдал гараагүй байдаг бөгөөд Саулын үхлээр эхэлж, Давидын хаанчлалаар үргэлжилж буй Израилийн хаант улсын эхлэлийн тухай хүүрнэл 2 Самуел номд үргэлжилдэг. Уг ном нь Давидын дөчин жилийн хаанчлалын тухай онцгойлон өгүүлдэг (5:4-5) бөгөөд түүний ялалт амжилт төдийгүй түүний завхайрал, аллага зэрэг гэм нүгэл, эдгээрийн үр дагавар гэр бүлд нь болон улс үндэстэнд нь нөлөөлж байгаа зэрэг эмгэнэлт явдлуудыг ч багтаасан. 2 Самуел номыг Давидын хаанчлалыг өгүүлдэг гэсэн утгаараа гол сэдвийг нь “гэм нүгэл хэрхэн зовлон бэрхшээл доторх ялалт болон хувирдгийг” харуулсан хэмээн нэгтгэн хэлж болно. Саулын удирдлага дор хаант улс байгуулагдаж, Давидын үед хаанчлал өргөжсөн. Саулын хаанчлал нь Израильд шүүгчдийн үеэс илүү тогтвортой байдлыг бий болгосон, харин Давидын хаанчлал нь өсөлт буюу өргөжилтийг авчирсан. Удирдагчдынхаа түүхийг нээлттэй өгүүлдэг Библийн нийтлэг загварын дагуу, 2 Самуел ном нь Давид хааны амьдралын сайн болон муу талыг хоёуланг нь харуулсан.

Гол хүмүүс: Давид, Батшеба, Натан, Абсалом, Иоаб, Амнон болон Ахитофел

2 Самуел ном дахь Христ: Хийсэн гэм нүглийг нь хамааруулахгүйгээр, Давид бол Израилийн хаан Христийн билэгдэл байв. Энэ номон дээр Бурхан Давидтай гэрээ байгуулсан бөгөөд энэ нь Христийн бодгалдь жинхэнэ утгаараа биелсэн юм.

Хувийн Судлалд: Агуулга

1. Давидын ялалтууд (1:1–10:19)

- A. Хаанд өргөмжлөгдсөн нь (1:1–5:5)

1:1-16	2:12-32	3:31-39
1:17-27	3:1-5	4:1-12
2:1-7	3:6-25	5:1-5
2:8-11	3:26-30	

B.	Хаант улсаа нэгтгэсэн нь (5:6–6:23) 5:6-25	6:1-11	6:12-23
B.	Хаант улсын талаарх гэрээ (7:1-29) 7:1-7	7:8-17	7:18-29
G.	Хааны булаан эзлэлт (8:1–10:19) 8:1-18	9:1-13	10:1-19
2.	Хааны гэм нүгэл (11:1-27)		
A.	Хааны завхайрал (11:1-13)		
B.	Хааны өдөөсөн аллага (11:14-27)		
3.	Хааны зовлон бэрхшээл (12:1–24:25)		
A.	Гэр булд нь учирсан зовлон (12:1–13:36)		
	12:1-14	12:24-25	13:1-23
	12:15-23	12:26-31	13:24-36
B.	Хаант улсад нь учирсан зовлон (13:37–24:25)		
	13:37-39	17:1-14	20:13-26
	14:1-20	17:15-29	21:1-22
	14:21-33	18:1-18	22:1-51
	15:1-12	18:19-33	23:1-7
	15:13-37	19:1-7	23:8-39
	16:1-4	19:8-43	24:1-14
	16:5-14	20:1-9	24:15-17
	16:15-23	20:10-12	24:18-25

Хаадын Дээд (Давидын үхэл – Хаант улсын үймээн)

Номын нэр болон зохиогч: Зохиогч нь тодорхойгүй, гэхдээ иудейчууд уг номыг Иеремиаг бичсэн гэж үздэг. Чарли Ририйн хэлснээр:

Эдгээр номын зохиогч эсвэл эмхэтгэгч нь хэн ч байлаа гэсэн тэрээр түүхэн эх сурвалжуудыг ашигласан (11:41; 14:19, 29). Тэр Вавилонд цөлөгдөн амьдарч байсан нэгэн байх магадлалтай бөгөөд Езра, Езекиел, Иеремиа, эсвэл нэр нь үл мэдэгдэх нэгэн ч байж болох юм (гэхдээ Иеремиа Вавилонд биш Египетэд нас барсан учир 2Хаад номын сүүлчийн бүлгийг Иеремиагаас өөр хүн бичсэн болов уу; Иеремиа 43:6-7).⁷

Хаадын дээд болон дэд ном нь анхандаа нэг ном байсан (1 ба 2-р Самуел, мөн Шастирын дээд ба дэд номууд шиг) бөгөөд Еврей уламжлалын дагуу зүгээр л “Хаад” (мелехим) гэж нэрлэдэг байсан. Уг номууд нь Соломоны үээс Вавилонд олзлогдох үеийг хүртэлх Иуда болон Израилийн хаадын түүхийг өгүүлдэг тул энэ нь тун тохирсон нэр юм. Хаадын дэд ном нь МЭӨ 853 онд Ахазиагийн хаанчлалын үе эхэлж байгаагаар гэнэт төгсдөг.

Бичигдсэн огиоо: Ойролцоогоор **МЭӨ 550 он**. Иехоахин широнгоос суллагдаж байгаа нь 2Хаад номд тэмдэглэгдсэн хамгийн сүүлчийн үйл явдал юм. Энэ нь түүнийг широнд хоригдсоноос хойш 37 жилийн дараа болсон (МЭӨ 560). Тиймээс Хаадын дээд болон дэд ном нь тэр үйл явдлаас өмнө бичигдсэн байх боломжгүй. Мөн МЭӨ 516 онд иудейчууд Вавилоны олзлогдолтоос буцаж ирсэн талаар эдгээр номд бичигдээгүй бөгөөд хэрвээ энэ үйл явдал болчихсон байсан бол зохиогч номдоо энэ талаар бичих байсан нь гарцаагүй болов уу. Тиймээс Хаадын дээд болон дэд ном нь МЭӨ 560-516 оны хооронд хамгийн эцсийн хувилбараараа бичигдэж дууссан бололтой.⁸

Сэдэв болон зорилго: Давид хааныг нас барсны дараа (1-2-р бүлэг) түүний хүү Соломон хаан болсон. 1-11-р бүлэг нь Соломон хааны амьдрал болон хаанчлалын тухай өгүүлдэг бөгөөд энд мөн Израиль алдрын

оргилд хүртэл өсөж хөгжин, хаант улс нь өргөжин тэлж, Иерусалимд ордон болон Сүмийг барьсан тухай өгүүлдэг. Гэхдээ Соломон амьдралынхаа сүүлийн жилүүдэд харийн шашин шүтлэгтэй эхнэрүүд нь түүнд хүчтэй нөлөөлснөөс болж Эзэнээс хөндийрч, Сүмд Бурханд мөргөл өргөхөөс зүрх сэтгэл нь эргэсэн.

Зүрх сэтгэл нь хуваагдсан хаан ардаа мөн л хуваагдсан хаант улсыг үлдээсэн. Учир нь, ирэх зуунд нь Хаадын дээд ном нь Бурханы эш үзүүлэгчид болон заавар зарчмаас өөрөөр өсөж хөгжиж буй дуулгаваргүй хоёр ард түмний, хоёр хэсэг хаадын хоёр ихэр түүхийг дагах шаардлагатай болсон.⁹

Дараагийн хаан нь хаант улсынхаа умард хэсгийг алдсан Рехобоам байлаа. Үүний дараа, 10 овгийг багтаасан умард хаант улс нь Израиль гэдэг нэртэй, Иуда болон Бениамин гэсэн 2 овгийг багтаасан өмнөд хаант улс нь Иуда гэдэг нэртэй болсон. Хаадын дээд номын сүүлчийн бүлэгт хорон муу Ахаб хаан болон Ахабын бузар муу байдал болон Израилийн дуулгаваргүй байдлыг зэмлэн буруутгаж байсан эш үзүүлэгч зөвт Элия нарын голлон өгүүлдэг.

Тиймээс, гол сэдэв нь дуулгаваргүй байдал нь хаант улсыг хэрхэн сүйрэл мөхөл уруу хөтөлж буйг харуулах явдал юм. Улс үндэстний сайн сайхан байдал нь Израильтай хийсэн Бурханы гэрээнүүдэд хүмүүс хэр итгэмжит байгаагаас, мөн тэднийг удирдаж буй удирдагчийнх нь итгэмжтэй байдлаас шалтгаалж байв. Хаадын дээд ном нь зөвхөн эдгээр хаадын түүхийн тэмдэглэлийг өгөөд зогсохгүй, ямар ч хааны амжилт нь Бурханы хууль буюу үнэнд хаан хэр үнэнч байгаа дээр тулгуурлаж байсан гэдгийг онцлон өгүүлсэн. Тус ном нь үнэхээр “*зөв шударга байдал улс үндэстнийг алдарицуулж, харин нүгэл хилэнц ард түмнийг гутаадаг*” (Сургаалт үгс 14:34) гэдгийг харуулсан. Бурханы гэрээнд итгэмжгүй байх нь уналт доройтолд, мөн олзлогдоход хүргэдэг.

Гол хүмүүс: Соломон, Иеробоам, Рехобоам, Елиа, Елиша, Ахаб болон Иезебел

Хаадын дээд ном дахь Христ: Давидын нэгэн адил, Соломон ч гэсэн Хуучин гэрээн дэх Христийн агуу билэгдлүүдийн нэг бөгөөд газар дэлхий дээр ирээдүйд хаанчлах Мессиагийн дүр зургийг харуулдаг. Ялангуяа Соломон Христийн энэ дэлхий дээр хаанчлалд Христэд нэр хүнд, алдар суу, эд баялаг зэрэг нь бүгд Христэд хамарагдах болно гэдгийг харуулдаг. Түүнчлэн Соломон өөрт байсан агуу мэргэн ухаанаар Христийн дүр төрхийг мөн илэрхийлдэг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Нэгдсэн хаант улс: Соломоны хаанчилсан дөчин жил (1:1–11:43)

A. Соломон хаан ширээг хүлээн авсан нь (1:1–2:46)

1:1-10	2:1-9	2:28-35
1:11-37	2:10-18	2:36-46
1:38-53	2:19-27	

B. Соломоны мэргэн ухаан (3:1–4:34)

3:1-5	3:10-15	4:1-19
3:6-9	3:16-28	4:20-34

C. Соломоны Сүм (5:1–8:66)

5:1-12	7:13-51	8:54-61
5:13-18	8:1-11	8:62-66
6:1-38	8:12-21	
7:1-12	8:22-53	

D. Соломоны алдар хүнд (9:1–10:29)

9:1-9	10:1-13
9:10-28	10:14-29

E. Соломоны доройтол болон уналт (11:1-43)

11:1-13	11:14-40	11:41-43
---------	----------	----------

2. Хуваагдсан хаант улс: Хоёр хаант улсын эхний наян жил (12:1–22:53)

А. Хуваагдлын шалтгаан (12:1-24)

12:1-15	12:16-24
Б. Израиль дахь Иеробоамын хаанчлал (12:25–14:20)	
12:25-33	13:11-34
13:1-10	14:1-20
В. Иуда дахь Рехобоамын хаанчлал (14:21-31)	
Г. Иуда дахь Абиамын хаанчлал (15:1-8)	
Д. Иуда дахь Асагийн хаанчлал (15:9-24)	
Е. Израиль дахь Надабын хаанчлал (15:25-31)	
Ё. Израиль дахь Баашагийн хаанчлал (15:32–16:7)	
Ж. Израиль дахь Елагийн хаанчлал (16:8-14)	
З. Израиль дахь Зимрийн хаанчлал (16:15-20)	
И. Израиль дахь Омрийн хаанчлал (16:21-28)	
К. Израиль дахь Ахабын хаанчлал (16:29–22:40)	
16:29-34	19:1-8
17:1-16	19:9-21
17:17-24	20:1-12
18:1-19	20:13-25
18:20-35	20:26-43
18:36-46	21:1-10
Л. Иуда дахь Иехошафатын хаанчлал (22:41-50)	
М. Израиль дахь Ахазиагийн хаанчлал (22:51-53)	

Хаадын Дэд

(Тарж бутарсан нь – Санаатай гэм нүгэл нь гашуудам төгсгөлийг авчирдаг)

Номын нэр болон зохиогч: Хаадын дээд болон дэд ном нь анхандаа нэг ном байсан тул урьд өгүүлсэн Хаадын дээд номын зохиогчтой холбоотой хэсгийг үзнэ үү.

Бичигдсэн огноо: Ойролцоогоор МЭӨ 550 он (Хаадын дээд ном дахь мэдээллийг харна уу)

Сэдэв болон зорилго: Хаадын дэд ном нь Елиа болон түүний залгамжлагч Елиша нарын түүхээр үргэлжилдэг, гэхдээ үүнийг мөн “Хоёр хаант улсын түүх” гэж нэрлэж болно. Уг номд Умард Израилийн хаант улс болон Өмнөд Иудагийн хаант улс эцэстээ өөр үндэстнүүдэд булаан эзлэгдэж, олзлогдох хүртэлх түүхийг өгүүлдэг. Израиль МЭӨ 722 онд Ассирид, Иуда МЭӨ 586 онд Вавилонд эзлэгдсэн. Хоёр хаант улсад хоёуланд нь эш үзүүлэгчид хүмүүсийг гэмшихгүй бол Бурхан шийтгэх болно гэдгийг сэрэмжлүүлэн хэлсээр байсан.

Хаадын дэд номд улс үндэстний дотор санаатай, зориудын гэм нүгэл байх нь гашуудам төгсгөлийг авчирдаг гэдгийг заадаг. 1, 2-р Самуел номд, үндэстэн төрж, Хаадын дээдэд хуваагдаж, харин Хаадын дэд номд тарж бутарсан. Олон жилийн турш эш үзүүлэгчдээрээ дамжуулан Бурхан өөрийн ард түмэнд анхааруулж, өмгөөлж байсан боловч эцэст нь Бурханы тэвчээртэй байдал нь Түүний амлаж байсанчлан сахилгажуулалт уруу эргэсэн. Энэ хоёр ном нь анхандаа нэг байсан учир Хаадын дээд болон дэд ном нь ижил сэдэв болон зорилготой. Эдгээр нь итгэмжгүй байдал (Бурханы хуульд дуулгаваргүй байж, эсргүүцэх) нь хаант улсыг тулхэн унагах хэмжээнд хүртэл Бурханы сахилгажуулалтад хүргэдэг гэдгийг бидэнд заадаг. Хаад Бурханы үнэнд анхаарлаа хандуулж, зөв шударгаар удирдаж чадаагүйн улмаас хоёр хаант улс хоёул нуран унасан юм.

Гол хүмүүс: Елиа, Елиша, Иосиа, Нааман, Хезекия

Хаадын дэд ном дахь Христ: Елиа Христийн замыг бэлтгэгч баптизм хүртээгч Иоханыг урьдаас харуулсан (Матай 11:14; 17:10-12; Лук 1:17). Елишагийн хувьд, тэр Есүс Христийн үйлчлэлийг олон

талаараа бидэнд сануулдаг. Ирвинг Л.Женсен энэ тал дээр тэдний үйлчлэлийг харьцуулж, нэгтгэсэн байдаг:

Елиа олон хүмүүсийн өмнө агуу зүйлсийг хийж байснаараа алдартай бол Елишагийн хувьд маш олон тооны гайхамшигуд хийж байсан, эдгээрийн ихэнх нь хувь хүмүүсийн хэрэгцээнд зориулагдаж байснаараа ялгаатай. Елиагийн үйлчлэл Бурханы хууль, шүүлт, хатуу байдлыг онцолдог. Харин Елиша үүн дээр Бурханы хайр, нигүүлсэл, зөөлөн байдлыг нэмж харуулсан. Елиа баптисм хүртээгч Иоханы адил нүглийн гэмшлийн мэдээг дамжуулж байсан. Үүнийг дагалдан, Елиша Христийн хийж байсан шиг сайхан сэтгэлийн үйлс болон гайхамшигудыг үйлдэж, үүгээр эдгээр эш үзүүлэгчдийн үгс Бурханаас ирсэн гэдгийг харуулж байв.¹⁰

Хаадын дээд болон дэд номын агуулгыг харьцуулсан Раирийн судалгааг анхааралтай ажиглана уу.¹¹ Энэ харьцуулалт нь санаатай гэм нүгэл нь гашуудам төгсгөлийг авчирдаг гэдгийг тодорхой харуулж байна.

Хаадын дээд болон дэд номыг харьцуулах нь	
Хаадын дээд	Хаадын дэд
Давид хаанаар эхэлдэг	Вавилоны хаанаар төгсдөг
Соломоны алдар суу эхэлдэг	Иехоиахины ичгүүр төгсгөл болдог
Дуулгавартай байдлын ерөөлөөр эхэлдэг	Дуулгавартай байдлын хараалаар төгсдөг
Сүм барьж эхэлсэн	Сүм шатаж байгаагаар төгсдөг
Итгэлээсээ урвах үйл явц өрнөсөн.	Итгэлээсээ урвахын үр дагаврыг өгүүлсэн
Хаад хэрхэн Бурханы ард түмний удирдаж чадахгүй байгааг харуулсан	Уналтын үр дагавар хэрхэн нөлөөлж буйг харуулсан
Эш үзүүлэгч Елиаг танилцуулсан	Эш үзүүлэгч Елишаг танилцуулсан
Эзэний тэсвэр тэвчээрийг онцолсон	Эзэн гэм нүглийг гарцаагүй шийтгэх болно гэдгийг батлан харуулсан

Хувийн Судлалд: Агуулга

1. Хуваагдсан хаанчлал (1:1–17:41)

- A. **Израиль** дахь Ахазиагийн хаанчлал (1:1-18)
- B. **Израиль** дахь Иехорамын (Иорам) хаанчлал (2:1–8:15)

- 1) Елиагийн үйлчлэл шилжсэн нь (2:1-14)
- 2) Елиашагийн үйлчлэл эхэлсэн нь (2:15-25)
- 3) Моабын эсрэг Иехорамын аян дайн (3:1-27)
- 4) Елиашагийн үйлчлэл (4:1–8:15)

4:1-7	5:15-27	7:3-14
4:8-17	6:1-7	7:15-20
4:18-37	6:8-23	8:1-6
4:38-44	6:24-33	8:7-15
5:1-14	7:1-2	

- B. **Иуда** дахь Иорамын (Иехорам) хаанчлал (8:16-24)

- G. **Иуда** дахь Ахазиагийн хаанчлал (8:25-29)

- D. **Израиль** дахь Иехугийн хаанчлал (9:1–10:36)

- | | | |
|---------|----------|----------|
| 9:1-13 | 9:33-37 | 10:34-36 |
| 9:14-26 | 10:1-17 | |
| 9:27-32 | 10:18-33 | |

- E. **Иуда** дахь Аталиа хатны хаанчлал (11:1-16)

- Ё. **Иуда** дахь Иехоашийн (Иоаш) хаанчлал (11:17–12:21)

- | | | |
|------------|----------|--|
| 11:17-20 | 12:4-18 | |
| 11:21-12:3 | 12:19-21 | |

- Ж. **Израиль** дахь Иехоахазын хаанчлал (13:1-9)

- З. **Израиль** дахь Иехоашийн (Иоаш) хаанчлал (13:10-25)

- И. **Иуда** дахь Амазиагийн хаанчлал (14:1-22)

- К. **Израиль** дахь II Иеробоамийн хаанчлал (14:23-29)
- Л. **Иуда** дахь Азариагийн (Узза) хаанчлал (15:1-7)
- М. **Израиль** дахь Зехариагийн хаанчлал (15:8-12)
- Н. **Израиль** дахь Шаллумын хаанчлал (15:13-15)
- О. **Израиль** дахь Менахемийн хаанчлал (15:16-22)
- Ө. **Израиль** дахь Пекахиагийн хаанчлал (15:23-26)
- П. **Израиль** дахь Пекагийн хаанчлал (15:27-31)
- Р. **Иуда** дахь Иотамын хаанчлал (15:32-38)
- С. **Иуда** дахь Ахазын хаанчлал (16:1-20)
- Т. **Израиль** дахь Хосеагийн хаанчлал (17:1-41)
 - 1) Израилийн ялагдал (17:1-6)
 - 2) Израилийн гэм нүглүүд (17:7-23)
 - 3) Израиль тарсан нь (17:24-41)

2. Иудагийн хаант улс тэсэж үлдсэн нь (18:1–25:30)

- А. Хезекиагийн хаанчлал (18:1–20:21)

18:1-6	19:1-7	19:20-37
18:7-12	19:8-13	20:1-11
18:13-37	19:14-19	20:12-21

- Б. Манассегийн хаанчлал (21:1-18)
- В. Амоны хаанчлал (21:19-26)
- Г. Иосиагийн хаанчлал (22:1–23:30)
- Д. Иехоахазын хаанчлал (23:31-33)
- Е. Иехоиакимын хаанчлал (23:34–24:7)
- Ё. Иехоиахины хаанчлал (24:8-16)
- Ж. Зедекиагийн хаанчлал (24:17–25:21)
 - 1) Вавилоны эсрэг бослого болон Сүм устсан нь (24:17–25:10)
 - 2) Вавилон уруу гурав дахь удаагаа аваачигдсан нь (25:11-21)
- З. Гедалиагийн захиригаа, тоглоомын засгийн газар (25:22-26)
- И. Вавилонд Иехоиахиныг сулласан нь (25:27-30)

Шастирын Дээд (Сүмийн бэлтгэл)

Номын нэр болон зохиогч: Шастирууд номын (Шастирын дээд ба дэд номууд нь анхандаа нэг ном байсан) зохиогч нь тодорхойгүй, гэхдээ иудейн уламжлалаар бол Езраг зохиогч нь гэж үздэг. Номын турш үргэлжилж буй бичиглэлийн хэв маягаас нь тус номыг эмхэтгэхэд хэд хэдэн эх сурвалжийг ашигласан боловч нэг хянагч эцсийн бүтээгдэхүүн болгосон гэдэг нь харагддаг. Эдгээр эх сурвалжид Самуел (1 Шастир 29:29), Исаиа (2 Шастир 32:32), болон бусад хүмүүсийн (2 Шастир 9:29; 12:15; 20:34; 33:19) эш үзүүлэгийн бичвэрүүд ордог, гэхдээ хамгийн гол эх сурвалж нь “Израиль болон Иудагийн хаадын ном” (2 Шастир 16:11; 25:26) байсан. Сүм, тахилчлал, Давидын удам болон Иудагийн Өмнөд хаант улс зэрэгт анхаарлаа маш хүчтэй хандуулдаг учир номын агуулгаас нь уг номыг зохиогч нь тахилч хүн байсан гэж таамагладаг. Тус номын эмхэтгэгч нь Езра мөн гэсэн итгэлийг Шастирууд болон Езра ном дахь Сүмийг барьж, Эзэнд өргөж байгаа зэрэг нийтлэг сэдвүүд бас дэмжиж байдаг.

Хэдийгээр Хаад болон Шастирууд ном нь иудейн түүхийн ижил цаг үеийг хамардаг боловч байр суурь нь тун өөр. Агуулга нь хоорондоо төстэй боловч энэ нь энгийн нэг давталт биш харин илүү Израилийн ард түмний түүхийн талаарх сүнслэг тайлбар болж өгдөг. Хаад ном нь хүний үзэл бодолтой илүү холбоотой бол Шастирууд ном нь Бурханы байр суурийг илүү харуулдаг.

Анхандаа Шастирын дээд ном нь дэд номтойгоо нэг ном байсан (МЭӨ 180 он хүртэл) бөгөөд Еврей гарчиг нь “өдрийдийн үгс (үйл явдал)” гэсэн утгатай байв. Энэ нь Адамаас эхлэн Вавилонд олзлогдох хүртэл, мөн цөллөг дэх иудейчүүдийг буцаж явахыг зөвшөөрсөн Персийн хаан Корешийн зарлиг хүртэлх

Израилийн түүхийг өгүүлдэг. Энэ утгаар нь үүнийг “Хуучин гэрээний жижигрүүлсэн загвар” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь Хуучин гэрээний түүхийн урсгалыг нэгэн жижиг бортогод багтаасантай адил юм.¹²

Септуагинтыг хийж байх явцдаа орчуулагчид нь Шастируудыг хоёр хэсэг болгож хуваасан. Тухайн үед үүнд Самуел болон Хаад номуудад бичигдээгүй үлдсэн хэсэг гэсэн утгаар нь “Үлдсэн зүйлс” гэсэн гарчиг өгчээ. “Шастирууд” гэдэг нэрийг Жероме Латин Библидээ өгсөн байна (МЭ 385-405). Жероме энэ нэрийг “Ариун түүхийн бүхэл шастирууд” гэсэн утгаар өгчээ.¹³

Бичигдсэн огноо: МЭӨ 450–425

Сэдэв болон зорилго: Хаадын дээд ном нь Адамаас Саул хааны үхэл хүртэлх түүхийн тоймыг өгүүлж эхэлдэг. Номын үлдсэн хэсэгт Давид хааны хаанчлалын тухай гардаг. Шастирууд ном нь Самуел болон Хаад номуудыг давтсан юм шиг харагддаг, гэхдээ энэ нь цөллөгөөс буцаж ирсэн хүмүүст тэд бол Давид хааны удмынхан, Бурханы сонгогдсон ард түмэн байсан гэдгийг сануулахын тулд бичигдсэн. Угийн бичиг нь Давидын амлалт болон Бурхан Абрахамыг агуу үндэстний эцэг болгож, түүгээр дамжуулан үндэстнийг ерөөх болно гэсэн Абрахамын амлалтыг харуулахад чиглэсэн. Бурхан гэрээндээ итгэмжит байдаг гэдэг нь номын гол сэдэв юм.

Шастирууд ном нь хууль, тахилчлал болон сүмийн үүрэг ролийг онцолдог. Хэдийгээр Соломоны сүм устсан боловч хоёр дахь сүм нь Үлдэгсдийг эхний сүмтэй холбож чадаж байв. Энэ ном нь бас өнгөрсөн цаг үе өнөөгийн тэдний хувьд утга учир бүхий хичээл байсан гэдгийг заадаг. Итгэлээсээ урвах, хуурамч шүтээн шүтэх, харь үндэстнүүдтэй гэрлэх, нэгдмэл бус байсан зэрэг нь тэдний одоогийн энэ сүйрлийн учир шалтгаан нь байсан. Цөллөгөөс ирсний дараа Израиль дахин харийн бурхдыг хэзээ ч шүтээгүй нь үнэхээр чухал ач холбогдолтой зүйл юм.¹⁴

Гол хүмүүс: Өмнө дурдсанчлан, энэ нь Давидын тухай ном. Гэхдээ 1 Самуел номд дурдагддаг Натаан, Батшеба, Уриа зэрэг өөр бусад чухал хүмүүс ч бас гардаг.

1 Шастир ном дахь Христ: 1 ба 2-р Самуел номд Давидыг Христийн билэгдэл байсан гэж хэлсэн нь энд ч мөн хамаатай.

Хувийн Судлалд: Агуулга

1. Адамаас Давид хүртэлх угийн бичиг (1:1–9:44)

- A. Адамаас Абрахам хүртэл (1:1-27)
- B. Абрахамаас Иаков хүртэл (1:28-54)
- C. Иаковоос Давид хүртэл (2:1-55)
- D. Давидаас олзлогдох хүртэл (3:1-24)
- D. Арван хоёр овгийн угийн бичиг (4:1–8:40)
 - 4:1-23 7:1-5 7:20-29
 - 4:24-43 7:6-12 7:30-40
 - 5:1-26 7:13 8:1-32
 - 6:1-81 7:14-19 8:33-40
- E. Иерусалемын оршин суугчид (9:1-34)
- Ё. Саулын гэр бүл (9:35-44)

2. Давидыг тосолсон болон өсөлт (10:1–12:40)

- A. Саулын үхэл (10:1-14)
- B. Давидыг хаанд өргөмжилсөн нь (11:1-3)
- C. Иерусалимыг эзлэн авсан нь (11:4-9)
- D. Давидын баатар эрс (11:10–12:40)

3. Давидын хаанчлал (13:1–29:21)

- A. Давид ба Бурханы авдар (13:1–17:27)

- 1) Давид Бурханы авдрыг Кидонд авчирсан нь: Уззагийн үхэл (13:1-14)
 - 2) Давидын алдар хүнд ба Филистчүүдийг ялсан ялалт (14:1-17)
 - 3) Давид Бурханы авдрыг Иерусалимд авчирсан нь (15:1-29)
 - 4) Давид баяр тэмдэглэсэн болон Бурханы авдрын талаарх зохион байгуулалт (16:1-43)
 - 5) Давид Сүм барихыг хүссэн нь: Давидын гэрээ (17:1-27)
- Б. Давидын дайн (18:1-20:8)
- | | |
|---------|----------|
| 18:1-17 | 19:10-19 |
| 19:1-9 | 20:1-8 |
- В. Давидын гэм буруутай тооллого (21:1-30)
- Г. Давидын Сүмд зориулсан бэлтгэл (22:1-23:1)
- Д. Давид Левичүүдийн зохион байгуулалт хийсэн нь (23:2-26:32)
- 1) Левичүүдийг тоолсон болон тэдний үүрэг хариуцлагууд (23:2-32)
 - 2) Левичүүдийг хорин дөрвөн бүлэг болгон хуваасан нь (24:1-31)
 - 3) Хөгжимчдийг томилсон нь (25:1-31)
 - 4) Хаалгануудын сахиулуудыг томилсон нь (26:1-19)
 - 5) Эрдэнэсийн нярвуудыг томилсон нь (26:20-28)
 - 6) Захирагчдыг томилсон нь (26:29-32)
- Е. Давидын хотын тэргүүнүүд (27:1-34)
- Ё. Ард түмэндээ болон Соломонд өгсөн Давидын сүүлчийн зааврууд (28:1-21)
- Ж. Давидын өргөлүүд болон мөргөл (29:1-21)

4. Давидын үхэл ба Соломоны хаанд өргөмжилсөн нь (29:22-30)

Шастирын Дэд (Сүм устсан нь)

Номын нэр болон зохиогч: Өмнө дурдсанчлан Шастирын дээд болон дэд ном нь анхандаа нэг ном байсан. Шастирын дээд номын адил, зохиогч нь тодорхойгүй боловч иудейн уламжлалын дагуу Езраг зохиогч нь гэж үздэг бөгөөд бичиглэлийн хэлбэр болон үзэл санааны үргэлжлэл зэрэг нь шастирч гэж нэрлэгддэг нэг хүний бичсэн ажил гэдгийг харуулдаг. Левичүүд болон сүмийн талаар дэлгэрэнгүй бичсэн зэрэг төстэй байдлууд нь Езраг зохиогч нь гэдгийг дэмждэг. Зохиогч нь хэн ч байлаа гэсэн дараах хэд хэдэн албан ёсны эх сурвалжийг номдоо ашигласан. Үүнд:

1. Израиль, Иудагийн хаадын ном (27:7; 35:27; 36:8)
2. Иуда болон Израилийн хаадын ном (16:11; 25:26; 28:26; 32:32)
3. Израилийн хаадын ном (20:34; 33:18)
4. Хаадын номын тайлбар (24:27)
5. Эш үзүүлэгч Натаны тэмдэглэл, Ахиагийн эш үзүүллэг болон үзмэрч Иddогийн үзмэр (9:29)
6. Шемаиагийн тэмдэглэл (12:15)
7. Иddогийн тэмдэглэл (13:22)
8. Эш үзүүлэгч Исаиагийн бичээс (26:22)
9. Хозайн тэмдэглэлүүд (33:19)
10. Гашуудал (35:25)
11. Хаан Давид болон түүний хүү Соломоны бичээс (35:4)

Бичигдсэн огноо: МЭӨ 450–425

Сэдэв болон зорилго: Шастирын дээд ном 1 ба 2-р Самуел номтой төстэй байсан бол Шастирын дэд ном нь Давидын удмынхны түүхийг өгүүлдэг бөгөөд Хаадын дээд ба дэд номтой төстэй. Умард хаант улсын ард түмний итгэлгүй байдал болон Давидын адил бурханлаг хаан нэг ч байгаагүй зэргээс болж Шастирын дээд номд Умард хаант улсын талаар огт дурдаагүй гэдгийг онцлон хэлэх нь зүйтэй юм. Номын 1-9 дүгээр бүлэгт Соломоны хаанчлалын үед сүмийг барьсан талаар өгүүлдэг. Харин 10-36 дугаар бүлэгт Иерусалим хот устаж, хүмүүсийг Вавилон уруу цөлөх хүртэл Өмнөд Иудагийн хаант улсын түүх гардаг. Түүнчлэн,

энд ард түмэндээ шинэчлэлт, сэргэлтийг авчирсан Аса, Иехошафат, Иоаш, Хезекиа, Иосиа зэрэг хаадын амьдралын талаар илүү ихийг өгүүлдэг.

Шастирууд ном нь Самуел болон Хаад номтой ижилхэн түүхийг өгүүлдэг, гэхдээ зарим нэг зүйлсийг илүү онцлон, өөр байр сууринаас хандсан байдаг. Үүнд: Шастирын дээд номын субъект нь Давид хаан бол Шастирын дэд номд Давидын гэр субъект нь болдог. Хаад номд үндэстний түүхийг хаан ширээнээс, Шастирууд номд тахилын ширээнээс (сүм) өгүүлэгддэг. Хаадад гол сэдэв нь хааны ордон, харин Шастирт сүм гол сэдэв нь болдог. Хаад ном улс төрийн түүхэнд анхаарлаа хандуулдаг бол Шастирууд номд Израилийн түүхийн шашны болон сүнслэг элементэд анхаардаг.

Шастирууд ном нь жирийн нэг түүхэн тэмдэглэл биш. Энэ бол Давидын династийн сүнслэг шинж чанарын талаар Бурханы тайлбар толь юм. Ийм ч учраас, нэг ч бурханлаг хаан үгүй Умард хаант улсыг ерөнхийд нь үл тоомсорлон үлдээж, Давидын удмын бурханлаг хаад байсан, сэргэлт болж байсан Өмнөд Иудагийн хаант улс дээр гол анхаарлаа хандуулсан.

Гол хүмүүс: Иосиа, Рехобоам, Соломон

2 Шастир ном дахь Христ: Давидын хаан ширээ устсан ч Давидын удам үлдсэн. Аллага, ов мэх, тэмцэл тулаан, олзлолт гээд энэ бүхэн Мессиагийн удам уруу довтолсон боловч энэ нь Адамаас Зеруббабел хүртэл цэвэр агаад үл тасалдсан хэвээр үлдсэн юм. Матай 1 болон Лук 3-р бүлэг дэх угийн бичгээс Христ дэх биелэл харагддаг.¹⁵

Шастирын дэд номд маш их анхаарал татдаг сүм ч гэсэн Христийн нэгэн сайхан дүр зураг болдог. (Матай 12:6; Иохан 2:19; Илчлэлт 21:22).

Хувийн Судлалд: Агуулга

1. Соломоны хаанчлал (1:1–9:31)

А. Соломоны хаанчлалын эхэн (1:1-17)

1:1-13	1:14-17
--------	---------

Б. Соломоны сүм (2:1–7:22)

2:1-10	5:1-10	7:4-7
2:11-18	5:11-14	7:8-10
3:1-2	6:1-11	7:11-22
3:3-17	6:12-42	
4:1-22	7:1-3	

В. Соломоны алдар хүнд (8:1–9:28)

8:1-18	9:1-12	9:13-28
--------	--------	---------

Г. Соломоны үхэл (9:29-31)

2. Иудагийн хаад (10:1–36:21)

А. Рехобоам (10:1–12:16)

10:1-19	11:14-17	12:1-8
11:1-13	11:18-23	12:9-16

Б. Абия (13:1-22)

13:1-3	13:4-19	13:20-22
--------	---------	----------

В. Аса (14:1–16:14)

14:1-15	15:8-19	16:7-14
15:1-7	16:1-6	

Г. Иехошафат (17:1–20:37)

17:1-2	18:28-34	20:14-19
17:3-19	19:1-4	20:20-25
18:1-7	19:5-11	20:26-34

18:8-11	20:1-4	20:35-37
18:12-27	20:5-13	
Д. Иехорам (21:1-20)		
Е. Ахазия (22:1-23:15)		
22:1-4	22:8-12	23:12-15
22:5-7	23:1-11	
Ё. Иоаш (23:16-24:27)		
23:16-21	24:3-7	24:20-22
24:1-2	24:8-19	24:23-27
Ж. Амазия (25:1-28)		
25:1-13	25:14-16	25:17-28
З. Уззия (26:1-23)		
26:1-5	26:6-15	26:16-23
И. Иотам (27:1-9)		
К. Ахаз (28:1-27)		
28:1-4	28:5-15	28:16-27
Л. Хезекия (29:1-32:33)		
29:1-4	30:13-27	32:9-19
29:5-19	31:1-2	32:20-33
29:20-36	31:3-21	
30:1-12	32:1-8	
М. Манассе (33:1-20)		
33:1-9	33:10-20	
Н. Амон (33:21-25)		
О. Иосиа (34:1-35:27)		
34:1-7	34:22-30	35:20-27
34:8-13	34:31-33	
34:14-21	35:1-19	
Ө. Иоахаз (36:1-4)		
П. Иехоиаким (36:5-8)		
Р. Иехоиахин (36:9-10)		
С. Зедекия (36:11-21)		

3. Кореш хааны зарлиг (36:22-23)

Езра

(Сүмийг дахин барьсан ба Ард түмэн сэргэсэн нь)

Номын нэр болон зохиогч: Хэдийгээр уг ном нь зохиогчийнхоо нэрээр нэрлэгдээгүй боловч иудейн уламжлалын дагуу Талмудад Езраг зохиогч нь гэсэн байдаг. Езра эдгээр номыг бичихдээ янз бүрийн баримтууд (4:7-16), ургийн бичиг (2:1-70) мөн хувийн тэмдэглэлээ (7:27-9:15) эх сурвалж болгон ашигласан.

Езра номын ихэнх хэсгүүд дэх гол дүр нь Езра бөгөөд энэ нь түүнийг зохиогч нь гэж үзэх үзлийг дэмждэг. 1-10 дугаар бүлэгт өгүүлсэн үйл явдлууд, Нехемиагийн 8-10 дугаар бүлэгт бас түүний тухай гардаг бөгөөд ишлэлүүд нэгдүгээр биеийн төлөөний хэлбэрээр бичигдсэн байдаг. Уламжлалт үзлээр бол Езраг Хуучин гэрээний номуудыг цуглуулан Бичээст нэгтгэсэн “Агуу синаагог”-ийг (агуу чуулган гэсэн утгатай) үндэслэгч гэж үздэг. Өөр нэг уламжлалын дагуу түүнийг Библийн номуудыг нэгтгэн цуглуулж, мөн мөргөлийн синагогийн хэлбэрийг анхлан үүсгэсэн гэж үздэг.¹⁶

Эртний Еврей Библид, Езра болон Нехемиа номыг нэг гэж үздэг бөгөөд “Езрагийн ном” гэж нэрлэдэг. Орчин цагийн Еврей Библид англи Библийн нэгэн адил Езра болон Нехемиа гэж хоёр хуваасан байдаг.

Түүнчлэн, Иосефус (эртний иудейн түүхч), Жероме (Латин Вулгэйтийг бичигч) нар Езра болон Нехемиа номыг нэг ном гэж үздэг.

Бичигдсэн огноо: МЭӨ 457–444

Сэдэв болон Зорилго: Түүхэн цаг хугацааны хувьд, Езра Шастирын дэд номын төгсгөл хэсгээс өгүүллэгээ үргэлжлүүлж, Вавилоны цөллөгөөс буцан ирж буй иудейчүүдийн түүхийг болон сүмийг дахин барьж байгаа тухай өгүүлдэг. Сүнслэг болон үзэл баримтлалын хувьд, Езра эш үзүүлэгчдийн тунхаглаж байсанчлан далан жилийн цөллөгийн дараа ард түмнээ амлагдсан газарт буцаан авчрах болно гэсэн амлалтаа Бурхан хэрхэн биелүүлж байгаа талаар онцлон өгүүлдэг. Шастирууд номын адил, Езра тахилч хүнийхээ хувьд, Бурханы ард түмэн болох Израиль үндэстний амьдралд сүм болон сүм дэх мөргөл хүндэтгэл чухал ач холбогдолтой болохыг харуулсан. Ном Персийн хаан Корешийн ард түмнүүдийн үлдэгсдийг нутаг уруугаа буцаж явахыг зөвшөөрсөн зарлигаар эхэлдэг. Ард түмэн баяр хөөртэйгээр Сүмийг дахин барьж эхэлсэн боловч Умардаас ирсэн дайснуудаас болж 18 жилээр хойшилсон. Эцэст нь, Дариус хаан тэднийг сүмээ барьж дуусгахыг зөвшөөрсөн зарлиг гарсан (Езра 1-6). 7-10 дугаар бүлэгт ард түмэнд хуулийг зааж, үндэстний сүнслэг амьдралыг шинэчилсэн тахилч Езра буцаж ирсэн тухай өгүүлдэг.

Номын сэдвийг нэгтгэн, Езра болон Зеруббабелын удирдлага дор буцаж ирсэн иудейн үлдэгсдийн сүнслэг, ёс суртахууны болон нийгмийн сэргээн босголт хэмээн хэлж болно.

Гол хүмүүс: Кореш (буцаж явахыг зөвшөөрсөн зарлиг гаргасан Персийн хаан), Езра (тахилч, мөн бичээч), Иешуа (ахлах тахилч) болон Зеруббабел.

Езра ном дахь Христ: Бурхан Давидын гэрээг сахиж, мөн Давидын Хүү, Мессиагийн төлөө үр удмыг нь мөнхөд байлгах болно гэсэн амлалтаа биелүүлэхийн зэрэгцээ Өөрийн ард түмнийг газар нутагт нь сэргээн босгох болно гэсэн амлалтаа хэрхэн биелүүлж байгааг Езра болон Нехемиа ном харуулдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Сэргээн босголт: Зеруббабелын удирдлага дор эхний хүмүүс Иерусалимд ирсэн нь (1:1–6:22)

A. Кореш хааны зарлиг (1:1-11)	1:1-4	1:5-11
B. Ард түмнээ тоолсон нь (2:1-70)	2:1-35 2:36-39	2:40-60 2:61-70
C. Сүмийн барилга эхэлсэн нь (3:1-13)	3:1-7	3:8-13
G. Эсэргүүцэл (4:1-24)	4:1-7	4:8-16
D. Барилга дахин эхэлсэн нь (5:1–6:12)	5:1-5	5:6-17
E. Сүм баригдаж дууссан нь (6:13-22)	6:13-18	6:19-22

2. Ард түмний дундах шинэчлэлт; Езрагийн удирдлага дор буцаж ирсэн нь (7:1–10:44)

A. Иерусалимд буцаж ирсэн нь (7:1–8:36)	7:1-10 7:11-26 7:27-28	8:1-14 8:15-20 8:21-32	8:33-36
B. Иерусалимын сэргэлт (9:1–10:44)	9:1-4 9:5-15	10:1-17 10:18-44	

Нехемиа

(Хотыг сэргээн барьсан нь)

Номын нэр болон зохиогч: Хэдийгээр зарим хүмүүс “Хакалиагийн хүү Нехемиагийн үгс” (1:1) гэдэг үгсээс болж уг номыг Нехемиа бичсэн гэж итгэдэг боловч өөр зарим хүмүүсийн хувьд Нехемиагийн тэмдэглэл, бичиг баримтаас Езра иш татан уг номыг бичсэн гэсэн үзлийг баримталдаг. Олон судлаачдын хувьд бас номын ихэнх хэсэг Нехемиагийн Иерусалимд буцаж ирсэн үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой хувийн тэмдэглэлээс бүрддэг учир түүнийг тус номын зохиогч гэж үздэг гэсэн үзлийг дэмждэг (1:1-7;73; 12:31-13:31).¹⁷

Хэдийгээр анхандаа Езра номтой нэг ном байсан боловч номын сүүлийн хагасыг Персийн хааны сөнч байсан, түүнчлэн Езратай нэг үед амьдарч байсан Нехемиагийн нэрээр нэрлэсэн. Нехемиа гэдэг нэр нь “ЭЗЭН тайвшруулдаг буюу тайтгаруулдаг” гэсэн утгатай.

Бичигдсэн огноо: Эртний Еврей Судрын сүүлийн хэсэг болох Езра-Нехемиа номын түүхэн үйл явдал нь бичигдсэн хугацаатай ижил буюу ойролцоогоор **МЭӨ 445-425 он**.

Сэдэв болон зорилго: Нехемиа ном нь цөллөгөөс буцаж ирсэн иудейчүүдийн түүхийг өгүүлдэг. Нехемиа Персийн хаан Артексеркс хааны сөнч байснаа болж, Иерусалимын захирагч болж, хотын ханыг засварлахад ард түмнийг удирдсан. Езра, Нехемиа нар нэг цаг үед амьдарч байсан (Нехемиа 8:2, 9). Тэд хоёулаа Бурханы хүмүүс байсан, гэхдээ Эзэнд өөр үүрэгтэйгээр үйлчилсэн. Езра тахилч байсан бөгөөд буцаж ирсэн үлдэгсдийн сүнслэг сэргээн босголтод илүү анхаарч байсан бол, Нехемиагийн хувьд Иерусалимын ханыг дахин барихад анхаарч, улс төрийн үүрэг хариуцлага бүхий захирагчаар ажиллаж байсан.

Нехемиа ном нь бас цөллөгийн он жилүүдийн дараа эх нутагтаяа Өөрийн ард түмнийг буцаан авчрахад Бурханы гар илэрхий байсан гэдгийг харуулахын тулд бичигдсэн. Зеруббабелийн удирдлага дор эхний хэсэг буцаж ирснээс хойш ерэн дөрвөн жилийн турш барьж чадаагүй байсан ханыг Нехемиагийн удирдлага дор тэд тавин хоёр өдрийн дотор барьж дуусгасан. Итгэл, дуулгавартай байдлаар дамжуулан, тэд дааж давамгүй мэт эсэргүүцлийг ялан гарч чадсан.¹⁸

Гол хүмүүс: Нехемиа, Артаксеркс, Санбаллат, Езра

Нехемиа ном дахь Христ: Сэргээн босгох ажлаа гүйцэтгэхийн тулд өндөр байр сууриа орхиход Христ бэлэн байсны дүр зургийг Нехемиа харуулдаг. Цаашилбал, Артаксерксийн зарлиг нь, хэдийгээр тодорхойгүй цаг хугацаагаар тасалдсан боловч, Мессиагийн ирэхийг тоолж эхлэх Даниельн далан долоо хоногийн эш үзүүллэг биелж эхэлснийг харуулдаг (Даниел 9:25-27).

Хувийн Судлалд: Агуулга

1. Ханыг дахин барьсан нь (1:1-7:73)

A. Дахиж барихад бэлтгэсэн нь (1:1-2:20)

1:1-11	2:1-10	2:11-20
--------	--------	---------

B. Дахин барьсан нь (3:1-7:73)

3:1-32	5:1-13	6:15-18
--------	--------	---------

4:1-8	5:14-19	7:1-65
-------	---------	--------

4:9-23	6:1-14	7:66-73
--------	--------	---------

2. Ард түмнийг сэргээн босгосон нь (8:1-13:31)

A. Гэрээний шинэчлэлт (8:1-10:39)

8:1-8	8:13-18	10:1-27
8:9-12	9:1-38	10:28-39

Б. Ард түмэн гэрээнд дуулгавартай байх нь (11:1–13:31)		
11:1-19	12:27-30	13:10-14
11:20-36	12:31-47	13:15-22
12:1-21	13:1-3	13:23-31
12:22-26	13:4-9	

Естер (Бурханы хүмүүсийн хамгаалалт)

Номын нэр болон зохиогч: Тус номыг хэн бичсэн нь тодорхойгүй, гэхдээ ямар ч гэсэн Персийн соёлыг маш сайн мэддэг хүн бичсэн. Зохиогч нь тэнд байсан, тайлбарлан бичиж буй үйл явдлаа нүдээр харсан гэрч байсан бололтой. Тиймээс, тэрээр иудей хүн байсан болов уу. Зарим хүмүүс Езра эсвэл Нехемиаг бичсэн гэж үздэг боловч энэ үзлийг дэмжих тодорхой баримт байдаггүй.¹⁹

Хадасса гэдэг еврей нэрийг өөрчлөн, “од” гэсэн утга бүхий Естер гэдэг перс нэрээр нэрлэх болсон гол баатрынх нь нэрээр тус номыг нэрлэдэг.

Бичигдсэн огноо: Естер номд гардаг үйл явдлууд нь Езра номын зургаа, долдугаар бүлгийн хооронд буюу Зеруббабелын удирдлагаар дор эхний хэсэг буцаж ирснээс Езрагийн удирдлагаар хоёр дахь хэсэг буцаж ирсэний хооронд болсон. Естер ном нь Ахашверош хааны сүүлчийн жилүүд (10:2-3) буюу түүний хүү Артаксеркскийн хаанчлалын (МЭӨ 464-424) үед МЭӨ 470-465 оны хооронд бичигдсэн.

Сэдэв болон зорилго: Естер номд Персийн Ахешверош хааны хатан болохоор сонгогдсон үзэсгэлэнт иудей охины түүх гардаг. Хаман бүх иудейчүүдийг алахаар төлөвлөх үед хатан Естерийн авга ах Мордехаи ард түмнээ аврахыг хичээ хэмээн Естерийг ятгасан. Естер амь насаараа дэнчин тавьж, иудейчүүдийг аврахын тулд хаанд бараалхсан. Хэдийгээр энэ нь Бурханы нэрийг дурдаагүй Библийн цорын ганц ном боловч хүнд хэцүү цаг, хавчлага зовлон дунд Бурхан ард түмнээ харж халамжилж байдаг гэдгийг харуулах нь тус номын зорилго болон сэдэв юм.

Гол хүмүүс: Естер, Хаман, Мордехаи, Ахешверош

Естер ном дахь Христ: Естер ард түмнийхээ авралын төлөө өөрийн амийг үхэлд хүргэхэд бэлэн байсан, мөн тэднийг өмгөөлөгч болсон зэргээрээ Христийг билэгддэг. Үүн дээр нэмээд, Бурхан Мессиаг өгөхийн тулд иудейчүүдийг байнга хамгаалж байсан гэдгийг бид харж болно.

Хувийн Судлалд: Агуулга

1. Иудейчүүдэд аюул нүүрлэсэн нь (1:1–3:15)

А. Вашти хатны оронд Естерийг хатнаар сонгосон нь (1:1–2:23)

1:1-9	2:1-7	2:17-20
1:10-22	2:8-16	2:21-23

Б. Иудейчүүдийн эсрэг Хаманы хуйвалдаан (3:1-15)

2. Иудейчүүдийг аварсан нь (4:1–10:3)

А. Иудейчүүдийн төлөөх Естериин шийдвэр (4:1–5:14)

4:1-8	4:15-17	5:9-14
4:9-14	5:1-8	

Б. Хаманы ялагдал (6:1–7:10)

6:1-9	7:1-6
6:10-14	7:7-10

В. Ахашверош хааны зарлиг ба Мордехаи (8:1-17)

8:1-8	8:9-17
-------	--------

- Г. Иудейчүүдийн дайснууд ялагдсан нь (9:1-19)
9:1-10 9:11-19
- Д. Пурим баярын өдрүүд (9:20-32)
- Е. Мордехайн нэр гавьяаг тунхаглаж, хааны удаах хүн болгосон нь (10:1-3)

З-р хэсэг

Яруу Найргийн Номууд

Оршил: Эхний арван долоон номын тойм (Хууль ба Түүх) буюу Эхлэлээс Нехемиа номыг хүртэл Хуучин гэрээний бүхий л түүхийг хамардаг. Бусад үлдсэн бүх номууд нь буюу яруу найргийн болон эш үзүүллэгийн номууд нь эдгээр арван долоон номын түүхэнд багтдаг. Энэ хэсэгт үзэх яруу найргийн номууд нь харьцангуй бага хэсэг бөгөөд Иов, Дуулал, Сургаалт үгс, Номлогчийн үгс, Соломоны дуун гэсэн таван ном ордог. Эдгээрийг үзэхийн өмнө, бид энэ таван номд бүгдэд нь байдаг зарим нэг онцлог шинжуудийг авч үзэх шаардлагатай.

“Яруу найргийн” гэсэн нэр томьёо нь эдгээр номын хэлбэрийг л зөвхөн хэлж байгаа гэдгийг оюутнууд тодорхой ойлгох хэрэгтэй. Түүнчлэн эдгээр нь жирийн нэг хүний уран сэтгэмжийн үр бүтээл биш юм. Энэ номууд нь жинхэнэ хүний амьдрал, туршлагыг дүрслэн харуулдаг.

Харилцаа: Бидний үзсэн арван долоон ном нь түүхийг, харин энэхүү яруу найргийн таван ном нь бодит амьдралыг өгүүлдэг. Эдгээр нь хувь хүмүүст тохиолдсон үйл явдлуудыг дүрслэн өгүүлдэг. Түүхэн номууд нь үндэстний талаар анхаардаг бол, яруу найргийн номууд нь ард түмний сэтгэл санаа, хандлагад илүү анхаардаг. Түүхэн номууд нь еврей үндэстний, харин яруу найргийн номууд нь хүмүүний зүрх сэтгэлийн тухай өгүүлдэг.

Яруу найргийн номууд нь Хуучин гэрээний Судар дахь цорын ганц яруу найраг биш юм. Эш үзүүллэгийн номуудад ч гэсэн томоохон хэмжээний яруу найраг байдаг гэдгийг бид хожим үзэх болно.

Бурханы сонгосон ард түмэн болох Израиль үндэстэнтэй холбоотой гол онцлог шинж зэргээс нь үүдэн Хуучин гэрээг үндсэн дервэн хэсэгт хуваадаг:

1. Хууль – Израилийн ёс суртахууны амьдралтай холбоотой
2. Түүхэн – Израилийн үндэсний хөгжил, амьдралтай холбоотой
3. Яруу найргийн – Израилийн сүнслэг амьдралтай холбоотой
4. Эш үзүүллэгийн – Мессия дотор биелэх Израилийн ирээдүйн амьдралтай холбоотой

Яруу найргийн таван номыг ч гэсэн өөр хоорондоо харилцах байдлаар нь авч үзэж болно.

1. Иов – Зовлонгоор дамжин ирэх ерөөл
2. Дуулал – Залбираар дамжин ирэх магтаал
3. Сургаалт үгс – Сургаал заавраас ирэх мэргэн ухаан
4. Номлогчийн үгс – Бодит байдлаар дамжин ирэх үнэн
5. Соломоны дуун – Нэгдмэл байдлаас ирэх баяр хөөр

Еврей яруу найргийн цаг үеүд: Еврей яруу найраг нь Хуучин гэрээний түүхийн туршид гардаг боловч яруу найргийг үндсэн гурван цаг үед хуваадаг:

1. Эцгүүдийн үе – Иов (ойролцоогоор МЭӨ 1750 он)
2. Давидын үе – Дуулал (ойролцоогоор МЭӨ 1050 он)
3. Соломоны үе (ойролцоогоор МЭӨ 950 он)
 - a. Соломоны дуун – залуу хүний хайр сэтгэл
 - b. Сургаалт үгс – дунд эргэм насны хүний мэргэн ухаан
 - c. Номлогчийн үгс – хөгшин хүний гашуудал (ойролцоогоор МЭӨ 950 он)²⁰

Яруу найргийн номууд дахь Христ: Өмнө дурдсанчлан, Мессия Христ бол бүхэл Библийн зүрх юм. Emmaу орох замд хоёр дагалдагч өмнөх өдрүүдэд нь болсон цовдлолт, үхэл, амилалтын тухай мэдээ зэргээс болж гуниглан, мөн эргэлзэж тээнэгэлзэн явж байх үед амилсан Аврагч тэдэн дээр ирж, Бичээст Өөрийнх нь тухай хэлсэн зүйлсийг тайлбарлаж өгсөн (Лук 24:27). Үүний дараа, тэр арван нэгэн шавьтайгаа уулзах үедээ ийн хэлсэн: “*Ta нартай хамт байхдаа Миний ярьж байсан үг ийм болой. Энэ*

нь Мосгийн Хууль, Эши узуулэгчид болоод Дуулал дахь Миний тухай бичигдсэн бүхэн биелэгдэх ёстой” (Лук 24:44)

Яруу найргийн ном тус бүрийг судалж эхлэхийн өмнө тэдгээрийн Христологийн байр суурийг ойлгож авах нь чухал юм. Энэ талаар Норман Жейслер ийн хэлсэн байdag:

Хуулийн номуудад Христийн ирэх суурийг тавьж, түүхэн номуудад Христийг ирэх бэлтгэлийг хийсэн бол яруу найргийн номууд нь ард түмний зүрх сэтгэлд Христ хэрэгтэй гэдгийг илчлэн харуулдаг юм. Эдгээр нь санаатай болон санамсаргүй, тодорхой болон тодорхойгүй байдлаар аль алинаар нь амьдрал Христ дотор биеллээ олдог гэдгийг харуулдаг.²¹

Иов ном нь Христийн зуучлалын хэрэгцээг, Дуулал нь Христтэй нэгдэх хэрэгцээг, Сургаалт үгс нь Христ доторх мэргэн ухааны хэрэгцээг, Номлогчийн үгс нь туйлын сэтгэл ханамжийн хэрэгцээг, Соломоны дуун нь Христтэй хайраар нэгдэх хэрэгцээг харуулдаг.

Еврей Яруу Найраг

Еврей яруу найргийн мөн чанар: Еврей яруу найраг нь англи яруу найргаас ялгаатай бөгөөд шүлгийн холбоц, хэмнэл зэргийг онцолдог. Еврей яруу найраг нь хэд хэдэн онцлог шинж чанартай. Библийн яруу найргийн хамгийн гол онцлог шинж бол зэрэгцүүлэл (нэг ижил утгыг өөр өөр мөрөнд харьцуулж, зэрэгцүүлэх) юм. Түүнчлэн еврей яруу найрагт маш олон “дүрслэл” хэрэглэсэн байdag.

Еврей яруу найргийн гурван төрөл: Еврей яруу найрагт дараах гурван төрөл бий: (1) Уянгын (шүлэглэсэн) яруу найраг, энэ нь анхнаасаа лир хөгжимтэй хоршин хэрэглэгддэг байсан (Дуулал); (2) Сургаалт (зааж сургасан) яруу найраг, энэ нь үнэний тунхаглалуудыг ашиглан, амьдралын үндсэн зарчмуудыг зааж ойлгуулдаг (Сургаалт үгс, Номлогчийн үгс); (3) Жүжигчилсэн яруу найраг, энэ нь харилцан яриаг ашиглан, хэлэх гэсэн мэдээгээ дамжуулдаг (Иов, Соломоны дуун).

Еврей яруу найргийн хоёр гол элемент: Зэрэгцүүлэл ба Дүрслэл

Зэрэгцүүлэл

Еврей яруу найраг нь бодол санааг өөр өөр байдлаар дахин давтаж илэрхийлдэг. Зэрэгцүүлэл гэдэг нь эдгээр бодол санааг харьцуулахыг хэлдэг. Бодол санааг зэрэгцүүлэн өгүүлэх хэд хэдэн хэлбэр бий:

- А. Ойролцоо утга – Энэ нь эхний мөрийн санааг ихэвчлэн хоёр дахь мөрөнд нь өөр үгээр давтан хэлдэг (Дуулал 2:4; 3:1; 7:17).
- Б. Эсрэгцүүлэл – Эхний мөрөн дэх санааг онцлохын тулд хоёр дахь мөрийн санаатай эсрэгцүүлэн харьцуулдаг (Дуулал 1:6; 34:10). Эдгээрийг “гэхдээ” гэдэг үгээр ялгаж таньж болно.
- В. Нийлмэл – Хоёр дахь мөр нь эхний мөрөн дэх санааг илүү хөгжүүлж, тайлбарладаг (Дуулал 1:3; 95:3).
- Г. Климатик – Хоёр дахь мөр нь сүүлийнх нь нэр томьёог өөр зүйлээр давтдаг. (Дуулал 29:1).
- Д. Билэгдлийн – Эхний мөр нь гол санааг агуулж, хоёр дахь мөр нь үүнийг ямар нэг зүйрлэлээр тодруулан тайлбарладаг (Дуулал 42:1; 23:1).

Дүрслэл

Нэг зүйлийг нөгөөгөөр төлөөлүүлэн хэрэглэхийг дүрслэл гэдэг. Аливаа бодол, сэтгэл санааг илэрхийлэхийн тулд еврей яруу найрагт дүрслэлийг хэрэглэдэг.

Жишиг нь: “**“Эзэний хуульд баярлагч нэгэн нь”** “урсгал усны дэргэд тарьсан мод адил” (Дуулал 1:2-3). “**Баярлагч нэгэн нь**” жинхэнэ “мод” биш харин түүнийг модтой адилтгаж байна. Иймэрхүү төрлийн өгүүлбэрүүдэд “шиг”, “мэт”, “адил” гэх зэрэг үгс орсон байгаа харж болно (Дуулал 5:12; 17:8; 131:2).

Нэг зүйлийг өөр зүйлтэй харьцуулахдаа “бол” гэдэг үгийг хэрэглэдэг дүрслэл бас байдаг. Дуулал 23:1-д, Давид “**“Эзэн бол миний Хоньчин”** гэсэн байdag. Давид өөрөө саглагар үстэй, дөрвөн хөлтэй хонь биш,

харин Эзэн бол хоньдоо халамжлагч хоньчинтой адил бөгөөд түүнийг халамжилдаг гэсэн санааг хэлж байна (Дуулал 84:11; 91:4).

Зарим тохиолдолд аливаа санааг онцлон тэмдэглэхийн тулд хэтрүүлэг хэрэглэдэг. Дуулал 6:6-д, Давид “Шоно бүр би ороо хөвүүлж, дэвсгэрээ ч нулимсаараа нэвт ногодог” гэсэн. Энэ нь түүний уйтгар гунигийг онцлон харуулж байна. Давид ороо хөвтөл уйлаагүй нь лавтай (Дуулал 78:27; 107:26).

Заримдаа асууж тодруулахын тулд биш харин баталж, эсвэл эсэргүүцэхийн тулд асуулт асуусан байдаг. Давид Дуулал 35:10-д “Хэн Тантай адил вэ?” хэмээн асуухдаа, зүгээр л “Түүнтэй адил хэн ч үгүй” гэсэн хариуг авахын тулд биш, харин Бурханы агуу байдлыг онцлон харуулахыг хүссэн (Дуулал 56:8; 106:2).

Дүрслэлийн хамгийн сүүлийн жишээ бол Бурханы бодгалийг тайлбарлахын тулд амьтны зарим хэсгийг ашиглах юм. Энэ нь Бурханы талаарх тодорхой нэг үнэнийг харуулахын тулд хэрэглэгддэг. Жишээ нь, Дуулал 17:8-д Давид Эзэнээс “далавчнуудынхаа сүүдэрт намайг халхлаач” гэж гүйж байна. Бурхан бол шувуу биш, гэхдээ эх шувуу үр төлөө хамгаалдаг шиг өөрийг нь хамгаалаач гэж Давид Бурханаас гүйж байна (Дуулал 91:4).

Иов

(Зовлонгоор дамжин ирэх ерөөл)

Номын нэр болон зохиогч: Иов ном нь уг номын гол баатрын нэрээр нэрлэгдсэн бөгөөд Иов нь түүхэн хүн байсан (Езекиел 14:14, 20; Иаков 5:11) гэдгийг бид мэдэх боловч зохиогч нь хэн гэдэг нь тодорхойгүй агаад зохиогчийн талаар бичигдсэн ямар нэг зүйл байдаггүй. Тайлбар толь бичигчид зохиогч нь Иов өөрөө, Елихү, Мose, Соломон, эсвэл өөр бусад хүн байсан гэж үздэг.

Энэ ном нь Абрахам, Исаак, Иаков, Иосефын цаг үед, туйлын их (эд баялаг, гэр бүл, эрүүл мэндээ алдан) зовлон амсаж, яагаад гэж асууж буй Иов хэмээх гол дүрийнхээ баатраар нэрлэгдсэн ном юм.

Бичигдсэн огноо: Бид нэгэнт зохиогч нь хэн бэ гэдгийг тодорхойлж чадахгүй тул бичигдсэн цаг хугацааг нь тогтоох боломжгүй. Гэхдээ Мосегийн хууль өгөгдөхөөс өмнө тухайн түүх болж өнгөрсөн гэсэн цаг хугацааг тогтоож болно (МЭӨ 1445–1405). Хууль өгөгдөж, Левичүүдийн тахилчлал бий болохын өмнө гэр булийн тэргүүн нь тахилч байсан. Иов гэр бүлийнхээ тахилчийн хувьд тахил өргөж байгаа тухай гардаг (Иов 1:5). Энэ нь Хууль өгөгдөхөөс өмнөх үйл явдал болохыг харуулж байна. Абрахамын цаг үед энэ түүх болж өнгөрсөн бололтой байдаг.

Сэдэв болон зорилго: Тус ном нь зовлон зүдгүүр, бузар муу нүүрлэсэн үе дэх Бурханы сайн сайхан, шударга ёс болон хамгийн дээд эрх мэдлийг харуулдаг. Ингэхдээ, уг ном нь хэрвээ Бурхан энэрэл хайрын Бурхан юм бол, зөвт хүн зовохыг яагаад зөвшөөрдөг вэ? гэсэн асуулттай тэмцэлддэг. Энэ нь Бурханы дээд эрх мэдэл болон хүн үүний хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг тодорхой заадаг. Иовын гурван найз өрөнхийдөө ижилхэн хариулт өгдөг. Тэд бүхий л зовлон зүдгүүр нь нүглийн үр дагавар гэдэг. Харин Елихү зовлон нь ихэнхдээ зөвт нэгнийг цэвэршүүлэн, ариутгах арга болдог хэмээн хэлдэг. Тийм ч учраас, Иовын өөрийн зөвт байдлыг арилгаж, түүнийг Өөрт нь бүрэн итгэдэг тийм байр сууринд аваачих нь Бурханы зорилго байв.²² Энэ сэдвийг нэгтгэн Глеасон Арчер дараах дүгнэлтийг өгсөн байдаг:

Энэ ном нь бурханлаг хүний амьдрал дахь гай гамшиг, өвчин зовлон зэргийн онолын асуудлыг хөнддөг. Энэ нь зөвт хүн яагаад зовдог вэ гэсэн асуултын хариуг өгдөг. Энэ хариулт нь гурван талт хэлбэрээр гарч ирдэг: (1) Бурхан бол Түүний өгдөг ивээл ерөөлөөс нь ангид байсан ч хайрлуулах зохист нэгэн; (2) Бурхан бурханлаг хүний сүнсийг хүчирхэгжүүлж, цэвэршүүлэх арга хэрэгсэл болгож зовлон зүдгүүрийг зөвшөөрөх боломжтой; (3) Бурханы арга замууд ба бодол нь хүний өчүүхэн жижиг оюун ухаантай харьцуулбал дэндүү уудам өргөн. Хэдийгээр хүн амьдралд тохиолдож буй асуудлуудыг Бүхний чадагч Нэгэний алсын хараа, өргөн хүрээгээр харж чаддаггүй боловч харин Бурхан Өөрийнх нь алдар хүнд болон бидний туйлын сайн сайхан байдалд юу нь хамгийн

сайн бэ гэдгийг үнэхээр мэддэг юм. Иовын гурван “тайтгаруулагч” Елифаз, Билдад, Зофар нарын үзэл бодлын эсрэг энэ хариулт өгөгдөж байна.²³

Номын өөр нэг зорилго бол Бурхан ба Сатаны хоорондын цаг үеийн зөрчилдөөнийг болон зовлон зүдгүүр энэ зөрчилдөөнтэй ямар хамаарлтай болохыг харуулдаг. Төгсгөлд нь хэлэхэд, энэ нь Ром 8:28 дахь үнэнийг батлан харуулж байна.

Гол хүмүүс: Гэм зэмгүй, зөвт хүн Иов; Иовыг буруутгагчид Елифаз, Билдад, Зофер; Иовын найзуудаас илүү залуу, илүү ухаалаг Елиху; Сатан.

Иов ном дахь Христ: Иов номд Христийг хэд хэдэн байдлаар харуулсан. Иов Чөлөөлөгчийг хүлээн зөвшөөрч (19:25-27), мөн Зуучийн төлөө залбирдаг (9:33; 33:23). Иов “зовлонгийн” нууцыг тайлбарлаж өгөх хэн нэгэн өөрт нь хэрэгтэй байна гэдгийг мэдэж байсан бөгөөд энэ нь зөвхөн Христ дотор хариулагдсан. Христ бидний зовлон зүдгүүрийг өөртөө авч, Бурханы эсрэг Сатаны буруутгалд төгс хариултыг өгөн, түүнийг ялсан юм (Еврей 2:14-18; 4:15; Ром 8:32-34).

Хувийн Судлалд: Агуулга

1. Өмнөтгөл: Иовд тохиолдсон гамшигууд (зовлон шаналал) (1:1–2:13)

- A. Түүний нөхцөл байдал ба зан чанар (1:1-5)
- B. Түүний асуудлууд ба эдгээрийн эх сурвалж - Сатан (1:6–2:10)

1:6-12	1:13-22	2:1-10
--------	---------	--------
- C. Түүнийг тайтгаруулагчид (2:11-13)

2. Гурван найзынх нь хуурамч тайтгаруулал ба харилцан яриа (3:1–31:40)

- A. Маргааны эхний тойрог (3:1–14:22)
 - 1) Иовын гашуудал (3:1-26)

3:1-19	3:20-26	
--------	---------	--
 - 2) Елифазын хариулт (4:1–5:27)

4:1-11	5:1-7	5:17-27
4:12-21	5:8-16	
 - 3) Иовын хариулт (6:1–7:21)

6:1-7	6:24-30	7:7-10
6:8-13	7:1-6	7:11-21
6:14-23		
 - 4) Билдадын хариулт (8:1-22)

8:1-7	8:8-10	8:11-22
-------	--------	---------
 - 5) Иовын хариулт (9:1–10:22)

9:1-12	9:25-35	10:8-17
9:13-24	10:1-7	10:18-22
 - 6) Зофарын хариулт (11:1-20)

11:1-6	11:7-12	11:13-20
--------	---------	----------
 - 7) Иовын хариулт (12:1–14:22)

12:1-6	13:13-19	14:13-17
12:7-12	13:20-28	14:18-22
12:13-25	14:1-6	
13:1-12	14:7-12	
- B. Маргааны хоёр дахь тойрог (15:1–21:34)
 - 1) Елифазын хариулт (15:1-35)

15:1-16	15:17-35	
---------	----------	--
 - 2) Иовын хариулт (16:1–17:16)

16:1-5	16:18-22	17:6-16
16:6-17	17:1-5	

3)	Билдадын хариулт (18:1-21) 18:1-4	18:5-21	
4)	Иовын хариулт (19:1-29) 19:1-6	19:7-22	19:23-29
5)	Зофарын хариулт (20:1-29) 20:1-11	20:12-19	20:20-29
6)	Иовын хариулт (21:1-34) 21:1-16	21:17-26	21:27-34
B.	Маргааны гурав дахь тойрог (22:1-31:40)		
1)	Елифазын хариулт (22:1-30) 22:1-11	22:12-20	22:21-30
2)	Иовын хариулт (23:1-24:25) 23:1-7 23:8-17	24:1-12 24:13-17	24:18-25
3)	Билдадын хариулт (25:1-6)		
4)	Иовын хариулт (26:1-31:40) 26:1-4 26:5-14 27:1-6 27:7-12 27:13-23 28:1-11 28:12-22 28:23-28	29:1-20 29:21-25 30:1-8 30:9-15 30:16-23 30:24-31 31:1-4 31:5-8	31:9-12 31:13-15 31:16-23 31:24-28 31:29-37 31:38-40

3. Елихугийн үгс (32:1-37:24)

A.	Эхний үг: Зовлон шаналлаар дамжуулан Бурханы хүнд өгдөг зааварчилгаа (32:1-33:33)		
	32:1-10	33:1-7	33:19-22
	32:11-14	33:8-12	33:23-28
	32:15-22	33:13-18	33:29-33
B.	Хоёр дахь үг: Бурханы шударга байдал ба хэрсүү чанарыг баталсан нь (34:1-37)		
	34:1-9	34:16-20	34:31-37
	34:10-15	34:21-30	
B.	Гурав дахь үг: Цэвэр ариун байдлын давуу талууд (35:1-16)		
	35:1-8	35:9-16	
G.	Дөрөв дэх үг: Бурханыг шударга бус хэмээн буруутгасан Иовын гэм буруу ба Бурханы агуу байдал (36:1-37:24)		
	36:1-16	36:24-33	37:14-20
	36:17-23	37:1-13	37:21-24

4. Шуурган дотроос ирсэн Бурханы илчлэлт (38:1-42:6)

A.	Эхний илчлэлт (38:1-40:5)		
1)	Бурханы бүхний чадагч байдал бүтээлд тунхаглагдсан нь (38:1-39:30)		
	38:1-7	38:25-30	39:5-12
	38:8-11	38:31-33	39:13-18
	38:12-15	38:34-38	39:19-25
	38:16-18	38:39-41	39:26-30
	38:19-24	39:1-4	
2)	Иовын өөрийгөө буруутгасан өчил (40:1-5)		
B.	Хоёр дахь илчлэлт: Бурханы хүч ба хүний сүл дорой байдал; Иовын даруу хариулт (40:6-42:6)		
	40:6-9	40:19-24	41:12-34
	40:10-14	41:1-11	42:1-6
	40:15-18		

5. Сүүлийн тайлбарууд (42:7-17)

- А. Худал тайтгаруулагчдыг Бурхан зэмлэсэн нь (42:7-9)
- Б. Иовын сэргэлт ба шагнал (42:10-17)

Дуулал

(Залбираар дамжин ирэх магтаал)

Номын нэр болон зохиогч: Дуулал ном нь Библийн хамгийн урт ном бөгөөд энэ нь амьдралд тулгардаг бүхий л нөхцөл байдлын талаар хүмүүний зүрх сэтгэлд ярьдаг учир Судар дахь хамгийн өргөн ашиглагддаг ном гэж хэлж болно. Залбирай болон магтаалаар дамжуулан санаа алдалт нь дуу болж олонтаа өөрчлөгддөг. Номын ихэнх хэсгийн хувьд Дуулал номын эх бичвэрт нь зохиогчийнх нь тухай байдаггүй боловч, ихэнх тохиолдолд гарчиг нь зохиогчийнхоо тухай өгүүлдэг. Гарчигт өгүүлсэн байдлаар нь дууллуудын зохиогчийг тодорхойлбол:²⁴

Дууллуудыг зохиогчид		
Давид	78	Дуулал 1-41; 51-70; 86; 103; 108-110; 122; 124; 131; 133; 138-145
Асаф	12	Дуулал 50, 73-83
Корагийн хөвгүүд	12	Дуулал 42-49; 84-85; 87-88
Соломон	2	Дуулал 72, 127
Мосе	1	Дуулал 90
Етан	1	Дуулал 89
Тодорхой бус	44	Дуулал 71; 91-102; 104-107; 111-121; 123; 125-126; 128-130; 132; 134-137; 146-150

Еврей хэлээр Дуулал ном нь “Магтаал” буюу “Магтаалын ном” гэсэн нэртэй байдаг. Зөвхөн ганц Дуулал л (145) “магтаал” гэдэг үгээр нэрлэгдсэн боловч Дуулал номын амин зүрх нь магтаал юм. Дууллууд нь “дуу буюу хөгжмийн зэмсэгтэй хамт дуулагдах шүлэг” юм. “Дуулал” гэдэг үг нь хоршин дуулахаар “утсан хөгжим тоглох” гэсэн утгатай еврей үгээс гаралтай.

Бичигдсэн огноо: Дуулал ном нь маш өргөн утга агуулгатай, цаг хугацааны хувьд их өргөн хүрээг хамарсан, янз бүрийн нөхцөл байдал дунд амьдарч байсан маш олон төрлийн сонсогчидтой ном юм. Дуулал ном нь олон арван ааш араншин, нөхцөл байдлыг тусган харуулдаг учир ямар цаг үед амьдарч байгаагаас үл хамааран үүнийг үншигч нэгэнд тус ном нь үнэхээр чухал ач холбогдолтой байдаг аж. Дуулал номын бичигдсэн он цагийн талаар Глеасон Арчер ийн бичсэн байдаг:

Эдгээрээс, хамгийн эртнийх нь буюу Мосегийн бичсэн Дуулал 90 нь МЭӨ 1405 оны үед зохиогдсон байх магадлалтай. Давидын дууллууд нь анх МЭӨ 1020 оноос 975 оны хооронд бичигдсэн бөгөөд Асафын дууллууд мөн үүнтэй ойролцоо цаг үед бичигдсэн. Дуулал 127 нь Соломоны хаанчлалын үеийнх буюу МЭӨ 950 оных бололтой. Энд дурдагддаг Корагийн болон Езрахитчүүдийн үр удмынхны цаг хугацааг тодорхойлоход хүндрэлтэй байдаг бөгөөд тэднийг цөллөгийн өмнөх үеийнх болов уу гэж үздэг. Зарим дууллуудад гарчиг байдаггүй, тэдний зарим нь Давидынх гэдэг нь эргэлзээгүй (жишээ нь, Дуулал 2, 33) бусад нь нэлээн хожуу үеийнх буюу цөллөгөөс буцаж ирэх хүртэлх цаг хугацааг хамарсан гэж үзэж болно (126, 137 гэх мэт, 137 нь дор хаяж цөллөгийн үеийнх). Гэхдээ нэгэн баттай зүйл бол аль ч дууллыг ойролцоогоор МЭӨ 500 оноос хойш бичигдсэн гэж үздэггүй.²⁵

Сэдэв болон зорилго: Дуулал ном нь мөргөлийн ерөнхий сэдвээр дамжуулан итгэл найдвар, тайтгарлын мэдээг бидэнд хүргэдэг. Эдгээр нь үндсэндээ Бурханы бодгаль болон ажил үйлсэд хандаж буй хувь хүний хариу үйлдэл болох айdas, гомдол зэрэгт зориулсан ерөндөг юм. Эдгээр нь Израилийн сүнслэг амьдрал, итгэл, мөргөлийн илэрхийлэл юм. Дуулал номд дэлхий ертөнц дэх энгийн хүмүүний амьдралын туршлагуудыг Бурханы мөн чанар, амлалт, төлөвлөгөө, оршихуйн талаас харж бичсэн байдаг бөгөөд бид үүнээс Бурханы ард түмний зүрх сэтгэлийг тольдон харж болно.

150 дууллын цуглуулгад олон төрлийн сэдэв, нөхцөл байдал, бодол санааг багтаасан байдаг. Энэ нь тус номыг ямар нэг зорилго болон сэдвээр өрөнхийлөн дүгнэхэд төвөгтэй гэсэн утгатай, гэхдээ дууллууд нь бүгдээрээ Бурханы сайн сайхан болон извэл нигүүсэлд хандсан итгэгч хүний хувийн хариуг багтаасан байдаг гэж баттайяа хэлж болно. Дууллыг бичигч нь Бурханы дайснуудаас аюул занал нүүрлэх үед, эсвэл Бурханы олон төрлийн хангамж (үйлдлүүд)-ийг харах үед гарч ирж байсан өөрийнхөө урам хугаралт, айдас эсвэл баяр талархлаас үүдэлтэй дотоод сэтгэлийн хөдлөлөө эдгээр дуулалд бичиж үлдээсэн байдаг. Дууллыг бичигч гуниг зовлонтой, эсвэл баяр хөөртэй ямар ч сэдвээр бичсэн өөрийгөө амьд Бурханы оршихуйд байгаагаар илэрхийлсэн байдаг. Мэдээж хэрэг, Дуулал 2-р бүлэг гэх мэт Бурханы Өөрийнх нь илчлэлт, бодол санаа зэргийг голлон агуулсан хэд хэдэн дуулал байдаг, гэхдээ энэ нь нэлэн онцгой тохиолдол юм.²⁶

Дууллуудын олонх нь Бурханы Үг, Түүний мөн чанаруудын тойм болон ирэх Мессиатай холбоотой мессиагийн дууллууд байдаг.

Дуулал номыг хуваах нь: Дуулал ном нь үнэхээр таван номыг нэгтгэсэн нэг ном юм. Ном тус бүр магтаалаар (Бурханыг магтсан магтаал) төгсдөг бөгөөд Дуулал 150 нь цуглуулгыг бүхэлд нь дүгнэсэн дүгнэлт хэлбэрээр бичигдсэн магтаал юм.

Епифаниус “Еврейчүүд Дуулал номыг таван номд хуваасан бөгөөд энэ нь дахин өөр нэг Пентатух болж байгаа юм” гэж хэлсэн байдаг. Дуулал 1:1-ийн Мидрашид “Мосе Израильчуудад Хуулийн таван номыг өгсөн, харин эдгээртэй адилаар Давид тэдэнд Дууллын таван номыг өгсөн” гэсэн байдаг.²⁷

Пентатухтай тохирох байдлыг дараах тоймоор харуулж болох юм:²⁸

1. Хүн болон бүтээлийн тухай дууллууд (1-41) – Эхлэл номтой тохирдог.
2. Израиль болон Чөлөөлөлтийн тухай дууллууд (42-72) – Египетээс гарсан нь номтой тохирдог.
3. Мөргөл болон Сүмийн тухай дууллууд (73-89) – Левит номтой тохирдог.
4. Газар дэлхий дээрх бидний түр амьдралын тухай дууллууд (90-106) – Тооллого номтой тохирдог.
5. Бурханы Үг болон магтаалын тухай дууллууд (107-150) – Дэд хууль номтой тохирдог.

Номыг өөр хэлбэрээр хуваасан байдал:

Ном	Дуулал	Зохиогч	Гол агуулга
I	Дуулал 1- 41	Давид	Мөргөлжийн дуунууд
II	Дуулал 42 - 72	Давид & Кора	Гашуудлын дуун
III	Дуулал 73 - 89	Голлон Асаф	Гашуудлын дуун
IV	Дуулал 90 - 106	Голлон нэр нь үл мэдэгдэх зохиогч	магтаалын магтуу
V	Дуулал 107 - 150	Давид & нэр нь үл мэдэгдэх зохиогч	магтаалын магтуу

Дуулал номын төрөл буюу ангиллууд: Дууллуудыг төрөл байдлаар нь дараах ангиллуудад өрөнхийд нь хувааж, ангилдаг:

1. **Гашуудал** буюу Гуйлт, хувь хүний (Дуулал 3) эсвэл нийтийн (Дуулал 44)
2. **Талархал** буюу Магтаал, хувь хүний (Дуулал 30) эсвэл нийтийн (Дуулал 65)
3. Бурханд итгэх **Итгэл** (Дуулал 4)
4. ЭЗЭН **хааны** магтуунууд: Иерусалимын талаарх дууллууд (Дуулал 48), болон Хааны дууллууд (зарим нь Мессиагийнх; Дуулал 2, 110)
5. **Сургаалын** (зааж сургасан) болон **Мэргэн ухааны** дууллууд (Дуулал 1, 37, 119)
6. **Сэдэвт** дууллууд: Дууллуудыг дотор нь онцгой сэдвүүдийн дагуу ангилж болно. Жишээ нь: Бүтээлийн дууллууд (Дуулал 8, 19), Байгалийн дууллууд (Дуулал 19, 104), Толгой, сүүл холбосон эсвэл цээжлэхэд зориулсан дууллууд (Дуулал 111, 112, 119), Египетээс гарсан нь (Дуулал 78), Гэмшил (Дуулал 6), Мөргөлчний дуулал (Дуулал 120), Мессиагийн дууллууд болон Месииагийн тухай эш үзүүллэг бүхий дууллууд (Дуулал 2, 8, 16, 22, 40, 45, 72, 110, 118).

Гол хүмүүс: Дуулал номын гарчгууд нь Давид, Кора гэх мэтээр Дууллыг зохиогчийг буюу сэдвийг нь хэлдэг боловч Дуулал номын эх бичиг нь өөрөө тийм биш байдаг. Харин үүний оронд энэ нь Бурханы ард түмний мөргөл болон Эзэнтэй хамт алхах амьдралд илүү анхаардаг.

Дуулал ном дахь Христ: Дуулал номын олонх нь Мессиагийн дуулал байдаг бөгөөд Христийн бодгаль болон ажлын талаар өгүүлдэг. Эдгээрийг дараах байдлаар ангилж болно:

- Ерөнхийдөө Мессиагийн:** Эдгээр дуулал нь Мессиагийнх гэдэг нь нэлээн тодорхой харагддаг. Дууллыг бичигч нь зарим талаараа Христийн билэгдэл байдаг (уд.харьц. 34:20; 69:4, 9), гэхдээ багц ишлэлийн зарим хэсгүүд нь үүнд тохирдоггүй. Ийм тохиолдолд, Есүс болон элч нар дууллын илэрхийллэлтэй төстэй зүйлийг амсаж туулсан гэж хэлж болох юм (жишээ нь, 109:8 нь Үйлс 1:20-д).
- Билэгдэл – эш үзүүллэгийн:** Хэдийгээр дууллыг бичигч өөрийнхөө хувийн туршлагыг өгүүлж буй боловч үүнийг илэрхийлж буй хэл яриа нь түүний хувийн амьдралаас хол хэтэрсэн бөгөөд зөвхөн Христийн бодгальд л түүхэн байдлаар үнэн болсон зүйлс байдаг (22).
- Шууд бус байдлаар Мессиагийн:** Тухайн дуулал Давидын гэр юмуу эсвэл тодорхой нэг хаанд зориулагдсан бичигдсэн боловч үүний эцсийн бөгөөд туйлын биелэлт нь зөвхөн Христийн бодгальд л биелэх боломжтой байдаг (2, 45, 72).
- Цэвэр эш үзүүллэгийн:** Эдгээр дуулал нь Давидын хүү ч юмуу эсвэл ямар нэг хүнд хамааруулаагүй, харин шууд Христэд зориулагдсан дуулал байдаг (110).
- Хааны:** Эдгээр дуулал нь Мессия Христийн дотор биелэх тэрхүү Эзэний ирэлт болон Түүний хаанчлал байгуулагдахыг хүсэн хүлээсэн дууллууд юм (96-99).

Христийн амьдралд биелсэн тодорхой эш үзүүллэгийн биеллүүд:

Эш үзүүллэг	Дуулал	Шинэ гэрээний ишлэлүүд
1. Төрөлт	104:4	Еврей 1:7
2. Даруу болгогдсон нь	8:4	Еврей 2:6
3. Бурханлаг чанар	45:6	Еврей 1:8
4. Үйлчлэл	69:9	Иохан 2:17
5. Түүнийг эсэргүүцсэн нь	118:22	Матай 21:42
6. Түүнээс урvasан нь	41:9	Иохан 13:18
7. Цовдлогдсон үйл явдал	22	Матай 27:39, 43, 46; Лук 23:35
8. Амиалт	2 ба 16	Үйлс 2:27
9. Дээш одсон нь	68:18	Ефес 4:8
10. Хаанчлал	102:26	Еврей 1:11

Хувийн Судлалд: Агуулга

1. I ном: Мөргөлийн дуунууд (Дуулал 1–41)

- Дуулал 1: Ерөөгдсөн хүн: Амьдралын хоёр хэлбэрийг харьцуулсан нь: Уг ба Дэлхий
 Дуулал 2: Мессия Хаан: Бурхан болон Христийн эсрэг нэгдсэн нь
 Дуулал 3: Зовлон зүдгүүр дундах чимээгүй байдал: Аюул доторх хамгаалалт
 Дуулал 4: Бурханд итгэх итгэлийн оройн залбирайл
 Дуулал 5: Бурханы оршихуй дотор Бурханд итгэх өглөөний залбирайл
 Дуулал 6: Хүнд зовлон дундах зүрх сэтгэлийн залбирайл
 Дуулал 7: Хоргodoх залбирайл
 Дуулал 8: Бүтээгчийн алдар суу ба хүний сүр жавхлан
 Дуулал 9: Бурханы шударга байдлын төлөөх талархлын залбирайл
 Дуулал 10: Хорон муу нэгнийг ялахын төлөөх залбирайл
 Дуулал 11: Эзэн бол хоргodoх газар ба хамгаалалт
 Дуулал 12: Худалч хэлний эсрэг тусlamж хүссэн залбирайл
 Дуулал 13: Хүнд хэцүү үед тусlamж хүссэн залбирайл
 Дуулал 14: Хүний хорон муу байдал ба тэнэглэлийг тайлбарласан нь
 Дуулал 15: Бурханлаг хүний тухай тайлбар

- Дуулал 16: Эзэн бол ариун хүмүүсийн хоргodoх газар
 Дуулал 17: Бурханы шударга байдлаар дамжуулан чөлөөлөгдөхийн төлөөх залбиral
 Дуулал 18: Чөлөөлөлтийг магтсан залбиral
 Дуулал 19: Бурханы бүтээл, ажил үйлс болон бичигдсэн үг доторх Түүний илчлэлт
 Дуулал 20: Дайснуудаа ялахын төлөөх залбиral
 Дуулал 21: Хааны хүчтэй Эзэн
 Дуулал 22: Загалмайн дүр зураг: Зовлонгийн дуулал ба магтаал
 Дуулал 23: Тэнгэрлэг Хоньчны дүр зураг: Бурханы сайн сайхны тухай дуулал
 Дуулал 24: Алдрын Хааны дуулал
 Дуулал 25: Акростик (толгой холбосон) дуулал: Чөлөөлөлт, удирдамж, учлалын төлөөх залбиral
 Дуулал 26: Чөлөөлөлт болон шударга шулнуун байдлын төлөөх гуйлт
 Дуулал 27: Айдасгүйгээр Эзэнд итгэхийн төлөөх залбиral
 Дуулал 28: Тусlamжийн төлөөх залбиral ба үүний хариултын төлөөх магтаал—Эзэн бол миний Хад
 Дуулал 29: Бурханы хүчирхэг дуу хоолой
 Дуулал 30: Хэрэгцээт цаг үед Бурханы итгэмжит байдлын төлөө талархсан залбиral
 Дуулал 31: Гомдол, гуйлт, магтаалын залбиral
 Дуулал 32: Бурханд итгэх итгэл ба учлалын ерөөл
 Дуулал 33: Бүтээгч ба Чөлөөлөгч Эзэнийг магтаах нь
 Дуулал 34: Хангагч ба Чөлөөлөгч Эзэнийг магтаах нь
 Дуулал 35: Дайснаасаа аврагдах болон шударга ёсны төлөөх залбиral
 Дуулал 36: Хүмүүсийн бузар муу байдлыг Бурханы хайр энэрэлтэй харьцуулах нь
 Дуулал 37: Эзэн дотор амрахыг гүйсан гуйлт
 Дуулал 38: Эвлэрийн залбиral, гэм нуглийн хүнд ачааг мэдрэх нь
 Дуулал 39: Хүний сул дорой байдлыг хүлээн зөвшөөрсөн залбиral
 Дуулал 40: Авралыг хүлээн авч, мэдэрсэн баяр хөөртэй магтаал
 Дуулал 41: Бэрхшээл дундах Бурханы ерөөлийг магтсан нь

2. II ном: Гашуудлын дуун (Дуулал 42–72)

- Дуулал 42-43: Бурханыг хүсэн, Эзэний авралд найдах нь
 Дуулал 44: Үндэсний гашуудал ба Золилтын төлөөх залбиral
 Дуулал 45: Давидын хүүгийн хуримын дуу
 Дуулал 46: Бурхан бол бидний хоргodoх газар ба хүч чадал
 Дуулал 47: Эзэн бол ялагч Хаан
 Дуулал 48: Үзэсгэлэнт хот, Сион уулын магтаал
 Дуулал 49: Мэргэн ухаантүй баячуудын хоосон байдал
 Дуулал 50: Талархлын тахил
 Дуулал 51: Нүглээ хүлээн зөвшөөрөх ба нүглийн уччал
 Дуулал 52: Бардам, хорон муу хүний утгагүй явдал
 Дуулал 53: Бурхангүйчүүдийн дүр зураг
 Дуулал 54: Эзэн бол бидний Тусlamж
 Дуулал 55: Эзэн зөвт нэгнийг дэмжин тусладаг
 Дуулал 56: Айдас дундах итгэл
 Дуулал 57: Тусгаарлагдсан байдал дундаа Эзэний өргөмжлөх нь
 Дуулал 58: Зөвт хүн зайлшгүй шагнагдах болно
 Дуулал 59: Дайснуудаас чөлөөлөгдөхийн төлөөх залбиral
 Дуулал 60: Үндэстний чөлөөлөлтийн төлөөх залбиral
 Дуулал 61: Сул дорой зүрх сэтгэлээс гарах залбиral
 Дуулал 62: Эзэнийг хүлээх нь
 Дуулал 63: Бурханы хайраар цангахуй
 Дуулал 64: Хамгаалалтын төлөөх залбиral
 Дуулал 65: Газар дэлхий болон хүнийг гэсэн Бурханы харамгүй сэтгэл
 Дуулал 66: Бурхан юу хийснийг дурсан сана
 Дуулал 67: Бүх хүнийг Бурханыг магтаад уриалсан нь
 Дуулал 68: Бурхан бол дарлагдагсдын Эцэг

- Дуулал 69: Бурханы энэрэл хайрын дагуух чөлөөлөлтийн төлөөх залбирал
 Дуулал 70: Ядуу, зовж зүдэrsэн хүний төлөөх залбирал
 Дуулал 71: Өндөр настны төлөөх залбирал
 Дуулал 72: Мессиагийн алдарт хаанчлал
- 3. III ном: Гашуудлын дуун (Дуулал 73–89)**
- Дуулал 73: Мөнхийн байр суурийн төлөөх залбирал
 Дуулал 74: Үндэсний бэрхшээл зовлонгийн үед тусlamж хүссэн гүйт
 Дуулал 75: Шударга ёс бол Эзэнийх
 Дуулал 76: Иаковын Бурханы ялагч хүч чадал
 Дуулал 77: Зовлон зүдгүүрийн өдөрт Бурханы агуу байдлыг санагтун
 Дуулал 78: Израилийн түүхээс сурх хичээл
 Дуулал 79: Өөрийн бэлчээрийн хоньдыг санахыг Эзэнээс гүйсан гүйт
 Дуулал 80: Бурханы хайр энэрлийг гүйсан Израилийн гүйт
 Дуулал 81: Эзэнийг сонсохыг Израилиас гүйсан нь
 Дуулал 82: Шударга бус шүүгчдийг зэмлэсэн нь
 Дуулал 83: Израилийн дайснуудыг шүүхийн төлөөх залбирал
 Дуулал 84: Бурханы оршихуйг чин сэтгэлээсээ хүсэх нь
 Дуулал 85: Сэргэлтийн төлөөх залбирал
 Дуулал 86: Үндэстэн дээрх хайр энэрлийн төлөөх залбирал
 Дуулал 87: Сионд амьдрахын баяр хөөр
 Дуулал 88: Цөхрөлийн харанхуйн дундах залбирал
 Дуулал 89: Бурханы бодгалийг болон зовлон шаналлын төлөөх амлалтуудыг тунхаглах нь
- 4. IV ном: Магтаалын дуун (Дуулал 90–106)**
- Дуулал 90: Өөрсдийнхөө өдрүүдийг тоолохыг бидэнд заагаач
 Дуулал 91: Хамгийн дээд Нэгэний хоргodoх газарт
 Дуулал 92: Эзэнийг магтагтун
 Дуулал 93: ЭЗЭН алдартайгаар хаанчилдаг
 Дуулал 94: ЭЗЭН бол газар дэлхийн шүүгч: Өшөө авалт бол Түүнийх
 Дуулал 95: Биднийг Бүтээгчийн өмнө өвдөг сөгдөцгөө: Мөргөлд уриалсан дуудлага
 Дуулал 96: Дэлхий ертөнцийг зөвт байдал дотор шүүх Эзэнд мөргөгтүн
 Дуулал 97: Баярлагтун! Эзэн хаанчилж байна
 Дуулал 98: Эзэнд шинэ дууг дуулагтун
 Дуулал 99: Хаанчлагч Эзэнийг өргөмжлөгтүн
 Дуулал 100: Эзэнд баяртайгаар үйлчил: Тэр бол Эзэн, Тэр бол сайн
 Дуулал 101: Ариун амьдралын амлалт
 Дуулал 102: Дарлагдсан ариун хүний залбирал
 Дуулал 103: Эзэнийг магтагтун: Түүний энэрэл хайр мөнхийнх!
 Дуулал 104: Бүх бүтээлийг хalamжлагч Эзэний хайр хalamж
 Дуулал 105: Авралын түүхэн дэх Эзэний итгэмжит үйлс
 Дуулал 106: ЭЗЭНИЙ хайр ба Израилийн дуулгаваргүй байдлыг дурсан санасан нь
- 5. V ном: Магтаалын дуун (Дуулал 107–150)**
- Дуулал 107: Олон төрлийн зовлон бэрхшээлээс чөлөөлөгч Бурханыг магтах нь
 Дуулал 108: Ялалтын төлөөх залбирал ба магтаал
 Дуулал 109: Дайснуудын эсрэг шүүлт болон хамгаалалтын төлөөх залбирал
 Дуулал 110: Мессиаг Хaan Тэргүүн тахилч хэмээн харуулсан нь
 Дуулал 111: Бурханы итгэмжит байдлыг магтагтун
 Дуулал 112: Итгэлийн агуу ялалт
 Дуулал 113: Дорд болон бууж ирсэн Эзэнийг магтагтун
 Дуулал 114: Египетээс гарсны төлөөх магтаал
 Дуулал 115: Эзэний агуу байдал ба хуурамч шүтээний сул дорой байдал
 Дуулал 116: Чөлөөлөлтийн төлөө Эзэнийг магтагтун

- | | |
|--------|--|
| Дуулал | 117: Бүх хүмүүсийн магтаал |
| Дуулал | 118: Эзэний авралын сайн сайхны төлөөх магтаал |
| Дуулал | 119: Бичээсийн магтаал |
| Дуулал | 120: Гүтгэгчдээс чөлөөлөхийн төлөөх залбирал |
| Дуулал | 121: Эзэн бол миний Хамгаалагч |
| Дуулал | 122: Иерусалимын амар тайвны төлөө залбир |
| Дуулал | 123: Хайр энэрлийн төлөөх гүйлт |
| Дуулал | 124: Бидний Туслагч бол тэнгэр газрыг Бүтээгч! |
| Дуулал | 125: Израиль дээр амар тайван байг |
| Дуулал | 126: Сэргээн босголтын төлөөх магтаал |
| Дуулал | 127: Эзэний бэлэг болох хүүхдүүдийн төлөөх магтаал |
| Дуулал | 128: Эзэнээр ерөөгдсөн гэр бүл |
| Дуулал | 129: Хавчигдсан нэгний залбирал |
| Дуулал | 130: Бурханы чөлөөлөлтийг хүлээх нь |
| Дуулал | 131: Эзэнд хүүхэд шиг итгэх нь |
| Дуулал | 132: Сион дахь Эзэний ерөөлийн төлөөх залбирал |
| Дуулал | 133: Ахан дүүсийн нэгдмэл байдлын ерөөл |
| Дуулал | 134: Шөнөөр ч Эзэнийг магтагтуун |
| Дуулал | 135: Бурханы гайхамшигт үйлсийн төлөөх магтаал |
| Дуулал | 136: Мөнхөд үргэлжлэгч Бурханы хайр энэрлийн төлөөх магтаал |
| Дуулал | 137: Олзлогдолтын үеийн гашуудал |
| Дуулал | 138: Эзэн даруу нэгний залбирлыг сонсож, авардаг |
| Дуулал | 139: Эзэн намайг мэддэг |
| Дуулал | 140: Авралын төлөөх залбирал: Та бол миний Бурхан |
| Дуулал | 141: Миний залбирал утлага адил тооцогдог |
| Дуулал | 142: Хэн ч хайрхахгүй байсан ч Эзэн хардаг; Тэр ганцаараа миний Хувь |
| Дуулал | 143: Удирдамжийн төлөөх залбирал; Намайг тэгш газар дээр удирдаач |
| Дуулал | 144: Эзэн бол миний Хад, миний Дайчин |
| Дуулал | 145: Эзэний агуу байдал ба гайхамшигт үйлсийн төлөөх магтаал |
| Дуулал | 146: Өгөөмрөөр туслагч Эзэнийг магтагтуун |
| Дуулал | 147: Шаналсан зүрхийг анагаагч Эзэнийг магтагтуун |
| Дуулал | 148: Мэргэн Бүтээгч, Эзэнийг магтагтуун |
| Дуулал | 149: Өөрийн ард түмнээр баходдаг Эзэнийг магтагтуун |
| Дуулал | 150: Эзэнийг магтагтуун |

Сургаалт Үгс (Сургаал заавраас ирэх мэргэн ухаан)

Номын нэр болон зохиогч: 1Хаад 4:32-д хэлснээр, Соломон 3000 сургаалт үгс, 1005 дуу бичсэн бөгөөд энэ номын ихэнх сургаалт үгсийг бичсэн. Гэхдээ тэр ганцаараа энэ номын зохиогч биш гэдгийг сүүлийн бүлгүүдэд илэрхийлсэн байдаг. Сургаалт үгс номын гурван хэсэг нь Соломонд харьяалагддаг: 1:1–9:18; 10:1–22:16, болон 25:1–29:27. Гэхдээ, сүүлийнх нь хэсгийн сургаалт үгсийг (25:1–29:27) Хезекия хааны хүмүүс Соломоны цуглувулгаас сонгож авсан (25:1). Сургаалт үгс 22:17-д “мэргэдийн үгс”, мөн 24:23-д дахин “мэргэн хүмүүсийн үгс” хэмээн хэлсэн байдаг. Сургаалт үгс 22:17-21 нь Соломоны өөрийнх нь биш харин мэргэн хүмүүсийн хүрээнээс гаралтай байж магадгүй гэдгийг харуулдаг. 30-р бүлгийг Иазены хөвгүүн Агур, 31:1-9-ийг Лемуел хаан бичсэн.

Сургаалт үгс ном нь үнэнийг агуулсан зарчмууд, богино хэлц зэргээс бүрддэг бөгөөд номынхоо утгаар нэрлэгдсэн нь тодорхой юм. Сургаалт үгс гэдэг еврей үг нь “зэрэгцүүлэл”, “харьцуулалт”, “төстэй байдал” гэх мэт утгатай. Энэ нь ёс суртахууны зарчмуудыг харуулсан харьцуулалтын тухай хэлж байна. Сургаалт үгс нь зөвхөн ижил төстэй ухагдахууныг харьцуулаад зогсохгүй бас эсрэг зүйлсийг сөргүүлэн харьцуулсан байдаг. Номын нэр нь энэ бичвэр бол ухаалаг амьдрах боломжийг хүнд өгөхийн тулд бичигдсэн ёс суртахууны болон сүнслэг зааварчилгааны товчоон гэдгийг харуулж байна.

Бичигдсэн огноо: МЭӨ 950–700 он. Сургаалт үгс ном нь мэргэн ухааны ном учир түүхэн ном бус, харин Израилийн мэргэн ухааны сургуулийн бүтээл юм. Соломоны сургаалт үгс нь МЭӨ 931 онд түүнийг нас барахаас өмнө бичигдсэн, харин бусдыг нь Хезекиагийн бичээч нар МЭӨ 700-аад оны үед цуглуулсан.

Сэдэв болон зорилго: Номын нэр, “сургаалт үгс” гэдэг нэр томъёоны утга зэргээс Сургаалт үгс номын сэдэв болон зорилго бол амьдралын мэргэн ухаан гэдгийг харж болно. Тиймээс энэ нь гэм нүгэл, сайн сайхан, эд баялаг, ядуурал, хэл яриа, бардамнал, даруу зан, шударга ёс, гэр бүл (эцэг эх, үр хүүхэд, сахилгажуулалт), өшөө авалт, маргаан, донтолт, хайр, залхуурал, найз нөхөд, амьдрал ба үхэл гээд амьдралын бүхий л асуудлын талаар онцгой зааварчилгааг санал болгодог. Өдөр тутмын амьдралын мэргэн ухааны талаар Сургаалт үгс ном шиг ийм амьдралд ойр ном үүй.

Үндсэн сэдэв нь “*Эзэнээс эмээхүй нь мэргэн ухааны эхлэл мөн*” (1:7a). Эзэнээс эмээхүй амьдрах нь муухаг амьдрал уруу хөтөлдөг. Эзэнээс эмээхүй гэдэг нь Түүний ариун зан чанар, хүч чадлаас эмээхийг хэлдэг. Үүний зэрэгцээ, жинхэнэ мэргэн ухаан нь Эзэнээс эмээхүй уруу хөтөлдөг гэдгийг Сургаалт үгс ном харуулдаг (2:1-5).

Гол хүмүүс: Сургаалт үгс ном нь хүн бүрд зориулагдан бичигдсэн учир ямар нэг хувь хүнийг энд дурдаагүй.

Сургаалт үгс ном дахь Христ: 8-р бүлэгт мэргэн ухааныг хүн шиг үзэж, мөн төгс гэж харуулдаг. Энэ нь тэнгэрлэг (8:22-31) бөгөөд биологийн болон сүнслэг амьдралын эх үүсвэр (3:18; 8:35-36), зөвт агаад ёс суртахуунтай (8:8-9), үүнийг хүлээн авахыг хүссэн хүн бүхэн авах боломжтой (8:1-6, 32-35). Энэ мэргэн ухаан нь Христийн бодгаль дотор махан биеэр ирсэн бөгөөд “*түүн дотор мэргэн ухаан болоод мэдлэгийн бүх эрдэнэс нуугдсан байдал*” (Колоссай 2:3). “*Харин та нар Түүнээс болж Христ Есүс дотор байгаа юм. Христ Есүс нь бидний хувьд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусал ба золилт болсон юм*” (1 Коринт 1:30-ийг 1 Коринт 1:22-24-тэй харьцуул).²⁹

Хувийн Судлалд: Агуулга

1. Оршил: Сургаалт үгсийн зорилго (1:1-7)

2. Мэргэн ухааны сургаалт зааврууд: Залууст хэлэх сургаалт үгс (1:8–9:18)

- А. Эцэг эхээ дуулгавартай дага (1:8-9)
- Б. Муу нөхдөөс зайлсхий (1:10-19)
- В. Мэргэн ухааны дуудлага ба зөвлөгөө (1:20-33)
- Г. Завхай эмэгтэйгээс зайлсхий (2:1-22)
- Д. Бурханыг хүндэлж, итгэ (3:1-12)
- Е. Мэргэн ухааны ерөөлүүд (3:13-20)
- Ё. Бусдад эелдэг, өгөөмөр ханд (3:21-35)
- Ж. Мэргэн ухааныг ав (4:1-9)
- З. Муу нөхдөөс зайлсхий (4:10-19)
- И. Бүхнээс илүү, зүрх сэтгэлээ хамгаал (4:20-27)
- К. Бүү завхайр (5:1-14)
- Л. Хань ижилдээ итгэмжит бай (5:15-23)
- М. Батлан даагч болохоос зайлсхий (6:1-5)
- Н. Залхуурлаас зугт (6:6-19)
- О. Завхайрлаас зайлсхий (6:20-35)
- Ө. Завхай эмэгтэйгээс зайлсхий (7:1-27)
- П. Мэргэн ухаан ба муухаглалыг харьцуулсан нь (8:1–9:18)

3. Соломоны сургаалт үгс (10:1–24:34)

- А. Бузар муу болон бурханлаг байдлыг харьцуулсан сургаалт үгс (10:1–15:33)
- Б. Бурханлаг амьдралыг урамшуулан дэмжсэн сургаалт үгс (16:1–22:6)

- В. Янз бүрийн ажил хэргийн талаарх сургаалт үгс (22:17–23:35)
 - Г. Янз бүрийн хүмүүсийн талаарх сургаалт үгс (24:1-34)
- 4. Хезекиагийн хүмүүсийн хуулбарлан бичсэн Соломоны сургаалт үгс (25:1–29:27)**
- А. Бусадтай харилцах харилцааны талаарх сургаалт үгс (25:1–26:28)
 - Б. Ажил үйлсийн талаарх сургаалт үгс (27:1–29:27)
- 5. Агурын үгс (30:1-33)**
- А. Хувийн үгс (30:1-14)
 - Б. Тоон сургаалт үгс (30:15-33)
- 6. Лемуелын үгс (31:1-9)**
- 7. Сайн эхнэр (31:10-31)**

Номлогчийн Үгс (Бодит байдлаас ирэх үнэн)

Номын нэр болон зохиогч: Соломоныг Номлогчийн үгс номыг бичсэн гэж үзэх (дотоод ба гадаад) хоёр хүчин зүйл байдаг. Гадаад хүчин зүйлийн хувьд, иудейн уламжлалын дагуу тус номыг Соломоныг бичсэн гэж үздэг. Дотоод хүчин зүйлийн хувьд, Соломон үнэхээр зохиогч нь байсан гэж хэлэхээр хэд хэдэн зүйлс гардаг. Нэгд, зохиогч өөрийгөө “*Иерусалимын хаан, Давидын хүү*” (1:1) гэж тодорхойлсон. Удаах нь, тус номд зохиогчийн талаар үлэмж мэргэн ухаантай (1:16), туйлын баян (2:7), наргиж цэнгэх боломжтой (2:3), мөн асар их барилга байгууламж барьсан (2:4-6) гэж хэлсэн зэрэг нь бүгд Соломоныг зохиогч гэсэн санааг хэлж байна. Ийм байдлаа тодорхойлж болох өөр хүн Давидын үр удмын дунд байгаагүй.

Номлогчийн үгс (англиар Ecclesiastes) гэдэг нэр нь Септуагинтын гарчгаас эхлэлтэй. Грек үг нь “чуулган” гэсэн утгатай. Номын еврей нэр нь “чуулганыг хуралдуулж, үг хэлдэг хүн” буюу “номлогч” гэсэн утгатай.

Бичигдсэн огноо: МЭӨ 931 он. Иудейн уламжлалаар, Соломон хаан амьдралынхаа эхэн үед залуу эрийн хайр сэтгэлийг илэрхийлэн Соломоны дуун номыг бичсэн. Дунд эргэм насандаа, төлөвшиж буурь суусан дунд насны эр хүний мэргэн ухааныг харуулан Сургаалт үгс номыг бичсэн. Тэрээр Номлогчийн үгс номыг насан өндөр болсон хойноо бичсэн бөгөөд настай хүний гуниг харууслыг харуулсан (12:1-ийг хар). Хаадын дээд номын 11-р бүлэгт өгүүлдэг ёс суртахууны ноцтой алдаа буруундаа харамсаж, гэмшсэн Соломоны өчлийг Номлогчийн үгс ном харуулж байж болох юм. Тиймээс Номлогчийн үгс ном нь МЭӨ 931 онд хаант улс хуваагдахын өмнө буюу Соломоныг нас бараахын өмнөхөн бичигдсэн.³⁰

Сэдэв болон зорилго: Гол сэдэв нь амьдрал Бурханаас ангид бол хоосон. Энэ сэдвийн дагуу дөрвөн гол түлхүүр зорилго гарч ирдэг:

Нэгд, Бурхангүй амьдрал ямар ч утга учиргүй гэдгийг батлан харуулахын тулд Соломон хүний мэргэн ухаан, амжилт ололтод итгэх итгэлийг нураахыг хичээсэн. Ингэхдээ тэрээр хүний бүхий л зорилго эсвэл “хүний нүдэнд зөв юм шиг харагдаж байгаа арга замууд” бүгд сэтгэл ханамжгүй хоосон байдал уруу гарцаагүй чиглүүлдэг гэдгийг харуулсан. Үншигчдадаа Бурханы талаар бодуулахын тулд Соломон өөрийнхөө амсаж үзсэн хоосон байдлын талаар өгүүлдэг. Хүн өөрөө энэ амьдралаас эрж хайснаараа аз жаргалаа олж чадахгүй гэдгийг тэр харуулахыг хүссэн.

Хоёрд, Амьдрал дахь олон зүйлсийг бүрэн дүүрэн ойлгох боломжгүй, тиймээс бид харж байгаагаараа бус харин итгэлээрээ амьдрах ёстой гэдгийг Соломон баталж байна. Амьдрал бол тайлбарлаж боломгүй үйл явдлаар дүүрэн. Хүн захирч, эсвэл зохицуулж чадахааргүй зүйлс амьдралд олон байдаг боловч бид итгэлээрээ Бурханы ажил үйлс, хамгийн дээд мэргэн ухаан дотор амар тайван байж чадна. Номлогчийн үгс нь хүн хязгаартай гэдгийг зөвхөн батлаад зогсохгүй нууцлаг зүйлс амьдралд олон тохиолддог гэдгийг хэлснээрээ Иов номтой ихээхэн төстэй. Газар дэлхий дээрх амьдрал буюу “наран доорх амьдрал” нь

амьдралын өөрийнх нь түлхүүрийг өгч чаддаггүй. Үүн дээр үндэслэн, хүн зөвхөн энэ дэлхийн амьдралыг явцуу хүрээнд харах бус харин Бурханыг харж, Түүнд итгэж, эмээдэг байх учиртай.

Гуравт, Номлогчийн үгс ном нь амьдралын бодит байдлыг харуулснаараа Сургаалт үгс номоос ялгаатай. Энэ нь Сургаалт үгс ном дахь төгс төгөлдөр зүйлсээс амьдрал огт ялгаатай гэдгийг харуулдаг. Сургаалт үгс 10:16-д хорон муу болон шударга зөв хүний хоёулангийнх нь дээр шударга ёс байдаг гэдгийг батлан хэлдэг бол Номлогчийн үгс 8:14-д энэ нь үргэлж ийм байж чаддаггүй, эсвэл дор хаяж энэ амьдралд дандаа ийм байдаггүй гэдгийг хэлсэн байдаг. Эдгээр нь хоорондоо зөрчилдэж байна уу? Үгүй ээ, учир нь Сургаалт үгс нь Бурханы ерөнхий зарчмыг хэлж байгаа бөгөөд ямар ч гэм уналт үгүй үед бүрэн биелэх боломжтой, гэтэл бид уналт нүүрлэсэн, гэм нүгэлт өртөнцөд амьдарч байна. Сургаалт үгс номд хэлсэнчлэн шударга зөв ёс оршин байдаг боловч энэ нь хүний хязгаарлагдмал байр байдлаас болж “наран доорх” хүмүүний амьдралд үргэлж тодорхой харагдаад байдаггүй гэдгийг Номлогчийн үгс номд өгүүлдэг.

Дөрөвт, өөрийн стратегид тулгуурлагч хүний хувьд амьдрал үргэлж нууцлаг, урам хугармаар, мөн утгагүй хоосон байдаг гэдгийг Соломон харуулсан. Гэхдээ тус ном нь амьдралд ямар ч хариулт үгүй, эсвэл амьдрал бүхэлдээ үр ашиггүй, утга учиргүй гэсэн утгатай биш ээ. Утга учир, ач холбогдлыг нь олох боломжтой бөгөөд, түүний тайлбарласнаар энэ нь Бурханаас эмээхүй дотор байдаг. Тийнхүү Бурхантай нөхөрлөх нөхөрлөлөөр дамжуулан урам хугаралт нь сэтгэлийн баяр хөөр болж болно.

Гол хүмүүс: Гол хүн нь Соломон хаан.

Номлогчийн үгс ном дахь Христ: Хүн зөвхөн Бурхан дотор л бүрэн дүүрэн, сэтгэл хангалуун амьдралтай буюу амьтай, бялхам амьтай байж чадах агаад хүний Бурхантай харилцах цорын ганц үндэс суурь нь зөвхөн Христ юм (Иохан 10:10; 7:37-38). Амьдралд амсаж туулдаг хоосон байдал нь зөвхөн Эзэн Есүстэй хувьчлан харилцах харилцаагаар л дүүргэгддэг. Хүмүүний утга учиртай амьдрах гэсэн хүсэл эрмэлзлэл, сэтгэл хангалуун байдал нь зөвхөн Аврагч дотор л олдох боломжтой.

Хувийн Судлалд: Агуулга

- 1. Оршил: Асуудлыг тодорхойлсон нь (1:1-3)**
- 2. Асуудлыг батлан өгүүлсэн нь (1:4-2:26)**
 - А. Амьдралын тойргийн утгагүй байдал (1:4-11)
 - Б. Хүний мэргэн ухааны утгагүй байдал (1:12-18)
 - В. Эд баялаг, зугаа цэнгэлийн утгагүй байдал (2:1-11)
 - Г. Материализмын утгагүй байдал (2:12-23)
 - Д. Дүгнэлт: Бурханы хангамжид баярлаж, сэтгэл хангалуун бай (2:24-26)
- 3. Амьдралд зориулсан Бурханы өөрчлөгдөшгүй төлөвлөгөө (3:1-22)**
 - А. Тэр амьдралын үйл явдлуудыг урьдаас тогтоосон (3:1-11)
 - Б. Тэр амьдралын нөхцөл байдлыг урьдаас тогтоосон (3:12-13)
 - В. Тэр бүгдийг шүүдэг (3:14-21)
 - Г. Дүгнэлт (3:22)
- 4. Амьдралын нөхцөл байдлууд утга учиргүй болох нь (4:1-5:20)**
 - А. Бузар муу дарлал (4:1-3)
 - Б. Шаргуу ажиллах нь хоосон болох нь (4:4-12)
 - В. Улс төрийн амжилт хоосон болох нь (4:13-16)
 - Г. Хүний шашин шүтлэг хоосон болох нь (5:1-7)
 - Д. Хүний эд баялаг хоосон болох нь (5:8-17)
 - Е. Дүгнэлт (5:18-20)

5. Амьдрал бүхэлдээ утга учиргүй болох нь (6:1-12)
 - А. Эд баялаг нь сэтгэл хангалуун байлгаж чадахгүй (6:1-2)
 - Б. Үр хүүхэд сэтгэл хангалуун байлгаж чадахгүй (6:3-6)
 - В. Ажил хөдөлмөр сэтгэл хангалуун байлгаж чадахгүй (6:7-12)
6. Хоосон амьдралд зөвлөх нь (7:1-12:8)
 - А. Хүний хорон муу байдлын талаар зөвлөх нь (7:1-29)
 - Б. Бурханы хангамжийн тухай зөвлөх нь (8:1-9:18)
 - В. Амьдралын тодорхойгүй байдлын талаар зөвлөх нь (10:1-20)
 - Г. Амьдралд хөгширч, өтлөх талаар зөвлөх нь (11:1-12:8)
7. Дүгнэлт (12:9-14)

Соломоны Дуун

(Нэгдмэл байдлаас ирэх баяр хөөр)

Номын нэр болон зохиогч: Зохиогч нь Соломон. Түүний нэрийг долоон удаа дурддаг (1:1, 5; 3:7, 9, 11; 8:11-12) бөгөөд уг номд гардаг болзоот залууг Соломоныг гэж үздэг. 1-р ишлэлд Соломон бусад олон (үнэндээ олон сайн) дуу зохиосны адил (1 Хаад 4:32-д түүнийг 1005 ийм дуу зохиосон гэсэн байдаг) энэ дууг ч бас зохиосон гэсэн. Эх бичигт зүгээр л “Соломоны дуун” гэж хэлээгүй, харин “Соломоны дуунуудын дуун” гэж хэлсэн байгааг анхаар. Энэ номын нэрийн талаар доктор Чарльз Райри ийн бичсэн байдаг:

Энэ номыг хэд хэдэн маягаар нэрлэсэн байдаг: Еврей нэр нь 1-р ишлэлээс авсан бөгөөд “Дуунуудын дуун” буюу “дуунууд дундаас хамгийн сайн нь буюу хамгийн дээд зэргийнх” гэсэн утгатай. Англи нэр нь мөн л 1-р ишлэлээс авсан бөгөөд зохиогчийг нь харуулан “Соломоны дуун” гэсэн. Кантикл гэдэг нэр нь латин үгээс гаралтай бөгөөд зүгээр л “дуу” гэсэн утгатай.³¹

Бичигдсэн огноо: Ойролцоогоор МЭӨ 965

Сэдэв болон зорилго: Соломоны дуун нь хайр сэтгэл болон гэрлэлтийн талаарх Бурханы үзэл бодлыг буюу эрэгтэй, эмэгтэй хүний бие махбодын хайр сэтгэлийн үзэсгэлэн гоог дүрслэн харуулсан маш олон дүрслэл бүхий хайрын дуу юм. Тус ном нь хэд хэдэн үзэгдэл бүхий жүжиг хэлбэрээр бичигдсэн бөгөөд үүнийг дараах агуулгаас харж болно.

Дуун ном нь Соломоны хаанчлалын эхэн үед буюу ойролцоогоор МЭӨ 965 онд бичигдсэн бололтой. Энэ үед Соломон жаран хатан, наян татвар эмтэй байсан (6:8), харин амьдралынхаа сүүлийн жилүүдэд тэрээр долоон зуун хатан, гурван зуун татвар эмтэй байжээ (1 Хаад 11:3).

Гол хүмүүс: Сүйт бүсгүй (Шуламмит), хаан (Соломон), болон найрал дуучид (Иерусалимын охид)

Соломоны дуун ном дахь Христ: Энэ ном нь итгэгчдийг хайлласан Христийн хайрыг харуулдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Гарчиг (1:1)
2. Хайрлаж дурласан нь (1:2-3:5)
 - А. Сүйт бүсгүй хайр энхрийлэл хүссэн нь (1:1-8)
 - Б. Хоёр биендээ хайраа илэрхийлсэн нь (1:9-2:7)
 - В. Хаан сүйт бүсгүйн гэрт зочилсон нь (2:8-17)

Г. Сүйт бүсгүй салалтын тухай эхний удаа зүүдэлсэн нь (3:1-5)

3. Хайр дотор нэгдэх нь (3:6–5:1)

- А. Хуримын үйл явц (3:6-11)
- Б. Сүйт бүсгүйн гоо үзэсгэлэнг магтсан нь (4:1-15)
- В. Гэрлэлт нь бүрэн төгс зүйл юм (4:16–5:1)

4. Хайр дотор зовох нь (5:2–7:10)

- А. Сүйт бүсгүй салалтын тухай хоёр дахь удаагаа зүүдэлсэн нь (5:2-7)
- Б. Болзоот залуугийн сайхныг магтсан нь (5:8–6:3)
- В. Сүйт бүсгүйн гоо үзэсгэлэнг магтсан нь (6:4–7:10)

5. Хайр дотор төлөвшөн нь (7:11–8:14)

- А. Сүйт бүсгүй гэртээ зочлохыг хүссэн нь (7:11–8:4)
- Б. Аялал ба гэртээ ирсэн нь (8:5-14)

4-р хэсэг

Их Эш Үзүүлэгчид

Израилийн эш үзүүлэгчдийг бүхэлд нь харахуй

Оршил: Хуучин гэрээний тойм хэсгээс бид “Хуулийн номууд”, “Түүхэн номууд”, “Яруу найргийн номууд”-ыг үзээд байгаа билээ. Одоо бид сүүлийн хэсгийг буюу “Эш үзүүлэгчдийн номууд”-ыг үзэх гэж байна.

“Эш үзүүлэгчдийг” дотор нь “Их эш үзүүлэгчид” болон “Бага эш үзүүлэгчид” гэж хуваадаг. “Их эш үзүүлэгчдийн” номд Исаиа, Иеремиа, Гашуудал, Езекиел, Даниел гэсэн таван ном ордог. “Бага эш үзүүлэгчдийн” номд Хосеа, Иоел, Амос, Обадиа, Иона, Мика, Нахум, Хабаккук, Зефания, Хаггаи, Зехария, Малахи гэсэн арван хоёр ном ордог.

Мөн эдгээр эш үзүүлэгчдийн угсийг өөрсдөө бичсэн эсвэл хэн нэгэн нь бичиж тэмдэглэн үлдээсэн учир бичгэн эш үзүүлэгчид гэж нэрлэдэг. Натан, Ахия, Иддо, Иехү, Елиа, Елиша, Одед, Шемаиа, Азария, Ханани, Иахазиел, Хулда зэрэг эш үзүүллэгийг нь бичиж үлдээгээгүй эш үзүүлэгчид байдаг агаад тэднийг аман эш үзүүлэгчид гэж нэрлэдэг.

Зохиогчид: Эш үзүүллэгийн номуудын зохиогчийг нь тэдний дуудлага болон үйлчлэлийнх нь мөн чанартай холбоотой хэд хэдэн нэр томъёогоор хэлж тайлбарласан байдаг. Тэднийг эш үзүүлэгч, үзмэрч, харуул, Бурханы хүн, элч, Эзэний зарц гэх зэргээр нэрлэдэг.

“Эш үзүүлэгч” гэдэг үгийн гол санаа нь эрх мэдэлтэй яригч гэсэн утга. Тиймээс жинхэнэ эш үзүүлэгч нь Бурханы төлөө хүмүүстэй ярьдаг хүн юм. Энэ нь эш үзүүлэгчийн тухай тайлбарласан Хуучин гэрээний турван багц ишлэлээс тодорхой харагддаг: (1) Египетээс гарсан нь 6:28–7:2. Мосег Фараоны өмнө Бурханы үгийг дамжуулах шаардлагатай болох үед Бурхан Аароныг Мосегийн эш үзүүлэгчээр, өөрөөр хэлбэл түүний эрх мэдэлт төлөөлөгч, төлөөлөн үг хэлэгч болгон томилсон. Энэ тохиолдолд нэг хүн нь нөгөө хүнийхээ төлөө үг хэлж байна. (2) Тооллого 12:1-8. Аарон, Мириам нар атаархсанаасаа болж Бурханы илчлэлт болон тэдний хоорондын зууч болж байсан Мосегийн байр суурийг эзлэхийг санаархдаг. Харин Бурхан зөвхөн Мосетэй шууд ярилцах болно гэдгийг, мөн Тэрээр эш үзүүлэгчээр дуудагдсан хүмүүстэй үзэгдэл болон зүүдээр дамжуулан ярих болно гэдгээ гайхамшигтай байдлаар илэрхийлэн харуулсан. Энд “эш үзүүлэгч” гэдэг үгийн утга тодорхой харагддаг. (3) Дэд хууль 18:9-22. Мосег нас барахын өмнөхөн, эш үзүүлэгчийн ажил үүргийн талаарх албан ёсны мэдээлэл энд өгөгдсөн.³² Эдгээр ишлэлээс эш үзүүлэгч хүн бол Бурханы өөрт нь илчилсэн тэрхүү мэдээг дамжуулан хэлдэг нэгэн гэдэг нь илэрхий харагдаж байна.

Тэдний заавар буюу мэдээ: Бурханыг төлөөлөн үг хэлэгч хүний хувьд эш үзүүлэгчийн нэн тэргүүний үүрэг бол Бурханы ард түмний дунд тухайн үед тохиолдож буй түүхэн нөхцөл байдалд Бурханы ард түмэнд Бурханы мэдээг дамжуулах явдал юм. “Эш үзүүллэг” гэдэг үгийн илүү өргөн утгад тухайн асуудлын талаар номлох ордог бөгөөд үүнийг далд нууц зүйлийг гаргаж ирэх гэж нэрлэдэг. Илүү нарийвчилсан утга нь үйл явдлыг болохоос нь өмнө хэлэх бөгөөд үүнийг урьдчилан хэлэх гэдэг. Далд нууц зүйлийг гаргаж ирэх гэдэг нь юун түрүүнд Бурханы хүслийг мэдэж, гаргаж ирэх гэсэн утгатай юм. Энэ нь нэн яаралтай, чухал зүйл бөгөөд хүмүүсээс дуулгавартай байдлыг шаарддаг. Үүнтэй харьцуулбал, урьдчилан хэлэх гэдэгт Бурханы төлөвлөгөөний талаарх зөн билиг ордог. Энэ нь зөгнөлийн хэлбэртэй бөгөөд зөвт нэгнийг Бурханы амлалтыг харахад урамшуулж, эсвэл ирэх шийтгэлийн талаар сануулдаг. Бурханы мэдээг дамжуулах явцдаа эш үзүүлэгч нь зарим үед ирээдүйтэй холбоотой зүйлсийг илчлэн хэлэх тохиолдол байдаг, гэхдээ энэ нь эш үзүүлэгчийн мэдээний зөвхөн нэг жижиг хэсэг юм. Тиймээс эш үзүүлэгч нь Бурханы мэдээг хүлээн авч, аман, бодит, харагдах болон бичгэн хэлбэрээр хүмүүст дамжуулдаг, Бурханаар сонгогдсон хүн байжээ. Тийм ч учраас, эш үзүүлэгчид “Эзэн ийнхүү айлдаж байна” гэсэн хэллэгийг нийтлэг хэрэглэдэг байв.

Бурханы төлөөлөгчийн хувьд тэдний мэдээ нь Хуучин гэрээн дэх Бурханы ард түмний дунд гурван талт үүргийг гүйцэтгэдэг байсан гэж хэлж болно:

Нэгд, тэд өөрийн үндэстэндээ Мосегийн хуулийг зааж, тайлбарладаг номлогчийн үүргийг гүйцэтгэж байсан. Гэм нүглийг зэмлэн буруушааж, сануулах, шүүлтийн аюулыг ойлгуулах, гэмшилд дуудах, уччал эвлэрийг авчрах нь тэдний үүрэг хариуцлага байв. Эш үзүүлэгч нар өөрсдийнхөө хийдэг бусад бүхий л ажлаасаа илүү олон цагийг гэм нүглийг зэмлэж, гэмшилд дуудах ажилд зориулдаг байжээ. Энэхүү зэмлэл нь эш үзүүлэгчийн сануулгыг анхаарч ойшоохгүй байгаа хүмүүсийн дээр Бурхан шийтгэлийг илгээх гэж байгаа тухай зөгнөлтэй хамт хэлэгддэг байжээ (Иона 3:4).

Хоёрд, тэд ирэх шүүлт, чөлөөлөлт, Мессия болон Түүний хаанчлалтай холбоотой үйл явдлуудыг тунхагладаг зөгнөгчийн үүргийг гүйцэтгэж байсан. Ирээдүйн талаар зөгнөн хэлэх гэдэг нь хүнийг сониуч занг хангахад зориулагддаггүй, харин Бурхан ирээдүйг мэдэж, хянаж байдаг гэдгийг онцлон харуулах, мөн зорилго чиглэлтэй илчлэлтийг өгөхийн тулд байдаг. Жинхэнэ эш үзүүлэгчээр өгөгдсөн зөгнөл нь нүдэнд харагдахуйц байдлаар биелдэг. Хэлсэн зөгнөл нь биелэхгүй байгаа нь тухайн эш үзүүлэгч Эзэн БУРХАНЫ үгийг дамжуулаагүй байна гэдгийг харуулдаг (Дэд хууль 18:20-22). 1 Самуел 3:19-д Самуелын тухай Эзэн түүнтэй хамт байсан бөгөөд түүний эш үзүүлэгийн үгээс нэг нь ч биелээгүй үлдээгүй (“хөсөр унаагүй”) гэсэн байдал.

Гуравд, тэд Израилийн ард түмний харуулын үүргийг гүйцэтгэж байсан (Езекиел 3:17). Езекиел Сиона ханан дээр харуул болж, шашны урвалтын эсрэг сануулга өгч бүрээ үлээхэд бэлэн зогсож байсан. Тэрээр улс төр, цэргийн холбоотон болох гадныхны хүчинд найдахын эсрэг, Канаанчуудын шашны мөргөлийн зан үйл, хуурамч шүтээнд мөргөх уруу татлагын эсрэг ард түмэндээ сануулга өгч байв.

Эцэст нь, эш үзүүлэгчид эдгээр арга замаар Бурханы мэдээг дамжуулах үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ Израилийн шашны системд өөр нэгэн чухал үүргийг гүйцэтгэж байсан. Израиль дахь эш үзүүлэгчид нь хааны дипломатчийн үүргийг буюу Мосегийн гэрээг зөрчсөний төлөө ард түмнийг яллах, хуулийн арга хэмжээ авах үүргийг гүйцэтгэдэг байжээ.³³

Дөрвөн их эш үзүүлэгчдийг харьцуулах нь³⁴

Дөрвөн их эш үзүүлэгчдийг харьцуулах нь				
	Исаиа	Иеремиа	Езекиел	Даниел
Эш үзүүлж байсан хүмүүс:	Иуда дахь иудейчүүдэд	Иуда дахь болон цөллөг дэх иудейчүүдэд	Вавилонд цөлөгдсөн иудейчүүдэд	Вавилонд цөлөгдсөн иудейчүүдэд ба харь үндэстний хаадад
Хамрах байдал:	Иуда ба Иерусалим (Исаиа 1:1; 2:1)	Иуда ба үндэстнүүд (Иеремиа 1:5, 9-10; 2:1-2)	Израилийн бүхэл гэрт (Езекиел 2:3-6; 3:4-10, 17)	Израиль ба харь үндэстний гүрнүүд (Даниел 2:36-43; 9)
Хаадын хаанчлалын үе:	Уззия, Иотам, Ахаз, Хезекиа (Иудагийн хаад)	Иосиа, Иехоахаз, Иехоиаким, Иехоиакин, Зедекиа (Иудагийн хаад)	Зедекиа (Иудагийн хаан), Небухаднезар (Вавилоны хаан)	Иехоиаким, Иехоиахин, Зедекиа (Иудагийн хаад), Небухаднезар (Вавилоны хаан)
Огноо:	МЭӨ 740-680 он	МЭӨ 627-585 он	МЭӨ 592-570 он	МЭӨ 605-536 он
Түүхэн нөхцөл:	2Хаад 15-21; 2Шастир 26-30	2 Хаад 22-25	Даниел 1-6	Даниел 1-6

Хуучин гэрээнд Христийг хүлээж байсан нь³⁵

Өнөөг хүртэл бид Хууль нь Израиль үндэстнийг Бурханы Угийн хамгаалагчид (Ром 3:2), Мессиагийн удам угсаа (Эхлэл 12:1-3; Ром 9:4-5) болгож сонгосон сонголт (Эхлэл), чөлөөлөлт (Египетээс гарсан нь), ариусгал (Левит), удирдамж (Тооллого), заавар (Дэд хууль) зэргээр дамжуулан Христийн ирэх суурийг тавьсан гэдгийг үзсэн.

Христийн ирэлтийн цаашдын бэлтгэл нь Түүхэн номуудад өгөгдсөн байdag. Израилийн газар нутгийг тэдний эзэмшил болгон өгч (Иошуа), Израиль үндэстэн итгэмжит биш байж, харь үндэстнүүдэд эзлэгдэх үед Бурхан шүүгчдийг босгож (Шүүгчид), үндэстэн дотор итгэмжит хүмүүсийг байлгасаар байсан (Рут) юм. Саул хааны удирдлага дор улс үндэстэн тогтвортой байдалд хүрч (1 Самуел), үүний дараа Давид хааны удирдлага дор өргөжин тэлж (2 Самуел), Соломоны хаанчлалын үед улс үндэстэн сэргэн мандсан юм (1 Хаад 1-10). Гэвч дараа нь улс үндэстэн умард арван овог ба Иуда, Бениамин гэсэн өмнөд хоёр овог болж хуваагдсан (1 Хаад 11-22). Энэ хоёр улс хоёулаа доройтож (2 Шастир), улмаар Ассири болон Вавилонд олзлогдон, цөлөгдсөн юм (2 Хаад). Үүний үр дагаварт, Сүм жинхэнэ утгаараа үйлчилж чадахаа болж (1 Шастир), улмаар сүйрэхд хүрсэн (2 Шастир). Гэхдээ Бурхан амлалтдаа итгэмжит байdag учир ард түмнээ хамгаалсаар байсан (Естер) бөгөөд Израиль үндэстний үлдэгсэд газар нутагтаа буцан ирж (Нехемиа), Сүмийг дахин барьсан (Езра) юм.

Яруу найргийн номуудад Хуулийн номуудад суурь нь тавигдаж, Түүхийн номуудад хөгжиж бий болсон Израиль үндэстний ёс суртахууны үндэс суурийн хамт Христийн төлөө гэсэн сүнслэг хүсэл эрмэлзэл үргэлж илэрхийлэгдэж байdag.

Эш үзүүллэгийн номууд нь Христийг ирэх болно гэсэн агуу хүлээлттэй байсан. Жейслерийн хэлснээр энэ нь дараах байдлаар бий болсон:

Эхэн үеийн эш үзүүллэгчид нь (Хосеа, Иоел, Амос) Мессиагаар дамжуулан үндэсний сэргэлт болно хэмээн хүлээж байсан. Исаиа, Мика нар Христийн ирэлтээр дамжуулан олон үндэстэн аврагдах болно гэдгийг зөgnөn хэлж байв. Харин Обадиа, Иона, Нахум, Хабаккук, Зефания нар үндэстнүүдийн дээрх Бурханы шийтгэлийг сануулж байлаа. Гашуудал номд Бурханы ард түмний дээрх Бурханы шийтгэлийн төлөө гашуудаж байсан бол Христийн дотор гэрээ дахин баталгаажна гэдгийг Иеремиа харж байв. Езекиел Израиль үндэстний шашны сэргэлтийг хүлээж, Даниел улс төрийн сэргэлтийг зөgnөn хэлж байсан. Вавилонд олзлогдоны дараа, Хаггаи, Зехария нар ард түмнийг шашны сэргээн босголтод уриалж байсан бол Малахи нийгмийн болон ёс суртахууны сэргээн босголтод уриалж, тэднийг “*зөв шударгын нар мандаж, түүний гэрэл эдгээх туяагаар гийгүүлэх*” (Малахи 4:2) хүртэл хүлээ гэдгийг хэлж байсан.³⁶

Исаиа (ЭЗЭНий аврал)

Номын нэр болон зохиогч: Номын зохиогч нь нэлээн алдар цуутай, нөлөө бүхий иудей гэр бүлийн тэргүүн, Амозын хүү Исаиа гэдгийг ном өөрөө тодорхой хэлж өгдөг. Исаиагийн хувьд Ахаз хааны хаанчлалын үед ч хааны гэр бүлийнхэнтэй танил байгаа нь харагддаг. Тэрээр олон улсын харилцааны талаар сайн боловсрол эзэмшсэн нь илэрхий байдаг бөгөөд амьдралынхаа ихэнх хугацааг Иерусалим хотод өнгөрүүлж, хааны гэр бүлийнхэнтэй холбоотой байж, тэдэнд гадаад харилцааны талаар зөвлөгөө өгдөг байжээ. Хэдийгээр Исаиа Бурханаар удирдуулж байсан боловч харийн хүчтэнүүдтэй (Ассири, Египетийн аль алинтай нь) холбоо тогтоохыг эсэргүүцэж байснаас нь болж түүнийг үргэлж дооглож тохуурхдаг байжээ. Зургаадугаар бүлэгт Эзэний сануулсанчлан, түүний зорилго бүтэлгүйтэж, засгийн газар болон ард түмэн аль аль нь өөрсдийнхөө итгэл найдварыг Бурханы хүн дээр болон Түүний амлалтуудад бус, харин улс төрийн холбоотнууддаа тавих болсон.

Эртний уламжлалт үзлээр, Манассегийн хаанчлалын үед түүнийг хөндий гуалин дотор хийн, хөрөөдөж алсан гэж үздэг (Еврей 11:37). Исаиа 37:37-38-д Сеннахерибын үхлийн талаар бичсэн байдгийг үзвэл Исаиаг МЭӨ 681 онд Сеннахерибыг нас барсны дараах үе хүртэл амьдарсан гэж таамаглаж болно.³⁷

Ариун Сүнсний онгод дор уг номыг бичсэн хүмүүн зохиогчийнх нь нэрээр тус номыг Исаиа гэж нэрлэсэн. Энэ эш үзүүллэгчийн еврей нэр нь “ЭЗЭН бол аврал” гэсэн утгатай бөгөөд энэ нь тус номын агуулга болон гол сэдвийг гайхалтайгаар дүгнэн хэлсэн гэж хэлж болно.

Бичигдсэн огноо: МЭӨ 740–680 он. Исаиа МЭӨ 740 оноос 680 он хүртэл маш удаан хугацааны турш үйлчилсэн. Түүний үйлчлэл Уззия хааны хаанчлалын сүүл үед эхэлж (МЭӨ 790-739), Иотам (МЭӨ 739-731), Ахаз (МЭӨ 731-715), Хезекиа (МЭӨ 715-686) хаадын үед үргэлжилсэн. Харь үндэстний захирагчид захиц байх үед Исаиа Тиглат-филесерин (МЭӨ 745-727) үеэс Ассирийн Сеннахерибын (МЭӨ 705-681) үеийг хүртэл үйлчилсэн.

Сэдэв болон зорилго: Исаиагийн нэр нь “Аврал бол ЭЗЭНийх” гэсэн номын сэдвийг харуулдаг. “Аврал” гэдэг нэр томьёо Исаиа номд хорин зургаан удаа гардаг бол бусад бүх эш үзүүлэгчдийн номыг нийлүүлээд зөвхөн долоон удаа л гардаг байна. Үүнээс үүдэн, мөн Мессиагийн цагаатгалын ажил болон авралын талаар маш олон зүйл хэлсэн байдаг учир Исаиаг “сайн мэдээний эш үзүүлэгч” гэж нэрлэдэг. Үнэндээ тус номд Хуучин гэрээний өөр ямар ч номоос илүүгээр Мессиагийн ажил үйлс болон бодгалийн талаар өгүүлсэн байдаг. Зарим талаар Исаиа ном нь Библийн жижигрүүлсэн хэлбэр юм.

Библи 66 номтой, Исаиа ном 66 бүлэгтэй. Исаиагийн эхний 39 бүлэг нь Хуучин гэрээний 39 номтой тохицдог бөгөөд ерөнхийдөө ирэх Мессиаг хүсэн хүлээсэн маягтай байдаг. Сүүлийн 27 бүлэг нь Шинэ гэрээний 27 номтой маш төстэй шинжтэй, учир нь эдгээр нь Эзэний Зарц болох Мессиагийн тухай болон Түүний хаанчлалын талаар маш олон зүйлийг өгүүлдэг. 1-39 дүгээр бүлэг нь хүний авралын асар их хэрэгцээг өгүүлдэг бол 40-66 дугаар бүлэг нь Мессиа болон Түүний хаанчлал дотор Бурхан авралыг өгсөн гэдгийг илчилдэг.

Гол хүмүүс: Эш үзүүлэгч Исаиа гол хүн нь, гэхдээ Исаиа номын гол төв нь Израилийн хүчирхэг Нэгэн, Израилийн ариун Нэгэн, Түмэн цэргийн Бурхан Эзэн болох ЭЗЭН гэдэг нь тодорхой харагддаг.

Исаиа ном дахь Христ: Хуучин Гэрээний өөр ямар ч ном Исаиа ном шиг Христийн дүр зургийг ийм бүрэн бүтэн агаад олон талаас нь харуулж чадаагүй. Исаиа номд Мессиаг хамгийн дээд нэгэн гэдгийг (6:1), Түүний мэндлэх болон хүн болох тухай (7:14; 9:6; 11:1), Сүнсээр хийгдэх Түүний үйлчлэлийг (11:2), Түүний бурханлаг чанарыг (7:14; 9:6), Түүнийг Давидын үр удам болохыг (11:1), бидний оронд төлсөн Түүний цагаатгалын ажлыг (53), Түүний Зарц Аврагчийн үйлчлэлийг (49–52) гээд өөр олон зүйлийг өгүүлдэг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Зэмлэл ба шүүлтийн эш үзүүллэг (1:1–39:8)

A. Иудагийн эсрэг эш үзүүллэгүүд (1:1–12:6)

1) Иудагийн зэмлэл (1:1–5:30)

1:1-9	2:12-22	5:1-7
1:10-17	3:1-12	5:8-30
1:18-31	3:13-26	
2:1-11	4:1-6	

2) Эш үзүүлэгчийн үүрэг даалгавар (6:1-13)

6:1-7	6:8-13
-------	--------

3) Мессиагийн ирэлт (7:1–12:6)

7:1-9	8:9-22	10:20-34
7:10-16	9:1-7	11:1-10
7:17-25	9:8-21	11:11-16
8:1-8	10:1-19	12:1-6

B. Харь үндэстнүүдийн эсрэг эш үзүүллэгүүд (13:1–23:18)

1) Вавилоны эсрэг (13:1–14:23)

13:1-5	13:17-22
13:6-16	14:1-23

2) Ассирийн эсрэг (14:24-27)

3) Филистийн эсрэг (14:28-32)

4) Моабын эсрэг (15:1–16:14)

- 5) Дамаск болон Түүний холбоотон Израилийн эсрэг (17:1-14)
 6) Этиопын эсрэг (18:1-7)
 7) Египетийн эсрэг (19:1-20:6)
 19:1-10 19:11-25 20:1-6
 8) Вавилоны эсрэг (21:1-10)
 9) Едомын эсрэг (21:11-12)
 10) Арабын эсрэг (21:13-17)
 11) Иерусалимын эсрэг (22:1-25)
 12) Тирийн эсрэг (23:1-18)
- В. Эзэний өдрийн тухай эш үзүүллэгүүд (24:1-27:13)
 1) Их зовлонгийн шүүлтүүд (24:1-23)
 2) Хаанчлалын ялалт ба ерөөлүүд (25:1-27:13)
 25:1-12 26:11-21
 26:1-10 27:1-13
- Г. Израиль болон Иудагийн эсрэг эш үзүүллэгүүд (Гаслан ба Ерөөлүүд) (28:1-35:10)
 1) Самари золгүй еэ (28:1-29)
 28:1-13 28:14-29
 2) Иуда золгүй еэ (29:1-31:9)
 29:1-8 29:17-24 30:18-33
 29:9-16 30:1-17 31:1-9
 3) Мессия болон Түүний хаанчлалыг харагтуун (32:1-20)
 32:1-8 32:9-20
 4) Иерусалимыг дээрэмдэгч Ассири золгүй еэ (33:1-24)
 33:1-12 33:13-24
 5) Үндэстнүүд золгүй еэ (34:1-17)
 6) Ирэх хаанчлалыг харагтуун (35:1-10)
- Д. Сеннахерибын эсрэг эш үзүүллэгүүд (36:1-39:8)
 1) Ассирийн доог тохуу (36:1-22)
 2) Бурханы үнэн (37:1-7)
 3) Ассирийн сүрдүүлэг (37:8-35)
 37:8-13 37:14-20 37:21-35
 4) Ассирийг ялсан ялалт (37:36-38)
 5) Хезекиагийн өвчин (38:1-22)
 6) Хезекиагийн тэнэглэл (39:1-8)

2. Тайвшрал буюу эвлэрүүллийн эш үзүүллэг (40:1-66:24)

- А. Бурханы агуу байдал болон Израилийн чөлөөлөлтийн тухай эш үзүүллэгүүд (40:1-48:22)
 40:1-20 43:8-13 45:8-25
 40:21-31 43:14-21 46:1-13
 41:1-20 43:22-28 47:1-15
 41:21-29 44:1-8 48:1-16
 42:1-13 44:9-20 48:17-22
 42:14-25 44:21-28
 43:1-7 45:1-7
- Б. Израилийн чөлөөлөгчийн тухай эш үзүүллэг; Зовлонт зарцын аврал (49:1-57:21)
 49:1-13 52:1-15 56:1-12
 49:14-26 53:1-12 57:1-21
 50:1-11 54:1-17
 51:1-23 55:1-13

В. Израилийн сүр жавхлант ирээдүйн тухай эш үзүүллэг; амар тайвны төлөөх Бурханы хөтөлбөр (58:1–66:24)		
58:1-12	61:1-11	65:1-16
58:13-14	62:1-12	65:17-25
59:1-8	63:1-6	66:1-2
59:9-21	63:7-14	66:3-9
60:1-14	63:15-19	66:10-24
60:15-22	64:1-12	

Иеремия

(Шүүлт болон гэм нүглийн эсрэг сануулга)

Номын нэр болон зохиогч: Исаиа номын нэгэн адил, тус номын хүмүүн зохиогч нь Бетлехем нутаг дахь Анатотын тахилч Хилкиагийн хүү Иеремия юм (1:1). Иеремия эш үзүүллэгээ өөрийн нарийн бичиг Барухад хэлж өгч бичүүлдэг байжээ. Иеремиаг ихэвчлэн “гашуудаж буй эш үзүүлэгч” (9:1; 13:17), эсвэл “ганцаардлын эш үзүүлэгч” (энэ нь түүнийг гэрлэж болохгүй гэж тушаасантай (16:2) холбоотой байж магадгүй) гэж нэрлэдэг. Тэрээр мөн “дурамжхан эш үзүүлэгч” гэдгээрээ алдартай (1:6), гэхдээ тэр маш их эсэргүүцэлтэй тулгарч, зодуулж, шоронд хоригдож байсан ч гэсэн Өмнөд Иудагийн хаант улсад Бурханы шүүлтийг итгэмжтэйгээр тунхагласан юм (11:18-23; 12:6; 18:18; 20:1-3; 26:1-24; 37:11-38:28). Тус ном нь зохиогчийнхоо нэрээр Иеремия гэж нэрлэгдсэн. Иеремия гэдэг нэр нь “ЭЗЭН байгуулдаг” гэсэн утгатай.

Бичигдсэн огноо: МЭӨ 627–585. Иеремия нь Зефания, Хабаккук, Даниел болон Езекиел нартай нэг цаг үед амьдарч байсан. Түүний эш үзүүллэгийн үйлчлэл МЭӨ 626 онд эхэлж, 586 оноос хойш дуусгавар болсон. Тун удалгүй түүний үйлчлэлийг Зефания үргэлжлүүлэх болжээ. Езекиел 593 онд Вавилонд үйлчлэлээ эхэлсэн бөгөөд Иерусалимд үйлчилж байсан энэхүү агуу эш үзүүлэгчийн үйлчлэлийн сүүл үтэй нь нэг цаг хугацаанд үйлчилж байжээ. Хэдийгээр Иеремия хэзээ, хаана нас барсан нь тодорхойгүй байдаг боловч иудей уламжлалын дагуу Иеремиаг Египетдэд амьдарч байхдаа нас барсан гэж үздэг (Еврей 11:37).

Сэдэв болон зорилго: Хоёр үндсэн сэдэв анхаарал татдаг: (1) гэм нүглийн эсрэг Бурханы шүүлтийн талаарх сануулга болон (2) хэрвээ үндэстэн жинхэнээсээ гэмших аваас дахин сэргэх болно гэсэн сэргэлт, найдварын мэдээ.

Гол хүмүүс: Номын турш гол хүн нь Иеремия бөгөөд түүний сургаал, түүнд тулгарсан эсэргүүцэл, хавчлага зэргийг өгүүлдэг.

Иеремия ном дахь Христ: Иеремия номд Христийн маш олон дүр зураг гардаг: Түүнийг амийн усны ундарга (2:13; уд.харьц. Иохан 4:14), Гилеадын гавар (8:22), Сайн хоньчин (23:4), зөв шударга Мөчир (23:5), бидний зөв шударга Эзэн (23:6) гэсэн байдаг. Түүнийг мөн Шинэ гэрээг авчрах Нэгэн гэсэн (31:31-34).

Иеремия номын эш үзүүллэгийн өөр нэг ач холбогдол бол Мессиагийн тухай тайлбарууд юм. Иехоиахини хараал (Иекониа, Кониа) нь түүний төрсөн үр удмаас хэн ч хаан ширээг нь залгамжлахгүй гэсэн утгатай (22:28-30). Матай 1:1-17 нь Соломон, Рехобоамаас авахуулаад түүний хууль ёсны (Есүсийн төрсөн эцэг нь биш) эцэг болох Иосефыг хүртэлх Христийн угийн бичгийг өгүүлсэн байдаг. Иосефын нэг ч хүү Давидын хаан ширээнд заларч чадахгүй, учир нь тэр ч гэсэн Иехоиахини хараал дор байгаа юм. Лук 3:23-38 нь Христийн удам угсааг Мариас (Есүсийн төрсөн эх) буцаан Давидын өөр нэг хүү болох Натаны тухай өгүүлсэн байдаг (Лук 3:31), ингэснээрээ дээрх хараалаас зайлсхийж байна. Зөв шударга Мөчир нь үнэхээр Давидын хаан ширээнд залрах болно.³⁸

Хувийн Судлалд: Агуулга

1. Иеремиагийн дуудлага болон үүрэг даалгавар (1:1-19)

- А. Дуудлага (1:1-10)
- Б. Дуудлагын баталгаа (1:11-19)

2. Иудагийн тухай эш үзүүлэгүүд (2:1-45:5)

- А. Иудаг зэмлэсэн нь (2:1-25:38)

1) Иудагийн санаатай үйлдэг гэм нүгэл (2:1-3:5)		
2) Иудагийн шийтгэл (3:6-6:30)		
3:6-10	4:19-31	6:1-21
3:11-25	5:1-13	6:22-30
4:1-18	5:14-31	
3) Иудагийн буруу шашин (7:1-10:25)		
7:1-34	9:1-26	
8:1-22	10:1-25	
4) Иуда Бурханы гэрээг зөрчсөн нь (11:1-13:27)		
11:1-17	12:1-6	13:1-11
11:18-23	12:7-17	13:12-27
5) Иуда хатаж хувхайрах нь (14:1-15:9)		
14:1-12	14:13-22	15:1-9
6) Иудагийн эш үзүүлэгч дахин дуудагдсан нь (15:10-16:13)		
15:10-21	16:1-13	
7) Иудагийн гэм нүглүүд (16:14-17:27)		
16:14-21	17:1-18	17:19-27
8) Иуда ба Хамгийн дээд Ваарчин (18:1-23)		
9) Иуда ба хагархай ваар (19:1-20:18)		
19:1-15	20:1-6	20:7-18
10) Иудагийн хаад (21:1-23:8)		
21:1-14	22:13-30	
22:1-12	23:1-8	
11) Иудагийн хуурамч эш үзүүлэгчид (23:9-40)		
12) Иуда олзлогдох нь (24:1-25:38)		
24:1-10	25:12-31	
25:1-11	25:32-38	
Б. Иеремиагийн зөрчилдөөнүүд (26:1-29:32)		
1) Иеремиагийн үйлчлэл дэх Иудагийн хариу үйлдэл (26:1-24)		
26:1-6	26:7-15	26:16-24
2) Иудад өгсөн Иеремиагийн зөвлөгөө: Небухаднэzzарт бууж өг (27:1-29:32)		
27:1-22	28:1-17	29:1-32
В. Иудагийн сэргэлтийн найдвар (30:1-33:26)		
30:1-17	31:27-40	33:1-13
30:18-24	32:1-15	33:14-26
31:1-26	32:16-44	
Г. Иерусалимын уналтын өмнөх үйл явдлууд (34:1-38:28)		
34:1-22	36:20-26	38:1-16
35:1-11	36:27-32	38:17-28
35:12-19	37:1-10	
36:1-19	37:11-21	
Д. Иерусалимын уналт (39:1-18)		
39:1-10	39:11-18	

- E. Иерусалимын уналтын дараах үйл явдлууд (40:1–45:5)
- | | | |
|----------|---------|----------|
| 40:1-16 | 42:1-22 | 44:20-30 |
| 41:1-10 | 43:1-13 | 45:1-5 |
| 41:11-18 | 44:1-19 | |
3. **Харь үндэстнүүдэд хандсан эш үзүүллэгүүд (46:1–51:64)**
- A. Египетийн эсрэг эш үзүүллэгүүд (46:1-28)
 - Б. Филистийн эсрэг эш үзүүллэгүүд (47:1-7)
 - В. Моабын эсрэг эш үзүүллэгүүд (48:1-47)
 - Г. Аммоны эсрэг эш үзүүллэгүүд (49:1-6)
 - Д. Едомын эсрэг эш үзүүллэгүүд (49:7-22)
 - Е. Дамаскийн эсрэг эш үзүүллэгүүд (49:23-27)
 - Ё. Арабын эсрэг эш үзүүллэгүүд (49:28-33)
 - Ж. Еламын эсрэг эш үзүүллэгүүд (49:34-39)
 - З. Вавилоны эсрэг эш үзүүллэгүүд (50:1–51:64)
- | | | |
|----------|----------|----------|
| 50:1-20 | 50:41-46 | 51:27-44 |
| 50:21-32 | 51:1-10 | 51:45-58 |
| 50:33-40 | 51:11-26 | 51:59-64 |
4. **Түүхэн нэмэлт (52:1-34)**
- А. Иерусалимын хувь тавилан (52:1-23)
 - Б. Зарим хүмүүсийн хувь тавилан (52:24-34)

Гашуудал (Нулимсан гол)

Номын нэр болон зохиогч: Гашуудал номын зохиогчийг уг номд дурдаагүй байдаг боловч Иеремиаг зохиогч нь гэсэн санааг дэмждэг хоёр хэсэг баримт байдаг. Номын нэр нь 1:1, 2:1, 4:1 ишлэлүүдийн эхний уг болох “Яаж!” гэдэг үгээр нэрлэгдсэн. Мөн номын утгаас үүдэн уг номыг иудейн уламжлалаар “Гашуудлууд” гэж нэрлэдэг.

Бичигдсэн огноо: МЭӨ 586 эсвэл 585. Тус ном нь 586 онд болсон Иерусалимын сүйрлийн дараахан бичигдсэн учир номыг бичсэн байж болох хамгийн боломжтой хугацаа нь МЭӨ 586 он юм. Гашуудал номын бичиглэлийн байдлаас нь үзвэл тус бичвэр нь 586 онд юмуу эсвэл 585 онд бичигдсэн бололтой байдаг.

Сэдэв болон зорилго: Номын гол сэдэв нь гэм нүгэлт Өмнөд Иудагийн хаант улс нуран унаж байгааг харж шаналсан эмгэнэл буюу гашуудал юм. Энд Иерусалим хотын болон Сүмийн сүйрлийг дүрслэн өгүүлсэн байдаг. Иудагийн гэм нүгэлд өгч буй Бурханы амласан шийтгэл ирчихээд байна. Хоёр дахь сэдэв нь үүнтэй холбоотой буюу гэм нүглийн шийтгэлийн тухай юм. Тийнхүү эш үзүүлэгч маань Бурхан тэдэнтэй харилцахдаа зөвт агаад шударга байдаг гэдгийг ард түмэн ойлгож, Түүний энэрэл хайрыг эрэлхийлэхийг хүсэн гүйж байна.

Иеремиа болон Гашуудал номыг харьцуулан судалж, эш үзүүлэгч Иеремиагийн оруулсан онцгой хувь нэмрийг харж болно:³⁹

Иеремиа (сануулга)	Иерусалим хотын ялагдал ба сүйрэл	Гашуудал (эмгэнэл) Эргэж харсан
Урагш харсан		

Гол хүмүүс: Иеремиа

Гашуудал ном дахь Христ: Гашуудал номд Аврагчийн дүр зургийг харуулсан хоёр элемент байдаг: (1) Энд Түүнийг дайснуудынхаа элэг доог болж, гадуурхагдаж, зовж шаналсан хүн буюу уй гашууны Хүн хэмээн дүрсэлсэн байдаг (1:12; 2:15-16; 3:14, 19, 30). (2) Иерусалимын сүйрлээс болж Иеремиагийн гашуудан шаналж буй нь Иерусалимын төлөө уйлж буй Христийн дүр зургийг бас харуулдаг гэж хэлж болох юм (Матай 23:37-38).

Хувийн Судлалд: Агуулга

1. **Иерусалимын сүйрэл (1:1-22)**
 - A. Эш үзүүлэгчийн гашуудал (1:1-11)
 - B. Иерусалим хотын гашуудал (1:12-22)
2. **Өөрийнхөө ард түмний эсрэг Эзэний уур хилэн (2:1-22)**
 - A. Бурханы уур хилэн (2:1-10)
 - B. Зохиогчийн гашуудал (2:11-22)
3. **Зовлонт эш үзүүлэгч (3:1-66)**
 - A. Түүний гашуудал (3:1-18)
 - B. Түүний найдвар (3:19-42)
 - C. Түүний зовлон (3:43-54)
 - D. Түүний залбираал (3:55-66)
4. **Иерусалимын хүмүүсийн ялагдал (4:1-22)**
 - A. Хотын бүслэлт (4:1-12)
 - B. Бүслэлтийн учир шалтгаанууд (4:13-20)
 - C. Ирээдүйн найдвар (4:21-22)
5. **Сэргэлтийн толоох залбираал (5:1-22)**
 - A. Нүглээ хүлээн зөвшөөрөх (5:1-18)
 - B. Гүйлт (5:19-22)

Езекиел (Тэд Намайг ЭЗЭН гэдгийг мэдэх болно)

Номын нэр болон зохиогч: Зохиогч нь Вавилонд цөлөгдөж байхдаа эш үзүүлэгчийн дуудлагыг хүлээн авсан Бузын хүү, тахилч Езекиел юм (1:1-3). Түүний эш үзүүлэгчийн үйлчлэлд Бурханы алдар, Сүм, тахилчлал, тахил зэрэг тахилчийн хандлага нэлээн давамгайлсан байдаг. Езекиелийн тухай бүхий л мэдээллийг зөвхөн Езекиел номоос өөрөөс нь авах боломжтой. Тэрээр гэр бүлтэй (24:15-18), өөрийнхөө байшинд амьдардаг байсан (3:24; 8:1) бөгөөд цөллөгт байсан бусад хүмүүсийн хамт боломжийн эрх чөлөөтэй амьдарч байжээ.

Исаиа, Иеремиа номын нэгэн адил Езекиел ном ч гэсэн зохиогчийнхоо нэрээр нэрлэгдсэн бөгөөд Езекиел гэдэг нь “Бурхан хүчирхэгжүүлдэг” буюу “Бурханаар хүчирхэгжсэн” гэсэн утгатай.

Бичигдсэн огноо: МЭӨ 593–571. Езекиел ном нь маш олон он сарыг багтаасан байдаг учир эш үзүүлэгүүдийнх нь цаг хугацааг нэлээн нарийвчлалтай тогтоох боломжтой. Тус номд 13 он сар өдөр дурдсанаас арван хоёр нь онцгойлон Езекиелийн Эзэнээс уг хүлээн авсан цаг хугацааг хэлсэн байдаг. Нэг он сар өдөр нь Иерусалимын уналтын тухай мэдээг авчирсан элчийн ирсэн хугацааг хэлсэн (33:21). МЭӨ 593 онд эш үзүүлэгчийн дуудлагыг хүлээн авснаас хойш Езекиел 22 жилийн турш идэвхтэй үйлчилсэн. Түүний эш үзүүлэгийн хамгийн сүүлийнх нь он сар өдөр МЭӨ 571 оны үе гэж бичигдсэн байдаг.

Сэдэв болон зорилго: Езекиелийн гол анхаарч байсан зүйл нь Израилийн гэм нүглийн төлөөх ял зэмлэл (1-32) болон Бурханы ирээдүйд хийх зүйл болох тайтгаруулал (33-48) зэрэг юм.

Гол хүмүүс: Вавилон руу цөллөгдөхийн өмнө болон дараа Израильд эш үзүүлэгч байхаар дуудагдсан тахилч, Бузын хүү Езекиел.

Езекиел ном дахь Христ: Мессия Христийг өндөр ууланд суулгагдсан сүрлэг хуш мод (17:23-24), мөн Исаиа (11:1), Иеремиа (23:5; 33:15), Зехария (3:8; 6:12) номууд шиг Мөчир гэж дүрсэлсэн хэлсэн байдаг. Езекиел бас Мессиагийн талаар удирдан захирах эрх бүхий Хаан (21:26-27), жинхэнэ Хоньчин шиг үйлчлэх Нэгэн (34:11-31) гэсэн байдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Езекиелийн дуудлага ба үүрэг даалгавар (1:1-3:27)

A. Езекиел Бурханы алдрыг харсан нь (1:1-28)	1:22-28	
B. Езекиел Бурханы үгийг дамжуулаг үүрэг даалгавар авсан нь (2:1-3:27)	3:1-15	3:16-27

2. Иуда болон Иерусалим дээрх өнөөгийн шүүлтүүд (4:1-24:27)

A. Ирэх шүүлтийн дервөн тэмдэг (4:1-5:17)	4:9-17	5:1-17
B. Ирэх шүүлтийн тухай хоёр мэдээ (6:1-7:27)	7:1-19	7:20-27
B. Үзэгдлээр дамжуулан хүлээн авсан дервөн эш үзүүллэг (8:1-11:25)	10:1-22	11:14-25
8:1-18	10:1-22	11:14-25
9:1-11	11:1-13	
G. Тэдний дээр ирэх шүүлт гарцаагүй болох нь (12:1-24:27)		
12:1-28	17:1-10	21:18-32
13:1-23	17:11-24	22:1-31
14:1-11	18:1-32	23:1-21
14:12-23	19:1-14	23:22-49
15:1-8	20:1-32	24:1-14
16:1-59	20:33-49	24:15-27
16:60-63	21:1-17	

3. Харь үндэстнүүдийн эсрэг эш үзүүллэгүүд (25:1-32:32)

A. Аммоны эсрэг (25:1-7)		
B. Моабын эсрэг (25:8-11)		
B. Едомын эсрэг (25:12-14)		
G. Филистийн эсрэг (25:15-17)		
D. Тирийн эсрэг (26:1-28:19)		
E. Сидоны эсрэг (28:20-26)		
Ё. Египетийн эсрэг (29:1-32:32)		
29:1-21	31:1-9	32:1-16
30:1-19	31:10-18	32:17-32
30:20-26		

4. Израилийн сэргэлтийн тухай эш үзүүллэгүүд (33:1-48:35)

A. Израиль газар нутагтаа эргэн ирэх нь (33:1-39:29)		
33:1-20	36:1-21	37:24-28
33:21-33	36:22-38	38:1-23
34:1-10	37:1-10	39:1-24
34:11-31	37:11-14	39:25-29
35:1-15	37:15-23	

Б. Израиль хаант улсаа дахин сэргээх нь (40:1–48:35)		
40:1-4	44:1-14	47:13-23
40:5-49	44:15-31	48:1-9
41:1-26	45:1-6	48:10-20
42:1-20	45:7-25	48:21-22
43:1-12	46:1-18	48:23-29
43:13-17	46:19-24	48:30-35
43:18-27	47:1-12	

Даниел

(Израилийн эцсийн хувь тавилан)

Номын нэр болон зохиогч: Даниелын өөрийнх нь хэлсэн үг (12:4) болон 7:2-р ишлэлээс хойш “Би” гэдэг үг хэрэглэсэн зэргээс энэхүү эш үзүүллэгийн номын зохиогчийг Даниел гэж үздэг. Залууд нь буюу МЭӨ 605 онд Небухаднеззар хаан түүнийг Вавилон уруу цөллөгт авчирчээ. Тэрээр тэнд Небухаднеззар болон Дариус хааны ордонд төрийн зүтгэлтэн байв. Хэдийгээр тэр эш үзүүлэгчийн албыг хашиж байгаагүй боловч Христ түүнийг эш үзүүлэгч гэж тодорхойлсон байдал (Матай 24:15; Mark 13:14).

Тус ном нь зохиогчийнхоо нэрээр Даниел гэж нэрлэгддэг бөгөөд энэ нэр нь “Бурхан бол Шүүгч” буюу “Бурхан бол миний Шүүгч” гэсэн утгатай.

Бичигдсэн огноо: МЭӨ 537. Небухаднеззар хаан МЭӨ 605 онд Иерусалимыг эзэлж авсны дараа Даниел бусад залуу эрчүүдийн хамт Вавилон уруу цөлөгдсөн бөгөөд Вавилоны цөллөгт байхдаа энэ номыг бичсэн.

Сэдэв болон зорилго: Бурханы хамгийн дээд хүч чадал бол тэрслүү ертөнцийн хүчинүүдийг шүүж, устгагч цорын ганц үнэн Бурханых агаад Тэрээр Өөрт нь итгэгч, Өөрийн ард түмнийг итгэмжтэйгээр чөлөөлөх болно гэсэн нь Даниел номын гол сэдэв юм. Дэлхий ертөнцөд харийнхны хүч ноёрхож байгаа цаг үед ч, мөн үүний дараа ч гэсэн Израильд зориулсан Бурханы хамгийн дээд төлөвлөгөөг илчлэн харуулж, цөллөгт буй иудейчүүдэд урам зориг өгөхийн тулд Даниел ном бичигдсэн юм.

Гол хүмүүс: Номын гол хүмүүс нь залуудаа Вавилонд хүргэгдэж, засгийн газарт нь ажиллах болсон, мөн харь үндэстнүүд болон иудей үндэстэнд Бурханы онцгой үгийг дамжуулагч Даниел ба түүнтэй хамт тусгай сургалтад хамрагдахаар сонгогдсон гурван залуу Шадрах, Мешах, Абед-него нар юм (Тэд урьд нь Ханания, Мишаэл, Азария гэдэг еврей нэртэй байсан). Бусад чухал хүмүүс нь МЭӨ 605 онд Вавилоны хаан байсан Небухаднеззар; Белшазарын хаан ширээг залгамжлагч Дариус; Персийн эзэн хаан Кореш; 10-р бүлэгт Даниелд үйлчилж байгаа тэргүүн тэнгэр элч Михаэл нар.

Даниел ном дахь Христ: Даниел ном дахь Христийн нэгэн гол дүр зураг бол ирэх Мессия таслагдах болно гэсэн ойлголт юм (загалмайн тухай; 9:25-26). Гэхдээ, Христийг бас энэ ертөнцийн хаанчлалыг устгах Агуу чулуу (2:34, 45), Хүний Хүү (7:13), Эртний Нэгэн (7:22) хэмээн дурсэлсэн байдал. Даниел 10:5-9-д бичигдсэн үзэгдэл нь Христийн төрхтэй маш төстэй байдал (Илчлэлт 1:12-16).

Хувийн Судлалд: Агуулга

1. **Даниельн хувийн амьдралын түүх (1:1-21)**
 - А. Вавилонд цөлөгдсөн нь (1:1-7)
 - Б. Вавилон байхдаа итгэмжтэй байсан нь (1:8-16)
 - В. Вавилон дахь түүний нэр алдар (1:17-21)

2. Харь үндэстнүүдэд зориулсан эш үзүүллэгийн төлөвлөгөө (2:1-7:28)

- A. Небухаднезарын зүүдэлсэн асар том баримлын зүүд (2:1-49)
2:1-18 2:36-38 2:44-45
2:19-30 2:39 2:46-49
2:31-35 2:40-43
- B. Дүрэлзсэн галтай зуух: Итгэл доторх хичээл (3:1-30)
3:1-7 3:8-18 3:19-30
- C. Небухаднезарын үзсэн асар том модны үзэгдэл (4:1-37)
4:1-3 4:19-27
4:4-18 4:28-37
- D. Белшазарын найр ба ханан дээрх бичиг (5:1-31)
5:1-12 5:13-29 5:30-31
- E. Дариусын тэнэг зарлиг буюу Даниел арслангийн үүрэнд (6:1-28)
6:1-15 6:16-28
- F. Дөрвөн араатны тухай Даниельын үзсэн үзэгдэл (7:1-28)
7:1-8 7:13-14
7:9-12 7:15-28

3. Израильд зориулсан эш үзүүллэгийн төлөвлөгөө (8:1-12:13)

- A. Хуц, ухна, жижиг эврийн тухай Даниельын үзсэн үзэгдэл (8:1-27)
8:1-8 8:15-19 8:20-27
8:9-14
- B. Жилүүдийн далан долоон хоногийн тухай Даниельын эш үзүүллэг (9:1-27)
9:1-19 9:20-23 9:24-27
- C. Израилийн ирээдүйн тухай Даниельын эш үзүүллэгийн үзэгдэл (10:1-12:13)
10:1-9 11:14-19 11:40-45
10:10-21 11:20-28 12:1-4
11:1-4 11:29-35 12:5-13
11:5-13 11:36-39

5-р хэсэг

Бага Эш Үзүүлэгчид

“Бага эш үзүүлэгчид” гэдэг нэр томъёо: Библийн эдгээр арван хоёр номын ерөнхий нэрийг “Бага эш үзүүлэгчид” гэдэг. Энэ нэр томъёог МЭ IV зууны сүүл үед анх хэрэглэж эхэлжээ. Энэ эш үзүүлэгчдийн бичвэр нь (“Их эш үзүүлэгчид” гэж нэрлэгддэг) Исаиа, Иеримиа, Езекиел нарын эш үзүүлэгчээс харьцангуй богино учраас л “бага” гэж нэрлэгдсэн. Хуучин болон Шинэ гэрээний цаг үед, Хуучин гэрээг “Хууль болон Эш үзүүлэгчид” гэж нэрлэдэг байв.

Эш үзүүлэгийн ажил үүргийн уг гарал: Израиль үндэстнээр дамжуулан бусад бүх үндэстнийг ерөхийн тулд Бурхан Израилийг сонгосон бөгөөд эш үзүүлэгийн ажил үүргийн гарал үүсэл нь Бурханы энэ зорилгоос үүдэлтэй юм. Бурхан Израильд Хуулийг өгөхдөө хэрвээ тэд дуулгавартай байвал “**Миний эзэмшил**” (Эзэний онцгой баялаг) болно гэж амласан бөгөөд энэ нь бүх үндэстнүүдийн дундах “арин үндэстэн, тахилчдын хаант улс” болгох зорилготой байв (Египетээс гарсан нь 19:5-6 уд.харьц. Дэд хууль 4:6-8). Гэхдээ хэрвээ тэд бусад үндэстнүүдийн итгэл үнэмшил, арга замуудыг дагах аваас энэ зорилго биелж чадахгүй. Мосег нас бараыхын өмнөхөн, тэднийг амласан газар нутаг руу ороход бэлтгэж байх үедээ Бурхан Мосегээр дамжуулан ирээдүйг буюу тэнгэрлэг хүслийг мэдэхийн тулд үндэстнүүдийн ашигладаг мэргэ төлгө зэрэг хууль бус буюу чөтгөрийн арга замыг хатуу буруушаасан байдаг (Дэд хууль 18:9-14). Тэгвэл Бурханы хүслийг хэрхэн мэдэж болох вэ? Бурханы хүслийг Түүний ард түмэнд хүргэх жинхэнэ, хууль ёсны арга замын талаар Дэд хууль 18:15-22-д хэлсэн байдаг. Энд:

ЭЗЭН Бурхан чинь чиний төлөө та нарын дундаас, ах дүү нарын чинь дотроос над шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргажс ирнэ. Та нар түүнийг сонсогтун. Энэ нь Хореб ууланд цуулган болсон тэр өдөр чи ЭЗЭН Бурханаасаа гүйсан бүхний чинь дагуу юм. Тэгэхэд чи “ЭЗЭН Бурханы минь дуу хоолойг надад дахин бүү сонсгооч. Энэ их галыг надад дахин бүү харуулаач. Би үхчих вий” гэж хэлсэн билээ. ЭЗЭН надад “Тэдний хэлсэн уг зөв байна. Би тэдний ах дүү нарынх нь дундаас чам шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргажс, Өөрийнхөө угийг түүний аманд тавина. Миний түүнд тушаах бүхнийг тэр тэдэнд хэлнэ. Миний нэрээр түүний хэлэх Миний угийг сонсохгүй хэн бүхэн Миний шийтгэлийг хүлээх болно. Харин Миний хэлэгтүн гэж тушаагаагүй угийг эш үзүүлэгч Миний нэрээр дураараа яривал, эсвэл өөр бурхдын нэрээр яривал тэр эш үзүүлэгч үхэх болно” гэсэн. Та нар дотроо “ЭЗЭНий айлдаагүй уг гэдгийг бид яаж мэдэх билээ?” гэж бодох биз ээ. Хэрэв эш үзүүлэгчийн ЭЗЭНий нэрээр хэлсэн зүйл болох ч үгүй, биелэх ч үгүй байвал тэр нь ЭЗЭНий айлдсан уг биш. Тэр эш үзүүлэгч үүнийг дураараа хэлсэн байх тул чи түүнээс бүү ай.

Энэ илчлэлт нь эш үзүүлэгчийн ажил үүргийн Библийн эх үндэс болон учир шалтгааныг харуулж өгдөг. Түүнээс гадна, Израиль үндэстэн Абрахамын гэрээнд дурдагдсан Бурханы зорилгуудыг биелүүлэх ёстой бөгөөд Эзэн тэдэнд онцгой амлалт болон сануулгыг өгсөн юм (Эхлэл 12:1-3). Эдгээр нь Дэд Хууль 28-30 дугаар бүлгүүдэд ерөөл ба хараал хэмээн бичигдсэн (үүнийг заримдаа Палестины гэрээ гэж нэрлэдэг). Дуулгавартай байх аваас ерөөгдөж, харин дуулгаваргүй байвал хараагдах болно. Тэгвэл энэ зураглалд эш үзүүлэгч нар хэрхэн тохирч байна вэ? Тэд “**Та нар гэрээг зөрчсөн учраас гэрээний хараал та нар дээр бууж байна, эсвэл буух гэж байна**” гэж хэлдэг бөгөөд үүгээрээ дээрх зураглалд тохирдог юм. Өөрөөр хэлбэл, энэ нь Дэд хууль 28-30 дугаар бүлгүүдэд Бурханы сануулсан зүйл яг болж (эсвэл болох гэж) байна гэдгийг хэлдэг. Гэм нүгэл, шүүлтийн тухай эш үзүүлэгчийн мэдээг Хуучин гэрээний энэхүү нөхцөл байдал, ойлголт дээр үндэслэн хүлээн авах ёстой.

Эш үзүүлэгч нар зөвхөн анхааруулга, сэрэмжлүүлгийг тунхаглаад зогсохгүй, аврал болон Эзэний ирж буй алдрын мэдээг тунхагладаг. Эцсийн эцэст, Бурханы зорилгууд нь Түүний хүчит үйлсээр дамжуулан ард түмнийх нь амьдралд биелэх болно. Заримдаа эдгээр авралын мэдээ нь тэдний үзсэн үзэгдэл дотор тодорхой нэг үйл явдлаар дүрслэгдсэн байдаг (Даниел 9:24-27 ба 70 дахь долоо хоног). Зарим үед тэд Абрахам, Давид зэрэг хүмүүст өгсөн Бурханы амлалтуудыг батлан, тунхаглаж хэлдэг.

Бага эш үзүүлэгчдийн номын бичиглэлийн онцлог: Бүх эш үзүүлэгчдийг судалж байх явцад эдгээр нь бүгд нэг ижил үндсэн бүтэцтэй байгааг харж болно. Эдгээр нь: (1) үндэстнүүдийн гэм нүглээс болж шүүлт ирэх болно гэдгийг сануулсан сануулга; (2) гэм нүглийн тодорхойлолт; (3) ирэх шүүлтийн тухай тодорхойлолт; (4) гэмшилд дуудсан дуудлага; болон (5) ирээдүйд ирэх чөлөөлөлтийн амлалт зэрэг юм.

Нэг санаа хаанаас эхэлж, хаана дуусаж байгааг ойлгох нь эш үзүүлэгийн номыг тоймлох гол түлхүүр юм.⁴⁰ Эш үзүүлэгч нар “Эзэн ийн айлдаж байна ...” гэдэг угээр эхэлж, үүнтэй төстэй үг буюу хэллэгээр тухайн хэсгийг төгсгөдөг.

Он дарааллын тойм:

Библии дэх бага эш үзүүлэгчдийн дараалал

1. Хосеа	4. Обадиа	7. Нахум	10. Хаггай
2. Иоел	5. Иона	8. Хабаккук	11. Зехария
3. Амос	6. Мика	9. Зефания	12. Малахи

Эдгээрийг Иуда ба Израилийн хаант улс болон цөллөгийн дагуу бүлэглэх нь

Бүлэг	Ном	Ойролцоо огноо (МЭӨ)
ЦӨЛЛӨГИЙН ӨМНӨХ: Израилийн эш үзүүлэгчид	Иона Амос Хосеа	793-753 760 755-715
Иудагийн эш үзүүлэгчид	Обадиа Иоел Мика Нахум Зефания Хабаккук	840 835-796 700 633-612 630-625 600
ЦӨЛЛӨГИЙН ДАРААХ: Буцаж ирсэн үлдэгсдийн эш үзүүлэгчид	Хаггай Зехария Малахи	520 520-518 450-400

Хосеа

(Тэвчээртэй хайр)

Номын нэр болон зохиогч: 1-р ишлэлд дурдсанаар, уг номыг зохиогч нь Боерын хүү, Гомерын нөхөр Хосеа юм (1:3). Тэрээр Самарийн хааныг “манай хаан” (7:5) гэж хэлж, Израилийн хойд хаант улсын талаар санаа тавьж байснаас үзвэл хойд Израилийн иргэн байсан бололтой. Хосеагийн тухай мэдээллийг бид зөвхөн уг номоос л мэдэх боломжтой.

Энэ ном нь зохиогчийнхoo нэрээр нэрлэгдсэн бөгөөд Хосеа нь хойд хаант улсын сүүлчийн хаан Хошеатай адилхан нэртэй. Энэ хоёрын нэрийг ялгахын тулд энэхүү бага эш үзүүлэгчийн нэрийг Библид дандаа Хосеа гэж бичсэн байдаг. Сонирхолтой нь, Хосеа, Иошуа, Есүс гэдэг нэрс нь бүгд ХОШЕА буюу “аврал” гэсэн утгатай еврей угээс гаралтай. Гэхдээ Иошуа, Есүс гэдэг нэрс нь “ЭЗЭН бол аврал” гэсэн утгыг агуулдаг. Бурханы элч хүний хувьд, Хосеа хуурамч шүтээнээ орхиж, Эзэн руу эргэн ирэх аваас аврагдах болно гэдгийг ард түмэндээ хэлдэг.

Бичигдсэн огноо: МЭӨ 755-715. 1:1-д хэлснээр, Хосеа нь Иудагийн хаад болох Уззия (767-739), Иотам (739-731), Ахаз (731-715) болон Хезекия (715-686) нарын үед үйлчилж байсан. Тэрээр мөн Израилийн хаан II Иеробоамын (МЭӨ 782-752) өдрүүдэд үйлчилж байв.

Хосеагийн үйлчлэл хэдэн арван жилийг хамардаг бөгөөд Израилийн II Иеробоам (МЭӨ 793-753) болон Иудагийн Уззия хааны (МЭӨ 790-739) хаанчлалын сүүл үеэс эхэлж, Хезекиагийн хаанчлалын эхэн үед

үйлчлэл нь дуусан байна. Хезекиагийн хаан өөрийн эцэг Ахазтай хэсэг хугацаанд хамтран төр барьж байсны дараа 715 оны үеэс өөрөө хаанчилж эхэлсэн. Хосеагийн гол сонсогч нь Израиль байсан атал 1:1-д Израилийн ганцхан хааны нэр дурдагдсан мөртлөө Иудагийн дөрвөн хааны нэр бичигдсэн байдаг нь хачирхалтай юм. II Иеробоамын дараах Израилийн 6 хааны нэрийг дурдаагүйн шалтгаан нь тодорхой биш байдаг. Энэ нь Давидын удмынхны хаанчлалыг (3:5) Хойд Израиль дахь тогтвортгүй, задран унасан хаанчлалтай (7:3-7) харьцуулсан байж болох юм.⁴¹

Бас тэд харьцангуй чухал ач холбогдолтой бус агаад бүгд Небатын хүү I Иеробоамын гэм нүглийг үргэлжлүүлж байсан учраас II Иеробоамын дараах Израилийн зургаан хааны нэрийг хассан байж магадгүй. Үндсэндээ, Өмнөд Иудагийн хаант улсад зарим хаад шинэчлэл хийж байсан бол Хойд Израилийн хаант улсад тэдэнтэй адил сайн хаан нэг ч байгаагүй.

Сэдэв болон зорилго: Израиль үргэлж итгэмжгүй хандаж байсан ч, Бурхан үүнийг нь үл харгалзан Израилийг хайлласаар байсан бөгөөд Бурханы өөрчлөгдөж хувирдаггүй хайрыг харуулахын тулд Хосеа ном бичигдсэн. Хосеагийн гэрлэлтээр дамжуулан уг ном нь Өөрийн ард түмнийг Өөрийгөө мэдэх мэдлэгээр ивээж өрөөхийг хүсдэг Бурханы хайр энэрэл дүүрэн зүрх сэтгэлийг бидэнд харуулдаг. Энэ зорилгоос үүдэн Хосеа нь Умард хаант улсын эсрэг хүчтэй гэрчлэл болж байсан. Учир нь Умард хаант улс нь Эзэнтэй харилцах гэрээний харилцаанд итгэмжгүй байж, хувь хүмүүсийн болон нийгмийн амьдрал аль аль нь ёс суртахууны хувьд маш их ялзарч доройтсон байв. Тиймээс тус эш үзүүлэгч нь нутаг нэгтнүүдээ гэмшиж, тэсвэр тэвчээртэй, хайрын Бурхан руугаа буцаж ирээсэй хэмээн хүсэж байсан. Энэ нь Израилийг Өөрийнхөө гэрээний эхнэр, хайрт хүүхдүүдээ гэж үзэж, хайлаж байсан Бурханы хайраас харагддаг.

Гол хүмүүс: Хосеа, Гомер, Израилийн хаан Иехү

Христийн тухай Хосеа номд: Мессиаг Бурханы Хүү (11:1-ийг Матай 2:15-тай харьцуул), Өөрийн хүмүүсийг аврах цорын ганц Аврагч (13:4-ийг Иохан 14:6-тай харьцуул), биднийг үхлээс золигч Нэгэн (13:14-ийг 1 Коринт 15:55-тай харьцуул), биднийг агуу хайраар хайллагч Нэгэн (11:4), Өөр уруу нь буцан ирэгсдийг эдгээдэг Нэгэн (6:1) гэж дүрсэлсэн байдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Оршил (1:1)

2. Хосеагийн гэрлэлт: Бурханы Израильтai харилцаахааны дүр зураг (1:2–3:5)

- A. Хосеагийн гэр бүлийн эш үзүүллэгийн чанар (1:2-11)
 - 1) Хосеагийн гэрлэлт: Израилийн итгэмжгүй байдал (1:2-5)
 - 2) Хосеагийн хүүхдүүд: Израилийн шүүлт (1:6-9)
 - 3) Израилийн ирээдүй: Сэргэлт (1:10-11)
- B. Шийтгэлээр дамжуулан сэргэлт ирэх нь (2:1-23)
 - 1) Израилийг шийтгэх Эзэний шийтгэл (2:1-13)
 - 2) Израилийг сэргээх Эзэний сэргээлт (2:14-23)
- C. Хосеагийн гэрлэлт дэх сэргэлт (3:1-5)
 - 1) Тэнгэрлэг тушаал (3:1)
 - 2) Хосеагийн дуулгавартай хариу (3:2-3)
 - 3) Зүйрлэлийг тайлбарласан нь (3:4-5)

3. Хосеагийн мэдээ: Израилийн шүүлт ба сэргэлт (4:1–14:9)

- A. Израилийн эсрэг Эзэний шүүлтийн үндэслэл (4:1-6:3)
 - 1) Израилийн гэм буруу илчлэгдсэн нь (4:1-19)

4:1-3	4:7-10	4:15-19
4:4-6	4:11-14	
 - 2) Израилийн шүүлт тунхаглагдсан нь (5:1-15)

5:1-7	5:8-15	
-------	--------	--

- 3) Израилийн сэргэлт зөгнөгдсөн нь (6:1-3)
- Б. Израилийн эсрэг Эзэний шүүлтийн үндэслэл нэмэгдсэн нь (6:4–11:11)
- 1) Израилийн гэм буруу ба шийтгэл (6:4–8:14)

6:4-11	7:8-16	8:8-14
7:1-7	8:1-7	
 - 2) Израилийн гэм буруу ба шийтгэлийг дахин дурдсан нь (9:1–11:7)

9:1-6	9:15-17	10:11-15
9:7-9	10:1-2	11:1-4
9:10-14	10:3-10	11:5-7
 - 3) Эзэний энэрэл хайр шинэчлэгдсэн нь (11:8-11)
- В. Израилийн эсрэг Эзэний шүүлт дууссан нь (11:12–14:9)
- 1) Төгсгөлийн ял буруутгал (11:12–13:16)

11:12–12:11	13:1-3	13:9-11
12:12-14	13:4-8	13:12-16
 - 2) Төгсгөлийн уриалга (14:1-9)

14:1-3	14:4-7	14:8-9
--------	--------	--------

Иоел (ЭЗЭНИЙ ӨДӨР АЙСҮЙ)

Номын нэр болон зохиогч: 1:1-д хэлснээр, тус номын зохиогч нь Иоел бөгөөд энэ нь “ЭЗЭН бол Бурхан” гэсэн утгатай. Энэ нэр нь Бурхан бол Түүхийн Бурхан бөгөөд бүх бүтээл болон үндэстнүүд Түүний хүч чадал, хяналтын дор байдаг Бүхнийг чадагч нэгэн гэдгийг онцлон хэлдэг Иоелын мэдээтэй тохирдог. Бид түүний тухай эцгийнх нэр Петуел гэдгээс (1:1) өөр юу ч мэдэхгүй.

Бичигдсэн огноо: МЭӨ 835–796. Нэгэнт уг номд он цагийн талаар ямар нэг мэдээлэл өгөөгүй учир бид бичигдсэн огноог тодорхойлохдоо номоос олж болох дотоод баримт сэлтийг бидний мэдэх үйл явдлуудтай аль болох холбож үзсэн болно. Хүмүүс МЭӨ 835-400 онд бичигдсэн гэж үздэг боловч үүнийг батлахад хүндрэлтэй байдаг. Бидний хувьд, Тир, Сидон, Филист, Египет зэрэг улсуудыг дайснаа гэж нэрлэж байгаагаас нь үүдэн (3:4, 19), МЭӨ 835-796 онд бичигдсэн гэж үзэж байна. Эдгээр улсууд нь Өмнөд хаант улсыг Вавилон уруу цөлөгдөхөөс өмнө тэдний эртний дайснууд байсан юм. Цөллөгт явсны дараа Ассири, Вавилон, Перс улсууд тэдний дайсан байх болсон.

Сэдэв болон зорилго: Израиль ЭЗЭНИЙ өдөрт бэлтгэх хэрэгтэй гэдгийг Иоел саяхан Иудад гэнэт болж өнгөрсөн ган гачиг болон голионы учруулсан гамшиг зэргийг ашиглан зааж байна. Маш богино хугацаанд буюу хэдхэн цагийн дотор бүх ургамал ногоо юу ч үгүй болж, хоосорчээ. Хэрвээ үндэстэн гэмшиж, Эзэн рүү эргэх аваас Бурхан тэдэнтэй харилцах Өөрийн харилцааг сэргээж, тэднийг ерөөх болно. Иоелыг бичиж байх үед дээрх үйл явдал түүхэнд бодитоор болж өнгөрсөн шиг ирээдүйд ч гэсэн энэ нь бодитой үнэн байх болно. Иоелоор дамжуулан амласан бүрэн төгс ерөөл болон сэргээн босголтын хувьд иудейчүүд Бурханы Сүнс цутган буух үед болон Их зовлонгийн шүүлтийн үед эдгээрийг амсаж туулах болно. Энэ байдал нь тэднийг Эзэн рүү буцан ирэх учир шалтгаан болох болно.

Гол хүмүүс: Иоел

Иоел ном дахь Христ: Иоел номд Христийг Ариун Сүнс өгөгч Нэгэн (2:28 уд.харьц. Иохан 16:7-15; Үйлс 1:8), үндэстнүүдийг шүүгч (3:2, 12), Израилийн өмөг түшиг, хоргодох газар (3:16) гэсэн байдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Эзэний түүхэн өдөр (1:1-20)

- А. Түүхэнд тохиолдсон голионы гамшиг (1:1-12)
- | | | |
|-------|-------|--------|
| 1:1-3 | 1:4-7 | 1:8-12 |
|-------|-------|--------|

Б. Түүхэнд тохиолдсон ган гамшиг (1:13-20)

2. Эзэний эш үзүүлэгийн өдөр (2:1-3:21)

А. Эзэний өдөр айсуй (2:1-27)

- | | | |
|---|---------|---------|
| 1) Иудагийн халдлагын тухай эш үзүүлэг (2:1-11) | | |
| 2) Иудагийн авралд шаардагдах нөхцөл байдал (2:12-27) | | |
| 2:12-17 | 2:18-20 | 2:21-27 |

Б. Эзэний өдөр гарцаагүй болох нь (2:28-3:21)

- | | | |
|--|--------|---------|
| 1) Эзэний өдрийн өмнө болох эцсийн үйл явдлууд (2:28-32) | | |
| 2) Эзэний өдрийн үйл явдлууд (3:1-21) | | |
| 3:1-8 | 3:9-17 | 3:18-21 |

АМОС

(Онцгой эрхээ буруугаар ашигласны шүүлт)

Номын нэр болон зохиогч: Исаиа (хааны зөвлөх байсан), Иеремиа (тахилч байсан) нараас ялгаатай нь тус номыг малчин, инжрийн жимс хураачг Амос бичсэн (1:1; 7:14). Тэрээр Иерусалимаас өмнөд зүгт 16 км орчим газарт байдаг Бетлехемийн ойролцоо Текоагийн хүн байв. Хэдийгээр тэр малчин хүн байсан боловч Бурханы Үгийг сайн мэддэг хүн байжээ. Амос гэдэг еврей нэр нь “ачаа” буюу “ачаа үүрэгч” гэсэн утгатай. Энэ нь түүнд өгөгдсөн ачаанд тохирч байна. Хэдийгээр Амос Умард Израилийн хаант улсаас биш, харин Өмнөд Иудагийн хаант улсаас гаралтай боловч Умард хаант улсын өөрийгөө зөвтгөгч байдал, дэлхийлэг, шударга бус, шунахай байдлын эсрэг сануулгын мэдээг дамжуулах ачааг үүрсэн нэгэн байлаа. Амосыг Исаиагийн эцэг Амоэтай (Исаиа 1:1) андуурч болохгүй.

Бичигдсэн огноо: Ойролцоогоор МЭӨ 760 он. 1-р ишлэлд хэлснээр, Амос Уззиа, Иеробоам II нартай нэг цаг үед амьдарч, “Иудагийн хаан Уззиагийн өдрүүдэд (МЭӨ 790-739) болон Израилийн хаан Иоашийн хүү Иеробоамын өдрүүдэд (МЭӨ 793-753), газар хөдлөлтөөс хоёр жилийн өмнө” эш үзүүлж байжээ (1:1). Амос МЭӨ 767-753 оны үед эш үзүүлж байсан бололтой. Тэрээр “газар хөдлөлтөөс хоёр жилийн өмнө” эш үзүүлж байсан гэж хэлсэн боловч энэ үйл явдал хэзээ болсон нь тодорхойгүй байдаг.

Сэдэв болон зорилго: Амост өгөгдсөн тэнгэрлэг мэдээ нь юуны өмнө шүүлтийн талаар өгүүлдэг, гэхдээ энэ нь эцэстээ найдварын үгсээр төгсдөг. Дэлхий ертөнцийн хамгийн дээд захирагч, Эзэн Бурхан Өөрийнх нь эрх мэдлийн эсрэг тэрслэгч үндэстнүүдийг шүүхээр Дайчин мэт ирэх болно гэдгийг Амос сануулсан. Ялангуяа Израиль Бурханы гэрээг зөрчсөнийхөө төлөө шийтгэгдэх болно. Иеробоам хааны удирдлага дор материаллаг талаараа хөгжин цэцэглэж байсан умард хаант улсыг ирэх гэж буй шийтгэлээс зугтах цорын ганц зам болох гэмшилд авчрах гэж Амос хичээж байв. Энэ явцад, уг ном нь Бурхан ариун учраас бузар мууг үзэн яддаг бөгөөд Түүний шударга зан чанар Израилийн гэм нүглийг шийтгэлгүй өнгөрөхгүй гэдгийг илэрхийлэн харуулсан байдаг.

Гэхдээ, хэдийгээр улс үндэстэн устгагдсан ч, Бурхан Израилийн гэмшсэн цөөн тооны бүлэг хүмүүсийг хамгаалж үлдэх болно (үүнийг ихэвчлэн “үлдэгсэд” гэж нэрлэдэг). Нэгэн өдөр энэхүү жижиг бүлгийн хувьд гэрээний ерөөл болон улс төрийн нэр хүнд нь дахин сэргээгдэх бөгөөд үүний дараа Эзэн бүх үндэстнүүдийг Өөр рүүгээ дуудах болно.

Гол хүмүүс: Амос, Иудагийн хаан Уззиа, Израилийн хаан Иеробоам

Амос ном дахь Христ: Амос Христийг Давидын хаанчлалыг дахин босгогч (9:11), мөн Өөрийн ард түмнийг дахин сэргээх Нэгэн (9:11-15) гэж дүрсэлсэн байдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Танилцуулга: Зохиогч ба сэдэв (1:1-2)

2. Амосын найман шүүлт (1:3–2:16)

- А. Дамаскийн талаар (1:3-5)
- Б. Филистийн талаар (1:6-8)
- В. Тирийн талаар (1:9-10)
- Г. Едомын талаар (1:11-12)
- Д. Аммоны талаар (1:13-15)
- Е. Моабын талаар (2:1-3)
- Ё. Иудагийн талаар (2:4-5)
- Ж. Израилийн талаар (2:6-16)

3. Амосын номлолууд (3:1–6:14)

A. Израилийн мөхөл (3:1-15)	3:1-8	3:9-10	3:11-15
Б. Израилийн завхрал (4:1-13)	4:1-3	4:4-5	4:6-13
В. Израилийн төлөөх оршуулгын дуу (5:1–6:14)			
1) Ирэх шийтгэлээс болж Израиль сүйрэх нь 5:1-17	5:1-3 5:4-7	5:8-9 5:10-13	5:14-15 5:16-17
2) Шашинлаг хүмүүсийг зэмлэсэн нь (5:18-27)	5:18-20	5:21-24	5:25-27
3) Үндэстнийг бүхэлд нь хатуу зэмлэсэн нь (6:1-14)	6:1-3 6:4-7	6:8-11 6:12-14	

4. Амосын таван үзэгдэл (7:1–9:10)

- А. Цөлмөгч царцааны үзэгдэл (7:1-3)
- Б. Галын үзэгдэл (7:4-6)
- В. Тэгшлүүрийн үзэгдэл (7:7-9)
- Г. Түүхийн завсарлага: Бетелийн тахилчийн эсэргүүцэл (7:10-17)
- Д. Зуны жимстэй сагсны үзэгдэл (8:1-14)
- Е. Шүүж буй Эзэний үзэгдэл (9:1-10)

5. Израилийн сэргэлтийн тухай таван амлалт (9:11-15)

Обадиа (Шударга ёс)

Номын нэр болон зохиогч: Зохиогч нь Обадиа гэдэг нэртэй (1:1) Иудагийн олонд танил бус нэгэн эш үзүүлэгч юм. Түүний нэр нь “ЭЗЭНий зарц буюу ЭЗЭНд мөргөгч” гэсэн утгатай. Хуучин гэрээнд Обадиа гэдэг нэртэй хэд хэдэн хүн байсан. Үүнд Давидын армийн жанжин (1 Шастир 12:9), Бурханы эш үзүүлэгчдийг нууж байсан Ахабын зарц (1 Хаад 18:3), Иосиагийн өдрүүдэд амьдарч байсан нэгэн Леви хүн (2 Шастир 34:12), Езратай хамт цөллөгөөс буцаж ирсэн нэгэн удирдагч (Езра 8:9) зэрэг хүмүүсийг хэлж болно. Обадиагийн төрөлх хот болон гэр булийнх нь талаар хэлсэн зүйл нэг ч байдаггүй бөгөөд түүний эзгийн нэрийг дурдаагүй байдгаас үүдэн түүнийг хааны эсвэл тахилчийн удмын хүн биш байсан болов уу гэж үздэг.

Бичигдсэн огноо: МЭӨ 840. Библийн хамгийн богинохон ном бөгөөд 21-хэн ишлэлтэй. Бага эш үзүүлэгчдийн номууд дундаас тус номын бичигдсэн огноог тодорхойлоход хамгийн хэцүү. МЭӨ 848-841 оны хооронд Иехорамын хаанчлалын үед Араб, Филистчүүдэд эзлэгдэх болно гэсэн Едомын эсрэг эш үзүүллэгээс үүдэн бид Обадиаг МЭӨ 840 оны үед бичигдсэн гэж үзэж байна (2 Шастир 21:16-17).

Сэдэв болон зорилго: Обадиа номын сэдэв нь уналтын өмнө бардам зан явдаг гэдэг үнэнийг дахин давтдаг. Иерусалимд тохиолдсон бузар муу зүйлд баярлан хөөрснөөс болж Еdom шүүгдэж байна гэдгийг Обадиа номд тунхагладаг.

Гол хүмүүс: Обадиа

Обадиа ном дахь Христ: Обадиа номд Христийг үндэстнүүдийг Шүүгч (15-16), Израилийн Аврагч (17-20), хаанчлалыг Эзэмшигч (21) хэмээн дүрсэлсэн байдаг.⁴²

Хувийн Судлалд: Агуулга

1. **Едомын шүүлтийн тухай эш үзүүллэгүүд (1:1-9)**
 - A. Шүүлтийн гарцаагүй байдал (1:1-4)
 - B. Шүүлтийн бүрэн төгс байдал (1:5-9)
2. **Едомын шүүлтийн үндэслэл (1:10-14)**
 - A. Ахан дүүсийн хайр байхгүй учраас (1:10)
 - B. Ихэмсэг зан чанарынх нь улмаас (1:11-12)
 - B. Түрэмгийн байдлынх нь улмаас (1:13-14)
3. **Шүүлтийн цаг хугацаа (1:15)**
4. **Шүүлтийн үр дагаврууд (1:16-18)**
5. **Израилийн чөлөөлөлт (1:19-21)**

Иона

(Бурханы хүслээс зугтах нь)

Номын нэр болон зохиогч: Номын зохиогч нь Умард Израилийн хаант улс дахь Галилын эш үзүүлэгч Амиттаигийн хүү Иона юм. Үүнийг номоос харж болох (1:1) бөгөөд тус ном нь түүхэн ном гэдгийг энд дурдагдсан газар нутаг, хүмүүсийн бодит нэрсээс (2 Хаад 14:25), мөн бусад эх сурвалжуудаас, Шинэ Гэрээн дэх Есүсийн гэрчлэлээс харж болно (Матай 12:40). Түүний нэр нь “тагтаа” гэсэн утгатай.

Бичигдсэн огноо: МЭӨ 793–753. 2 Хаад 14:27-д Израилийн Иеробоам II хааны хаанчлалтай холбоотойгоор Ионагийн нэр дурдагддаг (МЭӨ 793-753). Иона нь Елишагийн дараа буюу Амос, Хосея нарын цаг үеэс өмнөхөн үйлчилж байжээ.

Сэдэв болон зорилго: Тус ном нь өөр арьс үндэстнийг үл хайрлах хандлага нь Бурханы хүслийг дагахад бидэнд саад болж болдог гэдгийг, мөн Еврейчүүдийн Бурхан бол (1) гэмшиж, Өөр рүү нь эргэсэн бүх хүнд авралыг өгдөг бөгөөд дэлхий ертөнцөд бүхэлд нь санаа тавьдаг Бурхан, (2) байгаль дэлхийг бүхэлд нь захирч, хүмүүний бүх хэргийг шийдэж байдаг гэдгийг харуулдаг.

Гол хүмүүс: Иона

Иона ном дахь Христ: Ионагаар дамжуулан, Христийн амилалтыг (Матай 12:40), мөн Түүнийг үндэстнүүдийн эш үзүүлэгч (гэхдээ Тэр Ионатай адилхан дургүй байгаагүй), үндэстнүүдийн Аврагч гэдгийг харуулсан. Христ бол Аврагч Эзэн гэдгийг Ионагийн амьдралаас харж болно (2:9).

Хувийн Судлалд: Агуулга

1. **Иона зугтсан нь (1:1-17)**

- A. Түүний зугтаах болсон шалтгаан (1:1-2)
 - B. Түүнийг зугтсан зам (1:3)
 - C. Түүний зугтсаны үр дагавар (1:4-17)
- 2. Ионагийн залбирал (2:1-10)**
- A. Түүний залбирлын онцлог шинж (2:1-9)
 - B. Түүний залбирлын хариу (2:10)
- 3. Ионагийн номлол (3:1-10)**
- A. Бурхан номлохыг тушаасан нь (3:1-3)
 - B. Ионагийн номлолын сэдэв (3:4)
 - C. Ионагийн номлолын үр дагаврууд (3:5-10)
- 4. Ионагийн сурсан зүйл (4:1-11)**
- A. Иона Бурханд гомдоллосон нь (4:1-3)
 - B. Ионад зориулсан Бурханы сургалт (4:4-11)

Мика

(Бурхантай адил хэн байдаг вэ?)

Номын нэр болон зохиогч: Тус ном нь зохиогчийнхоо нэрээр буюу эш үзүүлэгч Микагийн нэрээр нэрлэгдсэн. Энэ номын зохиогчийн талаар тус номоос өөрөөс нь болон Иеремиа 26:18-аас өөр мэдэх зүйл маш бага байдаг. Мика гэдэг нэр нь Микаиа гэдгийн богиносгосон хэсэг бөгөөд энэ нь “ЭЗЭНтэй адил хэн байдаг вэ?” гэсэн утгатай. Мика 7:18-д “**Тантай адил Бурхан хэн юм бэ?**” хэмээн энэхүү үнэнийг өчсөн байдаг. Иеремиагийн өдрүүдэд нутгийн ахмадууд Мика 3:12-оос иш татан, ард түмэн дээр буух шүүлтийн тухай Иеремиагийн мэдээг хамгаалсан байдаг (Иеремиа 26:18).

Мика нь Иерусалимын баруун өмнөд хэсэгт, Филистийн Гат гэдэг хотын ойролцоо байдаг Иудагийн нэгэн хот болох Морешетийнх (Мика 1:1 уд.харьц. 1:14) байв. Морешет нь олон улсын худалдааны хот болох Лахишийн ойролцоо Иудагийн үргжил шимт нутагт байдаг байжээ.

Бичигдсэн огноо: МЭӨ 700 он. Нэгдүгээр ишлэлд, Мика өөрийгөө Иотам (МЭӨ 750-732), Ахаз (МЭӨ 736-716), Хезекия (МЭӨ 716-687) нарын өдрүүдэд эш үзүүлж байсан гэдгээ хэлсэн байдаг. Мика голлон Иудад хандан эш үзүүлж байсан боловч Умард Израилийн хаант улсад ч бас хандан уг хэлж, Самарийн уналтыг зөгнөж байсан (1:6). Тэрээр МЭӨ 722 онд болсон Ассирийн булаан эзлэлтийн өмнө буюу ойролцоогоор МЭӨ 700 оны үед голлон үйлчилж байжээ.

Сэдэв болон зорилго: Бурханы Израильтай хийсэн гэрээний нөхцөлийг Израильчууд хэрхэн биелүүлж чадаагүй вэ гэдгийг Мика харуулсан байдаг. Энэ гэрээний дагуу хэрэв тэд дуулгавартай байвал өрөөгдөж (Дэд хууль 28:1-14), харин дуулгаваргүй байвал хараагдаж, амлалтын газар нутгаас хүртэл хөөгдөхөд хүрэх (Дэд хууль 28:15-68) учиртай байсан. Энэ үйл явцын дунд, Мика Иудагийн шударга бус байдлыг илчилж, ЭЗЭНий шударга, зөвт байдлыг тунхаглан, Эзэн тэднийг сахилгажуулахдаа ч гэсэн шударга байдаг гэдгийг харуулсан. Тэр Израиль болон Иудаг хүчирхийлэл, бардамнал, хууран мэхлэлт, шунахайрал, дарлал болон шүүгчид, эш үзүүлэгчид, тахилчдын дунд байсан хээл хахууль зэрэг гэм нүглээс болж буруутгаж байсан. Энэхүү сахилгажуулалт нь мэдээж хэрэг Бурханы тэднийг хайрлах хайраас үүдэлтэй агаад Тэр тэднийг дахин сэргээх болно.

Микагийн дамжуулсан гурван хэсэг мэдээний гол утга нь шүүлт, гэхдээ тэрээр бас сэргэлтийн үнэнийг ч гэсэн онцлон өгүүлсэн байдаг. Түүнчлэн, Мика өөрийнхөө мэдээ тус бүр дээр үлдэгэсдийн тухай өгүүлдэг (Мика 2:12; 4:7; 5:7-8; 7:18). Ирээдүйд ЭЗЭН Израилийн ард түмнийг сэргээж, ирэх Мессиагийн дор дэлхий ертөнц дээр байнга оршин суух газрыг өгөх болно гэдгийг тунхагласан.

Мика номын төгсгөлийн хэсэгт шүүлтийн өрөөг дүрслэн өгүүлсэн байдаг. Бурхан Өөрийн ард түмний эсрэг зарга үүсгэж, Өөрийн хэргийг шүүлгэх шүүгчдийн бүрэлдэхүүнд оруулахаар уул толгодыг хамтад нь дуудаж байна. Израилийн ард түмэн зүрх сэтгэлийнхээ мөргөлийн оронд хоосон ёс заншлыг бий болгож, энэ бол Бурханы шаарддаг бүх зүйлс гэж бодох болсон. Тэд өөрсдийн шударга бус үйл хэргийг халхлахын тулд өдөр тутмынхaa ажил хэрэг дээр Бурханы шударга ёсны хэм хэмжээг дагахаа больсон. Тэд Эзэн хүнээс юуг хүсэж шаарддаг вэ гэдгийг ойлгож чадаагүй. Тиймээс зөвхөн “гэм буруутай” гэсэн ялын тогтоол гараад хүргэсэн. Уг ном нь найдварын үгсээр төгсдөг.

Шүүлт явуулсан яг тэр Бурхан өөрөө энэрэл нигүүлсэл үзүүлэхдээ баярлан баясдаг: “Гэнийг уучилдаг, Өөрийн өвийн үлдэгсдийн тэрслүү үйлдлийг хэрэгсдэггүй Тантай адил Бурхан хэн юм бэ? Тэр хувиршигүй хайранд баясдаг тул уур хилэнгээ мөнхөд хадгалдаггүй” (7:18). Эш үзүүлэгч маань “Харин миний хувьд, би ЭЗЭНийг хүлээн харуулдах болно. Би авралынхaa Бурханыг хүлээнэ. Миний Бурхан намайг сонсох болно” (7:7) хэмээн тунхагласанд гайхах хэрэггүй юм.⁴³

Гол хүмүүс: Мика, Иотам, Ахаз, Хезекия

Мика ном дахь Христ: Мика номд Христийг Иаковын Бурхан (4:2), үндэстнүүдийн Шүүгч (4:3), Бетлехем хотод мэндлэх Захирагч (5:2 уд.харьц. Матай 2:1-6) хэмээн дүрсэлсэн байдаг. Мессиагийн мэндлэх газрын тухай Херодын асуултад тахилч, бичээч нар Мика 5:2-оос иш татан хариулсан.

Хувийн Судлалд: Агуулга

1. Оршил (1:1)

2. Эхний мэдээ: Иуда болон Самарид зориулсан шүүлт (1:1–2:13)

- A. Ирэх шүүлтийг зөгнөсөн нь (1:2-7)
- B. Ард түмний төлөө гашуудсан нь (1:8-16)
 - 1) Микагийн гашуудал (1:8-9)
 - 2) Бусад хүмүүсийг гашуудахад уриалсан Микагийн уриалга (1:10-16)
- B. Иудагийн гэм нүглүүд (2:1-11)
 - 1) Ард түмний гэм нүглүүд (2:1-5)
 - 2) Хуурамч эш үзүүлэгчдийн гэм нүглүүд (2:6-11)
- Г. Ирээдүйд дахин цуглах болно гэдгийг зөгнөсөн нь (2:12-13)

3. Хоёр дахь мэдээ: Сүйрлийг чөлөөлөлт дагах нь (3:1–5:15)

- A. Үндэстний удирдагч дээр ирэх шүүлт (3:1-12)
 - 1) Удирдагч дээр ирэх шүүлт (3:1-4)
 - 2) Хуурамч эш үзүүлэгч дээр ирэх шүүлт (3:5-8)
 - 3) Бүх удирдагч нар дээр ирэх шүүлт (3:9-12)
- B. Үндэстэнд зориулсан хаанчлалын өрөөлүүд (4:1–5:15)
 - 1) Хаанчлалын онцлог шинжүүд (4:1-8)
 - 2) Хаанчлалын өмнө болох үйл явдлууд (4:9–5:1)
 - 3) Хаанчлалын захирагч (5:2-15)

4. Гурав дахь мэдээ: Гэм нүглийн зэмлэл ба ерөөлийн амлалт (6:1–7:20)

- A. Эзэний зэмлэл (6:1-5)
- B. Израиль үндэстэнд хариулсан Микагийн хариулт (6:6-8)
- B. Гэм нүглээс үүдэлтэй Эзэний шүүлт (6:9-16)
 - 1) Гэм нүглүүд (6:9-12)
 - 2) Шийтгэл (6:13-16)
- Г. Мика Эзэнээс гүйсан нь (7:1-17)
 - 1) Израиль үндэстний гэм нүглээс болж Мика гашуудсан нь (7:1-6)
 - 2) Мика Эзэнд итгэж байсан нь (7:7-13)

- 3) Бурхан дахин Өөрийн хонин сүргийг хоньчлохын төлөө Мика залбирсан нь (7:14)
 - 4) Өөрийн ард түмэнд гайхамшигт зүйлсийг үзүүлэх болно гэсэн Эзэний амлалт (7:15-17)
- Д. Бурхан бол цорын ганц гэдгийг Мика дахин баталсан нь (7:18-20)

Нахум (Ниневегийн мөхөл)

Номын нэр болон зохиогч: Номын 1:1-д Елкош хүн Нахумын үзэгдлийн ном, Ниневегийн зөн гэж хэлснээс өөр энэхүү эш үзүүлэгчийн тухай мэдэх зүйл нэг ч байдаггүй. Нахум гэдэг нь “тайтгаруулал” гэсэн утгатай, гэхдээ түүний мэдээ нь Ниневед амьдарч байсан хорон муу ассиричуудыг тайтгаруулсан мэдээ байгаагүй юм. Харин энэ нь иудейчүүдийг тайвшруулах мэдээ байв. 1:15-аас харвал тэрээр Иудагийн эш үзүүлэгч байсан бололтой. Гэхдээ Елкош гэдэг газар яг хаана байсан нь тодорхойгүй байдал бөгөөд ихэнх консерватив эрдэмтэд тус хотыг өмнөд Иудагийн аль нэгтээ байсан гэж итгэдэг.

Бусад бүх бага эш үзүүлэгчдийн номын адил тус ном нь уг эш үзүүллэгийг хэлсэн эш үзүүлэгчийнхээ нэрээр нэрлэгдсэн.

Бичигдсэн огноо: МЭӨ 663–612 он. Нахум 3:8-10-д аль хэдийнэ болж өнгөрсөн Тибийн (Египетэд байдаг) мөхлийн тухай өгүүлсэн байдал. Тиб нь МЭӨ 663 онд мөхөж устсан улс юм. Нахум номынхоо гурван бүлэгт гурвууланд нь Ниневегийн сүйрлийн тухай зөгнөсөн бөгөөд энэ нь МЭӨ 612 онд биелсэн. Нахум Ниневегийн сүйрэл тун удахгүй болно гэж хэлж байснаас үзвэл түүний зөн энэ цаг үтэй их ойрхон өгөгдсөн бололтой (2:1; 3:14, 19). Үүнээс харвал тэрээр Иосия хааны үед буюу Зефания, Иеремиа нартай нэг цаг үед үйлчилж байжээ.

Сэдэв болон зорилго: Нахум номын гол сэдэв бол Ниневегийн уналт бөгөөд энэ нь Ниневе хотын бузар муу ассиричуудын эсрэг Бурханы өшөө авалт юм. Ионагийн харахыг хүсэж байсан тэр зүйлийг буюу ассиричууд дээрх Бурханы шүүлтийг ойролцоогоор зуун тавин жилийн дараа Нахум зөгнөн хэлж байна.

Ионагийн номлолын хариуд Ниневечүүд гэмшсэн боловч энэ нь тийм ч удаан үргэлжлээгүй бөгөөд тэд тун удалгүй хуучин хорон муу замууд руугаа эргэж, хэрцгийн догшин болцгоосон. Ассирийн хаан Саргон II Самарийг устгаж, Умард Израилийн хаант улсыг эзэлж аван, МЭӨ 722 онд арван овгийг тараан бутаргасан. Хожим нь, МЭӨ 701 онд Хезекиаг хаанчилж байх үед Ассирийн хаан Сеннахериб Иерусалимыг эзэлж авах дөхсөн. Ниневегийн хүчирхэг байдал, алдар цууг үл харгалзан, тэд Ариун Бурханы өмнө шүүгдэж, мөхөх болно гэдгийг эш үзүүлэгч Нахумаар дамжуулан тодорхой хэлсэн байдал. Ассирийн хүчирхэг байдал, бардамнал, харгис догшин байдал Бурханы хүчээр эцэс болох болно. Хэдийгээр тус ном Ассирийн мөхөл, шүүлтийн тухай голлон өгүүлдэг боловч Иудад тайвшралыг өгөхийн тулд бичигдсэн.

Гол хүмүүс: Нахум

Нахум ном дахь Христ: Хэдийгээр Нахум номд Мессиагийн талаар шууд өгүүлсэн эш үзүүллэгүүд байдаггүй боловч бүхий л эш үзүүллэгүүдэд ерөнхийд нь байдаг нэг зүйл энд бас байдаг. Энэ нь Христийг хартай Бурхан бөгөөд өрсөлдөгчдөөсөө өшөө авдаг гэсэн дүрслэл юм (1:2-13).

Хувийн Судлалд: Агуулга

1. **Оршил (1:1)**
2. **Ниневе дээр буулгах Бурханы шүүлтийн тухай эш үзүүллэг ба энэ шүүлт гарцаагүй болох нь (1:2-15)**
 - A. Ниневегийн эсрэг Бурханы ариун уур хилэн (1:2-8)
 - B. ЭЗЭНИЙ эсрэг Ниневегийн хуйвалдаан эцэс болох болно (1:9-11)

В. Ниневегийн шүүлтээс болж Иудагийн зовлон шаналал эцэс болох болно (1:12-15)

3. Ниневе дээр буулгах Бурханы шүүлтийг үгээр илэрхийлэх нь (2:1-13)

- А. Довтолгооныг дүрслэн хэлэхэд (2:1-6)
- Б. Ялагдлыг тунхаглан хэлэх нь (2:7-13)

4. Ниневе дээр буулгах Бурханы шүүлтийн шалтгаан (3:1-19)

- А. Түүний ичгүүртэй байдалд оруулагч заль мэх болон хүчирхийллээс болж (3:1-7)
- Б. Түүний Тиб (Но-Амон) руу дайрсан дайралт өөрийнх нь ялагдал болон хувирна (3:8-11)
- В. Түүний хамгаалалт үр ашигтгүй болох нь (3:12-19)

Хабаккук (Эргэлзээг шийдвэрлэсэн нь)

Номын нэр болон зохиогч: 1:1 болон 3:1-ээс зохиогч нь Хабаккук гэдгийг харж болно. Тэрээр өөрийгөө эш үзүүлэгч гэдгийг маш тодорхой хэлсэн бөгөөд түүний залбирал болон магтаал нь “*Найрал дууны удирдаачид, миний чавхаст хөгжим дээр тоглоход зориулав*” гэсэн үгээр төгссөн нь түүнийг тахилч хүн байсан болов уу гэж бодоход хүргэдэг.

Тус ном нь зохиогчийнхоо нэрээр нэрлэгдсэн. Хабаккук гэдэг нь “тэврэлт” гэсэн утгатай еврей үг юм. Бурхан бол өөрийнх нь аврал, хүч чадал учир энэхүү эш үзүүлэгч ЭЗЭНээс зуурсан.

Бичигдсэн огноо: МЭӨ 600. Вавилончууд нэрд гарч, алдарших болно гэдгийг сануулсан, мөн Вавилоны булаан эзлэлт ирэх гэж байна гэдгийг энэ номд урьдчилан өгүүлсэн байдаг зэргээс үзвэл Хабаккук нь Иудагийн Иехоиакимийн хаанчлалын үед үйлчилж байсан бололтой. Вавилон Иудаг хараахан булаан эзлээгүй байгаа, гэхдээ энэ нь ойрхон байна (1:6; 2:1) гэснээс харвал МЭӨ 605 онд Вавилон Иудаг эзэлж авахын өмнөхөн Хабаккук эш үзүүлсэн бололтой.

Сэдэв болон зорилго: Бузар муу Вавилончуудад эзлэгдэх болно гэснээс болж Хабаккук эргэлзэн тээнэгэлзэхэд хүрсэн бөгөөд түүний эргэлзээнээс энэхүү эш үзүүллэгийн сэдэв урган гардаг. Энэ нь түүний итгэл үнэмшлийн асуудлыг хөнддөг бөгөөд (1) Бурхан яагаад Иудагийн бузар муу ихэссээр байхад шийтгэлгүйгээр явуулсаар байна вэ? (1:2-4) (2) Ариун Бурхан (1:13) Вавилон шиг нүгэлт үндэстнийг Өөрийн шүүлтийн хэрэгсэл болгон ашиглаж яаж чадаж байна вэ (1:12-2:1)? гэсэн хоёр хэцүүхэн асуулт түүнд гарч ирсэн. Эдгээр бэрхшээлтэй асуудлуудыг ойлгоход Хабаккукт төвөгтэй байсан, гэвч энэ нь Бурханы түүнд өгсөн илчлэлтийн үр дүнд шийдвэрлэгдэж, баяр хөөртэй итгэлийн дууллаар эш үзүүлэгч номоо төгсгөсөн байдаг. Энэ нь сайн сайхан ба бузар муугийн асуудал дээрх Бурханы хүч чадлыг хамгаалсан ном юм.

Гол хүмүүс: Хабаккук

Хабаккук ном дахь Христ: Эш үзүүллэгийн мөн чанараас нь үзвэл, энд Христийг Аврагч гэж дүрсэлсэн байдаг. “Аврал” гэсэн үг 3:13, 18 дээр гурван удаа гардаг бөгөөд энэ үг нь “Есүс” гэдэг нэртэй (Матай 1:21) нэг үндэстэй үг юм. Түүнийг бас Ариун Нэгэн (1:12 уд.харьц. 1 Иохан 1:9), зөвт хүнийг итгэлээр зөвтгөгч Нэгэн (2:4), нэгэн өдөр “*далай усаар дүүрэн байдгийн адил Эзэний яруу алдын мэдлэгээр*” дэлхийг дүүргэх Нэгэн (2:14) гэсэн байдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Хабаккукийн эргэлзээ: Шалгагдаж, сургагдсан итгэл (1:1-2:20)

- А. Эхний асуулт: Бурхан Иудад бузар муу зүйлс үргэлжилсээр байхыг яагаад зөвшөөрдөг вэ? (1:2-4)
- Б. Бурханы эхний хариулт (1:5-11)
- В. Хоёр дахь асуулт: Бурхан яагаад Иудаг шийтгэхдээ бузар муу хүмүүсийг ашиглах вэ? (1:12-2:1)

Г. Бурханы хоёр дахь хариулт (2:2-20)

2. Хабаккукийн магтаал: Ялгуулсан итгэл (3:1-19)

- А. Бурханы мөн чанарыг магтах нь (3:1-3)
- Б. Бурханы хүч чадлыг магтах нь (3:4-7)
- В. Бурханы зорилгыг магтах нь (3:8-16)
- Г. Бурханд итгэх итгэлийг магтах нь (3:17-19)

Зефания

(Шүүлтээр дамжуулан ерөөгдөхүй)

Номын нэр болон зохиогч: 1:1-ээс үзвэл, тус номыг Хезекиагийн хүү, Амариин хүү, Гедалиагийн хүү, Кушийн хүү Зефания бичсэн. Эш үзүүлэгчийн удам угсааг дөрвөн үеэр дурдсан нь нэлээн онцгой тохиолдол юм. Ихэвчлэн зохиогчийн уг гарлын тухай мэдээлэл өгөхдөө зөвхөн эш үзүүлэгчийн аавыг дурддаг (Исаа 1:1, Иеремиа 1:1, Езекиел 1:3, Хосеа 1:1, Иоел 1:1). Ургийн бичгээс нь ийм уртыг бичсэн нь уг эш үзүүлэгчийг сурвалжит гаралтайг харуулж байгаа бөгөөд эш үзүүлэгчийн хуланц өвөө нь Хезекия гэдэг сайн хаан байжээ.

Тус ном нь эш үзүүлэгч Зефениагийн нэрээр нэрлэгдсэн бөгөөд энэ нэр нь “ЭЗЭН нуудаг” гэсэн утгатай (2:3).

Бичигдсэн огноо: МЭӨ 630-625 он. Оршил хэсэгт өгүүлснээр бол (1:10) Зефения нь Иосиагийн хаанчлалын үед (МЭӨ 640-609) эш үзүүлж байжээ. МЭӨ 612 оны Ниневегийн уналт болон МЭӨ 622-621 оны Иосиагийн шинэчлэлтийн өмнөхөн тэрээр эш үзүүлсэн. Энэ нь Иосиагийн шинэчлэлтээр бараг бүрмөсөн устсан (1:4-6) хуурамч шүтээн шүтэх явдал Иудад байсаар байна гэж Зефения тус номд бичсэн байдгаас тодорхой харагдаж байна. Энэ бүхэн нь уг номыг МЭӨ 630-625 оны хооронд бичигдсэн гэдгийг харуулдаг.

Сэдэв болон зорилго: Амон болон Манассегийн хаанчлалын бузар муу нөлөөнөөс болж Иудагийн ард түмний ёс суртахуун, сүнсний амьдрал мохож байна гэдгийг эш үзүүлэгч хэлсэн (3:1-7). Тиймээс уг ном нь Дэд хууль 28-р бүлэгт хэлсэн дуулгаваргүй байдлын үр дагавар болох хараалын сануулга болгож, Эзэний өдөр буюу шүүлтийн өдөр айсийг гэсэн үндэсэн сэдвийг хөнддөг. ЭЗЭНий ариун байдлын үүднээс харвал, Тэр Өөрийнхөө өмнө тайллагнуулахаар дэлхийн үндэстнүүдийг дуудаж, гэм нүглийн эсрэг Өөрийн ариун байдлыг өмгөөлж, илэрхийлэх ёстой. Гэвч Бурхан бол хайр энэрэл, ерөөлийн Бурхан учраас гэмшилд дуудсан дуудлага болон ерөөлийн амлалтыг бас онцлон дурдсан байдаг. Эдгээрээс үүдэн, Зефения номыг тодорхой гурван хэсэгт хувааж болно: гэм нүглийн төлөөх шүүлт, гэмшлийн дуудлага, ирээдүйн золилт буюу ерөөлийн амлалт.

Гол хүмүүс: Зефения, Иосиа

Зефения ном дахь Христ: Хэдийгээр энэ номд онцгойлон дурдаагүй боловч, Мессиаг Израиль үндэстэн доторх зөвт Нэгэн (3:5), мөн тэдний Хаан (3:15) гэж танилцуулсан байдаг.

Хувийн Судлал: Агуулга

1. Оршил (1:1)

2. ЭЗЭНий өдрийн шүүлт (1:2-3:8)

- А. Бүх дэлхий дээр буух шүүлт (1:2-3)
- Б. Иудагийн эсрэг шүүлт (1:4-2:3)
 - 1) Шүүлтийн учир шалтгаан (1:4-13)
 - 2) Шүүлтийн дурслэл (1:14-18)

- 3) Үндэстэнг уриалсан дуудлага: Гэмшиж, Бурханыг хай (2:1-3)
 - Б. Эргэн тойрны үндэстнүүдийн эсрэг шүүлт (2:4-15)
 - 1) Филистчүүдийн эсрэг (2:4-7)
 - 2) Аммончууд болон Моабчуудын эсрэг (2:8-11)
 - 3) Етиопчуудын эсрэг (2:12)
 - 4) Ассиричуудын эсрэг (2:13-15)
 - Г. Иерусалимын эсрэг шүүлт (3:1-7)
 - 1) Эш үзүүлэгчийн ялын төлөвлөгөө (3:1-5)
 - 2) Эзэний шүүлт (3:6-7)
 - Д. Бүх дэлхийн эсрэг шүүлт (3:8)
- 3. ЭЗЭНий өдрийн сэргэлт (3:9-20)**
- А. Үндэстнүүдийн сэргэлт (3:9-10)
 - Б. Израилийн сэргэлт (3:11-20)

Хагтаи (Зоригжуулалт)

Танилцуулга: Хагтаи нь Вавилоны цөллөгийн дараа ном бичсэн гурван эш үзүүлэгчийн нэг нь юм. Хагтаи, Зехария, Малахи нар бүгдээрээ Израильд буцан ирсэн иудейчүүдэд зориулан Бурханы үгийг хэлж байв. Тэд эх орондоо буцан ирсэн үлдэгсэд буюу одоо улс үндэстнээ болон Сүмээ дахин сэргээж, барьж байгуулах гэж хичээж буй бүлэг хүмүүсийн сүнслэг болон ёс суртахууны амьдралыг урамшуулан зоригжуулах зорилготой байв.

Хагтаи болон Зехария нар Сүмийг дахин барихтай холбоотой сүнслэг хэрэгцээнд нь голлон анхаарч байсан бол, харин Малахи үндэстнийг өөрийг нь сэргээн байгуулахтай холбоотой ёс суртахууны болон нийгмийн хэрэгцээ шаардлагад юун түрүүнд анхаарч байжээ.

Номын нэр болон зохиогч: Хагтаин нэр нь “баяр ёслол” эсвэл “баяр наадам” гэсэн утгатай үг бөгөөд зарим хүмүүс түүнийг гол баярын өдрүүдийн нэгэнд нь төрсөн гэсэн санааг дэвшүүлдэг боловч үүнийг дэмжсэн зүйл эх бичвэрт байдагтүй. Хагтаин тухай зөвхөн энэ номоос (9 удаа дурдагдсан байдаг) болон Езра 5:1-2, 6:14-д дурдсанаас мэдэж болно. Түүний тухай мэдээлэл маш бага. Тэр өөрийгөө “эш үзүүлэгч Хагтаи” (1:1) гэж танилцуулсан, гэхдээ өөрийн эцэг эх болон уг гарлынхаа тухай юу ч дурдаагүй. Тэрээр эш үзүүлэгч Зехария, захирагч Зеруббабел нартай нэг цаг үед амьдарч байсан.

Бичигдсэн эш үзүүлэгчдийн номд түгээмэл байдаг шиг энэ ном ч гэсэн эш үзүүлэгчийн өөрийнх нь нэрээр нэрлэгдсэн.

Бичигдсэн огноо: МЭӨ 520 он. Персийн хаан Корешийн улс төрийн бодлогын дагуу тавин мянга орчим иудейчүүдийг Иерусалим руу буцаж явахыг зөвшөөрсөн. Тэдний дунд Зеруббабел (Езра 1:2-4 уд.харыц. Исаиа 44:28), тэргүүн тахилч Иошуа, эш үзүүлэгч Хагтаи, Зехария нар байсан. МЭӨ 538 онд иудейчүүдийг эх нутагтаяа буцан ирж, Сүмээ дахин сэргээн босгох зөвшөөрлийг албан ёсоор өгсөн.

Тун удалгүй шатаалт тахилд зориулсан тахилын ширээг дахин босгож, Левичүүд тахил өргөж эхэлсэн (Езра 3:1-6) бөгөөд буцаж ирснийхээ дараа хоёр дахь жилдээ Сүмийн суурийг тавьсан (Езра 3:8-13, 5:16). Гэхдээ самаричуудын өдөөн хатгалт, мөн персчүүдийн хавчлага дарамт зэргээс болж Сүмийн сэргээн босголтын ажил зогсоход хүрсэн. Үүнээс хойш сүнсний хувьд хайхрамжгүй байдалд орж, Персийн хаан Дариус Хистаспесын (МЭӨ 521-486) хаанчлалыг хүртэл арван зургаан орчим жилийн турш Сүмийн барилгын ажил зогссон. Дариус хааны хоёр дахь жилд (МЭӨ 520) Сүмийг дахин сэргээн босгох ажилд иудейчүүдийг уриалан дуудаж, зоригжуулахын тулд Бурхан эш үзүүлэгч Хагтаиг босгосон (Езра 5:1-2, Хагтаи 1:1).

Хаггаи 1:1-д дурдсанаар, Дариус хааны хоёр дахь жилийн Елул сарын (наймдугаар сараас есдүгээр сар) нэгэнд түүний эхний мэдээ өгөгдсөн. Энэ нь МЭӨ 520 он байсан.

Номын сэдэв болон зорилго: Хаггаи ном нь Хуучин гэрээний хоёр дахь богино ном бөгөөд хамгийн богинохон нь Обадиа юм. Хаггаи номын бичиглэлийн хэв маяг нь шулуухан агаад энгийн. Номын агуулга нь богинохон хугацаанд үйлчилж байсан чухал бус мэт харагдахуйц нэгэн эш үзүүлэгчийн дамжуулсан дөрвөн мэдээний тэмдэглэл юм.

Хэдийгээр Хаггаи ном нь Хуучин гэрээний хоёр дахь богинохон ном боловч Сүмийг дахин барихад зорижкуулж байсан Хагтаин дөрвөн мэдээний хүч чадал, гүйцэтгэсэн үүргийг бид дутуу үнэлж болохгүй. Ийм богино бичвэр атлаа чухал сүнслэг ойлголтыг ихээр оруулж чадсан эш үзүүлэгчид цөөхөн байдаг. Хагтаин мэдээний нэгэн өвөрмөц онцлог бол түүний дамжуулж буй эдгээр мэдээ нь Бурханаас ирсэн гэдгийг маш хүчтэй сануулсан явдал юм. Тэрээр өөрийнхөө дамжуулж буй мэдээний тэнгэрлэг эрх мэдлийн талаар 25 удаа өгүүлсэн байдаг. Мөн тэр мэдээгээ танилцуулахдаа байнга “**Түмэн цэргийн ЭЗЭН ингэж айлдаж байна**” гэдэг бөгөөд төгсгөл нь ч мөн үүнтэй төстэй байдаг (“гэж Эзэн тунхаглаж байна”).

Цөллөгөөс буцаж ирсэн, Израилийн үлдэгсдийг Иерусалимд Сүмийг дахин барихад урамшуулан зорижкуулахын тулд Хаггаи ном бичигдсэн. Энэ явцад тэрээр дараах зүйлсийг заасан: (1) Өөрийг нь бүхний тэргүүнд тавьж буй Өөрийн хүмүүсийг Бурхан ивээдэг, (2) бид Эзэний үйлчлэлээс залхахгүй байх ёстой, (3) Бурханы маргаашийн амлалт нь бидний өнөөдрийн итгэл найдварын үндэс болдог.

Гол хүмүүс: Хаггаи, Дариус, Зеруббабел, Тэргүүн тахилч Иошуа

Хаггаи ном дахь Христ: Энд Мессиаг Сүмийн сүр жавхланг Сэргээн босгогч (2:7-9), дэлхийн хаанчлалыг унагаах Нэгэн (2:22) хэмээн дурсэлсэн байдаг.

Хувийн Судлал: Агуулга

1. **Нэг дэх мэдээ: Сүмийг дахин барихад уриалсан дуудлага (1:1-15)**
 - A. Танилцуулга (1:1)
 - B. Нэг дэх буруушаалт (1:2-6)
 - C. Засаж залруулах нь (1:7-8)
 - D. Хоёр дахь буруушаалт (1:9-11)
 - E. Эш үзүүлэгчийн мэдээнд хариулсан хариу (1:12-15)
2. **Хоёр дахь мэдээ: Бурханы амлалт дотор урамшин зорижжих дуудлага (2:1-9)**
 - A. Танилцуулга (2:1-2)
 - B. Ирээдүйн сүр жавхлангийн амлалтууд (2:3-9)
3. **Гурав дахь мэдээ: Амьдралаа цэвэр байлгах дуудлага (2:10-19)**
 - A. Танилцуулга (2:10)
 - B. Асуудал: Үлдэгсдийн дуулгаваргүй байдал (2:11-14)
 - C. Шийдэл: Үлдэгсдийн дуулгавартай байдал (2:15-19)
4. **Дөрөв дэх мэдээ: Ирээдүйд итгэлтэй байх дуудлага (2:20-23)**
 - A. Танилцуулга (2:20-21a)
 - B. Харь үндэстний хаанчлалын ирээдүйн сүйрлийн амлалт (2:21б-22)
 - C. Давидын хаанчлалын сэргэлтийн амлалт (2:23)

Зехария (ЭЗЭНий хардалт)

Номын нэр болон зохиогч: Эш үзүүлэгч Зехария нь Берехиагийн хүү, Иddогийн ач хүү байсан (1:1). Тэрээр Хаггтай нэг цаг үед амьдарч байсан (Езра 6:14).

Зехариагийн нэр нь “ЭЗЭН дурсан санадаг” эсвэл “ЭЗЭН дурсан санаж байдаг” гэсэн утгатай. Энэ нь бүх л номын турш давтагддаг сэдэв юм.

Бичигдсэн огноо: МЭӨ 520-518. Номын эхний ишлэл дээр Зехариаг Берехиагийн хүү, Иddогийн ач хүү хэмээн танилцуулж байгаа нь Нехемиа 12:4-д гардаг тахилч Иddог хэлж байгаа бөгөөд тэрээр Зеруббабелтай нэг цаг үед амьдарч байжээ. Зехария 2:4-д эш үзүүлэгчийг залуухан байсан гэж хэлсэн байдаг. МЭӨ 520 онд сэргээн босголтын ажлыг Хаггтай хамтарч хийх үедээ тэрээр нэлээн залуухан байсан бололтой. МЭӨ 518 онд буюу хоёр жилийн дараа түүний он сар нь дурдагсан эш үзүүлэгчийн сүүлчийнх нь өгөгдсөн байдаг (7:1-14). 9-14 бүлэгт гарч буй зүйлс нь хэдэн арван жилийн дараа буюу МЭӨ 480 оны үед болох зүйлсийн тухай өгүүлсэн. Энэ нь Гректэй холбоотой нэмэлт мэдээллээс харагддаг (9:13).

Зехариагийн хувийн ажил хэргийн талаар Матай 23:35-д хэлснээс өөр мэдээлэл байдаггүй. Энд түүнийг Сүмийн газар нутаг дээр алагдсан гэсэн санааг хэлсэн байдаг. Тахилч Иехоиадагийн хүү, өөр нэг Зехария нь бас үүнтэй ойролцоо цаг үед цаазлуулсан байна (Шастирын дэд 24:20-21).⁴⁴

Номын сэдэв болон зорилго: Зехария ном нь Сүмийг дахин барих ажлыг бүрэн дуусгахад нь Иудейн буцаж ирсэн үлдэгсдийг зоригжуулахын тулд бичигдсэн. Мессиагийн ирэлтэд бэлтгэж, дэлхий дээрх Израилийн сүнслэг өв залгамжлалыг дахин сэргээх ажлаа Бурхан хийж байна гэдгийг эш үзүүлэгч бас харуулсан байна. Онолын хувьд, Сүмийг барих нь Израилийн сүнслэг сэргэлтийг илтгэн харуулж буй хэрэг гэж Зехария үзэж байсан бөгөөд Бурханы хангамж хамгаалалтаар дамжуулан Бурханы ард түмэн өөрсдийн газар нутагт буцаж ирсэн гэдгийг харуулж, тус үндэстний ирээдүйн сүнслэг сэргэлт дэх гол давуу тал нь Мессия юм гэдгийн онцлон хэлсэн байдаг.

Гол хүмүүс: Зехария, Тэргүүн тахилч Иошуа

Зехария ном дахь Христ: Хуучин гэрээний номуудаас Зехария ном шиг Мессиагийн тухай илүү ихээр өгүүлсэн ном бараг байхгүй. Энэхүү ном нь Мессия буюу Христийг Зарц ба Хаан, Хүн ба Бурхан, Эзэний тэнгэр элч (3:1), зөв шударгын Мөчир (3:8), долоон нүдтэй Чулуу (3:9), цовдлогдсон Аврагч буюу жадлагдсан Нэгэн (12:10), ирж буй даруу Хаан (9:9-10), цохигдсон Хоньчин (13:7), ирж буй Шүүгч болон зөв шударгын Хаан (14) хэмээн хэлсэн байдаг.

Хувийн Судлал: Агуулга

1. Гэмшилийн дуудлага (1:1-6)
2. Зехариагийн үзсэн найман үзэгдэл (1:7-6:8)
 - A. Морьд ба Морьтнууд (1:7-17)
 - B. Дөрвөн эвэр ба дөрвөн дархан (1:18-21)
 - C. Хэмжүүр барьсан хүн (2:1-13)
 - D. Дэнлүүний алтан суурь (4:1-14)
 - E. Нисэж буй хуйлмал ном (5:1-4)
 - F. Сагсан дахь эмэгтэй (5:5-11)
 - G. Дөрвөн тэрэг (6:1-8)
3. Өргөмжлөгдсон Иошуа (6:9-15)

4. Мацаг барилтын талаарх асуултууд (7:1–8:23)

7:1-7	8:9-13	8:20-23
7:8-14	8:14-17	
8:1-8	8:18-19	

5. Ирээдүйн талаарх хоёр зөгнөл (9:1–14:21)

А. Мессиагаас татгалзах нь (9:1–11:17)

9:1-10	10:1-12
9:11-17	11:1-17

Б. Мессиаг хаан ширээнд өргөмжлөх нь (12:1–14:21)

12:1-5	13:1-6	14:1-8
12:6-14	13:7-9	14:9-21

Малахи

(Гэмшил ба буцан ирэлт)

Номын нэр болон зохиогч: Малахи 1:1-д л зөвхөн энэхүү эш үзүүллэгийн номын зохиогчийг Малахи гэж дурдсан байдаг. Түүний нэр нь “Миний элч” гэсэн утгатай. Энэ нь тус номын баптиисм хүртээгч Иоханы тухай эш үзүүллэг (Матай 11:10), “Гэрээний элч”-ийн (3:1-тай харьцуул) ирэлтийг урьдчилан хэлсэн зэрэгтэй тохирдог байна.

Бичигдсэн огноо: МЭӨ 450-400 он. Малахи номын бичигдсэн он сарын талаар Глейсон Арчер хэлэхдээ:

Номон дахь дотоод баримт нотолгоог харвал, түүний эш үзүүллэгүүд нь тавдугаар зууны хоёрдугаар хагаст буюу ойролцоогоор МЭӨ 435 оны үед өгөгдсөн байж болох юм гэдэг нь тодорхой харагддаг. Дараах шинж тэмдгүүдээс үүдэн бид энэхүү дүгнэлтэд хүрсэн юм: (1) Сүм аль хэдийнээ баригдаж дууссан бөгөөд Мосегийн тахилыг дахин сэргээсэн байсан (1:7, 10; 3:1); (2) Тухайн цаг үед Персийн захирагч захирч байсан; тиймээс энэ нь Нехемиагийн удирдаж байсан үе (МЭӨ 445 ба 433 онд) биш гэсэн үг юм; (3) Малахийн зэмлэн буруушааж байсан гэм нүгэл нь Нехемиагийн үйлчлэлийнхээ хоёр дахь үеийн турш засаж залруулахыг хүсэж байсан гэм нүглүүдтэй адилхан байсан. Тухайлбал, (а) Тахилчийн салан задгай байдал (1:6, Нехемиа 13:4-9), (б) аравны нэгийн өргөлийг үл тоомсорлож, Левичүүдийг ядууруулж байсан (3:7-12-тай харьцуул, Нехемиа 13:10-13), (в) харь эмэгтэйчүүдтэй их гэрлэж байсан (2:10-16-тай харьцуул, Нехемиа 13:23-28) зэрэг юм. Нехемиаг буцаж ирэхийн өмнөх жилүүдэд эдгээр зүй бус үйлсийн эсрэг Малахи аль хэдийнээ тэмцэж байсан гэж үзэх нь зүйд нийцэх бөгөөд үүнээс бид энэ үйл явдал нь ойролцоогоор МЭӨ 435 оны үед болсон гэж үзэж болох юм.⁴⁵

Сэдэв болон зорилго: Нехемиагийн удирдлага дор сэргэлтийн үе болж байсан хэдий ч (Нехемиа 10:28-39) тахилчид болон ард түмэн Бурхантай хамтдаа алхахдаа улам бүр хөрч, Хуулийг зөвхөн гаднах байдлаараа, хэлбэр төдий мөрдөх болжээ. Хэдийгээр ард түмэн Малахийн зэмлэн буруушаасан гэм нүглүүдийг (тахилчдын салан задгай байдал, арван нэгийн өргөлийг үл тоомсорлох, харь үндэстний эмэгтэйчүүдтэй гэрлэх) үйлдэж байсан атлаа Бурхан яагаад бидэнд сэтгэл ханамжгүй байна вэ хэмээн эргэлзэн гайхаж байсан. Малахи тахилчид болон ард түмний асуултад хариулж, тэдний гэм нүглийг илчлэн зэмлэж, тэдний ухарч няцсан, ядуу дорой хандлагуудын талаар бичсэн. Тэрээр мөн Мессиагийн замыг цэвэрлэх Эзэний элч ирэх тухай урам зоригийн үгээр номоо төгсгөсөн байдаг.

Малахи Израилийн ард түмнийг Эзэнд үнэн мөргөл өргөхгүй байгааг зэмлэж, тэднийг гэмшилд дуудсан (1:6, 3:7). Глейсон Арчер номын сэдвийг дараах маягаар дүгнэн хэлсэн байдаг:

Малахи номын сэдэв нь үнэн зүрх сэтгэлээр Бурхан руу хандах, Эзэний нүдэнд хамгийн чухал нь болох ариун амьдралын хэв маягтай байх зэрэг юм. Ингэвэл, Түүний таалал нь ард түмний эдийн засгийн хангалиун байдал, үр тариан дээр илрэн харагдах болно.

Израильчууд эдгээх үйлчлэл болон шүүлтээрээ дамжуулан ард түмнийг удирдаж, тэдний бүхий л итгэл найдвартыг биелүүлэх Мессиагийн ирэхийг хүлээж, ариун үндэстэн байх дээд дуудлагадаа зохистой амьдрах ёстой юм.⁴⁶

Гол хүмүүс: Малахи

Малахи ном дахь Христ: Вилкинсон болон Боя нарын Малахи ном дахь Мессиагийн талаар дараах гайхалтай сайн дүгнэлтийг хийсэн байдаг:

Малахи ном бол дараагийн эш үзүүлэгч, баптисм хүртээгч Иоханы “*Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтуун!*” (Иохан 1:29) гэсэн үгсээр дуусгавар болсон дөрвөн зуун жилийн эш үзүүлэгийн чимээгүй үеийн оршил юм. Малахи Эзэний өмнө замыг нь бэлтгэх элч ирэх болно гэдгийг зөгнөн хэлсэн (3:1-тай харьцуул, Исаиа 40:30). Хожим нь баптисм хүртээгч Иохан энэ эш үзүүлэгийг биелүүлсэн, харин дараагийн хэдэн ишлэлд тэрээр огцом үсрэлт хийж (3:2-5), Христийн хоёр дахь ирэлтийн тухай өгүүлсэн байдаг.⁴⁷

Хувийн Судлал: Агуулга

1. **Израилийн онцгой эрх бүхий газар (1:1-5)**
 - A. Бурханы хайрыг тунхагласан нь (1:1-2a)
 - B. Бурханы хайранд эргэлzsэн нь (1:2б)
 - C. Бурханы хайр илэрхийлэгдсэн нь (1:3-5)
2. **Израилийн ялзрал (1:6–3:15)**
 - A. Луйвардалт (1:6-14)
 - B. Итгэмжгүй байдал (2:1-9)
 - C. Сүнсний хувьд завхарсан гэрлэлтүүд (2:10-12)
 - D. Гэр бүл салалт (2:13-16)
 - E. Жигшмээр нүгэл (2:17)
 - F. Элчийн ирэлт (3:1-6)
 - G. Хулгай дээрэм (3:7-12)
 - H. Бардам зан (3:13-15)
3. **Израилийн ард түмэнд амласан амлалт (3:16–4:6)**
 - A. Дурсгалын номын тухай амлалт (3:16-18)
 - B. Христ ирэх тухай амлалт (4:1-3)
 - C. Елиа ирэх тухай амлалт (4:4-6)

Гуравдугаар Бүлэг

Шинэ Гэрээний Тойм

Танилцуулга

Шинэ гэрээ бол түүхэн үйл явдлуудын тэмдэглэл юм. Өөрөөр хэлбэл, бидний Эзэн Есүс Христийн авралын тухай “сайн мэдээ”-тэй холбоотой үйл явдлуудыг Шинэ гэрээнд тэмдэглэсэн байдаг. Эдгээр нь Түүний амьдрал, үхэл, амилалт болон дээш өргөгдөлт, мөн Есүсийн сонгож, илгээсэн элч нар энэ дэлхий дээрх Түүний ажил үйлчлэлийг үргэлжлүүлсэн тухай үйл явдлууд юм. Түүнчлэн энэ нь Хуучин гэрээний үед урт удаан хугацааны туршид хүлээгдэж байсан үйл явдлуудын биелэл юм. Цаашилбал, Шинэ гэрээ нь Ариун Сүнсний удирдамжаар бичигдсэнээрээ бусад түүхээс ялгаатай ариун дагшин түүх юм. Өөрөөр хэлбэл, Шинэ гэрээ нь Хуучин гэрээний нэгэн адил хүмүүний алдаа эндэгдлээс хамгаалагдсан бөгөөд Эзэн Өөрийн биеэр дахин ирэх өдрийг хүртэл өнөөгийн чуулган болон хүн төрөлхтний түүхийн бүхий л хугацаанд бурханлаг эрх мэдэлтэй юм.

“Шинэ гэрээ” хэмээх нэр томъёоны гарал үүсэл ба утга санаа: Библи нь Хуучин ба Шинэ гэрээ гэсэн хоёр хэсгээс бүрддэгийг бид мэднэ. Харин энэ нь чухам ямар учиртай юм бол? “Гэрээ” гэсэн грек үг нь “хүсэл, гэрээ хэлцэл буюу хэлэлцээр” гэсэн утгыг илэрхийлдэг. Тэгэхлээр, Хуучин гэрээ нь юуны өмнө, Синаи ууланд Мосед өгөгдсөн гэрээн дээр үндэслэн Бурханаас израильчуутдай тогтоосон ажил хэргийн харилцааны талаарх тэмдэглэл юм. Нөгөө талаас, Шинэ гэрээ нь (Иеремиа 31:31-д урьдчилан хэлэгдэж, 1 Коринт 11:25-д Эзэн Есүсийн байгуулсан) Христэд итгэлээр дамжуулан авралыг хүлээж авах бүх хүмүүстэй Бурханы байгуулсан шинэ хэлэлцээр буюу гэрээ юм.

Хуучин гэрээнд Бурханы ариун байдлыг Хуулийн зөвт хэм хэмжээгээр илчлэн харуулж, Аврагч ирнэ хэмээн амласан байдаг. Харин Шинэ гэрээнд Бурханы ариун байдлыг хүн төрөлхтөн уруу ирсэн, Түүний зөвт Хүүгээр нотлон харуулсан. Тэгэхлээр, Шинэ гэрээ нь энэхүү шинэ гэрээ хэлцлийн агуулгыг илчилсэн бичээсүүдийг өөртөө агуулдаг аж.

Шинэ гэрээний мэдээ нь (1) нүглийн уччалын төлөө Өөрийгөө өгсөн Хүн (Матай 26:28) болон (2) Түүний авралыг хүлээн авсан хүмүүс (чуулган) дээр голлон анхаардаг. Тиймээс Шинэ гэрээний гол сэдэв нь аврал юм.⁴⁸

Эндээс харахад, Хуучин ба Шинэ гэрээ гэсэн нэрс нь эхэндээ Бурханаас хүнтэй байгуулсан хоёр удаагийн гэрээний харилцаатай холбоотой хэрэглэгдэж байснаа, дараа нь энэ хоёр харилцааны тухай өгүүлсэн номуудтай холбоотой хэрэглэгдэх болжээ. “Хуучин ба Шинэ гэрээ нь Бурхан биднийг Өөртөө хүлээн авсан үед байгуулагдсан бурханлаг гэрээ юм.”⁴⁹

Бурхан Шинэ гэрээнд бэлтгэсэн нь: Шинэ гэрээний үед Ром нь дэлхийн бараг ихэнх улсад ноёрхлоо тогтоосон, хүчирхэг гүрэн байлаа. Харин Палестинд, Иудейн Бетлемхем хэмээх нэгэн жижигхэн хотод дэлхийг өөрчлөх Нэгэн төрсөн юм. Элч Паул энэ Хүний тухай, “Харин цаг нь болоход **Бурхан эмэгтэй хүнээс Хуулийн** (ө.х., Хуучин гэрээ) **дор төрөх Өөрийн Хүүгээ илгээсэн юм**” хэмээн бичсэн байдаг. Бурхан энэ дэлхийг Мессиагийн ирэлтэд онцгой, гайхамшигтай арга замуудаар бэлтгэсэн юм. Ийнхүү бэлтгэхэд хэд хэдэн хүчин зүйл хувь нэмэр болжээ.

Иудей үндэстнээр дамжуулан бэлтгэсэн нь: Христийн ирэлтэд зориулсан бэлтгэл нь Хуучин гэрээний түүх юм. Бурхан иудейчүүдийг тахилчдын хаанчлал болох нандин эзэмшил, ариун үндэстэн болгохоор бүх үндэстнүүдийн дундаас сонгон авсан (Египетээс гарсан нь 1:5-6). Энэ утгаараа, эзгүүд болох Абрахам, Исаак, Иаков нарт амлалтууд өгөгдсөнөөс эхлээд (Эхлэл 12:1-3; Ром 9:4) иудейчүүд Бурханы Үгийг сахин хамгаалагчид (Хуучин гэрээ [Ром 3:2]), Аврагчийн үр удмыг залгамжлагчид болох учиртай байлаа (Эхлэл 12:3; Галат 3:8; Ром 9:5). Тэгэхлээр, Хуучин гэрээ нь Христийн тухай мэдээллээр дүүрэн агаад алдаршуулагдсан, зовлонт Аврагч ирэх тухай энд урьдчилан хэлсэн байдаг. Түүнчлэн, Шинэ гэрээнд нэлээд олон эш үзүүллэгээс гадна Мессиагийн удам угсаа, төрсөн газар болон төрөх үеийнх нь нөхцөл байдал, Түүний амьдрал, үхэл, тэр ч байтугай амилалтын тухай маш дэлгэрэнгүй өгүүлсэн хэсгүүд олон байдаг.

Бурхан Израилийг Өөрт нь дуулгаваргүй хандаж, зүрх сэтгэлээ хатууруулсных нь төлөө харийн боолчлолд тушаасан ч гэсэн Мессиагийн ирэлтэд бэлтгэх тухай амлалт ёсоороо далан жилийн дараа тэднээс үлдэгсдийг эх нутагт нь буцаан авчирсан. Хуучин гэрээний сүүлийн ном бичигдсэнээс хойш дөрвөн зуун жил өнгөрсөн байлаа. Тухайн үеийн шашин шүтлэгт фарисайн хоёр нүүрт, хэт ёс жаяг дагасан уур амьсгал давамгайлж байсан боловч Мессия ирэх тухай яриа олны дунд тархаж, үлдэгсэд Түүнийг хүлээсээр байсан юм.

Грек хэлээр дамжуулан бэлтгэсэн нь: Христ бүх үндэстэнд Сайн мэдээг тунхаглуулахаар шавь нараа өртөнцийн хязгаар хүртэл илгээх үед (Матай 28:19-20) “дэлхий нийт нэг хэл”-тэй байсан нь туйлын ач холбогдолтой зүйл байлаа. Христийг мэндлэхээс 300 гаруй жилийн өмнө Македонийн хаан Филиппийн хүү Их Александр дэлхийг хөндлөн гулд самнаж, үндэстнүүдийг толгой дараалан булаан эзэлсний дүнд грек хэл ийнхүү дэлхий нийтийн хэл болсон байв. Александр хааны мөрөөдөл нь бүх дэлхийг нэг хэлтэй болгох явдал байжээ. Тэрээр ялалт байгуулсан газар бүрдээ грек хэлийг олон нийтийн хэл, Грекийн соёлыг оюун санаа, аж амьдралын үлгэр дуурайл болгон тогтоосон байдаг. Хэдийгээр Александр хааны эзэнт гүрэн урт наслагүй ч грек хэл дэлхий нийтийн гол хэл хэвээр үлджээ.

Үүнээс харахад, Бурхан хүмүүсийн хамгийн сайн мэддэг, хамгийн ойлгомжтой хэлийг ашиглан Христийн ирэлтэд бэлтгэж байжээ. Аврагчийн тухай мэдээг тунхаглахад тухайн үеийн хамгийн нийтлэг хэл болох грек хэлийг ашигласан байдаг. Ийнхүү Шинэ гэрээ нь тухайн үеийн хамгийн нийтлэг хэл болох Койн грек хэл дээр бичигджээ. Шинэ гэрээг бичсэн хүмүүсээс харь үндэстэн Лукаас бусад нь иудей хүн байсан хэдий ч Шинэ гэрээ еврей, арамей хэлний алинаар нь ч биш, харин грек хэлээр бичигджээ. Тухайн үед Койн грек хэл бараг бүх үндэстний хоёр дахь хэл болсон байжээ.

Ромчуудаар дамжуулан бэлтгэсэн нь: Аврагчийг ирэхэд дэлхийг бэлтгэх ажлаа Бурхан дуусаагүй, үргэлжлүүлсээр байлаа. Христийг Палестинд төрөх үед дэлхийг Ромын эзэнт гүрэн захирч байлаа. Ромын эзэнт гүрэн эрхшээлдээ буй улс үндэстнүүдэд өөрийн хууль дүрмийг тулган хэрэгжүүлдэг байв. Ромын түүхэнд болсон хамгийн урт, хамгийн их цус урсгасан дайн Август Цезарь хааны үед дууссан гэдэг. Үүний дүнд 100 жил үргэлжилсэн иргэний дайн дуусаж, Ром хил хязгаараа үлэмж хэмжээгээр тэлжээ. Түүнчлэн Ром улс зам харилцааг хөгжүүлж, түүгээр цэрэг арми нь байнгын эргүүл хийх болсон нь хүмүүст Ромын эзэнт гүрний нутаг дэвсгэр дээгүүр айх аюулгүй, амар тайван аялах боломжийг бүрдүүлж өгчээ. Энэ эзэнт гүрний захирагч цорын ганц хаан гэдгийг илэрхийлсэн хааны титэм, нарийн нэхсэн маалингтан даавуун хувцас өмссөн анхны ром хүн бол Август хаан байлаа. Тэрээр ухаалгаас гадна ард түмнээ ихэд анхааран халамжилдаг хаан байв. Август Ромд амар тайван, хөгжил цэцэглэлтийг авчирснаар Ром хүмүүсийн амьдрах, аялах дуртай газар болжээ. Энэ үеийг түүхэнд “Пакс Ром” буюу Ромын амар тайван (МЭӨ 27–МЭ 180) гэж нэрлэдэг. Августын хийсэн энэ бүх зүйлийг хараад хүмүүс түүнийг төрөх үед нэгэн бурхан төрсөн гэж ярих болжээ. Үнэндээ яг ийм нөхцөл байдлын дунд хувь хүнээс авахуулаад дэлхийн амар тайвны эх сурвалж болсон Нэгэн төрсөн юм. Түүнээс ирэх амар тайван нь хүний өгдөг амар тайван шиг түр зуурынх биш байлаа. Есүс нь бурхан гэдэг нэртэй хүн биш, харин жинхэнэ Бурхан байсан юм. Тухайн үед Ромын эзэнт гүрний хууль дүрэм үйлчилж байсан нь Есүсийн амьдрал, үйлчлэлд энэ дэлхийг бэлтгэхэд тустай байсан бөгөөд тэгснээр Сайн мэдээ тунхаглагдах боломжтой болсон юм.

Шинэ гэрээний үеийн шашины өртөнц: Шинэ гэрээг судлахынхаа өмнө Аврагчийг ирэх үеийн болон хожим чуулганыг дэлхий дахин уруу илгээх үеийн шашин шүтлэгийн талаар өрөнхий ойлголтыг олж авах нь тустай байх болно. Мерил С. Теннигийн бичсэн дараах зүйлийг уншихдаа та дэлхий дахины өнөөгийн байдалтай ямар адилхан байгааг анзаараарай:

Өөр хоорондоо асар их ялгаатай хэрнээ бүгдээрээ хэзээ ч хүрэх боломжгүй ямар нэг бурхан юмуу бурхад хүрэх гэж тэмцдэг нийтлэг нэг шинжтэй, бие биетэйгээ өрсөлдөгч олон шашин оршин тогтнож байсан өртөнцөд христэч чуулган төрөн гарсан юм. Бурхан сайн дураараа Өөрийгөө эцгүүд болох Моше болон эш үзүүлэгч нарт илчилсэн гэж заадаг иудеизмээс өөр бурханлаг илчлэлт ба гэм нүгэл, авралын талаарх жинхэнэ үнэн ойлголтыг итгэлтэйгээр зааж чадах шашин (итгэл үнэмшил) байсангүй. Ёс зүйн өнөөгийн хэм хэмжээнд гэм нүглээс гэтэлгэх хэрэгсэл ч, авралыг соёрхох хүч ч байхгүй.

Иудеизмд ч гэсэн илчлэгдсэн үнэн нь уламжлалууд болон мэдлэггүй хүмүүст ойлгомжгүй байсан юм. Харийн шашинтууд болон Бурханы Үгэнд итгэдэггүй, түүний талаар мэдлэггүй бүх шашнууд нь хүмүүст өгөгдсөн Бурханы илчлэлтийг үргэлж гажуудуулан гүйвуулдаг. Тэдгээрт үнэний үндсэн элементүүд хадгалагдаж байдаг хэдий ч бүгдийг нь худал зүйл болгон мушгин гүйвуулдаг. Тэднийхээр бол Бурханы бүрэн эрх нь хувь тавилан, нигүүлсэл нь хүлцэнгүй байдал, зөвт байдал нь дур зоргоороо тогтоосон дүрэм журамд захирагдах явдал, мөргөл нь хоосон ёслол, залбирал нь амин хувшинаас гүйлт, ер бусын байдлаар ирж буй доройтол нь мухар сүсэг болж хувирдаг. Бурханы гэрлийг домог болон худал хуурмагийн үүл халхалдаг. Үүнээс болж үүссэн итгэл үнэмшил, үнэ цэнийн талаарх ойлгомжгүй байдал нь хүмүүсийг эцэс төгсгөлгүй эргэлзээн дунд төөрч будлихад хүргэдэг. Зарим хүмүүсийн хувьд амьдралынх нь гол философи өөрийнхөө ашиг сонирхлыг эрэлхийлэх явдал (хүссэнээ хийх) болдог. Учир нь, хэрэв тодорхой байдал гэж байдаггүй юм бол хүмүүсийн зан хандлагыг удирдан чиглүүлэх байнгын зарчмууд гэж байхгүй, нэгэнт ийм зарчмууд байхгүй учраас хүн тухайн цаг мөчид хожиж болох зүйлийг олж авахын төлөө амьдрах ёстой гэж тэд үздэг. Хуучин бурхад нь хүч чадал, эрх мэдлээ алдаж, шинэ бурхад гарч ирэхгүй байсан учир үл итгэх байдал зонхилох болов. Эзэнт гүрэнд шашны олон шинэ урсгал нэвтрэн орж ирж, аагаа багтаасан баячуудын шохоорхол, аргаа барсан ядуусын хорогдох газар нь болов. Хүний амьдралыг үнэ цэнэ, утга учиртай болгодог баяр хөөр, хувь тавилангийн талаарх ойлголтыг хүмүүс бараг мартсан байлаа.⁵⁰

Шинэ гэрээний бүтэц, зохион байгуулалт: Шинэ гэрээ нь есөн хүний бичсэн хорин долоон номоос бүрддэг. Тэдгээрийг бичиглэлийн хэв шинжээр нь үндсэн гурван бүлэг болгон ангилдаг:

- Түүхийн таван ном:** Сайн мэдээний номууд болон Үйлс ном
- Хорин нэгэн захидал:** Ромоос Иуда хүртэлх номууд
- Эш үзүүллэгийн нэг ном:** Илчлэлт

Дараах хүснэгтүүдэд Шинэ гэрээний номуудын ангилал болон тэдгээрт багтдаг номуудыг дэлгэн харуулав.⁵¹

Шинэ гэрээний номууд					
Түүхийн номууд	Захидлууд				Эш үзүүллэгийн номууд
Матай	Паулын захидлууд		Ерөнхий захидлууд		
	Анхны (илгээлтийн аяллынхаа үеэр бичсэн)	Сүүлийн (Иерусалимд баривчлагдсаныхаа дараа бичсэн)			
Марк	Галат	Эхний удаа шоронд хоригдсон	Шоронгоос сулаагдсан	Хоёр дахь удаагаа шоронд хоригдсон	Иаков Еврей
Лук	1 Тесалоник 2 Тесалоник	Колоссай	1 Тимот	2 Тимот	Иуда
Иохан	1 Коринт 2 Коринт	Ефес	Тит		1 Петр 2 Петр
Үйлс	Ром	Филемон			1 Иохан 2 Иохан 3 Иохан
		Филиппой			

Шинэ гэрээний номуудын өрөнхий тойм		
Түүхийн номууд	Сайн мэдээний номууд: Матай, Марк, Лук, Иохан	Тунхаглал: Аврагч ирсэн тухай, Түүний бодгаль болон ажил үйлс.
	Үйлс: Элч нараар дамжуулан хийсэн Ариун Сүнсний үйлс	Дамжуулж буй мэдээ: Ирж буй Аврагчийн тухай мэдээг тунхагладаг.
Захидлууд	Захидлууд: Чуулганууд болон хувь хүмүүст бичсэн захидлууд. Ром номоос Иуда хүртэл	Тайлбар: Христийн бодгаль болон ажил үйлсийн ач холбогдол, энэ нь христэч амьдралд хэрхэн нөлөөлөх ёстой тухай тайлбарладаг.
Эш үзүүлэгийн номууд	Илчлэлт: Эзэн Есүс Христийн апокалипс	Төгсгөл: Төгсгөлийн үеийн үйл явдлууд болон Эзэний хоёр дахь ирэлтийн тухай, энэ удаа Түүний хаанчлал мөнхөд үргэлжлэх тухай урдьчилан өгүүлсэн.

Шинэ гэрээний номуудын дэс дараалал: Шинэ гэрээний номууд нь он тооллын дарааллаар биш, харин логик дарааллаар байрласан байдаг. Райrigийн тайлбарласнаар,

Шинэ гэрээний эхэнд нь Христийн амьдралын тухай өгүүлсэн Сайн мэдээний номууд, дараа нь христитгэл түгэн тархсан тухай түүхийг хүүрнэсэн Үйлс ном, араас нь чуулганнд тулгарсан асуудлууд болон чуулганы тухай үзэл баримтлалууд үүссэн тухай өгүүлсэн захидлууд, эцэст нь Христийн хоёр дахь ирэлтийн тухай үзэгдэл буюу Илчлэлт ном ордог.⁵²

Шинэ гэрээний номууд чухам хэзээ бичигдсэн талаар Библи судлаач эрдэмтэд янз бүрийн үзэлтэй байдаг ч дараах дарааллыг нэлээд түгээмэл хүлээн зөвшөөрдөг:

Ном	Огноо (МЭ)	Ном	Огноо (МЭ)
Иаков	45-46	Үйлс	61
Галат	49	1 Петр	63-64
Марк	50 эсвэл 60	1 Тимот	63
Матай	50 эсвэл 60	Тит	65
1 ба 2 Тесалоник	51-52	Еврей	64-68
1 Коринт	55	2 Петр	67-68
2 Коринт	56	2 Тимот	66
Ром	57-58	Иуда	70-80
Лук	60	Иохан	85-90
Колостай, Ефес	60-61	1, 2, 3 Иохан	85-90
Филиппой, Филемон	60-61	Илчлэлт	96

Шинэ гэрээний номуудыг эмхэтгэн нэгтгэсэн нь: Шинэ гэрээний номууд нь анхандаа тус тусдаа салангад номууд байсан боловч аажимдаа нэгтгэгдэн, одоо бидний мэдэх Судрын каноны Шинэ гэрээний хэсэг бий болжээ. Эртний чуулганы үеийн олон бичвэрүүдийн дундаас Бурхан Шинэ гэрээний 27 номыг хадгалан авч үлдсэн юм. Эдгээр нь Бурханы амьсгалснаар, элч нарын эрх мэдлээр бичигдсэн учраас ийнхүү каноны Шинэ гэрээний хэсэг болон хадгалагдан үлджээ. Энэ үйл явцыг Райри ийнхүү тун гайхалтай дүгнэн хэлжээ:

Эдгээр ном нь анх тус тусдаа бичигдээд, каноны Шинэ гэрээний хэсгийг бүрдүүлсэн хорин долоон ном болон нэгтгэгдэх хүртэл нэлээд хугацаа өнгөрсөн. Хамгийн эхлээд Паулын захидлууд болон Сайн мэдээний номууд гэх мэт хэсэг номуудыг хүлээн авсан чуулганууд

болон хувь хүмүүс хадгалж авч үлдсэн байсан бөгөөд аажмаар нийт хорин долоон номыг эмхэтгэн цуглуулсан бөгөөд эдгээрийг чуулган нэг бүхэл ном хэмээн хүлээн зөвшөөрчээ.

Ийнхүү эмхэтгэн нэгтгэх үйл явц бараг 350 жил үргэлжилсэн аж. II зууны үед хуурамч сургаал, худал үзэл баримтлалыг сурталчилсан ном ихээр тараагдах болсон учраас жинхэнэ зөв зүйтэй Судрыг бусад христэч ном зохиолуудаас ялгах хэрэгцээ шаардлага гарч иржээ. Тийнхүү уг Сударт багтах ёстой номуудыг тодорхойлох зорилгоор хэд хэдэн шалгуурыг боловсруулсан байна.

1. Уг номыг хэн нэгэн элч бичсэн үү? Эсвэл, энэ ном хэн нэгэн элчийн сайшаал дэмжлэгийг авсан уу?
2. Уг номд сүнслэг мөн чанарын тухай өгүүлдэг үү?
3. Бурханы амьсгалснаар бичигдсэн гэх нотолгоо уг номд байна уу?
4. Уг номыг чуулганууд өргөнөөр хүлээн авсан уу?

Гэхдээ канонд багтахаар сонгосон хорин долоон номыг эртний чуулганууд бүгдийг нь хүлээн зөвшөөрсөн үү? гэвэл бас үгүй аж. Гэвч хүлээн зөвшөөрөгдөөгүй үлдсэн номуудыг үндэслэлгүй, худал гэж үзэж болохгүй юм. Хувь хүмүүст бичсэн захидлууд нь (Филемон, 2 ба 3 Иохан) чуулгануудад бичсэн захидлууд шиг өргөн хүрээгээр хүлээн зөвшөөрөгдөөгүй аж. Иаков, Иуда, 2 Петр, 2 ба 3 Иохан, Филемон номуудыг канонд оруулах асуудал нэлээд маргаантай байсан ч эцэст нь тэдгээрийг оруулж, МЭ 397 онд уг каноныг Картэйжийн Зөвлөлөөр баталгаажуулжээ.

Шинэ гэрээний бичээсүүдээс өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн эх хувь нэг ч байхгүй хэдий ч тэдгээрийг бүхэлд нь болон хэсгээс нь хуулж бичсэн 4500 гаруй грек гар бичмэл, 8000 орчим латин гар бичмэл, мөн эх номуудыг орчуулсан 1000 орчим хувилбар байдаг. Эдгээр хуулбарыг хооронд нь харьцуулж, анхааралтай судалснаар бид Шинэ гэрээний талаар үнэн зөв, баталгаатай мэдлэгтэй болно.⁵³

1-р ХЭСЭГ

ТҮҮХИЙН НОМУУД

Танилцуулга: Өмнө дурдсанчлан, Шинэ гэрээний номуудыг бичиглэлийн хэв шинжээр нь түүхийн номууд, захидалтууд, эш үзүүллэгийн номууд гэж гурав ангилааг. Шинэ гэрээний 46 хувийг Сайн мэдээний дөрвөн ном эзэлдэг. Харин эдгээр нь Үйлс номтой хамтдаа Шинэ гэрээний 60 хувийг бүрдүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, энэ таван номд христитгэлийн түүхэн хөгжлийг хүүрнэн өгүүлсэн байдаг. Христитгэл нь Сайн мэдээний мөн чанар болох түүхэн баримт дээр тулгуурладаг. Сайн мэдээ нь бусдын гэрчлэлээс авсан тааламжтай сайхан мэдээ юм. Энэ бол түүх - түүхэн баримтуудын нотолгоо юм.

Сайн мэдээний дөрвөн номд Есүсийн мэндэлсэн тухай, Түүний амьдрал, үхэл, амилалтын тухай өгүүлдэг бол Үйлс номд эртний чуулган дахь элч нарын үйлчлэлийн түүхийг тоймлон хүүрнэдэг. Үүгээрээ Үйлс ном нь захидалтуудад өгүүлсэн зүйлийг илүү сайн ойлгоход бидэнд маш чухал үүрэгтэй. Эдгээр нь тодорхой газар оронд амьдарч байсан түүхэн бодитой хүмүүст хаяглагдсан захидалтууд юм. Тэгэхлээр, Шинэ гэрээ нь амласан ёсоороо хүн төрөлхтний өнгөрсөн түүхэнд төдийгүй одоо болон ирээдүйд ажилласаар байх амьд Бурханы тухай Сайн мэдээний түүхэн ном юм.

Синоптик Сайн мэдээний номууд: Сайн мэдээний номуудыг судалж эхлэхийнхээ өмнө “Синоптик Сайн мэдээ” гэж чухам юуг хэлж байгааг тодруульяа. Сайн мэдээний ном бүр өөрийн гэсэн зорилго, онцлох зүйлтэй боловч Матай, Марк, Лук номуудыг Синоптик Сайн мэдээний номууд гэж нэрлэдэг. Учир нь тэд Христийн амьдралыг нэг үзэл бодлын өнцгөөс харж бичсэн бөгөөд агуулга, дэс дараалал нь адилхан байдаг. Түүнчлэн тэдгээрт Христийн амьдралыг Иоханы Сайн мэдээнд өгөгдсөн дүрслэлээс цааш нь үргэлжлүүлэн хүүрнэсэн байдаг. Эхний гурван Сайн мэдээний номд байдаг нийтлэг хэсгүүд:

- Иохан баптист Мессия ирэх тухай зарлан тунхагласан (Матай 3, Марк 1, Лук 3)
- Есүс баптиسم хүртсэн (Матай 3, Марк 1, Лук 3)
- Есүс соригдсон (Матай 4, Марк 1, Лук 4)
- Есүсийн сургаал ба үйлдсэн гайхамшигүүд (Сайн мэдээ тус бүрийн үндсэн хэсэг)
- Есүсийн дүр хувиралт (Матай 17, Марк 9, Лук 9)
- Есүс зовлон эдэлж нас барсан; Түүнийг оршуулсан (Матай 26-27, Марк 14-15, Лук 22-23)
- Есүсийн амилалт (Матай 28, Марк 16, Лук 24)

Сайн мэдээний дөрөн номын зорилго ба онцловын ялгаа: Сайн мэдээний дөрвөн ном нь Есүс Христийн бодгалийг илчлэн харуулах зорилготой. Матай 16:13-16 ишлэлд,

Есүс Цезарь Филипийн нутагт очих үедээ шавь нараасаа “Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна?” гэж асуув. Тэгэхэд нь тэд “Зарим нь баптизм хүртээгч Иохан, зарим нь Елиа, харин зарим нь Иеремиа эсвэл эш үзүүлэгчдийн нэг гэж ярьdag” гэхэд, Тэр “Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ?” гэсэнд, Симон Петр “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн” гэв.

Есүсийн үед амьдарч байсан дийлэнх хүмүүсийн дунд байсан түгээмэл дөрвөн үзэл санааг Матай 16:14-д хэлжээ. Эхний үед Есүсийг Бурханы Хүү мөн гэж хүлээн зөвшөөрөх хүн цөөхөн байсан. Тиймээс Сайн мэдээг бичигчид Есүсийн бодгаль болон ажил үйлчлэлийн талаар өгүүлж, Тэрээр үнэндээ хэн байсныг Сүнсний удирдлага доор илчлэн бичжээ. Сайн мэдээний дөрвөн ном нь өөр өөр зүйлд голлон анхаардаг ч аль аль нь Эзэнээс шавь наарт хандуулсан асуултуудад хариулдаг. Есүс гэж чухам хэн болохыг эдгээр номд маш оновчтой илэрхийлсэн байдаг. Тэр бол Хуучин гэрээнд зөгнөгдсөн Мессия, Эзэний Зарц, Хүний Хүү, Бурханы Хүү бөгөөд энэ дэлхийг Аврагч Нэгэн гэдгийг Сайн мэдээний дөрвөн номд маш тодорхой өгүүлдэг. Түүнчлэн Бурханы бодгалийг дүрслэн хүүрнэж, Христийн ажил үйлчлэлийг дөрвөн өөр байдлаар илэрхийлэн харуулдаг.

Матай. Назарын Есүс бол өөрсдийнх нь Хаан бөгөөд Мессия гэдэгт иудейчүүдийг итгүүлэхийн тулд Матай Сайн мэдээний энэ номоо иудейчүүдэд хандан бичжээ. Матай Есүсийн уг гарлыг илэрхийлэхдээ

Түүний тухай зөгнөл хэрхэн биелснийг харуулсан арван ишлэлийг ашиглаж, хэдийгээр Есүс гологдож цовдлогдсон ч Тэрээр хуучин гэрээний удаан хүлээгдсэн Мессия мөн гэдгийг үүгээрээ илэрхийлэхийг зорьжээ (Матай 1:23; 2:15; 2:18; 2:23; 4:15; 8:15; 12:18-21; 13:35; 21:5; 27:9-10). Тухайн үндэстэн бүхэлдээ Есүсийг голж, цовдолсон боловч энэ Хаан хоосон булشاа үлдээгээд явсан юм.

Марк номыг уншихад түүнийг ромчуудад хандан бичсэн мэт сэтгэгдэл төрдөг. Энд Есүсийг “**Өөрийн амийг олны төлөө золиос болгон өгөхийн тулд**” ирсэн Эзэний Зарц гэсэн байдаг. Сайн мэдээний номуудаас хамгийн богино нь болох Марк ном маш өрнөлттэй, хурц тод, амьд бичигдсэн агаад, ялангуяа Есүсийн энэ дэлхий дээр өнгөрүүлсэн сүүлийн долоо хоногийн амьдралыг өөрийн нүдээр харсан хүмүүсийн гэрчлэлийг хүүрнэдэг. “Энэ Сайн мэдээний гуравны нэг нь Түүний амьдралын хамгийн сүүлийн, хамгийн чухал долоо хоногийн үйл явдлуудын тухай өгүүлдэг.”⁵⁴

Лук Эмч, түүхч мэргэжилтэй Лук өөрийн бичсэн Сайн мэдээний номдоо Есүсийг “**алдагдсаныг хайж, аврахаар**” (Лук 19:10) ирсэн Хүний Хүү гэсэн байдаг. Тэрээр Христийн бурханлаг чанарыг тунхаглахаас гадна жинхэнэ хүмүүн мөн чанарыг нь бас онцлон тэмдэглэдэг. Лук хүмүүний философийг сонирхон судалдаг хүн байсан учраас үүнийг бичихдээ грекчүүдийн талаар бодож байсан гэж зарим хүн үздэг.

Иохан уншигчдын анхаарлыг Христийн бурханлаг мөн чанарт хандуулахыг зорьсон. Тэрээр Есүс бол Өөрт нь итгэж, Өөрийг нь хүлээн авсан хүнд мөнх агаад бялхам амийг соёрхдог Бурханы мөнхийн Хүү гэдгийг онцолсон (Иохан 1:1-2, 12; 3:16-18, 36; 10:10). Иоханы Сайн мэдээ нь бүх хүн төрөлхтөнд зориулагдсан хэдий ч түүнийг онцгойлон чуулгануд зориулан бичжээ. Есүс нас бараахаасаа хэдхэн цагийн өмнө шавь нартайгаа салах ёс гүйцэтгэн, тэднийг тайтгаруулсан тухай тус номын таван бүлэгт тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн, Есүс бол Аврагч байсныг нотлох, мөн Түүнд итгэнээр мөнх амьтай болно гэдэгт бүх хүмүүсийг урамшуулан ятгах зорилгоор Есүсийн долоон гайхамшигт тэмдгийг дурдсан байдаг (Иохан 20:30-31).

Матай (Иудейчүүдийн Хаан)

Номын нэр болон зохиогч: Сайн мэдээний номуудыг зохиогчийнх нь нэрээр нэрлэсэн байдаг. Сайн мэдээний бусад номуудын адил энэхүү анхны Сайн мэдээний номд зохиогчийнх нь нэрийг дурдаагүй ч элч Матай түүнийг бичсэн гэдгийг эртний чуулганууд нийтээр нотолдог. Түүнчлэн, өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн эртний бичвэрүүдэд “Матайн өгүүлснээр” хэмээн тэмдэглэсэн байдаг нь энэ Сайн мэдээг Матай бичсэн гэдгийг баталдаг юм. Тэгэхээр Есүсийн анхны шавь Матай иудейчүүдийн Мессия болох Нэгэний тухай өгүүлсэн Матай хэмээх энэхүү иудей бичвэрийг бичжээ. Матайн жинхэнэ нэрийг Леви гэдэг байжээ. Түүний эцгийг Алфай гэдэг байв. Эзэн түүнийг дагуулахаар дуудах хүртэл Матай Палестинд Ромын татвар хураагчаар ажилладаг байжээ (Матай 9:9, 10; Марк 2:14-15). “Намайг дага” хэмээн Есүсийг хэлсэн даруй тэр босож, Түүний дагасан нь Есүсийн үйлчлэлд түүний зүрх сэтгэл хэдийнээ хөдөлсөн байсны илэрхийлэл байж болох юм.

Бичигдсэн огноо: **МЭ 50, 60-аад он.** Матай номыг МЭ 40-140 оны хооронд бичигдсэн гэж үздэг. Гэвч “МЭ 70 онд болсон Иерусалимын сүйрлийг ирээдүйд болох үйл явдал (24:2) гэснээс үзвэл энэ ном арай эрт бичигдсэн байж таарна. Зарим хүмүүс үүнийг хамгийн анхны (МЭ 50-иад онд бичигдсэн) Сайн мэдээний ном гэж үздэг бол, зарим нь тэдэнтэй санал нийлдэгтгүй. Тэд Матай номыг 60-аад оны үед бичигдсэн гэдэг.”⁵⁵

Сэдэв болон зорилго: 16:13-15 ишлэлд Есүсийн шавь нартаа тавьсан асуултуудаас тодорхой харагдаж байгаачлан, Матай Назарын Есүсийн тухай асуусан иудейчүүдийн асуултуудад хариулсан юм. Есүс Өөрийгөө тэдний Мессия гэж тов тодорхой тунхагласан. Тэрээр эш үзүүлэгчдийн зөгнөсөн Хуучин гэрээний Мессия үнэхээр мөн байсан уу? Хэрэв тийм бол, шашны удирдагчид яагаад Түүнийг хүлээж аваагүй вэ? Мөн, Тэр яагаад амлагдсан хаант улсыг байгуулаагүй вэ? Ер нь энэ хаант улс байгуулагдах болов уу? Хэрэв байгуулагдах бол хэзээ вэ? Ийнхүү Матай Есүс бол удаан хүлээсэн Мессия мөн гэдгийг иудейчүүдэд харуулах зорилгоор энэ номыг тэдэнд зориулан бичсэн юм. Есүсийн угийн бичиг (1:1-17),

зурхайчдын айлчлал (2:1-12), Есүсийн Иерусалим уруу орж ирсэн байдал (21:5), үндэстнүүдийн шүүлт (25:31-46), мөн Сайн мэдээний бусад номуудад болон Хуучин гэрээний эш үзүүллэгийн биелэлтэд ч бас гардаг “тэнгэрийн хаанчлал”-ын тухай байн байн дурдсанаас нь үүнийг харж болно.

Христийн тухай Матай номд: Өмнө онцлон тэмдэглэсэнчлэн, Матайн гол зорилго нь Есүс бол Хуучин гэрээний үеэс хүлээж байсан Мессия мөн гэдгийг нотлон харуулах явдал байсан. Тэр бол Абрахам болон Давидын Хүү юм. Тиймээс Тэр бол хаанчлалыг амлаж ирсэн Хаан билээ. Сайн мэдээний энэ номд “тэнгэрийн хаанчлал” гэдэг үг гучин хоёр удаа давтагдсан байдаг. Есүс Хуучин гэрээний хүлээлтийг гүйцэлдүүлсэн гэдгийг харуулахын тулд Матай Есүсийн амьдралд Хуучин гэрээний эш үзүүллэг биелэгдсэн тохиолдлуудыг арван удаа онцлон тэмдэглэжээ. Түүнчлэн, Матай Хуучин гэрээнээс ойролцоогоор 130 удаа иш татсан нь Шинэ гэрээний бусад номуудаас олон байгаа юм.

Хувийн Судлал: Агуулга

1. Хааны бодгаль ба танилцуулга (1:1–4:25)

- | | |
|---------------------------------------|---------|
| A. Хаан мэндэлсэн нь (1:1-25) | |
| 1:1-17 | 1:18-25 |
| B. Түүнийг таньсан нь (2:1-12) | |
| C. Түүнийг авч зугтсан нь (2:13-23) | |
| 2:13-15 | 2:16-23 |
| D. Түүний замыг бэлдэгч (3:1-17) | |
| 3:1-12 | 3:13-17 |
| E. Түүнд тулгарсан сорилтууд (4:1-11) | |
| F. Түүний анхны шавь нар (4:12-25) | |
| 4:12-17 | 4:18-22 |
| | 4:23-25 |

2. Хааны тунхаглал (5:1–7:29)

- | | |
|---|---------|
| A. Хувь хүний өсөлт хөгжлийн тухай (5:1-12) | |
| B. Итгэгчдийн хариуцлагын тухай (5:13-20) | |
| C. Харилцааны тухай (5:21-48) | |
| D. Өглөг, залбирал, мацаг барилтын тухай (6:1-18) | |
| 6:1-6 | 6:7-15 |
| E. Жинхэнэ баялгийн тухай (6:19-34) | |
| 6:19-24 | 6:25-34 |
| F. Хуулийн биелэлтийн тухай (7:1-29) | |
| 7:1-6 | 7:13-14 |
| 7:7-12 | 7:15-23 |
| | 7:24-29 |

3. Хааны эрх мэдэл (8:1–11:1)

- | | |
|--|------------|
| A. Эдгээх (8:1-17) | |
| 8:1-13 | 8:14-17 |
| B. Бусдыг дуудан дагуулах (8:18-22) | |
| C. Шуургыг номхотгох (8:23-27) | |
| D. Чөтгөрийг зайлцуулах (8:28-34) | |
| E. Илүү олон хүнийг эдгээх (9:1-38) | |
| 9:1-8 | 9:14-17 |
| 9:9-13 | 9:18-38 |
| F. Шавь наараа удирдан чиглүүлэх (10:1–11:1) | |
| 10:1-15 | 10:24-39 |
| 10:16-23 | 10:40–11:1 |

4. Хааны ажил ба эсэргүүцэлтэй тулгарсан нь (11:2–16:12)

- | | |
|--|--|
| A. Есүс Иоханыг сайшаасан нь (11:2-19) | |
|--|--|

B.	Гэмшилд дуудсан нь (11:20-30) 11:20-24	11:25-30	
B.	Фарисайчуудын эсэргүүцэл (12:1-50) 12:1-7	12:30-32	12:46-50
	12:8-21	12:33-37	
	12:22-29	12:38-45	
G.	Сургаалт зүйрлэлүүд (13:1-58) 13:1-9	13:31-32	13:45-46
	13:10-17	13:33-35	13:47-52
	13:18-23	13:36-43	13:53-58
	13:24-30	13:44	
D.	Иоханыг цаазалсан нь (14:1-12)		
E.	Өөр олон гайхамшигууд (14:13-36) 14:13-21	14:22-36	
Ё.	Ёс заншил ба хоёр нүүр гаргах (15:1-20) 15:1-14	15:15-20	
J.	Өөр олон хүнийг эдгээсэн нь (15:21-39) 15:21-28	15:29-31	15:32-39
3.	Илүү их эсэргүүцэл тулгарсан нь (16:1-12)		
5.	Хааны шавь нар бэлтгэгдсэн нь (16:13–20:28)		
A.	Петрийн итгэлийн өчил (16:13-28) 16:13-20	16:21-23	16:24-28
B.	Есүсийн дүр хувиралт (17:1-13)		
B.	Чөтгөрийг зайлцуулсан нь (17:14-23)		
G.	Итгэл ба татвар (17:24-27)		
D.	Итгэл ба хайр (18:1-19:12) 18:1-6	18:12-14	18:21-35
	18:7-11	18:15-20	19:1-12
E.	Итгэл ба хүүхдүүд (19:13-15)		
Ё.	Итгэл ба дагалдуулал (19:16-30) 19:16-26	19:27-30	
J.	Зөвшүүлэлийг сайшаасан нь (20:1-16)		
3.	Эрх мэдэл үү, эсвэл үйлчлэл үү? (20:17-28) 20:17-19	20:20-28	
6.	Хаан гэдгээ харуулсан нь (20:29–23:39)		
A.	Сохор хүнийг эдгээсэн нь (20:29-34)		
B.	Иерусалимд орж ирсэн нь (21:1-27) 21:1-11	21:18-22	
	21:12-17	21:23-27	
B.	Сургаалт зүйрлэлээр сургамжилсан нь (21:28–22:14) 21:28-32	21:33-46	22:1-14
G.	Дахин эсэргүүцэл тулгарсан нь (22:15-46) 22:15-22	22:23-46	
D.	Фарисайчуудыг илчилсэн нь (23:1-39) 23:1-12	23:13-36	23:37-39
7.	Хааны урьдчилан хэлсэн зүйлс буюу эш үзүүллэгүүд (24:1–25:46)		
A.	Буцахдаа бэлтгэсэн нь (24:1-51) 24:1-14	24:29-31	24:42-51
	24:15-28	24:32-41	
B.	Буцахтай холбоотой сургаалт зүйрлэлүүд (25:1-30) 25:1-13	25:14-30	

В. Шүүлт (25:31-46)

8. Хаан гологдож, зовлон эдэлсэн нь (26:1-27:66)

А. Урвалт ба баривчлагаяа (26:1-56)

26:1-5	26:20-25	26:47-56
26:6-13	26:26-35	
26:14-19	26:36-46	

Б. Шүүх хурал ба Петрийн үгүйсгэл (26:57-75)

26:57-68	26:69-75
----------	----------

В. Иудасын харуусал (27:1-10)

Г. Есүсийг цовдолсон нь (27:11-56)

27:11-26	27:27-32
----------	----------

Д. Есүсийг оршуулсан нь (27:57-66)

27:33-56

9. Хаан гэдгээ баталсан нь (28:1-20)

А. Түүний амилалт (28:1-10)

Б. Нуун дарагдуулсан нь (28:11-15)

В. Агуу захирамж (28:16-20)

Марк
(Эзэний Зарц)

Номын нэр болон зохиогч: Маркийн Сайн мэдээнд бичигчийнх нь нэр дурдагдаагүй учраас үүнийг чухам хэн бичсэн нь үнэндээ тодорхойгүй. “Маркийн өгүүлснээр” гэсэн тодотголыг хожим МЭ 125 оноос өмнө хэн нэгэн бичээч нэмж оруулсан байдаг ч энэ номыг Марк бичсэн гэдгийг батлах хангалттай нотолгоо (гадаад болон дотоод) байдаг. Энэ номыг “Марк, элч Петрийн тусламжтайгаар бичсэн гэдгийг эртний чуулганы эцгүүд нэгэн санаатай гэрчилсэн байдаг.”⁵⁶ МЭ 112 онд Папиас гэдэг хүн Маркийг “Петрийн хэлмэрч” гэж бичсэн байдаг. “Үйлс 10:36-43 ишлэлд буй Петрийн номлолыг Маркийн Сайн мэдээтэй харьцуулбал, энд Есүсийн амьдралыг тойм маягаар дүрсэлсэн байдаг бол Марк маш дэлгэрэнгүй өгүүлдэг” гэж Уолтер М. Даннет тэмдэглэсэн байдаг.⁵⁷

Марк Христийн анхны шавь нарын нэг биш ч гэсэн тэрээр Петрийн анд (1 Петр 5:13), Барнабын үеэл (Колоссай 4:10), Иерусалимдаа хөрөнгө чинээ, эрх мэдэлтэй хүмүүсийн тоонд ордог нэгэн байжээ. Түүний эхийг Мария гэдэг байв (Үйлс 12:12). Түүний энэ бүх харилцаа холбоо, ялангуяа Петртэй харилцаатай байж, түүнээс мэдээлэл авч байсан нь Маркийн Сайн мэдээ элчийн эрх мэдэлтэй гэдгийг батлах баттай нотолгоо болдог. Петр түүнийг “миний хүү Марк” (1 Петр 5:13) гэснээс харвал Петр Маркийг Христ уруу авчирсан байж болох юм.

Түүнчлэн, Марк Паултай маш ойр дотно харилцаатай байжээ. Энэ тухай Чарльз Райр ийнхүү бичжээ:

Илгээлтийн анхны аяллаар Паул, Барнаб нартай хамт явах ховорхон завшаан түүнд олдсон хэдий ч тэрээр уг аяллыг дуусгалгүй орхижээ. Тийм учраас Паул хоёр дахь аяллаараа түүнийг авч явахаас татгалзсан байна. Тийнхүү Марк Барнабтай хамт Кипр уруу явжээ (Үйлс 15:38-40). Үүнээс бараг арван хоёр жилийн дараа Марк Паултай дахин нийлсэн (Колоссай 4:10; Филемон 24) бөгөөд Паул цаазлуулахаасаа өмнө түүнийг өөр уруугаа дуудаж авчуулжээ (2 Тимот 4:11). Амьдралдаа гаргасан нэг алдаанаас нь болж хэн нэгнийг хэрэгцээгүй хүн гэж дүгнэж болохгүй гэдгийг Маркийн намтар харуулдаг.⁵⁸

Бичигдсэн огноо: МЭ 50, 60-аад он. Марк номын бичигдсэн огноог тодорхойлоход төвөгтэй байдаг ч үүнийг Сайн мэдээний дөрвөн номын эхнийх нь гэж олон эрдэмтэн үздэг. Учир нь Марк номын бараг бүх ишлэлийг нөгөө турван номд иш татсан байдаг аж. Марк ном нь МЭ 70 оноос өмнө, Иерусалимын сүм нураагүй байхад бичигдээж (13:2).

Сэдэв болон зорилго: Марк номын сэдэв нь “Христ бол Зарц.” 10:45-р ишлэлд үйлчлэл болон тахилын талаар “*Учир нь Хүний Хүү хүртэл үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд, мөн Өөрийн амийг олны төлөө золиос болгон өгөхийн тулд ирсэн юм*” хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Марк номыг анхааралтай уншвал, Марк энэ ишлэлд үйлчлэл ба тахилыг хэрхэн илэрхийлснийг олж харах болно.

Марк номыг ромчууд болон харь үндэстнүүдэд зориулан бичжээ. Тиймээс энд Есүсийн угийн бичиг болон Уулан дээрх сургаалыг орхигдуулжээ. Түүнчлэн шашны удирдагч нарын буруутгалд ч нэг их ач холбогдол өгөөгүй байна. Учир нь ийм буруутгалууд нь иудей уншигчдын соёл заншилтай илүү холбоотой тул харь үндэстнүүдэд сонин биш байх байлаа. Марк Есүсийг Ажилчин, Зарц гэдэг талаас нь харуулдаг учраас уг ном Христийн үйл ажиллагааг онцолж, Түүнийг ажил үйлчлэлээ үр нөлөөтэй хийж яваа үнэнч Зарц хэмээн үзүүлдэг.

Христийн тухай Марк номд: Марк Аврагчийг дүрслэхдээ олны төлөө Өөрийн амийг дуулгавартайгаар золиос болгон өгөхөөр ирсэн Зарц гэдгийг онцолдог. Есүс Өөрийнхөө хэрэгцээг хойш тавиад, бусдын бодит болон сүнслэг хэрэгцээг хамгийн түрүүнд хангахын төлөө үйлчилж байсан гэдгийг уг ном маш тодорхой онцлон өгүүлдэг. Аврагчийн бусдад үйлчилж байсныг ийнхүү онцолсныг дараах байдлаар дүгнэсэн байдаг:

Христийн хүүрнэсэн далан сургаалт зүйрлэлээс Маркийн Сайн мэдээнд дөнгөж арван найм нь гардаг (зарим нь ганцхан өгүүлбэрээр) хэдий ч Марк Христийн үйлдсэн гучин таван гайхамшигийн талаас илүү хувийг дурдсан нь Сайн мэдээний номууд дахь хамгийн өндөр харьцаа юм.⁵⁹

Хувийн Судлал: Агуулга

1. Зарцыг үйлчлэлд бэлтгэсэн нь (1:1-13)

- A. Түүний замыг бэлдэгч (1:1-8)
- B. Баптисм хүртсэн нь (1:9-11)
- C. Соригдсон нь (1:12-13)

2. Зарц Галилд тунхагласан нь (1:14–9:32)

A. Түүний үүрэг даалгавар (1:14–2:12)	1:14-28	1:29-45	2:1-12
B. Анхны эсэргүүцэл (2:13–3:35)	2:13-22	3:1-12	
	2:23-28	3:13-35	
B. Сургаалт зүйрлэлүүд (4:1-34)	4:1-12	4:26-29	
	4:13-25	4:30-34	
G. Гайхамшигүүд (4:35–5:43)	4:35-41	5:1-20	5:21-43
D. Эсэргүүцэл нэмэгдсэн нь (6:1–8:26)	6:1-6	6:33-52	7:14-23
	6:7-13	6:53-56	7:24-37
	6:14-32	7:1-13	8:1-26
E. Петр Христэд итгэснээ өчсөн нь (8:27-33)			
Ё. Дагалдагч байхын үнэ цэнэ (8:34–9:1)			
Ж. Дүр хувиралт (9:2-13)			
З. Сүнсэнд эзэмдүүлсэн хүүг чөлөөлсөн нь (9:14-29)			
I. Есүс Өөрийнхөө үхлийг урьдчилан хэлсэн нь (9:30-32)			

3. Зарц Перт тунхагласан нь (9:33–10:52)

А. Есүс шавь нараа бэлтгэхээр тунхагласан нь (9:33–10:45)

9:33-37	10:1-12	10:17-31
9:38-50	10:13-16	10:32-45

Б. Сохор Бартимайг хараатай болгосон нь (10:46-52)

4. Зарц Иерусалимд зовлон эдэлсэн нь (11:1–15:47)

А. Албан ёсоор Өөрийгөө таниулсан нь (11:1-19)

11:1-14	11:15-19
---------	----------

Б. Залбирлын талаар сургасан нь (11:20-26)

В. Удирдагчдын эсэргүүцлтэй тулгарсан нь (11:27–12:44)

11:27-33	12:13-27	12:41-44
12:1-12	12:28-40	

Г. Ирээдүйн талаар сургасан нь (13:1-37)

13:1-2	13:14-23	13:33-37
13:3-8	13:24-27	
13:9-13	13:28-32	

Д. Зовлон эдэлсэн нь (14:1–15:47)

14:1-11	14:43-52	15:16-21
14:12-21	14:53-65	15:22-41
14:22-31	14:66-72	15:42-47
14:32-42	15:1-15	

5. Зарц амилуулагдсан нь (16:1-20)

А. Түүний амилалт (16:1-8)

Б. Хүмүүст үзэгдсэн нь (16:9-18) Эргэлзээтэй текст

В. Тэнгэр өөд авагдсан нь (16:19-20) Эргэлзээтэй текст

Лук (Хүний Хүү)

Номын нэр болон зохиогч: Теофилд хаяглагдсан Лук, Ўйлс номуудыг хоёуланг нь Лук бичсэн гэж үздэг. Хэдийгээр энэ хоёр номын алинд нь ч түүнийг зохиогч нь гэж нэрлэсэн хэсэг байдаггүй ч “хайрт эмч” (Колоссай 4:14) гэсэн байгаа нь Лук эдгээрийг бичсэн гэж үзэхэд нэлээд түлхэц болж өгдөг.

Энэ хоёр ном грек Шинэ гэрээний дерөвний нэг гаруй хувийг бүрдүүлдэг. Лукийн нэр Колоссай 4:14; 2 Тимот 4:11; Филемон 24 гэсэн гуравхан газар л гардаг. Түүнчлэн Ўйлс номын “бид” гэсэн хэсгүүдэд (16:10-17; 20:5–21:18; 27:1–28:16) Лук өөрийнхөө тухай өгүүлсэн гэж үздэг. Ўйлс номын эдгээр хэсэг нь Лук Паултай ойр дотно харилцаатай, түүний хамтран аялагч байсныг илтгэн харуулдаг. Паулын хамтрагчдаас хоёроос бусдыг нь гуравдугаар бие дээр заан нэрлэсэн байdag бөгөөд тэр хоёр хамтрагч нь Тит, Лук нар байх магадлалтай юм. Паул “хайрт эмч Лук” (Колоссай 4:14), “миний хамтран зүтгэгч” (Филемон 24) гэсэн нь энэ номыг Лук бичсэн гэдгийг улам тодотгодог.

Колоссай 4:10-14 ишлэлд Паул Лукийг иудейчүүдээс тусад нь дурдсанаас үзвэл тэрээр харь үндэстэн байсан гэдэг нь илэрхий байна. Энд элч Паул өөрийн хамтран зүтгэгчдээс Аристарх, Марк, Иохан нарыг л зөвхөн иудейчүүд гэжээ. Тэгэхлээр энэ ишлэлд дурдагдсан бусад хүмүүс болох Епафр, Лук, Дэм нар иудей биш, харь үндэстнүүд болж таарна. “Лукийн грек хэлний гайхалтай чадвар болон Ўйлс 1:19-д ‘өөрсдийнхөө хэлээр’ хэмээн хэлсэн хэсэг нь түүнийг иудей хүн биш байсныг илтгэн харуулдаг.”⁶⁰

Лук Есүс Христийг нүдээр гэрчлэгч биш (Лук 1:2) гэдгээс өөр түүний өмнөх амьдралын талаар, өөрөөр хэлбэл, Есүст хэрхэн итгэсэн талаар мэдэх юм бидэнд үнэндээ байхгүй. Тэрээр эмч мэргэжилтэй хэдий ч Лук, Ўйлс номуудыг бичсэн, илгээлтийн үйлчлэлд Паултай хамтран зүтгэж байсан, Сайн мэдээг

дэлгэрүүлэгч байжээ. Паулыг итгэлийнхээ улмаас амиа алдах үед (2 Тимот 4:11) Лук түүнтэй хамт байсан. Харин түүнээс хойших амьдралынх нь талаар тодорхой баримт сэлт бидэнд байдаггүй.⁶¹

Бичигдсэн огноо: МЭ 60 он. Лукийн Сайн мэдээ (1) МЭ 59-63 он, (2) МЭ 70, 80-аад онд бичигдсэн гэсэн хоёр таамаглал нэлээд түгээмэл байдаг боловч Үйлс номын төгсгөлийг үзвэл, тухайн үед Паул Ромд байжээ. Мөн түүнчлэн, Лук ном Үйлс номын өмнө бичигдсэн (Үйлс 1:1) байдаг. Эдгээрээс хараад, Лукийн Сайн мэдээ МЭ 60 оны үед бичигдсэн байж таарна.

Сэдэв болон зорилго: Уг номын зорилгыг эхний дөрвөн ишлэлд маш тодорхой хэлсэн байдаг:

Бидний дунд биелсэн үйл явдлуудын талаар олон хүн эмхтгэхээр шийдсэн билээ. Анхнаас нь нүдээр гэрчлэгчид хийгээд үгийн үйлчлэгчид бидэнд тэдгээрийг уламжилсанчлан, бүгдийг эхнээс нь нягтлан судалсан тул танд түүнийг дэс дараалан бичижсөн өгөх нь надад бас зохицтой санааглаа, эрхэм хүндэт Теофил минь. Энэ нь танд заасан зүйлсийн талаарх гарцаагүй үнэнийг танд таниулахын тулд юм шуу. (Лук 1:1-4)

Сайн мэдээг хүргэж буй түүний арга барилын талаар хэд хэдэн зүйлийг анхаарах хэрэгтэй:

Түүний ажилд бусдын хийсэн зүйл түлхэц болсон (1:1) агаад, тэрээр нүдээр гэрчлэгчдээс асууж лавлаж (1:2), улмаар Теофилд гарцаагүй үнэнийг таниулахын тулд (1:4) гэрч нараас олж авсан мэдээллээ Ариун Сүнсний удирдамж доор нягтлан судалж, эмхэлж цэгцэлсэн (1:3) гэдгээ Лук хэлжээ. Энэ бол маш сайн судлагдаж, баримтаар нотлогдсон бичвэр юм.⁶²

Лук өөрөө харь үндэстэн учраас Христийн амьдралыг хүүрнэсэн энэ хоёр номоо харь үндэстэн уншигчдад ойлгогдохуйц бичихэд ихээхэн анхаарсан байж таарна. Тэрээр “өөрийнхөө Сайн мэдээг грек уншигчдад илүү ойлгомжтой болгохын тулд арамай үгсийг грек уруу орчуулж, иудейн ёс заншил, газарзүйн онцлогийг тайлбарласан”⁶³ байгаа нь үүнийг илтгэн харуулдаг.

“Хайрт эмч”-ийн бичсэн Лук ном нь Сайн мэдээний номуудаас хамгийн урт, хамгийн дэлгэрэнгүй ном юм. Энэ номд Аврагчийг: Хүний Хүү, алдагсаныг хайж, аврахаар ирсэн Төгс Хүн гэж харуулсан байдаг (19:10). Матай номд Есүсийг Давидын Хүү, Израилийн Хаан гэдэг бол, Марк номд Түүнийг бусдын төлөө үйлчлэгч Эзэний Зарц, харин Лук номд хүмүүсийн хэрэгцээг хангагч Хүний Хүү, хүмүүсийн дундаас сонгогдож, хүмүүсийн дунд шалгагдан, Аврагч ба Тэргүүн Тахилч байхаар бэлтгэгдсэн хүмүүсийн дундах төгс Хүн гэж дүрсэлдэг. Матайн Сайн мэдээнд чухал үйл явдлуудыг бүлэглэсэн байдаг бол, Марк номд эдгээр үйл явдлыг товчлон хүүрнэдэг. Харин Лукийн Сайн мэдээнд эмч\түүхч мэргэжилтэй Лук дээрх чухал үйл явдлуудыг илүү дэлгэрэнгүй өгүүлдэг.

Хүний Хүү, мөн Бурханы Хүү болох Христийн төгс хүмүүн мөн чанар нь Түүний бие махбодын төрөлт буюу Адам хүртэл үргэлжлэх угийн бичгээр (3:38; Матай номд энэ угийн бичиг дөнгөж Абрахам хүрээд зогсдогийг санаарай) илэрхийлэгддэг. Есүсийн оюун санааны хөгжлийн талаар 2:40-52 ишлэлд өгүүлдэг бөгөөд тэнгэрээс Эцэгийн дуу гарч, Ариун Сүнсээр тослон баптиسم хүргээнээр (3:21-22) Есүс ёс суртахуун болон сүнсний хувьд төгс болгогджээ (3:21-22). Тийнхүү бид Есүсээс бие махбод, оюун санаа болон сүнсний хувьд төгс Нэгэнийг хардаг.

Христийн тухай Лук номд: Есүсийн хүмүүнлэг энэрэнгүй чанарыг Лукийн Сайн мэдээнд дахин дахин онцолсон байдаг. Христийн угсаа гарвал болон Тэрээр хэрхэн мэндэлж, өсөж төлөвшөн талаар Лук ном бүрэн дүүрэн мэдээллийг өгдөг. Тэр бол бидний гуниг зовлонг Өөртөө авч, авралын үнэлж баршгүй бэлгийг санал болгохын тулд нүгэлт хүмүүний зовлонтой адил болгогдсон, Хүний төгс Хүү юм. Төгс хүний талаарх Грекийн жишигийг зөвхөн Есүс л гүйцэлдүүлдэг.⁶⁴

Хувийн Судлал: Агуулга

1. Танилцуулга: Бичвэрийн арга ба зорилго (1:1-4)

2. Хүний Хүүг хүмүүстэй адилтгасан нь (1:5-4:13)

A. Христийг төрөхийн өмнөх үйл явдлууд (1:5-56)		
1:5-25	1:39-45	
1:26-38	1:46-56	
B. Христийг төрөх үетэй давхцан тохиосон үйл явдлууд (1:57-2:38)		
1:57-66	2:1-20	
1:67-80	2:21-38	
C. Христийг хүүхэд байхад болсон үйл явдлууд (2:39-52)		
2:39-40	2:41-52	
D. Христ Өөрийгөө таниулахын өмнөх үйл явдлууд (3:1-4:13)		
3:1-20	3:23-38	
3:21-22	4:1-13	

3. Хүний Хүү хүмүүст үйлчилсэн нь (4:14-9:50)

A. Христ Өөрийгөө таниулсан нь (4:14-30)		
B. Христ эрх мэдлээ харуулсан нь (4:31-5:28)		
4:31-37	5:1-11	5:27-28
4:38-44	5:12-26	
B. Христийн ажлыг тайлбарласан нь (5:29-6:49)		
5:29-39	6:12-19	6:46-49
6:1-11	6:20-45	
C. Христийн ажил өргөжсөн нь (7:1-9:50)		
7:1-17	8:16-21	9:12-27
7:18-39	8:22-25	9:28-45
7:40-50	8:26-39	9:46-50
8:1-3	8:40-56	
8:4-15	9:1-11	

4. Хүний Хүүг хүмүүс голсон нь (9:51-19:27)

A. Христийг эсэргүүцэх нь улам нэмэгдэв (9:51-11:54)		
9:51-56	10:30-37	11:29-36
9:57-62	10:38-42	11:37-54
10:1-16	11:1-13	
10:17-29	11:14-28	
B. Христийг голсонтой холбоотой өгөгдсөн сургаал (12:1-19:27)		
12:1-12	14:7-15	17:1-10
12:13-34	14:16-24	17:11-21
12:35-48	14:25-35	17:22-37
12:49-59	15:1-7	18:1-8
13:1-9	15:8-10	18:9-17
13:10-17	15:11-32	18:18-34
13:18-21	16:1-13	18:35-43
13:22-35	16:14-18	19:1-10
14:1-6	16:19-31	19:11-27

5. Хүний Хүү хүмүүсийн төлөө зовлон эдэлсэн нь (19:28–23:56)

19:28-44	21:25-28	22:54-65
19:45-48	21:29-33	22:66-71
20:1-8	21:34-36	23:1-7
20:9-18	21:37-38	23:8-12
20:19-26	22:1-13	23:13-25
20:27-47	22:14-23	23:26-32
21:1-9	22:24-38	23:33-49
21:10-19	22:39-46	23:50-56
21:20-24	22:47-53	

6. Хүний Хүүгийн жинхэнэ болохыг хүмүүсийн өмнө нотолсон нь (24:1-53)

24:1-12	24:36-49
24:13-35	24:50-53

Иохан (Бурханы мөнхийн Хүү)

Номын нэр болон зохиогч: II зууны эхэн үеэс эхлэн чуулган Сайн мэдээний дөрөв дэх номыг Зебедеен хүү, Иаковын дүү Иохантай холбож үзэх болжээ. Иохан, Иаков нарыг Есүс “Аянгын хөвгүүд” (Марк 3:17) гэж нэрлэсэн байдаг. Түүний эх Саломе, Есүсийг Галилд байхад нь Түүнд үйлчилж, мөн цовдлогдоход нь харж байжээ (Марк 15:40-41). Иохан Есүсийн арван хоёр шавийн нэг төдийгүй, Түүний “хайртай шавь” (13:23; 18:15-16; 19:26-27) байсан юм. Тэрээр Есүсийн хамгийн ойрын хүрээний шавь нарынх нь нэг байлаа. Есүс дүр хувирахдаа өндөр уул өөд дагуулан гарсан гурван шавийн (Матай 17:1) дунд Иохан байжээ. Түүнчлэн Иохан Петртэй ойр дотно харилцаатай байв. Христийг тэнгэр өөд өргөгдсөний дараа Иохан, Паулын адилтган хэлсэнчлэн, чуулганы “багананууд”-ын (Галат 2:9) нэг болсон юм.

Үнэнийг хэлэхэд, Сайн мэдээний дөрөв дэх номыг хэн бичсэн нь тодорхойгүй. Уг бичвэрт зохиогчийн нэр дурдагдаагүй байна. Сайн мэдээний ном нь бичиглэлийн хэв маягаараа захианаас ялгаатай учир үүнд гайхах явдалгүй юм. Эртний захидалын ердийн хэв маягийн дагуу Паул захидал бүрийнхээ эхэнд өөрийнхөө нэрийг бичдэг байсан. Сайн мэдээний дөрвөн номоос зохиогч нь ч өөрийнхөө нэрийг бичсэн нэг ч ном байдаггүй. Харин тэд өөрсдийгөө бичвэрийн дунд шууд бус байдлаар илчилсэн байдгаас гадна уламжлалын дагуу танигдсан байдаг.

Бичигдсэн огноо: МЭ 85–90 он. Энэ номыг Сайн мэдээний “дөрөв дэх” нь гэж чуулган үздэг бөгөөд Иохан үүнийг өтөл насандaa бичсэн хэмээн эртний чуулган итгэдэг байжээ. Тиймээс энэ номыг 85-95 оны хооронд бичсэн байх магадлалтай юм. Иохан 21:18, 23-р ишлэлд Петрийн өтлөх тухай, мөн Иохан түүнээс урт наслах тухай нэлээд хугацааг алгасан өгүүлдэг.⁶⁵

Сэдэв болон зорилго: Магадгүй, Библийн бусад номуудтай харьцуулбал Иохан өөрийнхөө Сайн мэдээний номын сэдэв ба зорилтыг хамгийн сайн тодорхойлсон гэж хэлж болох юм. Томасыг амилсан Аврагчтай уулзсаны дараа Иохан Сайн мэдээнийхээ зорилтыг ийнхүү тодорхой хэлсэн нь учиртай юм. Томас амилалтад эргэлзэж байсан (Иохан 20:24-25) бөгөөд тийнхүү эргэлзээгээ илэрхийлсэн даруй Эзэн шавь нарт үзэгдэж, Томаст хандан дараах үгсийг хэлсэн,

*Хуруугаа нааш нь хүргэ, Миний гарыг үз. Гараа нааш нь хүргэ, Миний хажсуу уруу хий.
Итгэлгүй бус, харин итгэлтэй бай гэхэд Томас Түүнд, ‘Эзэн минь, Бурхан минь’ гэв.
Есүс түүнд, ‘Чи Намайг харсан учраас итгэв үү? Хараагүй итгэсэн хүмүүс нь ерөөлтэй
еэ!’ гэжээ. (20:26-29)*

Үүний дараа Иохан хүмүүсийн анхаарлыг Есүст итгэх хэрэгцээ шаардлагад хандуулсан нь түүний номын сэдэв бөгөөд зорилго юм.

**Мөн энэ номд бичээгүй өөр олон тэмдгийг Есүс [Өөрийн] шавь нарын өмнө узүүлсэн юм.
Харин эдгээр нь Есүс бол Христ, Бурханы Хүү мөн гэдэгт та нарыг итгүүлэхийн тулд
бичигдсэн бөгөөд ингэснээр итгэлээр дамжуулан та нар Түүний нэрээр амьтай болох
юм. (20:30-31)**

Энэ зорилгынхoo дагуу Иохан Христийн бодгаль болон зорилгыг илчлэхийн тулд долоон гайхамшигт тэмдгийг сонгосон ба үүгээр дамжуулан хүмүүс Есүс бол Аврагч гэдэгт итгэх боломжтой байлаа. Эдгээр тэмдэг нь Есүсийн алдрыг харуулсан юм (Иохан 1:14; Исаиа 35:1-2; Иоел 3:18; Амос 9:13). Тэдгээр долоон тэмдэг нь:

1. Усыг дарс болгосон (2:1-11)
2. Түшмэлийн хүүг эдгээсэн (4:46-54)
3. Тахир дутуу хүнийг эдгээсэн (5:1-18)
4. Үй олон хүнийг хооллосон (6:6-13)
5. Нууран дээгүүр алхсан (6:16-21)
6. Төрөлхийн сохор хүнд хараа оруулсан (9:1-7)
7. Лазарыг амилуулсан (11:1-45)

Матай, Марк, Лукийн Сайн мэдээтэй харьцуулбал Иоханы онцгой сэдэв ба зорилго нь түүний Сайн мэдээний өвөрмөц шинж чанараар хялбархан ялгаралтадаг.

Иоханы Сайн мэдээг бусад гурван Сайн мэдээтэй харьцуулбал түүний илэрхийлэл ямар өвөрмөц болохыг харж болно. Иохан Есүсийн уг гарал, төрөлт, баптизм, сорилт, чөтгөрүүдийг зайлцуулсан түүх, сургаалт зүйрлэлүүд, дүр хувиралт, Эзэний Зоог, Гетсемани цэцэрлэг дэх шаналал болон тэнгэр өөдөр өргөгдсөн тухай өгүүлдэггүй. Харин Есүсийн Иерусалим дахь үйлчлэл, Иудей үндэстний баяр ёслолууд, Есүс хувь хүмүүстэй хэрхэн харилцаж (3:1-4:38; 18:28-19:16), шавь нартаа хэрхэн үйлчилж (13:1-17:26) байсан тухай онцлон өгүүлдэг. Уг Сайн мэдээний гол хэсэг нь Есүс бол Бурханы Хүү, Мессия мөн гэдгийг тунхаглан харуулдаг долоон гайхамшиг буюу “тэмдгүүдийн” тухай өгүүлсэн “Тэмдгүүдийн номд” (2:1-12:50) агуулагддаг. Түүнчлэн энэхүү “Тэмдгүүдийн номд” Есүсийн агуу хүүрнэлүүдийг багтаасан байх агаад эдгээр нь тухайн тэмдгүүдийг тайлбарлаж, утга учрыг нь тунхаглан зарладаг. Жишээ нь, Есүс 5000 хүнийг хооллосныхоо (6:1-15) дараа Өөрийгөө Амийн талх хэмээгээд, тэнгэрлэг Эцэг нь өртөнцөд амийг өгөхийн (6:25-35) тулд Өөрийг нь илгээсэн гэдгийг илчлэн харуулсан. Энэхүү дөрөв дэх Сайн мэдээний өөр нэг чухал онцлог шинж бол Есүсийн хэлсэн “Би бол” хэмээх тунхаглалууд юм (6:35; 8:12; 10:7, 9, 11, 14; 11:25; 14:6; 15:1, 5).

Энэхүү Сайн мэдээний өвөрмөц шинжийг зөв ойлгож авч үзэх хэрэгтэй. Анхнаасаа Сайн мэдээнүүд нь намтрин зорилгоор бичигдээгүй юм. Сайн мэдээг бичигчид маш их хэмжээний мэдээлэл дундаас өөрийнх нь зорилгыг гүйцэлдүүлж чадах материалыг сонгож авсан байдаг. Хэрэв Матай, Марк, Лук номд буй Есүсийн хэлсэн бүх үгсийг чангаар дуудан унших аваас энэ нь ердөө гурван цаг орчим л болно гэсэн тооцоо байдаг.⁶⁶

Христийн тухай Иохан номд: Христийн бурханлаг чанар нь Библийн олон хэсгийн байнгын сэдэв болдог ч гэсэн Есүсийг Бурханы биежсэн Хүү хэмээн Түүний бурханлаг чанарыг илүү хүчтэй илэрхийлсэн ном үүнээс өөр байхгүй. “Есүс гэдэг хүн” (9:11) хэмээн тодорхойлогдсон нэгнийг “Цорын ганц Хүү болох Бурхан” (1:18), “Амьд Бурханы Хүү, Христ” (6:69) буюу “Бурханы Ариун Нэгэн” (6:69) гэж бас нэрлэсэн байдаг.

Есүс Христийн бурханлаг чанарын тухай энэхүү тунхаглалыг Иоханы Сайн мэдээнд тэмдэглэгдсэн Есүсийн “Би бол” гэсэн тунхаглалууд улам бүр хүчтэй болгодог. Энэхүү долоон тунхаглал нь:

1. Би бол “амийн талх” (6:35)
2. Би бол “өртөнцийн гэрэл” (8:12)
3. Би бол “үүд” (10:7, 9)
4. Би бол “сайн хоньчин” (10:11, 14)
5. Би бол “амилалт ба амь” (11:25)
6. Би бол “зам, үнэн, амь” (14:6)

7. Би бол “усан үзмийн жинхэнэ мод” (15:1, 5)

Иоханы Сайн мэдээний Христийн бодгалийг дахин онцолсон өөр нэг өвөрмөц онцлог нь Есүсийг Бурханы Хүү гэдгийг баталсан таван гэрчлэл юм. Иохан 5:31-47 ишлэлд Есүс Өөрийг нь эсэргүүцэгчдийн асуултад хэрхэн хариулж байгаа тухай өгүүлдэг. Хэлж ярж байгаа зүйл нь Түүний гэрчлэлийг батлахад хангалтгүй байна хэмэн тэд буруутгасан учраас Есүс Өөрийнхөө тунхаглалыг үнэн зөв гэдгийг баталсан өөр гэрчлэлүүдээр тэдний буруутгал шударга бус гэдгийг харуулдаг. Эдгээр бусад гэрчлэлд Түүний Эцэг (5:32, 37), Иохан баптист (5:33), Түүний үйлдсэн гайхамшигууд (5:36), Судрууд (5:39) болон Моисе (5:46) багтдаг. Хожим 8:14-р ишлэлд Тэрээр Өөрийнх нь гэрчлэл үнэхээр үнэн гэдгийг тунхагласан. Хэд хэдэн тохиолдолд Есүс Өөрийгөө Хуучин гэрээний “Би байдал” буюу “Яавэ”-тэй адилтгасан байдал (4:25-26; 8:24, 28, 58; 13:19; 18:5-6, 8). Түүний бурханлаг чанарыг 1:1; 8:58; 10:30; 14:9; 20:28-р ишлэлүүдэд хамгийн сайн нотлон харуулсан буй.

⁶⁷

Хувийн Судлал: Агуулга

1. Танилцуулга: Бурханы Хүүгийн биежил (1:1-18)

- A. Христ Бурхан (1:1-2)
- B. Биежихийн өмнөх Христийн ажил (1:3-5)
- C. Христийн замыг засагч (1:6-8)
- D. Христээс татгалзсан нь (1:9-11)
- E. Христийн биежил (1:14-18)

2. Бурханы Хүү Өөрийгөө таниулсан нь (1:19-4:54)

- A. Иохан баптистаар дамжуулан (1:19-34)
- B. Иоханы шавь нарт (1:35-51)
- C. Канад болсон хурим дээр (2:1-11)
- D. Иерусалимын сүмд (2:12-35)
- E. Иохан баптистаар дамжуулан (3:22-36)
- F. Самари эмэгтэйд (4:1-42)
- G. Капернаумын нэгэн түшмэлд (4:43-54)

3. Бурханы Хүүг эсэргүүцсэн нь (5:1-12:50)

A. Иерусалимд болсон баяр дээр (5:1-47)		
5:1-17	5:33-35	5:39-47
5:18-24	5:36	
5:25-32	5:37-38	
B. Галилд Дээгүүр Өнгөрөх баярын үеэр (6:1-71)		
6:1-14	6:26-40	6:59-65
6:15-25	6:41-58	6:66-71
B. Иерусалимд Майхан баяр дээр (7:1-10:21)		
7:1-24	8:12-30	9:13-34
7:25-39	8:31-47	9:35-41
7:40-53	8:48-59	10:1-21
8:1-11	9:1-12	
G. Иерусалимд сүмийг Шинэтгэн ариусгасны баяр дээр (10:22-42)		
10:22-30	10:31-42	
D. Бетанд (11:1-12:11)		
11:1-16	11:38-46	12:1-11
11:17-29	11:47-53	
11:30-37	11:54-57	

E.	Иерусалимд (12:12-50)		
	12:12-19	12:27-36	12:44-50
	12:20-26	12:37-43	
4. Бурханы Хүүгийн зааварчилгаа (13:1–16:33)			
A.	Уучлалын тухай (13:1-20)	13:1-4	13:5-20
B.	Өөрөөс нь урвах тухай (13:21-30)		
C.	Явах гэж байгаа тухайгаа (13:31-38)		
D.	Диваажингийн тухай (14:1-15)	14:1-6	14:7-15
D.	Ариун Сүнсний тухай (14:16-26)		
E.	Амар амгалангийн тухай (14:27-31)		
F.	Үр жимстэй байх тухай (15:1-17)	15:1-11	15:12-17
G.	Ертөнцийн тухай (15:18–16:4)	15:18-27	16:1-4
H.	Ариун Сүнсний тухай (16:5-15)		
I.	Өөрийнхөө эргэж ирэх тухай (16:16-33)	16:16-22	16:23-33
5. Бурханы Хүүгийн зуучлан залбирал (17:1-26)			
	17:1-12	17:13-21	17:22-26
6. Бурханы Хүүг цовдолсон нь (18:1–19:42)			
	18:1-11	19:1-15	19:31-37
	18:12-24	19:16-22	19:38-42
	18:25-27	19:23-27	
	18:28-40	19:28-30	
7. Бурханы Хүүгийн амилалт (20:1-31)			
A.	Хоосон булаш (20:1-10)		
B.	Амилсан Эзэн харагдсан нь (20:11-31)		
	20:11-18	20:24-29	
	20:19-23	20:30-31	
8. Төгсгөл: Тэнгис хавийн газраар харагдсан нь (21:1-25)			
A.	Долоон шавьдаа харагдсан нь (21:1-14)	21:1-11	21:12-14
B.	Петрт хандаж хэлсэн үгс (21:15-23)	21:15-17	21:18-23
C.	Сайн мэдээний төгсгөл (21:24-25)		

Үйлс

(Сайн мэдээ түгэн дэлгэрсэн нь)

Номын нэр болон зохиогч: Хэдийгээр Үйлс номд зохиогчийн нэрийг дурдаагүй ч түүнийг Лук бичсэн болох нь бусад баримт нотолгоонуудаар батлагддаг. Үйлс ном бол эмч Лукаас Теофилд хандан “Есүс юу үйлдэж, зааж эхэлснээс авахуулан бүгдийг” бичсэн хоёр хэсэг сургаалын хоёр дахь хэсэг нь юм.

Нэрний хувьд бүх грек гар бичмэлүүдэд “Үйлс”, эсвэл “Элч нарын үйлс” гэсэн байдаг. Гэхдээ хэрхэн, яагаад ийнхүү нэрлэх болсон нь тодорхойгүй. Үнэндээ энэ номд бүх элч нарын үйлсийг өгүүлдэггүй

учраас “Элч нарын үйлс” гэсэн нь оновчтой нэр биш юм. Харин Петр, Паул хоёрын тухай түлхүү онцолсон байдаг ч Сүнсирэх тухай амлалт нь Сайн мэдээг Сүнсний хүчээр дэлхий даяар тунхаглах бүх элч нарт өгөгдсөн байлаа (1:2-8). Сүнсирэх үеэс эхлэн христитгэл түгэн дэлгэрсэн тухай Үйлс 2-р бүлэгт өгүүлдэг учраас энэ номыг “Ариун Сүнсний үйлс” гэж нэрлэсэн бол тохирох байсан гэж олон хүн үздэг. Үйлс номд гардаг гол хүмүүс нь Петр, Иохан, Стефан, Филип, Иаков, Барнаб, Силас, Паул нар юм.

Бичигдсэн огноо: МЭ 61 он. Уг ном бичигдсэн цаг хугацааны талаар Стэйнли Таузэнт ийнхүү дүгнэжээ:

Үйлс ном нь МЭ 70 онд Иерусалимыг сүйрэхээс өмнө бичигдсэн байж таарна. Эс бөгөөс ийм дуулиантай үйл явдлыг дурдалгүй өнгөрөх учиргүй гэдэг нь мэдээж. Уг номын үндсэн нэг сэдэв нь иудейчүүд Есүс Христээс татгалзсан тул Бурхан тэднээс эргэж, Харь үндэстэн уруу хандсан тухай агаад энэ талаас нь авч үзвэл үнэн байх магадлалтай юм.

Паулыг МЭ 66-68 үед нас барсан гэж үздэг бөгөөд хэрвээ энэ явдал Үйлс ном бичигдэхээс өмнө болсон юм бол Лук түүний үхлийн талаар дурдаагүй өнгөрөх нь юу л бол.

Түүнчлэн МЭӨ 64 онд болсон Ромын их түймрийн дараа эхэлсэн Нерогийн үеийн (Неро хаанд хамаатай) хавчлагын талаар Лук дурдаагүй байдаг.

Түүнээс тэр үед Неро хаан чуулганыг устгахын төлөө улайран тэмцэж байсан бөгөөд Үйлс номд дэлгэн тавьсан хамгаалалт нь түүнийг ятгаж болиулахад (түүний бодлыг өөрчлөхөд) тэгтлээ нөлөөлж чадахааргүй байлаа.

Үйлс ном МЭ 60-62 оны үед бичигдсэн гэдэгтэй уламжлалт үзэлтэй эрдэмтэд ихэнхдээ санал нэгддэг. Хэрэв тийм бол энэ ном Ром юмуу, аль эсвэл Ром, Кайсарид хоёуланд нь бичигдсэн байх боломжтой. Уг номыг бичиж байх үед Паул шоронгоос суллагдах тун дөхсөн, эсвэл дөнгөж суллагдаад байсан бололтой.⁶⁸

Сэдэв болон зорилго: Үйлс ном нь Шинэ гэрээний номуудыг хооронд нь холбож өгдгөөрөө бусад номуудаас онцгой юм. Энэ нь Лукийн хоёр дахь ном учраас Сайн мэдээний номуудад тэмдэглэсэнчлэн, Есүсийн “*юу үйлдэж, зааж эхэлснээс авахуулаад*” (1:1) үргэлжлүүлэн өгүүлдэг. Энэ номд Христийн дээш өргөгдсөн үеэс Шинэ гэрээний захидлуудын үе хүртэлх түүхийг хүүрнэдэг. Есүс Христ Ариун Сүнсээр дамжуулан ажил үйлчлэлээ үргэлжлүүлж, Үтийт тунхаглан, Христийн Бие болох чуулганыг байгуулахаар илгээгдсэн элч нарын дотор ажиллаж байгааг бид уг номоос тодорхой хардаг. Үйлс ном нь Сайн мэдээний номууд ба Захидлуудыг холбодог түүхэн холбоос юм.

Энэ ном нь зөвхөн ийм холбоос болоод зогсохгүй биднийг Паулын амьдрал болон түүний захидлуудын түүхэн нөхцөл байдалтай танилцуулдаг. Үйлс номд чуулганы эхний 30 жилийн амьдралыг хүүрнэн өгүүлдэг.

Стэйнли Таузант Үйлс номын зорилгын талаарх янз бүрийн үзэл бодлыг нэгтгэн дүгнэснийхээ дараа ийнхүү бичсэн байдаг:

Үйлс номын зорилгыг дараах байдлаар дүгнэж болох юм: Хаанчлалын тухай мэдээг иудейчүүдээс Харь үндэстнүүд уруу, Иерусалимаас Ром уруу хандуулсан Лукийн Сайн мэдээг тайлбарлах. “Хэрэв христитгэл нь Хуучин гэрээ болон иудеизмд үндэслэгдсэн юм бол яаж дэлхий дахини шашин болсон юм бэ?” гэсэн асуултад Лукийн Сайн мэдээ хариулдаг. Үйлс ном нь Лукийн Сайн мэдээний үргэлжлэл болохынхоо хувьд мөн ийм асуудалд хариулт өгдөг.⁶⁹

Үйлс 1:8-р ишлэлд Үйлс номын сэдвийг маш тодорхой илэрхийлсэн бөгөөд энэ нь Ариун Сүнс Бурханы хүмүүсийн дотор оршиж, Аврагчийг Иерусалим (төрөлх нутаг) болон бүх Иуда, Самари (хөрш зэргэлдээ болон эргэн тойрны нутаг), тэр ч байтугай ертөнцийн хязгаар хүртэл (дэлхий) гэрчлэх эрхийг тэдэнд олгодог тухай ажээ.

Христийн тухай Үйлс номд: Үйлс номын номлолын гол сэдэв нь амилсан Аврагч юм. Хуучин гэрээний Судрууд, түүхэн амилалт, элч нарын гэрчлэл болон Ариун Сүнсний ятган сэнхрүүлэгч хүч – энэ бүгд Есүс бол Эзэн бөгөөд Христ (2:22-36; 10:34-43) гэдгийг гэрчилдэг. “Түүнд итгэсэн хэн боловч Түүний нэрээр нүглийн учалыг хүлээн авдаг гэж бүх эш үзүүлэгчид Түүнийг гэрчилдэг гэв.” (10:43) “Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй.” (4:12)⁷⁰

Хувийн Судлал: Агуулга

1. Иерусалим дахь гэрчлэл (1:1–6:7)

- | | | |
|---|--------------------------------------|---------|
| A. Сонгогдогсдыг хүлээсэн нь (1:1–2:47) | Хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл 1 | |
| 1:1-8 | 1:12-26 | 2:14-36 |
| 1:9-11 | 2:1-13 | 2:37-47 |
| B. Иерусалим дахь Чуулганы өргөжилт (3:1–6:7) | Хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл 2 | |
| 3:1-10 | 4:13-31 | 5:17-32 |
| 3:11-26 | 4:32-37 | 5:33-42 |
| 4:1-12 | 5:1-16 | 6:1-7 |

2. Бүх Иуда болон Самари дахь гэрчлэл (6:8–9:31)

- | | | |
|---|--------------------------------------|---------|
| A. Стефан итгэлийнхээ улмаас алагдсан нь (6:8–8:1a) | | |
| 1) Стефана г баривчилсан нь (6:8–7:1) | | |
| 2) Стефаны хэлсэн үг (7:2-53) | | |
| 7:2-8 | 7:17-29 | 7:44-53 |
| 7:9-10 | 7:30-34 | |
| 7:11-16 | 7:35-43 | |
| 3) Стефан уруу дайрсан нь (7:54–8:1a) | | |
| B. Филипийн үйлчлэл (8:16-40) | 8:4-24 | 8:25-40 |
| C. Саулын мэдээ (9:1-19a) | | |
| D. Саулын зөрчилдөөн (9:196-31) | Хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл 3 | |

3. Ертөнцийн хязгаар хүртэл гэрчилсэн нь (9:32–28:31)

- | | | |
|---|--------------------------------------|----------|
| A. Чуулган Антиох хүртэл өргөжин тэлсэн нь (9:32–12:24) | Хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл 4 | |
| 9:32-43 | 10:34-48 | 12:1-19 |
| 10:1-23 | 11:1-18 | 12:20-24 |
| 10:24-33 | 11:19-30 | |
| B. Чуулган Бага Азид өргөжин тэлсэн нь (12:25–16:5) | Хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл 5 | |
| 13:1-25 | 14:8-18 | 15:30-35 |
| 13:26-43 | 14:19-28 | 15:36-41 |
| 13:44-52 | 15:1-11 | 16:1-5 |
| 14:1-7 | 15:12-29 | |
| C. Чуулган Эгийн тэнгис хавийн нутгаар өргөжин тэлсэн нь (16:6–19:20) | Хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл 6 | |
| 16:6-13 | 17:1-9 | 18:1-21 |
| 16:14-21 | 17:10-15 | 18:22-28 |
| 16:22-34 | 17:16-21 | 19:1-10 |
| 16:35-40 | 17:22-34 | 19:11-20 |
| D. Чуулган Ром хүртэл өргөжин тэлсэн нь (19:21–28:31) | Хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл 7 | |
| 19:21-41 | 22:1-30 | 26:1-32 |
| 20:1-12 | 23:1-11 | 27:1-13 |
| 20:13-16 | 23:12-22 | 27:14-44 |
| 20:17-38 | 23:23-35 | 28:1-10 |
| 21:1-14 | 24:1-27 | 28:11-29 |
| 21:15-26 | 25:1-22 | 28:30-31 |
| 21:27-40 | 25:23-27 | |

2-р хэсэг

Паулын Захидлууд

Танилцуулга: Бид түүхэн номуудыг (Сайн мэдээний номууд болон Үйлс) судалж дуусаад, одоо Шинэ гэрээний 21 захидалыг үзэж эхлэх гэж байна. Хэрэв Илчлэлт номыг (үнэндээ энэ нь захидал мөн [Илчлэлт 1:4-ийг үз]) захидалд оруулбал нийтдээ 22 захидал болно. Гэхдээ түүний апоклипс онцгой чанарын улмаас бид энэ судалгаандаа түүнийг Шинэ гэрээний эш үзүүллэгийн номд багтааж байна. Захидлуудыг ерөнхийд нь Паулын болон Паулын бус (Ерөнхий) захидалууд гэж ангилдаг. Харин Паулын захидалуудыг дотор нь чуулганд болон пасторуудад (хоньчдод) бичсэн захидал гэж хоёр ангилдаг. Тэрээр чуулганд хандан найман захидал, харин пасторуудад хандан дөрвөн захидал бичсэн байдаг. Эдний хойноос Еврей итгэгчдийн найман захидал залган ордог. Сайн мэдээний утга санааг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэх явцдаа христитгэгчид олон асуулттай тулгараах нь мэдээж юм. Харин эдгээр захидал нь энэ бүх асуултад хариу өгч, Христийн бодгаль болон ажлыг тайлбарлаж, Сайн мэдээний үнэнийг итгэгчдийн амьдралд хандуулдаг.

Паулын уг сурвалж: Паул олон жилийн турш Тарсын Саул гэдэг нэрээрээ олны танил байжээ. Тэрээр Киликийн Тарс хотод төрсөн агаад эцэг эх нь иудей хүмүүс байв. Паул зөвхөн иудей хүн байгаад зогсохгүй, түүний өөрийнх нь хэлснээр, тэр фарисайн хүү фарисай (Үйлс 23:6), Бениамын овгийн хүн (Филиппой 3:4-5), еврей хүнээс төрсөн еврей (еврей буюу арамей хэлээр ярьдаг) байлаа. Тэрээр майхан хийж зarah арга ухаанд залуугаасаа суралцсан нь илэрхий байдаг (Үйлс 18:3). Түүний хэлснээс үзвэл, тэр залуу насандаа Иерусалимд очиж, Хиллелийн сургуулийн суут багш, олонд алдартай Гамалиел гэгч хүний дор сурчээ (Үйлс 22:3). Паул ийнхүү суралцаж байхдаа өвөг дээдсийнхээ ёс заншилд илүү сүжигтэй байж, Иудейн шүтлэг дотор үе чацуутнуудаасаа онцгойрон дэвшиж байжээ (Галат 1:14).

Иудейн шүтлэгт ийм их сүжигтэй байсан нь түүнийг бүх зүрх сэтгэлээрээ чуулганыг хавчихад нөлөөлжээ. Залуухан фарисай Паул, Стефаныг чуuluугаар шидэж алсан явдлыг сайшаасан байдал (Үйлс 7:58–8:3). Эрэгтэй, эмэгтэй гэж ялгалгүй бүх христитгэгчдийн эсрэг явуулсан энэ компанийт ажлын үеэр Паул итгэгчдийг баривчлах тухай бичгийг ахлах тахилчаасаа аваад, Христийн чуулганыг устгахаар өөр хотууд уруу явжээ (Үйлс 26:10-11; Галат 1:13). Тийнхүү нэгэн удаа ийм ажлаар Дамаск орохоор явж байх замдаа Паул Есүст итгэжээ (Үйлс 9).

Түүнчлэн Паул грек боловсрол эзэмшсэн учраас грекийн соёлыг гаргууд сайн мэддэг байв (Үйлс 17:28; Тит 1:12). Тийм ч учраас тэр грекийн философиyg сайн ойлгодог байжээ. Тэрээр өөрөөс нь өмнө амьдарч байсан болон өөрийнх нь үеийн зохиолчдын зүйр цэцэн үгсээс олныг мэддэг байв. Үүнээс гадна Паул Ромд төрсөн учраас Ромын иргэн байсан юм (Үйлс 22:28). Тийм ч учраас Паул Филиппойд широнд хоригдож байхдаа Ромын иргэний хувьд цезарьтай заргалдаа боломжтой байсан аж (Үйлс 16:37-39).

Дараа нь, Паул сайн мэдээг Харь үндэстнүүдэд хургэхээр сонгогдсон нэгэн байхын төлөөнөө гайхалтай бэлтгэгджээ. Тэрээр “*заримыг нь аврахын тулд бүх хүнд би бүх юм болж байлаа*” (1 Коринт 9:22) хэмээн хэлж чадсан юм.

Паул Христэд итгэсэн нь: Есүс Христийн чуулганыг тууштайгаар идэвхийлэн хавчиж байсан Паул Дамаск уруу явах замдаа дахин амилсан, алдаршуулагдсан Христтэй уулзсан нь түүний амьдралыг орвонгоор нь өөрчилсөн юм (Үйлс 9:3-30).

Есүс бол Мессия бөгөөд Бурханы Хүү гэдгийг Паул үгүйсгэдэг байсан. “*Харагтуун. Тэнгэр нээгдэхийг болон Бурханы баруун талд зогсож байгаа Хүний Хүүг би харж байна*” (Үйлс 7:56) хэмээн Стефаныг хэлэх үед ч Паул Христийг үхлээс амилсан гэдэгт итгээгүй юм. Тэрээр “Худалч!” хэмээн хашхираад, түүнийг чуuluугаар шидэж байжээ. “*Түүнийг алсан явдлыг Саул сайшаан*” зогсож байлаа. Харин Дамаскийн ойролцоо Эзэн Есүс түүнтэй ярих үед тэрээр Стефаны зөв, өөрийнх нь буруу байсныг ойлгосон юм. Есүс үнэхээр амьд байжээ! Тэрээр Бурханы Хүү мөн болох нь гарцаагүй үнэн байв. Ингээд Саул (одоо Паул) Дамаскийн синагогуудад Христ бол Аврагч мөн хэмээн тунхаглаж эхэлжээ. Хэдийгээр

энэ явдал гэнэтийн, сэтгэл догдлом зүйл байсан боловч баларшгүй үр нөлөөгөө үлдээсэн юм. Энэ нь Иерусалимд анх удаа ирэхээсээ өмнө Араб болон Дамаскт өнгөрөөсөн үеийг нь тодорхой тайлбарлаж болох юм (Галат 1:16-19). Дараа нь Паул нутаг уруугаа буцжээ. Түүний 8-10 жилийн ажил үйлчлэлийн талаар тун бага мэдээлэл үлдсэн байдаг.⁷¹

Паулын захицуудын онцлог шинжүүд: Паулын захицуудыг нэг бүрчлэн тоймлон үзэхээсээ өмнө тэдгээрийн зарим онцлог шинжүүдийг харцгаая.⁷²

Шоронгийн Захицууд

Ефес, Филиппой, Колоссай, Филемон номуудыг Паул шоронд байхдаа бичсэн учраас эдгээрийг заримдаа “Шоронгийн захицууд” гэж нэрлэх нь бий. Эдгээр захидалд Паулын хоригдож байсан нөхцөл байдлын талаар дурдсан байдаг (Ефес 3:1; 4:1; 6:20; Филиппой 1:7, 13; Колоссай 4:10, 18; Филемон 1, 9, 10).

Паул дээрх агуу захицуудыг нэг бол Ромын цэргийн хуаранд, эсвэл өөрийн хөлсөлсөн байранд (Үйлс 28:30) хоригдож байх үедээ бичсэн байдаг бөгөөд энэ нь Бурхан бидний зовлон шаналтыг хэрхэн авч, түүнийг Өөрийнхөө алдрын төлөө, бидний үйлчлэлийн боломжийг өргөжүүлэхийн (Филиппой 1:12-13) тулд хэрхэн ашигладгийг харуулж буй гайхамшигт дурслэл юм. Хэдийгээр биднийг хорьж saatuulж болох ч Бурханы Үг хэзээ ч хоригдоггүй гэдгийг энэ түүх харуулдаг (2 Тимот 2:9).

Хоньчны Захицууд

Паулын өөр нэг чухал бүлэг захильтыг “Хоньчны захицууд” гэж ерөнхийд нь нэрлэдэг. Тимот, Тит (1 ба 2 Тимот ба Тит) нарт бичсэн гурван захидалд энэ нэрийг хэрэглэсэн байдаг. Анхандаа тэдгээрийг Филемонтой хамтад нь ерийн л нэг хувийн захицууд гэж үзэж байсан боловч Чуулганы амьдралтай маш их холбоотой байсан учраас “Хоньчны захицууд” гэж нэрлэх болжээ. Хувь хүнд хаяглагдсан учраас эдгээр номд хувийн харилцаа их мэдрэгдэг боловч нэлээд албаны шинж чанартай мэдээллүүд ч бас байдаг. Паул Бурханы гэр болсон чуулганыг хэрхэн халамжлах талаар заавар зөвлөмж өгөхийн тулд Тимот, Тит нарт хандан эдгээр захильтыг бичжээ (1 Тимот 3:14-15; 4:6-15 уд.харьц, 2 Тимот 2:2).

Эдгээр захидалд чуулганы засаглал, бодлого болон үйл хэргийн тухай өгүүлээд, чуулганыг эрүүл саруулаар хоньчлоход энэ бүх зүйл амин чухал гэж үзсэн байдаг. Эцэст нь хэлэхэд, Бурхан бидний хоньчлох үүрэг хариуцлагад тус дэм болж, нутгийн чуулганыг удирдан чиглүүлж, өсгөн хөгжүүлэхэд туслах зорилгоор эдгээр номыг бичүүлсэн юм.

Энэ үүднээс бид нэгэн чухал ажиглалтыг хийх хэрэгтэй юм. Паулын бичсэн арван гурван захидаас эдгээр нь хамгийн сүүлчийнх нь аж. Энэ асуудал яагаад тийм чухал гэж? Хэрэв эдгээр захидалд чуулганы дэг журам, үйлчлэл, зохион байгуулалтын тухай өгүүлдэг юм бол яагаад хамгийн эхэнд бичигдээгүй юм бэ? Хэрэв өнөөдөр та бид иймэрхүү ажил хийхээр зэхэж байгаа бол хамгийн эхлээд удирдлагын зохион байгуулалт, бүтцийг цэгцлээд, дараа нь үзэл баримтлалын талаар санаа тавих байсан байх.

Тиймээс удирдлагын зохион байгуулалт, дэг жurmын талаар бодож эргэцүүлэх шаардлагатай зарим нэг саналыг доор өглөө:

Санал 1: Зохион байгуулалт, дэг журам мэдээж чухал. Чуулган бол сүнслэг бие бөгөөд итгэгч хүн бүр түүний онцгой үүрэг, зорилго бүхий нэг эрхтэн юм. Чуулганы үйл ажиллагаанд нэн шаардлагатай зүйл бол зөв теологи (сургаал) ба Бурханы үгийн талаарх ойлголт бөгөөд үүнийг Христтэй адилхан болох амьдралд хувьчлан хэрэгжүүлэх явдал юм. Энэ нь Чуулганы сүнслэг болон ёс суртахууны үндэс суурийг бүрэлдүүлдэг ба энэ суурин дээр бидний арга барил, стратеги, удирдлага зохион байгуулалт тулгуурладаг. Тиймээс, хэдийгээр бидний арга барил өөр байж болох ч Бурханы Үгийн сүнслэг болон ёс суртахууны зарчмуудтай хэзээ ч зөрчилдөх ёсгүй.

Жишээ нь, Чуулганыг дэмжих өргөл нь бүх нийтийг хамарсан, эсвэл хувийн аль нь ч байж болно. Гэхдээ мөнгө цуглуулах, өргөл хандив өргөх үйл ажиллагааг Библийн зарчмуудын дагуу явуулах хэрэгтэй. Итгэгчид сайн дурын үндсэн дээр өргөх ёстой бөгөөд энэ зарчмыг зөрчсөн аливаа аргыг хэрэглэж болохгүй (2 Коринт 9:6-10).

Санал 2: Чуулган нь Угийг зөв тайлбарласан, зөв сургаал дээр үндэслэгдсэн байх ёстой (2 Тимот 2:15). Бурханы бодит үнэн ба энэхүү үнэнийг сүнсний хувьд боловсорсон хүмүүс амьдралд хэрэгжүүлэх явдал нь Чуулганы эрүүл саруул байдалд амин чухал юм (1 Тимот 3:1-10). Итгэгчид зөвхөн уламжлал юмуу, нөхцөл байдал дээр үндэслэн чуулганыг авч явах гэж хичээх үед чуулган Библийн дагуу бус, сүнслэг хүсэл тэмүүлэлгүй, Бурханы төлөвлөсөн үйл ажиллагааг явуулах чадамжгүй байгууллагаа болж хувирдаг.

Тэгэхээр, эдгээр ном нь чуулганы дэг журмын талаарх өмнө дурдагдаагүй асуудлыг хөндөн тавьдаг. Бурхан чуулганд зориулсан тусгай дэг журмын талаар зааварчилгаа өгөхөөсөө өмнө Ром, 1 ба 2 Коринт, Галат, Ефес, Филиппой, Колоссай номуудыг Чуулганд өгсөн. Яагаад тэр вэ? Байгууллага чухал учраас уу? Үгүй ээ! Харин байгууллага болон удирдлага нь чуулганы өсөлт хөгжилтөд тэргүүн зэргийн бус ч, хоёрдугаар зэргийн ач холбогдолтой учраас тэр юм. Мөн эрүүл саруул сургаал, сүнслэг байдал нь Бурханы жишигт нийцэхүйц үр нөлөөтэй үйлчлэлийг төрүүлж, бүхий л төрлийн үйлчлэлд Христийн сүнс ба зан чанарыг тунхаглан харуулдаг.

Паулын захидалтууд нь Эзэн Есүс Христ болон Сайн мэдээний дамжуулж буй мэдээ, мөн Түүнтэй нэгдсэн итгэгчдийн нэгдлийн талаарх түүний ижил төстэй болон ялгаатай онцлолын талаар цохон тэмдэглэсэн байдаг. Дараах хүснэгтээс ялгааг нь харна уу:

Эзэн Есүсийг онцолсон нь	
Ром	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы хүч
1 Коринт	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы мэргэн ухаан
2 Коринт	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы амар тайван
Галат	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы зөвт байдал
Ефес	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы баялаг
Филиппой	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы хангалаан байдал
Колоссай	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы дүүрэн байдал
1 Тесалоник	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы амлалт
2 Тесалоник	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы шагнал
1 Тимот	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы зуучлагч
2 Тимот	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы шүүгч
Тит	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы ээлдэг байдал
Филемон	Христ бол бидэнд өгөгдсөн Бурханы найдвэр

Сайн мэдээний мэдээг онцолсон нь	
Ром	Сайн мэдээ болон түүний мэдээ
1 Коринт	Сайн мэдээ болон түүний үйлчлэл
2 Коринт	Сайн мэдээ болон түүний үйлчлэлүүд
Галат	Сайн мэдээ болон түүний гажуудуулагчид
Ефес	Сайн мэдээ болон түүний тэнгэрлэг байдал
Филиппой	Сайн мэдээ болон түүний дэлхийн байдал
Колоссай	Сайн мэдээ болон түүний гүн ухаанууд
1 Тесалоник	Сайн мэдээ болон Чуулганы ирээдүй
2 Тесалоник	Сайн мэдээ болон антихрист
1 Тимот	Сайн мэдээ болон түүний пасторууд
2 Тимот	Сайн мэдээ болон түүнийг эсэргүүцсэн нь
Тит	Сайн мэдээ болон түүнийг хэрэгжүүлсэн нь
Филемон	Сайн мэдээ болон түүний хамаарал

Итгэгчдийн нэгдлийн талаарх Сайн мэдээний онцлог	
Ром	Христ доторх зөвтгөл
1 Коринт	Христ доторх ариусгал
2 Коринт	Христ доторх тайтгарал
Галат	Христ доторх эрх чөлөө
Ефес	Христ доторх өргөмжлөл
Филиппой	Христ доторх баяр баходал
Колоссай	Христ доторх бүрэн гүйцэд байдал
1 Тесалоник	Христ доторх өөрчлөлт
2 Тесалоник	Христ доторх нөхөн төлбөр
1 Тимот	Христ доторх тэмүүлэл
2 Тимот	Христ доторх шийдвэр төгс байдал
Тит	Христ доторх идэвхжүүлэлт
Филемон	Христ доторх сэдэлжүүлэлт

Ром

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы хүч)

Номын нэр болон зохиогч: Уг захидалд өгүүлсэнчлэн, үүнийг бичигч нь Паул юм (1:1). Анхны чуулганы үеэс авахуулаад энэ захидалыг Паулынх гэж бараг бүгд итгэж иржээ. Паулын амьдралын талаар бүгдэд танил болсон баримтуудтай яг тохирсон түүхэн хэсгүүд уг захидалд олон байдаг. Энэ номын онолын агуулга нь элч Паулын бусад бичвэрүүдтэй таарч байгааг бусад захидааудтай нь харьцуулан хялбархан харж болно.

Паулын “хамгийн агуу бүтээл” хэмээн нэрлэгддэг Ром номыг тэрээр Ромын чуулганд хандан бичсэн учраас ийнхүү нэрлэжээ (1:7, 15). Паул Ромд чуулган байгуулаагүй боловч Харь үндэстнүүд уруу дуудагдсан элч болохынхоо хувьд Ромын итгэгчид дээр очиж (15:22-23), итгэлээрээ тэнд чуулган байгуулж, улмаар түүндээ Сайн мэдээ тунхаглахыг олон жил хүсжээ (1:13-15).

Ромд үйлчлэхийг хүссэн тэрбээр тийшээ очих бэлтгэл болгон Ром номыг бичжээ (15:14-17). Паул Палестины ядууст зориулан хандив цуглуулж байх үедээ Коринтоос энэ захидалыг бичсэн байна. Тэрээр цуглуулсан мөнгөө хүргэж өгөхөөр Коринтоос Иерусалим уруу явсан бөгөөд тэндээсээ цаашаа Ром, улмаар Испани хүрнэ гэж төлөвлөж байсан (15:24) боловч энэ төлөвлөгөө нь бүтээгүй юм. Эцэст нь, Паул Ромд очсон боловч харамсалтай нь широнгийн хоригдол болон хүргэгджээ. Коринтын ойролцоо Кенхрей хотын чуулганы итгэгч Фойбе (16:1) энэ захидалыг Ромд хүргэсэн бололтой.

Бичигдсэн огноо: МЭ 57–58 он. Ром ном нь Паулын илгээлтийн гурав дахь аяллын сүүлээр буюу МЭ 57-58 онд бичигджээ (Үйлс 18:23–21:14; Ром 15:19). Ром 15:26-д Паулын хэлснээс үзвэл, тэрээр Македони болон Ахайн (Коринт байсан газар) чуулгануудаас хэдийнээ хандив хулээн аваад байсан бололтой. Өөрөөр хэлбэл, тэр Коринтод аль хэдийн ирсэн байжээ. Харин Коринтын чуулганд захидал бичих үедээ Паул тэнд хараахан очоогүй байсан юм. Тэгэхлээр МЭ 55 онд Коринтын чуулганд бичсэн захидааудын (уд.харьц, 1 Коринт 16:1-4; 2 Коринт 8-9) дараа Ром ном бичигдсэн болж таарч байна.

Сэдэв болон зорилго: Түүний зарим захидалд тодорхой асуудлын талаар өгүүлдэг бол Ром ном тийм биш. Ром номыг бичих болсон гурван шалтгаан байдаг. **Эхнийх нь**, Паул Иерусалимаас хүрч ирээд, Ром уруу явах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдэх, түүний энэ айлчлалд тэндхийн чуулганыг бэлтгэх зорилготой байсан (15:24, 28-29 уд.харьц, Үйлс 19:21). Паул тэдэнд өөрийнхөө төлөвлөгөөнүүдийг танилцуулж, тэдгээрийнх нь биелэлтэд оролцон, бас залбирахыг тэднээс хүссэн (15:30-32). **Хоёр дахь** зорилго нь гэвэл, Бурханы тунхагла хэмээн өөрт нь өгсөн Сайн мэдээг бүрэн дүүрэн, дэлгэрэнгүй тунхаглах явдал байсан юм. Паул “*Ромд байгаа та нарт ч мөн сайн мэдээг тунхаглахыг би маш их хүсэж байна*” (1:15) хэмээн хэлэхдээ тэрээр зөвхөн тэдэнд тунхаглахад бэлэн байгаад зогсоогүй, тэднийг Сайн мэдээний утга агуулгыг тодорхой ойлгож, өнгөрсөн (зөвтгөл буюу хэн нэгнийг зөвт хэмээн тунхаглах), одоо (ариусгал буюу тусгаар байлгах), ирээдүйн (алдаршуулал буюу Христийн алдрыг хуваалцах) бүхий л амьдралд хандуулан өргөжүүлэсэй гэж хүссэн. **Гурав дахь** зорилго нь, “Сайн мэдээ нь Хууль болон Хуучин гэрээний хөвч

хөндүүлэх ёслол гэх мэт зүйлийг яах бол? Иудейчүүдэд юу тохиолдох бол? Бурхан иудейчүүдийг хойш тавьсан уу? Тэр иудейчүүдэд өгсөн амлалтаа мартсан уу?” гэх мэт Ром дахь иудей болон Харь үндэстэн итгэгчдийн дунд аянаа урган гарч ирж байсан асуултуудтай холбоотой байсан. Паул эдгээр асуултад хариулж, иудей болон Харь үндэстнүүдэд зориулсан Бурханы авралын төлөвлөгөөг тайлбарласан.

Ром номын 1:16-17 ишлэлд Паулын хөндсөн сэдэв маш тодорхой байдаг. Бурхан нүгэлтнийг хэрхэн авардаг тухай элч энд өгүүлдэг. Эдгээр ишлэлд уг захидлын бүх агуу сэдвүүд нэг дор багтсан байдаг. Тэдгээр нь: Сайн мэдээ, Бурханы хүч чадал, аврал, итгэдэг хүн бүр, Бурханы зөвт байдал, иудей болон Харь үндэстнүүдийн тухай юм. Уг захидлын сэдэв ба агуулгыг Чарльз Райр ийнхүү гайхалтай дүгнэн хэлжээ:

Паулын бусад захидлуудаас Ром ном нь итгэлээр зөвтгөгдөх үзэл баримтлалыг илүү системтэйгээр гарган тавьдаг. Уг захидлын сэдэв нь Бурханы зөвт байдлын тухай юм (1:16-17). Байгалийн илчлэлт (Ром 1:19-20), нүглийн түгээмэл шинж чанар (Ром 3:9-20), зөвтгөл (Ром 3:24), эвлэрүүлэл (Ром 3:25), итгэл (Ром 4:1), анхны нүгэл (Ром 5:12), Христтэй нэгдэх тухай (Ром 6:1), Израилийг сонгосон ба түүнээс татгалзсан тухай (Ром 9-11), сүнслэг бэлгүүд (Ром 12:3-8) болон эрх мэдэлд захирагдах тухай (Ром 13:1-7) маш олон христэч суурь үзэл баримтлалын талаар өгүүлдэг.⁷³

Танилцуулга (1:1-17) болон Паулын хэлсэн төгсгөлийн үгийг (15:14-16:27) оруулалгүйгээр Ром номыг дараах гурван хэсэгт хувааж үздэг:

1. Эхний найман бүлэг нь итгэлээр дамжуулан Бурханаас ирэх зөвтгөлийн (зөвтгөл ба ариусгал) сайн мэдээний үндсэн үзэл баримтлалыг тоймлосон **онолын хэсэг**.
2. Дараагийн гурван бүлэг нь (9-11) иудей ба Харь үндэстнүүдтэй харилцах Бурханы харилцаа болон Сайн мэдээтэй харилцах тэдний харилцааны талаар өгүүлсэн **үндэстний тухай хэсэг**.
3. Үлдсэн бүлгүүд нь (12-16) Сайн мэдээг итгэгчдийн өдөр тутмын амьдралд хандуулсан **бодит хэрэгжүүлэлтийн хэсэг** юм.

Христийн тухай Ром номд: Паул Есүс Христийг хоёр дахь Адам гэж дурсэлсэн. Өөрт нь итгэсэн бүх хүнд Өөрийн зөвт байдал болон орлуулалт болсон үхлээрээ дамжуулан зөвтгөлийг өгдөг хоёр дахь Адам гэж тэр хэлсэн. Тэрээр хүмүүсийн гэм нүглийн төлөөх Бурханы буруутгал ба уур хилэнг Өөртөө авч, Өөрийнхөө зөвт байдлыг нүгэлт хүмүүст энэрэнгүй бэлгэ болгон өргөсөн юм. Түүний үхэл ба амилалт нь итгэгчдийн золилт, зөвтгөл, эвлэрүүлэл, аврал болон алдаршуулалтын үндэс юм.⁷⁴

Хувийн Судлал: Агуулга

1. Танилцуулга (1:1-17)

1:1-7	1:8-15	1:16-17
-------	--------	---------

2. Буруутгал: Бүх хүн нүгэлтэй учраас зөвт байдал хэрэгтэй болох нь (1:18-3:20)

A. Ёс бус хүмүүсийг буруутгах нь (Харь үндэстэн) (1:18-32)	1:18-23	1:24-27	1:28-32
B. Ёс суртахуунтай хүнийг буруутгах нь (2:1-16)	2:1-11	2:12-16	
C. Шашинлаг хүмүүсийг буруутгах нь (иудейчүүд) (2:17-3:8)	2:17-24	2:25-29	3:1-8
D. Бүх хүнийг буруутгах нь (3:9-20)	3:9-18	3:19-20	

3. Зөвтгөл: Христээр ирэх Бурханы зөвт байдлыг буруутгах нь (3:21-5:21)

A. Зөвт байдлын тодорхойлолт (3:21-31)	3:21-26	3:27-31
--	---------	---------

B.	Зөвт байдлын дүрслэл (4:1-25)		
	4:1-8	4:13-15	
	4:9-12	4:16-25	
B.	Зөвт байдлын ерөөлүүд (5:1-11)		
G.	Зөвт байдал ба буруутгалын ялгаа (5:12-21)		
	5:12-14	5:15-17	5:18-21
4.	Ариусгал: Өгөгдсөн ба илэрхийлэгдсэн зөвт байдал (6:1-8:39)		
A.	Ариусгал ба гэм нүгэл (6:1-23)		
	6:1-7	6:12-14	6:20-23
	6:8-11	6:15-19	
B.	Ариусгал ба Хууль (7:1-25)		
	7:1-3	7:7-13	7:21-25
	7:4-6	7:14-20	
B.	Ариусгал ба Ариун Сүнс (8:1-39)		
	8:1-8	8:18-25	8:28-30
	8:9-17	8:26-27	8:31-39
5.	Цагаатгал: Иудей ба Харь үндэстэнд Бурханы зөвт байдал боломжтой болох нь (9:1-11:36)		
A.	Израилийн өнгөрсөн үе: Бурханаар сонгогдсон (9:1-29)		
	9:1-5	9:14-18	9:27-29
	9:6-13	9:19-26	
B.	Израилийн өнөөгийн байдал: Бурханаас татгалзсан (9: 30-10:21)		
	9:30-33	10:5-13	10:16-17
	10:1-4	10:14-15	10:18-21
B.	Израилийн ирээдүй: Бурханаар сэргээгдсэн (11:1-36)		
	11:1-6	11:11-16	11:25-32
	11:7-10	11:17-24	11:33-36
6.	Хэрэгжүүлэлт: Зөвт байдлыг үйлчилд хэрэгжүүлэх нь (12:1-15:13)		
A.	Бурхантай холбоотойгоор (12:1-2)		
B.	Өөртэйгөө холбоотойгоор (12:3)		
B.	Чуулгантай холбоотойгоор (12:4-8)		
G.	Нийгэмтэй холбоотойгоор (12:9-21)		
	12:9-13	12:14-21	
D.	Эрх мэдэлтэй холбоотойгоор (13:1-14)		
	13:1-7	13:8-10	13:11-14
E.	Бусад христитгэгчидтэй холбоотойгоор (14:1-15:13)		
	14:1-4	14:10-12	15:1-6
	14:5-9	14:13-23	15:7-13
7.	Хувийн мэдээ ба ерөөл (15:14-16:27)		
A.	Паулын төлөвлөгөөнүүд (15:14-33)		
	15:14-21	15:22-29	15:30-33
B.	Паулын хувийн мэндчилгээ (16:1-16)		
	16:1-2	16:3-16	
B.	Паулын төгсгөлийн үг ба ерөөл (16:17-27)		
	16:17-20	16:21-24	16:25-27

1 Коринт

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы мэргэн ухаан)

Номын нэр болон зохиогч: Энэ захидалын зохиогч нь Паул гэдгийг баталсан баримт нотолгоо (гадаад болон дотоод) хангалттай байдаг. Паул энэ захидалыг бичсэн гэдгийг батлах нотолгоонууд нэгдүгээр зуунаас хойш (МЭ 96 он) тасралтгүй олдсоор иржээ. Ромын Клемент (II зууны пастор) 1 Коринтын тухай коринтчуудад бичсэн захидалдаа “Ерөөгдсөн элч Паулын захидал” гээд түүнээс иш татсан байдаг. Дотоод нотолгоо нь маш илэрхий юм. Зохиогч хэд хэдэн газар өөрийгөө Паул хэмээн дурдсан байдаг (1:1; 16:21 уд.харьц, 1:12-17; 3:4, 6, 22).

Үйлс ном болон хэд хэдэн захидалуудыг нарийвчлан судалснаар Коринтын чуулганд Паулын оролцоо ямар байсан талаар дараах дүгнэлтэд хүрдэг: Паул Коринт уруу (1) эхнийхээ захидалыг (гээгдэж алга болсон) илгээснийхээ дараа тийшээ (2) анхныхаа айлчлалыг хийсэн. Үүний дараа тэр Коринт уруу (3) хоёр дахь захидаа (1 Коринт) илгээж, дараа нь (4) хоёр дахь удаагаа тэнд (“үй гашуу болж очсон,” 2 Коринт 2:1) очсон. Дараа нь тэр Коринт уруу гурав дахь (5) захидаа бичжээ (бас гээгдсэн). Үүний дараа Коринт уруу (6) дөрөв дэх захидаа буюу 2 Коринт номыг бичжээ. Эцэст нь, (7) Паул Коринт уруу гурав дахь аяллаа хийсэн байна (Үйлс 20:2-3). Үрэгдэж алга болсон хоёр захидалын хувьд, Бурхан тэдгээрийг Библийн каноны хэсэг болгохыг хүсээгүй учраас тийнхүү оруулаагүй гэдгийг тэмдэглэн хэлэх ёстой юм.

Бичигдсэн огноо: МЭ 55 он. Паул МЭ 50 оны үед, илгээлтийнхээ хоёр дахь аяллын үеэр анх удаа Коринтод Сайн мэдээг тунхаглажээ. Тэрээр тэнд байхдаа өөртэй нь адилхан майхан хийж зардаг Акул, Прискила гэгч эхнэр нөхөр хоёртой хамт ажиллаж амьдарч байв (Үйлс 18:3). Паул уламжлал ёсоороо эхлээд тэндхийн синагогт тунхаглажээ. Гэвч иудейчүүд түүнийг эсэргүүцэж хөөсөн байна. Тэгэхэд нь Паул синагогийн дэргэд гэртэй Иустын Тит гэдэг хүнийд очиж, үйлчлэлээ үргэлжлүүлжээ (Үйлс 18:7). Хэдийгээр иудейчүүд түүнийг Ромын захирагч Галлионы (энэ ялыг хэрэгсэхгүй болгосон) өмнө авчран буруутгасан боловч Паул Коринтод 18 сар амьдарчээ (Үйлс 18:1-17; 1 Коринт 2:3). Энэ захидалыг Паул Ефест гурван жил амьдарсны эцэст, МЭ 55 оноос хойш бичжээ (16:5-9; Үйлс 20:31). Паул Ефес хотод Пентекостын (16:8) өдөр хүртэл байсан гэж энд бичсэнээс үзвэл тэрээр энэ захидалыг бичиж байх үедээ Ефест жилээс хэтрэхгүй хугацаагаар амьдрах бодолтой байсан нь илэрхий байна.

Сэдэв болон зорилго: Энэ номын сэдэв ба зорилгыг ойлгоход тань тус болох зорилгоор тухайн үеийн нөхцөл байдлын талаар цухас дурдах нь зүйтэй болов уу. Коринт нь Грекийн хойд хэсгийг Пелопонтой холбосон, Эгийн тэнгис ба Адриатын тэнгисийн хоорондох нарийн зурvas газарт (их ус уруу түрж орсон хэсэгхэн хуурай газар) оршдог том хот (оиролцоогоор 700,000 хүн амтай; тэдний бараг гуравны хоёр нь боол) байжээ. Хэдийгээр энэ хот хөгжин цэцэглэсэн том хот мэт харагддаг ч Паул болон түүний хамтрагчид Коринт шиг ийм хотод Бурханы зөвт байдлын тухай сайн мэдээ ямархан амжилтад хүрэх бол хэмээн гайхаж байсан бололтой. Хотынхоо хувьд энэ хот бүдүүлэг материализм болон ужиг гэм нүгэлд баригдсанаараа алдартай байлаа. Коринт хотод сүм, бунхан маш олон байдаг байсны дотор 550 метр өндөртэй Акрокоринтын оргил дээр босгосон Афродита сүм хамгийн алдартай нь байлаа. Эртний Грекийн утга зохиолд үүнийг эд баялаг, ёс бус явдалтай холбон дүрсэлсэн байдаг. “Коринтын охин” хэмээх хэллэг нь янхан гэсэн утгаар гарч ирсэн байдаг. Түүнчлэн “коринтчууд шиг үйлдэх” гэсэн үг гарч ирсэн ба энэ нь “тэр бүлээс гадуурх бэлгийн харьцаанд орох” гэсэн утгыг илэрхийлдэг байв. Коринт хотын хамаг л эд баялаг, муу муухай зүйл Афродита сүм бол түүний мянга гаруй янхнууд дээр төвлөрсөн байдаг байжээ. Тийм ч учраас “Коринт уруу аялах нь хүн бүрийн хийгээд байх зүйл биш” гэсэн сэрэмжлүүлгийн үг гарсан байна.

Үйлс номоос харвал, Паулаас Сайн мэдээг сонсож итгэсэн хүмүүсийн дунд иудей хүн цөөхөн байсан бөгөөд бараг бүх итгэгчид нь Харь үндэстнүүд байжээ. Тэдний ихэнх нь жирийн анги давхаргын хүмүүс байснаас гадна цөөн тооны язгууртнууд байсан бололтой (1:26-31). Тэд нийгэм, здийн засгийн хувьд хоорондоо мэдэгдэм ялгаатай байлаа (7:20-24; 11:21-34); зарим нь зүсэн бүрийн ёс бус явдалд автсан хүмүүс байв (6:9-11). Гэсэн ч хэдий өөрсдийнх нь мэдлэг оюун доройтон завхарсан ч тэд грек хүн гэдгээрээ бардамнадаг байв (1:17; 2:1-5).⁷⁵

Тэгэхээр, Коринт хотын ёс бус байдал болон шашин шүтлэгийн нөхцөл байдал нь эндхийн чуулганы сүнсний болон ёс суртахууны байдалд хэрхэн сөргөөр нөлөөлснийг эндээс тодорхой харах боломжтой юм. Энэ захидлын үндсэн сэдэв нь Христ дотор ариусгагдаж, ариун хүмүүс хэмээн нэрлэгдэх болсон христитгэгч хүн өөрийн хүлээн авсан шинэ амийг амьдралынхаа бүхий л нөхцөл байдалд хэрэгжүүлэн амьдрах тухай юм. Христ доторх энэхүү шинэ амь нь Ариун Сүнсээр удирдуулан, шинэ амьдралаар амьдрахыг бидэнээс шаарддаг (3:16, 17; 6:11, 19-20). Христ дотор бидэнд илчлэгдсэн Бурханы мэргэн ухаан нь итгэгчдийг хувь хүний болон нийгмийн түвшинд өөрчлөхийн тулд өгөгддөг юм.

1 Коринт ном нь Паул, Коринт хотын чуулганд үүсээд байсан эмх замбараагүй байдал болон бусад олон асуудалтай холбоотой мэдээллийг хүлээж аваад, тэдгээр буруу зөрүү зүйлийг засаж залруулах зорилгоор бичсэн хоньчны захидал юм. Эдгээр асуудалд чуулган доторх хагарал (1:11), Бурханы мэргэн ухаанаас илүүтэй хүний буюу өртөнцийн мэргэн ухаанд найдах явдал (1:21-30), ёс бус байдал (5:1-13; 6:9-20), гэрлэлт болон гэр бүл салалт, хоол хүнс, мөргөл, сүнслэг бэлгүүд ба амилалттай холбоотой олон асуудал багтдаг. Тэдний шашин шүтлэг болон ёс бус нөхцөл байдлын улмаас энэ чуулганд худал итгэл үнэмшил, зан үйл бий болоод байжээ.

Христийн тухай 1 Коринт номд: Христ бол христэч амьдралын амин чухал эх сурвалж гэдгийг 1:30-д ийнхүү хэлсэн байдаг: “*Харин та нар Түүнээс болжс Христ Есүс дотор байгаа юм. Христ Есүс нь бидний хувьд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусгал ба золилт болсон юм.*”

Хувийн Судлал: Агуулга

1. Танилцуулга (1:1-9)

- A. Мэндчилгээ (1:1-3)
- B. Талархлын залбирал (1:4-9)

2. Чуулган доторх хагарал (1:10–4:21)

A. Хагарлын тухай мэдээлэл (1:10-17)		
B. Хагарлын шалтгаан (1:18–2:16)		
1:18-25	2:1-5	
1:26-31	2:6-16	
C. Хагарлын үр дагавар (3:1–4:5)		
3:1-4	3:10-15	3:18-23
3:5-9	3:16-17	4:1-5
D. Паулын санаа бодол ба жишээ (4:6-21)		
4:6-7	4:8-13	4:14-21

3. Чуулган доторх ёс суртахууны эмх замбараагүй байдал (5:1–6:20)

A. адан төрөлтэйгээ бэлгийн харьцаанд орсон хэрэг (5:1-13)		
5:1-5	5:6-8	5:9-13
B. Итгэгчид харь үндэстний шүүхийн өмнө өөр хоорондоо заргалдсан нь (6:1-8)		
6:9-11	6:12-20	

4. Гэрлэлтэй холбоотой зөвлөмжүүд (7:1-40)

A. Гэрлэлт болон гэрлэлтийг тэвчих тухай (7:1-9)		
B. Гэрлэлт ба салалт (7:10-24)		
7:10-11	7:17-20	
7:12-16	7:21-24	
C. Гэрлэлт ба христэч үйлчлэл (7:25-38)		
7:25-31	7:32-35	7:36-38
D. Гэрлэлт ба дахин гэрлэлт (7:39-40)		

5. Шүтээнд өргөсөн хоол хүнсийн холбоотой зөвлөмжүүд (8:1-11:1)

A. Асуулт: Христитгэгч хүн харийн бурханд өргөсөн хүнсийг идэж болох уу? (8:1-13)	8:1-3	8:4-6	8:7-13
Б. Паулын жишээ (9:1-27)	9:1-2	9:8-14	9:19-23
	9:3-7	9:15-18	9:24-27
В. Урамшуулал (10:1-11:1)	10:1-5	10:14-22	10:31-33
	10:6-13	10:23-30	11:1

6. Олон нийтийн мөргөлтэй холбоотой зөвлөмжүүд (11:2-14:40)

A. Эмэгтэй хүн толгойгоо бүтээх тухай (11:2-16)	11:17-22	11:27-32	
Б. Эзний зоогийн тухай (11:17-34)	11:23-26	11:33-34	
В. Сүнслэг бэлгүүдийг ашиглах тухай (12:1-14:40)	12:1-3	13:1-3	14:13-19
	12:4-11	13:4-7	14:20-25
	12:12-13	13:8-13	14:26-33
	12:14-26	14:1-5	14:34-36
	12:27-31	14:6-12	14:37-40

7. Аминалтын тухай үзэл баримтлал (15:1-58)

A. Аминалтын ач холбогдол (15:1-11)	15:1-2	15:3-11	
Б. Аминалтыг үгүйсгэхийн үр дагавар (15:12-19)			
В. Христэч итгэл найдвар (15:20-34)	15:20-28	15:29-34	
Г. Биеийн аминалт (15:35-50)	15:35-41	15:42-50	
Д. Христээр дамжуулан олж авах христитгэгчдийн ялалт (15:51-58)	15:51-57	15:58	

8. Иерусалимын төлөөх хандив (16:1-4)

9. Төгсгол (16:5-24)

16:5-9	16:13-14	16:21-24
16:10-12	16:15-20	

2 Коринт (Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы амар тайван)

Номын нэр болон зохиогч: Энэ захиад л мэндчилгээгээр эхэлж байгаа нь Паул үүнийг бичсэн гэдгийг харуулж байна. Паул зохиогч нь мөн гэдгийг гадаад, дотоод баталгаа хоёулаа маш тодорхой баталдаг. Үнэндээ ч “энэ нь Паулын бичиглэлийн хэв маягтайгаас гадна бусад бичвэрүүдтэй нь харьцуулбал түүний намтрыг илүү түлхүү оруулсан байdag.”⁷⁶

Бичигдсэн огноо: МЭ 56 он. Мөнгөний дархчуудын үймээнээс олж (Үйлс 19:23-41) Паул МЭ 56 оны хавар Ефесээс Македони уруу явжээ (Үйлс 20:1). Тэрээр замдаа Тройд саатаж, Титтэй уулзан (2 Коринт 2:13) Коринтын нөхцөл байдлын талаар шинэ мэдээ сонсоно хэмээн найдаж байсан боловч тэндээс Титийг олж уулзаж чадаагүй учир түүний аюулгүй байдлын төлөө санаа зовнисоор Македонийг зорьжээ (7:5-6). Паул Македонид Титтэй уулзаж, Коринтын чуулганы байдал ерөнхийдөө сайн байгаа тухай таатай мэдээ сонссоны дээр өөрийг нь болон элчийн байр суурийг эсэргүүцсэн бүлэг хүмүүс тэнд бий болоод байгаа

тухай муу мэдээ ч бас дуулжээ. Тиймээс Паул Македониос өөрийн дөрөв дэх захидал болох 2 Коринт номыг бичсэн байна. Дараа нь МЭ 56-57 оны өвөл Паул Коринт уруу гурав дахь аяллаа хийжээ (Үйлс 20:2-3).

Сэдэв болон зорилго: Паулын бүх захидааас 2 Коринт илүү хувьчилсан, халуун дотно шинжтэй байдаг. Хэдийгээр коринтчуудын зарим нь түүнийг хүчтэй шүүмжилж, түүнд хандах хандлага байнга өөрчлөгдөж байсан ч Паул энэ захидалдаа өөрийнхөө зүрх сэтгэлийг нээж, тэдний төлөөх хувиршгүй хайраа тунхагласан юм. Энэ номын гол сэдвийг Жеймс К. Лоери “Bible Knowledge Commentary” тайлбар тольд ийнхүү нэгтгэн дүгнэсэн байдаг:

Хуурамч багш нар өөрсдийгөө элч нар хэмээн тунхаглаж, чуулганд орж ирсэн явдал Паулын санааг ихэд зовоож байлаа. Тэд өөрсдийн үзэл санааг сурталчлахын сацуу Паулыг хувь хүнийх нь хувьд (нэр төрийг нь унагах) болон түүний дамжуулсан мэдээг няцаахыг оролдож байв. Тиймээс Паул өөрийнхөө элчийн эрх мэдэл болон дамжуулсан мэдээнийхээ үнэн зөв болохыг хамгаалах зорилгоор 2 Коринт номыг бичжээ. Ингэхдээ Паул өөрийгөө өмгөөлж хамгаалахыг зорилго болгоогүй юм. Учир нь өөрийнх нь үйлчлэл болон мэдээг хүлээж авах нь Коринтын чуулганы сүнслэг сайн сайхантай нягт холбоотой гэдгийг Паул мэдэж байсан.⁷⁷

Паул ийнхүү элчийн эрхийг өмгөөлөх явцад дараах гурван гол зорилго гарч иржээ: (1) Өөрийнх нь үйлчлэлд чуулган таатай хандсанд Паул баярлаж байгаагаа илэрхийлэх (1:1–7:16); (2) Иуда дахь христитгэгчдэд зориулсан өргөлийн амлалтыг нь тэдэнд сануулах (8:1–9:15); (3) өөрийн элчийн эрх мэдлийг өмгөөлөх (10:1–13:14).

Христийн тухай 2 Коринт номд: Бид энэ захидаас Христ бол бидний тайвшрал (1:5), ялалт (2:14), Эзэн (2:4), шинэ амьдралын эрх чөлөө (3:17), гэрэл (4:6), шүүгч (5:10), эвлэрүүлэл (5:19), бэлэг (9:15), эзэмшигч (10:7) болон хүч (12:9) гэдгийг хардаг.

Хувийн Судлал: Агуулга⁷⁸

1. Паулын зан чанар болон элчийн үйлчлэлийг тайлбарласан нь (1:1–7:16)

- A. Мэндчилгээ (1:1-2)
- B. Зовлон доторх Бурханы тайвшруулалд талархсан нь (1:3-11)
 - 1:3-7 1:8-11
- C. Паулын хандлага болон шударга зан чанар (1:12–2:4)
 - 1:12-14 1:23-24
 - 1:15-22 2:1-4
- D. Коринт дахь буруутгагчдыг учлах нь (2:5-11)
- E. Уйлчлэл дэх Бурханы удирдлага (2:12-17)
 - 2:12-13 2:14-17
- F. Коринтын итгэгчид - Христийн захия (3:1-11)
 - 3:1-3 3:4-11
- G. Бүтээлэггүй нүүрээр Бурханы алдрыг харах нь (3:12–4:6)
 - 3:12-18 4:1-6
- H. Шавар савнууд дахь баялаг (4:7-15)
 - 4:7-12 4:13-15
- I. Ухлийн найдвар болон энэ нь христитгэгчдийн хувьд юу гэсэн үг болох (4:16–5:10)
 - 4:16-18 5:1-5 5:6-10
- J. Эвлэрлийн үйлчлэл (5:11–6:10)
 - 5:11-15 5:20-21
 - 5:16-19 6:1-10
- K. Өөрийн хүүхдүүдэд хандсан Сүнслэг Эцэгийн хүсэлт (6:11–7:4)
 - 6:11-13 7:1
 - 6:14-18 7:2-4

К. Титтэй уулзсан нь (7:5-16)

7:5-12

7:13-16

2. Уриалга (ятгалга): Иерусалимын итгэгчдэд зориулсан хандив (8:1–9:15)

- A. Өгөөмөр сэтгэлийг урамшуулсан нь (8:1-15)
8:1-6 8:7-15
B. Тит болон түүний нөхдийг Коринт уруу илгээсэн нь (8:16–9:5)
8:16-24 9:1-5
B. Өгөөмрөөр өгөхийн үр дүн (9:6-15)

3. Паул элчийн эрхээ өмгөөлсөн нь (10:1–13:14)

- A. Паул элчийн эрхээ хамгаалсан нь; Түүний илгээлтийн үйлчлэлд хамарагдах газар нутаг (10:1-18)
10:1-6 10:7-11 10:12-18
B. Паул аргагүйн эрхэнд өөрөөрөө сайрхсан нь (11:1–12:21)
11:1-6 11:21-29 12:11-13
11:7-11 11:30-33 12:14-18
11:12-15 12:1-6 12:19-21
11:16-20 12:7-10
B. Сүүлчийн сануулга (13:1-10)
13:1-4 13:5-10
Г. Төгсгөлийн хэсэг (13:11-14)

Галат

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы зөвт байдал)

Номын нэр болон зохиогч: Паул захидлынхаа эхэнд “Элч Паул” хэмээн өөрийгөө маш тодорхой нэрлэсэн нь түүнийг энэ захидлын зохиогч гэдгийг бэлхнээ баталдаг.

Бичигдсэн огноо: МЭ 49 он. Галатын өмнөд хэсэгт байсан христитгэгчдэд энэ захидлыг бичжээ. Паулын илгээлтийн анхны аяллын үеэр эдгээр чуулган байгуулагдсан аж. Паул энэ захидлыг анхныхаа аяллын дараа (МЭ 49 оны үед Антиохоос бичсэн бололтой. Эндээс харвал, энэ захидал түүний хамгийн эхний захидал аж.) Иерусалимын Зөвлөл хуралдахын өмнөхөн бичжээ (Үйлс 15).

Сэдэв болон зорилго: Галатчуудад бичсэн энэ захидлыг теологичид “Христэч эрх чөлөөний тухай бүлэг” гэж нэрлэдэг. Галат ном нь иудеизмийг баримтлагчид болон хуулийг чандлан сахих тухай тэдний сургаалыг (нигүүлслийн оронд хуулийн дор амьдрах) хатуу шүүмжилдэг. Тэд Хуучин гэрээний янз бүрийн зан үйл, ёс жаяг гэх мэтчилэн маш олон зүйлийг зааж, тэдгээрийгээ чуулганд хэрэгжүүлсээр байлаа. Иймд элч Паул ажил үйлсийн тухай тэдний сайн мэдээг нящааж, итгэлээр зөвтгөгдөн, Ариун Сүнсээр ариусгагдахын давуу талыг батлан харуулахын тулд энэ захидлыг бичжээ.

Үүнээс гадна, иудеизмийг баримтлагч тэдгээр хүмүүс зөвхөн хуурамч сайн мэдээг тунхаглаад зогсоогүй, Паулын элчийн эрх мэдлийг гутаан доромжлохыг хичээсэн. Эхний хоёр бүлэгт Паул амилсан Христээс илчлэлтээр дамжуулан өөрт нь ирсэн элчийн эрх мэдэл болон сайн мэдээг хамгаалсан. Дараа нь, 2, 3-р бүлэгт зөвхөн итгэлээр зөвтгөгдөх тухай буюу нигүүлслийн тухай үнэн үзэл баримтлалыг нотолсон. Гэтэл зарим хүмүүс ийм үзэл баримтлал нь хүмүүсийг гэм нүгэл уруу хөтөлдөг хэмээн мэтгэсэн учраас элч Паул христэч эрх чөлөө гэдэг нь гэм нүгэл хийхийг зөвшөөрч байгаа хэрэг биш гэдгийг нотолсон. Тэгээд 5, 6-р бүлэгт христитгэгчид Сүнсний хүчээр амьдарч сурх хэрэгтэй бөгөөд Сүнсээр удирдуулсан амьдрал нь махан биеийн үйлсийг бус, харин Сүнсний үр жимсийг тунхаглан харуулдаг гэдгийг батлан өгүүлдэг.

Христийн тухай Галат номд: Итгэгчдийг Хуульд үхүүлсэн Христийн үхэл болон Христтэй адилхан болгогдсон амиар (2:20) дамжуулан итгэгчид боолчлооос чөлөөлөгдөж (5:1 д.иш), эрх чөлөөтэй болсон.

Загалмайн хүч нь итгэгчдийг хуулийн хараалаас, нүглийн хүчинээс, махан биеийн хүсэл тачаалаас чөлөөлдөг (1:4; 2:20; 3:13; 4:5; 5:16, 24; 6:14).

Хувийн Судлал: Агуулга

- 1. Хувь хүний хувьд: Нигүүлслийн Сайн мэдээ ба итгэлээр хүлээн авах зөвтгөлийг өмгөөлсөн нь (1:1–2:21)**

A. Танилцуулга (1:1-10)	1:1-2	1:3-5	1:6-10
B. Илчлэлтээр ирсэн нигүүлслийн Сайн мэдээ (1:11-24)	1:11-12	1:13-17	1:18-24
C. Нигүүлслийн Сайн мэдээг Иерусалимын чуулган сайшаан хүлээн авсан нь (2:1-10)			
D. Петрийг зэмлэхдээ нигүүлслийн Сайн мэдээг хамгаалсан нь (2:11-21)	2:11-14	2:15-21	
- 2. Узэл баримтлалын хувьд: Нигүүлслийн Сайн мэдээ ба итгэлээр хүлээн авах зөвтгөлийг тайлбарласан нь (3:1–4:31)**

A. Галатчуудын туршлага: Сүнсийг итгэлээр хүлээн авсан (3:1-5)			
B. Абрахамын жишээ: Тэр үйлсээр бус, итгэлээр зөвтгөгдсөн (3:6-9)			
C. Хуулиар бус, итгэлээр зөвтгөгдөх нь (3:10–4:11)	3:10-14	3:19-22	4:1-7
	3:15-18	3:23-29	4:8-11
D. Галатчууд ивээлүүдээ хуулиар бус, итгэлээр хүлээн авсан (4:12-20)			
E. Хууль болон нигүүлсэл нь бие бие үгүйсгэдэг (4:21-31)			
- 3. Амьдралд хэрэгжих байдлын хувьд: Нигүүлслийн Сайн мэдээ ба итгэлээр хүлээн авах зөвтгөлийг хэрэгжүүлсэн нь (5:1–6:18)**

A. Эрх чөлөөт байдал: Бат зогс (5:1-12)	5:1	5:2-6	5:7-12
B. Эрх чөлөөт амьдралдаа хэрэгжүүлэх нь: Бие биедээ хайраар үйлчил (5:13-15)			
C. Эрх чөлөөт амьдралын хүч: Сүнсээр удирдуул (5:16-26)	5:16-24	5:25-26	
D. Эрх чөлөөт амьдралаас гарах үйлс: Бүх хүнд сайныг үйлд (6:1-10)	6:1-5	6:6-10	
E. Төгсгөлийн үг (6:11-18)			

Ефес (Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы баялаг)

Номын нэр болон зохиогч: Шоронгийн захидал болгоны эхний ишлэлд зохиогч нь Паул гэдгийг тодорхой хэлсэн байдаг.

Бичигдсэн огноо: МЭ 60–61 он. Паул энэ захидалыг шоронд хоригдож байхдаа бичжээ (Ефес 3:1; 4:1; 6:20). Гэхдээ Паул Ефес номыг МЭ 57-59 онд Кайсарид хоригдож байхдаа (Үйлс 24:27) бичсэн үү, эсвэл МЭ 60-62 онд Ромд хоригдож байхдаа (Үйлс 28:30) бичсэн үү гэдэг дээр судлаачид санал зөрөлддөг боловч Ромын шоронгоос бичсэн гэдгийг баримт нотолдог. Ефес, Филиппой, Колоссай, Филимон захидалуудыг мөн энэ үед бичигдсэн гэж үздэг (Филиппой 1:7; Колоссай 4:10; Филимон 9). Филиппой (1:19-26), Филимон (1:22) номууд шиг Ефес ном Паулын шоронгоос суллагдсан тухай ямар нэг зүйл цухуйлгаагүй учраас Паул үүнийг МЭ 60 оны үед, Ромд хөлснийхөө байранд гэрийн хорионд байх үедээ бичсэн (Үйлс 28:30) гэж үздэг. Паул шоронгоос суллагдсаныхаа дараа 1 Тимот болон Тит номыг бичээд, дахин баривчлагдаад байхдаа 2 Тимотыг бичсэн бөгөөд дараа нь Ромд итгэлийнхээ улмаас нас барсан байна.

Сэдэв болон зорилго: Ефес номд Паул “чуулган бол Христийн бие” бөгөөд Христ энэ чуулганы Тэргүүн (1:22, 23), харин итгэгчид бие бисийнхээ эрхтнүүд агаад Христ доторх аливаас сүнслэг ерөөлөөр ерөөгдсөн гэсэн гайхамшигт нууцыг дэлгэн харуулсан (1:3; 2:11-22). Паул чуулганы (Христийн бие) тэргүүн болох Христ доторх өөрийн ерөөлүүдийн дундаршгүй баялгийн талаарх итгэгчдийн мэдлэгийн хүрээг тэлэхийг зорьсон нь тодорхой байна. Эндээс уг захидалд хоёр чухал зорилго урган гарч ирдэг. Эхийн нь, итгэгчдийн Христ доторх ерөөлийн баялаг болон тэдгээрээр дамжуулан Бурханы мөнхийн зорилго буюу тэнгэр, газар дахь бүх юмыг Христийн бодгаль дотор хэрхэн нэгтгэснийг (1:3-12) дурслэн харуулах явдал юм. Хоёр дахь сэдэв нь эхнийхээсээ урган гардаг. Өөрөөр хэлбэл, итгэгчид Христ доторх дуудлага болон тэнгэрлэг байр суурийнхаа дагуу амьдарч, мэдлэгийг хүлээн авах үүрэгтэй тухай өгүүлдэг (1:18-23; 3:14-21; 4:1).

Хэдийгээр Паул энэ захидаа ямар нэгэн тодорхой алдаа зөрчлийг засаж залруулах зорилгоор бичээгүй ч, итгэгчид Христ дотор хүлээн авсан зүйлээ ойлгоогүй юмуу амьдралдаа хэрэгжүүлэгүйгээс болоод, эсвэл төлөвшөөгүйгээс болоод бий болдог асуудлуудаас сэргийлэх зорилгыг агуулсан байдаг. Үүнтэй нягт холбоотой нэгэн богино хэсэг байдаг нь сатантай хийх итгэгчдийн тулааны тухай хэсэг юм (6:10-18). Ийнхүү Паул итгэгчдэд өгөгдсөн баялаг болон тэдний өдөр тутмын амьдрал ба тулааны талаар бичжээ.

Христийн тухай Ефес номд: “Христ доторх” буюу “Христтэй хамт” гэсэн үгс Ефес номд 35 удаа гардаг. Эдгээр нь Паулын байнга хэрэглэдэг илэрхийлэл боловч энэ номд илүү олон хэрэглэсэн байдаг. Аврагч доторх байр сууриараа дамжуулан итгэгчид ямар олон зүйлийг эзэмшидэг болохыг бид эндээс харж болно. Тэд Христ дотор байдаг (1:1) агаад Христ доторх аливаас сүнслэг ерөөлөөр ерөөгдсөн (1:3), Түүгээр сонгогдсон (1:4), Христтээр үрчлэгдсэн (1:5), хайрлагдсан (1:6), золигдсон (1:7), Түүний дотор өв залгамжлагчид болсон (1:11), Христ доторх Түүний алдрын магтаалын төлөө дуудагдсан (1:12), Түүгээр дамжуулан өөрсдийнх нь өвийн батлан даагч болох Ариун Сүнсээр тамгалагдсан (1:13-14), амилуулагдаж, тэнгэрлэг газарт Түүнтэй хамт суулгагдсан (2:5-6), сайн үйлсийн төлөө Христ дотор бүтээгдсэн (2:10), Христ дотор амлалтыг хамтран хуваалцагчид болсон (3:6), Христэд итгэлээр дамжуулан Бурханд очих эрхтэй болсон (3:12) билээ.

Хувийн Судлалд: Агуулга

1. Мэндчилгээ (1:1-2)

2. Үзэл баримтлалын хэсэг: Чуулганы дуудлага (1:3-3:21)

- A. Золилтын төлөөх магтаал (1:3-14)
- B. Мэргэн ухаан ба илчлэлтийн төлөөх залбирал (1:15-23)
- C. Байр сууриа шилжүүлж өгөх нь (2:1-22)
2:1-10 2:11-22
- D. Нэмэлт тайлбар (3:1-13)
- E. Ухаарлын залбирал (3:14-21)
3:14-19 3:20-21

3. Амьдралд хэрэгжүүлэх хэсэг: Чуулганы амьдрал (4:1-6:24)

- A. Итгэгчдийн нэгдмэл амьдрал (4:1-16)
4:1-6 4:7-16
- B. Итгэгчдийн зөвт амьдрал (4:17-5:21)
4:17-24 5:1-2 5:6-14
4:25-32 5:3-5 5:15-21
- C. Итгэгчдийн дэлхий дэх амьдрал (5:22-6:9)
5:22-24 6:1-8
5:25-33 6:9
- D. Итгэгчдийн сүнслэг дайн (6:10-20)
6:10-17 6:18-20
- E. Төгсгөлийн үг (6:21-24)

Филиппой

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы хангалуун байдал)

Номын нэр болон зохиогч: Энэ номыг Паул бичжээ. Тэрээр Македонийн Филиппой хотод анхлан байгуулсан чуулгандаа хандан энэ захильтыг бичсэн учраас “Филиппой” хэмээн нэрлэжээ.

Бичигдсэн огиоо: МЭ 60–61 он. Ефес номын адил Паул энэ захильтыг бас широнгоос бичжээ. Захирагчийн ордны харуул хамгаалалтын тухай (Филиппой 1:13) болон үхлийн ирмэг дээр байгаа (Филиппой 1:20-26) тухай бичсэн хэсэг нь түүнийг энэ захидаа Ромуос бичсэн гэсэн санааг илтгэдэг. Хэдийгээр Паул үхлийн ирмэг дээр байсан боловч суллагдана гэдэгтэй байсан. Эндээс үзвэл, Филиппой нь Ефесийн дараа, МЭ 60-61 онд бичигджээ.

Сэдэв болон зорилго: Паул Ефес номд “Чуулган бол Христийн бие” бөгөөд Христ энэ чуулганы Тэргүүн (1:22-23) болох тухай, мөн итгэгчид хамтдаа Христ доторх алив сүнслэг ерөлүүдээр ерөөгдсөн (1:3; 2:11-22) тухай гайхамшигт нууцыг дэлгэн тавьдаг бол Филиппой ном нь Ефес номыг амьдралд хандуулдаг. Филиппой ном нь Христээс ирэх эв нэгдэл болон Христ доторх байр суурь ба ерөлүүдээ баярлан хөөрөхгүй байхаас итгэгчдийг сэргийлдэг (Филиппой 1:27; 2:2; 4:1). Филиппой номын сэдвийг “Христ доторх байр хөөр болон нэгдмэл байдал” гэж хэлж болно.

Паул дараах тодорхой зорилгуудын улмаас уг захильтыг филиппойчуудад бичжээ: (1) Өөрт нь илгээсэн тэдний бэлгэнд талархаж байгаагаа илэрхийлэх (1:5; 4:10-19); (2) Өөрийнхөө нөхцөл байдлын талаар танилцуулах (1:12-26; 4:10-19); (3) хавчлага дунд бат зогсож, ямар ч нөхцөлд баяр хөөртэй байхад филиппойчуудыг урамшуулах (1:27-30; 4:4); (4) төлөв даруу, нэгдмэл байдал дотор амьдрахыг ятгах (2:1-11; 4:2-5); (5) Тимот, Епафродит нарыг Филиппойн чуулганд илгээх гэж буйгаа мэдэгдэх (2:19-30); (6) иудеизмийн хуулийг сахигчид болон тэдний дунд шургалан орж ирсэн, эрх чөлөөг буруу ашиглан хуулийг эсэргүүцэгч (хуулийг үл тоомсорлодог /ёс бус) хүмүүсээс сэрэмжлүүлэх (3-р бүлэг).

Христийн тухай Филиппой номд: Христийн биежлийн мөн чанар, бодит баталгаа болон зорилгын талаар үүнээс тодорхой, үүнээс илүү нотлон хэлсэн хэсэг Сударт байдаггүй (2:5-8). Энэ бүгдээс үзвэл, Паул Христийг итгэгчдийн хувьд бүх юм байсан, байгаа, байх болно гэж тунхагладаг бөгөөд тэдгээр нь: (1) амь (1:21); (2) даруу байдлын төгс жишээ бөгөөд хайрын өргөл (2:4-5); (3) аминалтын үед бидний дорд бисийг өөрчлөн Өөрийнхөө цог жавхлант биетэй адил болгох Нэгэн (3:21); (4) амьдралын ямар ч нөхцөл байдал дахь бидний хүч чадал (4:12) юм.

Хувийн Судлалд: Агуулга⁷⁹

- 1. Филиппойчуудад хандсан мэндчилгээ болон талархал (1:1-11)**
1:1-2 1:3-11
- 2. Ром дахь Паулын нөхцөл байдал: Христийг тунхагласан нь (1:12-30)**
1:12-18 1:21-26
1:19-20 1:27-30
- 3. Христэч амьдралын хэв маяг: Христтэй адил бодол санаатай байх (2:1-30)**
2:1-4 2:12-13 2:19-30
2:5-11 2:14-18
- 4. Христэч амьдралын шагнал: Христийн тухай мэдлэгтэй байх (3:1-21)**
3:1 3:7-11 3:17-21
3:2-6 3:12-16
- 5. Христэч амьдралын амар тайван: Христийн оршихуйг мэдэх (4:1-23)**
4:1-3 4:8-9 4:15-20
4:4-7 4:10-14 4:21-23

Колоссай

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы дүүрэн байдал)

Номын нэр болон зохиогч: Энэ захидлыг “колоссайчууд”-д зориулан бичсэн гэдэг нь 1:2-р ишлэлд буй Паулын мэндчилгээнээс тодорхой харагддаг.

Бичигдсэн огноо: МЭ 60–61 он. Паул Ромын шоронд хоригдож байхдаа дөрвөн захидал бичсэн байдаг. Тэрээр энэ захидлаа МЭ 60-61 онд бичжээ (Ефес, Филиппий номуудын бичигдсэн огнооны талаарх хэсгийг үз).

Сэдэв болон зорилго: Энэ номд Христийн дээд эрх мэдэл, удирдлага болон Түүний бие болох чуулган дахь Христийн бүрэн дүүрэн байдлыг тунхагладаг Сайн мэдээний хүчийн талаар өгүүлдэг. Энэ богино захидлаас бид Паулын илэрхийлсэн “Христийн бүрэн дүр зураг”⁸⁰-ийг хардаг. Христитгэгчдийн итгэлийн гол төв болсон Есүс Христ нь Өөрийн бодгаль болон гүйцэлдүүлсэн ажлынхаа улмаас бидний хувьд хэрэгтэй бүх зүйл маань болдог гэдгийг Колоссай ном илэрхийлэн харуулдаг. Учир нь Түүний дотор бид бүрэн төгс болгогддог (2:10) юм. Зуун хувь хүн байсан Аврагч Бурхан, орчлон өртөнцийн Бүтээгч агаад Тэтгэгч, хүмүүний түр зуурын хийгээд мөнхийн хэрэгцээг бүрэн шийдвэрлэгч - Есүс Христийн бодгаль ба ажлын бүрэн дүүрэн байдал, дээд эрх мэдэл, бүрэн хангалаан байдал, хосгүй шинж чанарыг Колоссай номд дэлгэн хүүрнэдэг. Энд Христийг хүн төрөлхтний болон өртөнцийн Бүтээгч/Тэтгэгч бөгөөд Золигч/Эвлэрүүлэгч гэж харуулдаг.

Христийн тухай Колоссай номд: Вилкинсон, Баа нар ийнхүү тэмдэглэсэн байдаг:

Христ судлалын энэхүү онцгой ном нь “бүх удирдлага ба эрх мэдлийн тэргүүн” (2:10), бүтээлийн Эзэн (1:16-17), эвлэрүүллийн Зохиогч (1:20-22; 2:13-15) болох Христ дээр гол анхаарлыг төвлөрүүлдэг. Христ бол итгэгчдийн найдварын үндэс (1:5, 23, 27), шинэ амьдралын хүч чадлын эх үүсвэр (1:11, 29), золилт ба эвлэрүүлэл (1:14, 20-22; 2:11-15), Бурханы бүрэн дүүрэн байдлын биет хэлбэр (1:15, 19; 2:9), бүх юмын Бүтээгч ба Тэтгэгч (1:16-17), чуулганы Тэргүүн (1:18), үхлээс амилсан Бурхан-Хүн (1:18; 3:1), бүхэнд хангалттай Аврагч (1:28; 2:3, 20; 3:1-4) юм.⁸¹

Хувийн Судлал: Агуулга⁸²

- 1. Узэл баримтлалын хэсэг: Христийн бодгаль ба ажил (1:1–2:5)**

1:1-2	1:13-14	1:24-29
1:3-8	1:15-20	12:1-5
1:9-12	1:21-23	
- 2. Маргаантай (Дүгнэлт) хэсэг: Тэрс үзлийг Христтэй нэгдсэн нэгдэл дотроос авч үзэх нь (2:6–3:4)**

2:6-7	2:16-19	3:1-4
2:8-15	2:20-23	
- 3. Амьдралд хэрэгжүүлэх хэсэг: Христ доторх итгэгчдийн амьдрал (3:5–4:6)**

3:5-11	3:22-25	4:5-6
3:12-17	4:1	
3:18-21	4:2-4	
- 4. Хувийн хэсэг: Хувийн төлөвлөгөө болон Элчийн үйл хэрэг (4:7-18)**

4:7-9	4:10-17	4:18
-------	---------	------

1 Тесалоник

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы амлалт)

Номын нэр болон зохиогч: 1 Тесалоник номыг Паул бичсэн гэдгийг 1:1, 2:18 ишлэлүүд баталдаг.

Бичигдсэн огноо: МЭ 51–52 он. Элч Паул Коринт хотод арван найман сар байх үедээ (Үйлс 18:1-11) тесалоникчуудад хоёр захидал бичсэн байдаг. Эхнийхийг нь Тесалоникаас дөнгөж буцаж ирээд байсан Тимотоос тэндхийн чуулганы өсөлт дэвшлийн талаар шинэ мэдээ сонсоод бичжээ. Харин хоёр дахь захидаа үүнээс хэдхэн долоо хоногийн (эсвэл хэдхэн сар) дараа бичсэн байна. Тэгэхээр энэ захидалыг барагцаагаар МЭ 51-52 онд бичигдсэн гэж үздэг.

Сэдэв болон зорилго: Паул Тесалоникт ердөө гуравхан долоо хоног байсан (Үйлс 17:2) учраас шинэ чуулганд тохирсон заавар зөвлөмж өгөх боломж түүнд байгаагүй. Тиймээс тесалоникчуудад бичсэн энэхүү захидалын зорилгыг дараах байдлаар дүгнэж болох юм: тесалоникчуудын амьдралд Бурханы хийсэн бүхэнд талархлаа илэрхийлэх (1:2-3), ажил үйлчлэлийнх нь талаар худал гүтгэлэг явуулж байсан хүмүүсээс өөрийгөө өмгөөлөх (2:1-12), тесалоникчуудыг өнгөрсөн харанхуй амьдрал уруу нь эргүүлэх гэсэн дарамт шахалт, хавчлагын эсрэг бат зогсоход тэднийг урамшуулан зорижуулах (3:2-3; 4:1-12), хэдийн нас барсан христитгэгчдийн хувь тавилангийн талаарх онолын асуултад хариулт өгөх (4:1-13), “Эзний өдөр”-ийн тухай асуултад хариулах (5:1-11), мөн чуулганы амьдралд тулгарсан зарим тодорхой асуудлуудыг шийдвэрлэх (5:12-13; 19-20).

Христийн тухай 1 Тесалоник номд: Бүх бүлэгт Эзний дахин ирэлтийн тухай дурдахаа Христ бол одоо болон ирээдүйд Түүнийг ирэх үе дэх итгэгчдийн авралын найдвар гэдгийг харуулдаг. Тэр ирэхдээ биднийг уур хилэнгээс (Их зовлонгийн тухай өгүүлж буй нь эргэлзээгүй) гэтэлгэж (1:10; 5:4-11), шагнаж (2:19), төгс болгож (3:13), дахин амилуулан (4:13-18) Θөрт нь найдагч бүх хүмүүсийг ариусгах (тусгаарлах) болно (5:23).

Хувийн Судлал: Агуулга

1. Өнгөрсөнд: Итгэлийн үйлс (1:1–3:13)

1:1-5	2:9-12	3:1-5
1:6-10	2:13-16	3:6-10
2:1-8	2:17-20	3:11-13

2. Одоо: Хайрын хөдөлмөр (4:1-12)

4:1-8	4:9-12
-------	--------

3. Ирээдүйд: Найдварын тэвчээр (4:13–5:28)

4:13-18	5:12-13	5:23-24
5:1-11	5:14-22	5:25-28

2 Тесалоник

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы шагнал)

Номын нэр болон зохиогч: Энэ захидалыг 1 Тесалоник номын адил Паул бичжээ (2 Тесалоник 1:1; 3:17).

Бичигдсэн огноо: МЭ 51–52 он. Энэ номын түүхэн нөхцөл байдал 1 Тесалоник номынхтой маш адилхан учраас ихэнх хүмүүс үүнийг Паул эхний захидаасаа хойш нэг их удалгүй, магадгүй зургаан сар орчмын дараа бичсэн байх гэж үздэг. Тесалоникийн чуулганы нөхцөл байдал нэг их өөрчлөгдөөгүй байсан хэдий ч хавчлага улам бүр өсөж байсан бололтой (1:4-5). Тиймээс Паул энэ болон бас бусад шалтгааны улмаас энэхүү хоёр дахь захидаа МЭ 51 юмуу 52 онд, Силас, Тимот нар эхнийх нь захидалыг Тесалоникт хүргэж өгөөд, тэндээс шинэ мэдээтэй ирснийх нь дараа Коринт хотоос бичжээ.

Сэдэв болон зорилго: Пулыг 2 Тесалоник номыг бичихэд хүргэсэн зүйл бол тэндхийн чуулганд газар авч байсан гурван гол зүйлийн талаарх мэдээ байсан юм. Тэдгээр нь: (1) тэдэнд тулгарч байсан хавчлага улам бүр хүчтэй болж байгаа тухай мэдээ (1:4-5); (2) Паулын гэх хуурамч захидалын тухай болон “Эзний өдөр”-ийн талаарх сургаалыг нь гажуудуулж байгаа тухай мэдээ (2:1); (3) Эзэн дахин ирэх тухай итгэл

үнэмшилд зарим хүний хандаж байгаа байдал. Энэ итгэл үнэмшлийг ажил хөдөлмөр хийхгүй байх шалтаг болгон ашиглаж байсан учраас элч Паул энэ залхуу (лазан), замбараагүй (эмх журамгүй амьдрал) байдал тэдний дунд газар аваад байгааг сануулах зорилгоор үүнийг бичжээ (3:5-15).

Энэ захиалыг бичихэд хүргэсэн хэрэгцээг хангахын тулд Паул коринтчуудыг тайтгаруулж, мөн засаж залруулах зорилгоор уг захиалыг бичжээ. Ингэхдээ тэр дараах гурван чухал зорилгыг өмнөө тавьсан: (1) Бурханы шүүлтийн өдөр ирэх шагнал болон шийтгэлийг тесалоникчүүдад тайлбарлаж, тэвчээртэй байхад урамшуулах (1:3-10); (2) Тэр өдөр аль хэдийнээ ирчихээд байгаа мэтээр батлахыг оролдож байгаа нь худлаа гэдгийг нотлохын тулд Эзний өдөр болох гол үйл явдуудыг тодорхой болгох (2:1-12); (3) Ажил хийхийг эсэргүүцдэгийг засаж залруулахын тулд чуулганы зүгээс хийх ёстай алхмуудын талаар тодорхой зааварчилгаа өгөх (3:6-15).

Христийн тухай 2 Тесалоник номд: Энэ номын, ялангуяа 1-2 дугаар бүлгийн гол сэдэв нь Христ энэ дэлхийг шүүхээр буцаж ирэх тухай бөгөөд тэр үед Христ бүх эсэргүүцэгчдийг шийтгэн устгах болно. 2 Тесалоник ном нь Христийг ирж буй шүүлт хэмэн урьдчилан харуулдаг.

Хувийн Судлал: Агуулга

1. Мэндчилгээ болон танилцуулга (1:1-2)
 2. Тесалоникчуудыг сайшааж, хавчлагатай холбогдуулан тайтгаруулсан нь (1:3-12)
 3. Эзний өдөртэй холбоотой залруулга ба уриалга (2:1-17)
2:1-12 2:13-15 2:16-17
 4. Залхуу хойрго байдалтай холбоотой буруутгал ба тушаал (3:1-15)
3:1-5 3:6-13 3:14-15
 5. Төгсгөлийн мэндчилгээ болон ерөөлийн залбирал (3:16-18)

1 ТИМОТ

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы Зуучлагч)

Номын нэр болон зохиогч: Тимот бол Ефесийн чуулган болон нийгэмд дэх зөрчил бэрхшээл дунд үйлчилж байсан залуу үйлчлэгч юм. Паул Тимотын халамжлагчийн хувьд түүнд зөвлөгөө өгөх зорилгоор хувьчлан 2 захидал бичсэн. Тэрээр мөн ийм шалтгаанаар Крет уруу Титэд захидал бичсэн байдаг. Энэ гурван захидалыг хоньчны захидал гэж нэрлэдэг.

Бичигдсэн огноо: МЭ 63 он. 1 Тимот болон Тит захидлуудыг Үйлс номтой харьцуулбал цаг хугацааны хувьд, Паулыг эхний удаа Ромын шоронгоос цагаатгагдан суллагдсаны (ялыг хэрэгсэхгүй болгосон) дараа бичигдсэн болох нь тодорхой харагддаг. Тиймээс 1 Тимот номыг Паул анх удаа шоронд ороод суллагдсаныхаа дараа буюу МЭ 63 оны хавар, МЭ 64 онд Ромын эзэн хаан Нерогийн хавчлага эхлэхээс өмнө бичсэн гэж үзэх нь зүйтэй юм. Тэрээр анх удаа шоронд ороод дөнгөж суллагдсаныхаа дараа МЭ 63 оны үед энэ захидлаа бичжээ. Харин Тит ном МЭ 65 оны үед, 2 Тимот МЭ 66 онд бичигдсэн байна. Эртний чуулганы эцэг гэгдэх Еусебийн хэлснээр, Паул МЭ 67 онд нас барсан аж. Тэрээр Ромын иргэн байсан учраас түүнийг Петр шиг загалмайд цовдлолгүй, харин толгойг нь сэлмээр авч цаазлан хороосон гэдэг.

Паул МЭ 48-56 оны хооронд илгээлтийн аяллуудаа хийсэн байдаг. МЭ 56-60 оноос Паул Ромын шүүхэд алгуурхан хандсаар эцэст нь Ромд иржээ. Тэрээр МЭ 61-62 онуудад Ромд хоёр жилийн турш хөлсний байранд, гэрийн хорионд байсан бөгөөд хоёр дахь жилийнхээ эцсээр суллагдсан байна. МЭ 62-67 оноос Паул илүү чөлөөтэй аялах болж, Тимотыг Ефест, Титийг Кретэд улдээгээд, дараа нь тус бүрд нь захиа

бичжээ. Тэгэхээр 1 Тимот болон Тит ном нь ойролцоогоор МЭ 63-65 онуудад бичигдсэн байх магадлалтай гэж үздэг. Паул дахин баригдаж шоронд орсныхoo дараа Тимотод хоёр дахь захидаа бичсэн нь 2 Тимот ном юм. Тэгэхээр ойролцоогоор МЭ 66 онд бичигдсэн энэ номыг Паулын сүүлчийн захидал гэж үздэг.

Сэдэв болон зорилго: 1 Тимот захидаас бид таван гол зорилгыг харж болно. Тэдгээр нь: (1) Тимотод даалгагдсан үүрэг хариуцлага (1:3), түүнд өгөгдсөн сүнслэг бэлэг (4:14) түүний сайн гэрчлэл (6:12) болон түүнд хариуцуулсан үзэл баримтлалыг хамгаалсан явдлыг нь (6:20) сануулан, сүнс болон зүрх зоригийг нь урамшуулан зоригжуулах; (2) Хуурамч багш нарын алдаатай сургаалыг засаж залруулахад нь Тимотод Библийн зөв ойлголтыг өгч, цаашид зөв үзэл баримтлалыг үргэлжлүүлэн авч явахыг урамшуулах (1:3-11, 18-20; 4:1-16; 6:3-10); (3) чуулганы мөргөлийг удирдах талаар удирдамж өгөх (2:1-15); (4) ирээдүйд гарч болох олон асуудлыг шийдвэрлэх удирдамжийг өгч, чуулганы ахлагч, үйлчлэгчдэд байх ёстой дадал зуршил (3:1-16) болон янз бүрийн бүлгийн хүмүүст байх ёстой зан чанарууд (5:1-20) зэрэг зүйлсийг хэрхэн зохицуулах ёстойг харуулах; (5) материализмын бузар муу зүйлсээс урьдчилан сээрэмжлүүлэх (6:11-19).

1 Тимот захидал нь Тит, 2 Тимот захидааудын адил хувь хүн болон чуулганд хамаатай сэдвийг хөнддөг. Хувь хүнд хандан “*сайн тэмцлээр тэмц*” (1:18) гэсэн сэдвээр хүүрнэдэг бол, чуулганд хандан, Бурханы гэр болох чуулганд хэрхэн хандах тухай өгүүлдэг (3:15).

Христийн тухай 1 Тимот номд: Аврагчийн бодгаль болон үйлчлэлийг онцлон харуулсан хэд хэдэн багцлал байдаг. Христ бол бидний үйлчлэлд зайлшгүй шаардлагатай бидний дуудлага, хүч чадал, итгэл болон хайрын эх үүсвэр (1:12-14); нүгэлтнүүдийг аврахаар ирсэн Нэгэн (1:15); “*Бурхан ба хүмүүсийн хоорондох ганц Зууч*” (2:5); “*Махан биеэр илчилгэсэн [Тэр нь] Сүнс дотор зөвтгөгдсөн, тэнгэр элч нарт харагдсан, үндэстнүүдийн дунд тунхаглагдсан, ертөнцөд илтгэгдсэн, алдар дотор дээши авагдсан*” (3:16); “*бүх хүмүүсийн, ялангуяа итгэгчдийн Аврагч*” (4:10) юм.

Хувийн Судлал: Агуулга

1. **Мэндчилгээ (1:1-2)**
2. **Үзэл баримтлалын талаарх зааврууд (1:3-20)**

1:3-7	1:12-17
1:8-11	1:18-20
3. **Мөргөлийн талаарх зааврууд (2:1-15)**

2:1-7	2:8	2:9-15
-------	-----	--------
4. **Удирдагчдын талаарх зааврууд (3:1-16)**

3:1-7	3:8-13	3:14-16
-------	--------	---------
5. **Аюулын талаарх зааврууд (4:1-16)**

4:1-5	4:6-10	4:11-16
-------	--------	---------
6. **Янз бүрийн үүрэг хариуцлагын талаарх зааврууд (5:1-6:10)**

5:1-2	5:17-22	6:1-2
5:3-8	5:23	6:3-10
5:9-16	5:24-25	
7. **Тимотод өгсөн сүүлчийн зааврууд (6:11-21)**

6:11-16	6:17-19	6:20-21
---------	---------	---------

2 Тимот

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы шүүгч)

Номын нэр болон зохиогч: 1 Тимот номыг үз.

Бичигдсэн огноо: МЭ 66 он. 1 Тимот номыг үз.

Сэдэв болон зорилго: Бид 2 Тимот номоос огт өөр нөхцөл байдлыг олж хардаг. 1 Тимот, Тит захицууд дээр Паул хүссэн газруудаараа аялах боломжтой, эрх чөлөөтэй нэгэн байсан бол энэ захидалд тэрээр широнд үхлийн ирмэг дээр байгааг харж болно. Паул энэ захицыг бичиж байхдаа дараах хоёр гол зорилгыг өмнөө тавьжээ: (1) Үхлийн ирмэг дээр ирээд байсан учраас Тимоттой амжиж уулзахын тулд түүнийг аль болох яаралтай Ромд ирэхийг ятгах (4:9, 21ийг 4:6-8 ишлэлтэй харьцуул); (2) зөв үзэл баримтлалаас тууштай зуурч, түүнийг бүх буруу сургаалаас хамгаалах, итгэлээс урвах явдал газар авч байгаа цаг үед амьдарч байгаа гэдгээ ойлгон, бэрхшээл зовлонг сайн цэрэг адил тэвчин даван туулахыг Тимотод анхааруулах.

1 Тимот номын адил энэ захидал нь хувь хүнд болон нийтэд хандсан сэдвийг хөндсөн байдаг. Хувь хүнд хандсан сэдэв нь “чамд өгөгдсөн Бурханы бэлгийн дөлийг бадраахыг чамд сануулъя” (2 Тимот 1:6) гэсэн хэсэг юм. Үүнээс гадна хувь хүн болон олон нийтийн аль алинд нь хандсан сэдвийг хөндсөн хэд хэдэн ишлэл байдаг (1:14; 2:1-2; 2:15; 4:5). Чуулганд хандсан сэдвийн хувьд, Бурханы сайн цэрэг адил (2:2-4) зовлон ба үйлчлэлээрээ бусдад зааж сургах чадвартай, эсвэл магадгүй сайн тэмцлээр тэмцэж, үйлчлэлээ дуусгаж байгаа (4:6-7) итгэмжит хүмүүст зөв сургаалыг даатгах тухай юм.

Христиин тухай 2 Тимот номд: Бүх үйлчлэл болон үйлчлэлийг тэвчээртэй авч явах бидний чадварын гол цөм нь Христиин бодгаль ба Түүний ажлын тухай үзэл баримтлал юм. Тиймээс үйлчлэл дэх тэсвэр хатуужлыг онцлон өгүүлдэг ямар ч номын үндэс суурь нь Христиин тухай үзэл баримтлал байдаг гэдэг нь гайхаад байх зүйл биш юм. Энд Түүнийг “үхлийг устган, амь ба үхэшгүй байдлыг сайн мэдээгээр дамжуулан гэрэлд авчирсан” (1:10), үхлээс амилсан Нэгэн (2:8), аврал болон мөнх алдрыг өгсөн Нэгэн (2:10), бүх итгэгчидтэй хамт үхэж, тэдэнтэй хамт амьдарч, итгэмжит үйлчлэлийнх нь төлөө тэднийг шагнан (зөвт байдлын титэм), Өөртэй нь хамт хаанчлах онцгой эрх мэдлийг тэдэнд өгсөн Нэгэн (2:11-13; 4:8) гэж дүрслэн өгүүлдэг.

Хувийн Судлал: Агуулга

- 1. Мэндчилгээ (1:1-2)**
- 2. Тимотын төлөөх талархал (1:3-7)**
- 3. Тимотын үүрэг хариуцлагыг сануулсан дуудлага (1:18-18)**
1:1-14 1:15-18
- 4. Итгэмжит үйлчлэгчийн зан чанар (2:1-26)**
2:1-7 2:14-19
2:8-13 2:20-26
- 5. Итгэмжит үйлчлэгчид зориулсан сэрэмжлүүлэг (3:1-17)**
3:1-9 3:10-17
- 6. Үгийг тунхаглах үүрэг даалгавар (4:1-5)**
- 7. Итгэмжит үйлчлэгчийн тайтгарал (4:6-18)**
4:6-8 4:9-15 4:16-18
- 8. Төгсгөлийн үг (4:19-22)**

Тит (Христ: Бидэнд өгсөн Бурханы энэрэл)

Номын нэр болон зохиогч: Хоньчны захидлуудын зохиогчийн талаар өмнө үзсэн учраас 1 Тимот номыг үзнэ үү.

Үйлс номд Титийн тухай огт дурдаагүй боловч Паулын захидлуудад олон удаа (13 удаа) түүний талаар дурдсан байдаг. Тэрээр сайн мэдээг түгээх үйлсэд Паулын хамгийн дотнын, итгэмжит хамтран зүтгэгчдийн нэг байсныг эдгээр багц ишлэлээс тодорхой харж болно. Паул нигүүлслийн сайн мэдээний (Үйлс15:1) талаар Иерусалимын удирдагчидтай ярилцахаар Антиохоос Иерусалим уруу явахдаа хөвч хөндүүлэлгүйгээр нигүүлслийг хүлээн авч болох жишээ болгон Титийг (Харь үндэстэн) дагуулж явсан (Галат 2:1-3). Энэ нь уг асуудлын талаарх Паулын байр суурийг баталсан юм (Галат 2:3-5). Түүнчлэн Тит Паулын гурав дахь аяллын туршид түүнтэй хамт Ефест үйлчилсэн гэсэн таамаглал байдаг. Дараа нь Элч Паул түүнийг Коринтын чуулганд туслуулахаар тэндээс Коринт хот уруу илгээжээ (2 Коринт 2:12-13; 7:5-6; 8:6).

Бичигдсэн огноо: МЭ 65 он. Хэдийгээр энэ номын бичигдсэн он тодорхой биш ч гэсэн түүнд өгүүлэгдсэн чухал үйл явдлуудыг нэгтгэн дүгнэж үзэх нь түүний бичигдсэн огноог барагцаалахад тусална. Тухайн үед Паул Ром дахь гэрийн хорионоос суллагдсан байлаа (энэ тухай Үйлс номын сүүлийн хэсгээс харж болно). Паул Ромын иргэн байсан бөгөөд буруутгагчид нь түүнд тулгаж байгаа ялаа нотолж чадаагүй учраас тэд Цезарийн өмнө түүнийг буруутгахгүй байхаар шийдсэн бололтой (Үйлс 24-25; 28:30). Тэдний зарга талаар болж, Паул чөлөөлөгдсөн байна. Дараа нь элч Паул Ефест очиж Тимотыг тэндхийн чуулганд үйлчлүүлэхээр үлдээгээд, өөрөө цаашаа Македони уруу явжээ. Тэрээр Македониос (Грекийн хойд хэсэг) 1 Тимот захидлыг бичсэн (1Тимот 1:3). Дараа нь тэр Кретэд очиж, тэндхийн чуулганд шийдвэрлэгдээгүй үлдсэн асуудлуудыг цэгцлүүлэхээр Титийг үлдээгээд, өөрөө Ахай аймгийн Никопол уруу явжээ (Грекийн өмнөд хэсэг, Тит 3:12). Тэгээд Паул Титийг урамшуулж, зааварчилгаа өгөх зорилгоор Македони юмуу Никополын аль нэгнээс энэ захидлыг бичжээ. Үүний дараа тэр Трой уруу явсан (2 Тимот 4:13) бөгөөд тэнд байхад нь түүнийг баривчилж, Ромд авчран шоронд хориод, эцэст нь цаазаар авсан. Өмнө дурдсанчлан, Паул хоёр дахь удаагаа гянданд хоригдож байхдаа Ромоос 2 Тимот захидлыг бичсэн. Энэ явдал МЭ 62-67 оны үед болжээ.

Сэдэв болон зорилго: Энэ захидлаас хэд хэдэн сэдэв болон зорилгыг харж болно. Паул энэ захидлыг: (1) Кретэд чуулгануудыг зүй ёсоор нь байгуулахын тулд дутуу зүйлсийг гүйцээхэд юу шаардлагатай байгаа талаар Титэд заавар өгөх; (2) Титэд эсэргүүцэл тулгарч байсан учир түүнд эрх мэдлийг өгөх (2:15; 3:1-15); (3) энэ эсэргүүцэлтэй хэрхэн нүүр тулах талаар зааварчилгаа өгөх; итгэл болон ёс зүйн талаар онцлон зааварчлах; (4) хуурамч багш нараас сээрэмжлүүлэх (1:5, 10-11; 2:1-8, 15; 3:1-11); (5) өвөл Никополд Титтэй дахин уулзах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдэхийн тулд бичжээ. Энэ уулзалт болсон эсэхийг бид мэдэхгүй. Ямар ч байсан Тит Кретэд буцаж ирээд амьдралынхаа эцсийн мөч хүртэл тэнд үйлчилсэн гэж үздэг.

Амийг аварснаар бидэнд илэрхий болсон Бурханы нигүүлсэл болон Христийн үхэл биднийг хэрхэн бурханлаг бус байдлаас татгалзан, Бурханы үзэл баримтлалыг дагагч, сайныг үйлдэгч хүмүүс болохын хувьд хэрхэн зөвт бөгөөд ухаалаг амьдрахыг зааварчилж байгааг энэ сэдэв харуулдаг (2:10-3:9).

Ахлагч хүнд байх ёстой чанарууд (1:5-9), янз бүрийн насны хүмүүст өгсөн заавар зөвлөгөө (2:1-8), эрх баригчидтай харилцах харилцаа (3:1-2), сэргээлт нь хүний үйлс болон Ариун Сүнсэй ямар холбоотой болох (3:5), Бурханы хүмүүсийн дундах сайн үйлсийг дэмжихэд нигүүлслийн үүрэг (2:11-3:8) гэх мэт нэлээд хэдэн чухал асуудлын талаар уг захидал өгүүлдэг.

Христийн тухай Тит номд: Паулын бусад сургаалын дагуу, христитгэгчдийн биеэ авч явах байдал өнгөрсөн, одоо, ирээдүйд Христийн бодгаль болон Түүний ажилтай ямар холбоотой болохыг бид энэ номоос хардаг. Түүнчлэн бид эндээс бурханлаг байдал (2:12) болон Аврагчийн золилтын ажлыг (2:13) хардаг. Энэ номд Христ Есүсийг “**бидний аугаа Бурхан ба Аврагч болох Есүс ... өөрийгөө бидний төлөө**

өгсөн нь биднийг алив ёс бус байдлаас золин, **Өөртөө сайн үйлсийн төлөө зүтгэлтэй, тусгай ард түмнийг цэвэршигүүлэхийн тулд юм**” (2:13-14) хэмээн дурсэлсэн байдаг.

Хувийн Судлал: Агуулга

1. Нээлтийн мэндчилгээ (1:1-4)
2. Чуулганы ахлагчдад байх ёстой чанарууд (1:5-9)
3. Чуулган дахь ёс бусыг үйлдэгчид (1:10-16)
4. Чуулган дахь хэсэг бүлгүүд (2:1-3:11)

2:1-2	2:9-10	3:1-11
2:3-5	2:11-14	
2:6-8	2:15	
5. Сүүлчийн зааварчилгаа ба мэндчилгээ (3:12-15)

Филемон

(Христ: Бидэнд өгөгдсөн Бурханы найдвар)

Номын нэр болон зохиогч: Паул шоронгийн бусад захидалынхаа (Ефес, Филиппой, Колоссай) нэгэн адил Филемоныг Ромын шоронд анхны удаа хоригдож байхдаа бичжээ. Тэрээр Ромын эзэнт гүрний мянга мянган боолын нэг, эзнээсээ оргон зугтсан Онесимын эзэн Филемонд уг захидалыг бичсэн аж. Онесим Ромд оргож ирээд, улмаар баригдаж шоронд хоригдоод байхдаа элч Паултай танилцаж, түүнээс болж Христийг хүлээн авчээ (1:10). Тийнхүү Онесим, Филемон хоёр хоёулаа бие биенийхээ өмнө христэч үүрэг хариуцлага хүлээх хэрэгтэй болсон. Өөрөөр хэлбэл, Онесим өөрийн эзэн Филемон уруу буцаж, харин Филемон түүнийг христэч дүүгийн ёсоор учлан хүлээж авах ёстой байсан. Оргон зугтсан боолыг үхэх ялаар шийтгэх нь энгийн зүйл байсан боловч Паул Онесимын өмнөөс учлал гүйн өмгөөлсөн.

Бичигдсэн огноо: МЭ 60–61 он. Паул Ромын шоронд эхний удаа хоригдож байхдаа бичсэн гэдгээс үзвэл энэ захидал МЭ 60-61 оны үед бичигдсэн байж таарна.

Сэдэв болон зорилго: Паулын бүх захидалуудаас хамгийн хувьчилсан өнгө аяс бүхий энэ захидалын гол зорилго нь Онесимыг учлан, хайртай дүү, сайн мэдээний хамтран зүтгэгч болохынх нь хувьд түүнийг буцаан хүлээж авахыг Филемоноос хүсэх явдал байв (1:10-17). Онесимын учруулсан хохирлыг өөртэй нь тооцохыг Паул Филемоноос гүйсан байдаг. Энэ утгаараа уг захидал нь бидний оронд өөртөө шийтгэлийг авсан Христийн дүр зурагтай тохирдог юм (1:18). Филемон номын хоёр дахь зорилго нь Христийн амийн үр нөлөөг амьдралаараа илэрхийлэн харуулахыг хичээж яваа бидэнд христэч хайрыг хэрхэн амьдралд хэрэгжүүлэх тухай зааж сургах явдал юм. Энэ нь гэр бүл доторх харилцаа болон эзэн - зарц, ажил олгогч - ажилтны хоорондох харилцаа гэх мэт бусадтай харилцах харилцааг маань өөрчилдөг. Энэ шинэ харилцааны талаар Паул шоронгийн бусад захидалууддаа (Ефес 6:5-9; Колоссай 3:22; 4:1) өгүүлсэн байдаг. Харин энэ захидалаас бид нэгэн гайхалтай үлгэр жишээг олж хардаг. Филемон захидал дахь Паулын сүүлийн зорилго нь тэрээр Филемоны төлөө талархлаа илэрхийлж, шоронгоос суллагдах үед нь байр сууц бэлтгэхийг хүсэх явдал байлаа (1:4-7, 22). Эцэст нь дүгнэн хэлэхэд, энэ захидалын сэдэв нь амьдралыг өөрчлөгч Сайн мэдээний хүч чадлын тухай юм. Энэхүү хүч нь нийгмийн янз бүрийн нөхцөл байдалд хүрч, бидний харилцааг боолчлоо ах дүүгийн барилдлага уруу өөрчилдөг.

Колоссай чуулганд зөвхөн Филемон ганцаараа боолын эзэн байсан юм биш (Колоссай 4:1). Тиймээс бусад христитгэгч эздийн боол-ахан дүүсийн харилцаанд энэ захидал заавар өгсөн. Филемоны боолоо захиравх эрх мэдлийг Паул үгүйсгээгүй, харин Онесимд тохиолдоод байгаа нөхцөл байдалд түүнтэй христитгэгч дүүгийн ёсоор харилцахыг түүнээс хүссэн (1:16) юм. Үүний зэрэгцээ Онесимын барагдуулах ёстой өрийг

Паул хувиасаа төлнө гэдгээ хэлсэн. Ингэснээрээ энэ захидал боолчлолыг эсэргүүцэж байгаа хэрэг бус, харин нийгмийн ийм тогтолцоон дунд христитгэгч эзэд болон боолууд хэрхэн итгэлээр амьдрахыг зааж зөвлөдөг. Магадгүй, Филемон Онесимыг чөлөөлж, Паул уруу буцаан явуулсан байж болох юм (1:14). Түүнчлэн, хожим нь Онесим Ефесийн чуулганы үйлчлэгч, улмаар бишоп болсон гэсэн таамаг бас байдаг.⁸⁴

Христийн тухай Филемон номд: Христээс итгэгч хүмүүсийн хүлээн авдаг учлалыг Филемоны жишээгээр энэ ном маш гайхалтай үлгэрлэн харуулдаг. Асар их гэм бурууд унаад байсан Онесимын (1:11, 18) төлөөх хайрынхаа улмаас Паул түүний төлөө зуучлан (1:10-17) залбирдаг. Паул өөрийн эрх мэдлийг хойш тавьж (1:8), Онесимын өрийн оронд өөрийгөө өгөхийг хүссэн (1:19). Филемоны энэрэнгүй үйлсээр Онесим шинэчлэгдэн сэргээгдэж, шинэ харилцаанд орсон (1:15-16). Бидний нөхцөл байдал ч мөн Онесимынхтэй адил юм. Паул Филемоны өмнө Онесимыг өмгөөлсөн нь Христ Бурханы өмнө биднийг зуучилсантай адил юм. Онесим хуулиар буруутгагдсан байсан боловч нигүүлслээр аврагдсан.⁸⁵

Хувийн Судлал: Агуулга

1. **Филемоны төлөөх талархлын залбирал (1:1-7)**
1:1-3 1:4-7
2. **Онесимын төлөөх Паулын гуйлт (1:8-18)**
1:8-9 1:10-16 1:17-18
3. **Филемонд өгсөн Паулын амлалт (1:19-21)**
4. **Хувийн асуудлууд (1:22-25)**

3-р хэсэг

Ерөнхий Захидлууд

Танилцуулга: Бид одоо Шинэ гэрээний каноны сүүлийн найман захидалыг үзэх гэж байна. Тэдгээрийн долоог нь Ерөнхий буюу Католик (нийтэд зориулсан) захидал гэж нэрлэдэг ба Еврей номыг энэ ангиллаас хассан байдаг. Эдгээр захидалыг чуулгануудад болон хувь хүмүүст хандаж бичсэн Паулын бусад захидаас ялгахын тулд католик гэдэг нэр томьёог ашигласан агаад энэ нь ерөнхий буюу нийтийн гэсэн утгыг илэрхийлдэг.⁸⁶ Эдгээр нь (2 ба 3 Иоханаас бусад нь) тодорхой нэг бүс нутагт хаяглагдан, түүгээр хязгаарлагдаагүй юм. Жишээ нь, Иаков номыг “*харь газар тархсан арван хоёр овогт*” хэмээн хаягласан нь газар газрын итгэгчдэд (тухайн үеийн бүх христитгэгч иудейчүүд бололтой) зориулсан гэсэн санааг илэрхийлдэг. Мөн 1 Петр захидалыг “Понт, Галат, Каппадок, Ази болон Битун нутгуудаар тархсан, түр суурьшигч нарт (иргэн бус)” хэмээн хаягласан нь эдгээр нутагт оршин сууж буй итгэгчдэд зориулан бичсэн гэсэн санааг илэрхийлж байна. Түүнчлэн, хэдийгээр 2 ба 3 Иохан ном нэр бүхий тодорхой хүмүүст хаяглагдсан боловч тэдгээрийг энэ бүлэг захидалд багтаадаг. Ийм ялгаануудын улмаас энэ найман захидалыг тус хичээл дээр “Ерөнхий захидал” хэмээн нэрлэсэн юм. Ер нь Паулын захидалууд хүлээн авагчийнхаа нэрээр нэрлэгддэг боловч Ерөнхий захидалуудын хувьд, Еврей номоос бусад нь зохиогчийнхоо нэрээр нэрлэгдсэн байдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Ерөнхийд нь, бид Иаков болон 1 Петр номыг Аврагчтай хамт ариун амьдрахад итгэгчдийг уриалан дуудсан ёс суртахууны (зөв, буруугийн талаарх бурханлаг зарчмуудын дагуу) ном гэж хэлж болно. 2 Петр болон Иуда нь итгэгчдийг хуурамч багш нарын аюулаас сэрэмжлүүлсэн, итгэлийнхээ төлөө тэмцэхэд дуудсан, төгсгөлийн үеийн (эш үзүүллэгийн) сануулга болсон номууд юм. Харин Еврей болон Иоханы захидалууд нь Бурханы сүүлчийн илчлэлт болон Хуучин гэрээний бүрэн биеллийн үед Христ дотор байж, сайн мэдээний үнэнийг гажуудалгүй, Христийн амийн дагуу амьдрахад итгэгчдийг дуудсан, Христийн онол ба ёс суртахууны тухай номууд юм.

Хэдийгээр энэ найман захидал хэмжээний хувьд том биш ч (Шинэ гэрээний 10-аас бага хувийг бүрдүүлдэг) үзүүлэх үр нөлөө нь асар их юм. Эдгээр захидал нь христэч үнэний баялгийн талаарх өөр өөр байр суурийг санал болгосноороо Паулын арван захидалыг улам баяжуулж өгдөг. Энэ таван зохиогч (Иаков, Петр, Иохан, Иуда болон Еврей номын зохиогч) тус бүрдээ өөрийн гэсэн онцгой хувь нэмрээ оруулсан юм. Хэрэв энэ таван хүний бичвэрүүдийг Библийн канонд оруулаагүй байсан бол Уйлс номоос хойших Шинэ гэрээний илчлэлтүүд зөвхөн нэг элчийн байр сууриар хязгаарлагдах байсан учраас эдгээр захидал нь Паулын захидалууд шиг агуу юм.⁸⁷

Еврей (Христ: Бүхнээс дээгүүр Нэгэн)

Номын нэр болон зохиогч: МЭ-ий эхний хэдэн зууны турш энэ захидалын зохиогчийн талаар хүмүүс нэлээд санал зөрөлддөг байжээ. Харин түүнээс хойш 1200-гаад жилийн туршид (МЭ 400 оноос 1600 оныг хүртэл) үүнийг Паулын “Еврейчүүдэд бичсэн захидал” гэж дийлэнх хүн үзсээр иржээ. Энэ номын хамгийн эртний нэр нь “Еврейчүүдэд” гэдэг байжээ.

Зохиогчийн тухайд эрдэмтэд маш олон санаа гаргаж, тодорхой асуудал дэвшүүлж байсан боловч зохиогчийг нэрээр нь дурдсан нэг ч хэсэг уг номд байдаггүй. Түүнчлэн хэзээ, хаана, хэнд зориулагдан бичигдсэн нь ч тодорхойгүй байдаг.

Гэхдээ уг номын зохиогч тухайн үеийн уншигчдад нууц биш, тэдний сайн мэддэг хүн байжээ (13:18-24). Гэсэн хэдий ч зарим нэг шалтгааны улмаас эртний чуулган энэ номын зохиогчийн тал дээр хэд хэдэн саналд хуваагдсан байжээ. Чуулганы нэг хэсэг нь түүнийг Паулынх гэж үзэж байсан бол нөгөө хэсэг нь Барнаб, Лук эсвэл Клементийнх гэж итгэж байжээ. Харин өөр нэг хэсэг нь түүнийг нэр нь үл мэдэгдэх нэгэн бичсэн гэж үзэж байсан. Хэдийгээр Еврей номын зохиогч нь тодорхой биш боловч үүнд сүнслэг түн утга санаа нь түүнийг Бурханы онгodoor бичигдсэн болохыг гэрчлэн харуулдаг.

Паул захидлаа хэнд зориулж бичиж байгаагаа тодорхой бичдэг байсан бол Еврей захидлын хувьд тиймгүй байгаа нь бидэнд нэгийг бодогдуулдаг. Түүнчлэн энэ номд Хуучин гэрээнээс олонтаа иш татаж, тахилын тогтолцоог ихэд онцолсноос үзвэл, үүнийг хүлээн авагчид нь еврейчүүд байсан болов уу гэсэн сэтгэгдлийг төрүүлдэг. Энэ талаар Зэйн С. Ходжес хэлэхдээ:

Еврей номын анхны уншигч нь түүний зохиогчийн адил тодорхойгүй байдаг. Гэхдээ ямар ч байсан тэд тодорхой бүлгийн нэг хэсэг байсан илэрхий юм. Дараах хэдэн эргэцүүллээс бид үүнийг харж болно. Уншигчдынх нь түүх тодорхой байсан тул зохиогч тэдний “өнгөрсөн өдрүүд”-ийн тухай дурджээ (Еврей 10:32-34). Тэрээр өнгөрсөнд болон тухай үеийн бусад христитгэгчдэд хандаж байсан тэдний өгөөмөр сэтгэл (6:10) болон сүнсний байдлыг (5:11-14) сайн мэдэж байсан. Түүнээс гадна зохиогч тэдэнтэй тодорхой холбоотой байсан бөгөөд тэдэн уруу очих санаатай байгаагаа илэрхийлсэн байдаг (13:19, 23). Магадгүй Тимоттой хамт очих бодолтой байсан бололтой. Энэ аяллын төлөө залбирахыг тэднээс мөн хүссэн байдаг (13:18).

Дээрх бүхнээс хараад, энэ номын уншигчдын дийлэнх нь иудей гаралтай хүмүүс байсан гэж үзэж болохоор байна. Хэдийгээр энэ нь заримдаа эргэлзээ төрүүлдэг ч захидлын агуулга өөрөө ийм дүгнэлт гаргахад хүргэдэг. “Еврейчүүдэд” гэсэн эртний нэр нь мэдээж, таамаг төдий нэр байж болох авч энэ бол байх л ёстой ердийн зүйл юм. Энд хэлэгдэж байгаа бүхэн Харь үндэстнүүдэд зориулагдсан мэт харагдаж болох ч зохиогч цэвэр иудейчүүдийг ихэд онцолж, Левийн тахилын тогтолцоо амь бөхтэй байсаар байгааг тууштай эсэргүүцэж байгаагаас үзвэл, уншигчдын ихэнх нь хуучин итгэл уруугаа хазайсан иудейчүүд байсан гэдгийг харж болно. Түүнчлэн уг номыг зохиогч Хуучин гэрээний Судруудын эрх мэдлийг маш хүчтэй илэрхийлсэн байгаа нь үүнийг тэдгээр Судрыг сайн мэддэг, түүгээр өсөж хүмүүжсэн хүмүүст зориулан бичсэн болохыг илтгэн харуулдаг.⁸⁸

Бичигдсэн огиоо: МЭ 64–68 он. Дараах хэдэн баримтын улмаас энэ номыг МЭ 64-68 онд бичсэн гэж үздэг: Нэгдүгээрт, МЭ 95 онд Ромын Клемент (эртний чуулганы пастор) энэ номоос иш татсан байдаг. Хоёрдугаарт, уг ном МЭ 70 оны Иерусалимын сүйрлээс өмнө бичигдсэн болох нь дараах шалтгаануудын улмаас илэрхий харагддаг: (1) хэрэв ийм чухал үйл явдал болсон байсан бол зохиогч энэ номд хөндсөн гол асуудал болох иудейчүүдийн тахилын тогтолцооны төгсгөлийн зэрэгцээ сүмийн сүйрлийн талаар дурдах байсан; (2) зохиогч нь Сүмийн тухай болон тахилын тухай одоо болж байгаа мэтээр өгүүлсэн байдаг (5:1-3; 7:23, 27; 8:3-5; 9:6-9, 13, 25; 10:1, 3-4, 8, 11; 13:10-11); (3) 13:23-р ишлэлд зохиогч Тимотыг дөнгөж суллагдаад байгаа тухай дурдсан байна. Хэрэв Тимотын Паултай хамт Ром үйлчилж байсантай холбож үзвэл энэ нь 60-аад оны сүүлээр байх ёстой.

Сэдэв болон зорилго: Еврей номын сэдэв нь Христийн сүр жавхлангийн агуу байдал буюу Түүний давуу байдал, мөн Хуучин гэрээний бүх тогтолцоон дахь христитгэлийн тухай гэдэг нь тодорхой. Үүнийг илэрхийлэн харуулахын тулд “илүү”, “төгс”, “тэнгэрлэг” гэх мэт үгсийг илэрхий ашигласан байдаг. Христ бол эрхэм дээд бөгөөд илүү гэдгийг зохиогч харуулахыг гол зорилгоо болгоходо дараах таван зүйлийг илчлэн харуулахыг хичээсэн. Христ бол эрхэм дээд: (1) Хуучин гэрээний эш үзүүлэгчдээс (1:1-3); (2) тэнгэр элч нараас (1:4-2:18); (3) Мосегээс (3:1-6); (4) Иошуагаас (3:7-4:16); (5) Аароны тахилчлалаас (5:1-10:18). Энэ сэдвийн гол зорилго нь Хуучин гэрээний тогтолцооны түр зуурын сүүдрээс (10:1) болоод Христ дотор олж авсан зүйлээсээ эргэж, бууж өгөх вий хэмээн уншигчдаа сэрэмжлүүлэх явдал байлаа. Ийнхүү тэр өөрийн уншигчдыг төлөвшил уруу урин дуудаж, өөрсдийнхөө бурханлаг дуудлагыг гүйцэлдүүлсэн итгэмжит христигэгчдэд өгөгдөх шагналд урамшуулсан. Үүний тулд тэднийг христэч итгэл дотроо өсөж төлөвшихөд уриалан дуудсан таван багцлалыг өгч, тэдгээрээр дамжуулан сэрэмжлүүлсэн (2:1-4; 3:1-4:13; 5:11-6:20; 10:26-39; 12:14-29).

Христийн тухай Еврей номд: Христийн эрхэм дээд байдлыг харуулахыг гол зорилгоо болгосон Еврей ном нь Шинэ гэрээн дэх Христийн тухай онолын цорын ганц ном юм. Энэ номд Христийг Бурханы мөн чанарын бодит илэрхийлэл, Түүний алдрын туяа (1:3, 13), Түүний баруун гарч залардаг (1:3), Эцэг Бурханаар Бурхан хэмээн тунхаглагдсан Нэгэн (1:8-9), мөнхийн Бүтээгч (1:10-12), Мелхизедэкийн хэргээний дагуу гарч ирсэн Мөнхийн Тахилч (7 бүлэг), Бурхан Эцэгээр Бурхан хэмээн тунхаглагдсан (1:3)

Хүү хэмээн тунхагласан байдаг. Түүнчлэн энд Христийг тэнгэрлэг Эш үзүүлэгч, Тахилч, Хаан хэмээн илэрхийлдэг. Тэр ганц удаагийн тахилаар шийдэх боломжгүй зүйлийг үйлдэн, бидний нүглийн асуудлыг нэгмөсөн шийдэж, биднийг Өөрийн ахан дүүс болгон Өөртөө золин авсан, бидний Аврагч юм. Тийнхүү Тэр бидний сул дорой байдлыг хуваалцсан тэнгэр дэх бидний Агуу Тэргүүн Тахилч болсон юм.

Хувийн Судлал: Агуулга

1. Христ Хуучин гэрээний удирдагчдаас дээгүүр болох нь (1:1–7:28)

- A. Христ Хуучин гэрээний эш үзүүлэгчдээс илүү дээгүүр болох нь (1:1-3)
- B. Христ тэнгэр элч нараас илүү дээгүүр болох нь(1:4–2:18)

1:4-14	2:5-8	2:14-18
2:1-4	2:9-13	
- B. Христ Мосгээс илүү дээгүүр болох нь (3:1-6)
- Г. Христ Иошуагаас илүү дээгүүр болох нь (3:7–4:13)

3:7-11	4:1-5	
3:12-19	4:6-13	
- D. Христ Аароны тахилчлалаас илүү дээгүүр болох нь (4:14–7:28)
 - 1) Бат зуурахыг уриалсан нь (4:14-16)
 - 2) Тахилчийн чадварууд (5:1-10)

5:1-4	5:5-10	
-------	--------	--
 - 3) Сүнслэг залхуурлыг орхихыг уриалсан нь (5:11–6:12)

5:11-14	6:1-8	6:9-12
---------	-------	--------
 - 4) Бурханы амлалтын баталгаа (6:13-20)
 - 5) Христ тахилчийн үүргээс илүү дээгүүр болох нь (7:1-28)

7:1-3	7:11-22	
7:4-10	7:23-28	

2. Бидний Тэргүүн Тахилчийн эрхэм дээд тахилын ажил (8:1–10:39)

- A. Илүү сайн гэрээ (8:1-13)

8:1-6	8:7-13	
-------	--------	--
- B. Илүү сайн асар (9:1-10)

9:1-5	9:6-10	
-------	--------	--
- B. Илүү сайн тахил (9:11–10:18)

9:11-14	9:23-28	10:11-18
9:15-22	10:1-10	
- Г. Ятгалгууд (10:19-39)

10:19-25	10:26-31	10:32-39
----------	----------	----------

3. Итгэлээ хадгалахын төлөөх сүүлчийн гуйлт (11:1–12:29)

- A. Түүхэн дэх итгэлийн баатруудын жишээ (11:1-40)

11:1-2	11:13-16	11:30-31
11:3-7	11:17-22	11:32-38
11:8-12	11:23-29	11:39-40
- B. Итгэлээ хадгалахыг уриалсан нь (12:1-11)

12:1-2	12:3-11	
--------	---------	--
- B. Итгэлээ хадгалахыг ятгасан нь (12:12-17)

12:12-13	12:14-17	
----------	----------	--
- Г. Итгэлээ хадгалахад өдөөсөн нь (12:18-29)

12:18-24	12:25-29	
----------	----------	--

4. Төгсгөл (13:1-25)

- A. Христэч амьдралын бодит зарчмууд (13:1-17)

13:1-6	13:7-14	13:15-16
--------	---------	----------

- Б. Залбирахыг гүйсан нь (13:18-19)
- В. Ерөөл (13:20-21)
- Г. Хувийн тэмдэглэл (13:22-23)
- Д. Мэндчилгээ болон сүүлчийн ерөөл (13:24-25)

Иаков

(Христ: Улгэр жишээ)

Номын нэр болон зохиогч: “Бурхан ба Эзэн Есүс Христийн зарц Иаков би харь газарт тархсан арван хоёр овогт мэндчилж байна” (1:1) хэмээн энэ захидал эхэлдэг. Шинэ гэрээнд дөрвөн өөр Иаков гардаг. Тэдгээр нь: (1) Зебедеен хүү, Иоханы ах Иаков (Марк 1:19); (2) Алфайн хүү Иаков (Марк 3:18); (3) Иудасын эцэг Иаков (Искариотын биш; Лук 6:16); (4) Эзэний дүү Иаков (Галат 1:19) нар юм. Энэ талаар Райри ингэж бичжээ:

Шинэ гэрээн дэх Иаков нэртэй дөрвөн хүнээс зөвхөн хоёрыг нь буюу Зебедеен хүү (Иоханы ах) Иаков, Эзэний дүү Иаков хоёрын аль нэгийг энэ номын зохиогч гэж таамагладаг. Гэвч Зебедеен хүү Иаков МЭ 44 онд итгэлийнхээ төлөө алагдсан учраас түүний хувьд энэ номын зохиогч байх боломжгүй юм (Үйлс 12:2). Түүнчлэн энэ захидаас ажиглагддаг асар их эрх мэдэл нь Шинэ гэрээнд арай цөөн дурдагддаг хоёр Иаковыг (“Жижиг гэгдэг Иаков” болон Лук 6:16-д дурдсан Иаков) уг номын зохиогч гэх таамаглалаас хасаж, харин Иерусалимын чуулганы удирдагчаар хүлээн зөвшөөрөгдсөн, Есүсийн дүү Иаков уруу анхаарлыг хандуулдаг (Үйлс 12:17; 15:13; 21:18). Иерусалимын Зөвлөл дээр Иаковын хэлсэн уг (Иаков 1:1 ба Үйлс 15:23; Иаков 1:27 ба Үйлс 15:14; Иаков 2:5 ба Үйлс 15:13) болон энэ захидалын грек хэл дээрх хувилбарын адил төстэй байдал нь энэ дүгнэлтийг баталдаг.⁸⁹

Иаков захидаа хүлээн авагчдадаа хаягласан байдлыг тайлбарлах хэрэгтэй юм. Тэрээр “**харь газарт тархсан арван хоёр овогт**” (1:1) хэмээн захидаа хаягласан байдаг. 1:19, 2:1-р ишлэлд “ах дүүс минь” хэмээсэн нь МЭ 66-70 оны хооронд тархан явсан хүмүүсийг бус, харин сүүлийн удаагийн тархалтаар нутгаасаа гарч явсан христитгэгч иудейчүүдийг (Матай 1:11, 12, 17) хэлж байна гэж ойлгож болох юм. Пентекостын өдөр болоход дэлхийн өнцөг булан бүрээс иудейчүүд Иерусалимд цугласан тухай Үйлс номын эхний бүлгүүдэд өгүүлдэг (Үйлс 1:5). Тэдний ихэнх нь Пентекостын өдөр болсон гайхамшигуудыг нүдээрээ харж, чихээрээ сонсож, улмаар Есүс Христэд итгэцгэсэн. Дараа нь тэдний олонх нь дэлхийн өнцөг булан бүр тийш, өөр өөрсдийн гэртээ буцсан. Иаков өөрийнхөө номд чухам энэ тухай бичжээ.

Бичигдсэн огноо: МЭ 45 юмуу 46 он. Ихэнх судлаачид Иаков номыг МЭ 45 оны үед бичигдсэн гэж үздэг бөгөөд үүнээс үзвэл энэ нь хамгийн анхны захидал байж ч болох юм. Ийнхүү үзэх болсон шалтгаан нь: (1) Энэ номоос Иудейн хэв шинж нэлээд хүчтэй ажиглагддаг бөгөөд энэ нь түүнийг чуулганд иудейчүүд давамгайлж байсан үед бичсэн болохыг харуулдаг. (2) Харь үндэстний хөвч хөндөлттэй холбоотой маргааны тухай энэ номд дурдаагүй. (3) “Синааг” гэдэг үгийг “чуулган” гэхээсээ илүүтэй уулзалт, эсвэл уулзалтын газар (2:2) гэдэг утгаар хэрэглэсэн байдаг. (4) Харь үндэстэн итгэгчид болон иудей итгэгчдийн хоорондох харилцаа гэх мэт Иерусалимын Зөвлөл дээр яригдсан асуудлуудын (Үйлс 15:1д.иш; МЭ 49 он) талаар дурдаагүй байгаа нь энэ ном маш эрт бичигдсэн гэсэн санааг илэрхийлдэг. (5) “Христийн сургаалын талаар дурдсан хэсгүүд нь Сайн мэдээний номуудтай үгчлэн таардаггүй нь магадгүй Иаков номыг Сайн мэдээний номуудаас өмнө бичсэн гэдгийг харуулж байж болох юм.”⁹⁰

Сэдэв болон зорилго: Амьд, хүчтэй, үр нөлөө бүхий идэвхтэй итгэлтэй байх талаар Иаков санаа тавьж байсан нь тодорхой харагддаг. Иаков үхмэл, идэвхгүй итгэлийн үр дагавруудыг итгэгчдэд урьдчилан сануулж, хувь хүн болон сүм чуулганы аль алийг нь итгэлийн өсөлт болон жинхэнэ сүнслэг төлөвшилт уруу өдөөн хөдөлгөхийн тулд энэ захидалыг бичжээ.

Христийн тухай Иаков номд: 1:1; 2:1-р ишлэлд Иаков “Эзэн Есүс Христ” хэмээн онцлон дурдаад, улмаар Түүний ирэлтийн талаар урьдчилан хэлсэн байдаг (5:7-8). Энэ захидалын 108 ишлэлд Хуучин

гэрээний 22 номоос иш татсан байдгаас гадна Есүс Христийн уулан дээрх сургаалаас битүү цухуйлгасан хэсэг доод тал нь 15 байдаг.

Хувийн Судлал: Агуулга⁹²

1. Итгэлээр зогсох (1:1-27)

- | | | |
|---|---------|---------|
| A. Мэндчилгээ (1:1) | | |
| B. Элдвийн сорилтон дунд баяр хөөртэй байх (1:2-12) | 1:2-4 | 1:5-8 |
| | | 1:9-12 |
| B. Ухэлд хүргэх уруу татлагуудыг эсэргүүцэх (1:13-18) | | |
| G. Тэнгэрлэг үнэн дотор амрах (1:19-27) | 1:19-25 | 1:26-27 |

2. Энэрэнгүй сэтгэлээр үйлчлэх (2:1-26)

- | | | |
|--------------------------------|---------|---------|
| A. Бусдыг хүлээн авах (2:1-13) | 2:1-7 | 2:8-13 |
| B. Бусдыг дэмжих (2:14-26) | 2:14-17 | 2:18-26 |

3. Хэл яриандаа болгоомжтой хандах (3:1-18)

- | | | |
|---------------------------------------|-------|--------|
| A. Хэл яриагаа захирах (3:1-12) | 3:1-5 | 3:6-12 |
| B. Бодол санаагаа хөгжүүлэх (3:13-18) | | |

4. Гэмшин захирагдах (4:1-17)

- | | | |
|---|--------|---------|
| A. Атаа хорслоос номхон даруу байдал уруу эргэх (4:1-6) | | |
| B. Ял шийтгэлээс шударга байдал уруу эргэх (4:7-12) | 4:7-10 | 4:11-12 |
| B. Бардамнаал сайрхлаас итгэл уруу эргэх(4:13-17) | | |

5. Чин сэтгэлээсээ хуваалцах (5:1-20)

- | | | |
|--|---------|---------|
| A. Эд хөрөнгөө хуваалцах(5:1-6) | | |
| B. Тэсвэр тэвчээрээ хуваалцах (5:7-12) | | |
| B. Залбирлаараа хамт байх (5:13-20) | 5:13-18 | 5:19-20 |

1 Петр (Христ: Зовлонгийн үлгэр жишээ)

Номын нэр болон зохиогч: Зохиогч нь элч Петр гэдгийг эхний ишилэлд (1:1) тодорхой хэлжээ. 1 Петр номыг элч Петрийнх гэж эртний чуулган нийтээрээ хүлээн зөвшөөрдөг байжээ.

Энэ захидлыг харь нутагт (Понт, Галат, Каппадок, Ази болон Битун) түр сууж байсан сонгогдогсодод (итгэгчид) бичсэн аж (1:1). Өөрөөр хэлбэл, тархалтаас болж газар дэлхийгээр тархан суурьшсан иудей болон харь үндэстэн итгэгчдэд зориулан энэ захиаг бичсэн байна. “Тархан суурьшигсад” гэж Палестинд амьдарч байгаа бус, харин Газрын дундад тэнгис хавийн нутгаар тархсан иудейчүүдийг ерөнхийд нь хэлдэг. Харин энэ номын хувьд, бурхангүй ертөнцөд Бурханы хүмүүс болон тархсан Харь үндэстэн христитгэгчдийн тухай ярихдаа энэ үгийг хэрэглэсэн бололтой.⁹³ Петр энэ захиаг бичиж байхдаа иудей болон харь үндэстэн итгэгчдийн аль алиных нь талаар бодож байсан.

1 Петр захидлыг Бага Азийн хойг дээр орших Ромын таван мужаар тархсан христитгэгчдэд хаяглан бичжээ. Энэ газар бол өнөөгийн Туркийн хойд хэсэг юм. Эдгээр мужийн чуулганууд Харь үндэстнүүд болон иудейчүүдээс бүрдэж байжээ. Энэ захидалд Хуучин гэрээнээс иш татсан хэсэг нэлээд олон байдаг.

Тус захидлын эхэнд “тархсан” (1:1) хэмээн орчуулагдсан DIASPORA буюу ТАРХАН СУУРЫШСАН хэмээх нэр томьёо нь христитгэгч иудейчүүдийн хувьд маш онцгой ач холбогдолтой юм. Иерусалимаас гадна амьдарч байсан иудейчүүдийг ТАРХАН СУУРЫШИГСАД хэмээн нэрлэдэг.

Бурханы Угийг огт мэдэхгүй байсан тэднийг ариун амьдрал уруу уриалан дуудсан Петрийн ятгалгыг Харь үндэстэн уншигчид анзаарах байлаа (1:14). Түүнчлэн Харь үндэстэн итгэгчид өмнө нь Бурханыг мэддэггүй байсан хэдий ч, харин одоо “Бурханы ард түмэн” хэмээн тооцгдох болсондоо асар их урамших байлаа (2:10). Петр Бага Азийн чуулгануудыг урамшуулсан энэ захидалдаа иудей болон Харь үндэстэн итгэгчдийг хоёуланг нь тодорхой байна.⁹⁴

Бичигдсэн огноо: МЭ 63–64 он. Чуулганы уламжлалт үзлээр Петрийн амьдралын сүүлийн он жилүүдийг Ром хоттой холбож үздэг. Хэрэв 5:13-р ишлэлд Вавилон гэсэн нь цаад утгаараа Ромыг хэлсэн гэж үзвэл, Петр уг захидлыг амьдралынхаа сүүлийн арван жилийг Ромд өнгөрүүлж байхдаа буюу МЭ 63 оны үед, өөрөөр хэлбэл, МЭ 64 оны Неро хааны хавчлагын өмнөхөн бичжээ. Тэр үед Петр Ромыг христитгэлийн дайсан гэж хараахан үздэггүй байжээ (1 Петр 2:13-17). Неро хааны хавчлагын дараа ийм үг хэлэх нь илүү хэцүү байх байсан.

Сэдэв болон зорилго: 1 Петр номд янз бүрийн үзэл баримтлалын талаар өгүүлэхийн сацуу христэч амьдрал болон үүрэг хариуцлагын талаар маш олон зүйлийг хүүрнэдэг учраас уг номын сэдэв болон зорилго нь зовлон дээр, тодруулбал итгэлээсээ болж хавчигдаж буй зовлон дээр голлон анхаарсан байдаг. Энэ бол өнөөгийн энэ дайсагнасан ертөнцөд христитгэгчид хэрхэн Христийн элчин сайд, түр оршин суугчийн ёсоор амьдрахыг харуулсан гарын авлага болсон ном юм (1:1, 13-21; 2:11-12; 3:14, 17; 4:1, 13, 15, 16, 19).

Энэ номд хэд хэдэн онцгой зорилго байдаг. Хавчлага дунд байгаа итгэгчдэд удирдамж өгөхдөө: (1) Христээс ирэх илчлэлт болон аврал, түүний чөлөөлөлт дээр анхаарлаа хандуулах (1:3-12); (2) Христийг зовлон дундах өөрсдийн төгс үлгэр жишээ болгон даган дуурайх (2:21-24); (3) Харь үндэстнүүдийн дунд сайн үлгэр дуурайл болохын тулд Бурханы онцгой ард түмэн болон дуудагдсан тэрхүү дуудлагынхаа дагуу амьдрахыг (2:4-12; 4:1-19) анхааруулсан. Түүнчлэн үзэл баримтлал болон бодит үйлдлийн хоорондох чухал холбоосыг харуулах (5:12), чуулганыг энэ дэлхийд үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулах чадвартай байхад чухал шаардлагатай зүйл болох бурханлаг удирдлага болон Бурханы хонин сүргийг хариулах явдлыг урамшуулан зорижуулах зэрэг өөр зорилгууд энэ номд агуулагддаг (5:1-4).

Христийн тухай 1 Петр номд: Энэ ном Христийн бодгаль болон үйлчлэлийн талаар голлон өгүүлдэг. Христийн амилалтаар дамжуулан христитгэгчид “амьд найдвар” ба “мөхөшгүй (устаж алга болохгүй) өв”-тэй (1:3-4) болсон. Хэд хэдэн газар Петр Христийн ирж буй илчлэлт болон алдрын тухай өгүүлдэг (1:7, 13; 4:13; 5:1). Түүнчлэн бидний нүглийг загалмай дээр үүрч, биднийг Өөртөө золин авсан Бурханы Хурга болох Христийн бодгаль болон үйлчлэлийн тухай (1:18-19; 2:24), зовлон дунд бидний төгс үлгэр дуурайлал болсон Христийн тухай (2:21-24), итгэгчдийн Харгалзагч бөгөөд Ахлах Хоньчин (2:25; 5:4) болсон Христийн тухай өгүүлдэг.

Хувийн Судлал: Агуулга

1. Итгэгчдийн аврал (1:1-12)

- A. Мэндчилгээ (1:1-2)
- B. Ирээдүйн (амьд) найдвар болон өнөөгийн зовлон (1:3-9)
- C. Өнөөдрийн аврал ба өнгөрсөн үеийн илчлэлт (1:10-12)

2. Итгэгчдийн ариусгал (1:13–2:12)

- A. Ариун байдал уруу дуудагдсан нь (1:13-21)
1:13-16 1:13-16
- B. Бусдыг чин сэтгэлээсээ хайрлахад дуудагдсан нь (1:22-25)
- C. Угийн цэвэр сүүг хүсэхэд дуудагдсан нь (2:1-3)

- Г. Сүнслэг тахилуудыг өргөхөд дуудагдсан нь (2:4-10)
 - 2:4-8
 - 2:9-10
 - Д. Махан биеийн хүслийг эсэргүүцэхэд дуудагдсан нь (2:11-12)
- 3. Итгэгчид эрх мэдэлд захирагдах нь (2:13–3:12)**
- А. Засгийн газарт захирагдах нь (2:13-17)
 - Б. Ажил олгогчдоо захирагдах нь (2:18-20)
 - В. Христийн үлгэр дуурайл (2:21-25)
 - Г. Гэр бүл дэх захирах, захирагдах ёс (3:1-8)
 - Д. Амьдралын бүх талбарт дуулгавартай байх нь (3:9-12)

4. Итгэгчдийн зовлон (3:13–5:14)

- А. Зовлон дунд шаардлагатай зан чанар (3:13-17)
- Б. Зовлон дахь Христийн үлгэр дуурайл (3:18–4:6)
 - 3:18-22
 - 4:1-6
- В. Зовлон дундах тушаалууд (4:7-19)
 - 4:7-11
 - 4:12-19
- Г. Зовлон дундах харгалзагчид (хоньчид) (5:1-11)
 - 5:1-5
 - 5:6-11
- Д. Төгсгөлийн үг буюу ерөөл (5:12-14)

2 Петр (Христ: Угийн хангалттай байдал)

Номын нэр болон зохиогч: Зохиогч нь өөрийгөө Симон Петр (1:1) гэж маш тодорхой хэлсэн байдаг. Энэ номыг элч Петр бичсэн гэдгийг батлах өөр олон дотоод нотолгоо бий. Эцсийн амьсгалаа хураах гэж буй эцэг хүний гэрээслэл мэт ихэд хувьчлан бичсэн хэсэгтээ тэрээр өөрийгөө Христийн дүр хувиралтыг нүдээр харсан гэрч хэмээн мэдэгдэхдээ (1:16-18 уд. харьц. Матай 17:1-5) нэгдүгээр биеийн ганц тооны төлөөний угийг ашигласан байдаг (1:14). Түүнчлэн Петр үүнийг өөрийнхөө хоёр дахь захидал гэдгийг батлан хэлсэн (3:1) бөгөөд элч Паулыг “бидний хайрт ах” (3:15) гэсэн нь түүнийг хувьчлан таньдаг байсныг нь илтгэн харуулдаг. Энэ захидалыг Петрийн анхны захидаас ялгахын тулд “Хоёрдугаар Петр” гэж нэрлэжээ.

Петр эхнийхээ захидалыг бичсэн итгэгчдэд (3:1) энэ захидаа зориулжээ. Энэ бол эцсийн гэрээслэл, сээрэмжлүүлэг бөгөөд “эцсийн өдөр”-ийн тухай захиа юм (1:14; 2:1-22; 3:3). Тэр “Понт, Галат, Каппадок, Ази болон Битун” дахь иудей болон харь үндэстний чуулгануудын жинхэнэ итгэлт христитгэгчдэд хандан бичжээ (1 Петр 1:1).

Бичигдсэн огноо: МЭ 67–68 он. Энэ бол Петр ажил үйлчлэлийнхээ төгсгөл үед бичсэн хагацлын захиа гэж хэлж болохоор захидал юм (1:12-14). Эртний чуулганы түүхч Еусебын хэлсэнчлэн, Петрийг Неро хааны хавчлагын үеэр (МЭ 67-68 оны үе) цаазалжээ. Эдгээр жилийн аль нэгэнд энэ захидал бичигдсэн гэж үздэг.

Сэдэв болон зорилго: Паул амьдрал, үйлчлэлийнхээ сүүлийн он жилүүдэд итгэлээсээ урвах аюул ирж байгаа тухай сээрэмжлүүлж байсны адил Петр ч мөн эш үзүүлэгчид болон Эзэн Өөрөө, мөн Түүний элч нарын урьдчилан хэлж байсны дагуу хуурамч багш нарын аюул занал газар авч байгаа тухай сээрэмжлүүлжээ (2:1; 3:1-3). Энэхүү богинохон захидалын зорилго нь чуулганд тулгарч буй аюул занал, ялангуяа хуурамч багш нар олширч байгааг сээрэмжлүүлэх явдал байлаа.

2 Петр нь Бурхан биднийг амь болоод сүсэглэлд хэрэгтэй бүхнээр хангасан (1:3) гэдгийг дурдаад, уншигчдыг Христ дотор өсөж, үр ашигтүй, үр жимсгүй (1:8) байж болохгүй хэмээн хичээнгүйлэн ятгасан байдаг. Тийнхүү Паул үүн дээр үндэслэн уншигчдаа улам бүр өсөн нэмэгдэж байгаа хуурамч багш нараас сээрэмжлүүлсэн. Өөрт нь энэ дэлхий дээр амьдрах хугацаа бага үлдсэнийг (1:13-15) Петр мэдэж байсны

дээр Христийн биед аюул нүүрлээд (2:1-3) байсан учраас ийм зүйлийг бичих хэрэгтэй болсон байна. Ийнхүү Петр тэдний ой ухаан, бодол санааг сэргээхийг хүссэн (1:13; 3:1-2) бөгөөд тэгснээр тэд түүний сургаалыг мартахгүй санах чдвартай болох байлаа (1:15). Үүний тулд Петр төлөвшен итгэгч хүн ямар байх талаар дэлгэрэнгүй дүрслэн өгүүлээд, уншигчдаа Аврагчийн тухай мэдлэг болон нигүүлсэл дотор өсөхийг урамшуулжээ (1:2-11; 3:18).

Цааш нь, Петр хуурамч багш нартай холбоотой асуудлыг авч үзэхэд нь Бурханы Угийн мөн чанар тэдний баталгаатай үндэс суурь (1:12-21) болно гэдгийг хэлсэн. Үүний дараа тэрээр хуурамч багш нараас ирэх аюул заналаас сээрэмжлүүлээд, тэдний дээр гарцаагүй буух шийтгэлийг дэлгэрэнгүй дүрслэн өгүүлжээ (2:1-22). Эцэст нь, Петр Христ баталгаатай буцаж ирнэ хэмээн уншигчдаа урамшуулсан зоригжуулсан байдаг (3:1-16). Ийнхүү Петр хамгийн сүүлд Эзэний дахин ирэлтийн талаар онцлон хэлэхийн сацуу дараах эцсийн уриалгыг өгсөн байdag:

Тиймээс хайртууд минь, та нар эдгээрийг хүлээж буй учраас амар амгалан дотор болон толбогүй бөгөөд гэм зэмгүйгээр Түүнд олдохыг хичээгтүн... Тиймээс хайртууд минь, та нар үүнийг урьдаас мэдэж, өөрсдийгөө сэргийл. Эс тэгвэл та нар ёс зарчимгүй хүмүүсийн тохирогдолд автаж, тогтвортой байдлаа алдчих вий. Харин бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор осогтуун. Эдүгээ болон мөнхийн өдөрт аль алинд нь Түүнд алдар нь байх болтугай. Амен.

Христийн тухай 2 Петр номд: Христийг “Эзэн болон Аврагч” гэж дөрвөн удаа, “Эзэн” гэж арван дөрвөн удаа хэлснээрээ, Христ бол амь болоод сүсэглэлийн эх үүсвэр гэдэгт бидний харааг чиглүүлдэг. Ариун уулан дээрх сүр жавхлан хувиралтыг болон Аврагчийн дахин ирэлтийг урьдаас харж дурдсан байдаг. Тэр үед ариун уулан дээр Петр болон өөр хоёр дагалдагчийн харсан гайхамшигтай зүйлийг бүх дэлхий харах болно.

Хувийн Судлал: Агуулга

1. Мэндчилгээ (1:1-2)

2. Христэч зан чанарын өсөлт дэвшилт (1:3-21)

- | | | |
|----------------------------------|---------|---------|
| A. Итгэлийн өсөлт (1:3-11) | 1:5-8 | 1:9-11 |
| B. Итгэлийн хөрс суурь (1:12-21) | 1:12-15 | 1:16-18 |

3. Хуурамч багш нарыг буруутгасан нь (2:1-22)

- | | |
|--|--|
| A. Тэдний аюул занал болон үйлдэл (2:1-3) | |
| B. Тэдний сүйрэл буюу ял шийтгэл (2:4-10) | |
| C. Тэдний талаарх дүрслэл болон онцлог шинжүүд (2:11-22) | |

4. Ирээдүйн талаарх дүрслэл ба итгэл найдвар (3:1-18)

- | | | |
|---|-------|-------|
| A. Хуурамч багш нарын доог тохуу (3:1-7) | 3:1-2 | 3:3-7 |
| B. Эзэний өдрийн удаашрал (3:8-9) | | |
| C. Эзэний өдрийн төгсгөлд болох зүйлс (3:10-13) | | |
| D. Аюул занал дунд хэрэгтэй хичээл зүтгэл (3:14-18) | | |

1 Иохан

(Христ: Бурханы хайр)

Номын нэр болон зохиогч: Хэдийгээр энэ номд зохиогчийн нэрийг дурдаагүй боловч үүнийг Иохан бичсэн гэсэн уламжлалт үзэл байдаг. Үүнийг зохиогч нь Аврагчийг дотно сайн мэддэг, Түүнийг нүдээрээ харсан гэрч нарын нэг байсан (1:1-5).

Иохан энэ захидаа итгэгчдэд зориулж бичсэн гэдгийг уг номын аль ч ишилэлээс харж болох ч (2:1, 12-14, 19; 3:1; 5:13) чухам хаанахын ямар итгэгчдэд зориулсан нь тодорхойгүй байдаг. Эндээс үзвэл, тэрээр үүнийг хэд хэдэн чуулганд илгээхээр төлөвлөсөн байж болох юм. Магадгүй, тэдгээр чуулган нь Ефес хотын ойр орчмын чуулганууд байсан байх. Учир нь Иохан амьдралынхаа сүүлийн жилүүдийг Ефест өнгөрүүлсэн гэж эртний зохиолчид үздэг.

1 Иохан номыг хамгийн анх Азид (өнөөгийн Турк) албан ёсоор хэрэглэсэн гэсэн баримт байдаг бөгөөд энэ аймагт Ефес хот оршдог байжээ. Иохан энэ аймгийн нутаг дэвсгэр даяар тархсан олон чуулганд үйлчилж байсан хэмээн Александрын Клемент (I зууны үеийн пастор) хэлсэн байдаг. Тиймээс 1 Иоханыг Ази аймгийн чуулгануудад илгээсэн гэж үзэж болох юм.

Бичигдсэн огноо: МЭ 85–90 он. Иоханы энэ захидал болон бусад захидааудын бичигдсэн огноог тодорхойлоход хэцүү боловч нэлээд олон үг хэллэг, сэдвүүд нь Иоханы Сайн мэдээтэй адилхан байдаг учраас үүнийг уг Сайн мэдээний номын дараа, гэхдээ МЭ 95 онд болсон Домитаны хавчлагын өмнө бичсэн гэж үзэх нь зүйтэй юм. Тэгэхээр энэ ном бичигдсэн байж болох хамгийн бодит хугацаа нь МЭ 85-90 оны хоорондох үе юм.

Сэдэв болон зорилго: Энэ номын сэдэв нь Эзэн Есүс Христээр дамжуулан Бурхантай нөхөрлөх тухай юм (1:3-7). Иохан тухайн үеийн итгэгчдэд тулгараад байсан, магадгүй гностисизмын (бүх материаллаг зүйлс бузар муу бөгөөд зөвхөн мэдлэгээр л дамжуулж эрх чөлөөг олж авна гэсэн итгэл үнэмшил) эртний хэлбэр байж болох тэрс үзлийг эсэргүүцэн, Бурхантай нөхөрлөх нөхөрлөлийн мөн чанарыг тодорхойлох зорилгоор энэ захидалыг бичжээ. Тэрээр энэ захидалдаа Бурханыг гэрэл, хайр болон амь гэж дүрсэлсэн байдаг. Бурхан бол гэрэл (1:5), Бурхан бол хайр (4:8, 16), Бурхан бол амь (1:1-2; 5:11-13) юм. Тэгэхээр Бурхантай нөхөрлөх гэдэг нь Түүний амь, бусдын төлөөх Түүний хайр болон Түүний зөвт байдлыг хэрэгжүүлсэн амьдрал уруу удирдан замчилдаг тэрхүү гэрэл дотор алхахыг хэлдэг аж. Энэ номд маш олон шалгуур буюу баталгааг өгсөн байдаг бөгөөд зарим хүмүүс үүнийг авралын шалгуур гэж үздэг. Харин энэ номын гол сэдэв нь хуурамч багш нар болон тэдний сонсогчид нь итгэгчид байсан тухай өгүүлдэг учраас эдгээр шалгуур болон нотолгоог бидний нөхөрлөлийг, тодруулбал биднийг Аврагч дотор оршиж байгаа эсэхийг, мөн Түүнийг хэр таньж мэдэж байгааг шалгах зүйл гэж үзэх нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, итгэгч бид Аврагчтайгаа дотно харилцаатай байснаар бидний доторх Түүний амийг мэдэрдэг бөгөөд дээрх шалгуур, нотолгоонууд нь бидний энэ харилцааг шалгадаг.

Тэдгээр итгэгчдэд яг ямар төрлийн тэрс үзэл тулгараад байсныг тогтооход төвөгтэй ч 1 Иохан номын агуулгаас харвал, Христийн биежлийг үгүйсгэх, гэм нүгэл нь Бурхантай нөхөрлөх нөхөрлөлд саад болохгүй гэж тунхаглах явдал байсан нь илэрхий байдаг. Ийнхүү Иохан дараах таван зорилгоор өөрийнхөө “бяцхан хүүхдүүдэд” (2:1, 18, 28; 3:7, 18; 5:21) энэ захидалыг бичжээ: (1) жинхэнэ нөхөрлөлийг дэмжих (1:3д.иш); (2) бүрэн дүүрэн баяр баясгаланг мэдрэх (1:4); (3) жинхэнэ нөхөрлөлөөр дамжуулан ариун байдлыг хөхүүлэх дэмжих (1:6–2:2); (4) тэр үзлээс сэрэмжлүүлэн хамгаалах (2:18-27); (5) баталгаа өгөх (5:11-13).

Христийн тухай 1 Иохан номд: Энэ ном нь итгэгчдийн амьдрал дахь Аврагчийн үйлчлэлийг голчлон өгүүлдэг бөгөөд Түүний хоёр дахь ирэлтийг урьдчилан сануулдаг. Түүний цус нь нүглээ хүлээн зөвшөөрсөн (1:9) итгэгчдийг бүх гэм нүгэл болон бүхий л зөвт бус байдлаас үргэлж цэвэрлэдэг (1:7). Үнэндээ, Христ бол Эцэгийн өмнө биднийг өмгөөлөх зөвт Өмгөөлөгч (2:1) бөгөөд зөвхөн итгэгчдийн төдийгүй бүх ертөнцийн төлөөх тахил (2:2) хэмээн энэ захидал тунхагладаг. Түүнчлэн Есүс бол маань биеэр ирсэн Христ (2:22; 4:2-3); Өөрийн баптисм болон загалмайг илэрхийлэн, цус болон усаар ирсэн

нэгэн (5:6) агаад Түүнийг дахин ирэхэд бид Түүнийг харж, Түүнтэй адил болно (2:28–3:3) гэж энэ номд өгүүлдэг.

Хувийн Судлал: Агуулга

1. **Танилцуулга ба захидалын зорилго (1:1-4)**
2. **Нөхөрлөлд амин чухал нөхцөлүүд (1:5–2:2)**
 - A. Гэрэл дотор алхах (1:5-7)
 - B. Нүглээ хүлээн зөвшөөрөх (1:8–2:2)
1:8-10 2:1-2
3. **Нөхөрлөлд нийцэх зан авир (2:3-27)**
 - A. Нөхөрлөлийн шинж чанар – Христтэй адил байх (2:3-11)
2:3-6 2:7-11
 - B. Нөхөрлөлийн тушаал – Дэлхийг бүү хайрла (2:12-17)
2:12-14 2:15-17
 - B. Нөхөрлөлтэй холбоотой анхааруулга – Антихристээс сэргэмжлэх (2:18-27)
2:18-25 2:26-27
4. **Нөхөрлөлийн онцлог шинжүүд (2:28–5:3)**
 - A. Бидний хэтийн цэвэр ариун байдал (2:28–3:3)
2:28-29 3:1-3
 - B. Христийн үхлээр зөвт байдал бодит болсон нь (3:4-24)
3:4-10 3:13-22
3:11-12 3:23-24
 - B. Сүнснүүдийг нягтлах (шалгах) нь (4:1-6)
4:1-3 4:4-6
 - Г. Нөхөрлөлийн дүр зураг, Христийн адил хайрлах нь (4:7–5:3)
4:7-14 4:15-21 5:1-3
5. **Нөхөрлөлийн үр дүн (5:4-21)**
 - A. Дэлхийг ялах нь (5:4-5)
 - B. Христийн бодит байдлын баталгаа (5:6-12)
 - B. Итгэгчдийн авралын баталгаа (5:13)
 - Г. Хариултаа авсан залбирлын баталгаа (5:14-17)
 - Д. Нүглийн ялалт (5:18-21)

2 Иохан (Христ: Биежсэн Бурхан)

Номын нэр болон зохиогч: Хэдийгээр зохиогчийн нэрийг тодорхой дурдаагүй ч энэ номыг элч Иохан бичжээ. Тэрээр өөрийгөө зүгээр л “ахлагч” хэмээсэн нь зохиогчийн талаар юу ч дурдаагүй 1 Иохан болон Иоханы Сайн мэдээний номтой адилхан байгаа юм. 2 ба 3 Иохан номууд нь нэг танилцуулгатай байдаг. Иохан өөрийгөө “ахлагч” хэмээн танилцуулсан нь тэрээр унишигчдынхаа дунд нэртэй, танигдсан нэгэн байсныг илтгэн харуулдаг. Хэдийгээр нь энэ нь ахлагчдад өгдөг албан ёсны хэргэм боловч Петр энэ нэрээрээ өөрийнхөө унишигчдын дунд танигдсан байсан учраас захидалдаа үүнийг ашигласан бололтой.

Энэ номыг элч Иохан бичсэн гэсэн уламжлалт үзлийн дагуу үүнийг “Хоёрдугаар Иохан” гэж нэрлэжээ.

Энэ захидалыг “*“сонгогдсон эзэгтэй болоод түүний хүүхдүүдэд”* (1:1, 4-5) гэж хаягласан байдаг. Захидалыг хүлээн авагчдын талаар тодорхой зүйл байдаггүй.

Бичигдсэн огноо: МЭ 85–90 он. Хэдийгээр бичигдсэн он цагийг нь тодорхойлоход төвөгтэй ч захидалын гол утга санаа болон нөхцөл байдал нь үүнийг 1 Иохантай (МЭ 85-90) нэг цаг үед бичсэн байж болох юм гэсэн санааг илэрхийлдэг. Дээр дурдсан адил төстэй байдлууд ч мөн үүнийг илтгэдэг (1 Иохан номын бичигдсэн огнооны талаарх хэсгийг үз).

Сэдэв болон зорилго: 2 Иохан номын сэдэв нь уншигчдыгаа элч нарын үзэл баримтлалын үнэн дотор, тушаалуудын дагуу үргэлжлүүлэн алхаасай хэмээсэн элч хүний санаа зовнилын тухай юм (1:4-6). Учир нь “...олон мэхлэгчид өртөнцөд орж ирсэн. Тэд Ecus Christiig махан биеэр ирснийг хүлээн зөвшөөрдөггүй” (1:7) учраас Иохан тэднийг Христийн сургаал дотор байдаггүй, тэрхүү үнэнээс холдсон хүмүүсийн бузар муу заль мэхнээс хамгаалахын тулд энэ захидалыг бичжээ (1:9). Үүнтэй холбоотой дараах хоёр зорилгыг эндээс харж болно: (1) тэрээр өөрийн уншигчдыг бүрэн шагналаа алдахаас сэргийлэх (1:9); (2) хуурамч багш нарыг өөрсдийн гэр буюу чуулгандаа хүлээн авч, христитгэгчдийн ёсоор тэдэнтэй мэндчилэх талаар тэдэнд тодорхой зааварчилгаа өгөхийн тулд үүнийг бичжээ. Харин тэрээр тэднийг үнэн сургаал заадаг багш нар шиг гэрийн чуулгандаа найрсаар хүлээн аваасай гэж хүсээгүй юм. Гэхдээ тэр тэдэн уруу дайрч довтлох юмуу, эсвэл тэдэнд гэрчлэхээс татгалз гэж тэр хэлээгүй.

Христийн тухай 2 Иохан номд: 2 Иохан ном нь 1 Иоханы адил Христийн биежлийн тухай Библийн үзэл баримтлалыг хамгаалахад голлон анхаарсан байдаг. Ecus Christi махан биеэр ирсэн гэдэг бодит үнэнийг үгүйсгэгчдийн бурууг нотлохын тулд Иохан үүнийг бичсэн.

Хувийн Судлал: Агуулга

1. Эхлэл болон мэндчилгээ (1:1-3)
2. Үнэний дотор алхаж байгааг сайшаасан нь (1:4)
3. Бие биеэ хайрлахыг тушаасан нь (1:5-6)
4. Хуурамч багш нараас сэрэмжлүүлж, тэднийг эсэргүүцэхийг зааварласан нь (1:7-11)
5. Төгсгөлийн үг буюу сүүлчийн мэндчилгээ (1:12-13)

3 Иохан (Христ: Нэр)

Номын нэр болон зохиогч: Энэ захидалын зохиогч нь мөн л элч Иохан юм. 2 ба 3 Иохан номын аль алинд нь Иохан өөрийгөө “ахлагч” хэмээн танилцуулсан байдаг. Мөн түүнчлэн энэ хоёр захидаас хоёулангас нь “үнэн дотор хайлрадаг” (аль алиных нь 1:1), “үнэн дотор явж” (аль алиных нь 1:4) гэсэн үгсийг харж болно.

Эн нь Иоханы захидалуудаас хамгийн хувийн чанартай захияа гэдэг нь тодорхой харагддаг. Гайос хэмээх найзад нь тулгараад байсан чуулганы асуудалтай холбогдуулан Иохан энэ захидалыг бичиж, “хайрт Гайост” хэмээн хаяглан илгээжээ. Захидалын эхэнд буй энэ хэдэн үгээс өөр Гайосын талаар өгүүлсэн зүйл байдаггүй аж. Дээрх дүрслэлээс үзвэл, Гайос нь Бага Азийн чуулгануудын дунд нэлээд танигдсан хүн байсан бололтой. Иохан амьдралынхаа сүүлийн жилүүдийг эндхийн чуулгануудад үйлчилж өнгөрөөсөн гэдэг. Гайос гэдэг нэр Шинэ гэрээнд нэлээд хэдэн удаа гардаг. Тухайлбал, Ром 16:23 (Коринтын Гайос), Ййлс 19:29 (Македонийн Гайос), Ййлс 20:4 (Дербийн Гайос) ишлэлүүдэд Гайос гэдэг нэртэй хүмүүс гардаг боловч Иохан тэдний алинтай ч харилцаа холбоотой байгаагүй аж.

Бичигдсэн огноо: МЭ 85–90 он. 1 ба 2 Иохан номуудын адил төстэй байдал нь энэ номыг МЭ 85-90 оны хооронд бичигдсэн гэж үзэхэд хүргэдэг.

Сэдэв болон зорилго: Иохан Гайост хандан Сайн мэдээг тунхаглахаар нэг газраас нөгөөд аялж явдаг христитгэгчдэд (илгээлтийн эзэд), ялангуяа ийм үйлчлэлийг хийж яваа харийн хүмүүст зочломтгой хандаж, тусалж дэмжих талаар бичжээ. Уг захидалын сэдэв нь үнэн дотор явж буй Гайосын үйлчлэл ба христэч хайрын илэрхийллийг үнэний дотор явахын оронд Иоханы үгийг эсэргүүцэн, эрх мэдэлд санаархаж буй Диотрефийн хувия хичээсэн байдалтай харьцуулан хүүрнэсэн байдаг (1:9).

Энэ захидаас Иоханы дараах хэдэн зорилгыг бид тодорхой харж болно: (1) Гайосыг сайшаан магтах (1:1-ба); (2) өөрийнх нь илгээсэн христэч үйлчлэгчдийг үргэлжлүүлэн дэмжиж туслаар зааварчилж урамшуулах (1:66-8); (3) Диотрефийн хувия хичээсэн байдлыг зэмлэн буруушаах (1:9-11); (4) Деметрт заавар өгөх (1:12); (5) өөрийн биеэр очиж, тулгараад байгаа бэрхшээлийг шийдвэрлэх хүсэлтэй байгаагаа Гайост мэдэгдэх (1:10a, 13-14).

Христиин тухай 3 Иохан номд: Хэдийгээр Есүс Христийн нэрийг энд шууд дурдаагүй боловч “**Учир нь тэд ... Нэрийн төлөө явцгаасан билээ**” хэмээсэн нь Түүний тухай ажээ. Энэ нь Эзэн Есүсийн төлөө үйлчлэх (Үйлс 5:40-41; 5:41 дэх грек өгүүлбэрийн бүтэц нь үүнтэй төстэй байдаг) гэсэн үг болох нь гарцаагүй юм. Паул Ром 1:5-д үүнтэй адилхан өгүүлбэр ашигласан байдаг. 1 Иохан 2:12-р ишлэлд Иохан “**Нүгэл чинь Түүний (Христийн) нэрийн учир учлагдсан**” гэж бичсэн бол Иоханы Сайн мэдээнд “**Есүсийн нэрэнд**” итгэх тухай өгүүлсэн байдаг (Иохан 1:12, 3:18).

Хувийн Судлал: Агуулга

1. Танилцуулга буюу мэндчилгээ (1:1)
2. Гайосыг сайшаасан нь (1:2-8)
 - A. Түүний бурханлаг байдал (1:2-4)
 - B. Түүний өгөөмөр сэтгэл (1:5-8)
3. Диотрефийг буруушаасан нь (1:9-11)
 - A. Түүний хувия хичээсэн хүсэл (1:9)
 - B. Түүний хувия хичээсэн үйлдлүүд (1:10-11)
4. Деметрийг сайшаасан нь (1:12)
5. Төгсгөлийн үг (1:13-14)

Иуда

(Христ: Хүн төрөлхтний аюулгүй байдал)

Номын нэр болон зохиогч: Зохиогч нь өөрийгөө Иуда хэмээн танилцуулсан байдаг (1:1). Энэ нэр грекээр Иудас гэж бичигддэг боловч Есүсээс урvasan Иудасаас ялгахын тулд Библийн англи орчуулгуудад Иуда гэж бичдэг. Зохиогч өөрийгөө Есүс Христийн боол, Иаковын дүү хэмээн тодорхойлжээ. Матай 13:55, Марк 6:3-р ишлэлүүдэд Иудаг Есүстэй эх нэгтэй, эцэг ондоотой ах дүүс гэж бичсэн байдаг.

Дараах зүйлийг анзаарах нь тустай:

Иуда Есүстэй эх нэгтэй, эцэг ондоотой ах дүүс байсан боловч тэрээр өөрийгөө төрсөн ах Иаковтайгаа холbon тун даруухнаар тодорхойлсон байна. Эхлээд тэр өөрийгөө Есүс Христийн боол хэмээн нэрлэсэн нь Түүнтэй махан биеийн удам угсаагаар холбогдох зохиистой нэг ч хүн байхгүй гэдгийг илэрхийлэхийг хүссэн нь тодорхой. Гэвч өөрийгөө ялгаж таниулах зайлшгүй шаардлага түүнд байсан юм. Учир нь тухайн үед (I зуун) Иуда гэдэг нэр нийтлэг байсан (урвагч Иудасыг оруулаад Есүсийн хоёр дагалдагч ийм нэртэй байсан) тул тэрээр өөрийгөө Иаковын дүү хэмээн нэмэлт мэдээллээр ялгаж өгсөн байна.⁹⁶

Иуда өөрийнхөө захидалыг тодорхой хэсэг бүлэг хүмүүст биш, бүх итгэгчдэд хандан бичсэн бололтой. Тэгэхдээ уг захидалыг “*дүүдагдсан хүмүүс буюу Эцэг Бурханд хайрлагдан, Есүс Христэд хамгаалагдсан та бүгдээд*” хэмээн хаяглажээ (1:1). Тэрээр захидалынхаа хулээн авагчдыг “хайртууд минь” буюу “хайрт наиз нар минь” (1:3) гэсэн байдаг.

Бичигдсэн огноо: МЭ 70–80 он. Хэдийгээр агуулгын хувьд 2 Петр номтой адил боловч энэ хоёр номын хамгийн гол ялгаа нь Петр “хуурамч багш нар байх болно” гэж (2 Петр 2:1) сэргэжлүүлсэн бол Иуда “хэсэг хүмүүс сэм шургалан орж ирсэн” (1:4) хэмээн мэдэгдсэн байдагт оршидог. 2 Петр номд хуурамч багш нарын асуудлыг урьдчилан хэлсэн бол Иуда номд тэр асуудал яг нүүрлээд байгаа тухай бичсэнээс үзвэл Иуда ном 2 Петр номын дараа бичигдсэн болох нь илэрхий байна. Хэрэв 2 Петр номыг ойролцоогоор МЭ 67-68 онд бичигдсэн гэж үзвэл Иуда нь МЭ 70-80 оны үед бичигдсэн байж болох юм.

Сэдэв болон зорилго: Иуда энэ захидалдаа эхлээд бидний нийтлэг авралын тухай бичихээр төлөвлөж боловч чуулганд янз бүрийн тэрс үзэл шургалан орж ирэх явдал газар авч, чуулганд аюул занал нүүрлээд байсан учраас тэрээр гностик үзлийг баримтлагчдаас чуулганд сэм зааж байсан хуурамч сургаалаас итгэлээ хамгаалах хэрэгтэй хэмээн итгэгчдийг ятгаж суухын оронд энэ зүйлд тэднийг хүчтэй уриалж, шахаж шаардах хэрэгтэй болжээ. Гностисизм нь бүх материаллаг зүйлс бузар, харин сүнслэг бүх зүйл сайн гэж үздэг. Тиймээс тэд “сүнслэг” амьдралаа тэтгэн тордож, харин хүссэн бүхнээ хийхийг нь махран биедээ хүлээн зөвшөөрдөг байжээ. Үүний үр дүнд тэд зүсэн бүрийн ёс бус зүйлийн буруутан болдог аж.⁹⁷

Үүнтэй уялдуулан, бид Иуда номоос дараах хоёр гол зорилгыг харж болно: (1) чуулганыг үймүүлж, итгэгчдийг завхруулж буй ёс бус хүмүүсийн үйлдлийг буруутгах; (2) элч нарын чуулганд тунхаглаж байсан үнэнийг хамгаалахын төлөө тэмцэж байхдаа итгэл дотроо бат зогсож, тасралтгүй өсөхийг итгэгч нарт зөвлөх.

Христийн тухай Иуда номд: Иуда ном нь Христийн доторх итгэгчдийн аюулгүй байдал (1:24), Түүнээс ирдэг мөнх амь болон Түүний дахин ирэлт уруу бидний харааг чиглүүлдэг (1:21). Бурханы оршихуйд орох боломжийг бидний Эзэн Есүс Христ л бидэнд өгдөг (1:25).

Хувийн Судлал: Агуулга

1. **Мэндчилгээ болон зорилго (1:1-4)**
2. **Хуурамч багш нарын талаарх дүрслэл болон тэднийг илчилсэн нь (1:5-16)**
 - A. Тэдний өмнөх шүүлт (1:5-7)
 - B. Тэдний өнөөгийн дүр төрх (1:8-13)
 - C. Тэдний ирээдүйн шүүлт (1:14-16)
3. **Итгэгчдийг хамгаалж, уриалсан нь (1:17-23)**
4. **Ерөөл (1:24-25)**

4-р ХЭСЭГ

Эш Үзүүллэгийн Ном

Илчлэлт (Христ: Дахин ирэх Нэгэн)

Танилцуулга: Илчлэлт ном нь хүн төрөлхтөнд өгсөн Бурханы илчлэлт болох Библийн дүгнэлт болоод төгсгөл юм. Эхлэл ном нь үүсэл гарвалын тухай ном бол Илчлэлт ном нь төгсгөлийн тухай ном юм. Уг номд төгсгөлийн үед болох үйл явдууд, Эзэний дахин ирэлт, Түүний төгсгөлийн үеийн хаанчлал болон мөнхийн улсын талаар өгүүлдэг. Библийг бүхэлд нь унших явцад тэнгэр ба газар, нүгэл ба үүний хараал, уй гашуу, хүн ба хүний аврал, Сатан, түүний уналт мөхөл, Израиль, түүний сонголт, ивээл ерөөлүүд ба сахилгажуулалт, үндэстнүүд, Вавилон болон Вавилонизм, хаанчлалууд ба Түүний хаанчлал зэрэг сэдвүүдтэй танилцдаг бөгөөд эдгээр сэдэв нь улам бүр өрнөж байдаг. Эцэст нь, Илчлэлт номоос энэ бүхний шийдэл болон биелэлийг олж хардаг юм. Дээрх сэдвүүд нь Сайн мэдээний номууд болон Захидлууд дээр нэгдэж эхэлдэг, гэхдээ Илчлэлт ном дээр л эдгээр нь бүгд хамт нэгдэж, уулздаг юм.

Үүнийг дараах байдлаар харуулж болно:

Илчлэлт: Библийн биелэлт

Хуучин ба Шинэ Гэрээ	
Диваажин ба Там Хүн – бүтээл, уналт, аврал Нүгэл – үр дагавар, хараал, уй гашуу Сатан – мөн чанар, уналт, мөхөл Үндэстнүүд – дуулгаваргүй байдал, шашнууд Израиль – сонголт, ивээл ерөөл, сахилгажуулалт Амлагдсан Аврагт – үйлчлэл, удирдлага Хаант улс - амлалтууд, хөтөлбөр	Илчлэлт ном

Номын нэр болон зохиогч: Уг номд хэлснээр зохиогчийнх нь нэрийг Иохан гэдэг (1:4, 9; 22:8). Тэрээр эш үзүүлэгч (22:9), Бага Азийн чуулгануудад танигдсан удирдагч хүн байсан бөгөөд тэдэнд зориулж Илчлэлт номыг бичсэн (1:4).

Энэ Иохан нь Эзэний шавь нарын нэг, элч Иохан байсан гэсэн уламжлалт үзэл байдаг. Энэ ном нь эш үзүүлэгийн чанартай ном учир Иоханы Сайн мэдээнээс бичигдсэн хэв маягаараа ялгаатай.

Бичигдсэн огноо: МЭ. 96 он. Ихэнх эрдэмтэд уг номыг Домитианы хаанчлалын үед буюу МЭ. 81-96 оны хооронд бичигдсэн гэж үздэг. Учир нь Александрын Клемент, Еусебиус зэрэг эртний чуулгануудын зохиолч, бичигч нар үүнийг баталсан байдаг. Энэ ном нь Иоханы сайн мэдээ болон түүний захидлуудын (1, 2, болон 3 Иохан) дараахан тун удалгүй бичигдсэн бөгөөд Шинэ Гэрээний хамгийн сүүлд бичигдсэн ном юм.

Сэдэв болон Зорилго: Илчлэлт номын гол сэдэв нь Сатаны дэлхий даяар тархсан системээр дамжуулан хорон муу болсон хүн төрөлхтний зан чанарын дахь бузар муу байдал болон эдгээр дайсныг ялан дийлж, Мянган жилд (Илчлэлт 20-р бүлэг дэх мянган жил) болон үүрд мөнхөд байгуулагдах Эзэний хаанчлалын хоорондох зөрчил юм.

Энэ нь Иоханд өгөгдсөн үзэгдлүүдээр дамжуулж, уг номыг хүлээн авсан уншигчид болон сонсогчдод (1:3) ертөнц дэх бузар муугийн эх үүсвэр болон чөтгөрийн мөн чанарыг батлан харуулж чадсан. Мөн Илчлэлт

ном нь Давидын Үндэс, Иудагийн овгийн Арслангийн ялан дийлэгч хүчийг харуулсан байдаг. Энэ Арслан нь алагсан боловч үнэхээр амьд сэргүүн байгаа Хурга бөгөөд гэм нүгэлтэй, дуулгаваргүй ертөнцийн эсрэг Бурханы айdas төрүүлэм ариун байдлын шүүлтийг авчрагч Нэгэн юм.

Энэ номд хэд хэдэн чухал хүмүүс гардаг. Хамгийн эхнийх нь Эзэн Есүс; тэгээд зохиогч Иохан, хоёр гэрч, хуурамч эш үзүүлэгч, далайгаас гарч ирсэн араатан, эцэст нь, Эзэнтэй хамт эргэн ирж буй сүйт бүсгүй зэрэг юм.

Илчлэлт ном дахь Христ: Илчлэлт ном нь үнэндээ, “Есүс Христийн илчлэлт” учир энэ нь Түүний алдар, мэргэн ухаан ба хүч чадал (1:1-20), мөн чуулганууд дээрх Түүний эрх мэдэл (2:1-3:22), ертөнцийг шүүх Түүний эрх мэдэл, хүч чадлыг (5:1-19:21) батлан харуулдаг. Христийн илчлэлтийн хувьд, энэ номд дүрслэлийн нэрс маш олон байдаг. Онцгойлон энд Есүс Христийг Итгэмжит гэрч, үхэгсдээс анх төрсөн, газрын хаадаас илүү дээгүүр Захирагч (1:5); Эхэн ба Эцэс (1:17); Амьд Нэгэн (1:18); Бурханы Хүү (2:18); Үнэн бөгөөд Ариун Нэгэн (3:7); Амен, итгэмжит бөгөөд үнэн Гэрч болох Бурханы бүтээлийн Анхдагч (3:14); Иудагийн овгийн Арслан, Давидын Үндэс (5:5); Хурга (5:6); Итгэмжит бөгөөд Үнэн (19:11); Бурханы Үг (19:13); ХААДЫН ХААН, ЭЗДИЙН ЭЗЭН (19:16); Альфа ба Омега (22:13); гэрэлт үүрийн Цолмон (22:16); болон Эзэн Есүс Христ (22:21) хэмээн дүрсэлсэн байдаг.

Хувийн Судлалд: Агуулга

1. Эхлэл (1:1-8)

1:1-3 1:4-8

2. Өнгөрсөн юмс (1:9-20)

1:9-11 1:12-16 1:17-20

3. Өнөөгийн юмс (2-3)

- A. Ефес дэх чуулганд өгөгдсөн мэдээ (2:1-7)
- Б. Смирна дахь чуулганд өгөгдсөн мэдээ (2:8-11)
- В. Пергам дахь чуулганд өгөгдсөн мэдээ (2:12-17)
- Г. Туатейр дахь чуулганд өгөгдсөн мэдээ (2:18-29)
- Д. Сардай дэх чуулганд өгөгдсөн мэдээ (3:1-6)
- Е. Филаделфи дахь чуулганд өгөгдсөн мэдээ (3:7-13)
- Ё. Лаодик дахь чуулганд өгөгдсөн мэдээ (3:14-22)

4. Ирээдүйн юмс (4:1-22:5)

- A. Их зовлонгийн үе (4:1-19:21)

- | | | | |
|---|-------|---------|---------|
| 1) Тэнгэр дэх хаан сэнтий (4:1-11) | 4:1-4 | 4:5-11 | |
| 2) Лацтай долоон хуйлмал ном ба Хурга болох Арслан (5:1-14) | 5:1-5 | 5:6-10 | 5:11-14 |
| 3) Лац бүхий шүүлтүүд (6:1-17) | 6:1-2 | 6:5-6 | 6:9-11 |
| | 6:3-4 | 6:7-8 | 6:12-17 |
| 4) Завсарлага: Их зовлонгоос чөлөөлөгдсөн нь (7:1-17) | 7:1-3 | 7:9-12 | |
| | 7:4-8 | 7:13-17 | |
| 5) Шүүлтийн эхний дөрвөн бүрээ (8:1-13) | 8:1-2 | 8:8-9 | 8:13 |
| | 8:3-5 | 8:10-11 | |
| | 8:6-7 | 8:12 | |

6)	Тав, зургаа дахь бүрээ болон эхний хоёр зовлон (9:1-21)		
	9:1-6	9:12	9:20-21
	9:7-11	9:13-19	
7)	Тэнгэр элч болон Бяцхан ном (10:1-11)		
	10:1-7	10:8-11	
8)	Асар, хоёр гэрч болон долоо дахь бүрээ (11:1-19)		
	11:1-6	11:11-13	11:15-18
	11:7-10	11:14	11:19
9)	Тэнгэр элч нарын тэмцэл (12:1-17)		
	12:1-2	12:5-6	12:10-12
	12:3-4	12:7-9	12:13-17
10)	Араатан болон хуурамч эш үзүүлэгч (13:1-18)		
	13:1-6	13:7-10	13:11-18
11)	Онцгой зарлалууд (14:1-20)		
	14:1-5	14:9-12	14:17-20
	14:6-7	14:13	
	14:8	14:14-16	
12)	Сүүлчийн долоон гамшигийн өмнөх хэсэг (15:1-8)		
	15:1	15:2-4	15:5-8
13)	Шүүлтийн аяга (16:1-21)		
	16:1	16:4-7	16:12
	16:2	16:8-9	16:13-16
	16:3	16:10-11	16:17-21
14)	Шашинлаг Вавилоны шүүлт (17:1-18)		
	17:1-7	17:8-14	17:15-18
15)	Худалдаа наймааны төв болох Вавилоны шүүлт (18:1-24)		
	18:1-3	18:9-10	18:21-24
	18:4-8	18:11-20	
16)	Христийн хоёр дахь ирэлт (19:1-21)		
	19:1-4	19:9-10	19:19-21
	19:5-6	19:11-16	
	19:7-8	19:17-18	
B.	Христийн хаанчлал (Мянган жил) болон Цагаан өнгөтэй их сэнтий (20:1-15)		
1)	Сатаныг хүлсэн нь (20:1-3)		
2)	Ариун хүмүүсийн амилалт (20:4-6)		
3)	Эсэргүүцэгч нүгэлтнүүд (20:7-9)		
4)	Сатаны мөхсөн нь (20:10)		
5)	Нүгэлтнүүд шүүгдсэн нь (20:11-15)		
B.	Мөнхийн улс (21:1-22:5)		
1)	Тэнгэрээс буун ирсэн Шинэ Иерусалим (21:1-8)		
	21:1-4	21:5-8	
2)	Шинэ Иерусалимын дүрслэл (21:9-27)		
	21:9-14	21:15-21	21:22-27
3)	Шинэ Иерусалимын баяр жаргал (22:1-5)		
G.	Төгсгөлийн үг (22:6-21)		
	22:6	22:12-13	22:18-19
	22:7	22:14-15	22:20
	22:8-9	22:16	22:21
	22:10-11	22:17	

Дөрөвдүгээр Бүлэг

Тай Ллын Үндсэн Зарчмууд

Танилцуулга

Энэхүү 4-р бүлэг нь уг номыг судалж буй хүмүүст тайллын дөрвөн дүрэм, арван таван үндсэн зарчмыг танилцуулах зорилготой юм. Энэ бүлэгт, дүрэм гэдэг нь Бурханы үгийг судлах бүхий л үедээ дагаж мөрдөх шаардлагатай тогтсон удирдамжийг хэлнэ. Харин зарчим гэдэг нь дүрмийн нэг хэсэг юм. Дүрмийг мөрдөхөд зарчим чухал байр суурь эзэлдэг боловч бүх үед хэрэглээд байх шаардлагагүй байдаг. Оюутнууд энэ хэсгийг судлах явцдаа энд танилцуулсан янз бүрийн зарчмуудыг хэзээ, хэрхэн хэрэглэх талаар ойлголттой болох болно.

Бурханы үгийг үнэн зөв тайлах нь бидний насан туршийн зорилго юм. Библиэ нээгээд л бүх ишлэлийн утгыг хоромхон зуурт ойлгоод авчих тийм ид шидийн томьёо гэж байхгүй. Гэхдээ тэглээ гээд оюутан хүн үнэнийг эрэхээс няцаж, урам хугарч болохгүй! Бурхан Өөрийнхөө үгэн дотор ойлгоход төвөгтэй зарим зүйлсийг оруулсан нь тодорхой зорилготой юм. Тэгснээр бид Ариун Сүнсэнд найдах болно (1 Коринт 3:10-16). Зарим багцлалыг ойлгоход хялбар байдаг бол зарим нь ердөө ойлгогддоггүй (1 Коринт 13:12).

Хэрэв Бурханы Үгийг тайлбарлахдаа ямар нэгэн томьёо ашиглах юм бол христитгэгч биш хүн ч гэсэн Бурханы Үгийг бүгдийг нь тайлбарлаж чадах байсан. Дагалдагч нар нь Өөрийг нь эрэлхийлж, Үгийг нь судлан сүнсээр өсөөсэй гэж Бурхан хүсдэг (2 Тимот 2:15). Дараах дүрэм болон зарчмуудыг өөртөө чухал удирдамж болгон ашиглаарай. Тэгэхдээ таныг бүхий л үнэн уруу удирдах Ариун Сүнсэнд итгэж найдах нь чухал шүү (Иохан 16:13).

Бид энэ хичээлээр дараах дүрэм болон зарчмуудыг судална:

Дүрэм - 1: Судрыг бүхэлд нь судалж, Бурхан болон Есүс Христийн талаарх бодит үнэнийг эрж хайх

- A. Зарчим - 1: Бурханы уг чанарыг судлах
- B. Зарчим - 2: Христийн илчлэгдсэн арга замыг эрж хайх

Дүрэм - 2: Ойлгомжтой тодорхой багц ишлэлийг ашиглан бодит үнэнийг ойлгохыг хичээх

- A. Зарчим - 3: Илчлэлт нь алгуур өрнөлгтэй явагддаг үйл явц гэдгийг ойлгох
- B. Зарчим - 4: Шууд утгаар нь тайлж ойлгох
- C. Зарчим - 5: Онцгой шинжүүдийг авч үзэх
- D. Зарчим - 6: Гол багцлалуудыг судлах
- E. Зарчим - 7: Хүний хүслийг таньж мэдэх
- F. Зарчим - 8: Гэрээнүүдийг санах

Дүрэм - 3: Судрыг Судартай нь харьцуулахыг хичээх

- A. Зарчим - 9: Ялгаатай зүйлсийг олж харах
- B. Зарчим - 10: Хам сэдвийг нь авч үзэх
- C. Зарчим - 11: Харьцуулан тайлбарлах
- D. Зарчим - 12: Зохицолдолгоог эрэлхийлэх
- E. Зарчим - 13: Диспенсацийг анхаарч үзэх
- F. Зарчим - 14: Эш үзүүллэгт болгоомжтой хандах

Дүрэм - 4: Бурханы үгийг зохих ёсоор хэрэгжүүлсэн христэч амьдралаар амьдрахыг хичээх

- A. Зарчим - 15: Зөв хэрэгжүүлэлт нь зөв тайлал дээр үндэслэгддэг
- B. Зөв зохистой хэрэгжүүлэлтийн таван алхам
- C. Зөв тайлал хийхэд тулгардаг зургаан саад
- D. Буруу хэрэгжүүлэлтийн найман шалтгаан

1-р ХЭСЭГ

Нэгдүгээр Дүрэм

Судрыг бүхэлд нь судалж, Бурхан болон Есүс Христийн талаарх бодит үнэнийг эрж хайх

Бурханы үндсэн шинж чанаруудын голыг нь харуулдаг энэ дүрэм нь Библийг зөв тайлбарлахад маш чухал юм. Түүний гол мөн чанар хэзээ ч өөрчлөгдөж, хэзээ ч өөртэйгөө зөрчилдөггүй. Уг дүрэм нь, Бид Бурханы сүрдэм мөн чанарыг (Филиппий 3:10) хэр их ухаарна тэр хэмжээгээр Түүний хэлсэн үгийг ойлгох чадвартай болдог. Энэ үнэн дээр уг дүрэм тулгуурладаг.

Эцэг, Хүү ба Ариун Сүнс бүгд ижилхэн мөн чанартай гэсэн бодит үнэн нь Гурвалын талаарх Библийн нотолгоо болдог. “Гурвал” гэдэг нэр томьёо нь Эцэг, Хүү, Ариун Сүнс нь нэг Бурханы гурван илэрхийлэл гэсэн санааг илэрхийлдэг. Тэдгээр нь өөр өөрийн үүрэгтэй. Эцэг төлөвлөдөг (Үйлс 2:23), Хүү гүйцэтгэдэг (Иохан 5:36), харин Ариун Сүнс энэ төлөвлөгөөг хүмүүст илчилдэг (Иохан 16:13). Бид тэдний үүргийг тус тусад нь судалж болох авч Гурвалыг салгаж үзэж болохгүй. Цорын ганц Бурхан байдаг (Дэд хууль 6:4). Бурханы шинж чанарууд Эцэг, Хүү, Ариун Сүнсэнд бүгдэд нь агуулагдаж байдаг учраас тэд бүгдээрээ нэг Бурхан юм.

Дараагийн хэсгүүдэд бид Гурвалын талаар нарийвчлан судлах болно.

A. Зарчим - 1: Бурханы төгс мөн чанарыг судлах

Бурханд арван гол шинж чанар байдаг. Тэднийг цээжээр мэддэг, байнга давтан хэлдэг байх ёстой.

1. Хамгийн дээд эрх мэдэл

Бурханд ХАМГИЙН ДЭЭД ЭРХ МЭДЭЛ байдаг. Өөрөөр хэлбэл, Тэр Хаан бөгөөд хааны ёсоор үйлддэг. Хамгийн дээд эрх мэдэл гэдэг нь хязгаарлагдмал хүрээн дэх бүрэн нөлөөлөл юм. Бурхан бүх бүтээлүүдээс дээгүүр эрх мэдэлтэй учраас Түүнд гадны ямар ч хүч нөлөөлж чадахгүй. Тэр бол бүтээл биш, харин Бүтээгч (Ром 1:20, 25) юм. Тиймээс Тэр юунаас ч үл хамааран Өөрийнхөөрөө төлөвлөж, Өөрийн хууль болон шүүлтийг тогтоох эрх мэдэлтэй юм. Хэдийгээр Түүний зорилгыг ойлгоход хэцүү байж болох ч Тэрээр Өөрийн сонгосончлон үйлдэх эрхтэй юм.

2. Зөвт байдал

Бурхан бол төгс ЗӨВТ БАЙДАЛ юм. Өөрөөр хэлбэл, Тэр бүхэлдээ төгс юм. Тэр бүх талаараа зөвт байдлын жишиг учраас бидний даган дуурайх ёс суртахууны хэм хэмжээг тогтоож өгдөг (Ефес 5:1).

3. Шударга байдал

Бурхан бол ШУДАРГА. Өөрөөр хэлбэл, Тэр бүхэлдээ, бүрэн төгс шударга юм. Бурханы шударга байдал нь Түүний зөвт байдлын шаардлагуудын хариулт болдог. Бурханд “ялгаварлах үзэл” байдаггүй (Ром 2:11). Тэр хэнд ч тал засдаггүй. Гэм нүгэл (Түүний хуулийг зөрчих) байгаа газар (Ром 5:13) Түүний шударга байдал тогтоогдох ёстой.

4. Хайр

Бурхан бол Хайр. Өөрөөр хэлбэл, Түүний хайр бол төгс бөгөөд болзолгүй юм. Хэдийгээр өөрийн сэтгэлд таагүй байсан ч бусдын төлөө сайныг үйлдэхийг хайр гэдэг. Бүх хүмүүст Бурханыг таниулахын тулд христитгэгчид Түүний хайрыг бусдад түгээх ёстой (Иохан 13:34-35).

5. Мөнх амь

Бурхан бол МӨНХ АМЬ юм. Өөрөөр хэлбэл, Тэр мөнхөд байсан бөгөөд байсаар байх болно. Мөнх амьд эхлэл, төгсгөл байдаггүй. Харин христитгэгч бидэнд эхлэлтэй, харин төгсгөл байхгүй үүрд мөнхийн амь өгөгдсөн юм. Бурхан хэзээ ч үхэхгүй гэдгийг Түүний мөнх амь бидэнд харуулдаг.

6. Бүхнийг чадагч – Төгс Хүчит

Бурхан бол БҮХНИЙГ ЧАДАГЧ. Өөрөөр хэлбэл, Тэрээр юуг ч хийх хүч чадалтай. Түүний Бүхнийг чадагч гэдгийг харуулах нэг жишээ бол газар, тэнгэрийг бүтгэсэн явдал юм (Эхлэл 1:1). We are told that the “Эзний үгээр” тэнгэрүүд, “амных нь амьсгалаар” (Дуулал 33:6) тэдгээрийн бүх эрхэс бүтээгдсэн гэж Бурханы угэнд хэлсэн байдаг.

7. Хаа сайгүй оршигч – Бүх газарт оршдог

Бурхан бол ХАА САЙГҮЙ ОРШИГЧ. Өөрөөр хэлбэл, Бурхан цаг хугацааны нэг агшинд бүх газарт ижилхэн оршин байдаг. Гэхдээ энэ нь Бурхан бол бүх зүйл (пантеизм) гэсэн үг биш, харин Тэр хaa сайгүй оршин байдаг гэсэн үг юм. Энэ ойлголтоос бид Бурханы хувийн мөн чанарыг хардаг.

8. Бүхнийг мэдэгч – Бүгдийг мэддэг

Бурхан бол БҮХНИЙГ МЭДЭГЧ. Тэр өнгөрсөнд болсон, одоо болж байгаа мөн ирээдүйд болох бүхнийг мэддэг. Бурхан зөвхөн одоо болж байгаа бус ирээдүйд болох бүх үйл явдлын үр дүнг мэддэг. Тэр бүх шийдвэрийн үр дагаврыг мэддэг. Түүний мөнхийн төлөвлөгөөнд энэ бүх хүчин зүйлийг тооцсон байдаг (Ром 8:28-30).

9. Хувиршгүй чанар – Хэээ ч өөрчлөгддөггүй

Бурхан бол ХУВИРШГҮЙ. Түүний төгс мөн чанар өчүүхэн төдий ч өөрчлөгддөггүй.

10. Үнэн

Бурхан бол туйлын үнэн. Бурханы хэлсэн бүхэнд бүрэн итгэж болно гэдгийг Түүний энэ зан чанар бидэнд өгүүлдэг (Тооллого 23:19). Үнэндээ, Бурханы хувьд худал хуурмаг нь боломжгүй юм (Тит 1:2).

Хувийн Судлал: 4-р бүлэг, 1A хэсэг

1. Дээр өгөгдсөн Бурханы гол арван чанарыг цээжил.

2. Дуулал 11-ийг уншаад, өөрийн чадах хэмжээгээр аль болох зан чанарыг нэрлэ.

Б. Зарчим - 2: Христийн илчлэгдсэн арга замыг эрж хайх

Түүх бүхэлдээ Есүс Христийн эргэн тойронд төвлөрсөн байдаг гэдгийг энэхүү хоёр дахь зарчим харуулдаг. Есүс Христ бол бүхнийг Бүтээгч (Иохан 1:1, 3, 14; Колоссай 1:16-17), Альфа ба Омега, “эхлэл ба төгсгөл” (Илчлэлт 1:8) бөгөөд хүний дүрээр ирсэн цорын ганц Бурхан (Филиппой 2:6-8) гэдгийг энэ зарчим илэрхийлдэг.

Бид Бурханы Үгийг ойлгохыг хичээх явцдаа тухайн багц ишлэлд хийж байгаа бидний тайлбар Эзэн Есүс Христийн Үнэнтэй хэр нийцэж байгааг харах ёстой. Ийнхүү нягтлах нэг арга бол Судрын тухайн хэсэгт гарч байгаа хүн, газар орон, эд юмс болон үйл явдал Эзэний талаар бидэнд юу зааж байгааг харах явдал юм. Бид Эзэн Есүс Христийн үнэнийг эрж хайх хэрэгтэй болохоос, энэ үнэний “сүүдэр” (Еврей 10:1; Иохан 14:6) төдий болох хуучин хуулийг судлах ёсгүй юм. Бурхан Хуучин гэрээн дэх бүх хүн, газар нутаг болон бүх үйл явдлыг Бурхан бидэнд жишээ болгон өгөхдөө Өөрийнх нь талаар судалж ойлгоход (1 Коринт 10:1-6) туслахыг зорилго болгосон.

Бидэнд Бурханы тухай зааж байгаа нэгэн **хүний** жишээг Ионагийн эш үзүүллэгээс олж болно. Бурхан Ионаг ассиричууд уруу явахыг тушаасан боловч тэр тэдэн уруу очихыг хүсээгүй гэдгийг та санаж байгаа байх. Тэр Бурханы яв гэснээс огт өөр зүгт усан онгоцоор явсан. Гэтэл шуурга болж, Иона усан онгоцноос шидэгдэн далайд хаягдav. Аварга загас түүнийг залгиж, гурав хоногийн дараа Ассирийн эрэг дээр бөөлжиж гаргажээ. Энэ бүхний эцэст Иона Бурханы тушаалыг биелүүлэхээр шийдэв. Гурван өдөр, гурван шөнө гэснийг Есүсийн булшинд байх хугацааг заасан “эш үзүүлэгч Ионагийн тэмдэг” (Матай 12:39-40) гэж нэрлэдэг.

Түүнчлэн *газар нутаг* ч мөн Эзэний тухай бидэнд заадаг. Есүс Бетлеме (“талхны гэр” гэсэн утгатай) хотод төрөх ёстой байсан (Мика 5:2). Үнэндээ, Есүс тэнгэрээс бууж ирсэн талх бөгөөд сүнслэг амьдралыг тэтгэгч Хүн (Иохан 6:35) юм.

Бидэнд Эзэнийг мэдүүлэх зорилгоор бий болсон олон **эд юмс** байдаг. Тухайлбал, Асар болон Сүмийг нэрлэж болох юм. Хэрэв бид оршихуйн талхны ширээ, алтан дэнлүүний суурь болон шатаалт тахилын алтан ширээ бүхий Ариун газрыг авч үзвэл энэ бүх эд юмс Есүсийг илтгэн харуулдаг болохыг хялбархан харж чадна. Тэр бол амийн Талх (Иохан 6:35), “ертөнцийн Гэрэл” (Иохан 8:12) бөгөөд бидний залбирлуудыг сонсдог Нэгэн юм. (Утлага нь ариун хүмүүсийн залбирлыг [Илчлэлт 8:3-4] илтгэдэг бөгөөд залбирал нь “тахил” юм [Еврей 13:15-16].)

Левийн тахилч нарын хийдэг байсан өргөлүүд гэх мэт *үйл явдлууд* нь бидэнд бас Эзэний тухай заадаг. Бүх өргөл (Левит 1-7 бүлэгт өгүүлсэн) нь Есүс “нэг удаа бүгдийн төлөө биеэ өргөсөн” (Еврей 10:10-12) гэдгийг бидэнд харуулах зорилготой байсан. Тэр үнэхээр “*ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы хурга*” байсан (Иохан 1:29).

Библийн бүх номын гол сэдэв нь Есүс гэдгийг оюутнууд харах боломжтой.⁹⁸

Эхлэл:	Бүтээгч ба эмэгтэйн Үр хүүхэд (1:1; 3:15)
Египетээс гарсан нь:	Нүгэлтнүүдийн төлөө нядлуулах Бурханы Хурга (12:1-13)
Леви:	Тэргүүн Тахилч (бүтэн ном)
Тооллого:	Иаковаас гарч ирсэн од (24:17)
Дэд хууль:	Мосегийн адил Эш үзүүлэгч (18:15)
Иошуа:	Эзэний дайчдын Жанжин (5:13-15)
Шүүгчид:	Шүүгч (11:27)
Рут:	Золилтыг хийгч хамгийн ойрын садангийн Хүн (3)
Самуел:	Хаадын Эзэн (2 Самуел 7:18-20)
Хаад/Шастир:	Газар тэнгэрийн Эзэн (бүх ном)
Езра:	Сэргээн босгогч (1:1)
Нехемия:	Итгэмжит (9:32)
Естер:	Хүндлүүштэй (10)
Иов:	Амилсан бөгөөд буцаж ирсэн Золигч (19:25)
Дуулал:	Ерөөлтэй Хүн (1)
	Бурханы Хүү (2)
	Цовдлогдсон Нэгэн (22)
	Амилсан Нэгэн (23)
	Ирж буй Нэгэн (24)
	Захирагч Нэгэн (72)
	Магтаалын Удирдагч (150)
Сургаалт үгс:	Мэргэн ухаан (4)
Номлогчийн Үгс:	Мартагдсан мэргэн Хүн (9:14-15)
Соломоны дуун:	Миний Хайрт (2:16)
Исаа:	Зовлонт орлуулагч (53)
Иеремиа:	Эзэн бол бидний зөв шударга юм (23:6)
Иеремиагийн гашуудал:	Гашуудаж буй Хүн (1:12-18)
Езекиел:	Хaan сэнтий (1:26)
Даниел:	Цавчигдсан чулуу (2:34)
Хосеа:	Давидын агуу Хaan (3:5)
Иоел:	Элбэгээр хангагч Хaan (2:18-19)
Амос:	Израилийн Аврагч (3:12)
Обадиа:	Сион уулан дээрх Аврагч (иш. 17)
Иона:	Оршуулагдсан бөгөөд амилсан Аврагч (бүтэн ном)
Мика:	Үүрд мөнхийн Бурхан (5:2)
Нахум:	Зовлонгийн өдөр дэх бэхлэлт (1:7)

Хабаккук:	Бидний итгэлийн зангуу (2:4)
Зефания:	Шүүлт болон ариусгалын төлөө бидний дунд оршигч (3:5, 15)
Хагтай:	Цохигдсон Хоньчин (2:17)
Зехария:	Мөчир (3:8)
Малахи:	Зөв шударгын нар (4:2)
Матай:	Еврейчүүдийн Хаан (2:1)
Марк:	Яавэгийн Зарц (бүтэн ном)
Лук:	Хүний төгс Хүү (3:38; 4:1-13)
Иохан:	Бурханы Хүү (1:1)
Үйлс:	Өргөгдсөн Эзэн (1:8-9)
Ром:	Зөв шударга байдал (3:22)
1 Коринт:	Үхлээс амилуулагдсан анхны Үр жимс (15:20)
2 Коринт:	Бидний төлөө нүгэл болгогдсон (5:21)
Галат:	Хуулийн төгсгөл (3:10, 13)
Ефес:	Бидний Хуяг дуулга (6:11-18)
Филиппой:	Хэрэгтэй бүхнээр хангагч (4:19)
Колоссай:	Тэргүүн болох Нэгэн (1:18)
1 Тесалоник:	Дахин ирж буй Эзэн (4:15-18)
2 Тесалоник:	Дэлхийг шүүхээр ирж буй Шүүгч (1:7-9)
1 Тимот:	Зуучлагч (2:5)
2 Тимот:	Шагналын титэм (4:8)
Тит:	Агуу Бурхан бөгөөд Аврагч (2:13)
Филемон:	Хоригдлын хамтрагч (1:9)
Еврей:	Итгэлийн амралт болон Эш үзүүллэгийг гүйцэлдүүлэгч (9-11)
Иаков:	Амралтын өдрийн Эзэн (5:4)
1 Петр:	Хуучин гэрээний эш үзүүллэгийн сэдэв (1:10-11)
2 Петр:	Удаан зовсон Аврагч (3:9)
1 Иохан:	Амийн Үг (1:1)
2 Иохан:	Антихристийн бай (1:7)
3 Иохан:	Үнэний амьд жишээ (1:3-4)
Иуда:	Итгэгчдийн аюулгүй байдал (1:24-25)
Илчлэлт:	Хаадын Хаан, зэдийн Эзэн (19:11-16)

Хувийн Судлал: 4-р бүлэг, 1Б хэсэг

- Иохан 1:1, 3, 14; Колоссай 1:16-17; Филиппой 2:6-8 ишлэлүүдийг унш. Есүс Христ гэж хэн бэ?**
- Еврей 10:1-18; Иохан 14:6. Нүглийг юу зайлцууж чадахгүй вэ? Хэн нүглийг зайлцуулж чадах вэ?**
Бодит байдал болон түүний тусгал болох сүүдрийг ялгаж тодорхойл.
- Матай 12:39-40; Иона 1-р бүлгийг унш. Иона болон Есүс Христийн адил төстэй зүйлсийг бич.**
- Мика 5:2; Иохан 6:32-51 ишлэлийг унш. Эдгээр багцлалуудад Есүс Христийн талаар юуг илчилсэн байна вэ?**
- Египетээс гарсан нь 25:23-40; Иохан 6:35; 8:12-ыг унш. Асрын тавилгууд Есүс Христийн талаар юуг өгүүлдэг вэ?**
- Левит 3; Еврей 10:10-12; Иохан 1:29-ийг унш. Эвийн тахил болон Есүс Христийн хооронд ямар нийтлэг зүйл байна вэ?**
- Есүс Христийн дүрслэн өгүүлсэн ишлэлүүдийг хараад, өөртөө Есүсийг төсөөлнө үү.**

2-р хэсэг

Хоёрдугаар Дүрэм

Ойлгомжтой тодорхой багц ишлэлийг ашиглан бодит үнэнийг ойлгохыг хичээх

Судраас хамгийн ойлгомжтой хэсгийг олж аваад, түүнийгээ ойлгоход төвөгтэй хэсгүүдийг судлахдаа ашиглахыг энэ дүрэм бидэнд заадаг.

Энэ дүрэмтэй холбоотой зургаан зарчмыг бид сурна. Эдгээр зарчим нь Бичээсийн янз бүрийн сэдвүүдийг олж үнэлж цэгнэхэд оюутнуудад тусална.

Мөн илчлэлт алгуур өрнөлттэйгөөр өгөгддөг болох тухай болон Бурхан Өөрийнхөө төлөвлөгөөг түүхийн туршид хэрхэн дэлгэн илчилдэг тухай бид энэ хэсгээс үзэх болно. Бурхан төлөвлөгөөгөө хэрхэн илчилдгийг харахын тулд бид өгөгдсөн сэдэвтэй холбоотой багцлалуудын онцлог шинжүүдийг нарийвчлан судалж, үгчлэн тайлбарлах ёстой. Түүнчлэн бид хүнд тодорхой хүсэл байдаг тухай, энэ хүсэл нь бидний тайлалд хэрхэн нөлөөлдгийг авч үзнэ. Мөн Библийн тайлалд гэрээнүүд ямар үүрэг гүйцэтгэдэг талаар сурч мэдэх болно.

A. Зарчим - 3: Илчлэлт нь алгуур өрнөлттэй явагддаг үйл явц гэдгийг ойлгох

Бурхан үеийн туршид мэдээллийг алгуур аажмаар илчилдэг гэдгийг энэ зарчим бидэнд харуулдаг. Жишээ нь, Мессиагийн талаарх анхны эш үзүүллэгийг бид эмэгтэйн үр хүүхдийг амласан Эхлэл 3:15-р ишлэлээс олж хардаг. Хуучин гэрээ бүхэлдээ энэ “үр хүүхэд”-ийн тухай мэдээллийг цааш үргэлжлүүлдэг. Мессия нь Абрахамын (Эхлэл 12:3), Исаакийн (Эхлэл 21:12), Иаковын (Эхлэл 35:10-12) үр хүүхэд, Иудагийн үр удам (Эхлэл 49:8-11), Иессийн нахия (Исаиа 11:1), Давидын гэр (2 Самуел 7:12-16) байх болно гэж Библид хэлсэн байдаг. Тэр Бетлехемд төрөх болно (Мика 5:2). Тэрээр зуун хувь Бурхан, зуун хувь Хүн байх болно (Дуулал 110:1). Түүнийг Иммануел гэж дуудах болно (Исаиа 7:14). Тэр эш үзүүлэгч (Дэд хууль 18:18), тахилч (Дуулал 110:4), шүүгч (Исаиа 33:22), хаан (Иеремиа 23:5) байх болно. Түүнд Ариун Сүнсний онцгой тосолгоо (Исаиа 11:2) ба Бурханы өргөөний төлөөх зүтгэл байх болно (Дуулал 69:9).

Цаг хугацааны хувьд сунжирсан (дээр дурдсантай адил) илчлэлтийг “аажим өрнөлттэй илчлэлт” гэж нэрлэдэг. Ийм нөхцөлд өрөнхий эш үзүүллэг хийгддэг ба илүү нарийн ширийн зүйлсийг дараа нь цаг хугацааны явцад илчилдэг.

Ийм тохиолдолд тухайн сэдвийн талаарх хамгийн эхний ишлэлд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Яагаад гэвэл энэ нь бидний хувьд, уг сэдвийг ойлгох удирдамж олж өгдөг. Жишээ нь, Сатаны ажил болон түүний хорон санааны талаар хамгийн анх Эхлэл 3:1 ишлэлд дурдсан байдаг. Бид энэ “могой”-ны талаар илүү сайн мэдэх тусмаа түүнийг Бурханы дайсан, мэхлэгч Сатан мөн болохыг илүү сайн олж хардаг. Хүн төрөлхтний түүхийн туршид Сатан сайжирч өөрчлөгдэж байсан удаа байхгүй (Илчлэлт 12:9; 20:2-3, 10). Тэрээр цаг хугацааны туршид өөрийн арга барилыг өөрчилж байсан боловч хандлагаа хэзээ ч өөрчилж байгаагүй (Исаиа 14:12-14; Илчлэлт 12:9; 20:7-8). Зовлонгийн өдрүүдэд “ёс бус хүмүүс” Бурханы сүм дотор сууж, өөрийгөө Бурхан хэмээн тунхаглана (2 Тесalonик 2:4) гэснээс үүнийг тодорхой харж болно.

Өгөгдсөн сэдвийн талаарх үнэн нь түүний тухай анхлан дурдсан зүйлтэй холбоотойгоор илэрхийлэгддэг болохыг бид олонтаа хардаг. Өөрөөр хэлбэл, Эхлэл номд анх дурдагдсан хэд хэдэн сэдэв бүх Библийн туршид өгүүлэгдэж байгааг харж болно. Иймээс, Бурханы үгийг тайлж ойлгохыг хүсэж буй хүний хувьд Эхлэл номыг маш нухацтай, нарийвчлан судлах нь чухал юм.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 2А хэсэг

1. **Матай 1:1-25; 2:1; 3:16; Иохан 1:1, 14; 2:17; 5:22; 7:40; Еврей 5:9-10; Илчлэлт 19:16-г унш. Есүс тухайн эш үзүүллэгийн биелэл болж байгааг харуулсан ишлэлүүдийг тохируул.**
 - А. Эмэгтэйн үр – Эхлэл 3:15
 - Б. Абрахамын үр – Эхлэл 12:3
 - В. Исаакийн үр – Эхлэл 21:12
 - Г. Иаковын үр – Эхлэл 35:10-12
 - Д. Иудагийн үр удам – Эхлэл 49:8-11
 - Е. Иессийн нахия – Исаиа 11:1
 - Ё. Давидын гэр – 2 Самуел 7:12-16
 - Ж. Бетлехемд төрсөн – Мика 5:2
 - З. Бурхан ба хүн – Дуулал 110:1
 - И. Иммануел гэж нэрлэгдсэн – Исаиа 7:14
 - К. Эш үзүүлэгч – Дэд хууль 18:18
 - Л. Тахилч – Дуулал 110:4
 - М. Шүүгч – Исаиа 33:22
 - Н. Хаан – Иеремия 23:5
 - О. Ариун Сүнсний онцгой тосолгоо – Исаиа 11:2
 - Ө. Бурханы өргөөний төлөөх хичээл зүтгэл – Дуулал 69:9

2. Эдгээр ишлэл юуг баталдаг вэ?

Б. Зарчим - 4: Шууд утгаар нь тайлж ойлгох

Бурхан бодсоноо хэлдэг, хэлснээ боддог гэдгийг энэ зарчим бидэнд харуулдаг. Энэ нь Бурханы Үгийг ойлгоход бидэнд удирдамж болж өгдөг тул маш чухал зарчим юм. Бид хүүхдүүдээ зааж сургахдаа тэдэнд сануулахыг хүссэн зүйлээ аль болох тодорхой хэлж ойлгуулахыг хичээдэг. Тайлбарлаж байгаа зүйлийг маань сайн ойлгож ухаараасай гэсэндээ бид нэг зүйлийг өөр өөр арга замаар зааж сургадаг (Еврей 1:1). Бид нэг л мэдээллийг олон удаа давтаж хэлдэг. Бид бас өөрсдөө Бурханы хүүхдүүд биш гэж үү (1 Иохан 3:1)? Тэр бидний “Аав” (Ром 8:15) биш гэж үү? Библийг шууд утгаар нь тайлж ойлгох гэдэг нь Бурханы үнэн гэж хэлсэн зүйлийг шууд хүлээж авахыг хэлдэг.

Эхлээд Бурханы Үгэн дотроос энгийн, ойлгоход хялбар, нийтлэг хэрэглэгддэг ишлэлүүдийг олох хэрэгтэй. Учир нь эдгээр нь ойлгомжгүй багцлалуудыг тодорхой болгож өгнө.

Ийм энгийн, ойлгомжтой, нийтлэг хэрэглэгддэг ишлэлийн жишээг Иохан 3:16-гаас харж болно: **“Бурхан өртөнцийг үнэхээр хайрласан тул Цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.”** Энэ ишлэлд Бурханы хайранд эргэлзсэн “магадгүй”, “байж болох юм”, “хэрэв” гэх мэтийн үгс байдаггүй. Харин Бурхан өртөнцийг үнэхээр хайрладаг бөгөөд Түүнд “итгэсэн хэн ч” болов мөнх амьтай болдог хэмээн маш тодорхой хэлсэн байна. Бурханы илэрхийлээгүй мэдээллийг бид илэрхийлж гаргах ёсгүй юм.

Мөн Ром 3:23 ишлэлээс үүнтэй адил мэдээллийг харах боломжтой: **“Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй.”** Библид өгүүлсэнчлэн, Есүс Христээс бусад бүх хүн төрөлхтөн нүгэлтэй (1 Петр 2:22). Зөвхөн Библи л дүрэм журмыг тогтоодог учраас уг дүрэмдээ хэнийг хамааруулахгүй байх нь мөн л Библийн эрх юм. Бурхан Өөрийнхөө Үгэнд тодорхой хэлсэн зүйлсийг өөрсдийнхөөрөө цэгнэж, хэнд хамаатай, хэнд хамаагүйг нь тогтоож тодорхойлох эрхгүй. Есүс Христээс бусад бүх хүмүүс нүгэлтэй.

Судраас ямар нэг “далд” юмуу илүү “гүн гүнзгий” санааг эрж хайх, өөрсдийнхөөрөө таамаглах нь их аюултай. Библид ёгтлолын аргаар хандах нь Бурханы Үгэнд заавал ямар нэг зүйлийг нэмдэг тухай бид өмнө нь ярьсан билээ. Харин “үлгэр домгийн” хандлага нь Бурханы Үгээс хасахыг ямагт оролддог.

Эдгээр нь Библийг шууд утгаар нь тайлж ойлгохын ач холбогдлыг үүгүйсгэдэг учраас Бурхан биднийг энэ тал дээр болгоомжтой байхыг сээрэмжлүүлдэг (Илчлэлт 22:18-19).

Библи нь бодит түүх дээр үндэслэгддэг учраас бүхий л түүхийн хувьд чухал ач холбогдолтой юм (уд.харьц. 1 Коринт 15). Библийг шууд утгаар нь тайлахаас өөрөөр тайлах гэсэн оролдлогууд нь ихэнхдээ теологийг гүйвуулах шалтгаан болдог. Үүнийг Израиль болон Чуулганы түүхээс харж болно.

Шууд утгаар нь тайлж ойлгох шаардлагатай нийтлэг ишлэлүүдийн заримыг жишээ болгон өгье: Ром 8:35-39; Иохан 3:16, 18, 36; Ефес 2:8-10; 1 Иохан 2:1-2; Тит 3:5.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 2Б хэсэг

1. Дараах багцлалуудын тодорхой мэдээллүүдийг өөрийнхөө үгээр бичнэ үү.

- A. Ром 8:35-39
- B. Иохан 3:16
- C. Иохан 3:18
- D. Иохан 3:36
- E. Ефес 2:8-10
- F. 1 Иохан 2:1-2
- G. Тит 3:5

2. Эдгээр ишлэл танд болон таны хайртай нэгэнд хэрхэн тусаж байгааг эргэцүүлэн бод. Та эдгээрт итгэж байна уу?

B. Зарчим - 5: Онцгой шинжүүдийг авч үзэх

Библийг тайлбарлах үед тодорхой хэдэн асуултууд гарч ирдэг бөгөөд тэдгээрт заавал хариулах шаардлагатай байдгийг энэ зарчим харуулдаг. Жишээ нь, “Үүнийг хэн хэлсэн бэ?”, “Хэнд хэлсэн бэ?”, “Ямар нөхцөл байдал дунд хэлсэн бэ?”, “Хэнд хамаатай хэлсэн бэ?” гэх мэтийн асуултыг бид асуух ёстай.

Мөн Бурхан бүхий л түүхийн туршид еврейчүүд, харь үндэстнүүд болон Чуулган гэсэн гурван төрлийн хүмүүстэй ажиллаж байсныг энэ зарчим бидэнд харуулдаг (1 Коринт 10:32). Тиймээс, Библийн тухайн хэсгийг чухам хэнд хандан бичсэнийг олж тодорхойлох нь чухал юм. Тэгснээр бид уг амлалт, гэрээ эсвэл сээрэмжлүүлэг бидэнд хамаатай юу, үгүй юу гэдгийг мэдэж болно.

Удахгүй үзэх гэж буй гэрээний талаарх хичээлээр бид тухайн гэрээ чухам хэнд хандан хийгдсэн болох нь ямар чухал болохыг харах болно. Жишээ нь, харь үндэстнүүд (еврей бус үндэстэн) Бурханы өмнө итгээмжгүй, дуулгаваргүй байснаасаа болоод устгагдах юмуу тарж бутарч болох юм. Сумерчүүд, вавилончууд, ассиричууд, Персийн эзэнт улсад тохиолдсон явдлууд нь үүний жишээ юм.

Бурхан израильчуудыг зөвхөн тараах болно гэж амласан бус, бас дахин цуглуулах болно гэж амласан. Ийм амлалтыг хүлээн авсан өөр нэг ч үндэстэн байхгүй. Хэрэв бид Израильд онцгойлон өгөгдсөн энэ амлалтыг бусад үндэстнүүдэд хандуулах гэж оролдож эхлэх юм бол гарцаагүй алдаа гаргах болно.

Өөр нэг жишээ бол Израильд Канаан нутгийг өгнө гэдгээ амласан үндэстэн, газар нутаг болон иргэний харьяаллын тухай (Эхлэл 12:1-3, 13:15) амлалт юм. Харин тэнгэр дэх иргэний харьяаллыг Чуулганд амласан (Филиппой 3:20). Үндэстний байр суурь болон газар нутгийг Чуулганд амлаагүй юм.

Эцэст нь, Израильд өгөгдсөн ерөөлүүд (Бурхантай харилцах тэдний харилцаан дээр суурилсан, (Дэд хууль 8:7-10) болон Израилийг ерөөснийг нь (Эхлэл 12:3) төлөө харь үндэстнүүдэд өгөгдсөн ерөөлүүдийг харьцуулсан байдаг. Чуулганыг, эсвэл харь үндэстнүүдийг ерөөсөн хүмүүсийг ерөөнө гэсэн амлалт байдаггүй.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 2В хэсэг

1. Эхлэл 12:1-3 ишлэлийг унш. Бурхан хэнийг ерөөнө гэж амласан бэ?
2. Эхлэл 12:1-д Эзэн Абрахамыг ерөөхийн тулд ямар нөхцөл тавьсан бэ?
3. Эхлэл 26:5-ыг унш. Бурхан яагаад Исаакийг ерөөсөн бэ?
4. Еврей 11:8-ыг унш. Абрахам яагаад Бурханд дуулгавартай байсан бэ?
5. Абрахамд тавьсан нөхцөлийг (#2) чуулганд тавьсан уу?
6. Абрахамд амлагдсан ерөөлүүдийг чуулганд бас амласан уу?
7. Галат 3:28-29 ишлэлийг унш. Бид Абрахамын ерөөлөөс хуваалцаж болох уу?

Г. Зарчим - 6: Гол багцлалуудыг судлах

Бид тодорхой багцлалуудыг уншихдаа бидний сүнслэг амьдралд нэн чухал зарим нэг тодорхой сэдэвт хандаж буй Бурханы хандлагыг илэрхийлсэн үг гэж ойлгох хэрэгтэй гэдгийг энэ зарчим харуулдаг. Хэд хэдэн тусгаар хэсгийг Бурхан нэгтгээд дээрхийн адил чухал багцлал дотор оруулж өгсөн байх нь Библид олонтаа ажиглагддаг. Ийм жишээнүүдээс дурдвал:

- Есүс Христийн дахин амилалт – 1 Коринт 15
- Хүний хэл яриа – Иаков 3
- Израилийн дахин сэргэлт – Ром 11
- Итгэлийн ялалтууд – Еврей 11
- Бурхан Өөрийнхөө хүүхдүүдийг сахилгажуулдаг – Еврей 12:1-11
- Чуулган – Ефес 1-3
- Итгэлийн зөвт байдал – Ром 3:10-21
- Хууль – Египетээс гарсан нь 20
- Бурханы бүрэн хуяг дуулга – Ефес 6:10-17
- Хайр – 1 Коринт 13

Гол санааг тодорхойлохын тулд эхлээд Судрын хамгийн чухал багц ишлэлийг судлаад, дараа нь нэмэлт мэдээлэл олж авах зорилгоор холбогдох бусад ишлэлүүдийг судлахыг энэ зарчим биднээс шаарддаг.

Жишээ нь, хайрын шинж чанаруудыг хамгийн дэлгэрэнгүй илэрхийлсэн Библийн хэсэг бол 1 Коринт 13:4-8а ишлэл юм. Энд хайрын арван зургаан шинж чанарыг дурдсан бөгөөд эдгээр ишлэлийн утга санааг бүрэн ойлгохын тулд бид бүхэл бүтэн нэг долоо хоногийн хичээлийг зарцуулах хэрэгтэй болно. Дараах ишлэлүүдийг эргэцүүлэн бодьё:

Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй, зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй, зөвт бус байдалд баярладаггүй, бүгдийг далидалдаг, бүгдэд итгээдэг, бүгдэд найддаг, бүгдийг тэсвэрлэдэг. Хайр хэзээ ч дуусдаггүй.

Агуу захирамжийн талаарх асуултад Есүс хэрхэн хариулсныг Марк 12:29-31 ишлэлээс бид уншдаг:

Есүс, “Эхнийх нь ‘Сонс, Израиль аа! Бидний Бурхан Эзэн бол ганц Эзэн мөн. Чи өөрийн Бурхан Эзэнийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчээрээ хайллагтун’ гэсэн нь юм. ‘Чи хөришөө өөр шигээ хайрла’ гэсэн нь хоёр дахь нь юм. Эдгээрээс илүү өөр агуу тушаал байхгүй” гэлээ.

Хамгийн агуу хоёр тушаалд ийнхүү хайрын тухай хэлсэн учраас хайр нь Бурханы хувьд болон бидний хувьд ямар утга учиртай болохыг бид ойлгох шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, бид энэ тал дээр өөрсдийгөө Бурханы болон бусдын өмнө зөв үнэлэх боломжтой юм. Хайр ямар чухал болохыг Марк 12-р бүлэгт дүрслэн өгүүлдэг. Харин хайр хэрхэн илрэдэг тухай 1 Коринт 13-р бүлгээс харж болно.

Хэрэв та 1 Коринт 13-р бүлэгт тодорхойлсон “хайр”-ын шинж чанаруудаар өөрийгөө шалгахыг хүсэж байвал дараах асуултуудыг өөрөөсөө асуугаарай: “Би тэвчээртэй юу?”, “Би энэрэнгүй юу?”, “Би бусдад атаархдаг билүү?”

Энэ зарчмын өөр нэг жишээг “Бурханы бүрэн хуяг дуулга” гэсэн дүрслэлээс харж болно (Ефес 6:10-17). Итгэгчдийн сүнслэг хуяг дуулгыг бүгдийг нь нэг дор нэрлэсэн ишлэл үүнээс өөр байдаггүй. Исаиа 11:5-д “зөвт байдлыг бүсэлхийгээрээ бүслэх” хэмээн зөвхөн бүсний талаар дурдсан байдаг. 1Тесалоник 5:8-д “дуулга” болон “хуяг”-ийг нэрлэсэн байдаг бол Еврей 4:12-д Бурханы “хуяг дуулгын” нэг хэсэг болох “сэлэм”-ний талаар битүү дурдсан байдаг.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 2Г хэсэг

1. 1 Коринт 15-ыг унш. Дараах багц ишлэлүүдээс амилалттай холбоотой хэсгүүдэд тохиорх гарчиг өгнө үү.

- A. 15:1-11
- B. 15:12-19
- C. 15:20-28
- D. 15:29-34
- E. 15:35-49
- F. 15:50-58

2. 1 Коринт 15:3-5 ишлэлд авралын сайн мэдээний чухал хэсгийг юу гэсэн байна вэ?

Д. Зарчим - 7: Хүний хүслийг таньж мэдэх

Бурхан хүнд шийдвэр гаргах эрх чөлөөг өгсөн тухай, мөн энэ эрх чөлөөг ямар үүрэг хариуцлага дагалдаг тухай энэ зарчим харуулдаг (Иохан 3:18; Галат 6:7). Сонголт эрх чөлөөг анхлан Адам, Ева хоёрт өгсөн тухай Эхлэл 2-3 бүлэгт өгүүлдэг. Бурхан бүхнийг мэдэгч учраас тэднийг “*сайн мууг мэдүүлэгч мод*”-ны жимснээс иднэ гэдгийг мэдэж байсан боловч тэдний эрх чөлөөнд хориг хийхийг хүсээгүй. Адам, Ева хоёр хориотой жимс идэх сонголтыг хийж түүнээс идсэн. Тэд өөрсдийнхөө сонгож хийсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой учраас тийнхүү Еден цэцэрлэгээс хөөгдсөн.

Хүний сонгох чадварыг илэрхийлсэн олон нэр томьёо болон үг Библид байдаг. Тэдгээрээс хамгийн тодорхой нь “итгэх”, “итгэл” гэсэн үгс бөгөөд грек хэлэнд энэ хоёр үгийн үндэс нь ижилхэн байдаг. Бурхан бүхнийг мэдэгч учраас Хүү Есүс Христэд нь хэн итгэж аврагдахыг үргэлж мэддэг (Ром 8:29; 1 Петр 1:1-2). Тэрээр бүхнийг урьдаас мэддэг боловч хүмүүсийг итгэлд дуудахаа хэзээ ч больдоггүй.

Хүний гаргадаг сайн, муу шийдвэрийн аль алиныг Библид тэмдэглэсэн байдаг. Энэ нь Библийн дотоод шударга байдлыг гэрчлэн харуулдаг. Хүн буруу шийдвэр гаргах боломжтой гэдгийг бид энэ зарчим дээр үндэслэн мэдэх боломжтой. Өөрөөр хэлбэл, хүний гаргасан олон муу шийдвэр Бурханы Үгэнд тэмдэглэгдсэн байдгийг бид энэ зарчмаас харж болно. Бурхан Өөрийн төлөвлөгөөний зорилгын дагуу хүний энэ буруу үйлдлийг зөвшөөрдөг боловч ийнхүү үйлдэхийг хэзээ ч тушаадаггүй. Хэн нэгэн хүний шийдвэрийг Библид тэмдэглэсэн байдаг нь Бурхан тэр шийдвэрийг дэмжсэн гэсэн үг биш юм. Иудасыг Өөрөөс нь уrvана гэдгийг Есүс Христ мэдэж байснаар барахгүй түүнд анхааруулж байсан (Матай 26:24). Гэсэн ч Иудас Есүсээс урваж, үүнийхээ үр дагаврыг амссан.

Бурхан хүн төрөлхтөнд сонгох эрх чөлөөг өгсөн ч үргэлж төгс сонголт хийх чадварыг өгөөгүй юм. Тиймээс бид Библид тайлал хийхдээ хүний гэмт, муу сонголтын талаар эргэцүүлэн боддог байх хэрэгтэй.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 2Д хэсэг

1. Иохан 3:16-18 ишлэлийг унш. Хүн шүүлтээс аврагдахад шаардлагатай зүйл юу вэ?
2. Ром 3:21-26 ишлэлийг унш. Бурханы зөвт байдлыг хүлээн авахын тулд хүнд юу шаардлагатай вэ?
3. Эхлэл 2-3 ишлэлийг унш. Анхны эрэгтэй, эмэгтэй хүн Бурханы тушаалыг зөрчсөн үү?
4. Тэд зөрчсөн гэдгийг хэрхэн батлах вэ?
5. Иаков номыг унш. Энд буй 60 тушаалыг ажиглаарай. Тушаалыг хүлээн авсан хүн шийдвэр гаргах ёстой гэсэн шаардлагыг эдгээр тушаал гаргаж тавьсан байдал. Тэгвэл эдгээр тушаал тус бүрийн биднээс шаардаж байгаа зүйл юу вэ?

E. Зарчим - 8: Гэрээнүүдийг санах

Бурхан хүмүүстэй зөвшилцөл буюу гэрээнүүдийг байгуулсан тухай энэ зарчим харуулдаг. Хүний зөвшөөрлөөс хамаардаг болзолт гэрээнүүдээс гадна Бурханы Үгийн итгэмжит байдал дээр түшиглэсэн болзолт бус гэрээнүүд бас байдал.

Бурхан Өөрийнхөө ард түмэнтэй хэрхэн харилцдаг байсан тухай түүхэн тоймыг бид Түүний гэрээнүүдээс харах боломжтой учраас эдгээр нь чухал юм. Хэрэв бид Бурханы гэрээнүүдийг ойлгож, тэдгээр амлалтыг удирдлагаа болгох аваас бусад ишлэлүүдтэй зөрчилдэж байгаа мэт харагддаг багцлалуудыг буруу тайлбарлахгүй байх боломжтой. Жишээ нь, Бурхан хүн төрөлхтний түүхийн туршид израильчуудыг олонтаа шийтгэж байсан (Левит 26) боловч Бурхан тэднийг хамгаална гэж амласан учраас энэ үндэстэн хэзээ ч устаж үгүй болохгүй.

Хүн бүр хувьчлан судлах шаардлагатай есөн гэрээ байдал. Энэ хичээлээр бид тэдгээрийн талаар товч танилцуулаад, Библийн аль хэсэгт байдгийг дурдана.

1. Едений гэрээ

Бурхан Еден цэцэрлэгт Адамтай энэ гэрээг байгуулсан (Эхлэл 1-2). Энэ нь хүний дуулгавартай байдал дээр тулгуурласан, Бурхан хүнийг төгс байгаль орчин (2:8), төгс сайн хоол хүнс, үзэсгэлэнтэй зүйлс (2:9), төгс сайхан цаг агаар (1:6-7, 3:8), төгс бэлгийн харилцаа (2:21-25) болон өдөр бүр Бурхантай нөхөрлөх (1:26-27, 3:8) төгс харилцаагаар ерөөнө гэсэн амлалтуудыг багтаасан болзолт гэрээ байсан юм. Адам энэ гэрээг хүлээн авсан боловч хориотой модны жимснээс идэж болохгүй гэсэн Бурханы тушаалыг тэрээр зөрчих үед уг гэрээ зөрчигдсөн.

Ийнхүү Едений гэрээ цаашид хүчин төгөлдөр байхаа больсон авч ирээдүйд шинэ тэнгэр, шинэ газар бий болох үед түүнд тусгагдсан байсан олон ерөөл дахин сэргэх болно (Илчлэлт 21-22). Тиймээс энэ гэрээг Еден цэцэрлэгтэй холбоогүй хам сэдэв дотор тайлбарлах ёсгүй юм. Эзэн Есүс Христээс ангид амлагдсан бүх ерөлийг хүн төрөлхтөн авах боломжгүй юм.

2. Адамын гэрээ

Хүн төрөлхтөн гэмд унасны дараа, тэднийг Еден цэцэрлэгээс хөөхийн өмнө Адам, Бурхан хоёрын хооронд энэ гэрээ хийгдсэн (Эхлэл 3:14-19). Энэ нь болзолт бус гэрээ байсан.

Бидний “уналт” гэж нэрлэж заншсан анхны гэм нүүглийн үр дагавраас болж энэ гэрээ хийгдсэн юм. Бурхан мэхлэгчийг харааж (3:14), түүхийн туршид Адам болон мөгийн ур удам хоорондоо зөрчилдөх болно гэж хэлсэн (3:14-15). Эмэгтэй хүн хүүхэд төрүүлэхдээ өвдөж, эр хүнд захирагдах болно гэж Тэр хэлсэн. Газар хараагдсан (3:17-19) учраас түүнээс хоол хүнс олж идэх хэцүү болсон. Эрэгтэй, эмэгтэй хүн бие махбодын хувьд үхдэг болсон (3:19 уд. харьц. 2:17) бөгөөд хөёулаа Еден цэцэрлэгийн төгс сайхан орчноос хөөгдсөн (3:17-19).

Адамын гэрээ бүх гэрээний үед үргэлжлэх бөгөөд мянган жилийн хаанчлалын дараа Бурхан Сатаныг галт нуурт хаях хүртэл (Илчлэлт 20:7-10) бүх хүн төрөлхтөнд хүчин төгөлдөр байх болно. Адамын уналтын үр дагаврууд бүх хүн төрөлхтөнд өвлөгдөн ирсэн гэдгийг бид ойлгох ёстой (Ром 5:12-14).

3. Ноагийн гэрээ

Эхлэл 8:20-9:17 гардаг Ноагийн гэрээ нь Их үерийн дараа Бурхан болон Ноагийн хооронд хийгдсэн байдаг. Үерийн өмнөх үеийнхнийг устгах тухай энэ гэрээ нь болзолт бус гэрээ байсан. Хүмүүсийг ингэж үйл олноор нь устгах их үер дахиж болохгүй гэсэн Бурханы амлалт энэ гэрээнд тусгагдсан байдаг. Мөн Бурхан энэ гэрээнд газар дэлхийг хүнээр дүүргэж (9:1), ан амьтдын маыхыг хүнд хоол хүнс болгон өгөхөө (9:2-4) амлаад, хүний амийг хөнөөсөн хүнд цаазаар авах ял тулгахыг (9:5, 6) тушаасан. Бурхан энэ гэрээндээ итгэмжтэй гэдгийг солонгоор бэлгэдэн харуулсан.

Их үерийн дараагаас эхэлсэн Ноагийн гэрээ мөнхөд үргэлжилнэ. Хэдийгээр орон нутгийн чанартай үерүүд болж, хүмүүс амиа алдан, эд хөрөнгө сүйдэх боловч Их үер шиг бүх дэлхийг хамарсан сүйрлийг авчрах үер дахиж болохгүй. Энэ гэрээний үр дүнд хүмүүст ан амьтдын маыхыг идэх эрх чөлөө өгөгдсөн юм. Тиймээс өвс ургамал, ногоогоор хооллох тухай (Даниел 1) багцлалуудыг бүх хүн төрөлхтөнд тогтсон жишиг мэтээр тайлбарлах ёсгүй юм. Энэ гэрээний төгсгөлд хүний амийг хөнөөсөн хэрэгт Бурханы оноосон ял шийтгэлийг зааж өгсөн бөгөөд энэ шийтгэл өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.

4. Абрахамын гэрээ

Абрахамын гэрээний үндсэн амлалтуудыг Эхлэл 12:1-3 ишлэлээс харж болно. Харин үүнтэй холбоотой нэмэлт тайлбараудыг сүүлд нь өгсөн байдаг. Бурхан энэ гэрээг Абрахамтай байгуулсан. Абрахам Бурханы шаардлагуудыг биелүүлэх хүртэл энэ гэрээ нь болзолт гэрээ байсан юм. Харин дараа нь энэ гэрээ Абрахамын үр удамд болзолжүйгээр үргэлжилсэн юм.

Абрахамын гэрээнд хувь хүнд зориулсан ерөөл, тоолж баршгүй үр удам, газар нутаг, хот суурин, үндэстний байр суурийг амласнаас гадна Абрахамын үр удмыг ерөөгсдийг ерөөж, тэднээс төрөх Мессиагийн үр удмыг хамгаална гэсэн амлалтуудыг багтсан байдаг (Эхлэл 17:1-8).

Абрахамын гэрээ түүнд өгөгдсөн амлалтаар эхэлдэг. Мессиагийн удам угсааны талаарх амлалт нь Есүс Христийн анхны ирэлтээр биелэгдсэн (Галат 3:16). Материаллаг ерөөлийн амлалтууд нь Абрахамын амьдралд хэд хэдэн удаа биелсэн боловч Мянган жилийн хаанчлалын үед бүрэн утгаараа биелэх юм. Энэ гэрээ нь Абрахамд өгсөн амлалтуудаас эхлээд Мянган жилийн хаанчлал дуустал бүх гэрээний үеүдэд (диспенсац) үргэлжлэх болно.

Абрахамын гэрээний зарчмуудыг ашиглах нь ойлгоход төвөгтэй багц ишлэлийг утга санааг олж харахад тустай байдаг. Матай 11:20-24 нь ийм хүнд ишлэлд тооцогддог:

Тэгээд Тэр ихэнх гайхамигүудаа үйлдсэн хотуудыг зэмлэжээ эхлэв. Учир нь тэд гэмшиэгүй юм. 'Хоразин аа, чи золгүй еэ! Бетсайд аа, чи золгүй еэ! Хэрэв та нарт учирсан гайхамигүүд нь Tir, Сидонд тохиолдсон бол тэд аль эрт үнсэн дээр таар нөмрөөд гэмисэн байхсан. Харин Би та нарт хэлье. Шүүлтийн өдөр Tir болон Сидон нь та нараас илүү хүлийнээр байх болно. Капернаум аа, чи тэнгэрт тултал өргөмжлөгдсөн байх уу? Чи Үхэгсдийн оронд унах болно. Хэрэв та нарт учирсан гайхамигүүд нь Содомд тохиолдсон бол тэр хот энэ өдрийг хүртэл үлдэх байсан. Харин Би та нарт хэлье. Шүүлтийн өдөр Содомын газар чамаас илүү хүлийнээр байх болно гэлээ.'

Абрахамын гэрээний амлалтуудын улмаас Израильд гэмших боломж, цаг хугацаа өгөгдсөн үнэндээ Бурханы нигүүлсэл байсан юм. Хэрэв Израиль гэмшихгүй бол Бурхан хатуу шийтгэх болно. Гэхдээ Тэр энэ үндэстнийг хэзээ ч устгахгүй, хэзээ ч хүн төрөлхтний түүхээс арчиж хаяхгүй.

5. Мосгийн гэрээ

Энэ гэрээг Бурхан Синаи уулан дээр Мосетэй байгуулсан. Энэ тухай Египетээс гарсан 20-р бүлгээс гадна Левит, Тооллого, Дэд хууль номын зарим багцлалуудаас уншиж болно. Уг гэрээ нь дуулгавартай байдал дээр үндэслэгдсэн болзолт гэрээ юм. Бурханд дуулгавартай хүмүүс ерөөгдөж, харин дуулгаваргүй хүмүүс хараагдана гэсэн (Левит 26).

Мосгийн гэрээний гол зорилго нь Аврагч хэрэгтэй гэдгийг харуулах явдал байсан (Галат 3:24-25). Бурханы ёс суртахууны хуулийг энэ гэрээнд тодорхой харуулсан байдаг. Түүнчлэн, Асрыг барих болон Левийн тахилчлалд зориулсан удирдамжуудыг Израильд гаргаж өгөхийн тулд энэ гэрээ хийгдсэн байна.

Есүс Христ Хуулийг төгс сахин (Матай 5:17), энэ гэрээг гүйцэлдүүлэхээр ирсэн юм. Мосгийн гэрээ нь зөвхөн Израильд өгөгдсөн гэрээ юм. Өөрөөр хэлбэл, Мосгийн хууль анх өгөгдсөн үеэс (Египетээс гарсан нь 20) Чуулганы эхлэл болох Пентекостын өдөр хүртэлх хугацаанд хүчинтэй байхаар өгөгдсөн аж. Мөн Чуулганы дээш авагдалтын дараах хүн төрөлхтний түүхийн долоон жил буюу “Зовлонг”-ийн үе хэмээн бидний нэрлэдэг долоон жилийг энэ гэрээнд багтаадаг.

Хуучин гэрээний олон багцлал зөвхөн Мосгийн Хуулийн үед хамарагддаг гэдгийг бид ойлгох ёстой. Жишээ нь, тухайн үед нэлээд олон амьтныг “бузар” гэж үздэг байсан учраас идэхийг хориглодог байжээ (Левит 11). Харин Есүс Христ бүх хоол хүнс “цэвэр” гэж хэлсэн учраас дээрх хууль өнөөдөр хүчин төгөлдөр биш юм (Марк 7:14-18).

6. Давидын гэрээ

Бурхан энэ гэрээг Давидтай хийсэн бөгөөд энэ тухай 2 Самуел 7:8-19, Дуулал 89-д өгүүлдэг. Энэ нь Давидын гэрийг захирах үндэсний удирдагчийг тогтоож, үндэстнүүдийг мөнхөд захирах “Хүү”-г амласан болзолт бус гэрээ юм.

Давидыг хаанчилж байх үеэс энэ гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Амлагдсан “Хүү” болох Есүс Христийн анхны ирэлтээр (Лук 1:32) энэ гэрээний зарим хэсэг биелэгдсэн. Түүний үр дүнд мөнхөд үргэлжлэх болно.

Нэгэн үе Давидын удмынхан найман настай Иосиа хааны захиргаанд байсан (Хаадын дэд 22:1). Тэр үед амьдарч байсан еврейчүүд Давидын гэрээн дэх Бурханы амлалтуудад найдсан хэвээр байсан. Есүс Христийн үхлээс амилсныхаа дараа газар, тэнгэр дэх бүх эрх мэдлийг Өөртөө авснаар (Матай 28:18) энэ гэрээ бүрэн гүйцэд биелсэн юм. Есүс тэнгэр дэх сэнтийдээ заларч байгаа (Еврей 8:1) бөгөөд Тэрээр газар дээрх хаан сэнтийдээ залрахаар нэг өдөр буцаж ирнэ (Матай 25:31) гэдэгт итгэгчид өнөөдөр итгэлтэй байж болно.

7. Палестины гэрээ

Палестины гэрээ нь Абрахамын гэрээний үргэлжлэл юм. Иудейчүүд дуулгаваргүй байдлаасаа болж тарж бутарсан боловч хэрэв тэд гэмших аваас газар нутагт нь буцаана гэж энэхүү болзолт гэрээнд амласан байдаг (Дэд хууль 30:1-10).

Энэ гэрээ Израилийн эрин үед хамарагддаг бөгөөд Христийн хоёр дахь ирэлтийн (Матай 24:31; Марк 13:27) үед Бурхан иудейчүүдийг ер бусын байдлаар дахин цуглувуж, Египет мөрнөөс Евфрат мөрөн хүртэлх амлагдсан газрыг (Эхлэл 15:18) тэдэнд өгснөөр биеллээ олох болно. Энэ гэрээнд Израилийг тарааж бутраах тухай өгүүлсэн нь түр зуурын үзэгдэл гэдгийг тайллыг хийж буй хүн бодолцох хэрэгтэй.

8. Израильд өгөгдсөн Шинэ гэрээ

Израилийн гэртэй байгуулсан Бурханы Шинэ гэрээний талаар Иеремиа 31:31-34 ишлэлд тэмдэглэж, Еврей 8:8-12 ишлэлд дахин дурдсан байдаг. Есүс Христийн цусан дээр үндэслэгдсэн (Еврей 9:11-14) энэ гэрээ нь дахин төрсөн (хоёр дахь удаагаа төрсөн) иудейчүүдэд зориулагдсан болзолт бус гэрээ юм.

Энэ гэрээнд Мянган жилийн хаанчлалын үед Ариун Сүнс бүх дэлхийг эзэгнэж, асар их эд баялаг (Иеремиа 32:41; Исаиа 61:8) өгөгдөнө гэсэн амлалтуудыг багтсан. Судрыг судалж байхдаа энэ гэрээнд өгөгдсөн Бурханы амлалтууд зөвхөн итгэгч иудейчүүдэд хамаатай гэдгийг санах нь чухал юм. Энэ гэрээнд амлагдсан ерөөлүүдийг иудейчүүд удам дамжин өвлөхгүй.

9. Чуулганд өгөгдсөн Шинэ гэрээ

Бурхан энэ гэрээг Чуулгантай байгуулсан (Матаий 26:26-28). Христитгэгчдийн хувьд энэ нь загалмай (Еврей 9:11-14) дээр үндэслэгдсэн, Эзэний Зоогийн ёслолыг (1 Коринт 11:25) тэмдэглэсэн болзолт бус гэрээ юм. Энэ нь итгэгчдийн хаант тахилчлалыг тогтоож (Еврей 9:11), өнөөдөр болон өнө мөнхөд биелэгднэ гэж амладаг. Есүс Христ энэ гэрээний Зууч болсон (Еврей 9:15).

Пентекостын өдөр Чуулган байгуулагдсан (Үйлс 2) үеэс энэ гэрээ эхэлсэн бөгөөд мөнхөд үргэлжлэх болно. Энэ гэрээнээс хүлээн авсан ерөөлүүд нь мөнхөд үргэлжлэх агаад хэзээ ч авагдахүй гэдгийг судлаач оюутнууд санах хэрэгтэй. Тиймээс итгэгч хүмүүсийн амьдралд ямар ч бэрхшээл тулгарсан Бурхан тэднийг хэзээ ч орхихгүй бөгөөд тэд бүрэн аюулгүй байдалд байдаг (Матаий 28:18-20).

Хувийн Судлал: 4-р бүлэг, 2Д хэсэг

1. Ямар гэрээнүүд болзолтой байсан бэ?

- A.
- B.
- C.

2. Ямар гэрээнүүд болзолгүй байсан вэ?

- A.
- B.
- C.
- D.
- E.

3. Гэрээ тус бүртэй холбоотой багцлалуудыг уншаад, дүгнэлт хэсэгт өгөгдсөн дүрслэл дээр таны зүгээс нэмэх зүйл байгаа эсэхийг бодно уу.

З-р хэсэг

Гуравдугаар Дүрэм

Судрыг Судартай нь харьцуулахыг хичээх

Гурав дахь дүрэм нь Бурханы Үгийг зөв ойлгож, зөв хэрэгжүүлснээр олж авдаг мэргэн ухааныг эрэлхийлэх явдал юм. Бурханаас болж ямар нэгэн самуурал гардаггүй (1 Коринт 14:33), харин аливаа ойлгомжгүй байдал нь биднээс өөрсдөөс маань гардаг гэдгийг бид ойлгож, үүнийг итгэлээр хүлээн зөвшөөрөх ёстой юм. Бурхан бидэнд мэргэн ухааныг заахын тулд зүйрлэл болон оньсого таавруудыг Библид оруулж өгсөн байдаг (Сургаалт үгс 1:2-6).

Судрыг Судартай нь зөв харьцуулаагүйгээс тайллууд нь хоорондоо зөрчилдөх явдал гардаг. Нэг багц ишлэл нөгөөтэйгөө хэрхэн холбогдож байгааг бид ихэнхдээ анзаарч хардаггүй. Бурханы Үгийг ойлгохыг хичээж буй хүн төлөв даруу байх нь зүйтэй. Нэг ишлэл, нэг үгийг анхаарч үздэггүй, орхигдуулдаг хүмүүс эдгээр нь Судрыг ойлгоход ямар чухал ач холбогдолтой болохыг ухаарах хэрэгтэй.

Энэ дүрмийг хэрэглэхтэй холбоотой зургаан зарчим байдаг. Бурханы Үгэн дэх ялгаануудыг бид олж харах ёстой. Үүний тулд бид хам сэдвийг нь авч үзэх хэрэгтэй. Харьцуулсан тайлал нь Бурханаас Сударт тогтоосон дотоод зохицолдоог эрж хайдаг бөгөөд ингэхдээ тухайн ишлэлд заасан цаг үеийн талаар авч үздэг. Ялангуяа эш үзүүллэгийн багцлалуудыг тайлбарлахдаа үүнийг илүү анхаарах нь зүйтэй юм.

A. Зарчим - 9: Ялгаатай зүйлсийг олж харах

Бурханы тогтоосон ялгаатай зүйлсийг авч үзэхийг энэ зарчим бидэнд заадаг. Өөрөөр хэлбэл, итгэл ба үйлс, аврал ба нүгэл, хууль ба нигүүлсэл гэх мэт өөр олон ойлголтуудын хоорондох ялгааг бид олж харах ёстой. Библи маш олон ялгаануудыг гаргадаг. Библийг тайлахдаа эдгээр ялгааг олж таних нь бидний зорилго юм.

Жишээ нь, итгэл ба үйлсийн талаар судлах үед ямар ялгаанууд гарж болохыг Ефес 2:8-10 ишлэлээс харцгаая:

Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш, харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно. Учир нь бид сайн үйлсийн төлөөө Христ Есүс дотор бүтээгдсэн, Түүний бүтээл мөн. Бурхан биднийг тэдгээрийн дотор яваасай гэж урьдаас бэлтгэсэн билээ.

Аврал нь үйлсээр бус, харин итгэлээр дамжуулан нигүүлслээр өгөгддөг гэдэг нь тодорхой байна. Гэхдээ үйлс ч бас ач холбогдолтой гэдгийг үгүйсгэж болохгүй. Үйлс нь авралд нөлөөлдөггүй боловч христэч амьдралын чухал хэсэг юм.

Итгэл дангаараа юу ч биш юм. Харин итгэл нь биш, харин түүний объект нь чухал юм. Учир нь итгэлд итгэх хэрэгтэй хүн үнэндээ өөртөө итгэж найдах хэрэгтэй байдаг. Бид бүгдээрээ нүгэлтэй учраас өөртөө найдах нь объектоо буруу сонгож буй хэрэг юм (Ром 3:23).

Хадан цохионоос дүүжлэгдээд унах шахаж байгаа бадриун эрд жижигхэн мөчрөөс уясан нарийхан уяаг унжуулж өгвөл энэ уяа өөрийг нь даана гэдэгт хэр итгэлтэй байх бол? Нарийхан мөчрөөс бэхэлсэн тухан уяанаас бариад дээш гарч чадна гэж тэр лав итгэхгүй. Яагаад гэвэл, түүний итгэлээ тавих объект найдваргүй байна. Гэтэл бат бөх том мөчрөөс уясан бүдүүн уяанаас барьсан бол илүү итгэлтэй байж чадна. Яагаад гэвэл итгэлийн объект нь найдвартай байна.

Бидний нүглийг загалмай дээр Өөртөө үүрч, үхлээс дахин амилсан Есүс Христ нь бидний итгэлийн бат найдвартай объект болдог.

Үйлс нь ядууст туслах гэх мэт сайн зорилго санааг өөртөө агуулж байдаг (Галат 2:10). Гэвч сайн үйлс ч биднийг аварч чадахгүй (Тит 3:5). Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ харуулах хэрэгсэл болгож Бурхан ажил үйлсийг бидэнд өгсөн юм. Бид Есүс Христийн нэрээр үйлдсэн бүхнээ Түүний өмнө тайлагнаж, түүндээ таарсан шагналыг авах болно (2 Коринт 5:10). Аливаа үйлс нь бидний төлөө Эзэний хийсэн зүйлд талархсан сэтгэлээс гарах ёстой болохоос биш, өөртөө ашиг хонжкоо олж авах хандлагатай байх ёсгүй.

Бидний авч үзэж болох өөр нэг ялгаа бол итгэгч хүний авралын хамгаалалт болон түүний амьдрал дахь нүглийн бодит байдлын хоорондох ялгаа юм. Биднийг Өөрийнх нь дайсан байсаар атал Эзэн бидний аврахын тулд нас барсан нь Түүний хамгийн агуу ажил байсан гэж ярьдаг. Тэгвэл нэгэнт бид Түүний гэр бүлийн гишүүн болсон болохоор Бурхан одоо бидний төлөө бага зүйлийг хийдэг гэсэн үг үү (Ром 5:6-10)?

Итгэгчид аврагдсаныхаа дараа ч нүгэл үйлддэг гэж Библи тодорхой хэлдэг.

Хэрэв бид нүгэлгүй гэж хэлбэл өөрсдийгөө мэхэлж байгаа бөгөөд бидний дотор үнэн алга. Хэрэв бид нүгээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжсит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилжс, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. Хэрэв бид нүгэл үйлдээгүй гэж хэлбэл, бид Түүнийг худалч болгоож байгаа хэрэг бөгөөд бидний дотор Түүний үг алга. (1 Иохан 1:8-10)

Энэ багц ишлэлд итгэгчдийн талаар ярьж байгаа нь тодорхой байна. Бид нүгэл үйлдэх хандлагатай байдаг гэдгийг сануулж, үүнээс урьдчилан сануулсан хэсэг Шинэ гэрээнд олон байдаг. Тэгвэл, хэрэв бид байнга нүгэл үйлдвэл авралаа алдах уу, алдахгүй юу? гэсэн асуулт урган гарч ирдэг.

Аврал нь мөнхөд өгөгдсөн гэж Ром ном болон Библийн бусад олон номд баталдаг. Паул энэ тухай “Тиймд эдүгээ Есүс Христ дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. Учир нь Христ Есүс доторх амийн Сунсний хууль нь чамайг нүглийн болон ухлийн хуулиас чөлөөлсөн” (Ром 8:1-2) гэж хэлсэн. Коринт чуулганы итгэгчид зүсэн зүйлийн гэм нүгэлд хутгалдсан байсан. Паул тэднийг “махан биеийн хүн” гэж нэрлэсэн (1 Коринт 3:1-2) боловч “аврагдаагүй хүмүүс” гэж ер хэлээгүй юм. Харин тэр тэднийг “ариун хүмүүсээс” (1 Коринт 1:2) бүрдсэн “чуулган” хэмээн нэрлэсэн.

Христитгэгчид нүгэл үйлдэж, нүгэлт амьдралд хутгалдах үе байдаг. Энэ бол хэнд ч тодорхой зүйл. Гэвч тэд хэзээ ч авралаа алдахгүй. Энэ ч бас тодорхой. “Хэрэв бид итгэмжтэй байгаагүй бол Тэр итгэмжсит хэвээрээ байна” (2 Тимот 2:13).

Христитгэгчийн үйлдсэн гэм нүгэл заавал хор уршиг дагуулдаг бөгөөд тэрээр шагналуудаа алдахад хүрдэг. “Хэрэв бид Түүнийг үгүйсгэвэл, мөн Тэр биднийг үгүйсгэх болно” (2 Тимот 2:12). Хэрэв бид Түүнийг үгүйсгэвэл Түүнтэй хамт хаанчлахгүй гэдгийг энэ ишлэлийн хам сэдэв баталж байна.

Бурхан Өөрийнхөө Үгэн дотор тогтоож өгсөн ялгааг дээрх хоёр дүрслэлээс бид харах боломжтой. Янз бүрийн ойлголтуудын хоорондох харилцан хамаарлыг ойлгохын тулд маш урт хугацаа хэрэгтэй юм.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 3А хэсэг

1. Ефес 2:8-10 ишлэлийг унш. Аврал дахь Бурханы бэлэг юу вэ?
2. Аврал авахын тулд хүн өөрийн зүгээс юу хийх ёстой вэ?
3. Хүн авралыг хүлээн авахдаа юуны төлөө дахин бүтээгддэг вэ?
4. Тит 3:5-ыг унш. Бид сайн үйлсээр аврагдах уу?

5. 1 Иохан 1:8-ыг унш. Итгэгчид нүгэл үйлддэг үү?
6. 1 Иохан 1:9-ийг унш. Хэрэв итгэгчид нүгэл үйлдвэл юу хийх ёстой?
7. 1 Иохан 1:10-ыг унш. Хэрэв бид нүгэл үйлдээгүй гэж хэлбэл хэнийг худалч болгож байна вэ?
8. Еврей 13:15-16 ишлэлийг унш. Эдгээр ишлэлд ямар сайн үйлсийн талаар дурдсан байна вэ?
9. Колоссай 3:12-17 ишлэлийг унш. Энд нэрлэсэн сайн үйлсийг тоочно уу?
10. 2 Коринт 5:10-ыг унш. Итгэгч хүн сайн үйлсийнхээ төлөө ирээдүйд юуг авах вэ?

Б. Зарчим - 10: Хам сэдвийг нь авч үзэх

Библийн тухайн үг, ишлэл болон өгүүлбэрт өмнөх юмуу ардах мэдээлэл гэж заавал байдаг (хэрэв хамгийн эхний юмуу хамгийн сүүлийн үг, өгүүлбэр, ишлэл биш л бол) гэсэн бодит үнэн дээр энэ зарчим тулгуурладаг. Энэ зарчим нь тухайн үг ба ишлэлийн байрлал, мөн тэдгээрийн бусад үг, бусад ишлэлтэйгээ хэрхэн холбогдож байгааг голлон анхаардаг. Бурхан тэдгээр үг ба ишлэлтэй хамгийн ойр байгаа багцлалуудаар юмуу, эсвэл Библийн өөр хэсэгт буй тэдгээртэй ижил сэдэв бүхий багцлалуудаар дамжуулан агуулгыг нь тодорхой болгож харуулдаг.

Тухайн ишлэлийг хам сэдвээс нь салгаж, ямар ч авцалдаагүй өөр утга санааг оруулж тайлбарлаж огт болохгүй. Ишлэлийг ингэж хам сэдвээс нь салгаж ашиглах нь өөрийнхөө санааг батлах гэсэн зальхай арга зам юм. Ийм буруу үйлдэл нь бидний өмнө нь ярилцсан ётголын хэлбэрээр илэрдэг.

Библийг хам сэдэв дотор нь тайлах гэдэг нь тухайн багц ишлэлийг хэн, хэнд зориулан хэлж байгааг болон уг багц ишлэлийн сэдэв, ямар цаг үед, ямар газар бичигдсэнийг уншигчдын зүгээс тодорхойлохыг хэлдэг.

Судрын багц ишлэл бүрд гурван төрлийн хам сэдэв байдаг:

1. Ойрын хам сэдэв

Нэг догол мөрөнд байгаа ишлэлүүд ойрын хам сэдэвт ордог. Жишээ нь, Галат 5:11-д “Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд чөлөөлсон юм. Иймд бат зогс, дахижс боолчлолын буулганд бүү орогтун” гэж хэлсэн байдаг. “Боолчлол” гэдэг нь бие махбодын хувьд хэн хүний юмуу улс төрийн хүчиний мэдэлд орох гэсэн санааг ер нь илэрхийлдэг болохоор бид энэ нэр томьёог ямар ч соёл заншилд, ямар ч цаг үед хандуулан хэрэглэх хандлагатай байж болох юм. Гэхдээ энэ хам сэдвийн хувьд сүнслэг боолчлолын тухай яригдаж байна. Уг багц ишлэлд хуулийн ёс жаягт (онцгойлон хөвч хөндөх ёслол) боолчлогдож, “бие биедээ хайраар үйлчлэх” “эрх чөлөө”-гүй (Галат 5:13) хүмүүсийн тухай дурджээ.

2. Завсрлын хам сэдэв

Нэг ном дотор байгаа ишлэлүүдийг завсрлын хам сэдэвт хамааруулдаг. Жишээ болгон Матай 24:40-р ишлэлийг харцгаая: “Тэр үед хоёр хүн талбайд байхад нэгийг нь авч, ногдоог нь орхино.” Энэ багц ишлэлийн хам сэдэв нь “Эцсийн өдрүүд”-ийн тухай өгүүлж байна. Тэгэхээр хэн авагдаж, хэн үлдэх вэ? гэсэн асуулт гарч ирж байна. Сүм дээш авагдах үетэй адил зөвт хүмүүс авагдаж, хорон муу хүмүүс нь орхигдох уу? Эсвэл, Есүс Христийн хоёр дахь удаагаа ирж, мянган жилийн хаанчлалыг байгуулах үетэй адил хорон муу хүмүүс авагдаж, зөвт хүмүүс үлдэх юм уу? Ойрын хам сэдэв энэ асуултад хариулт өгдөггүй.

Харин Матай 13:49-р ишлэлд энэ асуултын хариулт өгөгдсөн байдаг. Энэ багц ишлэлд мөн “эцсийн өдрүүд”-ийн тухай “зөвт хүмүүсийн дундаас муу хүмүүсийг ялгана” гэж хэлсэн байдаг. Тэгэхээр, хэн авагдаж, хэн орхигдох вэ? гэсэн асуултад завсрлын хам сэдэв хариулж байна. Энэ багц ишлэл нь Есүсийн хоёр дахь ирэлтийн талаар өгүүлжээ.

Тухайн номын хам сэдвийг бүхэлд нь ойлгохын тулд ишлэл ишлэлээр нь нэг бүрчлэн уншиж судлахад завсрын хам сэдэв маш чухал байдаг. Хэрэв эхлээд шууд Матай 24-р бүлэгт анхаарлаа хандуулах юм бол дээрх асуултын хариултыг олж авахад тун хэцүү байх болно. Харин Матай номыг бүхэлд нь уншвал уг асуултын хариултыг хялбархан олох болно.

3. Холын хам сэдэв

Холын хам сэдэв гэдэг нь Бурханы Уг бүхэлдээ юм. Өөрөөр хэлбэл, Библи дэх тогтвортой шинжийг энэ хам сэдэв харуулдаг. Библийн аль нэг багцлалыг өөр багцлалуудаар тайлбарлах боломжтой болохыг холын хам сэдэв харуулдаг. Жишээ нь, “нигүүлсэл”, “итгэл”, “хайр” гэдэг үсгийг конкорданс ашиглан судлах үедээ бид эдгээр үгийг агуулсан Библийн бусад багцлалуудыг зайлшгүй унших хэрэгтэй болдог. Конкорданс гэдэг нь тухайн үгийг агуулсан ишлэлүүдийн жагсаалт юм. Конкордансын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг энэ номын сүүл хэсэгт өгөх болно.

Эш үзүүллэгийн тайлан буюу “бэлэгдэл”, “дүрслэл” гэх мэт илүү төвөгтэй хэсгийг тайлахад холын хам сэдэв их тустай байдаг. Жишээ нь, Ариун газар болон Ариунаас ариун газрыг хооронд нь заагладаг байсан Асрын хөшгийг (Египетээс гарсан нь 26:31-35) Есүс Христийн бие гэж Еврей 10:20-д тайлбарласан байдаг.

“**Үнэний үгийг зөв заах**”-ын (2 Тимот 2:15) тулд Библийг хам сэдэв дотор нь тайлах нь онцгой ач холбогдолтой. Бид ямар нэг “онол”-ын тунхаглалыг хийхдээ Библийн ойрын, завсрын болон холын хам сэдвүүд харилцан зохицдог гэдгийг батлах үүднээс өөрийнхөө тунхаглалыг үргэлж Судраас баталж чаддаг байх хэрэгтэй. Хэрэв бидний итгэж байгаа зүйлс Судартай зохицолдохгүй байвал бидний онолын тунхаглал алдаатай байна гэсэн үг юм.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 3Б хэсэг

1. Галат 5:1; Ром 8:2-ыг унш. Христ доторх сүнслэг эрх чөлөөгөө ашиглан бид юу хийх ёстой вэ?
2. Галат 5:13-ыг унш. Бидэнд өгөгдсөн эрх чөлөөг бид хэрхэн ашиглах ёстой вэ?
3. 1 Коринт 10:28-31 ишлэлийг унш. Эсэргүүцэл тэмцэлтэй тулгарах үедээ бид эрх чөлөөгөө ашиглан хэрхэн түүнд хариу үйлдэх ёстой вэ?
4. 2 Коринт 3:17-г унш. Ариун Сүнс Өөртэйгөө хамт юуг авчирдаг вэ?
5. Иаков 1:25-ыг унш. Бид ерөөгдөхийн тулд ямар төгс хуулийг сахих ёстой вэ?
6. Иаков 2:12-ыг унш. Бид хэрхэн ярьж, хэрхэн үйлдэх ёстой вэ?
7. 1 Петр 2:16. Бид эрх чөлөөгөө хэрхэн ашиглах ёстой вэ?
8. 2 Петр 2:1, 17-19 ишлэлүүдийг унш. Хуурамч багш нар юуг амладаг вэ?
9. Галат 5:1-ээс эхлээд (ойрын хам сэдэв), 5:13 (завсрын хам сэдэв) хүртэл унш. Дээр дурдсан (холын хам сэдэв) бусад ишлэлүүдийг ашиглан эрх чөлөөний бусад шинжүүдийг тодорхойл.

B. Зарчим - 11: Харьцуулан тайлбарлах

Харьцуулан тайлбарлах зарчим нь Бурханы Угийн дотоод нэгдмэл байдал дээр үндэслэгддэг бөгөөд утга санааг нь зөв ойлгохын тулд Судартай нь харьцуулах нь маш чухал ач холбогдолтой гэдгийг бидэнд заадаг.

Нигүүлсэл ба өршөөл гэх мэт хоорондоо төстэй сэдвүүдийг харьцуулах нь маш чухал. Түүнчлэн Бурхан ба Сатан гэсэн эрс тэс ялгаатай сэдвүүдийг харьцуулж үзэх нь ч бас чухал байдаг. Төстэй болон ялгаатай сэдвүүдийг холын хам сэдэв дотор харьцуулах үедээ бид маш олон салангад жижиг хэсгүүдийг эвлүүлэн, нэг том зураг болгож харах хэрэгтэй. Жижиг хэсгүүдийг ийнхүү эвлүүлэн нэг ерөнхий зураг гаргахад теологийн зорилго оршдог бөгөөд тэгэх ч учиртай юм.

Зөвхөн шинэ итгэгч ч бус (1 Тимот 3:6), туршлагатай тайлбарлагч ч гэсэн теологийн дүгнэлт хийхдээ болгоомжтой хандаж (Сургаалт үгс 3:5-6), Судрын 31 000 гаруй ишлэлээс ямар нэг чухал зүйлийг анзаараплгүй орхигдуулахаас болгоомжлох хэрэгтэй. Болзошгүй алдаанаас урьдчилан сэргийлэхийн тулд маш болгоомжтой байх ёстой гэдгийг бидний судалж буй материалын цар хэмжээ өөрөө бидэнд сануулдаг.

Бид Судрыг Судартай нь харьцуулж байхдаа теологийн нэг ижил ойлголтыг Библийн өөр өөр хэсгүүдэд авч үзсэн байхыг олж хардаг. Жишээ нь, “итгэлээр зөвтгөгднө” (Эхлэл 15:6; Ром 3-4) гэдэг атал Иаков 2:14-26 ишлэлд “үйлсээр аврагдах” тухай эсрэг зүйлийг өгүүлдэг. Ийм тохиолдолд бид энэ хоёр ишлэлийг хоёуланг нь авч үзэх хэрэгтэй. Тэгснээр, бид үйлс нь Бурханы төлөвлөгөөний нэг чухал хэсэг бөгөөд энэ нь авралыг олж авах хэрэгсэл биш, харин аврал өөд биднийг хөтөлдөг итгэлийн үр дүн гэдгийг ойлгодог. Ефес 2:8-10 ишлэлд энэ зарчмыг мөн заасан байдаг. **“Нигүүлслээр та наар итгэлээрээ аврагдсан”** бөгөөд **“сайн үйлийн төлөө бүтээгдсэн”** гэж бидэнд хэлсэн байдаг.

Маргаантай асуудлууд дээр теологийн ямар нэгэн үзэл баримтлалыг гаргаж ирэхгүй байхыг энэ зарчим бидэнд сургадаг. Жишээ нь, Марк номын грек бичвэрийн утга санаа 16:9-р ишлэлээс авахуулаад дуустлаа маш тодорхойгүй байдаг. Зарим хүмүүс эдгээр багцлал дээр тулгуурлан онолын үзэл баримтлалыг гаргаж ирсэн нь эцэстээ буруу теологи гарч ирэхэд хүргэсэн.

Судрыг Судартай нь харьцуулахын ач холбогдлыг харуулсан өөр нэг жишээ бол Шинэ гэрээний номуудад олонтаа яригдаг “нууц”-ын (тодруулбал, үл мэдэгдэх зүйл) тухай ойлголт юм. Ефес 3-р бүлэгт энэ ойлголтын талаар хэд хэдэн удаа дурдсан байдаг. “Нууц гэж юу вэ?” Энэ асуултын хариултыг Колоссай 1:25-27 ишлэлээс олох боломжтой:

Бурханы үгийг биелүүлэхийн тулд та нарын тусын тулд Бурханаас надад соёрхсон үргийн дагуу би энэхүү чуулганы үйлчлэгч болсон юм. Тэрхүү нууц нь онгорсон үеүдээс, үр удмуудаас нууцлагдаж байсан боловч одоо Өөрийнх нь ариун хүмүүст илэрхийлэгдэжээ. Бурхан харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг гээж юу болохыг тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм. Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвэр болох Христ мөн.

Энэ “нууц” нь Мессиатай тогтоох шинэ харилцаа мөн гэж Сударт хэлдэг. Энэхүү шинэ харилцаа нь Чуулганы эрин хэмээгдэх шинэ эриний тэмдэг юм.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 3В хэсэг

1. Ром 3:21-28 ишлэлийг унш. Хүн Бурханы өмнө хэрхэн зөвтгөгдсөн бэ?
2. Ефес 2:8-9 ишлэлийг унш. Хүн хэрхэн аврагдсан бэ?
3. Иаков 2:14-26; Ефес 2:10-ыг унш. Итгэгч хүн ямар үр жимс гаргах ёстой вэ?
4. Иаков 2-р бүлэгт үйлсгүй итгэлийн талаар зохиогч юу гэж хэлсэн бэ?
5. Энэ нь, хэрэв итгэгч хүн сайн үйлс хийхгүй бол аврагдахгүй гэсэн утгатай юу? (Тит 3:5-ыг үз)
6. Иаков 2-р бүлэгт Абрахам хүүгээ өргөх үедээ итгэгч болсон байсан уу?

7. Иаков 2-р бүлэгт “Чамд итгэл байна, харин надад үйлс байна. Чи надад итгэлээ үйлсгүйгээр харуул, харин би чамд өөрийнхөө итгэлийг үйлсээрээ харуулъя” гэж асуусан хүн хэн бэ?
8. Еврей 11:1-ийг унш. Итгэлийг харж болох уу?
9. Эдгээр багцлалуудыг нэг бүрчлэн тунгаан бодоод, Иаков 2:14-д буй “аврагдсан”, 2:22; 2:24 ишлэлүүдэд буй “зөвтгөгдсөн” гэсэн үгсийг тайлбарла.

Г. Зарчим - 12: Зохицолдолгоог эрэлхийлэх

Бурхан бол самуурлын Бурхан биш (1 Коринт 14:33) бөгөөд Түүний Үг үнэн агаад итгэмжтэй гэдгийг энэ зарчим харуулдаг. Өөрөөр хэлбэл, Бурханы үг хоорондоо хэзээ ч зөрчилддөггүй. Библи нь бүхэлдээ Амьд Бурханы амьсгалаар бичигдсэн учраас түүнийг бүрэлдүүлж буй хэсгүүд хоорондоо яв цав нийцдэг.

Судрыг тайлахтай холбоотой гардаг зөрөлдөөнтэй асуудлууд нь Бурханаас биш, харин хүний өөрийнх нь мөн чанараас улбаатай байдаг. Олон хүн Бурханы Үгийг өөрсдийнхөө сэтгэлийн хөдөлгөөн дээр тулгуурлан хүлээн авдаг. Харин Судар үүний эсрэг сэргэмжлүүлдэг (Иохан 5:37; Сургаалт үгс 3:5-6; 2 Коринт 5:7). Судрын зарим хэсгийг бид Бурхантай нүүр тулан уулзахаасаа(1 Коринт 13:12) өмнө бүрэн гүйцэд ойлгож чадахгүй. Тиймээс, бид бүх зүйл дээр Бурханд найдаж, итгэлээр амьдрахыг (Еврей 11:6; Колоссай 2:6) зөвшөөрч байна уу, үгүй юу гэдэгт л асуудлын гол оршиж байгаа юм.

Хоорондоо илт зөрчилдэж буй мэт ишлэлүүд нь үнэндээ бие биенээ гүйцэлдүүлж байдаг гэдгийг ойлгох үедээ бид мэргэн ухааныг олж авдаг. Ойлгоход хэцүү тунхаглалууд болон таавруудыг ухаж ойлгох үедээ бид мэргэн ухааныг олж авдаг гэж Сургаалт үгс номын эхэнд хэлсэн байдаг (Сургаалт үгс 1:2-6). Гэхдээ үүний тулд шаргуу хөдөлмөрлөх хэрэгтэй. Жишээ нь, бидний дээр дурдсанчлан, итгэл, үйлс хоёрын хоорондох харилцаа холбоог зөв ойлгохын тулд Иаков 2 болон Ром 3-4 ишлэлийг хоёуланг нь судлах ёстой.

Судрын өөр багцлалуудыг хоорондох уялдаа холбоог авч үзэхдээ орчуулгын жижиг ялгаа хүртэл чухал нөлөө үзүүлэх боломжтойг ойлгохын сацуу, цаг хугацаа болон газар нутагтай холбоотой шинж тэмдгүүдийг соргогоор хардаг байх ёстой юм. Ямар ч тохиолдолд Бурханы Үг хоорондоо хэзээ ч зөрчилддөггүй гэдгийг бид ямагт санаж байх учиртай.

Үнэнийг ойлгоход хялбар байлгахын тулд Бурханы Үг нэг ижил зарчмыг өөр арга замаар илэрхийлэх явдал нэлээд байдгийг бид бас ойлгох хэрэгтэй юм. Жишээ нь, Ром 3:23-д “бүгд нүгэл үйлдсэн...” гэсэн байдаг. Бүх хүмүүс нүглийнхээ төлөө өргөл авчрахыг Левит номд тушаасан. Энэ хоёр багц ишлэл хоёулаа нэг зүйлийн талаар ярьж байна.

Бурханы Өөрийнхөө Үгийн бүтэц, зохион байгуулалтыг Өөрөө удирдан зохицуулдаг болох нь Библийг судлах явцад тодорхой болдог.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 3Г хэсэг

1. Өмнөх хэсэгт үзсэн (ЗВ) судалгааны арга барил нь энэ зарчмыг баталж байна уу?
2. Ром 3:21-28; 5:1-2, 8-10; 8:35-38; Иохан 10:27-29 ишлэлүүдийг унш. Авралын талаар дэвшүүлсэн гол санаа юу вэ?
3. 1 Коринт 6:9-10 ишлэлийг унш. Эдгээр ишлэл юны талаар сургаж байна вэ?
4. Энэ багц ишлэлээс ямар нэгэн зөрчил харагдаж байна уу?
5. 1 Коринт 3:10-15 ишлэлийг унш. Илэрхий байгаа зөрчлийг хэрхэн зохицуулж болох вэ?

- 6. Иаков 1:12-ыг унш. Амийн титмийг хүлээн авахын тул хүн юу хийх ёстой вэ?**
- 7. 1 Петр 5:1-4 ишлэлийг унш. Алдрын титмийг хүлээн авахын тулд хүн юу хийх ёстой вэ?**
- 8. 2 Тимот 4:7-8 ишлэлийг унш. Зөвт байдлын титмийг хүлээн авахын тулд хүн юу хийх ёстой вэ?**

Д. Зарчим - 13: Диспенсацийг анхаарч үзэх

Бурхан Өөрийнхөө ард түмэнд өөр өөр үүрэг хариуцлагыг хүлээлгэсэн үеүдийг диспенсац гэдэг. Өөрөөр хэлбэл, энэ нь дээрх үүрэг хариуцлагуудаар ангилагдсан түүхэн цаг хугацааны агшинууд юм. “**Тахилчийн үүрэг өөрчлөгдөхөд хууль ч өөрчлөгдөх зайлшгүй байдал бий болдог ажгуу**” гэж Еврей 7:12-д хэлсэн байдаг. Бурхан түүхийн өөр өөр үеүдэд, өөр өөр үүрэг хариуцлагуудыг хүлээлгэдэг тухай энэ ишлэлд заажээ.

Адамын уналтаас хойших үеийг дөрвөн диспенсацид хуваадаг:

1. Харь үндэстний эрин үе - Адамын уналтаас Египетээс гарсан хүртэл

Энэ үеийн талаар Эхлэл болон Иов номд бичигдсэн байдаг. Энэ үе нь ойролцоогоор МЭӨ 3900-1445 он хүртэл үргэлжилдэг.

2. Израилийн эрин үе - Египетээс гарснаас Пентекостын өдөр хүртэл

Энэ үеийн талаар Эхлэл, Иов номоос гадна Хуучин гэрээний бүх номд өгүүлсэн байдаг. Түүнчлэн Сайн мэдээний дөрвөн ном болон Үйлс номын 1-р бүлэгт бас энэ үеийн талаар өгүүлдэг. Мянган жилийн хаанчлалын тухай дурдсан хэд хэдэн багцлал Хуучин гэрээнд байдаг. Жишээ нь, Исаиа 61-66; Езекиел 40-48.

Энэ үе ойролцоогоор МЭӨ 1445-МЭ 33 он хүртэл үргэлжилдэг. Мөн энэ үед “Зовлонгийн үе” буюу “Даниельн дал дахь долоо хоног” (Даниел 9:24-27) гэдгээр нь бидний мэдэх болсон Чуулганы дээш авагдалтаас Есүсийн хоёр дахь ирэлт хүртэлх үе мөн энэ эринд багтдаг.

3. Чуулганы эрин үе - Пентекостын өдрөөс Чуулган дээш авагдах хүртэл

(Израилийн эрин үеийн сүүлчийн долоон жил буюу Зовлонгийн долоон жил нь Чуулган дээш авагдсанаас Есүс Христийн хоёр дахь ирэлт хүртэл үргэлжилдэг.)

Чуулганы эрин үеийн талаар Үйлс 2–28, Ефес болон Илчлэлт 2–3 бүлэгт өгүүлдэг. Харин Израилийн эрин үеийн төгсгөл болох Зовлонгийн үеийн талаар Илчлэлт 4-19 бүлгээс харж болно.

Энэ үе МЭӨ 33 оноос эхэлсэн бөгөөд Чуулган дээш авагдах хүртэл үргэлжилнэ.

4. Мянган жилийн хаанчлалын эрин үе - Есүс Христийн хоёр дахь ирэлтээс Цагаан өнгөтэй агуу их сэнтийн шүүлт хүртэл

Энэ үеийн талаар Илчлэлт 20 болон Хуучин гэрээний зарим багцлалуудад бичсэн байдаг.

Хүмүүст Бурханы өгсөн өөр өөр тахилчлалыг авч үзэх үед бид диспенсацуудын талаар илүү тодорхой ойлгодог. Жишээ нь, Израиль нь Египетээс гарсан даруйдаа үндэстэн болон бүрэлдэх хүртлээ “Харь үндэстний эрин үе (буюу диспенсац)”-д хамрагдаж байсан. Энэ үед тахилчлалын үйлчлэлийг гэр бүл доторх настайчууд нь гүйцэтгэдэг байсан ба үүнийг “гэр бүлийн тахилчлал” гэж нэрлэдэг байжээ. Үүний жишээ бол Ноа (Эхлэл 8:20), Абрахам (Эхлэл 22:2), Иов (Иов 1:5) юм. Дагах ёстой хуулийг нь Бурхан “тэдний зүрх сэтгэлд бичсэн” (Ром 2:15) байсан.

Иудейчүүдийг Египетээс гарсны дараахан Израилийн эрин үе (буюу диспенсац) эхэлсэн бөгөөд Бурхан леви овгийг нэгэн цоо шинэ тахилчлалд дуудсан. Үүнийг бид “левийн тахилчлал” гэдгээр нь мэддэг билээ. Энэ тахилчлал нь Леви овгийн Аароны үр удам дээр үндэслэгдсэн байсан. Левийн тахилчлал нь Асар дотор, хожим Сүмд хийгддэг байжээ. Энэ үеийн тахилчид Бурханы Мосед өгсөн тусгай арга барилыг ашиглан амьтдаар тахил өргөх, Бурханд мөргөл үйлдэх, Бурханы Үгийг

зааж сургах зэрэг үүргийг гүйцэтгэх ёстой байсан. Тэдний дагах ёстой хуулийг Египетээс гарсан нь, Левит, Тооллого, Дэд хууль номд бичсэн. Харамсалтай нь, Есүс Христийг төрсөн үед эдгээр арга барилыг гажуудуулж, ёслолын зан үйлийг түүний илэрхийлж буй бодит санаанаас илүүд үзэх болсныг нэмж тэмдэглэх нь зүйтэй юм (Еврей 10:8).

Есүс Христийн загалмай болон амилалтын дараа Пентекостын өдөр Бурхан нэгэн шинэ эрин үеийг эхлүүлсэн. Энэ бол “Чуулганы эрин үе” буюу Чуулганы диспенсац юм. Энэхүү шинэ диспенсацид Есүс Христэд итгэдэг бүх хүн Бурханы тахилч болсон (1 Петр 2:5, 9). Эдгээр шинэ “итгэгч – тахилч” нь амьтдаар тахил өргөх шаардлагагүй, харин оронд нь **“өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөх ..”** хэрэгтэй бөгөөд “**энэ нь [тэдний] сүнслэг мөргөл**” (Ром 12:1) юм. Энэ диспенсацид тахилчлалын хэлбэр өөрчлөгдсөн боловч сүнслэг үүргүүд нь хэвээр үлдсэн юм. Эдгээр нь Бурханы Үгийг заах болон мөргөлд удирдах үүрэг юм. Бурхан Өөрийн зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд гаргаж ирсэн өөр өөр арга барил болон хэлбэрүүдээр диспенсациуд нь илэрхийлэгддэг. Чуулганы диспенсац нь “хайрын хязгаар дотор” (Ром 13:8-10; Галат 5:14; Иаков 2:8) “Эрх чөлөөний хуулийг” (Иаков 1:25; 2:12) биелүүлэх ёстой юм.

Мянган жилийн хаанчлал болон Хаадын диспенсацийн үед Леви овгийн Задокийн хөвгүүдээр (Езекиел 40:46; 43:19; 44:15; 48:11) удирдуулсан шинэ тахилчлал гарч ирэх болно. Хуулиуд нь “Израилийн гэртэй хийсэн Шинэ гэрээ” (Иеремиа 31:31-33; Еврей 8:8-10) дээр суурилагдах агаад Эзэн Есүс Христ **“бүх үндэстнийг төмөр таягаар захирах”** (Илчлэлт 12:5) үедээ эдгээр хуулийг тогтооно.

Тиймээс, диспенсацийн тайлал нь арга барил болон хэлбэрийн өөрчлөлтийг харуулдаг боловч бие махбодын бус, харин сүнслэг зарчмууд дээр үндэслэдэг юм. Жишээ нь, өнөөгийн диспенсацид бид Эзэн Есүс Христийн сүүлчийн тахилыг дурсан санахын тулд Бурханд амьтдаар тахил өргөх шаардлагагүй болсон (Еврей 10:10). Харин үүний оронд Чуулган Эзэний зоог барьж, Түүний тахилыг дурсан санаж, магтаалын тахилыг өргөдөг (1 Коринт 11:23-34). Мянган жилийн хаанчлалын үед амьтдаар тахил өргөх тахилын өөр хэлбэр бий болох бөгөөд энэ нь загалмай дээр Христийн гүйцэлдүүлсэн ажлыг эргэн дурсах зорилготой тахил байх юм (Езекиел 43:18-27).

Түүхийг ийнхүү диспенсацид хуваах нь Судрын тайллаас үүсэлтэй бөгөөд энэ нь хатуу тогтсон зүйл биш юм. Нэг диспенсациас нөгөө уруу шилжсэн тодорхой цаг хугацааны талаар хэд хэдэн үзэл хандлага байдаг. Гэхдээ эдгээр хандлага нь Бурхан түүхийн өөр өөр цаг хугацаанд амьдарч байсан хүмүүст өөр өөр үүрэг хариуцлагыг тогтоодог гэсэн диспенсацийн зарчмыг үгүйсгэдэггүй.

Орчин үед “гипер-диспенсационализм” гэж нэрлэдэг нэгэн шинэ чиг хандлага гарч ирсэн бөгөөд энэ нь түүхийг олон жижиг диспенсацид хуваадаг. Энэ хандлага нь Библи дээр үндэслэдэггүй гэдгийг бид тэмдэглэх ёстой. Зөв тайллыг гажуудуулж, өөрийн нэр хүндийг ахиулах зорилгоор үүнийг хялбархан ашиглах боломжтой. Энэ зарчмыг хэт хатуу барих нь хуульд боолчлогдох, тэр ч бүү хэл христэч амьдралынхаа утга учрыг алдахад хүргэж болох юм. Жишээ нь, Есүс уулан дээрх сургаалдаа Израилийн эрийн үеийн зарчмуудыг ярьсан гэдэг шалтгаанаар бид эндээс Чуулганы үнэ цэнийг олж харахгүй бол Эзэн Есүс Христийн хэлсэн үгс бүгд “эрүүл” хэмээн 1 Тимот 6:3-д Паулын хэлсэн зарчмыг зөрчиж буй хэрэг юм.

Үндсэн зарчмуудыг баримтлах нь энэ чиг хандлагын хамгийн гол зорилго юм. Библийн түүхийн туршид тахилчлалын хэлбэр болон арга барил өөрчлөгдөж байсан боловч тэдгээрийн үндэс суурь болсон зарчмууд нь хэвээр үлдсэн юм. Аль ч диспенсацид бүх тахилчид Эзэнд тахилуудыг өргөж, Бурханы Үгийг заах ёстой байдаг.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 3Д хэсэг

1. Еврей 7:12-ыг унш. Тахилчлал өөрчлөгдөхөд өөр юу өөрчлөгдөх ёстой вэ?

2. Эхлэл 8:20; Иоб 1:5-ыг унш. Эдгээр нь Харь үндэстний эрин үеийн тахилчлалын жишээ юм. Үүнийг “Гэр бүлийн тахилчлал” гэж иэрлэдэг. Энэ үед тахил өргөх хариуцлагыг хэн хүлээдэг байсан бэ?
3. Ром 2:15-ыг унш. Харь үндэстний эрин үед ямар хуулийг мөрдөх ёстой байсан бэ?
4. Египетээс гарсан нь 28:1-ийг унш. Энд Израилийн эрин үеийн тахилчлалын талаар өгүүлдэг. Энэ үед тахил өргөх үүргийг хэн хариуцдаг байсан бэ?
5. Дэд хууль 4:44-46 ишлэлийг унш. Израильчууд ямар хуулийг мөрдөх ёстой байсан бэ?
6. 1 Петр 1:1-2; 2:5, 9-ийг унш. Чуулганы эрин үед хэн тахилчилдаг вэ?
7. Ром 13:8-10; Иаков 2:8-ыг унш. Чуулганы тахилчид ямар хуулийг мөрдөх ёстой вэ?
8. Езекиел 40:46; 43:19; 44:15; 48:11-ийг унш. Мянган жилийн хаанчлалын үед хэн тахилчлах вэ?
9. Еврей 8:8-10 ишлэлийг унш. Энэ эрин үеийг ямар хууль захирах вэ?
10. Левийн тахилч нар амьтдаар тахил өргөдөг байсан. Хаант тахилчид өөрсдийгөө өргөх ёстой. Ялгаа нь юу вэ?

E. Зарчим - 14: Эш үзүүллэгт болгоомжтой хандах

Библи ирээдүйн зүйлсийг урьдчилан хэлдэг гэдгийг энэ зарчим бидэнд заадаг. Түүнчлэн, Жинхэнэ эш үзүүллэгүүд нь Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүсээр дамжуулан Бурханаас ирдэг учир “Судрын нэг ч эш үзүүллэгт эш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүй” (2 Петр 1:19-21) гэдгийг Библи маш тодорхой хэлдэг. Эш үзүүллэгийг тайлах гэсэн олон оролдлого байдаг боловч харамсалтай нь, тэдний ихэнх нь үндэслэлгүй байдаг. Шашны урсгалууд хүмүүсийг өөртөө татах зорилгоор эш үзүүллэгүүдийг ийнхүү өөрсдийн дураар тайлбарлах нь нийтлэг байдаг. Есүс Христэд итгэдэг хүн бүр тахилч гэдгийг байнга санаж байх хэрэгтэй. Хэрэв хэн нэгэн хүн тань дээр хүрч ирээд, өөрт нь шинэ, онцгой тайлал байгаа тухай яривал та болгоомжтой байгаарай. Мөн, хэрэв хэсэг бүлэг хүмүүс танд хандан, өөрсдийнхөө бүлэгт орох болзол болгон шинэ, онцгой тайллыг нь хүлээн зөвшөөрөхийг шаардвал та тэднээс болгоомжлох хэрэгтэй.

Эш үзүүллэгийн тайлал нь олон мянган хэсэгт хуваагдсан (10000 орчим эш үзүүллэгийн ишлэл байдаг) нэг том зургийг эвлүүлж, нэг бүтэн зураг болгодог. Энэ зураг бүрэн гүйцэд болох үед түүхийн бүхий л үеийн туршид (өнгөрсөн, одоо, ирээдүй) анхаарлын төв болсон Есүс Христийг бид олж харна. Энэхүү ерөнхий зурагт бүгдийн мэддэг бодит баримт, нотолгоонууд бүгд багтсан байх ёстой. Уг зурагт тохирогчийг гэж бодож байгаа баримтуудыг бид өөрсдийн дураар орхигдуулах эрхгүй.

Эш үзүүллэгийн тайллын талаарх хичээл нь тусдаа нэг том хичээл болж орох боломжтой юм. Яагаад гэвэл, эш үзүүллэгийн ном нь Судрын 1/4-ийг эзэлдэг. Харин энэ хичээлийн тухайд, бид дараах үндсэн гурван удирдамжийг дагах нь чухал юм.

1. Эш үзүүлэгч өөрөө ямар нэг тайлал хийсэн эсэхийг тогтоох

Эш үзүүлэгч өөрийнхөө эш үзүүллэгт ямар нэг тайлал хийсэн эсэхийг эхлээд тогтоох хэрэгтэй. Жишээ нь, Иохан 2:19-21 ишлэлд Есүс Сүмийн талаар тайлбарласан байдаг.

Есүс тэдэнд, энэ сүмийг устга. Би үүнийг гурван одрийн дотор босгоно гэсэнд шудейчүүд: Энэ сүмийг барихад дөчин зургаан жил шаардагдсан байтал, үүнийг гурван одрийн дотор босгоно гэж үү? гэв. Гэтэл Есүс Өөрийн биеийн сүмийн тухай айлдсан ажээ.

Иймэрхүү эш үзүүллэгүүдэд тайлал хийх хялбар байдаг. Гэтэл заримдаа Бурхан олон зуун жилийн дараах зүйлсийн талаар ярьж буй хэрнээ түүнийгээ тэмдэглэн хэлэхгүй ч байж болно гэдгийг ойлгох хэрэгтэй. Тэр ч байтугай нэг ишлэл дотор хүртэл олон зуун жилийн дараах зүйлсийг өгүүлж болно. Жишээн нь, Есүс Лук 4:18-21 ишлэлд Исаиа 61:1-2-ыг иш татан бидэнд тайлбарласан байдаг.

2. Тухайн эш үзүүллэг биелэгдсэн эсэхийг тогтоох

Тухайн эш үзүүллэгийн биелэлтийн талаар дурдсан өөр багцлалуудад байдаг эсэхийг эхлээд бид олж тогтоох ёстой. Тэгснээр бид хараахан биелэгдээгүй ямар эш үзүүллэгүүд байгааг мэдэх боломжтой болно.

Жишээ нь, Ноагийн Үер болох тухай түүнээс 120 жилийн өмнө эш үзүүлсэн байдаг (Эхлэл 6:3). Энэ эш үзүүллэг биелсэн гэж Судар бидэнд хэлдэг (Эхлэл 7-8).

Түүнчлэн, Эзэн бүх Израиль үндэстнийг ер бусын байдлаар дахин цуглувуна гэж Судар эш үзүүлдэг (Зехария 9:14; Матай 24:31). Харин энэ эш үзүүллэг хараахан биелэгдээгүй байна. Бид үүнийг зөвхөн Судраас төдийгүй, мөн түүхээс тодорхойлох боломжтой.

Зарим эш үзүүллэгүүдийн биелэлтийг олж харахын тулд бид түүхийн ном сурах бичиг гэх мэт гаднах эх сурвалжуудыг уншиж судлах хэрэгтэй. Дэлхийн түүх нь Бурханы онгodoор бичигдээгүй учраас Бурханы үгтэй тохирохгүй байж болно гэдгийг санах хэрэгтэй. Харин бид зөвхөн Бурханы Үгэнд итгэх ёстой.

3. Эш үзүүллэгийн үг хэллэгт анхаарал хандуулах

Эш үзүүллэгт шилжсэн утгатай үг, зүйрлэл (Илчлэлт 5-р бүлэгт Эзэнийг “Иуда овгийн Арслан”, “Бурханы Хурга” гэж зүйрлэсэн), бэлгэ тэмдэг (Илчлэлт 13-р бүлэгт “араатан”) болон дүрслэлийг (Египетээс гарсан нь 25–40 бүлэгт газар дээрх Асар) өргөн ашигласан байдаг. Тиймээс бид юуны түрүүнд тухайн эш үзүүллэгт хэрэглэсэн үг хэллэгийг Библи хэрхэн тайлбарласныг олох ёстой.

Гэхдээ энэ нь таамаглал болохоос, тайлал биш гэдгийг санах хэрэгтэй. Тухайн үг хэллэгийн утгыг таамаглаж эхлэх үед янз бүрийн таамаглалууд гарч ирдэг. Өөрсдийнхөө таамаглалыг “үзэл баримтлал” болгож хувиргах нь хүмүүсийн хувьд тун амархан зүйл. Тиймээс, цаг нь болохоос нааш бид зарим эш үзүүллэгийн үг хэллэгийг ойлгож чадахгүй гэдгийг бид ойлгох хэрэгтэй юм (Даниел 12:4, 8-10).

Хувийн Судлал: 4-р бүлэг, 3Е хэсэг

1. **2 Петр 1:19-ийг унш. Есүс Христийн төрөлт, нас барагт, амиалт нь эш үзүүллэгийн биелэлт байсан гэдгээс үүдэн бид эш үзүүллэгийн талаар юу хэлж болох вэ?**
2. **2 Петр 1:20-ийг унш. Жинхэнэ эш үзүүллэгийн хувьд юу чухал вэ?**
3. **2 Петр 1:21-ийг унш. Хэнд жинхэнэ эш үзүүллэг хэрхэн өгөгддөг вэ?**
4. **Лук 4:18-21; Исаиа 61:1-2 ишлэлүүдийг унш. Яг тэр мөчид болж байсан ямар зүйлийн талаар Есүс хэлсэн бэ?**
5. **Эхлэл 6-8 бүлгийг унш. 6:3-д өгөгдсөн эш үзүүллэг биелэгдсэн үү?**
6. **Исаиа 7:14; Матай 1:18-25 ишлэлүүдийг унш. Энэ эш үзүүллэг биелэгдсэн үү?**
7. **Иохан 14:1-3 ишлэлийг унш. Энэ эш үзүүллэг биелэгдсэн үү?**
8. **1 Тесалоник 4:16-17 ишлэлийг унш. Энэ эш үзүүллэг биелэгдсэн үү?**

9. Зехариа 14:1-8 ишлэлийг унш. Энэ эш үзүүллэг биелэгдсэн үү?
10. 1 Тесалоник 4:16-17; Зехариа 14:1-8 ишлэлүүдэд дүрсэлсэн үйл явдлуудыг тодорхойл.
11. Илчлэлт 5:4-6 ишлэлийг уншаад, Есүс Христийг тодорхойлон бичихэд дүрслэлийн ямар нэр томьёонуудыг ашигласныг жагсаан бич.

4-р ХЭСЭГ

Дөрөвдүгээр Дүрэм

Бурханы үгийг зохих ёсоор хэрэгжүүлсэн христэч амьдралаар амьдрахыг хичээх

Энэ дүрэм нь Иохан 7:17-д Есүс Христийн хэлсэн үгээс үүдэлтэй. Хэрэв бид Бурханы Угийг үнэхээр “мэдэх”-ийг хүсж байгаа бол Түүний Угийн дагуу “үйлдэхийг” хүсдэг байх ёстой. Бурханы Угийг сурахад оюун ухааны зөв шударга байдал зайлшгүй шаардлагатай гэдгийг энэ зарчим харуулдаг. Бид өөрсдийн бодол санааг хойш тавиад, Бурханы Сүнсний зүйлсийг чин сэтгэлээсээ эрж хайх ёстой (1 Коринт 2:14). Энэ зарчмыг хэрэгжүүлэхдээ хувь хүн өөрийнхөө до тоод сэтгэлийн нягтлах хэрэгтэй юм. Жишээ нь, бид өөрсдийнхөө хандлагыг хэр цэвэр байгааг үнэлж дүгнэх ёстой юм (2 Коринт 13:5).

Бид өөрсдийн буруу зөрүү бодол санааг зөв хэмээн итгэхдээ амархан бөгөөд тэдгээрийгээ Библиэр “нотлох” санаатай бөөн эрэл хайгуул болдог. Ийм хандлагаар бид бараг юм болгоныг “нотолж” болдог. Яагаад гэвэл, энэ нь биднийг өр зөв зүг уруу чиглүүлэх багцлалуудыг олж харах нүдийг сохолж орхидог.

Жишээ нь, Давид хаан өөрийн хамгийн үнэнч дайчны эхнэр Батшебатай завхайрсан явдлыг (2 Самуел 11) зарим хүмүүс өндөр албан тушаалд байгаа хүн завхайрч, хүн алах эрхтэй хэмээн тайлбарлаж, үүнийгээ батлах гэж оролддог. Тэгвэл, дараагийн бүлгийг уншаад, “Арван тушаал”-тай (Египетээс гарсан нь 20:1-17) харьцуулбал, аллага болон завхайрлыг бидний Бурхан хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй гэдгийг баталж болно. Бурхан Давидын гэмшилийг хараад, түүнд нигүүлслээ үзүүлсэн учраас л Давид хаан хэвээр үлдсэн юм (Дуулал 51).

A. Зарчим - 15: Зөв хэрэгжүүлэлт нь зөв тайлал дээр үндэслэгддэг

Бурханы Угийн зөв зохистой хэрэгжүүлэлт нь зөв тайлал дээр үндэслэгддэг. Хэрэгжүүлэлт нь олон байж болох хэдий ч аливаа ишлэлд зөвхөн нэг л зөв тайлал байдаг. Жишээ нь, 1 Тимот 3:1-7 ишлэлд чуулганы “харгалзагч” хүнд байх ёстой шинж чанаруудыг дурдсан байдаг. Энэ тайлал нь яг энэ байр сууринд байгаа хүнд хамаатай юм. Харин “харгалзагч” нь “шинэ итгэгч” байж болохгүй бөгөөд энд дурдсан шинж чанарууд нь чуулганы бүх эрчүүд, тэр тундаа удирдагчдын хүрэх ёстой төлөвшилтийг харуулдаг гэдэг нь хэрэгжүүлэлт юм.

Бурханы Угийг зөв зохистой хэрэгжүүлнэ гэдэг нь дээр дүрэм болон зарчмуудыг анхааралтай, зөв шударгаар хэрэглэх явдал юм. Өөрөөр хэлбэл, нигүүлсэл ба итгэл дээр суурилсан харилцааг Бурхантай бий болгох зорилгоор Бурханы талаарх мэдлэгийг эрж хайх явдал юм. Түүнчлэн, энэ нь Ариун Сүнсний хүч ба үйлчлэлээр Есүс Христийг эрж хайх гэсэн үг юм.

Ойлгомжтой, тодорхой хэлэгдсэн багц ишлэл нь бидний амьдралын чиглүүлэгч болдог бөгөөд дагалдагч хүн хуулийн боолчлолд бус, харин зөвт амьдралаар амьдарч, бүх зүйл дээр Есүс Христтэй адил байхын тулд Бурханы Угийн зохицолдолгоог олж харах ёстой юм (Ариун Сүнснээс хүлээн авах мэдлэгийнхээ хэмжээгээр).

Хувийн Судлал: 4-р бүлэг, 4А хэсэг

- 1 Тимот 3:1-7 ишлэлийг уншаад, харгалзагч хүнд байх ёстой шинж чанаруудыг жагсаан биши.**
- Пастор болох хүсэлтэй хүмүүс өөрсдийгөө эдгээр шинж чанарын дагуу шалгана уу.**

B. Зөв зохистой хэрэгжүүлэлтийн таван алхам

1 дэх алхам: Бурхан танд ойлголтыг болон сүнслэг зарчмуудын зөв хэрэгжүүлэлтийг өгөхийн төлөө залбир (Иаков 1:5).

2 дахь алхам: Тайлал хийж буй багц ишлэлээ бүрэн зөв ойлгохыг хичээ. Үүний тулд тухайн үгийг өгүүлбэртэй нь, өгүүлбэрийг догол мөртэй нь, догол мөрийг бүлэгтэй нь, бүлгийг номтой нь холбож судлах хэрэгтэй (2Тимот 2:15).

3 дахь алхам: Тухайн багц ишлэлийн тайллаас гарч ирж буй сүнслэг зарчмыг тодорхойлох. Сүнслэг зарчим нь бүх цаг үе, бүх соёл заншилд адилхан байх болно. Жишээ нь, гэр бүлээс гадуурх бэлгийн харилцааг аль ч цаг үед, аль ч соёл заншилд нүгэл гэж үздэг. Энэ тохиолдолд, сүнслэг зарчим нь бэлгийн ёс бус харилцаанаас зайлсхийх явдал юм (Ром 13:8-10).

4 дахь алхам: Судрын сүнслэг зарчмаас гажсан зүйл амьдралд чинь байгаа эсэхийг шударгаар нягтлаад, гэм буруугаа засахын тулд Бурханд бууж өгөх. Үүний тулд алдаагаа Эзэний өмнө чин сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч (1 Иохан 1:9), итгэлийн амьдралаа шинэчлэх хэрэгтэй (Колоссай 2:6). Дуулал 51-р бүлгийг анхааралтай уншиж, Давид Батшебатай нүгэл үйлдсэнийхээ төлөө хэрхэн гэмшиж байгааг (2 Коринт 13:5) нягтлан харах шаардлагатай.

5 дахь алхам: Нигүүлсэл ба итгэл дотор алх. “*Тиймээс та нар Эзэн Есүс Христийг хүлээн авсан шигээ Түүн дотор алхахдаа*” (Колоссай 2:6) гэж элч Паул бидэнд хэлсэн. Бид итгэлээр дамжуулан нигүүлслээр Түүнийг хүлээн авсан (Ефес 2:8-9) учраас тэрхүү хүлээн авсан нигүүлслийнхээ дагуу үйлдэх (Ефес 2:10) ёстой юм.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 4Б хэсэг

1. **Иаков 1:5-ыг унш. Биднийг юуны төлөө залбир гэж хэлсэн байна вэ?**
2. **2 Тимот 2:15-ыг унш. Судрыг ойлгож, хэрэгжүүлэхэд юу шаардлагатай вэ?**
3. **1 Тимот 3:1-7 ишлэлээс үзвэл, таны хувьд гол сүнслэг зарчмууд юу вэ?**
4. **Эдгээр зан чанар нь харгалзагч хүнд байх ёстой учраас итгэгч хүнд заавал байх шаардлагагүй юу?**
5. **Эдгээр зарчмын дагуу өөрийнхөө амьдралыг үнэлж дүгнэнэ үү.**
6. **Таны амьдралд Бурханы өмнө улайх шаардлагатай гэм нүгэл бий юу? Хэрэв байгаа бол иэн даруй энэ зүйлийг хийгээрэй.**
7. **Итгэлийн алхмаа шинэчлэх шаардлагатай хэсэг таны амьдралд бий юу? Хэрэв байгаа бол та тийнхүү үйлдэхэд бэлэн байна уу?**

B. Зөв тайлал хийхэд тулгардаг зургаан саад

Бурханы Угийг зөв тайлахад олон саад бэрхшээл тулгардаг. Тэдгээрээс зургааг нь бид үзэх болно. Алдаанаас хамгаалагдсан хүн гэж байдаггүйг санагтуун. “*Тиймээс өөрийгөө зогсож байна гэжс боддог хүн унаачихгүй тулд болгоомжтой байг*” хэмээн 1 Коринт 10:12-д Паул урьдчилан сануулсныг ямагт санаж байх нь чухал юм.

1. Махан бие

Бурханы Угийг тайлбарлахад тулгардаг эхний саад бол махан бие юм. Махан бие гэдэгт байнгын гэм нүгэлт амьдралын хэв маяг ордог бөгөөд үүнийг “махан биеийн дагуу явах” (1 Коринт 3:3) гэж ихэвчлэн хэлсэн байдаг. Энэ нь итгэгч хүн Ариун Сүнсээр удирдуулж, Түүний үр жимсийг гаргахын оронд (Галат 5:19-23) “махан биеийн дагуу” явж нүгэл үйлдэхийг илүүд үзэх гэсэн утгатай юм. Энэ бол нүглээ хүлээн зөвшөөрч улайгаагүй (1 Иохан 1:9), чин сэтгэлээр гэмшээгүй амьдрал юм (2 Коринт 12:21).

Хэрэв Судрыг тайлагч өөрөө маан биеийн дагуу үйлддэг, өөрөөр хэлбэл, завхайрал, бузар, тачаангуй байдал, шүтээн шүтэх, идшид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тээр үзэл, атаархал, архидалт, утга учиргүй наргиж цнгэх зэрэгт (Галат 5:19-21) хутгалдсан бол түүний тайлан буруу байх гарцаагүй. Жишээ нь, Библийг зааж байгаа хүн өөрөө бэлгийн ёс бус харилцаанд орсон бол тэрээр энэ сэдэвтэй холбоотой багцлалуудын утгыг гажуудуулах хандлагатай байдаг.

Үнэн нь Ариун Сүнсээр л илчлэгддэг (Иохан 16:13) учраас “маан биеийн дагуу явдаг” хүн Ариун Сүнснээс ангид амьдралын замыг сонгосноор (богино хугацаанд ч гэсэн) үнэний талаар буруу ойлголттой болдог. Учир нь тэр Үгийн “сүнслэг үнэлэмжийг” ойлгох гэж хичээдэггүй.

“Маан биеийн дагуу явдаг” хүн “төрөлх хүн”-ээс бага зэрэг ялгаатай боловч ерөнхийдөө төстэй. “Төрөлх хүн” гэж итгэгч биш хүнийг хэлдэг. **“Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүнд эдгээр нь муунхаг явдал бөгөөд эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг”** (1 Коринт 2:14). “Төрөлх хүн” Сүнснэй холбогдох боломжгүй байдаг бол “маан биеийн дагуу явдаг” хүн Ариун Сүнснэй нөхөрлөх боломжтой хэрнээ нөхөрлөдөггүй итгэгч хүн юм. Тэдний хэн нь ч Бурханы Үгийг зөв ойлгож чадахгүй.

2. Ихэрхүү зан

Ихэрхүү зан гэж нэр алдрын хойноос хөөцөлдөх, бусдын сайшаал магтаалын төвд байхыг хүсэхийг хэлнэ. Ихэрхүү зан нь Бурханы Үгийг буруу тайлбарлахад шууд нөлөөлдөг. Сургаалт үгс 16:18-д **“Сүйрлийн өмнө бардам зан явдаг бол бүдэрч унахын өмнө дээрэлхүү зан явдаг”** хэмээн бидэнд сануулсан байдаг. Судрыг зөв тайлахад энэ зөвлөмжийг санаж байх нь тун хэрэгтэй.

Бид Бурханы Үгийг нарийвчлан судлахын сацуу **“үнэний үгийг зөв заах”** (2 Тимот 2:15) ёстой. Бидний судалгаа Эзэнийг болон бусдыг хайрлах хайраар (Марк 12:29-31) хөтлөгдөх ёстой болохоос өөртөө нэр төр, алдар гавьяаг олж авах зорилгыг агуулах учиргүй. Бидний ойлголтыг тэлэх ямар нэг “шинэ” зүйлийг сурч судлах нь бидний сүнслэг өсөлтөд шаардлагатай байдаг. Гэхдээ, хэрэв бид бусдад сэтгэгдэл төрүүлэхийн тулд шинэ мэдээллийг олж авах зорилгоор Бурханы Үгийг судалж байгаа бол энэ нь дэмий хоосон зүйл юм. Учир нь энэ тохиолдолд бидний хандлага буруу байна.

Судалгааны ямар ч арга биднийг алдаанаас найдвартай хамгаалж чадахгүй гэдгийг бид мартаж болохгүй. Ялангуяа, Бурханы Үгийг ойлгоход Ариун Сүнсний үүрэг оролцоо маш чухал гэдгийг мартах аваас бидэнд ямар ч “арга барил” тус болохгүй.

3. Өөрийн үзэмжээр хандах

Бурханы Үгийг зөв тайлбарлахад саад болдог гурав дахь зүйл бол тухайн багц ишлэлд өөрийн үзэмжээр хандах явдал юм. Өөрийн үзэмжээр хандах гэдэг нь өөрийн хүсэл дээр үндэслэгдсэн буруу итгэл үнэмшил бөгөөд энэ нь “Би ийм байхыг хүсэхгүй байна” гэсэн сөрөг хандлагаар тухайн текстийг гажуудуулдаг. Хэрэв иймэрхүү хандлага хүчтэй байвал Бурханы үгийн тухайн хэсгийг гажуудуулах аюултай юм.

Харамсалтай нь, зарим хүмүүс өөрсдийнхөө буруу итгэл үнэмшлийг Бурханы үгээр зөвтгөх зорилгоор иймэрхүү хандлагыг олонтаа ашигладаг. Тухайлбал, Библид арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг өгүүлсээр атал тэд өөрсдийнхөө энэ итгэл үнэмшлийг батлахын тулд Библийн багцлалуудад өөрсдийнхөө үзэмжээр ханддаг.

Христ уруу баптисм хүртсэн та нар бүгдээрээ Христ уруу бүгдээрээ Христийг өмссөн юм. Иудей ч гэж байхгүй, грек ч гэж байхгүй, боол ч гэж байхгүй, чөлөөт хүн ч гэж байхгүй, эр ч гэж байхгүй, эм ч гэж байхгүй. Хэрэв та нар Христийнх юм бол та нар Абрахамын үр бөгөөд амлалтын дагуу өв залгамжлагчид мөн (Галат 3:27-29).

Хэрэв Бурхан арьсны өнгөөр ялгаварлан гадуурхдаг байсан бол нэг ч харь үндэстэн (еврей бус) аврагдахгүй байх байсан.

4. Тууштай бус байдал

Бид Бурханы Угийг тайлбарлах үедээ хэд хэдэн “СҮНСЛЭГ” дадал зуршлыг өөртөө тууштай төлөвшүүлж чадахгүй бол Библийг тайлахдаа алдаа гаргаж, буруу тайлал хийх боломжтой.

a. Өөртөө байнга дүн шинжилгээ хийж, нүглээ улайхдаа тууштай байх

2 Коринт 13:5-д “Та нар итгэл дотор байгаа эсэхээ шалга, өөрсдийгөө батал!” гэж бидэнд хэлсэн. Бид зөвхөн өөрсдийн үйлдлийг төдийгүй, бас хандлагaa Эзэний өмнө авчирч, Түүний хэмжүүртэй харьцуулах шаардлагатай. Хэрэв алдаа гаргаснаа мэдвэл түүнийгээ Эзэний өмнө хүлээн зөвшөөрч, Түүгээр цэвэрлэгдэх ёстой. 1 Иохан 1:9-д “Хэрэв бид нүглээ хүлээн зөвшиөрвөл Тэрээр итгэмжсит, зөвт бөгөөд бидний нүглийг училж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ” гэж хэлдэг. Хэрэв бид энэ дадлыг өөртөө төлөвшүүлэхгүй бол тун амархан махан биеийнхээ дагуу явж, үүнээсээ болж Бурханы Угийг буруу тайлбарладаг.

б. Залбиралд тууштай байх

Матай 7:7-8 ишлэлд “Гүй тэгвэл та нарт өгнө. Хай тэгвэл та нар олно. Тоги тэгвэл та нарт нээгдэнэ. Гүйдаг хүн бур авна, эрж хайдаг хүн олно, тогишдог хүнд нээгдэнэ” гэж бидэнд хэлсэн. Бурханы Угийг ойлгохын тулд бид тууштай залбирах ёстой. Энэхүү сүнслэг дадлыг тууштай төлөвшүүлж чадахгүй бол Угийг нь тайлж ойлгохыг тэгтлээ их хүсэж буй Бурхантайгаа нөхөрлөх бидний нөхөрлөл тасрахад хүрэх болно.

в. Бурханы Угийг судлахад тууштай байх

2 Тимот 2:15-д “Чи өөрийгөө ичих явдалгүй ажилчин, үнэний угийг зөв заагч гээж Бурханд сайшаалган харуулахыг хичээгтүн” гэж хэлсэн байдаг. Библийг тууштай судлахгүй бол тухайн ишлэлийн хам сэдвийг ойлгохгүй өнгөрөхөд хүрнэ.

5. Буруу арга барил

Тайлалд хэрэглэж буй бидний арга барил тайлал алдаа мадаггүй болоход саад болдог. Тухайн текстийн талаарх бидний итгэл үнэмшил түүний тайлалд нөлөөлдөг. Жишээ нь, Библи бүхэлдээ Бурханы амьсгалснаар бичигдсэн (2 Тимот 3:16-17) гэдэгт хэрэв бид итгэдэггүй бол Есүсийн үйлдсэн гайхамшигуудыг шинжлэх ухааны үүднээс тайлбарлах гэж оролдох байсан. Харин, хэрэв Библи бүхэлдээ үнэн бөгөөд бодит илчлэлт мөн гэж итгэх аваас гайхамшигуудыг түүхэн дэх Бурханы оролцоо гэж тайлах болно.

Бурханы Угийг тайлах авьяас бэлэг цөөн хэдхэн хүмүүст л өгөгдсөн байdag гэж зарим хүн итгэдэг. Харин бүх итгэгч тахилч (1 Петр 2:5, 9) гэж Библи хэлдэг. Бид тахилч учраас Бурханы нигүүлслийн хаан ширээнд (Еврей 4:16) ойртох эрхтэй бөгөөд тэнд Ариун Сүнс Бурхан Өөрөө бидэнд зааж сургадаг (1 Коринт 2:15).

Зарим хүмүүс шууд утгаар нь тайлж ойлгох ёстой багцлалуудыг ёгтлол болон зүйрлэлээр тайлбарлаж, Библийг гажуудуулдаг. Ёгтлол нь текстэд гадны нэмэлт утгыг оруулдаг. Хэрэв бид Ноагийн Уерийг дэлхий нийтийг хамарсан гамшиг (үер) гэж шууд утгаар нь ойлгохын оронд хүн төрөлхтний давж гарах ёстой зовлонг дүрслэн харуулсан зүйрлэл гэж үзэх юм бол энэ нь ёгтлолын тайлбар болно.

Үлгэр домогт бага зэргийн үнэн агуулагддаг боловч, ихэнхдээ үйл явдлыг их хэмжээний хэтрүүлэгтэйгээр дүрслэн илэрхийлдэг. Хэрэв бид Ноагийн Уерийг орон нутгийн бага хэмжээний үер байсныг дэлхий нийтийг хамарсан гамшиг байсан мэтээр нутгийн оршин суугчид хожим хэт дөвийлгөн ярьсан хэмээн тайлбарлавал энэ нь үлгэр домгийн тайлал болно. Өөрөөр хэлбэл, худал хуурмагийн далайгаар хүрээлүүлсэн бага хэмжээний үнэнийг үлгэр домгийн тайлал гэнэ гэж хэлж болно.

Тэр ч байтугай зарим хүмүүс ёгтлолын болон үлгэр домгийн тайллыг Есүс Христ болон Түүний загалмай, дахин амилалтын талаарх багцлалуудыг тайлахад ашиглаж байгаа нь хэрхэвч зөвшөөрч болохгүй юм. Хэрэв ийм тайллууд үнэн байсан бол Есүс Христ бидний гэм нүглийн төлөө нас

бараагүй, биднийг аврахын тулд булшлагдаагүй, мөн дахин амилаагүй байх байсан. Хэрвээ эдгээр үйл явдал үнэхээр тохиолдоогүй бол элч Паулын хэлсэнчлэн бид тун хэцүү асуудал дунд байх байсан (1 Коринт 15).

Түүнчлэн, зүйрлэл болон үг хэллэгийн онцлогийг хайхралгүй, зөвхөн шууд утгаар нь тайлах арга ашиглах нь тайлалд мөн саад болдог. Жишээ нь, Соломоны дуун хэмээх гайхалтай номыг шууд утгаар нь үгчлэн тайлбал уг ном бүхэлдээ ямар ч утгагүй болно. Тиймээс, хэрэглэгдсэн үг хэллэгийн онцлог болон зүйрлэлийг шууд утгаар тайлах аргатай хослуулах нь энэ номыг тайлах хамгийн зөв арга болно. Энэ талаар бид энэ номын өөр бүлэгт нарийвчлан үзэх болно.

6. Буруу ойлголт

Бурханыг хүний оюун ухаан бүрэн гүйцэд ойлгож чадахгүй. Хэрэв бид өөрсдийн чадвараар Бурханыг бүрэн ойлгож чадна гэвэл үнэндээ өөрсдөөрөө бардамнаан ихэрхэж буй хэрэг болно. Сургаалт үгс 3:5-7 ишлэлд “*Бүх зурхээрээ Эзэнд итгэ. Өөрийн ойлголтод бүү түшиглэ. Өөрийн бүх замаараа Түүнийг таныж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно. Өөрийнхөө нүдний өмнө бүү мэргэн бай. Эзэнээс эмээж хорон муугаас эргэ*” гэж бидэнд хэлсэн. Өөрийн ойлголтоор бус, харин итгэлээр алхахыг Бурхан биднээс хүсдэг.

Өөрийн Бурхан Эзэнийг бүрэн гүйцэд ойлгох өдөр ирнэ гэж Библид хэлсэн байдаг. 1 Коринт 13:12-д “*Учир нь бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, харин дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ харин дараа нь би бүрэн мэдэх болно*” гэж Паул бичсэн. Судартай холбоотой өнөөдөр бидэнд хариулт нь тодорхойгүй байгаа асуултуудын хариут бид Эзэнтэй нүүр нүүрээрээ уулзах тэр өдөр (2 Коринт 3:18) авах болно.

I зууны үеийн иудейчүүд дан ганц өөрсдийнхөө оюун ухааны чадвар, ойлголтод найдсан учраас Есүс Христ бол Мессия гэдгийг танилгүй, харамсалтай алдаа гаргасан. Матай 22:41-46 ишлэлд Есүс болон фарисайчуудын хооронд болсон ярилцлагыг авч үзье:

Фарисайчуудыг цуглах зуур Есүс тэднээс - Та нар Христийн тухай юу гэж боддог вэ? гэж асуухад тэд – Давидынх гэцгээв. Тэр тэдэнд – Тэгвэл яагаад Давид Сүнсээр Түүнийг “Эзэн” гэж дуудаад, “Эзэн, миний Эзэнд “Би Чиний дайснуудыг хөл дор чинь тавих хүртэл Миний баруун гарын залрагтун” гэсэн. Хэрэв Давид Түүнийг “Эзэн” хэмээн дууддаг бол Тэр яаж түүний хүү байх билээ? гэж айлдав. Хэн ч хариуд нь Түүнд үг хэлж чадаагүй бөгөөд тэр өдрөөс хойши нэг ч хүн Түүнээс юм асуухыг зурхэлсэнгүй.

Есүс Дуулал 110:1-ээс иш татаад, Мессия яаж нэгэн зэрэг Давидын “хүү” болон Давидын “Эзэн байх вэ? гэж асуусан. Зөв хариулт нь: Мессия бол Бурхан ч мөн, бас хүн ч мөн. Тэгвэл ийм хариулт хүний ойлголттой зөрчилддэг.

Хувийн Судлал: 4-р бүлэг, 4В хэсэг

- 1 Коринт 3:3-ыг унш. “Махан биеийн дагуу явах” буюу “махан бие” гэдгээр Паул ямар хоёр зүйлийг илтгэн харуулсан бэ?
- Галат 5:19-21 ишлэлийг унш. Атаа жөтөө болон маргаан гэж юуг хэлэх вэ?
- Атаа жөтөө болон маргаанд орсон хүн тайллыг хэрхэн өөрчлөх гэж оролдох болох вэ?
- Сургаалт үгс 3:5-6; 1 Коринт 8:1-ийг унш. Бид юунд найдах ёсгүй вэ? Яагаад?
- Бид өөрсдийн сурх арга барил, дадал зуршлаар бардамнааснаар бид махан биедээ захирагдаж, бидний тайлал үнэнээс гажих боломжтой юу?

6. Бид Библийг өөрсдийн хүслээр тайлбарлах гэж оролдож болох уу? Яагаад?
7. Бурханы Үгийг судлахад хамгийн чухал зүйл юу вэ?
8. 2 Коринт 13:5; 1 Иохан 1:9-ийг унш. Библии судлахад ямар хоёр зүйл чухал вэ?
9. Матай 7:7-8; Иаков 1:5-ыг унш. Библийг судлахдаа бид юуг эрэлхийлэх ёстой вэ?
10. Библийг судлах явцдаа бид яагаад тууштай байх ёстой вэ?
11. 2 Тимот 3:16-17 ишлэлийг унш. Зөв тайллыг хайж эхлэхээсээ өмнө бид Библийн талаар юу ямар итгэл үнэмшилтэй болох ёстой вэ?
12. Исаиа 55:8-9 ишлэлийг унш. Бид хүмүүний ойлголтыг Бурхантай холбоыг хичээх үедээ бид юуг санах ёстой вэ?
13. Иаков 3:14-ийг унш. Хэрэгжүүлэлтэд саад болдог ямар гурван зүйл байдаг вэ?

Г. Буруу хэрэгжүүлэлтэд хүргэдэг найман зүйл

Энэ найман зүйлийг өнгөц харахад тун энгийн мэт санагддаг ч Бурханы Үгийг судалж буй хүн эдгээрт тун нухацтай хандах ёстой. Учир нь эдгээр нь дотроо өөр өөр төвшинтэй байдаг. Жишээ болгон Сургаалт үгс 3:5-6 ишлэлийг авч үзье: “*Бүх зүрхээрээ Эзэнд итгэ. Өөрийн ойлголтод бүг тусиглэ. Өөрийн бүх замаараа Түүнийг танъяж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно.*”

1. Хэрэгжүүлэлтийг амжилттай хийх хүчийг хүлээн авахын төлөө Эзэнд найдахыг хүсэхгүй байх.
2. Бурханы үнэнтэй зөрчилдсөн хандлага, үйлсээ өөрчлөхөөс татгалзах.
3. Зөв зарчмууд гэж мэдсээр байж дагахгүй байх.
4. Дэлхийн жишигт амархан нийцэх.
5. Бурханы Үгийг өөрийнхөө амьдралд хэрэгжүүлэх хүсэл сонирхолгүй байх.
6. Нүгэлд хэт хуульчирхсан байдлаар хандах, эсвэл түүнийг байдаг гэдгийг үгүйсгэх.
7. Мэргэн ухааныг сэтгэл хөдлөлөөр орлуулах.
8. Өөрийн үзэл баримтлал, итгэл үнэмшил болон залхуу байдлаасаа болж үнэнийг гажуудуулж, буруу ойлголтой болох.

Тавдугаар Бүлэг

**Бурханы Бодгалийн
Талаарх
Үзэл Баримтлал**

1-р ХЭСЭГ

Гурвал

A. Гурвалын тодорхойлолт

Өөрийгөө Эцэг (Иохан 6:27), Хүү (Иохан 1:1), Ариун Сүнс (Үйлс 5:3-4) гэж илэрхийлдэг цорын ганц үнэн Бурхан байдаг (Дэд хууль 4:35; 6:4; 1 Коринт 8:4-6; Ефес 4:3-6; Иаков 2:19) гэдгийг бид маш тодорхой хэлж чадна. Түүний мөн чанарын талаарх нарийн ширийн зүйлийг бид бүрэн ойлгож чадахгүй.

Бурхан бол бидний бүхий л ойлголтоос хол давуу учраас, мөн шулуухан хэлэхэд Тэр бол Бурхан учраас Гурвалын тухай бүрэн төгс тодорхойлолт гаргаж ирнэ гэдэг хэцүү (Ром 11:33). Түүнд таалагдахын тулд бидний христитгэлийн алхаа нь итгэлийн алхаа байх учиртай (Еврей 11:6). Хэрэв Бурханы тухай, диваажингийн талаар мэдэж ойлгож болох ямар нэг эх сурвалж бидэнд байсан бол бид харж буй зүйлээрээ алхах байсан. Нэг л өдөр бид Бурханыхаа тухай бүрэн гүйцэд мэдэх болно (1 Коринт 13:12), гэвч одоогоор бид бүрэн ойлгож чадахгүй зүйлсээ итгэлээрээ хүлээн авах ёстай. Гурвалын тухай нэгэн дүрслэлийг өндөгнөөс харж болно. Өндөг нь хальс, өндөгний шар болон цагаан гэсэн гурван тусдаа хэсэгтэй боловч бүхэлдээ нэг л зүйл юм.

Гурвалын гишүүд нь гурван үүрэг рольтой гэдгийг бид тодорхой хэлж чадна. Эцэг бол Төлөвлөгч (Үйлс 2:23), Хүү бол Гүйцэтгэгч буюу төлөвлөгөөг биелүүлэгч Нэгэн (Иохан 5:36), харин Ариун Сүнс бол Илчлэгч юм (Иохан 16:13). Хэдийгээр бид тэдний ялгаатай үүрэг ролийн талаар судалж болох ч Гурвалыг хувааж үзэх гэж оролдох ёсгүй. Эцэг, Хүү, Ариун Сүнс нь бүгд зөвхөн Бурханд л байж болох онцлог шинж чанартай.

Гэхдээ энэ нь бидний хувьд асуудал болох ёсгүй. Хэдийгээр бид суудлын автомашины дотоод ажиллагааг ойлгохгүй байж болох ч хөдөлгүүрийг нь асаагаад, зорьсон газартаа хүрч, үр дүнг нь харж чаддаг. Үүний адилаар бид Бурханы бүтээсэн зүйлсээр Түүний мөн чанарын үр дүнг харж болно (Ром 1:20).

B. Баталгаа

Эцэг, Хүү, Ариун Сүнсийг аль алийг нь “Бурхан” гэж нэрлэж байгаа нь Гурвалын баталгаа болж өгдөг бөгөөд үүнийг өмнөх хэсэгт өгүүлсэн. Хэрэв Эцэг, Хүү, Ариун Сүнс нь зөвхөн Бурханд байдаг шинж чанаруудтай, зөвхөн Бурханы хийж чадах ажлуудыг хийдэг юм бол энэ “Гурав” нь үнэндээ “Нэг” Бурхан гэдэг нь тодорхой болж байна.

4-р бүлгийн “Бурханы төгс мөн чанар дээр үндэслэн тайлбарлах” гэсэн нэгдүгээр хэсэгт Бурханы төгс мөн чанарыг танилцуулсан. Харин одоо бид Бурханы шинж чанаруудыг илүү өргөн хүрээнд тайлбарлаж, шинж чанар тус бүрийг Гурвалын гишүүдтэй холбож үзэх болно.

Энэ бол судалгааны нэгэн чухал хэсэг юм. Эдгээр ишлэл нь бүхий л Библийн теологийн үндсэн хоёр суурийг тавьдаг бөгөөд Үгийг судалж буюу оюутны хувьд үүнийг мартах ёсгүй. Эхний суурь бол “Ганц, цорын ганц Бурхан байдаг”, хоёр дахь нь “би бол Тэр биш.”

B. Бурханы төгс мөн чанарын арван чанар

Эхний хаалт () нь Бурхан Эцэгтэй холбоотой ишлэлүүдийг, хоёр дахь хашилт < > нь Хүүтэй холбоотой, гурав дахь хашилт [] нь Ариун Сүнстэй холбоотой ишлэлүүдийг тус тус харуулах болно.

1. Хамгийн дээд эрх мэдэл

Бурхан бол ХАМГИЙН ДЭЭД ЭРХ МЭДЭЛТЭЙ, энэ нь Тэр бол Хаан бөгөөд Хааны ажлыг хийдэг гэсэн утгатай. (Даниел 4:17; 1 Тимот 1:17; Дуулал 47:2, 7), <Илчлэлт 19:16; Иохан 5:21>, [Зехария 4:6; 1 Петр 4:14; 1 Коринт 12:11].

Дээд эрх мэдэл гэдэг нь “тодорхой хүрээн дотор хамгийн дээд эрх мэдлээр ажиллах” гэсэн утгатай. Бурхан гаднын аливаа хараа хяналтаас ангид чөлөөтэй байдаг бөгөөд бүх бүтээлээс дээгүүрх хамгийн дээд эрх мэдэлтэй. Тэр бол Бүтээгч болохоос бүтээгдсэн нэгэн биш юм. (Ром 1:20, 25).

Бурхан Өөрийн төлөвлөгөө, Өөрийн хуулиуд, Өөрийн шүүлтуудийг тогтоох эрх мэдэлтэй. Товчоор хэлбэл, хэдийгээр Түүний зорилгуудыг ойлгоход хүнд байж болох ч Тэр хийхээр сонгосон зүйлээ хийх эрх мэдэлтэй.

2. Зөвт байдал

Бурхан бол туйлын ЗӨВТ, энэ нь Тэр бүх талаараа төгс гэсэн утгатай. (Иохан 17:25; 1 Иохан 1:5), <1 Иохан 2:1; Лук 1:35; Еврей 7:26>, [Исаиа 32:15-18; Дуулал 143:10; Нехемиа 9:20]. Тэр бол бүх зүйл дээрх зөвт байдлын хэм хэмжээ юм. Тэрээр ёс суртахууны хувьд бүрэн төгс бөгөөд бидний дагах дуурайх хэм хэмжээ билээ (Ефес 5:1).

3. Шударга ёс

Бурхан бол ШУДАРГА. Тэр бүрэн төгс шударга. (Исаиа 45:21; Иов 37:23), <Иохан 5:22, 30; Илчлэлт 19:11>, [Исаиа 4:4; 28:6]. Бурханы шударга ёс нь Түүний зөвт байдлын шаардлагуудаас урган гардаг. Бурханд хүмүүсийг “ялгаварлах үзэл” байдаггүй (Ром 2:11), Тэр нүүр тал хардаггүй. Гэм нүгэл (Түүний хуультай зөрчилдэж буй зүйл) хаана байна (Ром 5:13), Түүний шударга ёс ажиллаж байх ёстай.

Хүн Бурханы зөвт байдлыг хангаж чадахгүй, тиймээс хүнд Бурханы шударга ёстой “эвлэрүүлж” (тайвшруулж) чадах Мессия хэрэгтэй. Эзэн Есүс Христ бүх дэлхийн гэм нүглийг төлж, нас бараахдаа загалмай дээр энэхүү “эвлэрүүлэл”-ийг гүйцэлдүүлсэн билээ (1 Иохан 2:1-2).

4. Хайр

Бурхан бол ХАЙР, энэ нь Тэр төгс, болзолгүй хайраар хайрладаг гэсэн утгатай. (1 Иохан 4:8-10; Тит 3:4; Иохан 17:24-26), <Иохан 15:9>, [Галат 5:22].

Бурханы энэ шинж чанар хүн төрөлхтнийг зольж авахаар Есүс Христийг илгээнээс үүдэлтэй (Иохан 3:16). Бидний гэм нүглийн төлөөсийг төлөхөд Эзэнийг загалмай дээр тогтоож байсан тэр зүйл бол хайр юм <Лук 23:34>; мөн Ариун Сүнсний “үр жимсний” эхнийх нь хайр байдаг [Галат 5:22].

Хайр гэдэг бусдын төлөө юу нь сайн, зөв болохыг үйлдэх, өөрт нь таагүй санагдаж байсан ч үүнийг хийх гэсэн утгатай. Христитгэгчид Бурханы хайрыг хуваалцагч, бусдад түгээгч нар бөгөөд ингэснээрээ бусад хүмүүсийг Бурхан дээр ирэх, Түүнийг таньж мэдэхэд тусалдаг (Иохан 13:34-35).

5. Мөнх амь

Бурхан бол МӨНХ АМЬ. Тэр үргэлж байсан, бас үргэлж байх болно. (Исаиа 57:15), <Иохан 8:54; 1 Иохан 5:11-12; Мика 5:2; Илчлэлт 1:8,17>, [Еврей 9:14].

Мөнх амь нь эхлэл, төгсгөлгүй. Христитгэгчид бид үнэхээр үүрд мөнхийн амьтай бөгөөд энэ нь эхэлсэн цэгтэй харин төгсгөлгүй юм. Бурханы мөнх амь нь Тэр үхэлд огт захирагддаггүй гэдгийг харуулдаг.

6. Омнипотент - Бүхнийг чадагч

Бурхан бол ОМНИПОТЕНТ, энэ нь Тэр бол бүхнийг үйлдэх хүчтэй гэсэн үг юм. (Марк 14:36; 1 Петр 1:5), <Матай 28:18; Илчлэлт 19:6>, [2 Тимот 1:7; Ром 15:13].

Түүний бүхнийг чадагч чанарын нэгэн жишээг тэнгэр газрыг бүтээлээс харж болно (Эхлэл 1:1). “Эзэний үг”-ээр тэнгэрүүдийг бүтээж, Түүний “амных нь амьсгал”-аар бүх эрхэс бүтээгдсэн (Дуулал 33:6).

7. Омнипресент - Хaa сайгүй оршигч

Бурхан бол ОМНИПРЕСЕНТ, энэ нь Тэр нэг цагт ижил хүчээр хaa сайгүй байгч гэсэн утгатай. (Сургаалт үгс 15:3; Шастирын дэд 2:6), <Матай 18:20; 28:20>, [Дуулал 139:7-16]. Гэхдээ энэ нь Бурхан бол бүх юм (Пантизм буюу дэлхийн бүх юм Бурханы тусгал гэж үзэх үзэл) гэсэн үг биш, харин Тэр бол хaa сайгүй байгч. Энэ нь зөвхөн Бурханд л байдаг Түүний хувийн мөн чанарыг бидэнд харуулж байна.

Бид бас энэ шинж чанараас Бурхан хол ойроос шалтгаалан хүч нь өөр өөр үйлчилдэггүй гэдгийг харж болно (Дуулал 139:7-17). Тэр зарим хүмүүсийг илүү анхаарч, заримд нь бага анхаарал тавьдаг юм бишээ. Мөн Тэр бол Хaa сайгүй оршигч гэдэг нь нэг ижил цагт нэгээс илүү газарт Өөрийгөө илэрхийлж чаддаг гэсэн утгатай.

8. Омнисиент - Бүхнийг мэдэгч

Бурхан бол ОМНИСИЕНТ. Тэр өнгөрсөн, одоо, ирээдүйн бүх юмыг мэддэг. (Дуулал 139:1-6; Еврей 4:13), <Иохан 2:24, 25; 18:4; Матай 9:4>, [1 Коринт 2:10-11; Исаиа 11:2].

Тэр бүх зүйлийн үр дагаврыг мэддэг, зөвхөн бодит байдлыг биш, бас байж болох бүх боломжийг мэдэж байдаг. Тэр бүхий л цаг үеийн турш шийдвэр бүрээс гарах бүх үр дагаврыг мэддэг. Түүний мөнхийн төлөвлөгөө нь энэ бүх хүчин зүйлсийг тооцож үзсэн байдаг (Ром 8:28-30).

9. Хувиршгүй - Өөрчлөгдөшгүй

Бурхан бол ХУВИРШГҮЙ, энэ нь Түүний төгс мөн чанарууд хэзээ ч өөрчлөгдөхгүй гэсэн утгатай. (Иаков 1:17; Еврей 6:17; Малахи 3:6), <Еврей 13:8>, [1 Коринт 12:4; Ефес 1:13].

Бурхан амласан зүйлээ үргэлж үйлдэх ёстой болдог тул энэ шинж чанар нь хүн төрөлхтний хувьд маш ашиг тустай чанар юм. Тэрээр нэгэнт “*Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй*” (Ром 8:1) гэж айлдсан, тиймээс Түүнийг бодлоо өөрчлөхгүй гэдэгт бид бүрэн итгэж болно. Тэр Есүс Христэд итгэсэн хүн бүхэнд мөнх амийг амласан, тиймээс Тэр энэхүү Сайн мэдээндээ засвар оруулахгүй гэдгийг бид мэддэг (Иохан 3:16). Хэрвээ Бурхан амлалтуудаа өөрчилбөл худалч болох бөгөөд энэ нь зөвт бус хэрэг юм (Еврей 6:17-18).

Ертөнц дээрх бусад бүх зүйлс өөрчлөгддөг. Зөвхөн Бурхан л хувиршгүй юм. Тиймээс Түүнд итгэж найдах нь бидний сэтгэлийн “занггуу” болж чаддаг (Еврей 6:19).

10. Үнэн

Бурхан бол туйлын ҮНЭН. (Дэд хууль 32:4; Иохан 7:28; 17:3), <Иохан 14:6; 1 Иохан 5:20>, [1 Иохан 5:7, 8; 4:6; Иохан 14:17; 15:26; 16:13].

Энэ шинж чанар нь Бурханы хэлсэн бүх зүйлд бүрэн итгэж болно гэдгийг бидэнд харуулж байна (Тооллого 23:19). Үнэндээ хуурч мэхлэх гэдэг нь Бурханы хувьд байж боломгүй зүйл юм (Тит 1:2).

Жинхэнэ үнэн гэдэг нь Бурхан Өөрийгөө Есүс Христийн бодгаль дотор илэрхийлсэн явдал юм <Иохан 14:6>. Түүхийн туршид үнэнийг ямар нэг зарчим, ойлголт, тунхаг дотор хайсаар иржээ. Тийм ч учраас хүн төрөлхтөн үнэн гэж үзэж буй зүйлээ Есүс Христийн үгтэй харьцуулах ёстой <1 Тимот 6:3>.

Хувийн Судлалд: 5-р бүлэг, 1-р хэсэг

1. Эхлээд Дэд хууль 6:4-5-ыг унш. Тэгээд Иохан 6:27, Иохан 1:1, Үйлс 5:3-4-ийг уншина уу. Энд үнэн Бурхан хэд гарч байна вэ?
2. Дээрх багцлалуудаас харвал Бурхан гэж хэн бэ?

3. **Үйлс 2:23-ыг унш. Бурханы гол үүрэг юу вэ?**
4. **Иохан 5:36-г унш. Хүүгийн гол үүрэг юу вэ?**
5. **Иохан 16:13-14-ийг унш. Ариун Сүнсний гол үүрэг юу вэ?**
6. **Эцэг, Хүү, Ариун Сүнс нь бүгд Бурхан гэдгийг бид яаж батлах вэ?**
7. **Дараах багцлалуудаас Бурханы хамгийн дээд эрх мэдлийн талаар уншина уу.**
 - A. Эцэг-Даниел 4:17; 1 Тимот 1:17 ба Дуулал 47:2, 7
 - B. Хүү- Илчлэлт 19:16 ба Иохан 5:21
 - C. Ариун Сүнс-Зехария 4:6; 1 Петр 4:14 ба 1 Коринт 12:11

Гурвалд хамгийн дээд эрх мэдэл бий юу?

8. **Дараах багцлалуудаас Бурханы зөвт байдлын талаар уншина уу.**
 - A. Эцэг- Иохан 17:25 ба 1 Иохан 1:5
 - B. Хүү- Иохан 2:1; Лук 1:35 ба Ерей 7:26
 - C. Ариун Сүнс- Исаиа 32:15-18; Дуулал 143:10 ба Нехемиа 9:20

Гурвал туйлын зөвт үү?

9. **Дараах багцлалуудаас Бурханы шударга байдлын талаар уншина уу.**
 - A. Эцэг- Исаиа 45:21 ба Иов 37:23
 - B. Хүү- Иохан 5:22, 30 ба Илчлэлт 19:11
 - C. Ариун Сүнс- Исаиа 4:4 ба 28:6

Гурвал шударга уу?

10. **Дараах багцлалуудаас Бурханы хайрын талаар уншина уу.**
 - A. Эцэг- 1 Иохан 4:8-10; Тит 3:4 ба Иохан 17:24-26
 - B. Хүү- Иохан 15:9
 - C. Ариун Сүнс- Галат 5:22

Гурвалд төгс хайр бий юу?

11. **Дараах багцлалуудаас Бурханы мөнх амийн талаар уншина уу.**
 - A. Эцэг- Исаиа 57:15
 - B. Хүү- Иохан 8:54; 1 Иохан 5:11–12; Мика 5:2 ба Илчлэлт 1:8, 17
 - C. Ариун Сүнс- Ерей 9:14

Гурвал мөнх амьтай юу?

12. **Дараах багцлалуудаас Бурханы омнипотент (бүхнийг чадагч) чанарын талаар уншина уу.**
 - A. Эцэг- Марк 14:36 ба 1 Петр 1:5
 - B. Хүү- Матай 28:18 ба Илчлэлт 19:6
 - C. Ариун Сүнс- 2 Тимот 1:7 ба Ром 15:13

Гурвал омнипотент (бүхнийг чадагч) мөн үү?

- 13. Дараах багцлалуудаас Бурханы омнипресент (хаа сайгүй оршигч) чанарын талаар уншина уу.**
- А. Эцэг- Сургаалт үгс 15:3 ба Шастирын дэд 2:6
 - Б. Хүү- Матай 18:20 ба 28:20
 - В. Ариун Сүнс- Дуулал 139:7-16

Гурвал омнипресент (хаа сайгүй оршигч) мөн үү?

- 14. Дараах багцлалуудаас Бурханы омнисиент (бүхнийг мэдэгч) чанарын талаар уншина уу.**
- А. Эцэг- Дуулал 139:1-6 ба Еврей 4:13
 - Б. Хүү- Иохан 2:24-25; 18:4 ба Матай 9:4
 - В. Ариун Сүнс- 1 Коринт 2:10-11 ба Исаиа 11:2

Гурвал омнисиент (бүхнийг мэдэгч) мөн үү?

- 15. Дараах багцлалуудаас Бурханы өөрчлөгдөшгүй байдлын талаар уншина уу.**
- А. Эцэг- Иаков 1:17; Еврей 6:17 ба Малахи 3:6
 - Б. Хүү- Еврей 13:8
 - В. Ариун Сүнс- 1 Коринт 12:4 ба Ефес 1:13

Гурвал өөрчлөгдөшгүй чанартай юу?

- 16. Дараах багцлалуудаас Бурхан бол Үнэн гэдгийг уншина уу.**
- А. Эцэг- Дэд хууль 32:4; Иохан 7:28 ба 17:3
 - Б. Хүү- Иохан 14:6 ба 1 Иохан 5:20
 - В. Ариун Сүнс- 1 Иохан 5:7-8; 4:6; Иохан 4:17; 15:26 ба 16:13

Гурвал Үнэн үү?

2-р хэсэг

Бурханы Нэрс

Энэ хэсэгт Бичээст гардаг Бурханы нэрсийг судлах болно. Грек болон еврей хэл дээр Бурханыг хэд хэдэн өөр нэр томьёогоор нэрлэсэн байдаг бөгөөд эдгээр нь Түүний бодгаль, эсвэл зан чанарын ялгаатай талуудыг онцлон илэрхийлэхэд хэрэглэгддэг.

Зарим орчуулгад еврей эсвэл грек үгийг дуудлагад нь тулгуурлан, шинэ хэлэнд утгыг нь гаргахгүйгээр шууд буулгасан (үүнийг галиглах гэж нэрлэдэг) байдаг. Харин энд оюутнуудад зориулан еврей, грек хэл дээрх нэр болон орчуулгыг хоёуланг нь өгч байна.

A. Еврей нэр

1. Бурхан

“Бурхан” гэж орчуулагддаг еврей үг нь ЕЛОХИМ юм. Энэ нэр нь Эхлэл 1:1-д анх гардаг бөгөөд үүнээс хойш Хуучин гэрээнд 2500 гаруй удаа дурдагддаг. Энэ үгийн утганд Бурханы бүхий л төгс мөн чанар багтдаг бөгөөд тийнхүү Түүний бүхий л онцлог шинж чанарыг нэг зэрэг илэрхийлдэг. Энэ нэр нь ихэнх тохиолдолд Эцэгийн тухай ярихад хэрэглэгддэг, гэхдээ Гурвал бол Бурхан учраас энэ нэр Хүү болон Ариун Сүнсийг хэлэхэд бас хэрэглэгдэж байгааг харж болно.

ЕЛОХИМ гэдэг үг олон тоон дээрх (нэгээс илүү гэсэн утгатай) үг бөгөөд эрдэмтэд үүнийг “эрхэм дээдсийн олон тоо” гэж тайлбарладаг. Энэ нь Түүний хязгааргүй агуу байдлыг илэрхийлдэг. Хэдийгээр энэ үг нь олон тоон дээр байдаг боловч үйл үг нь үргэлж ганц тоон дээр байдаг, энэ нь ганц Бурхан байдаг гэдгийг дахин харуулж байна (Дэд хууль 6:5).

ЕЛОХИМ гэдэг үг нь ихэнхдээ Бурханы тухай нэмэлт мэдээлэл өгдөг өөр үгтэй холбогдож, Түүний өөр нэг нэрийг бий болгодог.

a. Төгс хүчит Бурхан

ЕЛ ШАДДАЙ гэдэг нэрийг голдуу “Төгс хүчит Бурхан” гэж орчуулдаг. “ЕЛ” гэдэг нь ЕЛОХИМ-ийн богиносгосон хэлбэр. Үүнийг Бурхан Θεοιν ард түмний дээр ивээл ерөөлөө үзүүлэх үед ихэвчлэн хэрэглэдэг байсан. Энэ нэр дараах ишлэлд гардаг: Эхлэл 17:1; 28:3; 35:11; 43:14; 48:3; 49:25; Египетээс гарсан нь 6:3; Тооллого 24:4, 16; Рут 1:20, 21; Иов 5:17; 6:4, 14; 8:3, 5; 11:7; 13:3; 15:25; 21:15, 20; 22:3, 17, 23, 25, 26; 23:16; 24:1; 27:2, 10, 11, 13; 29:5; 31:2, 35; 32:8; 33:4; 34:10, 12; 35:13; 37:23; 40:2; Дуулал 68:14; 91:1; Исаиа 13:6; Езекиел 1:24; 10:5; Иоел 1:15.

6. Хамгийн дээд Бурхан

ЕЛ ЕЛИОН гэдгийг голдуу “Хамгийн дээд Бурхан” гэж орчуулдаг бөгөөд Түүнийг бүхий л зүйл дээр хамгийн дээд эрх мэдэлтэй гэдгийг харуулдаг. Энэ нэр дараах ишлэлд гардаг: Эхлэл 14:18, 19, 20, 22; 40:17; Тооллого 24:16; Дэд хууль 26:19; 28:1; 32:8; Иошуа 16:5; 2 Самуел 22:14; Хаадын дээд 9:8; Хаадын дэд 15:35; 18:17; Шастирын дээд 7:24; Шастирын дэд 7:21; 8:5; 23:20; 27:3; 32:30; Нехемиа 3:25; Дуулал 7:17; 9:2; 18:13; 21:7; 46:4; 47:2; 50:14; 57:2; 73:11; 77:10; 78:17, 35, 56; 82:6; 83:18; 87:5; 89:27; 91:1, 9; 92:1; 97:9; 107:11; Исаиа 7:3; 14:14; 36:2; Иеремиа 20:2; 36:10; Иеремиагийн гашуудал 3:35, 38; Езекиел 9:2; 41:7; 42:5.

b. Мөнхийн Бурхан

ЕЛ ОЛАМ гэдгийг голдуу “Мөнхийн/мөнхөд оршигч Бурхан” гэж орчуулдаг. ОЛАМ гэдэг еврей үг нь үүрдийн (төгсгөл байхгүй) гэхээс илүү мөнхийн (эхлэл буюу төгсгөл байхгүй) гэсэн утгатай. Энэ нэрийг Эхлэл 21:33 болон Исаиа 40:28-аас харж болно. “Мөнх” (ОЛАМ) гэсэн үг гарч байгаа хэсэгт олонх тохиолдолд Бурханы мөнх чанарыг илэрхийлж байдаг.

2. Эзэн

ЯАВЭ-г гол төлөв “ЭЗЭН” гэж орчуулдаг бөгөөд “Эзэн” эсвэл “эзэн” гэж орчуулагддаг бусад үгээс ялгахын тулд бүх үсгийг нь томоор бичдэг бололтой. ЯАВЭ нь бас Түүний бодгаль, үүрэг ролийг дүрслэн илэрхийлсэн бусад нэр томьёотой хамт хэрэглэгддэг.

“ЭЗЭН” гэдэг Бурханы нэр голдуу ЯАВЭ гэдэг еврей үгийн орчуулга байдаг. ЯАВЭ бол Бурханы Өөрийнх нэр (Египетээс гарсан нь 3:14) бөгөөд Хуучин гэрээнд 5300 гаруй удаа хэрэглэсэн байдаг. Энэ нь Түүний ухамсарт, идэвхтэй оршихуйг илэрхийлдэг. Хамгийн анх Эхлэл 2:4-д гардаг бөгөөд энэ нэрийг ЕЛОХИМ-тэй хамт хэрэглэсэн байдаг. Үүнийг ЭЗЭН БУРХАН гэж орчуулсан.

Вавилоны цөллөгийн дараа (МЭӨ 586-516) Израильд Бурханы энэ нэрийг туйлын ариун нандин гэж үзэх болсон тул тэд Түүний энэ нэрийг хэлэхийн оронд АДОНАИ гэж дуудах болжээ. Манай эриний зургаа болон додтугаар зууны үед ЯХВХ гэдэг гийгүүлэгчүүд дээр АДОНАИ-гийн эгшгүүдийг нийлж, “Яахова” гэдэг үгийг үүсгэсэн бөгөөд энэ нь ЯХВХ гэдэг нэрийг АДОНАИ гэж дуудахыг уншигчдад сануулахын тулд байжээ.

a. Эзэн хангана

ЯАВЭ ИРЭ гэдэг нэрийг “Эзэн хангана” гэж орчуулдаг. Энэ нэрийг Эхлэл 22:14-өөс харж болох ба энд Эзэн Абрахамд хүү Исаакийнх нь оронд тахил болгох эр хонь өгсөн тэр үеийг өгүүлдэг.

б. Эзэн бол миний туг далбаа

ЯАВЭ НИССИ гэдэг нэрийг “Эзэн бол миний туг далбаа” гэж орчуулдаг. Энэ нэрийг Египетээс гарсан нь 17:15-аас харж болох ба амалекчуудын ялагдлын дараа Мосегийн Эзэнд өгсөн нэр юм.

в. Эзэн бол амар тайван

ЯАВЭ ШАЛОМ гэдэг нэрийг “Эзэн бол амар тайван” гэж орчуулдаг. Шүүгчид 6:24-д энэ нэрийг хэрэглэсэн байдаг.

г. Түмэн цэргийн Эзэн

ЯАВЭ САББАОТ гэдэг нэрийг “түмэн цэргийн Эзэн” гэж орчуулдаг. Энэ нь цэргийн нэр томьёо бөгөөд Эзэн Израилийн болон тэнгэр элч нарын армийн захирагч гэсэн утгатай. 1 Самуел 1:3-д анх дурдагсанаас хойш зуугаас илүү удаа энэ нэрийг хэрэглэсэн байдаг.

3. Эзэн, Мастер, Эзэмшигч

АДОНАИ нь бас ЕЛОХИМ-тай адил олон тоон дээрх үг бөгөөд Бурханы сүр жавхланг илтгэдэг. Гэхдээ ЕЛОХИМ-аас ялгаатай нь АДОН гэсэн ганц тоон дээрх үг бас байдаг. АДОН гэдэг нь мастер буюу эзэмшигч гэсэн утга бүхий “эзэн” гэсэн үг юм. Үүнийг эрх мэдлийг илэрхийлэхэд хэрэглэдэг. Анх Эхлэл 18:3-д Абрахам Эзэнд хандаж үг хэлэхдээ энэ нэрийг хэрэглэсэн байдаг.

Үүнтэй адилхан грек үг нь КУРИОС.

Б. Грек нэрс

1. Бурхан

“Бурхан” гэдэг грек үг нь ТЕОС юм. Энэ нэр нь ЕЛОХИМ гэдэг еврей үгийн адил Бурханы бүхий л онцлог шинж чанарыг нэгэн зэрэг илэрхийлдэг. Септуагентэд (еврей Хуучин гэрээний грек орчуулга) ЕЛОХИМ-ыг орчуулахдаа ихэнх тохиолдолд энэ үгийг ашигласан байдаг.

Иохан 1:1 нь Эхлэл 1:1-тэй маш төстэй бөгөөд энд ЕЛОХИМ гэдгийг илэрхийлэхийн тулд ТЕОС гэдэг үгийг хэрэглэсэн. Энэ нь тэдний тодорхой харилцаа холбоог онцлон харуулж байна.

2. Эзэн

“Эзэн” гэдэг грек үг нь КУРИОС юм. Энэ нь Шинэ гэрээнд 700 гаруй удаа гардаг бөгөөд ноёрхол, дээд эрх мэдлийг онцлон хэлэхэд хэрэглэгддэг байна. Энэ үгийг бас зүгээр л хүндэтгэлийн нэр болгож хэрэглэдэг. Бид өмнө хэсэгт ТЕОС болон ЕЛОХИМ нь ижил утгатай гэдгийг үзсэн. Бид бас КУРИОС болон ЯАВЭ нь хоорондоо адилхан утгатай болохыг үзнэ. Марк 11:9-д, зохиогч Дуулал 118:26-аас иш татан “Эзэний нэрээр ирэгч нэгэн ероолтэй еэ” гэсэн байдаг. Дуулал 118 дахь еврей үг нь ЯАВЭ бөгөөд үүнийг КУРИОС гэж орчуулсан.

3. Мастер

ДЕСПОТЕС гэдэг үгийг ихэвчлэн “Мастер” гэж орчуулсан байдаг боловч заримдаа “Эзэн” гэсэн байдаг (Лук 2:29; Уйлс 4:24). КУРИОС-д ноёрхол, дээд эрх мэдэл гэсэн санааг илүү онцлодог бол

“Мастер” гэдэг үг нь үүнээс илүүгээр эзэмшигч гэсэн санааг онцолдог. Энэ нэр нь дараах ишлэлд гардаг: 1 Тимот 6:1, 2; 2 Тимот 2:21; Тит 2:9; 1 Петр 2:18; 2 Петр 2:1; Иуда 1:4; Илчлэлт 6:10.

Хувийн Судлалд: 5-р бүлэг, 2-р хэсэг

1. Бурханы еврей нэрсийг тохирох еврей үгтэй нь холбоно уу.

- | | |
|------------------------------|-----------------|
| A. БУРХАН | 1) ЯАВЭ САББАОТ |
| B. Төгс хүчит Бурхан | 2) ЯАВЭ НИССИ |
| C. Хамгийн дээд Бурхан | 3) ЕЛОХИМ |
| D. Мөнхийн Бурхан | 4) АДОНАИ |
| E. ЭЗЭН | 5) ЕЛ ШАДДАИ |
| F. ЭЗЭН хангана | 6) ЯАВЭ ШАЛОМ |
| G. ЭЗЭН бол миний туг далбаа | 7) ЕЛ ОЛАМ |
| H. ЭЗЭН бол амар тайван | 8) ЕЛ ЕЛИОН |
| I. Түмэн цэргийн ЭЗЭН | 9) ЯАВЭ |
| J. ЭЗЭН, МАСТЕР, ЭЗЭМШИГЧ | 10) ЯАВЭ ИРЭ |

2. Бурханы грек нэрсийг тохирох грек үгтэй нь холбоно уу:

- | | |
|-----------|-------------|
| A. БУРХАН | 1) КУРИОС |
| B. ЭЗЭН | 2) ДЕСПОТЕС |
| C. МАСТЕР | 3) ТЕОС |

З-р хэсэг

Бурхан Эцэг (Патерологи)

A. Түүний бодгаль чанар

Бурханыг дүрслэх хамгийн сайн арга зам бол Түүний Өөрийнхөө угэнд Өөрийгөө илчлэхэд хэрэглэсэн нэр томьёог судлах явдал юм. Бидний үзсэн Гурвалын тухай судлалд Эцэг, Хүү, Ариун Сүнсийг адилхан онцлог шинж чанартай гэдгийг үзсэн. Одоо бид тэнгэрлэг Эцэгийн маань тухай Библид заадаг тодорхой нэр томьёонуудыг авч үзье.

Эцэг, Хүү, Ариун Сүнс хоорондоо ялгаатай боловч цорын ганц Бурхан байдаг (Дэд хууль 6:4) гэдгийг анхаараарай. Бичээсийг судалж байх явцад тухайн ишлэлд Гурвалын аль гишүүнийх нь тухай хэлж байгааг ялгаж танихад хэцүү байх тохиолдол олонгаа гардаг. Бурханыг салгаж, эсвэл хувааж ойлгож болохгүй учраас энэ хүндрэлтэй байдлыг хүлээн зөвшөөрч, ойлгох хэрэгтэй (Иохан 10:30; 14:9). Эцэгийн бодгалийн тухай сонгосон уг хэллэг, багцлалуудыг судлах нь Бурхан хэн бэ гэдгийг ойлгох ойлголт болон үнэлэмж хүндлэлийг маань нэмэгдүүлж өгөх болно.

“Миний” гэх мэт хамаатуулах үгс нь “Эцэг” гэдэг үгтэй хамт олонтаа хэрэглэгддэг. Энэ нь Эцэгийн хувьчилсан мөн чанарыг дүрслэн харуулдаг байна. “Эцэг” гэдэг үгийн өмнө “таны”, “түүний” зэрэг үгсийг нэмсэн нь бас хувийн харилцааг тодотгон харуулдаг. “Бидний”, “та нарын”, “тэдний” гэх зэрэг олон тоон дээрх үгсийг нэмж байгаа нь хамтын буюу хэсэг бүлэг хүмүүстэй харилцааг дүрслэн харуулахын тулд хэрэглэгддэг бололтой.

B. Бурханы бодгалийг дүрсэлсэн харуулсан нь

- “Төгс хүчит” - Бурханы ивээж ерөөх хүч чадал, чадвар зэргийг илэрхийлдэг. Эхлэл 49:25; Тооллого 24:4, 16; Рут 1:20, 21; Иов 5:17; 6:4, 14; 8:3, 5; 11:7; 13:3; 15:25; 21:15, 20; 22:3, 17, 23, 25, 26; 23:16; 24:1; 27:2, 10, 11, 13; 29:5; 31:2, 35; 32:8; 33:4; 34:10, 12; 35:13; 37:23; 40:2; Дуулал 68:14; 91:1; Исаия 13:6; Езекиел 1:24; Иоел 1:15; Илчлэлт 1:8
- “Эртний Нэгэн” - Бурханы мөнх мөн чанарыг илэрхийлдэг. Даниел 7:9, 13, 22
- “Мөнхийн Бурхан” - Бурханы мөнх мөн чанарыг илэрхийлдэг. Эхлэл 21:33; Исаиа 40:28
- “Итгэмжит Бурхан” - Бурханы үл өөрчлөгдөх хайрын мөн чанарыг илэрхийлдэг. Дэд хууль 7:9
- “Эцэгийн алдар” - бүх алдар нь Бурханаас байдаг гэдэг үнэнийг илэрхийлдэг. Ефес 1:17
- “Энэрэл нигүүлслийн Эцэг” - Бурханы хосгүй нигүүлслийг илэрхийлдэг. 2 Коринт 1:3
- “Хамгийн дээд Бурхан” - дэлхий ертөнц дээрх эрх мэдлийн хамгийн дээд байр суурийг эзэгнэдэг гэдгийг илэрхийлдэг. Эхлэл 14:18, 19, 20, 22; Дуулал 57:2; 78:35; Еврей 7:1
- “Итгэмжит Бурхан ... шударга бус явдал үгүй” - Бурхан хэзээ ч буруу зүйл хийдэггүй гэдгийг илэрхийлдэг. Дэд хууль 32:4
- “Бурханы алдар” - Бурханы гайхамшигт мөн чанарыг илэрхийлдэг. Дуулал 29:3; Уйлс 7:2
- “Бурхдын Бурхан” - дэлхийн бусад шашнуудын “бурхад” гэж нэрлэгддэг зүйлсээс хамаагүй давуу гэдгийг илэрхийлдэг. Дэд хууль 10:17; Дуулал 136:2; Даниел 2:47; 11:36
- “Амар тайвны Бурхан” - Бурхан зөрчилдөөнийг хүсдэггүй гэдэг үнэнийг илэрхийлдэг. Ром 15:33; 16:20; Филиппой 4:9; 1 Тесалоник 5:23; Еврей 13:20
- “Амьдын Бурхан” - мөнх мөн чанарыг илэрхийлдэг. Матай 22:32; Марк 12:27; Лук 20:38
- “Өндөрт орших Бурхан” - хүндэтгэл бишрэлийг авах зохистой онцгой байр суурийг нь илэрхийлдэг. Мика 6:6
- “Үнэний Бурхан” - ганцхан Бурхан л үнэнийг тогтоодог гэдгийг илэрхийлдэг. Дуулал 31:5; Исаиа 65:16
- “Агуу, аймшигт Бурхан” - Бурханы гайхамшигт сүр жавхланг илэрхийлдэг. Дэд хууль 7:21; Нехемия 1:5; Даниел 9:4

- “Агуу хүчирхэг Бурхан” - Бурханы гайхамшигтай хүч чадлыг илэрхийлдэг. Иеремиа 32:18; Нехемиа 9:32
- “Бүх бурхдын дээд агуу Хаан” - хүн төрөлхтний бурхдаас дээгүүрх Бурханы дээд эрх мэдлийг илэрхийлдэг. Дуулал 95:3
- “Эмээх зохистой Нэгэн” - Бурханд үзүүлэх зохистой хүндэтгэлийг илэрхийлдэг. Дуулал 76:11, 12
- “Ариун Нэгэн” - Бурханы зөвт төгс байдал нь ер бусын онцгой гэдгийг илэрхийлдэг. Хаадын дэд 19:22; Иов 6:10; Дуулал 22:3; 71:22; 78:41; 89:18; Сургаалт үгс 9:10; 30:3; Исаиа 1:41; 5:19, 24; 10:17, 20; 12:6; 17:7; 29:19, 23; 30:11-12, 15; 31:1; 37:23; 40:25; 41:14, 16, 20; 43:3, 14-15; 45:11; 47:4; 48:17; 49:7; 54:5; 55:5; 60:9, 14; Иеремиа 50:29; 51:5; Езекиел 39:7; Хосеа 11:9, 12; Хабаккук 1:12; 3:3; 1 Иохан 2:20
- “Хартай Бурхан” - Бурхан Өөрийн ард түмнийг өөр ямар нэгэн “бурхан”-д үйлчлүүлэхийг хүсдэггүй гэдгийг илэрхийлдэг. Египетээс гарсан нь 34:14
- “Хартай, өширхөгч Бурхан” - Өөрийнх нь ард түмнийг хулгайлахыг оролдогчийн дээр Бурхан шийтгэлээ буулгах болно гэдгийг илэрхийлдэг. Нахум 1:2
- “Сүр жавхлангийн Хаан” - Түүний байр суурь нь хамгийн дээд алдар, сүр жавхланг хүртэх зохистой гэдэг үнэнийг илэрхийлдэг. Дуулал 24:7, 8, 9, 10
- “Амьд, үнэн Бурхан” - Бурханы мөн чанарын мөнх агаад бодит байдлыг илэрхийлдэг. 1 Тесалоник 1:9
- “Төгс хүчит Эзэн Бурхан” - Түүний эрх мэдэл (Эзэн), мөн чанар (Бурхан), хүч чадлыг (Төгс хүчит) илэрхийлдэг. Илчлэлт 4:8; 11:17; 15:3; 16:7; 19:6; 21:22
- “Амар тайван” - Бурханы дотоод төгс зохицлыг илэрхийлдэг. Шүүгчид 6:24
- “Хамгийн дээд Эзэн” - Бурхан оршин буй бүх зүйлсээс эрх мэдлийн хамгийн дээд байр суурийг эзэлдэг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 7:17; 47:2
- “Бидний Бурхан Эзэн” - Бурханы эрх мэдлийн хувьчилсан мөн чанарыг илэрхийлдэг. Дуулал 90:17; Даниел 9:9, 15; Марк 12:29; Уйлс 2:39
- “Хайр” - Бурханы мөн чанар дахь өөрийгөө зориулагч чанарыг илэрхийлдэг. 1 Иохан 4:8, 16
- “Энэрэл хайр” - Түүний хайрын мөн чанар болох үнэнч байдлыг илэрхийлдэг. Египетээс гарсан нь 34:6, 7; Дэд хууль 5:10; 7:9, 12; Хаадын дээд 8:23; Шастирын дээд 16:34; Шастирын дэд 6:14; Езра 3:11; Нехемиа 1:5; 9:17; Иов 37:13; Дуулал 6:4; 13:5; 26:3; 31:16; 32:10; 36:5, 7; 63:3; 89:2, 14; 103:8, 11; 136:1, 2-28; 138:8; Гашуудал 3:22, 32; Иоел 2:13
- “Сүр жавхлант Алдар” - Бурханы гайхамшигт мөн чанарыг илэрхийлдэг. 2 Петр 1:17
- “Тэнгэр дэх/дээр байгч Сүр жавхлант Нэгэн” - Түүний тэнгэрлэг ариун зан суртахуунтай гэдгийг илэрхийлдэг. Еврей 1:3; 8:1
- “Сүр жавхлант Нэгэн” - Түүний тэнгэрлэг ариун зан суртахууны онцгой, хосгүй байдлыг илэрхийлдэг. Исаиа 33:21
- “Хамгийн Дээд Нэгэн” - Бурхан бол байж болох бүхий л замаас буюу бүгдээс дээгүүр гэдэг үнэнийг өгүүлсэн энгийн илэрхийлэл. Тооллого 24:16; Дэд хууль 32:8; 2 Самуел 22:14; Дуулал 7:17; 9:2; 18:13; 21:7; 46:4; 47:2; 50:14; 57:2; 73:11; 77:10; 78:17, 35, 56; 82:6; 83:18; 87:5; 91:1, 9; 92:1; 97:9; 107:11; Исаиа 14:14; Гашуудал 3:35, 38; Даниел 3:26; 4:2, 17, 24, 25, 32, 34; 5:18, 21; 7:18, 22, 25, 27; Хосеа 7:16; 11:7; Марк 5:7; Лук 1:32, 35, 76; 6:35; 8:28; Уйлс 7:48; 16:17; Еврей 7:1
- “Миний дуу” - Бурханыг хүмүүний дуу хөгжмийн хэлээр илэрхийлж буй илэрхийлэл. Египетээс гарсан нь 15:2; Дуулал 118:14; 119:54; Исаиа 12:2
- “Цорын ганц Бурхан” - Бурханы жинхэнэ хосгүй байдлыг илэрхийлдэг. Иохан 5:44; 1 Тимот 1:17; Иуда 1:25
- “Цорын ганц мэргэн Бурхан” - Бурханы мэргэн ухааны хосгүй байдлыг илэрхийлдэг. Ром 16:27
- “Төгс байдал” - Бурханд ямар ч гэм нүгэл, алдаа дутагдал байхгүй гэсэн утгатай. Матай 5:48
- “Үнэн Бурхан” - Бурхан хүнийг бүтээсэн болохоос хүн Бурханыг бүтээгээгүй гэсэн утгатай. Шастирын дэд 15:3; Иеремиа 10:10; 1 Иохан 5:20

В. Эцэгийн үүрэг

Тэнгэр, газрыг бүтээхээс өмнө Төлөвлөгөөг зохиож, бий болгох нь Гурвал дахь Эцэгийн үүрэг байсан (Ефес 1: 11; 3:11).

Г. Эцэгийн үүргийг дурслэн харуулах нь

- “**Уран барилгачин**” - барилгын хэсэг тус бүрийн хоорондын харилцаа холбоо, түүний харагдах байдал, бүхий л дотоод ба гадаад даралт даацыг тооцоолж барилгыг зохион бүтээх, төлөвлөх Бурханы чадварыг харуулдаг. Еврей 11:10
- “**Барилгачин**” - аливаа төлөвлөгөөг бодит байдал болгож чадах чадварыг нь илэрхийлдэг. Еврей 3:4; 11:10
- “**Энэрэнгүй ба нигүүлсэнгүй Бурхан**” - Түүнийг хүн төрөлхтөнд тэсвэр тэвчээртэй ханддаг гэдгийг илэрхийлдэг. Египетээс гарсан нь 34:6
- “**Сул доройн хамгаалал**” - Бурхан хүчгүй сул дорой хүмүүстэй зүй бусаар харьцдаг эрх мэдэлтэй хүчирхэг хүмүүст дургүй гэдгийг илэрхийлдэг. Исаиа 25:4
- “**Мөнхийн Хаан**” - Бурханы мөнхийн дээд эрх мэдлийг илэрхийлдэг. Иеремиа 10:10
- “**Гэрлүүдийн Эцэг**” - дэлхий ертөнцийг гэрэлтүүлэхээр бүтээгдсэн бэлгүүдийг өгдөг Нэгэн гэдгийг илэрхийлдэг. Иаков 1:17
- “**Өршөөлийн Эцэг**” - Бурхан Өөрийн бүтээлийг үргэлж өршөөн нигүүлсдэг гэдгийг илэрхийлдэг. 2 Коринт 1:3
- “**Сүнснүүдийн Эцэг**” - Есүс Христэд итгэгч хүн бүхэнд өгдөг Бурханы сүнслэг амьдралын бэлгийг илэрхийлдэг. Еврей 12:9
- “**Эцэггүй хүний эцэг**” - Бурхан өнчин нэгнийг өрөвдөн энэрдэг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 68:5
- “**Уучлалын Бурхан**” - хүн төрөлхтнийг гэм нүглээс нь аврахыг хүсдэг Бурханы хүслийг илэрхийлдэг. Нехемиа 9:17; Дуулал 99:8
- “**Амийн усны Ундарга**” - Бурхан бол мөнхийн амьдралыг өгч, тэжээж тэтгэдэг Нэгэн гэсэн үнэнийг илэрхийлдэг. Иеремиа 2:13; 17:13
- “**Усан үзэм тариалагч**” - Бурхан сүнслэг үр жимс ургуулахад анхаардаг гэдгийг илэрхийлдэг. Иохан 15:1
- “**Израилийн алдар**” - Бурхан Израильд үнэнч, тууштай ханддаг гэдгийг илэрхийлдэг. 1 Самуел 15:29; Мика 1:15
- “**Бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурхан**” гэдэг нь Есүс Христийн бие бол Бурханы бүтээл гэдгийг илэрхийлдэг. Ром 15:6; 2 Коринт 1:3; Ефес 1:3; 1 Петр 1:3
- “**Бурхан бол миний Бүтээгч**” - хүний биеийг бүтээхэд Бурхан шууд оролцдог гэдгийг илэрхийлдэг. Иов 35:10
- “**Бурхан бол миний хад**” - Бурхан итгэгчдийг тууштайгаар хангадаг болохыг илэрхийлдэг. Дуулал 42:9
- “**Абрахам, Исаак, Иаковын Бурхан**” - Абрахамын гэрээн дэх Бурханы оролцоог илэрхийлдэг. Египетээс гарсан нь 3:16; Үйлс 3:13; 7:32
- “**Бүх тайвиралын Бурхан**” - зовлон цөхрөлийн үед Бурхан тусалж, дэмждэг гэдгийг илэрхийлдэг. 2 Коринт 1:3
- “**Бүх махан биеийн Бурхан**” - Бурхан бүхий л хүмүүсийн бүтээлийн эх сурвалж гэсэн үнэнийг илэрхийлдэг. Иеремиа 32:27
- “**Найдварын Бурхан**” - Бурханы төлөвлөгөөн дотор бидэнд ирээдүй бий гэдэг итгэл найдварыг илэрхийлдэг. Ром 15:13
- “**Хайрын ба амар тайвны Бурхан**” - Бурхан зөрчилдөөнийг эвлэрүүлэхийг хүсдэг гэдгийг илэрхийлдэг. 2 Коринт 13:11
- “**Миний авралын Бурхан**” - бидний мөнхийн аврал нь хувьчилсан буюу хувь хүнд хандсан мөн чанартай гэдгийг илэрхийлдэг. Дуулал 18:46; 25:5; 27:9; 51:14; 88:1; Мика 7:7; Хабаккук 3:18; Лук 1:47

- “**Миний хүч чадлын Бурхан**” - хүн төрөлхтний төлөөх Бурханы дэмжлэг нь хувьчилсан буюу хувь хүнд хандсан мөн чанартай гэдгийг илэрхийлдэг. Дуулал 43:2
- “**Нөхөн төлбөрийн Бурхан**” - Бурхан шударга бус зүйлсийн дээр шийтгэл буулгах болно гэсэн үнэнийг илэрхийлдэг. Иеремиа 51:56
- “**Бүх махан биеийн сүнснүүдийн Бурхан**” - амьдралыг тэтгэгч мөн чанарыг илэрхийлдэг. Тооллого 27:16
- “**Бидний Эцэг Бурхан**” - итгэгчид Бурхантай гэр бүлийн харилцаатай гэдгийг илэрхийлдэг. Ром 1:7; 1 Коринт 1:3; 2 Коринт 1:2; Галат 1:3; Ефес 1:2; Филиппой 1:2; Колоссай 1:2; 2 Тесалоник 1:1; 2:16; Филимон 1:3; Иаков 1:27
- “**Бидний хүч чадал болох Бурхан**” - Бурхан зөвхөн хувь хүний төдийгүй мөн хамтын хүч чадлын эх сурвалж болдог гэдэг үнэнийг илэрхийлдэг. Дуулал 81:1
- “**Дэлхий дээрх бүх хаанчлалын Бурхан**” - тэнгэр элч нар болон хүн төрөлхтний байгуулсан эрх мэдлийн бүхий л бүтцээс Бурхан илүү дээгүүр эрх мэдэлтэй гэдгийг илэрхийлдэг. Хаадын дэд 19:15; Исаиа 37:16
- “**Эцэг Бурхан**” - бүх зүйлийг хангаж, тэтгэж байдаг Бурханы хангалтыг илэрхийлдэг. Иохан 6:27; 1 Коринт 8:6; 15:24; Галат 1:1; Ефес 5:20; 6:23; Филиппой 2:11; Колоссай 1:3; 3:17; 1 Тесалоник 1:1; 2 Тесалоник 1:2; 1 Тимот 1:2; Тит 1:4; 1 Петр 1:2; 2 Петр 1:17; 2 Иохан 1:3; Иуда 1:1
- “**Миний өмнөөс өшөө авагч Бурхан**” - хувь хүнд үйлдсэн буруу зүйлийн төлөө Бурхан хувьчлан өшөө авдаг гэдгийг илэрхийлдэг. 2 Самуел 22:48; Дуулал 18:47
- “**Тэвчээр ба урамшууллыг өгөгч Бурхан**” - Бурхан бол итгэгчдийг хүнд хэцүү цаг үед нь дэмжиж тусалдаг Нэгэн гэсэн үнэнийг илэрхийлдэг. Ром 15:5
- “**Гай гамшигийг зөөлрүүлэгч Бурхан**” - Бурхан улс үндэстэн дээрх сахилгажуулалтаа хүчингүй болгож чадна гэдэг үнэнийг илэрхийлдэг. Иона 4:2
- “**Хардаг Бурхан**” - Бурхан хүн төрөлхтний анхаардаг гэдгийг илэрхийлдэг. Эхлэл 16:13
- “**Өнчин хүмүүсийн Туслагч**” - өнчин хүмүүст Бурхан анхаарал тавьж, тусалдаг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 10:14
- “**Тэр та нарыг Тайвшруулагч**” - өвчин шаналлыг багасгаж, тайвшруулдаг чадварыг нь илэрхийлдэг. Исаиа 51:12
- “**Тэр Өөрийн бодлуудаа хүнд тунхагладаг**” - Бурхан бодол санаагаа хүн төрөлхтөнд илчилдэг гэдгийг илэрхийлдэг. Амос 4:13
- “**Тэр тэд бүгдийн зүрхийг бүтээсэн**” - хүн төрөлхтний хамгийн гүн нууц хэсгийг хүртэл бүтээсэн Бурханы бүтээлч хүч чадлыг илэрхийлдэг. Дуулал 33:15
- “**Гуйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд**” - Түүний ажлын хэмжээлшгүй боломж, цар хүрээг илэрхийлдэг. Ефес 3:20
- “**Есүсийг үхэгдээс амилуулсан Тэр**” - Есүс Христийг үхлээс амилуулахад Бурханы гүйцэтгэсэн үүргийг илэрхийлдэг. Ром 8:11
- “**Ариун Аав**” - Бурханы зөвт төгс байдлыг илэрхийлдэг. Иохан 17:11
- “**Та нарын дунд буй Ариун Нэгэн**” - Бурханы зөвт байдлын оршихуйг илэрхийлдэг. Хоцеа 11:9
- “**Чиний Нөхөр**” - Өөрийн бүтээлийг хайрлан хангаж байдгийг нь илэрхийлдэг. Исаиа 54:5
- “**Бэлэвсний шүүгч**” - хамгаалах хүнгүй орхигдсон хүмүүсийг Бурхан харж ханддаг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 68:5
- “**Газар дэлхийн Шүүгч**” - Бурханы эрх мэдлийн хүрээ дэлхийн хэсэг бүрд хүрдэг гэдгийг илэрхийлдэг. Эхлэл 18:25
- “**Тэнгэрийн Хаан**” - Бурханы хаан ширээ оршигч газрыг илэрхийлдэг. Даниел 4:37
- “**Амьд Эцэг**” - Бурханы өнөөгийн халуун дотно байдлыг илэрхийлдэг. Иохан 6:57
- “**Эзэн**” - Бурхан бол мастер буюу эзэмшигч гэсэн угтатай. Лук 2:29
- “**ЭЗЭН миний туг**” - Бурхан бол улс үндэстний туг далбаа шиг бөгөөд бидний анхаарал Түүн рүү чиглэж байх ёстой гэдэг үнэнийг илэрхийлдэг. Египетээс гарсан нь 17:15

- “**ЭЗЭН миний хад**” - Бурхан итгэгчдэд тууштай ханддаг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 19:14; 28:1; 144:1
- “**Бүх газар дэлхийн Эзэн**” - Бурханы эрх мэдлийн хүрээнд бүх газар дэлхий байдаг гэдэг үнэнийг илэрхийлдэг. Иошуа 3:11,13; Дуулал 97:5; Мика 4:13; Зехария 4:14
- “**Тэнгэр газрын Эзэн**” - гариг ертөнцийн бүхий л хэсэг Бурханы эрх мэдэл дор байдаг гэдгийг илэрхийлдэг. Матай 11:25; Лук 10:21; Уйлс 17:24
- “**Хаадын Эзэн**” - Бурханы эрх мэдэл газар дэлхийн хаадынхаас ч дээгүүр гэдгийг илэрхийлдэг. Даниел 2:47
- “**Бидний Бүтээгч Эзэн**” - хүн төрөлхтнийг бүтээхдээ ашигласан Бурханы эрх мэдлийг илэрхийлдэг. Дуулал 95:6
- “**Бидний бамбай болох Эзэн**” - Өөрийн ард түмнийг хамгаалах Бурханы чадварыг илэрхийлдэг. Дуулал 59:11
- “**Та нарын эдгээгч Эзэн**” - Бурхан өвчин зовлонгоос дээгүүр эрх мэдэлтэй гэдгийг илэрхийлдэг. Египетээс гарсан нь 15:26
- “**Та нарыг ариусгагч Эзэн**” - дэлхийн бусад зүйлсээс та нарыг тусгаарлах Бурханы эрх мэдлийг илэрхийлдэг. Египетээс гарсан нь 31:13; Левит 20:8; 22:32
- “**Цохигч Эзэн**” - Бурхан янз бүрийн цаг үеүдэд ард түмнийхээ дээр тэнгэрлэг сахилгажуулалтыг өгдөг гэдгийг илэрхийлдэг. Езекиел 7:9
- “**Эзэн хангана**” - Бурхан ард түмнээ тэжээн тэтгэдэг гэдэг үнэнийг илэрхийлдэг. Эхлэл 22:14
- “**Чамайг Бүтээгч**” - Бурхан Өөрийн гараар чамайг бүтээсэн гэдгийг илэрхийлдэг. Исаиа 54:5
- “**Бүхнийг Бүтээгч**” - Бурханы бүтээх ажлын цар хүрээг илэрхийлдэг. Номлогчийн үгс 11:5; Иеремия 10:16; 51:19
- “**Тэнгэрт Эзэн**” - Бурхан бусдын эрх мэдлийг тогтоодог гэдгийн нэгэн жишээ. Колоссай 4:1
- “**Миний өмгөөлөгч**” - Бурхан биднийг хамгаалж өмгөөлдөг гэдгийг илэрхийлдэг. Иов 16:19
- “**Миний найдвар**” - Бурханд итгэх бидний итгэлийн хувьчилсан мөн чанарыг илэрхийлдэг. Дуулал 71:5
- “**Миний тусламж**” - авралын хувьчилсан мөн чанарыг илэрхийлдэг. Египетээс гарсан нь 18:4; Дуулал 27:9; 40:17; 54:4; 63:7; 70:5; 118:7; 121:1; Еврей 13:6
- “**Миний хоргodoх газар**” - хүмүүсийг хамгаалдаг Бурханы хамгаалалт хувьчилсан мөн чанартай гэдгийг илэрхийлдэг. Дуулал 32:7
- “**Миний найдвар**” - ирээдүйн талаар Бурханд итгэж найдах гэдэг нь хувьчилсан мөн чанартай гэдгийг илэрхийлдэг. Дуулал 25:5, 21; 39:7; 62:5; 71:5; 119:74, 81, 114, 147; Уйлс 23:6; 26:6
- “**Миний гэрэл**” - Бурханы удирдамжийн хувьчилсан мөн чанарыг илэрхийлдэг. Дуулал 27:1; Мика 7:8
- “**Зовлон шаналлын өдөр миний хоргodoх газар**” - зовлон гамшгийн үе дэх Бурханы хамгаалалтыг илэрхийлдэг. Иеремия 17:17; Дуулал 59:16
- “**Миний түшиг тулгуур**” - Бурханы хангалтууд хувьчилсан мөн чанартай гэдгийг илэрхийлдэг. 2 Самуел 22:19; Дуулал 18:18
- “**Чиний нүглийг дурсахгүй Нэгэн**” - Бурханы уччал хувьчилсан мөн чанартай гэдгийг илэрхийлдэг. Исаиа 43:25
- “**Бидний орших газар**” - Бурхан бол бидний жинхэнэ гэр орон гэсэн утгатай. Дуулал 90:1
- “**Бидний шүүгч**” - Бурхан бүх хүн төрөлхтний шүүгч гэсэн утгатай. 1 Самуел 24:15; Исаиа 33:22
- “**Бидний хууль тогтоогч**” - Тэр бүх хүн төрөлхтний хэм хэмжүүрийг тогтоох эрх мэдэлтэй гэсэн утгатай. Исаиа 33:22
- “**Бидний Аврагч**” - Бурхан хүн төрөлхтний төлөө авралыг худалдан авсан гэсэн утгатай. Исаиа 47:4; 63:16

- “**Бидний хоргodoх газар ба хүч чадал**” - Бурхан Өөрийн хүмүүсийн хамгаалагч гэсэн утгатай. Дуулал 46:1
- “**Тэнгэр газрын эзэмшигч**” - Бурхан бүх зүйлийн эзэмшигч гэсэн утгатай. Эхлэл 14:19, 22
- “**Ваарчин**” - Бурхан Өөрийн гар туйнаж хэлбэрт оруулдаг гэсэн утгатай. Исаиа 29:16; 45:9; 64:8; Иеремиа 18:4, 6; Зехария 11:13; Ром 9:21
- “**Чиний Аврагч**” - Бурхан Өөрийнхөө төлөө бус харин хүмүүсийн төлөө авралыг худалдан авсан гэсэн утгатай. Исаиа 54:5
- “**Ард түмнийхээ хоргodoх газар**” - Өөрийн хүмүүст санал болгодог Бурханы хамгаалалтыг илэрхийлдэг. Иоел 3:16
- “**Шуурганаас хоргodoх газар**” - хүмүүсийг хүчирхийлэл, дарлалаас хамгаалдаг Бурханы хамгаалалтыг илэрхийлдэг. Исаиа 25:4
- “**Зөвт Аав**” - Бурханы сайн сайхныг илэрхийлдэг. Иохан 17:25
- “**Шударга шүүгч**” - Бурханы шийдвэрүүд шударга байдаг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 7:11; Иеремиа 11:20; 2 Тимот 4:8
- “**Миний хоргodoх хад**” - Бурханы хамгаалалтын баттай байдлыг илэрхийлдэг. Дуулал 94:22
- “**Миний хүч чадлын хад**” - хувь хүнд хүч чадлыг өгдөг баттай байдлыг нь илэрхийлдэг. Дуулал 62:7
- “**Авралынхаа Хад**” - бидний аврал баттай гэдгийг илэрхийлдэг. Дуулал 95:1
- “**Ариун газар**” - Бурхан бол хорогдох газар гэдэг үнэнийг илэрхийлдэг. Исаиа 8:14; Езекиел 11:16
- “**Авралын хамгаалалт**” - Бурхан бол хорогдох газар гэсэн утгатай. Дуулал 28:8
- “**Халуунаас халхлах сүүдэр**” - дарамт шахалт гарч ирэх үед хангадаг гэдгийг илэрхийлдэг. Исаиа 25:4
- “**Хүч чадал**” - Бурханы хангалтын хүч чадлыг илэрхийлдэг. Исаиа 28:6
- “**Зүрхий минь хүч**” - Бурхан итгэгчдийн зүрх сэтгэлд хүч эрчмийг өгдөг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 73:26
- “**Миний авралын хүч чадал**” - бидний авралын цаадах хүч чадлыг илэрхийлдэг. Дуулал 140:7
- “**Дарлагдагсдыг хамгаалах бэхлэлт**” - хүнд дарлагдаж, зовж буй хүмүүсийг Бурхан хамгаалдаг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 9:9
- “**Бэрх цагийн бэхлэлт**” - дарамт шахалт байгаа ямар ч үед Бурханы хамгаалалт байсаар байдаг гэдгийг илэрхийлдэг. Дуулал 9:9
- “**Миний сэтгэлийн тэтгэгч**” - Бурханы сүнслэг хангалт хувьчилсан мөн чанартай гэдгийг илэрхийлдэг. Дуулал 54:4
- “**Багш**” - хүмүүст зааж сургах Бурханы чадварыг илэрхийлдэг. Иов 36:22; Исаиа 30:20
- “**Залбирлыг сонсдог Нэгэн**” - Бурхан хүн төрөлхтний бүхий л хүсэл тэмүүллийг ойлгодог гэсэн утгатай. Дуулал 65:2
- “**Хайр энэрлээ үзүүлэн, гэрээгээ сахин хадгалдаг Нэгэн**” - Бурхан хайрладаг учраас гэрээгээ сахидаг гэсэн утгатай. Хаадын дээд 8:23; Шастирын дэд 6:14
- “**Зовлон дундах бодит тусламж**” - бидэнд тусламж хэрэгтэй үед Бурхан бидэнтэй хамт байдаг гэсэн утгатай. Дуулал 46:1

Хувийн Судлалд: 5-р бүлэг, 3-р хэсэг

1. Ганц тоон дээрх биеийн төлөөний үг болох “миний”, “чиний”, “түүний” гэх мэт үгсийг Бурханы нэртэй хамт хэрэглэсэн тохиолдолд энэ нь харилцааны ямар хэлбэрийг илэрхийлж байна вэ?
2. Олон тооны төлөөний үг болох “бид”, “тэд” зэрэг үгсийг Бурханы нэртэй хамт хэрэглэсэн тохиолдолд энэ нь харилцааны ямар хэлбэрийг илэрхийлж байна вэ?

3. “Б” хэсэг дэх Бурханы бодгалтай холбоотой дүрслэлүүдийг дор өгүүлсэн төгс мөн чанаруудтай холбоно уу. Зарим дүрслэл нь иэгээс илүү шинж чанарыг агуулсан байж болох юм. Гэхдээ эдгээрийг зөвхөн энэ дасгалд үзсэн тэр шинж чанартай нь холбоорой. Та хүсвэл энэ номд гарч буй Бурханы төгс мөн чанарыг а, б, в гэх мэтээр тэмдэглэж болно.
- A. Хамгийн дээд эрх мэдэл
 - Б. Зөвт байдал
 - В. Шударга ёс
 - Г. Хайр
 - Д. Мөнх амь
 - Е. Омнипотент (Бүхнийг чадагч)
 - Ё. Омнипресент (Хаа сайгүй оршигч)
 - Ж. Омнисиент (Бүхнийг мэдэгч)
 - З. Өөрчлөгдешгүй
 - И. Үнэн
4. “Г” хэсэг дэх Эцэгийн үүргийн тухай дүрслэлүүдийг дор өгүүлсэн Эцэгийн ажил үүргийг тайлбарласан дүрслэлтэй холбоно уу. Дахин хэлэхэд, эдгээр дүрслэл нь иэгээс илүү категорид тохирч болно. Та хүсвэл энэ номд гарч буй Бурханы төгс мөн чанарыг а, б, в гэх мэтээр тэмдэглэж болно.
- A. Эрх мэдэлтэй
 - Б. Бүтээгч
 - В. Өмгөөлөгч ба Хамгаалагч
 - Г. Үлгэр жишээ
 - Д. Өгөгч
 - Е. Шүүгч
 - Ё. Удирдагч
 - Ж. Хайрлагч
 - З. Бүтээгч ба Хангагч
 - И. Баттай байгч ба Тэтгэгч

4-р хэсэг

Хүү Бурхан (Христологи)

A. Есүс Христийн бодгаль

Хүү, Есүс Христ бол махан бие дэх Бурхан юм. Есүс бол бурхан болсон сайн хүн байгаагүй, харин хүн болсон Бурхан байсан юм (Иохан 1:1, 14). Есүс Бурханы мөн чанарын жинхэнэ төлөөлөл байсан (Иохан 14:8-9; Еврей 1:3).

1. Есүс урьдаас оршин байсан нь

Есүс махан биетэй болж төрөхөөсөө оршин байсан. Үүнийг “*Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс, үзэгдэх ба үл үзэгдэх юмс, хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд ч бүтээгдсэн. Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна*” хэмээн хэлсэн байдаг (Колоссай 1:16). Есүс Өөрөө ч гэсэн иудейчүүдэд хандан “*Абрахам бий болохоос өмнө Би БАЙДАГ*” (Иохан 8:58) гэж айлдсан.

Иоханы сайн мэдээ Есүс урьд нь оршин байсан гэдгийг мөн баталсан байдаг. Номынхoo эхэнд Иохан “*Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Тэр эхэнд Бурхантай хамт байсан. Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй*” (Иохан 1:1-3) гэсэн. Түүнчлэн уг бүлэгт Иохан “*Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүсэл ба үнэнээр дүүрэн байсан юм*” (Иохан 1:14) гэж хэлсэн байдаг.

2. Бурхан-Хүний нэгдэл

Есүс бол Бурхан ба хүмүүн хоёулаа юм. Тэр жинхэнэ Бурхан атлаа жинхэнэ хүн байсан. Энэ үнэнийг ойлгоход үргэлж бэрх байдаг ч үнэхээр үнэн юм.

Есүс загалмай дээр нас барахаасаа өмнөхөн фарисайчуудаас нэгэн асуулт асуусан байдаг (Матай 22:41-46). Тэрээр “Давид хаан Мессиаг “Эзэн” хэмээн дууддаг бол Тэр бас яаж түүний “хүү” байх билээ?” Ингэж болох цорын ганц арга зам нь Мессия Бурхан ба хүн болж төрөх явдал юм.

3. Есүсийн төгс байдал

Есүс бүхий л талаараа төгс байсан. Бурхан гэдгийнхээ хувьд Тэр төгс байсан, харин Түүний хүмүүн чанарын хувьд төгс байсан эсэхэд зарим хүмүүс эргэлздэг.

“*Инэг хүнээр ертөнцөө нүгэл нь ирсний адил нүглээр үхэл нь ирсэн. Тиймээс бүгд нүгэл үйлдсэн тул үхэл нь бүх хүнд иржээ*” (Ром 5:12) гэдгийг бид Ром номоос сурсан. Тэрхүү нэг хүн гэдэг нь Адам бөгөөд түүний уналтаас болж гэм нүгэл болон бүх хүнд тархсан (Ром 5:13-19). Есүс энэ дэлхийн буюу биологийн авгүй байсан бөгөөд Ариун Сүнсээр “бүтээгдсэн” (Лук 1:35). Энэ нь Есүсийг “Бурханы Хүү” гэж нэрлэгдэх хүргэж байгаа төдийгүй, мөн анхны хүн Адамаар дамжин ирдэг гэм нүгэл болон үхэл Түүнд дамжихгүй болсон юм. Бусад бүх хүнээс ялгаатай нь Есүст Есүст Адамын нүгэлт мөн чанар байгаагүй. Адам бол төгс байдлаар бүтээгдсэн ч хожим нь унасан, харин Есүс бол төгс байдлаар бүтээгдсэн бөгөөд хэзээ ч унаагүй юм.

Есүс төгс амьдралаар амьдарсан, үүрд мөнхөд төгс байх болно гэдгийг Бурханы Үг бидэнд өгүүлдэг. Тэрээр “нүгэл үйлдээгүй”, ямар ч заль мэхтэй зүйл яриагүй (1 Петр 2:22). Есүс махан бие дотор гэм нүгэлгүй амьдарсан учраас Түүнийг “мөнхөд төгс болгогдсон” (Еврей 5:9; 7:28) гэсэн бөгөөд энэ нь Тэр хэзээ ч нүгэл үйлдэхгүй гэсэн утгатай.

B. Есүс Христийн үүрэг

Бурханы төлөвлөгөөн дэх Есүсийн үүрэг бол төлөвлөгөөнд шаарддаг зүйлийг хийх байсан (Иохан 8:28-29). Хүн төрөлхтнийг аврахын тулд хүн төрөлхтний гэм нүглийн төлөөсийг төлөх хэрэгтэй байсан бөгөөд Тэр энэ ажлыг бүрэн гүйцэд хийж гүйцэтгэсэн юм (2 Коринт 5:21).

1. Есүс хүүхэд болж ирсэн нь

Есүсийг мэндлэх болно гэдгийг Хуучин гэрээнд, онцгойлон эш үзүүлэгч Исаиагаар дамжуулан эш үзүүлсэн байсан (Исаиа 7:14; 9:6; 11:1; 53:2). Есүс бол “эмэгтэйн амлалтын үр хүүхэд” юм (Эхлэл 3:15).

Түүнийг Бетlehemд төрөх болно (Мика 5:2), Исаак (Эхлэл 21:12), Иаков (Эхлэл 35:10-12), Иуда (Эхлэл 49:8-11), Иесси (Исаиа 11:1), Давидаар (2 Самуел 7:12-16; Иеремиа 23:5; Дуулал 132:11) дамжуулан Абрахамын “үр удам” (Эхлэл 22:18; Матай 1:1; Галат 3:16) байх болно хэмээн эш үзүүлсэн байдаг.

2. Онгон төрөлт

Бурхан төлөвлөгөөний дагуу Мессия Есүс (Христ) онгон эмэгтэйгээс төрөх байсан (Исаиа 7:14). Хэдийгээр энэ нь теологийн хувьд ач холбогдолтой боловч Есүсийн төрөлт нь гайхамшиг байсан гэдгийг тэмдэглэх нь бас чухал юм. Энэ эш үзүүллэг нь Мариар дамжуулан тодорхой биелэгдсэн (Матай 1:20, 25).

3. Христийн үхэл

Есүсийн үхэл олон зүйлийг бүрэн биелүүлсэн. Тэр үхэх ёстай нэгэн байгаагүй (Лук 23:4). Нүгэл үйлдсэн бүх хүн (Ром 3:23) үхэх ёстай (Ром 6:23). Бид бүгд нэгэнт нүгэл үйлдсэн учир бүгдээрээ үхэх ёстай. Харин Есүсийн хувьд, Тэр нүгэл үйлдээгүй учраас үхэх ёсгүй байсан боловч бидний өмнөөс сайн дураараа Ариун агаад Зөвт Бурханы өмнө нүглүүдийн төлөөс болсон юм (Иохан 10:15-17).

a. Орлуулалт

“Орлуулалт” гэдэг нь Есүс бидний өмнөөс загалмайг үүрсэн гэсэн утгатай. Энэ тухай “**Биднийг нүгэлд үхүүлжс, зөвт байдалд амьдруулахын тулд Тэр Өөрөө бидний нүглийг модон дээрээ биедээ үүрсэн. Учир нь та нар Түүний шархаар эдээгдсэн билээ**” (1 Петр 2:24) хэмээн хэлсэн байдаг. Есүс бидний “нэрийн өмнөөс” биш, харин бидний “оронд” загалмай руу явсан юм. Тэр бидний “хараал”-ыг үүрсэн (Галат 3:13).

б. Золилт

“Золилт” гэдэг нь төлөөсийг төлсөн учир хүнийг чөлөөлөх гэсэн утгатай. Энэ нь худалдаж авахаас өмнө боолчлолд байсан хүнийг эрх чөлөөтэй болгохын тулд үнийг төлсөн гэсэн үг юм. Золилт гэдэг нь гэм нүглийн уччлал бөгөөд биднийг Сатаны эрх мэдлээс Бурханы хаанчлал руу оруулж буй хэрэг юм (Колостай 1:13-14).

Христ бүх хүн төрөлхтнийг худалдан авах үнийг төлсөн (2 Петр 2:1), тийнхүү бүх хүн гэм нүгэл, үхлийн хуулиас чөлөөлөгдөх боломжтой болсон юм (Ром 8:2). Энэ үнэ бол Есүсийн загалмай дээрх үхэл буюу Түүний Өөрийнх нь цус байсан (Илчлэлт 5:9-10). Бидний эрх чөлөөний төлөөх үнэ төлөгдсөн учир, Түүний бидэнд өгсөн нигүүлслийн төлөө одоо бид үүрэг хариуцлага учраас бус харин талархлын улмаас Эзэнд үйлчлэх (1 Коринт 6:19-20) эрх чөлөөтэй болсон. Бид хүний санаа бодлын бус харин эхлээд Христийн боол (эзнийхээ агуу байдлын улмаас эзнийхээ дор байхаар өөрсдөө сонгосон хүмүүс) байхaa сонгох ёстай (1 Коринт 7:19-23).

Христ дотор бидэнд өгөгдсөн эрх чөлөөг хамгаалахын тулд байнгын тэмцэл өрнөж байдаг (Галат 5:1). Хүмүүн бил гэм нүгэл болон сорилтод автаж, зүрх сэтгэлээ үүнд боолчлуулан, улмаар үл итгэгчид шиг амьдардаг (Ефес 5:1-14). Христийн төлбөрийг нь төлж, бидэнд нигүүлсэл болгон өгсөн эрх чөлөөг “махан биеийн төлөөх таатай боломж” болгон ашиглаж болохгүй, харин энэ нь биднийг бие биедээ хайраар үйлчлэхэд хүргэх учиртай (Галат 5:13).

в. Эвлэрүүлэл

“Эвлэрүүлэл” гэдэг нь хоёр талын дайсагналцал байхгүй болохыг хэлдэг. Тийнхүү эвлэрүүллийн үр дүн бол амар тайван юм.

Үл итгэгчид нь “Бурханы дайснууд” (Ром 5:10). Тийм ч учраас тэд Бурханы уур хилэнтэй нүүр тулах болдог (Ром 5:9). Энэ нь хувь хүн бүр Есүс Христэд итгэж, аврагдахаасаа өмнө (Иохан

3:16, 18, 36), Бурханы эсрэг өстөн дайсны байр сууринд (Ефес 2:3) байсан гэсэн үг юм. Есүс иудейчүүд болон харь үндэстнийг хоёуланг нь Бурхантай эвлэрүүлж, амар тайвныг тогтоохоор ирсэн (Ефес 2:16) бөгөөд Өөрийн биеийг өргөл болгон өргөж, амар тайвны үндэс суурийг тавьсан (Колоссай 1:22).

Бурхантай эвлэрүүлэхийн тулд нүглийн төлөөсийг төлөх хэрэгтэй байсан (2 Коринт 5:19). Есүс дайсагналцлын уг үндсийг устгасан бөгөөд Бурхан болон хүмүүсийн хооронд амар тайвныг тогтоох үйлчлэлийг бидэнд даалгасан (2 Коринт 5:18-21). Хоорондоо дайсагналцаж байгаа хоёр буюу хэд хэдэн хүнийг эвлэрүүлж, амар тайвныг тогтоох нь бидний эвлэрүүлийн үйлчлэлийн нэгэн хэсэг юм (Матай 5:9).

Бид Бурхантай эвлэрүүлсэн гэсэн энэхүү үнэн Бурханы хайрыг ямар агуу, ямар гайхалтай болохыг харуулдаг (Ром 5:8; Лук 6:31-35). Бүх хүн төрөлхтөн Бурхантай эвлэрэх боломжтой (Колоссай 1:20).

г. Тайтгаруулал

“Тайтгаруулал” гэдэг нь Ариун Бурханы зөвт байдал, шударга ёсыг хангах гэсэн утгатай. Үүнийг өргөлөөр дамжуулан хийдэг.

Бурхан гэм нүглээс болж хилэгнэн уурладаг. Бурханы уур хилэнгийн тухай үнэнийг Хуучин болон Шинэ гэрээнд хоёуланд нь маш тодорхой заасан байдаг (Дэд хууль 6:14-15; Иошуа 23:16; Дуулал 78:21; Иохан 3:36; Ром 1:18; Ефес 2:3; 1 Тесалоник 2:16 болон бусад). Мөн Бурхан бол энэрэнгүй бөгөөд нигүүлсэнгүй. Чарылз Райрын хэлсэнчлэн,

Хуучин гэрээний ойлголт нь учир шалтгаангүйгээр өөрийн сэтгэлийг хангахыг шаарддаг Бурхантай харанхуй будүүлэг шашин бус, харин Хуучин Гэрээний Бурхан бол гэм нүглийг анзаарахгүй өнгөрч чаддаггүй боловч хайрын улмаас Өөртэй нь нөхөрлөх замыг гаргаж өгдөг Бурхан юм.⁹⁹

Тийм ч учраас Бурханы уур хилэнг гүйцэлдүүлэн тайтгаруулах шаардлагатай байсан бөгөөд гэм нүгэлд хилэгнэсэн Бурханы уур хилэнг Есүс Христийн үхэл намжаасан юм (Ром 3:23-25). Есүс Өөрийн хайрыг харуулнаараа (1 Иохан 4:10) бүх хүн төрөлхтний эсрэг ассан Бурханы уур хилэнг тайтгаруулсан (1 Иохан 2:2). Энэ нь үргэлжид Бурханы Төлөвлөгөөний хэсэг, Есүс хүн болж мэндэлсний нэг чухал шалтгаан байсан юм (Еврей 2:17-18).

4. Есүс Христийн амилалт

“Амилалт” гэдэг нь үхлээс дахиж хэзээ ч үхэхгүй мөнхийн биетэй буцаж ирсэн нэгнийг дүрслэхэд хэрэглэдэг онцгой нэр томьёо юм (1 Коринт 15:42, 54). Энэ нь үхлээс эцэстээ дахин үхэх ижилхэн биетэй буцаж ирэх гэсэн утга бүхий “амь оруулах” гэдэг үгээс ялгаатай (Хаадын дээд 17:21-22; Хаадын дэд 4:34-35; Иохан 11:43).

Есүс Христ үхлээс амилсан. Есүс зүгээр унтсан эсвэл ухаан алдсан байгаагүй, харин үнэхээр үхсэн байсан гэдгийг Бичээст маш тодорхой хэлсэн байдаг (Матай 27:62-66; Марк 15:39, 44; Лук 23:48, 49; Иохан 19:33). Булш нь эш үзүүллэгийн биелэл байсан (Исаиа 53:9; Матай 27:57-58; Марк 15:42-45; Лук 23:50-52; Иохан 19:38) бөгөөд Есүсийг маалингтан даавуугаар ороож (Матай 27:59-60; Марк 15:46; Лук 23:53-54; Иохан 19:40-42), булшинд тавьсан (Матай 27:62-66). Иудейчүүд ч гэсэн Есүсийг оршуулсан гэдгийг мэдэж байсан төдийгүй булшийг нь лацдаж, Ромын дөрвөн харуулаар мануулсан (Матай 27:62-66). Хожим нь иудейчүүд Есүсийн шавь нар бисийг нь хулгайлсан гэсэн цуурхал тараасан байна (Матай 28:11-15; Марк 14:15).

Гурав дахь өдөрт бул чулууг нь уруу газар руу өнхрүүлж зайлцуулсан байсан (Матай 27:60-д “өнхрөх” гэсэн утгатай КУЛИО гэдэг грек үгийг хэрэглэсэн; Марк 16:3-4-д “өнхрүүлэх” гэсэн утгатай АНАКУЛИО гэдэг үгийг хэрэглэсэн; Лук 24:2-д өнхрүүлэн зайлцуулах гэсэн утгатай АПОКУЛИО гэдэг үгийг, Иохан 20:1-д зайлцуулагдсан гэсэн утгатай АИРО гэдэг үгийг хэрэглэсэн байдаг. Бул чулуу уруу газар руу өнхөрч, зайлцуулагдсан байжээ) бөгөөд булш хоосон байв. (Матай 28:5-8; Марк 16:2-8; Лук 24:1-8; Иохан 20:1).

Булшин дотор байсан бүх юм, тэр дундаа Есүсийн оршуулгын маалинган даавуун ороолт хэвээрээ үлдсэн байв. Тэд ер бусын хүч оролцохгүй л бол бие хөдөлж чадахааргүй болтол нь биеийг ороож тавьсан (Иохан 20:2-10) бөгөөд Есүсийн хувцсыг тайлаад, даавуугаар ороосон байжээ. Зөвхөн толгойн хэсгийн ороолт тайлгадсан байсан бөгөөд энэ нь бие байхгүй болсныг харуулж байв. Хэн нэг хүн биеийг ороосон даавуут тайлж, биеийг аваад, дараа нь даавууг буцааж ороосон гэж үзвэл яг хуучин байдлаар нь буцааж ороох боломжгүй бөгөөд цаг хугацааны хувьд ч амжихгүй байх байсан. Тэгэхээр бие шууд авагдсан байна.

Амилалтын дараа, Есүс Магдалын Мариад (Иохан 20:14); бусад эмэгтэйчүүдэд (Матай 28:9-10); Петрт (Лук 24:34; 1 Коринт 15:5); Еммау хүрэх замд явсан хоёр шавьд (Лук 24:13-33); Томасыг байхгүй үед элч нарт (Лук 24:36-43; Иохан 20:19-24) Томасыг байх үед дахин (Иохан 20:26-29); Галил нуур хавьд долоон шавь нарт (Иохан 21:1-23); Галил дахь уулан дээр 500 гаруй шавь нарт (1 Коринт 15:6); Өөрийн дүү Иаковд (1 Коринт 15:7); тэнгэр рүү дээш одох үедээ 11 шавь нарт (Матай 28:16-20; Лук 24:33-52; Үйлс 1:3-12); дээш одсоныхоо дараа Паулд (Үйлс 9:3-6; 1 Коринт 15:8) тус тус үзэгдсэн байна.

Христийн амилалт нь Есүс Христийн сайн мэдээний гол сэдвийн салшгүй чухал хэсэг юм (1 Коринт 15:1-3). Үүгээрээ Есүс дэлхийн бусад шашны удирдагчдаас ялгаатай бөгөөд өөр хэн ч үхлээс амилуулагдаагүй юм.

Есүс Өөрийгөө үхлээс амь орох болно гэдгийг тунхаглаж байсан (Матай 16:21; 17:9, 22-23; 20:18-19; 26:32; Марк 9:10; Лук 9:22-27) бөгөөд энэ үйл явдал түүхэнд үнэхээр бодитоор тохиолдоогүй байсан бол Түүний үйлчлэл бүхэлдээ худал хуурмаг зүйл болж, бид гэм нүглүүд дотроо өнөөг хүртэл байсаар байх байсан. (1 Коринт 15:16-17).

Есүсийг Бурхан Эцэг (Колоссай 2:12; 1 Тесалоник 1:10; 1 Петр 1:21; Еврей 13:20) Ариун Сүнсээр (Үйлс 2:24; Ром 8:11; 1 Петр 3:18) амилуулсан.

Есүс Христийн амилалт нь Түүний хэлж, үйлдэж байсан бүхэн үнэн агаад зөв сайн зүйл байсан гэдгийн нотолгоо (баталгаа) юм.

Христийн амилалтыг хүлээн зөвшөөрөх нь христитгэл дотор алхах үндэс суурь маань болдог (Ром 6:4).

5. Есүс Христийн дээш одолт

Христийн “Дээш одолт” гэдэг нь Есүс амилсныхаа дараа газар дэлхийгээс тэнгэр рүү буцаж явсныг хэлдэг. Есүс Эцэгийнхээ баруун гар талын суудалд буюу бүх бүтээлээс хамгийн дээд байр суурийг эзэлсэн (Дуулал 110:1; Ефес 1:20; Колоссай 3:1; Еврей 1:3, 13; 8:1; 10:12; 1 Петр 3:22).

Пентекостын өдрөөс арван хоногийн өмнө дээш одолт болсон. Дараа нь Есүс амласан ёсоор (Иохан 14:16-17) Ариун Сүнсийг илгээж (Үйлс 2:33), Өөрийн чуулганыг байгуулсан (Үйлс 1:9-11 уд.харьц. Үйлс 2). Түүний дээш одолт нь тэнгэр элч нарын тулаанд Есүс ялсан гэдгийн баталгаа юм (Еврей 1:3-13).

Есүс дээш өргөгдөхдөө, урьд нь нас барж, “Абрахамын өвөр” дээр байсан сүнснүүдийг Өөртэйгөө хамт авсан (Лук 16:22; Ефес 4:7-10). Тэр бас “хүмүүст бэлгүүдийг өгсөн” (Ефес 4:8) бөгөөд үүнийг Ариун Сүнс чуулганд хуваарилдаг байна (1 Коринт 12:11).

B. Есүс Христийн тэнгэрт залрах үе

Хоёр дахь удаагаа буцаж ирэх хүртлээ Эцэгийн баруун гар талд Христийн өнгөрөөж буй цаг хугацааг “тэнгэрт залрах үе” гэдэг. Энэ нь Түүний хувьд “дайснуудыг хөлийнх нь гишгүүр болгох” (Дуулал 110:1) хүртэл буюу эцсийн ялалт байгуулахаар газар дэлхий дээр буцаж ирэх хүртлээ Эцэгийн баруун гар талд залрах нь Бурханы төлөвлөгөөн дэх зайлшгүй зүйл байсан.

Тэнгэрт залрах үе нь Христийн дээш өргөгдөн өргөмжлөгдсөн байр суурь болон одоо Бурхан-хүн болж алдаршуулагдсан гэдгийг харуулдаг. Энэ нь “*“бүх эрх мэдэл Түүнд өгөгдсөн”*”, мөн “*“Түүний нэрэнд овдог бүхэн сөгдөх болно”*” гэсэн тэрхүү дүр зураг юм (Филиппой 2:9-10). Түүнчлэн энэ бол Даниел 7:13-14 дэх эш үзүүллэгийн биелэл юм.

Есүс Христ тэнгэрт заларч байх үедээ хүн төрөлхтөнд хандах дараах үйлчлэлийг хийдэг:

1. Зуучлан залбирагч

“Зуучлан залбирагчийн” хувьд Христ ариун хүмүүсийн төлөө Эцэгээс гүйдаг (Еврей 7:25). Үүнийг Ариун Сүнстэй хамт хийдэг (Ром 8:26, 27, 34) бөгөөд энэ нь мөн Эцэгийн хүслийн дагуу “*“бүхий л зүйл тэдний сайн сайхны төлөө”*” (Ром 8:28) байхыг Эцэгээс хүсэж буй хүсэлт юм.

2. Өмгөөлөгч

Бидний “Өмгөөлөгч” болох Есүс Бурханы хүүхдүүдийн эсрэг Сатаны мэдүүлдэг буруутгалд биднийг өмгөөлөн хариулдаг юм (1 Иохан 2:1; Илчлэлт 12:10).

3. Зууч

Бидний “Зууч” болох Есүс бол биднийг Бурхантай холбогч нэгэн буюу “дунд нь зогсож буй хүн” юм. Зууч гэдэг нь зөрчилдөж байгаа эсвэл зөвшилцэлд хүрэх хэрэгтэй байгаа талуудын төлөө ажилладаг хүн юм.

Есүс Христ бол Бурхан болон хүний хоорондох “зууч” юм (1 Тимот 2:5). Есүс Бурхан болон хүний хооронд хууль дээр бус харин нигүүлсэл дээр үндэслэгдсэн Шинэ гэрээг зуучилсан (Еврей 8:6-13). Мосгийн хуульд үндэслэгдсэн хуучин гэрээний дор үйлдэгдсэн гэм нүглүүдийн шийтгэлийн төлөөсөнд Есүсийн өргөсөн тахилын улмаас Шинэ гэрээ ирсэн юм (Еврей 9:13-15). Энэ Шинэ гэрээ мөнхөд үргэлжлэх болно (Еврей 12:22-24).

Есүс Өөрөө “*хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй*” (Иохан 14:6) хэмээн тунхаглахдаа Бурхан болон хүний хоорондох зууч гэдгээ илэрхийлсэн байдаг.

4. Тэргүүн тахилч

Эцэгийн шууд сонголтын дагуу Христ бол бидний “Агуу тэргүүн тахилч” юм. Есүс тахилчийн удам болох Леви овгоос төрөөгүй, тиймээс Есүсийн гарал үүсэлд үндэслэсэн тахилчийн байр суурийг эзлэх боломжгүй байсан (Еврей 5:4-10; 7:5-28). Есүс Христийн Тэргүүн тахилчлал бол Еврей номын гол сэдэв юм.

Есүс бол Левийн тахилчлал бий болохоос 400 жилийн өмнө, Абрахамын үед амьдарч байсан Мелхизедектэй адилхан Тэргүүн тахилч юм (Еврей 7:1-3). Хүмүүн чанартай нэгэн л энэхүү тахилчлалыг хийж чадах байсан, тийнхүү Есүс хүмүүн чанартай болсноороо хүн төрөлхтөнд өршөөнгүй агаад итгэмжит байж чадсан бөгөөд Эцэгтэй эвлэрүүлсэн билээ (Еврей 2:17; 4:14-15). Есүсийн тахилчлал үүрд мөнхөд байна (Еврей 6:20; 7:3, 24).

Тахилч хүн тахил өргөх үүрэгтэй (Еврей 8:1-3). Есүс Өөрийгөө (Еврей 9:6-14) “*“бүх цаг үеийн төлөө нэг өргөл”*” (Еврей 10:10, 12) болгон өргөсөн. Тиймээс Есүсийн “зуучлан залбирал”, “зууч”-ийн ажлууд нь Түүний Тэргүүн тахилчийн үйлчлэлээс үүдэлтэй.

Чуулган дахь бүх хүн тахилчид (1 Петр 2:5, 9; Илчлэлт 1:6) учраас бид Есүс Христийг дуурайж (1 Коринт 11:1), өөрсдийгөө Бурханы хүслийн дагуух өргөл болгон өргөдөг (Ром 12:1).

5. Чуулганы тэргүүн

Есүс Христ бол Чуулганы удирдагч буюу “тэргүүн” юм (Ефес 1:22-23; Колоссай 1:18). Есүс Христэд итгэгч хэн бүхэн Чуулган гэж нэрлэгддэг Христийн “сүйт бүсгүй” буюу “бие”-ийг бүрдүүлдэг (1 Коринт 12:13).

Есүс бол чуулганы амлагдсан нөхөр (Ефес 5:23) бөгөөд Тэрээр үл өөрчлөгдөх хайраараа үргэлжид хайлдаг (Ефес 5:25-27). Жинхэнэ “хурмын ёслол” Христийн хоёр дахь ирэлтийн өмнөхөн тэнгэрт болох болно (Илчлэлт 19:7-10 уд.харьц. 11-16), гэхдээ одоо ч гэсэн хайлаж, итгэмжит байдаг юм. “Сүйт бүсгүй” болох чуулган нь нөхөрт гарахад бэлтгэж байна (Ефес 4:15; 5:26-27).

6. Хоньчин

“Пастор” гэдэг нэр томьёо нь үнэндээ “хоньчин” гэсэн утгатай үг юм. Христ бол “Сайн Хоньчин” бөгөөд хоньдынхоо төлөө амиа өгсөн (Иохан 10:11). Энэ нь Түүний “Агуу Хоньчин” болохыг харуулдаг (Еврей 13:20).

Эцэгийн баруун гар талд, тэнгэрт заларч буй Есүс бол Өөрийн хоньдыг удирдаж, бас хамгаалж байдаг “Ахлах Хоньчин” юм (1 Петр 5:4).

Г. Есүс Христийн талаарх дүрслэлүүд:

- “**Өмгөөлөгч**” - Есүс Эцэгийн өмнө биднийг хамгаалан ярьдаг гэдгийг илэрхийлдэг. 1 Иохан 2:1
- “**Альфа ба Омега**” - грек цагаан толгойн эхний болон сүүлийн үсэг. Есүс бол Бурхантай харилцах харилцааны үндэс суурь гэдгийг үүгээр илэрхийлдэг. Илчлэлт 1:8; 21:6; 22:13
- “**Амен**” - Есүс бол аливаа амлалт дахь сүүлчийн үг гэсэн санааг илэрхийлдэг. 2 Коринт 1:20; Илчлэлт 3:14
- “**Тослогдсон Нэгэн**” - Есүсийг Мессиагаар сонгосон мөнхийн бурханлаг сонголтыг илэрхийлдэг. 1 Самуел 2:35; Шастирын дэд 6:42; Дуулал 2:2; 28:8; 84:9; 89:38, 51; 132:10, 17; Даниел 9:25-26; Үйлс 4:26
- “**Элч**” - Есүс эрх мэдэлтэйгээр илгээгдсэн гэсэн санааг илэрхийлдэг. Еврей 3:1
- “**Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч**” - Христ Бурхан болохынхоо хувьд Төлөвлөгөө зохиож, хүн болохынхоо хувьд тэрхүү төлөвлөгөөг гүйцэлдүүлсэн гэсэн утгатай. Еврей 12:2
- “**Авралын Зохиогч**” - Есүсийн авралд үндсэн үүргийг гүйцэтгэсэн гэдгийг илэрхийлдэг. Еврей 2:10
- “**Эхлэл ба Төгсгөл**” - Есүс бол амьдралын хамгийн гол зүйл гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 21:6; 22:13
- “**Бурханы бүтээлийн Анхдагч**” - Есүс бол Бурханы бүтээлийн захирагч гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 3:14
- “**Ереөлт бөгөөд цорын ганц хэмжээлшгүй Эрхт**” - Есүст хамгийн дээд эрх мэдэл байдаг гэдгийг илэрхийлдэг. 1 Тимот 6:15
- “**Эзэний Мөчир**” - Есүсийн хүмүүн чанар Түүний бурхан чанараар нь тэтгэгддэг болохыг илэрхийлдэг. Исаиа 4:2
- “**Бурханы талх**” - Есүсийн бурханлаг дэмжлэгийг илэрхийлдэг. Иохан 6:33, 51
- “**Амийн талх**” – Есүс бол амьдралын хэрэгцээг хангагч цорын ганц Нэгэн гэсэн утгатай. Иохан 6:35, 48
- “**Болзоот залуу**” – Есүс итгэгчидтэй ойр дотно харилцдаг бөгөөд тэднийг хамгаалдаг гэсэн санааг илэрхийлдэг. Исаиа 62:5; Матай 9:15; 25:1, 5, 6, 10; Марк 2:19, 20; Лук 5:34, 35; Иохан 2:9; 3:29; Илчлэлт 18:23
- “**Гэрэлт үүрийн цолмон**” - Есүс бол сүнслэг харанхуйн дундах гэрэлт од гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 22:16
- “**Ахлах Хоньчин**” - Есүс сүргийнхээ төлөө хариуцлага хүлээдэг гэсэн утгатай. 1 Петр 5:4
- “**сонгогдсон чулуу, үнэт булангийн чулуу**” - Есүс бол аливаа хэмжүүрийн жишиг байхаар онцгойлон сонгогдсон гэсэн санааг илэрхийлдэг. Булангийн чулуугаар тухайн байшингийн стандарт буюу жишигийг тогтоодог. Еврей 2:20; 1 Петр 2:4, 6

- “**Өөрийн Эзэн Христ Есүс**” – Есүс гэдэг хүн бол Мессия бөгөөд миний амьдралын Эзэн гэсэн утгатай. Филиппой 3:8
- “**Бидний найдвар болох Христ Есүс**” – Мессия Есүс бол бидний ирээдүйн итгэл найдвар гэдгийг илэрхийлдэг. 1 Тимот 1:1
- “**Бурханы Христ**” - Түүнийг Мессия болгон сонгосон гэсэн утгатай. Лук 9:20; 23:35
- “**Тэнгэрийн түмэн цэргийн Жанжин**” - Есүс бүх армийг захирах эрх мэдэлтэй гэсэн санааг илэрхийлдэг. Даниел 8:11
- “**Израилийн тайтгарал**” - Христийн өгдөг урам зоригийг хэлжээ. Лук 2:25
- “**Ард түмний гэрээ**” - Есүс бол итгэгчдэд өгөгдсөн шинэ гэрээний үндэс суурь гэсэн утгатай. Исаиа 42:6
- “**Үүд**” - Есүс бол Бурханы хаанчлал уруу орох үүд мөн гэдгийг харуулдаг. Иохан 10:7, 9
- “**Мөнхийн Эцэг**” - Есүс үргэлж Бурхан байсан гэдгийг бидэнд харуулдаг. Исаиа 9:6
- “**Мөнх амь**” - энэ бол хийсвэр ойлголт биш, харин хүнд байдаг бодит зүйл гэдгийг заадаг. 1 Иохан 1:2
- “**Мөнхийн Хад**” - Есүс дотор үргэлжид тогтвортой байх боломжтой гэдгийг заадаг. Исаиа 26:4
- “**Түүний мөн чанарын бодит илэрхийлэл**” - Махан биед ирсэн амьд Бурхан болох Христийн хүмүүн мөн чанарыг илэрхийлдэг. Еврей 1:3
- “**Итгэмжит бөгөөд Үнэн**” - Есүсийн тууштай бөгөөд үнэнч шударга байдлыг илэрхийлдэг. Илчлэлт 19:11
- “**Итгэмжит бөгөөд үнэн Гэрч**” – Есүс эш үзүүллэгийн үйл явдлуудад тууштай бөгөөд шударга ханддаг гэдгийг заадаг. Илчлэлт 3:14
- “**Итгэмжит Гэрч**” - Есүсийн амилалтын гэрчлэлийг заадаг. Илчлэлт 1:5
- “**Эхэн ба Эцэс**” - Есүс бол бүх бүтээлийн цорын ганц эх сурвалж гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 1:17; 2:8; 22:13
- “**Үхэгдээс анх төрсөн нь**” – Есүс анх удаа үхлийг ялан дийлж, амилсан биеийг хүлээн авсан гэдгийг илэрхийлдэг. Колоссай 1:18; Илчлэлт 1:5
- “**Бүх бүтээлийн Ууган нь**” - Есүс бүх бүтээлийн эхлэл гэсэн утгатай. Колоссай 1:15
- “**Нойрсогдоос анхны Үр жимс мөн**” - Есүс бол амилалтын анхны ерөөл мөн гэсэн утгатай. 1 Коринт 15:20
- “**Анхилуун үнэр**” - Есүсийн тахилаас ирэх ерөөлийг илэрхийлдэг. Ефес 5:2
- “**Татвар хураагч болон нүгэлтиүүдийн анд нөхөр**” – Хуулийг зөрчигчид болон нийгмээс гадуурхагдагсын төлөөх Есүсийн хайр халамжийг илэрхийлдэг. Матай 11:19; Лук 7:34
- “**Таны ард түмэн болох Израилийн Алдар**” - Есүс магтаал хүндлэлийг авах зохистой гэдгийг илэрхийлдэг. Лук 2:32
- “**Бүх дэлхийн Бурхан**” – бүх хүн төрөлхтөнтэй харилцах Есүсийн харилцааг илэрхийлдэг. Исаиа 54:5
- “**Бүгдийн дээр оршигч Бурхан**” - Израилийн Бурхан гэдгийг онцгойлон илэрхийлсэн. Ром 9:5
- “**Сайн Хоньчин**” - Есүсийн удирдлага болон хамгаалалтын мөн чанарыг илэрхийлдэг. Иохан 10:11
- “**Агуу Тэргүүн Тахилч**” - Есүс үүрэгт ажлаа ямар чадварлагаар гүйцэтгэдэг болохыг илтгэн харуулдаг. Еврей 4:14
- “**Агуу Гэрэл**” - Есүс харанхуйг хэрхэн зайлцуулдаг тухай илэрхийлдэг. Исаиа 9:2; Матай 4:16
- “**Агуу Хоньчин**” - Есүсийн удирдлага болон хамгаалалтын давуу байдлын илэрхийлдэг. Еврей 13:20
- “**Сайн гэрээний Батлан даагч**” - Есүс бол Бурхантай байгуулсан илүү сайн гэрээний амлалт байсан гэдгийг илэрхийлдэг. Еврей 7:22

- “Сэтгэлийн чинь Харгалзагч” - Есүс итгэгчдийн сэтгэлийн хамгаалдаг тухай өгүүлдэг. 1 Петр 2:25
- “Тэргүүн” - Есүсийн удирдлагын цаана байдаг оюуны чадамжийн илэрхийлдэг. 1 Коринт 11:3; Ефес 4:15; Колоссай 2:19
- “Харь үндэстнүүдийг захирахын тулд босох Түүнд” - Христийн эрх мэдэл Харь үндэстнүүдийг хүртэл захирна гэсэн утгатай. Ром 15:12
- “Тэр Ариусгагч” – хүмүүсийг үйлчлэлд сонгох Эзэний чадварыг илэрхийлдэг. Еврей 2:11
- “Тэр оюун санааг хийгээд зүрхийг Нягтлагч” - хүн төрөлхтний хандлагыг (сэдэл) тодорхойлох Есүсийн чадварыг илэрхийлдэг. Илчлэлт 2:23
- “Биеийн Тэргүүн” - Чуулган дахь Есүсийн ухаалаг удирдлагыг илэрхийлдэг. Колоссай 1:18
- “Чуулганы Тэргүүн” – Итгэгчдийн дундах Есүсийн ухаалаг удирдлагыг илэрхийлдэг. Ефес 5:23
- “Бүх удирдлага ба эрх мэдлийн Тэргүүн” - Есүсийн туйлын эрх мэдлийг илэрхийлдэг. Колоссай 2:10
- “Бүхнийг Өвлөгч” – Бурханы Хүүгийн хувьд Есүс бүх зүйлийг өвлөн авсныг илэрхийлдэг. Еврей 1:2
- “Тэргүүн Тахилч” - Есүсийн байр суурийг илэрхийлдэг. Еврей 2:17; 3:1; 4:14, 15; 5:5, 10; 6:20; 7:26; 8:1; 9:11; 13:11-12
- “Биднийг хайрладаг бөгөөд Өөрийнхөө цусаар биднийг нүглээс минь чөлөөлсөн” – Христ биднийг хайрласан учраас бидний гэм нүглийг училсан гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 1:5
- “Өөрийн цорын ганц Хүү” - Есүс Христ бол бүх бүтээлийн дотор туйлын онцгой гэдгийг илэрхийлдэг. Иохан 3:16; Еврей 11:17; 1 Иохан 4:9
- “Ариун агаад Зөвт Нэгэн” - Есүсийн төгс мөн чанарыг илэрхийлдэг. Ўйлс 3:14
- “Бурханы Ариун Нэгэн” - Есүсийн энэ дэлхий дээрх амьдрал төгс байсныг илэрхийлдэг. Марк 1:24; Лук 4:34; Иохан 6:69
- “Ариун Зарц” - Есүс хүүхэд адил дуулгавартай байдалд суралцсан гэдгийг илэрхийлдэг. Ўйлс 4:27, 30 (энд хэрэглэгдсэн ПАИС гэдэг грек үг “хүүхэд” гэсэн утгатай)
- “Израилийн найдвар” - Израилийг итгэл найдварын жинхэнэ үндэс суурь хэмээн заадаг. Иеремиа 14:8; 17:13; Ўйлс 28:20
- “Авралын эвэр” – авралд хүрэхэд шаардлагатай хүч чадлын илэрхийлдэг. Лук 1:69
- “Үл үзэгдэгч Бурханы дүр” - Есүс бол махан биед ирсэн Бурхан гэсэн утгатай. Колоссай 1:15
- “Иммануел” - “Бидэнтэй хамт буй Бурхан” гэсэн утгатай еврей үг. Исаиа 7:14; 8:8; Матай 1:23
- “Зүйрлүүлшгүй бэлэг” - Христийн сүр жавхланг үгээр бүрэн илэрхийлэх аргагүй гэдгийг илэрхийлдэг. 2 Коринт 9:15
- “Назарын Есүс” - Есүс аль хотод өссөнийг илэрхийлдэг. Матай 26:71; Марк 1:24; 10:47; Лук 4:34; 18:37; 24:19; Иохан 1:45; 18:5, 7; Ўйлс 2:22; 6:14; 10:38; 22:8; 26:9
- “Амьд, үхсэн бүх хүмүүсийн Шүүгч” – Есүс бүх дэлхийг шүүх эрх мэдэлтэй гэдгийг илэрхийлдэг. Ўйлс 10:42; 2 Тимот 4:1
- “Хаадын Хаан” – Есүс хамгийн дээд эрх мэдлийг ч захирдаг гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 19:16
- “Үндэстнүүдийн Хаан” - Есүс улс төрийн бүлгүүдээс дээгүүр эрх мэдэлтэй гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 15:3
- “Бурханы Хурга” - Бурханы зөвт байдлыг хангахын тулд Есүс Өөрийгөө тахил болгон өргөснийг илэрхийлдэг. Иохан 1:29, 36
- “Сүүлчийн Адам” - Есүс бол ямар ч нүгэлгүйгээр оршин байхаар ирэх сүүлчийн хүн гэдгийг илэрхийлдэг. 1 Коринт 15:45
- “Амь” - жинхэнэ амь бол зүгээр л бие махбодийн нөхцөл байдал биш, мөн Христийн бодгальд байдаг гэдгийг илэрхийлдэг. Иохан 1:4; 11:25; 14:6
- “Амь өгөгч Сүнс” - Есүс Ариун Сүнстэй нэгдмэл гэдгийг илэрхийлдэг. 1 Коринт 15:45

- “Харь үндэстэнд илчлэлтийн гэрэл” - Есүс бүх хүн төрөлхтний төлөө илчлэгдэх ёстой байсныг илэрхийлдэг. Лук 2:32
- “Амийн гэрэл” – Амьдралын хүнд хэцүү цаг мөч бүрд Есүс биднийг удирдан залж байдаг гэдгийг илэрхийлдэг. Иов 33:30; Дуулал 49:19; 56:13; Иохан 8:12
- “Хүмүүсийн гэрэл” - бүх хүн төрөлхтөнд Есүсийн санал болгодог удирдлагыг илэрхийлдэг. Иохан 1:4
- “Дэлхийн гэрэл” - дэлхийн сүнслэг харанхуйн дундах Есүсийн удирдлагыг илэрхийлдэг. Иохан 8:12; 9:5
- “Амьд Нэгэн” - Есүсийн амилалтын мөнх чанарыг илэрхийлдэг. Илчлэлт 1:17-18
- “Амьд Чулуу” - Есүсийн өгдөг бат тогтвортой байдлыг илэрхийлдэг. 1 Петр 2:4
- “Эзэн” - Есүсийн эрх мэдлийг илэрхийлдэг. Үйлс 4:24; Илчлэлт 6:10
- “Эзэн бөгөөд Аврагч Есүс Христ” - Есүс хүн төрөлхтнийг нүүглээс чөлөөлөхийн тулд Өөрийн эрх мэдлийг ашигласан гэдгийг илэрхийлдэг. 2 Петр 1:11, 20; 3:18
- “Алдрын Эзэн” - Есүсийн эрх мэдлийн гайхамшигт мөн чанарыг илэрхийлдэг. 1 Коринт 2:8
- “Эздийн Эзэн” - Есүс бүгдийг захирах эрх мэдэлтэй гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 19:16
- “Амар тайвны Эзэн” - Бурхан болон хүний хооронд амар тайвныг тогтоохын тулд Өөрийн эрх мэдлийг ашиглах гэсэн Есүсийн хүчлийг илэрхийлдэг. 2 Тесалоник 3:16
- “Ургацын Эзэн” – Сайн мэдээ түгээлт дэх Есүсийн дээд эрх мэдлийг илэрхийлдэг. Матай 9:38; Лук 10:2
- “Амралтын өдрийн Эзэн” - Арван хуулийн дөрөв дэхтэй холбоотой Есүсийн дээд эрх мэдлийг заадаг. Матай 12:8; Лук 6:5
- “ЭЗЭН бол бидний зөв шударга” - Есүс бол зөв шударгын үлгэр жишээ бөгөөд эх сурвалж гэдгийг илэрхийлдэг. Иеремиа 23:6; 33:16
- “Бурхан энэ хүнийг та нарт үзүүлсэн” – Бурхан Есүсийг дэмжин баталсан гэдгийг илэрхийлдэг. Үйлс 2:22
- “Хүн нь тэнгэрээс” - Есүсийн бурханлаг мөн чанарыг илэрхийлдэг. 1 Коринт 15:47
- “Үй гашууны хүн” - Өөрийг нь байнга эсэргүүцэгч хүн төрөлхтний төлөөх Есүсийн шаналлыг илэрхийлдэг. Исаиа 53:3
- “Эзэн” - Есүсийн давуу эрх мэдэл буюу чадамжийн илэрхийлдэг. Лук 5:5; 8:24, 45; 9:33; 17:13; Ефес 6:9; Колоссай 4:1; 2 Тимот 2:21
- “Шинэ гэрээний зууч” - Бурхантай илүү сайн гэрээг байгуулсан Нэгэн бол Есүс гэдгийг илэрхийлдэг. Еврей 9:15; 12:24
- “Өршөөнгүй, итгэмжит Тэргүүн Тахилч” - Есүсийн ажил үйлчлэлийн энэрэнгүй бөгөөд тууштай байдлыг илэрхийлдэг. Еврей 2:17
- “Гэрээний элч” – Бурхантай байгуулах шинэ гэрээний тухай мэдээг авчрагч гэдгийг илэрхийлдэг. Малахи 3:1
- “Мессия” - Бурханы ард түмнийг гэм нүүглээс чөлөөлөхөөр Бурханаар сонгогдсон Нэгэн гэсэн утгатай. Иохан 1:41; 4:25
- “Агуу хүчирхэг Бурхан” - Есүсийн Бурхан чанар ямар хүчтэй болохыг илэрхийлдэг. Исаиа 9:6
- “Үүрийн цолмон” - Харанхуйн дундах оддоос Есүс хамгийн хурц гэрэлтдэг гэсэн утгыг илэрхийлдэг. 2 Петр 1:19; Илчлэлт 22:16
- “Назарынх” - Есүсийг тохуурхсан нэр байсан. Матай 2:23
- “Давидын удам” - Есүсийн хүмүүн гарал нь Давид хааны удмаас эхтэй гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 22:16
- “Эцэгтэй хамт Нэгэн” - Бурханы төгс мөн чанарын нэгдмэл байдлыг илэрхийлдэг. Иохан 10:30
- “Эцэгийн цорын ганц Хүү” – Есүсийн хосгүй хувь чанарыг илэрхийлдэг. Иохан 1:14, 18

- “**Бидний Аврагч болох цорын ганц Бурхан**” - Есүсийн хосгүй хувь чанар болон ажил үйлчлэлийн онцгой байдлыг илэрхийлдэг. Иуда 1:25
- “**Бидний алдрын Эзэн**” - Есүс итгэгчдийн дунд агуу эрх мэдэлтэй гэдгийг илэрхийлдэг. Иаков 2:1
- “**Бидний Бурхан ба Аврагч**” - Есүсийн бодгаль болон Чуулган дахь үйлчлэлийн харилцан хамаарлыг илэрхийлдэг. 2 Петр 1:1
- “**Бидний амь**” - Есүсийн Чуулганд өгдөг амийг илэрхийлдэг. Колоссай 3:4
- “**Бидний Эзэн**” – Есүсийн эрх мэдлийг Чуулганд хүлээн зөвшөөрдөг гэдгийг илэрхийлдэг. Ром 1:4; 5:21; 7:25; 1 Коринт 1:9; Иуда 1:25
- “**Бидний цорын ганц Эзэгнэгч ба Эзэн**” - Чуулганы Есүсийн давуу байдал болон эрх мэдлийг хүлээн зөвшөөрсөн байдлын илэрхийлдэг. Иуда 1:4
- “**Бидний Дээгүүр Өнгөрөх баяр**” - Чуулганы төлөө Есүсийн өргөсөн тахилыг илэрхийлдэг. 1 Коринт 5:7
- “**Бидний энх тайван**” - Бурхан болон Чуулганы хооронд энх тайвныг тогтоох тухай өгүүлдэг. Ефес 2:14
- “**Бидний Аврагч**” – Есүс Чуулганыг гэм нүглээс чөлөөлснийг илэрхийлдэг. Тит 3:6
- “**Эмч**” - Есүсийн эдгээх чадварыг илэрхийлдэг. Лук 4:23
- “**Захирагч ба Аврагч**” – Есүс амь ба авралыг удирддаг гэсэн утгатай. Ўйлс 5:31
- “**Амийн Зохиолч**” - Есүс амийг удирддаг гэсэн санааг илэрхийлдэг. Ўйлс 3:15
- “**Энхийн Жонон**” - Есүс дэлхий ертөнц болон Бурханы хооронд харилцан зохицлыг тогтоодог гэсэн санааг илэрхийлдэг. Исаиа 9:6
- “**Жононгуудын Жонон**” - Есүсээс агуу удирдагч байхгүй гэсэн утгатай. Даниел 8:25
- “**Эш үзүүлэгч**” - Есүс Өөрөө эш үзүүлэгийн биелэл гэдгийг илэрхийлдэг. Дэд хууль 18:18-ийг Ўйлс 3:22-той харьцуул.
- “**Бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл**” - Есүс Эцэгийнхээ зөвт бөгөөд шударга байдлыг хангасан гэсэн санааг илэрхийлдэг. 1 Иохан 2:2
- “**Цэвэршүүлэгч**” - хүн төрөлхтнийг гэм нүглээс чөлөөлөхийн төлөө хийж буй Есүсийн ажил үйлсийг илэрхийлдэг. Малахи 3:3
- “**Түүний алдрын туяа**” - Эцэгийн мөн чанар ямар агуу болохыг илэрхийлдэг. Еврей 1:3
- “**Бүгдийн төлөөх золиос**” - Есүс биднийг чөлөөлөхийн тулд үнэ төлсөн гэсэн утгатай. 1 Тимот 2:6
- “**Амилалт ба амь**” - Есүс Христийн бодгалиар дамжуулан мөнх амь уруу амилах боломжтой гэдгийг бидэнд заадаг илэрхийлдэг. Иохан 11:25
- “**Шударга Шүүгч**” - Есүс Өөрийн төгс жишгийн дагуу шийтгэл ба шагналыг оноодог гэсэн санааг илэрхийлдэг. Дуулал 7:11; 2 Тимот 4:8
- “**Зөвт Нэгэн**” - Есүс Өөрийн төгс жишгүүдийг хувьчлан төгс хэрэгжүүлдэг гэдгийг илэрхийлдэг. Исаиа 24:16; Ўйлс 3:14; 7:52; 22:14; 1 Иохан 2:1
- “**Давидын удам ба үндэс**” – Давидын удмыг бий болгоход Есүсийн мөнх чанар оролцсон гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 22:16
- “**Газрын хаадын Захирагч**” – Газар дэлхий дээрх хамгийн дээд эрх мэдлийг ч Есүс захирдаг гэдгийг илэрхийлдэг. Илчлэлт 1:5
- “**Ертөнцийн Аврагч**” - зөвхөн Есүс л гэм нүглээс чөлөөлж чадна гэдгийг илэрхийлдэг. Иохан 4:42; 1 Иохан 4:14
- “**Хоньчин**” – Хайртай хүмүүстээ үзүүлдэг Түүний хайр халамжийг илэрхийлдэг. Эхлэл 49:24; Дуулал 80:1; Номлогчийн үгс 12:11
- “**Сэтгэлийн чинь Хоньчин**” – Хүний материаллаг бус хэрэгцээний төлөөх Есүсийн хайр халамжийг илэрхийлдэг. 1 Петр 2:25
- “**Ард түмний туг**” – хүмүүсийн хайх ёстой хүн бол Есүс мөн гэдгийг илэрхийлдэг. Исаиа 11:10

- “**Бурханы Хүү**” - Гурвал доторх Есүсийн холбоо хамаарлыг илэрхийлдэг. Иохан 10:36; 11:4
- “**Амьд Бурханы Хүү**” – Есүс ямар нэг шүтээнтэй бус, харин амьд Бурхантай холбоотой гэдгийг гэрчилдэг. Матай 16:16
- “**Хамгийн дээд Бурханы Хүү**” - тэнгэр элч нар Есүсийг хэрхэн үздэгийг илэрхийлдэг. Марк 5:7; Лук 8:28
- “**Мөнх авралын эх үндэс**” - Есүс бол авралын үндэс суурь гэдгийг илэрхийлдэг. Еврей 5:9
- “**Чиний цаг хугацааны бат суурь**” - амьдралд тохиолдох дайралт довтолгоог тэсэж гарах чадварыг илэрхийлдэг. Исаиа 33:6
- “**Чулуу**” - Есүс бол хүн төрөлхтний амьдралын бат суурь гэдгийг илэрхийлдэг. Исаиа 28:16
- “**Барилгачдын голсон чулуу**” - Израилийн удирдагчдын сонгосон бат суурь гэсэн санааг илэрхийлдэг. Дуулал 118:22; Матай 21:42; Марк 12:10; Лук 20:17; 1 Петр 2:7
- “**Багш**” (**Рабби**) - Есүсийн зааж сургах чадварын илэрхийлдэг. Иохан 20:16
- “**Шалгагдсан чулуу**” - Христийн амьдралын туршлагыг илэрхийлдэг. Исаиа 28:16
- “**Гэрчлэл нь өөрийнхөө зохистой цагт өгөгдөв**” - Бурханы төгс цагт илчлэгдсэн Есүсийн гэрчлэлийг илэрхийлдэг. 1 Тимот 2:6
- “**Жинхэнэ талх**” - Есүс бол Бурханаас өгөгдсөн жинхэнэ сүнслэг хоол гэсэн санааг илэрхийлдэг. Иохан 6:32
- “**Жинхэнэ гэрэл**” - Есүсийн үнэний илчлэлт алдаа мадаггүй гэдгийг илэрхийлдэг. Иохан 1:9; 1 Иохан 2:8
- “**Жинхэнэ усан үзмийн мод**” - Есүс бол сүнслэг үр жимсний (сайн үйлс) сүнслэг хангагч гэдгийг илэрхийлдэг. Иохан 15:1
- “**Үнэн**” - Есүсийн амьдрал бүхий л талаараа төгс төгөлдөр байсныг илэрхийлдэг. Иохан 5:33; 8:31-32; 14:6
- “**Зам**” - Есүс бол авралын эх сурвалж, бурханлаг удирдамж гэдгийг илэрхийлдэг. Матай 7:14; Иохан 14:5-6
- “**Авралын баялаг**” - хүн төрөлхтний аврал дахь Есүсийн үнэ цэнийг илэрхийлдэг. Исаиа 33:6
- “**Мэргэн ухаан**” - Бурханы үгэн дэх бүх зүйлийг ойлгох, зөв зохистой хэрэгжүүлэх Есүсийн чадварыг илэрхийлдэг. Исаиа 33:6
- “**Бидний хувьд мэргэн ухаан, зөвт байдал, ариусгал ба золилт болсон Нэгэн**” - Аврал болон сүнслэг төлөвшилт нь ямар нэгэн ухагдахуунд, харин Есүсийн бодгальд илэрхийлэгдсэн гэсэн утгатай. 1 Коринт 1:30
- “**Бурханаас ирсэн мэргэн ухаан болсон Нэгэн**” - мэргэн ухаан ч бас Есүсийн бодгаль дотор илэрхийлэгддэг гэсэн утгатай. 1 Коринт 1:30
- “**Хүмүүсийн гэрч**” - хүн төрөлхтөнд Есүсийн өгсөн гэрчлэлийг илэрхийлдэг. Исаиа 55:4
- “**Гайхамшигт Зөвлөгч**” - хүнд хэцүү цагт хэрэгцээтэй төгс тусlamжийг Есүс өгөх чадвартай гэдгийг илэрхийлдэг. Исаиа 9:6
- “**Үг**” - Есүс бол бүхий л харилцааны эх үндэс мөн гэдгийг заадаг. Дуулал 119:81; Иохан 1:1, 14; 1 Иохан 1:1; Илчлэлт 19:13
- “**Бурханы Үг**” - Есүс бол Бурханаас ирэх бүх харилцааны үндэс суурь гэсэн утгатай. 2 Петр 3:5; Иохан 1:1-5; Илчлэлт 19:13
- “**Амийн үг**” - Есүс бол амьд бүнхий үндэс суурь гэсэн утгатай. Филиппой 2:16; 1 Иохан 1:1
- “**Чиний нөхөр**” - Есүстэй тогтоож болох хамгийн дотно харилцааг илэрхийлдэг. Исаиа 54:5
- “**Чамайг Бүтээгч**” – Есүс бол хүн төрөлхтнийг Бүтээгч гэдгийг илэрхийлдэг. Исаиа 54:5
- “**Чиний Аврагч**” - Хүн төрөлхтний нүглийн төлөөсийг төлсөн Нэгэн бол Есүс гэдгийг илэрхийлдэг. Исаиа 54:5
- “**Таны Аврал**” - Хүн төрөлхтнийг нүглээс аварсан Нэгэн бол Есүс гэдгийг илэрхийлдэг. Лук 2:29-30

Хувийн Судлал: 5-р бүлэг, 4-р хэсэг

1. **Колоссай 1:16, Иохан 8:58-ыг унш. Есүс Христийн бодгалийн тухай бидэнд юуг өгүүлж байна вэ?**
2. **Матай 22:41-46 ишлэлийг унш. Мессиа хэрхэн Давид хааны Эзэн, мөн Түүний хүү болж төрсөн бэ?**
3. **1 Петр 2:22-ыг унш. Есүс Христийн амьдрал дахь гэм нүглийн талаар бидэнд юуг өгүүлж байна вэ?**
4. **Исаиа 7:14; 9:6; 11:1-2, 53:2-ыг унш. Мессиа ирэх тухай энд өгүүлсэн зүйлсийн талаар товч дүгнэлт бичээрэй.**
5. **Дараах багцлалуудыг уншаад, Есүсийн үхэл бидний төлөө юу хийсэн бэ гэдгийг хэлнэ үү:**
 - А. Галат 3:1
 - Б. Колоссай 1:13-14
 - В. Ефес 2:14-16
 - Г. 1 Иохан 2:1-2
6. **Дараах багцлалуудыг уншаад, Есүсийн амилалтын тухай зарим баримтуудыг хэлнэ үү:**
 - А. Матай 27:62-66
 - Б. Иохан 20:2-10
 - В. Иохан 20:14; Матай 28:9-10; Иохан 20:26-29; 21:1-23; 1 Коринт 15:6
 - Г. 1 Коринт 15:1-3
7. **Үйлс 1:9, Колоссай 3:1-ийг унш. Христ амилсныхаа дараа юу хийсэн бэ?**
8. **Дараах багцлалуудаас Есүс одоо Эцэгийнхээ баруун гар талд, тэнгэрт заларч байх үедээ юу хийж байгааг дүрслэн өгүүлнэ үү:**
 - А. Еврей 7:25
 - Б. 1 Иохан 2:1
 - В. 1 Тимот 2:5
 - Г. Еврей 4:14
9. **Ефес 1:22-23 ишлэлийг унш. Христ чуулганы хувьд хэн бэ?**
10. **Иохан 10:11, Еврей 13:20, 1 Петр 5:4-ийг унш. Бидний Эзэн ямар төрлийн “Хоньчин” бэ?**
11. **“Г” хэсэг дэх Хүүгийн бодгаль болон үүргийн тухай дүрслэлүүдийг дор өгүүлсэн Хүүгийн ажилтай холбоно уу. Дахин хэлэхэд, эдгээр дүрслэл нь нэгээс илүү категорид тохирч болно. Та хүсвэл энэ номд гарч буй Хүүгийн ажлыг 1, 2, 3 гэх мэтээр тэмдэглэж болно.**
 - А. Есүс өмнө нь оршин байсан
 - Б. Бурхан-Хүний нэгдэл
 - В. Есүсийн төгс байдал
 - Г. Есүсийн төрөлт, амьдрал
 - Д. Есүсийн үхэл
 - Е. Есүсийн амилалт
 - Ё. Есүсийн дээш одолт, тэнгэрт заларсан нь
 - Ж. Есүсийн үйлчлэл

5-р хэсэг

Бурхан Ариун Сүнс (Пниоматологи)

A. Ариун Сүнсний бодгаль¹⁰⁰

Ариун Сүнс бол Бурхан гэдэг нь хэдийнээ батлагдсан зүйл билээ. Ариун Сүнс нь бурханлаг хүч юмуу бурханлаг хандлагыг илтгэн харуулах зорилгоор хэрэглэдэг нэр төдий зүйл биш, харин Бодгаль юм. Үүний баталгаа нь Ариун Сүнсэнд бодгалийн гурван мөн чанар гурвуулаа агуулагдаж байгаа явдал юм. Тэдгээр нь: оюун ухаан, мэдрэмж болон хүсэл юм.

Чуулганы түүхийн туршид Ариун Сүнсний бодгаль болон ажлын талаар хүмүүс байнга санал зөрөлддөг байжээ. “*Амар тайвны хүлээс дотор Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн*” (Ефес 4:3) гэсэн зарчмыг бид онцгой анхаарах ёстой. Ариун Сүнсийг жинхэнээр ойлгож, Түүнд найдсанаар бид зөвхөн Бурханыг төдийгүй (1 Иохан 4:20), мөн нэг нэгнээ хайрлах болно (Галат 5:22).

Ариун Сүнсний “Сүм” бол Христийн бие юм. “*Та нарын* (биенийн төлөөний угийн олон тоо нь “та нар бүгдээрээ” гэсэн утгыг илэрхийлж байна) *бие* (ганц тоо) *бол Бурханы та нарт өгсөн, та нарын дотор байдаг Ариун Сүнсний сүм* (нэр угийн ганц тоо нь нэг бие ба нэг сүм гэсэн утгыг илэрхийлж байна) *мөн гэдгийг та нар мэддээгүй юм уу? Та нар өөрсдийнх биши гэдгээ мэддээгүй юмуу?*” (1 Коринт 6:19) хэмээн элч Паул асуусан байдаг. Мөн өмнө нь 1 Коринт номд Паул үүнтэй адилхан зүйлийг асуусан байдаг: “*Та нар* (та нар бүгдээрээ) *өөрсдөө* (олон тоо) *Бурханы сүм* (ганц тоо) *мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын* (та нарын бүгдийнх нь) *дотор оршидог гэдгийг мэддээгүй юм уу?*” (1 Коринт 3:16). Ариун Сүнс нь Христийн бие доторх хүн нэг бүрийг хооронд нь холбож өгдөг. Өөрсдийн бузар үйлдлээр Ариун Сүнсний “сүм”-д хор хөнөөл учруулж болохгүй хэмээн бидэнд сануулсан байдаг (1 Коринт 3:17). Есүс Христэд зөвхөн нэг л “сүйт бүсгүй” байдаг. Энэ хичээлийг судлах явцдаа бид энэ зүйлийг байнга санаж байх учиртай.

1. Оюун ухаан

Ариун Сүнс нь Бурханы зүйлсийг ойлгох, судлах чадвартай (1 Коринт 2:10-11). Үүнээс харахад, Ариун Сүнс оюун ухаантай (Ром 8:27) бөгөөд хүмүүст заах чадвартай юм (1 Коринт 2:13).

2. Мэдрэмж

Ариун Сүнс гомддог (Исаиа 63:10; Ефес 4:30) гэж Бурханы үгэнд тодорхой хэлсэн байдаг. Тэгэхлээр энэ нь Ариун Сүнс мэдрэмжтэй гэдгийг харуулж байна. Хэрэв Ариун Сүнс зүгээр л ямар нэгэн нөлөөлөл, эсвэл сэдэлжүүлэн өдөөгч зүйл байсан бол Түүнд иймэрхүү мэдрэмж, сэтгэлийн хөдлөл байхгүй байх байсан. Мөн Ариун Сүнсийг доромжилж болдог тухай Библид өгүүлсэн нь Түүнд мэдрэмж байдгийг бас баталдаг (Марк 3:29).

3. Хүсэл

Түүнчлэн Ариун Сүнс нь сонголт хийх чадвартай гэдэг нь тодорхой. Өөрөөр хэлбэл, Түүнд хүсэл байдаг. Тэрээр сүнслэг бэлгүүдийг Христийн биед эрх мэдэлтэйгээр тараадаг (1 Коринт 12:11). Үүнээс гадна Ариун Сүнс христитгэгчдийн үйл ажиллагааг удирдаж чиглүүлдэг (Үйлс 16:6-11).

4. Хэлбэр дүр

Есүсийг баптиسم хүртэх үед Ариун Сүнс амар тайвныг бэлгэдэн тагтааны дүрээр харагдсан тухай Сударт ганцхан удаа л дурдсан байдаг (Матай 3:16; Марк 1:10; Лук 3:22; Иохан 1:32).

Хувийн Судлал: 5-р бүлэг, 5А хэсэг

1. Бодгалийн ямар гурван мөн чанар байдаг вэ?

- А. 1 Коринт 2:10-11 ишлэлийг унш. Ариун Сүнсний талаар бидэнд юуг зааж байна вэ?
- Б. Ефес 4:30-ыг унш. Ариун Сүнсний талаар бидэнд юуг зааж байна вэ?
- В. 1 Коринт 12:11-ийг унш. Ариун Сүнсний талаар бидэнд юуг зааж байна вэ?

Б. Ариун Сүнсний үүрэг

1. Бүтээл

Ариун Сүнс Бүтээлийн ажилд Өөрийн үүргийг гүйцэтгэж, тэнгэр газрыг хэлбэршүүлэхэд оролцсон гэдэг нь тодорхой. Бурхан тэнгэр газрыг бүтээсний дараа газар нь ямар ч хэлбэр дүрсгүй, эзгүй хоосон байсан бөгөөд тэр үед “*Бурханы Сүнс*” дэгдээхэй дээрээ “далавчaa дэлгэн дэвэх” шувуу адил (Дэд хууль 32:11) “*усны мандал дээгүүр элин хальж байлаа*” (Эхлэл 1:2). Эзэн тэнгэр огторгуйг ердөө л “үг”-ээрээ бүтээж, Ариун Сүнс түүний од эрхсийг бий болгосон тухай Сударт өгүүлдэг (Дуулал 33:6). Ариун Сүнс бас Өөрийн бүтээлийг захирдаг (Иов 26:13).

Түүнчлэн Ариун Сүнс хүн төрөлхтнийг (Иов 33:4) болон амьтдыг бүтээж бүрэлдүүлэхэд оролцсон (Дуулал 104:24-25 ишлэлийг 104:30-тай харьцуул).

Бүтээл дэх Ариун Сүнсний үүрэг нь энэхүү бүтээлээр дамжуулан Эзэн Бурханыг илчлэх явдал юм (Исаиа 40:12-13 уд.харьц. Ром 1:20 уд.харьц. Иохан 16:13-14).

2. Илчлэлт

Илчлэлт дэх Ариун Сүнсний үүрэг нь хүн төрөлхтөнд шинэ үнэнийг тодорхой мэдүүлэх явдал юм (Иохан 16:13). Ариун Сүнс үнэнийг дамжуулахдаа хүнийг ашигладаг (2 Самуел 23:2) бөгөөд заримдаа энэ үнэн нь муу мэдээ байх тохиолдол ч байдаг (Мика 3:8).

Судар өөрөө Ариун Сүнсний илчлэлт юм (Матай 22:42-43; Үйлс 1:16; 4:24-25; 28:25-26; Еврей 10:15-16).

3. Ойлголт

Ариун Сүнс хүн төрөлхтөнд сүнслэг мэдээллийг илчилсэн бөгөөд тэдгээрийн заримыг ойлгоход үнэндээ төвөгтэй байдаг (1 Коринт 13:12). Тиймээс Бурханы үгийг ойлгоход (1 Коринт 2:12-16) болон амьдралын янз бүрийн нөхцөл байдалд Бурханы Үгийг аль хэсгийг авч хэрэгжүүлэх шаардлагатайг олж харахад Ариун Сүнс бидэнд тусалдаг (Лук 12:11-12; Еврей 3:7-8). Сүнслэг ойлголтыг ийнхүү амьдралд хэрэгжүүлэхийг “мэргэн ухаан” гэж нэрлэдэг.

4. Онгод оруулах

Ариун Судрыг бичих хүмүүст Ариун Сүнс урам зориг өгч, өдөөж байсан (2 Петр 1:21). “Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа” гэж Бурхан Өөрийнхөө үгэнд хэлсэн бөгөөд үүнийг үгчилбэл “Бурханы Сүнсээр” гэсэн утгатай юм (2 Тимот 3:16-17). Элч Паул энэ багц ишлэлийг бичихдээ Судрын өөр хаана ч дахиж бичигдээгүй грек үгийг ашигласан байдаг. Энэ нь ТЕОС (Бурхан) ба ПНЮМА (Сүнс) гэсэн грек үгсээс бүрдсэн ТЕОПНЮОСТОС гэдэг үг юм. Библи бүхэлдээ Бурхан Ариун Сүнсний онгodoор бичигдсэн.

5. Гайхамшигууд

Есүс Ариун Сүнсний хүчээр гайхамшигуудыг үйлдсэн (Лук 4:18).

Бусад гайхамшигт үйлдлүүдэд ч гэсэн Ариун Сүнс шууд зуучлагчийн үүргийг гүйцэтгэж байсан. Үүний тодорхой нэгэн жишээ бол Филип, Етиоп хүнд баптиисм хүртээгээд гэнэт алга болсон явдал юм (Үйлс 8:39). Өөр нэг жишээ нь Онгон бүсгүйн төрөлт.

6. Онгон бүсгүйн төрөлт

Тэнгэр элч Габриел онгон Мария дээр хүрч ирээд, түүнийг Ариун Сүнсээр хүүхэдтэй болж, төрөх хүү нь “Бурханы Хүү” хэмээн дуудагдах болно гэж хэлжээ (Лук 1:27, 35). Энэ багц ишлэл бидэнд Есүсийн тэнгэрлэг Эцэг нь Гурвалын нэг бодгаль гэдгийг хэлээд зогсохгүй, Ариун Сүнс бол Бурхан гэдгийг дахин батлан харуулдаг.

Мариаг хэвлэйдээ Есүсийг олсны дараа тэнгэр элч Мариатай гэрлэхээр сүй тавиад байсан Иосефт үзэгдэн, хайртай бүсгүй нь Ариун Сүнсээр жирэмслээд байгааг хэлсэн (Матай 1:18-20).

7. Гэм нүглийг буруушаах

Ариун Сүнсний өөр нэг онцгой үүрэг бол хүн төрөлхтний гэм нүглийг буруушаах явдал юм. Өөрөөр хэлбэл, хүмүүс Бурханы хуульд дуулгаваргүй хандсанаас болж гэм нүгэлд унадаг агаад тиймээс тэдэнд Аврагч хэрэгтэй гэдгийг Ариун Сүнс дэлхий өртөнц төдийгүй хувь хүмүүст маш тодорхой харуулдаг (Иохан 16:8). Тэрээр бидний мөс чанараар дамжуулан гэм нүглийг зэмлэдэг (Ром 9:1).

8. Сэргэлт

Сэргэлт гэдэг нь “шинэ төрөлт” гэсэн утгатай. Энэ нь авралын дараа биш, харин авралын үед явагддаг үйл явдлын дүрслэл юм. Ариун Сүнс нь Бурханы үгэнд өгөгдсөн амлалт дээр үндэслэн хүмүүст “шинэ төрөлт”-ийг өгдөг Бодгаль юм (1 Петр 1:23 уд.харьц. Тит 3:5).

9. Баптисм

Ариун Сүнсний баптисмын талаар христитгэгчдийн дунд маш их будлиан байдаг. Энэ талаар Библид юу хэлсэн байдгийг бүгдээрээ анхааралтай судалцгаая.

“Баптисм хүртэх” гэж орчуулсан грек үг нь (БАПТИЗО) “булхах, дүрэх” гэсэн утгатай бөгөөд грекчүүд энэ үгийг “даавуу будах, саваар ус хутгаж авах, эсвэл эх адаггүй олон асуултад дарагдах”¹⁰¹ гэсэн утгаар хэрэглэдэг. Баптисмын ёслол буюу “булхах” (жишээ нь, хүнийг усанд булхах, эсвэл цэргүүд тулааны өмнө жадаа цусанд дүрэх) нь хэн нэг хүнийг юмуу ямар зүйлийг хүлээн авах, эсвэл тэдгээрт өөрийгөө зориулж буйг бэлгэдэн харуулдаг. Амаар болон бичгээр үйлдсэн аливаа харилцааг тунхаглахад энэ аргыг хэрэглэдэг. Жишээ нь, Есүс Өөрийнхөө хүртэх ёстой “баптисм”-ын тухай ярьсан нь загалмайг хэлсэн аж (Марк 10:38). Тэрээр өмнө нь усаар баптисм хүртсэн (Марк 1:9) бөгөөд энэ нь Есүс Өөрийнх нь амьдралд зориулсан Эцэгийнхээ төлөвлөгөөг хүлээн авсныг илтгэн харуулдаг.

Баптисм хүртээгч Иохан Өөрийнхөө мэдээнд Мессиа ирж “Ариун Сүнсээр баптисм хүртээнэ” гэж амласан байдаг (Матай 3:11; Марк 1:8; Лук 3:16; Иохан 1:33; Үйлс 1:5). Тиймээс Эзэн Пентекостын өдөр Ариун Сүнсийг илгээх хүртэл Ариун Сүнсний баптисм хийгдэх боломжгүй (Иохан 14:16-17; Үйлс 2:1-4) бөгөөд Петр энэ өдрийг “эхлэл” гэж нэрлэсэн байдаг (Үйлс 11:16). Энэ өдрөөс өмнө нэг ч итгэгч үүнийг хүлээж авахгүй. Пентекостын өдөр эхэлсэн зүйл Чуулганы хувьд цоо шинэ юм байсан.

Ариун Сүнсний баптисм нь Пентекостын өдрөөс эхлэн итгэгчдийг “Христийн бие” (1 Коринт 12:12-13) буюу Чуулганы (Ефес 5:22-30) нэг хэсэг болгох зорилготой байсныг ухаарахгүйгээр Ариун Сүнсний баптисмыг ойлгох боломжгүй юм. Гэм нүгэл болон махан биеийн бузар хүсэл нь хэнийг ч энэ “бие”-ээс салгаж чадахгүй. Хэрэв тийм биш байсан бол коринтчууд гарцаагүй энэ “бие”-ээс салгагдах байсан (тэдний үйлдсэн зүсэн бүрийн гэм нүглийн талаар 1 Коринт 1-11 ишлэлээс унш).

“Ариун Сүнсээр баптисм хүртээх” тухай тушаасан, үүнд уриалсан зүйл Сударт байдаггүй. Тэгэхлээр, энэ нь хэн нэгэн хүн Есүсийн үхэл, оршуулга, амилалтыг хүлээн зөвшөөрч, Есүс Христэд итгэх үед (1 Коринт 15:1-4) тохиолддог зүйл юм. Энэ бол “нойтон” биш, харин “хуурай” баптисм юм. Итгэгчдэд зориулсан баптисмын тухай сүнслэг үнэнийг элч Паул ийнхүү маш тодорхой хэлсэн байдаг:

Эсвэл Христ Есүс уруу баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тиймд Эцэгийн алдраар Христ үхэгдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явахын тулд үхэл уруу баптисм хүртсэнээр Түүнтэй хамт оршиуулагдсан юм. Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж бас Түүний амилалттай нь ч холбогдох болно (Ром 6:3-5).

Итгэгч хүн Ариун Сүнсний баптисм хүртсэнээр түүний дотор Ариун Сүнс нутаглаж эхэлдэг (Иохан 14:17; Ром 5:5) бөгөөд тиймээс, Ариун Сүнсний баптисм нь хүмүүс Есүс Христийг өөрсдийн аврагчаар хүлээн авах үед хийгддэг аж.

10. Тамгалах

“Тамгалах” гэж лацыг лаван дээр ором гартал дараахтай адил үйлдэл юм. Есүс Христийн булшны амыг тагласан чулууг хэн нэгэн хөдөлгөхөөс сэргийлэх зорилгоор еврейчүүд түүнийг ийнхүү лацадсан байдаг (Матай 27:66). Хүмүүсийг Есүс Христэд итгэх үед Ариун Сүнс Бурханы “тамга”-аар тамгалдаг бөгөөд энэ нь хүний нүдэнд үл үзэгдэх тамга юм (Ефес 1:13).

Энэ бол Бурханаар хүлээн зөвшөөрөгдсөн хүнийг батлах бурханлаг баталгаа юм. Итгэгч хүн Есүс Христтэй байнгын холбоотой болдог бөгөөд Ариун Сүнс энэ холбоог “Түүний нэрээр тамгалдаг”. Ариун Сүнс Өөрөө Бурхан учраас энэхүү үл үзэгдэх тэмдгийг тавихын тулд “Бурханы тамга”-ыг хэрэглэдэг (2 Коринт 1:22).

Ийнхүү Ариун Сүнс биднийг тамгалсан учраас бид гэм нүгэл үйлдэж Түүнийг “гомдоох” ёсгүй (Ефес 4:30).

Биднийг “Золилтын өдрийн төлөө тамгалсан” (Ефес 1:13-14; 4:30) гэж хэлсэн бөгөөд энэ нь ирээдүйд Амилалтын өдөр бидний золилт бүрэн гүйцэд болох өдөр юм (Ром 8:23).

11. Нутаглах

Авралын үед Ариун Сүнс бидний дотор нутаглаж эхэлдэг. Энэ бол *“Би Энэгээс гүйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээс болжс өртөнц Түүнийг хүлээж авч чадахгүй. Харин та нар Түүнийг мэднэ. Яагаад гэвэл, Тэр та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна”* (Иохан 14:16-17) гэсэн Есүсийн амлалтын биелэл юм.

Пентекостын өдрөөс өмнө Ариун Сүнс итгэгчдийн дээр байх болно гэсэн байдаг бол энэ өдрөөс хойш Тэрээр итгэгчдийн “дотор” “нутаглах” болсон юм. Тиймээс, Ариун Сүнс ийнхүү нутаглах болсон нь Чуулганы эрин үеийн хувьд онцгой явдал юм (Ром 8:9; 1 Коринт 3:16; 6:19; 2 Тимот 1:14).

Гэм нүглийг буруушаах, үнэнийг илчлэх гэх мэт Ариун Сүнсний гол ажлууд хэвээрээ үлдсэн боловч “нутаглах газар” нь өөрчлөгдсөн юм.

Итгэгч хүн Ариун Сүнсээр баптисм хүртэх үед буюу тодруулбал, авралын ажлын үед Ариун Сүнс түүний дотор нутаглахаар орж ирдэг. Ариун Сүнсний баптисм болон нутаглал нь Бурханы бэлгүүд (Үйлс 11:16-17; Ром 5:5) учраас эдгээрийг хэн ч биднээс булааж чадахгүй (Ром 11:29). Хэдийгээр итгэгч хүн жигшмээр нүгэл үйлдсэн ч Ариун Сүнс түүний дотор “нутаглах”-аа больдоггүй гэдгийг бид Коринтын чуулганд тохиолдсон явдлаас мэдэх билээ. Коринтын итгэгчид зүсэн зүйлийн гэм нүгэлд хутгалдсан байсан хэдий ч 1 Коринт 1:2; 3:16; 6:19-р ишлэлүүдэд тэднийг аврагдсан хүмүүс гэж тооцсоор байсан бөгөөд энэ тухай уг номын 5-6 бүлэгт Паул өгүүлсэн байдаг.

Ариун Сүнс авралын дараа өгөгдсөн хоёр тохиолдлын талаар Үйлс номд тэмдэглэсэн байдаг (Үйлс 10:44; 19:1-6). Бурханы үгийг судалж буй хүн “Хэн?”, “Юу?”, “Хэзээ?” гэх мэт чухал асуултуудыг асуух нь ямар чухал болохыг байнга санаж байх хэрэгтэй юм. Дээрх хоёр тохиолдолд хүмүүс Мессиаг ирнэ гэдэгт итгэж байсан боловч Тэрээр хэдийнээ ирчихсэн байсныг мэдээгүй юм. Харин тэд Мессия ирсэн тухай сонсоод, үүнд итгэснээр Ариун Сүнсийг хүлээж авсан байна. Онцгой үйл явдлыг хүлээж аваад, дараа нь түүний зөв зүйтэйд итгэх нь ухаалаг хэрэг биш юм.

12. Дүүргэлт

Бид Ариун Сүнсний дүүргэлтийн талаар судлах явцдаа зарим нэг асуултад хариулт авах зорилгоор Бурханы Үгэнд анхаарлаа хандуулах болно. Ариун Сүнсний дүүргэлтийн талаар Библид юу

өгүүлснийг харж, үүнийг амьдралдаа хэрэгжүүлэх нь ямар ач холбогдолтой болохыг олж харах болно.

a. **Ариун Сүнсний дүүргэлт нь:**

1) **Үр чадвар, удирдлага гэх мэт онцгой үйлчлэлүүдийн төлөө өгөгдсөн**

Израилийн эрин үед онцгой ажил үүргийн төлөө сонгогдсон хүмүүс Ариун Сүнсээр дүүргэгдэг байсан. Ариун Сүнсээр дүүрэхийн төлөө Түүнээс гүйж болох ч (Лук 11:13) заавал ингэх шаардлага байхгүй. Асарыг босгох ажилд оролцож байсан Безалелын ур чадвараар Бурхан алдаршихын төлөө Ариун Сүнс түүнийг дүүргэсэн тухай Сударт тэмдэглэсэн байдаг (Египетээс гарсан нь 31:3; 35:31). Түүнчлэн, Мосег нас барсны дараа “*Иошуа*” Израилийг удирдахын тулд “*мэргэн ухааны сүнсээр дүүрэн болсон*” (Дэд хууль 34:9) хэмээсэн байдаг.

2) **Урамшуулан зоригжуулах болон эш үзүүлэх онцгой үйлчлэлийн төлөө өгөгдсөн**

Иохан баптист (Лук 1:15), түүний ээж Елизабет (Лук 1:41), аав Захария (Лук 1:67) нар Ариун Сүнсээр дүүрсэн тухай Лукийн Сайн мэдээний номоос бид уншдаг. Ариун Сүнсний “дүүргэлт” нь тодорхой үйлчлэлийг гүйцэлдүүлэхийн тулд Бурханаас өгөгддөг хүч чадалтай холбоотой гэсэн үндсэн зарчмыг бид эндээс хардаг.

3) **Тодорхой сонсогчидтой харилцаах онцгой харилцааны төлөө өгөгдсөн**

Есүс амилсныхаа дараа тэнгэр өөдөр авагдахынхаа өмнө шавь нартаа хандан “Ариун Сүнсийг хүлээн авагтуун” (Иохан 20:22) гэж хэлсэн. Энэ нь Ариун Сүнсийг сонсохыг ятгасан уриалга (Үйлс 1:2) төдийгүй хэдхэн өдрийн дараа Ариун Сүнс хүчийг олгохоор (хүч чадал өгөх) бууж ирэх мөчийг (Үйлс 1:8) хүлээхийг сануулсан тушаал байсан нь тодорхой юм. Ингэснээр, Есүсийг цовдолсон хүмүүсийг учлах нигүүлсэл тэдэнд өгөгдөх байлаа (Иохан 20:23).

Пентекостын өдөр Ариун Сүнс тэдэнд хүчийг өгөхөд тэд өмнө нь огт мэддэггүй байсан хэлээр ярьж эхэлсэн (Үйлс 2:1-11, онцгойлон 4, 8, 11-р ишлэлүүд). Тийнхүү Петр энэ бүлэгт тэмдэглэгдсэн номлолыг тунхаглаж (2:14-40), Есүс Христийн тухай мэдээг хүлээн авсан бүхэнд Ариун Сүнс өгөгдөнө (2:38-40) гэсэн амлалтыг дамжуулах хүчийг олж авчээ. Израилийн эрин үетэй адил тухайн үед ч мөн Ариун Сүнсний дүүргэлт нь онцгой үйлчлэлийг гүйцэтгүүлэхийн тулд өгөгддөг онцгой хүч гэдэг нь тодорхой байна.

4) **Сүнслэг хамгаалалт болон эр зоригийн төлөө өгөгдсөн**

Сүнсний дүүргэлтийн дараагийн нэг тохиолддол нь Петр иудейчүүдийн өмнө өөрийгөө хамгаалах үед (Үйлс 4:5-12) болон дараа нь энэ тухайгаа найз нартаа ярих үед болсон. Петр болон түүний найз нар Ариун Сүнсээр дүүргэгдэн, Бурханы Угийг зоригтойгоор ярих хүчтэй болсон (Үйлс 4:31). Ариун Сүнснээс хүчийг олох үед өөр хэлээр ярих чадвар өгөгдөөгүйг дээрх хоёр жишээнээс анзаараарай. Тэгэхлээр, Ариун Сүнсээр дүүрэх үед хэлүүдээр ярих чадвар заавал өгөгддөг гэж итгэх нь буруу юм.

Ариун Сүнс итгэгч хүний дотор орж нутаглах үйл явц нэг л удаа явагддаг боловч Ариун Сүнс цаашид түүний дотор байнга оршин байдаг бол Ариун Сүнсээр дүүрэх үйл явц олон удаа явагдаж болох ч тухайн хүн байнга Ариун Сүнсээр дүүрэн байдаггүйг бид дээрх жишээнүүдээс харж болохоор байна. Итгэгч хүмүүс Ариун Сүнсийг өөрсдийнхөө дотор “нутаглуулах” ёстой гэж тушаадаггүй, харин Ариун Сүнсээр “дүүрэн бай” (Ефес 5:18) гэж тушаасан байдаг нь үүнийг бас батлан харуулдаг. Ариун Сүнсний оршихуй нь Түүний байршлыг (Ариун Сүнс бидний дотор, бид Христ дотор байдаг) заадаг бол Ариун Сүнсээр дүүрэх нь итгэгчдээр дамжин илрэх Түүний хүч чадлыг харуулдаг.

5) **Үйлчлэлийг хүчирхэгжүүлэхийн төлөө өгөгдсөн**

Чуулган дахь Ариун Сүнсний дүүргэлт нь бусад итгэгчдэд хандсан бидний үйлчлэлийг хүчтэй болгохын төлөө байдаг. Анхны чуулганд бэлэвсэн эмэгтэйчүүдийг халамжлах талаар асуудал тулгарах үед (Үйлс 6:1) Есүсийн арван хоёр шавь цуглаанд хандан, энэ

асуудлыг шийдвэрлэж чадахуйц, Сүнс болон мэргэн ухаанаар дүүрэн хүмүүсийг сонгохыг (Үйлс 6:2-5) санал болгосон бөгөөд цуглаан ч тэдний хэлсэн ёсоор үйлдсэн. Чуулганы үйлчлэлд дуудагдсан хүмүүсийн хувьд Сүнсээр дүүрэн байж, Түүнээс хүчийг авах нь ямар чухал болохыг шавь нар харсан байжээ.

6) Сатаны заль мэхийг ялгаж танихын төлөө өгөгдсөн

Саул (Паул) илгээлтийнхээ эхний аяллын үеэр Ромын захирагч Сергио Паул гэдэг хүнд Бурханы үгийг танилцуулж байхдаа Елум гэгч нэгэн шидтэний эсэргүүцэлтэй тулгарсан (Үйлс 13:6-7). Тэр үед Паул Ариун Сүнсээр дүүрч, Елум Бурханы үгийг төөрөлдүүлэхээр зэхэж байгааг мэдсэн (Үйлс 13:8-10).

7) Эсэргүүцлийг даван туулахын төлөө өгөгдсөн

Паул, Барнаб хоёрыг Писидийн Антиохын иудейчүүд эсэргүүцэх үед тэд Ариун Сүнсээр дүүрсэн тухай (Үйлс 13:42-51) ишлэлд өгүүлдэг. Тухайн үед тэд ийнхүү Ариун Сүнсээр дүүрснээр өөрсдийн хүнд хэцүү үйлчлэлийг цаашид амжилттай үргэлжлүүлэхэд нь тусалсан юм (13:52).

6. Христитгэгчдийн өсөлтийн төлөөх Ариун Сүнсний дүүргэлт

Итгэгч хүн Ариун Сүнсээр дүүрэх ёстай гэсэн тушаал өгөгдсөн (Ефес 5:18) дээр үндэслэн итгэгч хүн бүр үргэлж Ариун Сүнсээр дүүрэн байдаггүй юм байна гэсэн дүгнэлтэд бид хүрэх боломжтой.

Гэм нүгэл нь итгэгчдийг Бурхантай нөхөрлөхөд саад болдог учраас Ариун Сүнсээр дүүрч, Түүнээс хүчийг авахад ч мөн саад болдог гэдгийг бид ойлгох хэрэгтэй юм (1 Иохан 1:6). Ариун Сүнсээр хэр дүүрэн байх нь бидний христэч амьдралыг буюу бид хэр зэрэг “гэрэл дотор алхаж” байгааг илтгэн харуулдаг (Иохан 8:12; 12:35-36; Ефес 5:7-10; 1 Иохан 1:7). Итгэгчид заримдаа гэм нүгэл үйлддэг (1 Иохан 1:8, 10). Энэ нь бидний Бурхантай нөхөрлөх нөхөрлөлд сэв суулгадаг учраас итгэгч бид Бурхан бол “итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг училж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ” (1 Иохан 1:9) гэдгийг итгэлээр хүлээн авч, нүглээ улайх ёстай.

Ариун Сүнсээр дүүрэх нь богино хугацаанд, бүрэн гүйцэд явагддаг үйл явц гэдгийг анхаарах хэрэгтэй. Ариун Сүнсээр дутуу дүүрсэн юмуу, зарим хэсэг нь дүүрсэн хүний тухай нэг ч ишлэл Библид байхгүй. Түүнчлэн Ариун Сүнсээр дүүрэх нь христэч төлөвшилтийг тодорхойлдог зүйл биш юм. Тиймээс: (1) тухайн итгэгчийн төлөвшилтөөс шалтгаалахгүй бүх итгэгч Ариун Сүнсээр дүүрэх боломжтой, (2) Ариун Сүнсээр дүүрэх нь бүрэн гүйцэд үйл явц юм. Хүн Ариун Сүнсийг эсэргүүцэх (Үйлс 7:51) боломжтой ч Түүгээр дүүргэгдэхийн тулд Түүнд захирагдах ёстай.

Энэ бүхнээс үзэхэд, Ариун Сүнсээр дүүрэх гэдэг нь христитгэгчдэд христэч амьдралаар амьдрах хүчийг өгдөг, агшин зуурын үйл явц юм гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Гэхдээ энэ нь христэч амьдралын зорилго биш, харин түүнийг эхлүүлж, улмаар тэтгэн дэмжиж байдаг гол элемент юм.

Ариун Сүнсээр дүүрснээр дараах дөрвөн үр дүн гардаг: Бурханыг магтах хүч (гадаад илэрхийлэл), Бурханд мөргөх (дотоод илэрхийлэл), Бурханд талархал өргөх, нэг нэгэндээ захирагдах (Ефес 5:19-21).

13. Залбирах

Ариун Сүнсээр дүүрэх тухай сэдвээс бид тууштай байдал ямар чухал болохыг харсан. Мөн “Сүнс дотор залбирах” нь чухал гэдгийг бид сурсан. Энэ нь Ариун Сүнс-Бурхантай харилцах бидний харилцааг илэрхийлдэг (Ефес 6:18; Иуда 1:20-21). Бид залбирч байхдаа Бурхантай нөхөрлөх ёстай гэдэг нь тодорхой. Тийнхүү бид гэм нүглээ байнга улайж байх хэрэгтэй юм (1 Иохан 1:9).

Хэрхэн залбирах, юу гэж хэлэх, тэр ч байтугай яг юун тухай залбирахаа ч мэдэхгүй үе бидэнд байдаг. Ийм үед бид Ариун Сүнс бидний өмнөөс Эцэгийн өмнө зуучлан залбирдаг (Ром 8:26-27) гэдгийг санаж, үүнээс тайвширалыг авах ёстой юм.

14. Ятгах

Ариун Сүнсний нэг үүрэг бол итгэгчийг аврал болон мөнхийн ерөөлүүдэд ятгах явдал юм. “*Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө ... гэрчилдэг*” бөгөөд бид “*Христийн хамтран залгамжлагчид*” юм (Ром 8:16-17).

Ариун Сүнс нь бидний мөнхийн өвийн “батлан даагч” юм (Ефес 1:13-14).

15. Зуучлах

Биднийг Өөрсдийн гүйлт хүсэлтийг илэрхийлэх чадваргүй байхад хүртэл Эцэг бидний хүсэлтийг мэддэг хэмээн Ариун Сүнс баталдаг (Ром 8:26-27).

16. Сүнслэг бэлэг өгөх

Есүс Христ Эцэг уруугаа дээш өргөгдөх үедээ хүн төрөлхтөнд сүнслэг бэлгүүдийг өгсөн (Ефес 4:11). Эдгээр сүнслэг бэлгийг Ариун Сүнс итгэгчдэд тарааж өгдөг (1 Коринт 12:11, 18; Еврей 2:4).

Сүнслэг бэлэг гэдэг нь Христийн биеийн төлөө амьдралын тодорхой хэсэгт амжилт гаргахын тулд Бурханаас өгөгдсөн чадвар юм (1 Коринт 12). Итгэгч хүн бүрд сүнслэг бэлэг өгөгдсөн бөгөөд тэд үүнийгээ бусдад үйлчлэхийн тулд ашиглах ёстой (1 Петр 4:10).

Сүнслэг бэлэг нь төрөлхийн юмуу, эсвэл олдмол чадвар биш учраас Ариун Сүнс хүний төрөлхийн авьяас чадварыг сүнслэг бэлгүүдээр дамжуулан ашиглах нь олонтаа байдаг. Жишээ нь, хэн нэгний хөгжмийн авьяас бэлэг нь Ариун Сүнснээс өгөгддөг ятгах бэлгээр дамжуулан илэрхийлэгдэж болох юм (Ром 12:8).

Өөртөө өгөгдсөн сүнслэг бэлгийг бүрэн дүүрэн ашиглахын тулд танд зарим нэг чадварууд хэрэгтэй болж болох юм. Жишээ нь, хэрэв танд заах бэлэг өгөгдсөн бол (Ром 12:7; 1 Коринт 12:28; Ефес 4:11) та Бурханы үгийг судалж (2 Тимот 2:15), түүнийг хэрхэн заах тал дээр суралцах хэрэгтэй юм.

Дараагийн хэсэгт бид сүнслэг бэлгүүдийн талаар илүү дэлгэрэнгүй үзэх болно.

17. Заах

Ариун Сүнсний өөр нэг чухал үүрэг бол бидэнд Бурханы зүйлсийн талаар заах явдал юм (Иохан 14:26). Онцгой хэрэгцээ гарсан тохиолдолд Тэр бидэнд үүнийг маш богино хугацаанд зааж болох (Лук 12:11-12) ба эсвэл урт удаан сургалтын үйл явцаар зааж сургаж болох юм (Иохан 16:13-15).

Зөвхөн Ариун Сүнсний заах үйлчлэлээр дамжуулан бид сүнслэг үнэнд суралцдаг (1 Коринт 2:10-16).

18. Чиглүүлэх

Ариун Сүнс бол бидний христэч амьдралын чиглүүлэгч юм. Бидний чиглүүлэгч болохын хувьд Түүний эн тэргүүн зорилго нь бидэнд Есүс Христийн тухай заах явдал (Иохан 16:13) бөгөөд тэгснээр бид Есүстэй адил болох юм (1 Коринт 11:1; Ефес 5:1).

Ёс суртахуунтай холбоотой асуудал (1 Тимот 1:8-11; Ром 8:12-14) гэх мэт Бурхан Өөрийнхөө Үгээр дамжуулан хүсэл зорилго тодорхой илэрхийлсэн хэсгүүдээс Ариун Сүнсний удирдамж чиглүүлгийг хараад хялбар байдаг. Библи нь Ариун Сүнсний онгodoор бичигдсэн учраас (2 Тимот 3:16-17; 2 Петр 1:21) бид Түүний хүслийг энд бичигдсэн зүйлсээс мэдэх боломжтой. Ийм ч учраас энэ нь бидний чиглүүлэг болдог юм.

Хоёр сайн зүйлээс аль нэгийг нь сонгох гэх мэт Бурханы онцгой хүсэл тодорхой илчлэгдээгүй үед бид өөрсдийгөө Түүнд “амьд, ариун тахил” (Ром 12:1) болгон өргөх ёстой бөгөөд тэгснээр бид тухайн зүйл дэх Түүний хүслийг мэдэж чадна (Ром 12:2).

Ариун Сүнсний чиглүүлэгтэй холбоотой бусад жишээг дараах ишлэлүүдээс харна уу: Үйлс 8:29; 10:19-20; 13:2-4; 16:6-7; 20:20-23.

19. Үр жимс ургуулах

Ариун Сүнс бидний дотор нутаглаж, биднээр дамжуулан үр жимс ургуулахыг хүсдэг. Энэ үр жимс нь “хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал” юм (Галат 5:22-23). Ийм үр жимсийг ургуулахын тулд бид христэч амьдралыг маань хүчирхэгжүүлэх боломжийг Ариун Сүнсэнд гаргаж өгөх хэрэгтэй (Галат 5:16, 25) бөгөөд тэгснээр бид өөрсдийн махан бие болон түүний гэмт үйлсийг ялан дийлж чадаа юм (Галат 5:17-21).

20. Баяр хөөр, аз жаргал

Ариун Сүнс бидний дотор баяр хөөрийг төрүүлж, биднээс аз жаргал ундран гардаг. Үлэмж их зовлон хавчлага дунд ч энэ баяр хөөр байсаар л байдаг (1 Тесалоник 1:6). Зөвхөн өөрөө өрөөгдсөн учраас биш, мөн бусдад ирсэн Эцэгийн өрөөлийн төлөө бид ийнхүү баярлан хөөрдөг (Лук 10:21).

21. Бялхам хайр

Ариун Сүнс христитгэгчийн дотор нутаглах үедээ Өөртэйгөө хамт бурханлаг хайр болон хэзээ ч хэний ч урмыг хугалахгүй итгэл найдварыг авчирдаг (Ром 5:5).

22. Зөвт байдал, амар тайван хийгээд баяр баясгалан

Итгэгч хүний амьдрал дахь хамгийн чухал өрөөл бол Бурханы хаанчлалын хамгийн чухал өрөөлүүд нь үнэндээ бие махбодийн гэхээсээ илүү сүнслэг өрөөл байдаг гэдгийг Ариун Сүнс итгэгчдийн амьдралд илчлэн харуулдаг (Ром 14:17).

23. Хүчийг өгөх

Итгэгчдийг итгэл найдвараар дүүргэж (Ром 15:13), мөнхийн тэнгэрлэг Сайн мэдээг тунхаглах чадвартай (1 Петр 1:12) байлгахын тулд Ариун Сүнс хүч чадлыг авчирдаг.

24. Ариусгах

Бид Бурханд магтаалын тааламжит тахилыг өргөдөг, мөн бусдын төлөө сайныг үйлддэг болохын (Ром 15:16 уд.харьц. Еврей 13:15-16) тулд Бурханд “тусгаарлагдсан (ариусгагдсан)” билээ. Энэхүү ариусгалд ёс суртахууны асуудлууд багтдаг. Яагаад гэвэл, ёс суртахууны хувьд ялзарсан хүмүүсийн сүнслэг өсөлт зогссон байдаг (1 Тесалоник 4:1-8). Бидний ариусгалын нэг хэсэг бол биднийг Өөр шигээ “ариун” болгох боломжийг “Ариун” Сүнсэнд тавьж өгөх явдал юм (1 Петр 1:16).

25. Нөхөрлөх

Эцэгийн хайр болон Есүс Христийн нигүүлсэл дээр үндэслэсэн нөхөрлөлийг итгэгчдийн дунд тогтоодог Нэгэн бол Ариун Сүнс юм (2 Коринт 13:14).

Хувийн Судлал: 5-р бүлэг, 5Б хэсэг

2. Дараах багцлалуудыг уншаад, Ариун Сүнсний үүргийг тодорхойл:

- | | |
|---------------------|-------------------------|
| A. Иов 33:4 | Л. Ефес 6:18 |
| Б. Иохан 16:13 | М. Ром 8:16-17 |
| В. 1 Коринт 2:12-16 | Н. Ром 8:26 |
| Г. 2 Петр 1:21 | О. 1 Коринт 12:11 ба 18 |
| Д. Лук 4:18 | Ө. Иохан 14:26 |
| Е. Лук 1:27, 35 | П. Галат 5:22-23 |
| Ё. Иохан 16:8 | Р. 1 Тесалоник 1:6 |
| Ж. Тит 3:5 | С. Ром 5:5 |
| З. Матай 3:11 | Т. Ром 14:17 |
| И. Ефес 1:13 | У. Ром 15:13 |
| Й. Иохан 14:16-17 | Ү. Ром 15:16 |
| К. Ефес 5:18 | Ф. 2 Коринт 13:14 |

B. Ариун Сүнсийг дүрсэлсэн нь:

- “**Өөр Туслагч**” – Есүсийн адил Түүний тайтгаруулах болон урамшуулах үйлчлэлийг илэрхийлдэг. Иохан 14:16
- “**Төгс хүчит Нэгэний амьсгал**” – Түүний амь өгөгч хүч чадлыг илэрхийлдэг. Иов 32:8; 33:4
- “**Бэлэг**” - Түүний оршихуй нь Бурханы бэлэг гэсэн санааг илэрхийлдэг. Үйлс 2:38; 8:19-20; 10:45
- “**Туслагч**” - Тэрээр хүмүүсийг үнэнийг заахад урамшуулдаг болохыг илэрхийлдэг. Иохан 14:26
- “**Барьцаа**” - бидний авралтай холбоотой тэмдэг бидэнд өгөгдсөн гэдгийг илэрхийлдэг. 2 Коринт 1:22; 5:5; Ефес 1:14
- “**Амласан**” - Бурханы Төлөвлөгөөн дэх Ариун Сүнсний үүргийг илэрхийлдэг. Үйлс 2:33; Ефес 1:13
- “**Үрчлэлийн Сүнс**” - Бурханы гэр бүлд биднийг авчирдаг Ариун Сүнсний үүргийг илэрхийлдэг. Ром 8:15
- “**Шүүлтийн Сүнс ба шатаагч Сүнс**” – Ариун Сүнсний зөвт байдал, шударга чанарыг илэрхийлдэг. Исаиа 4:4
- “**Христийн Сүнс**” - Есүс Христийн хүмүүн чанар дахь Ариун Сүнсний үүргийг илэрхийлдэг. Ром 8:9; Филиппой 1:19; 1 Петр 1:11
- “**Зөвлох ба хүч чадлын Сүнс**” – гачигдагсдад өгдөг Ариун Сүнсний энэрэл нигүүлсэл, тусlamж дэмжлэгийг илэрхийлдэг. Исаиа 11:2
- “**Итгэлийн Сүнс**” - Ариун Сүнс бол итгэх зохистой Нэгэн гэдгийг илэрхийлдэг. 2 Коринт 4:13
- “**Алдрын Сүнс**” - Ариун Сүнсний Өөрийнх нь сүр жавхланг илэрхийлдэг. 1 Петр 4:14
- “**Бурханы Сүнс**” - Ариун Сүнсний Өөрийнх нь бурханлаг мөн чанарыг илэрхийлдэг. Эхлэл 1:2; Египетээс гарсан нь 31:3; 35:31; Тооллого 24:2; 1 Самуел 10:10; 11:6; 19:20, 23; Шастирын дэд 15:1; 24:20; Иов 33:4; Дуулал 106:33; Езекиел 11:24; Матай 3:16; 12:28; Ром 8:9, 14; 1 Коринт 2:11, 14; 7:40; 12:3; Ефес 4:30; Филиппой 3:3; 1 Иохан 4:2
- “**Бурханы Сүнс**” - Ариун Сүнсний Бурхан адил мөн чанарыг илэрхийлдэг. Эхлэл 41:38
- “**Нигүүслийн, гүйлтийн Сүнс**” - Ариун Сүнсний нигүүлсэгч хандлага ба залбирагч нэгнийг сонсоходоо бэлэн байдаг гэдгийг илэрхийлдэг. Зехария 12:10
- “**Өөрийн Хүүгийн Сүнс**” - Гурвалд бүгдэд нь хандаж байна. Галат 4:6
- “**Ариун байдлын Сүнс**” – Тэр бол зөвхөн ариун чанартай Сүнс биш, мөн ариун байдлыг илэрхийлдэг гэсэн утгатай. Ром 1:4
- “**Шүүлтийн Сүнс**” - Ариун Сүнсний шүүлтийн илчлэлийг илэрхийлдэг. Исаиа 4:4
- “**Шударга Сүнс**” - Ариун Сүнсний үнэнч шударга байдлыг илэрхийлдэг. Исаиа 28:6

- “**Эзэнээс эмэхүй болон мэдлэгийн Сүнс**” – Түүний өгсөн мэдлэг Эзэнийг хүндлэхэд хүргэдэг гэдгийг илэрхийлдэг. Исаиа 11:2
- “**Амийн Сүнс**” - Ариун Сүнсний сүнслэг амь өгдөг үүргийг илэрхийлдэг. Ром 8:2
- “**Бидний Бурханы Сүнс**” - Ариун Сүнсний Чуулганы амьдрал дахь Бурханы илэрхийлэгч үүргийг харуулдаг. 1 Коринт 6:11
- “**Амьд Бурханы Сүнс**” - Бурхан болон шүтээнүүдийн хоорондох ялгаатай байдлыг илэрхийлдэг. 2 Коринт 3:3
- “**Эзэний Сүнс**” - Эзэнийг дэмждэг Түүний дэмжлэгийг илэрхийлдэг. Лук 4:18; Уйлс 5:9; 8:39; 2 Коринт 3:17
- “**ЭЗЭН Бурханы Сүнс**” - Эзэн болох Бурханыг дэмждэг Түүний дэмжлэгийг илэрхийлдэг. Исаиа 61:1
- “**Үнэний Сүнс**” - Ариун Сүнсэнд худал хуурмаг зүйл байдаггүй гэсэн утгатай. Иохан 14:17; 15:26; 16:13; 1 Иохан 4:6
- “**Мэргэн ухаан болон ойлголтын Сүнс**” - Бурханы үгийг зөв ойлгож, амьдралд хэрэгжүүлэхэд тусалдаг Ариун Сүнсний чадварыг илэрхийлдэг. Исаиа 11:2
- “**Мэргэн ухаан хийгээд илчлэлтийн Сүнс**” – хүмүүсийг Бурханы үгийг зөв хэрэглэж, тийнхүү Христийг улам илүү мэддэг болоход тусалдаг Ариун Сүнсний чадварыг илэрхийлдэг. Ефес 1:17
- “**Төгс хүчит Нэгэний дуу**” - Бурханы үгийн дамжуулагч Ариун Сүнсний үүргийг илэрхийлдэг. Езекиел 1:24
- “**Эзэний дуу**” - Ариун Сүнсний хэлж буй зүйл дээд эрх мэдэлтэй гэдгийг илэрхийлдэг. Исаиа 6:8

Хувийн Судлал: 5-р бүлэг, 5В хэсэг

3. “**B**” хэсэг дэх Сүнсний бодгаль болон үүргийн тухай дүрслэлүүдийг дор өгүүлсэн Сүнсний ажил үүргийг тайлбарласан дүрслэлтэй холбоно уу. Дахин хэлэхэд, эдгээр дүрслэл нь нэгээс илүү категориид тохирч болно. Та хүсвэл энэ номд гарч буй Сүнсний ажил үүргийг а, б гэх мэтээр тэмдэглэж болно.
- А. Ариун Сүнсний үүрэг
 Б. Ариун Сүнсний бодгаль

Зургаадугаар Бүлэг

**Бурханы Бүтээлийн
Тухай Онол**

1-р хэсэг

Бүтээл (Космологи)

Библийн хамгийн эхний ишлэл бидэнд “*Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжсээ*” хэмээн тунхагладаг (Эхлэл 1:1). “Бүтээжсээ” хэмээн орчуулагдсан еврей үг БАРА нь “аливаа шинэ юмыг эхлүүлэх”¹⁰² гэсэн утгатай бөгөөд мөн “оргүй хоосноос ямар нэг юм бүтээх” гэсэн санааг ч агуулдаг. Зөвхөн Бурхан л аливаа юмыг бий болгохын тулд “БАРА” гэж хэлсэн байдаг.¹⁰³

Бурхан тэнгэр ба газрыг бүтээсэн тухай Библийн өөр бусад хэсгүүдэд бичсэн байдаг (Исаиа 40:26-28; 42:5; 45:12, 18). Бид энэ үнэнийг хүлээн зөвшөөрөх нь маш чухал юм. Учир нь энэ бол хүн төрөлхтний байнга асуудаг “Хүн төрөлхтөн хэрхэн бий болсон бэ?” гэх асуултанд хариулт өгдөг. Зөв хариулт нь Бурхан хүн төрөлхтнийг бүтээсэн гэх хариулт юм.

Еврей номыг бичигч “*Бурханы угээр ертөнц бүтээгдсэн бөгөөд тийнхүү харагдах зүйлс нь үзэгдэх зүйлсээс бий болгогдоогүйг бид итгэлээр ойлгодог*” (Еврей 11:3) гэж өгүүлжээ. Энэ нь Бурхан үгээ хэлж газар тэнгэрийг бий болгосон гэсэн үг юм. Бүтээл нь хувьсан өөрчлөгдснөөр бус, харин Бурханы эрх мэдэл ба хүч чадлаар бий болсон (Дуулал 33:6; 148:4-5).

Библид Бурхан амьдралыг бий болгосон (Эхлэл 1:21) төдийгүй хүн төрөлхтний сүнсийг бүтээж (Эхлэл 1:27; 5:2; 6:7; Исаиа 45:12), дараа нь Өөрөө “амарсан” (Эхлэл 2:3-4) гэдгийг бидэнд харуулдаг. Ирээдүйд, хэзээ нэгэн өдөр Тэр шинэ газар, шинэ тэнгэрийг бүтээх болно (Исаиа 65:17; 2 Петр 3:10-13; Илчлэлт 21:1).

Хувийн Судлал: 6-р бүлэг, 1-р хэсэг

1. Эхлэл 1:1-ийг унш. Хэн тэнгэр ба газрыг бүтээсэн бэ?
2. Еврей 11:3-ыг унш. Бурхан тэднийг хэрхэн бүтээсэн бэ?
3. Эхлэл 1:2-31 ишлэлийг унш. Бурхан өөр ямар зүйлсийг бүтээсэн бэ?
4. 2 Петр 3:10-13, Илчлэлт 21:1-ийг унш. Бурхан ирээдүйд юу бүтээх вэ?

2-р хэсэг

Тэнгэр Элчүүд (Тэнгэр Элч Судлал)

A. Тэд хэн бэ?

Бурханы Үг бидэнд хүн төрөлхтөн биднээс гадна бүтээгдсэн биетүүд буюу тэнгэр элч нар гэж нэрлэгдсэн бүтээл байдаг гэдгийг тодорхой харуулдаг. Библийн Эхлэл номоос Илчлэлт ном хүртэл тэдний тухай тэмдэглэгдсэн зүйлс байдаг. Еврей (МАЛА'АК) ба грек (АНГЕЛОС) хэлний аль алинд нь “тэнгэр элч” гэдэг үгс “элч, төлөөлөгч” гэсэн утгыг агуулдаг. Тиймээс эдгээр биетүүд нь бодож бас харилцаж чаддаг гэсэн үг. Тэд ухаалаг биетүүд учир (Матай 8:29; 2 Коринт 11:3; 1 Петр 1:12) тэдэнд мэдрэх (Лук 2:13; Иаков 2:19; Илчлэлт 12:17), сонгох (Лук 8:28-31; 2 Тимот 2:26; Иуда 6) зэрэг чадварууд байдаг.

Тэнгэр элчүүд нь “сүнслэг” биетүүд (Еврей 1:14) бөгөөд Бурхан зөвшөөрвөл хүний биетэй болж чаддаг (Лук 2:9; 24:4). Тэд хүнээс дээгүүр байр суурь эзэлдэг ер бусын биетүүд юм (Еврей 2:7). Энэ нь тэд бол хүнээс илүү ухаантай, илүү чадварлаг гэсэн үг юм (Илчлэлт 10:1-3). Хэдий тийм боловч тэд бүхнийг мэддэггүй (1 Петр 1:12). Мөн Бурхан шиг бүхнийг чаддаггүй (Матай 25:41) төдийгүй хaa сайгүй оршиж чадахгүй.

Библид зөвхөн гурван тэнгэр элчийн нэрс гардаг. Тэд бол Михайл (Даниел 10:13; 21, 12:1, Иуда 1:9; Илчлэлт 12:7), Габриель (Даниел 8:16; 9:21; Лук 1:19, 26), Сатан (Илчлэлт 12:9) зэрэг юм.

B. Тэдний Бүтээгч

Энэ дэлхий өртөнцийг бүтээхээсээ өмнө (Иов 38:7) Бурхан тэнгэр элч нарыг бүтээсэн (Дуулал 148:2-5). Хүмүүс хүүхэд төрүүлдэг шиг тэнгэр элч нар “хүүхэд” төрүүлдэггүй учир (Лук 20:35) тэд үхдэггүй (Лук 20:36). Тиймээс тэдний тоо үргэлж тогтмол байдаг. Бид хэдэн тэнгэр элч нар байдгийг мэдэхгүй боловч маш их олон байдаг гэдгийг мэдэж болно (Еврей 12:22; Илчлэлт 5:11)

Бид Бурханыг төгс (Матай 5:48), мөн ямар ч гэм нүгэлгүй (2 Коринт 5:21) гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Нэгэнт ТэрӨөрөө төгс учир Тэр ямар ч гэм нүгэлгүй төгс нэгнийг бүтээдэг гэдэг нь ойлгомжтой. Учир нь “ямар ч муу муухай нь Түүнтэй хамт оршдоггүй” (Дуулал 5:4). Сатаны хувьд бид үүнийг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь тэр гэм нүгэлгүй бүтээгдсэн боловч Бурханыг эсэргүүцэн боссон (Езекиел 28:12-15; Исаиа 14:12-14).

Зарим хүмүүс тэнгэр элч нар бол үхсэн хүмүүс гэж боддог. Тэд хүн төрөлхтнөөс өмнө оршин байсан тул үхсэн хүмүүс байж таарахгүй гэдэг нь тодорхой. Харин тэд онцгой, тусгаар бүтээлгүүд юм.

B. Тэдний зохион байгуулалт

Тэнгэр элч нар хамтдаа цуглаж (Дуулал 89:5, 7) дайн тулаанд ордог (Илчлэлт 12:7) тул тэд сайн зохион байгуулалт, хэргэм зэрэгтэй байдаг гэдгийг мэддэг.

Хамгийн өндөр зэрэгтэй тэнгэр элч бол ахлах тэнгэр элч бөгөөд энэ нь бусдыг захирдаг тэнгэр элч гэж ойлгож болно. Михайлийг (Иуда 9) “Ахлах Жонон”-гуудын нэг гэдэг бөгөөд тэр бол цорын ганц ахлах тэнгэр элч юм. Түүнийг Эзэний тэнгэр элч нарыг удирдан Сатаны эсрэг тэмцдэг тухай Илчлэлт 12:7 ишлэлд бичсэн байдаг. Тэгэхээр ахлах тэнгэр элч нь ганцхан байдаг аж. Тэрээр бусдаас маш их өөр дуу хоолойтой байдаг (1Тессалоник 4:16).

Тэнгэр элч нарыг бас “захирагчид” (Ром 8:38; Ефес 1:21; 3:10; 6:12; Колоссай 1:16; 2:10, 15), “эрх мэдэлтнүүд” (Ефес 1:21; 2:2; 3:10; 6:12; Колоссай 1:16; 2:10, 15; 1 Петр 3:22), “хүч” (2 Петр 2:11), “хаан ширээ” (Ефес 1:21; Колоссай 1:16; 2 Петр 2:10; Иуда 1:8) гэж нэрлэдэг. Эдгээр нь үндсэндээ тэнгэрийн улс дахь тэдний байр суурь болон үүрэг хариуцлагыг илэрхийлдэг.

Мөн “Сераф”, “Херуб” гэсэн хоёр өөр төрлийн тэнгэр элчийн тухай гардаг. Сераф нь Библийн ганцхан

бүлэгт гардаг бөгөөд түүнийг 6 далавчтай хүнтэй адил биетэй хэмээн тодорхойлсон байдаг (Исаа 6:2, 6). Тэд галаар ариусгадаг тэнгэр элч шиг харагддаг (Тэдний нэрийн утга нь “шатаах”).

Херуб бол өндөр байр суурь эзэлдэг өөр нэг төрлийн тэнгэр элч юм. Учир нь Сатан тэдний нэг байжээ (Езекиел 28:14, 16). Адам ба Ева гэм нүгэлд унасны дараа тэдний Еден цэцэрлэгээс хөөхөд Херубууд цэцэрлэгийн дунд байрлах Амийн Модонд хэнийг ч ойртуулахгүйн тулд хамгаалагч болон томилогддог (Эхлэл 3:24).

Мөн Херуб нь Майхан Сүмийн гэрээний авдар (Египетээс гарсан нь 25:18-22), Даавуун хөшиг (Египетээс гарсан нь 26:1), халхавч (Египетээс гарсан нь 26:31) зэргийн нэг хэсэг гэж хэлсэн байдаг. Моис Өршөөлийн Суудал дээр байдаг хоёр Херубын дундаас Эзэний хэлэх үгийг сонсдог байжээ (Тооллого 7:89).

Херуб нь Соломоны сүмийн бас нэг чухал хэсэг юм. Хоёр Херубыг чидун modoор хийж, алтаар бүржээ. Тэдгээр нь 5 метрийн өндөртэй 5 метр урт далавчтай байжээ (Хаадын дээд 6:23-28). Тэд далавчаа Гэрээний Авдар дээгүүр дэлгэжээ (Хаадын дээд 8:6-7). Мөн тэднийг дотоод өргөөний хана болон хаалганд сийлдэг байжээ (Хаадын дээд 6:29-35). Мөн зарим сүмийн тавилганд байрлуулдаг байжээ (Хаадын дээд 7:29, 36).

Эш үзүүлэгч Езекиелийн үзсэн үзэгдэл Херубууд нь Бурхан хаан суудал байдаг өрөөг хөдөлгөж буй тухай гардаг (Езекиел 10:1-22). Библийн энэ хэсгээс харвал Херубийг сайтар ойлгох нь үнэхээр хэцүү боловч нь түүхэн чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. Тэдний үүрэг хараахан дуусаагүй. Учир нь тэд Мянганы Сүмд маш чухал хэсгийг эзэлнэ (Езекиел 41:18, 20, 25).

Херубын талаарх тодорхой зүйл нь тэд Бурханы төлөвлөгөөний нэг чухал хэсэг юм. Дараа бид тэдний үүргийг илүү нарийн судлах болно.

Г. Тэдний үйлчлэл

Тэнгэр элч нар түүхийн чухал үйл явдлуудад оролцжээ. Бурхан энэ ертөнцийг бүтээх үед тэд хамтдаа цуглаж баярлан хөөрч, талархал магтаалыг өргөжээ (Иов 38:6-7). Тэд Мосед хууль өгөгдөхөд тэнд байжээ (Галат 3:19; Еврей 2:2). Мөн Бурханы үнэн илэрхийлэгдэх үед тэнд бас оролцжээ (Даниел 7:15-27; 8:13-26; 9:20-27; Илчлэлт 1:1; 22:6, 8). Тэд зөвхөн израильчуудад (Даниел 12:1) бус, бас өөр үндэстнүүдэд санаа тавьжээ (Даниел 4:17; 10:21; 11:1; Илчлэлт 8-9, 16).

Тэнгэр элч нар Есүсийн төрөлтийг тунхаглаж (Матай 1:20), Түүний эцэг эхийг Египет уруу зугтахыг тушаасан (Матай 2:13-15) төдийгүй Египетээс буцаж ирэх үеийг нь ч товлосон (Матай 2:19-21). Тэд Түүнийг Сатанд соригдсоны дараа (Матай 4:11), мөн Түүнийг Гетсемани цэцэрлэгт байхад ч Түүнд үйлчилсэн (Лук 22:43). Тэд Түүний амилалтын үеэр (Матай 28:1-2), мөн Эцэг уруугаа буцахад нь тэнд байсан (Үйлс 1:10-11).

Тэнгэр элч нар эхэн үеийн Чуулганы үед сайн мэдээ тараагчдыг сайн мэдээ хүлээн авахад бэлэн болсон хүмүүс уруу илгээж (Үйлс 8:26; 10:3), зааварчилгаа хэрэгтэй нэгэнд нь алсын хараа өгч (Үйлс 10:3, 7), тэдний залбиралд хариулж (Үйлс 12:5-10), хүмүүсийг аюулаас авардаг байсан (Үйлс 12:11). Тэд Есүсийт эргэн ирэхэд үед ч (Матай 25:31; 2 Тессалоник 1:7), мөн шүүлтийн үед ч хамт байх болно (Илчлэлт 7:1; 8:2).

Тэнгэр элч нар Бурханыг магтаж (Дуулал 148:1-2; Исаа 6:3), Түүнд мөргөж (Еврей 1:6; Илчлэлт 5:8-13), Түүний тушаалыг биелүүлдэг (Дуулал 103:20; Илчлэлт 22:9).

Мөн тэнгэр элч нар зөвт бус хүмүүст оноосон шийтгэлийг гүйцэтгэдэг. Тэд ирж буй шийтгэлийг тунхаглаж (Эхлэл 19:13; Илчлэлт 14:6-7; 19:17-18), Бурханы заавраар зарим шийтгэлийг биелүүлж (Үйлс 12:23; Илчлэлт 16:1), хожим зөвт бус хүмүүсийг зөвт хүмүүсээс салгахад оролцно (Матай 13:39-40).

Тэнгэр элч нар одоо ч итгэгчдэд тусладаг (Еврей 1:14). Тиймээс бид ч гэсэн “*Харь хүмүүст зочломтгой хандахаа мартааж болохгүй. Учир нь зарим хүмүүс үүссээрээ тэнгэр элч нарыг мэдэлгүй зочилсон юм*” (Еврей 13:2). Тэд Христэд итгэгчдийн хийж буй зүйлийг ажиглаж (1 Коринт 4:9), биднээс суралцдаг (Ефес 3:8-10; 1 Петр 1:10-12). Бидний хүнд хэцүү цагт тэнгэр элч нар бидэнд ирж биднийг урамшуулан зоригжуулдаг (Үйлс 27:23-24). Биднийг нас барах үед тэнгэр элч нар биднийг мөнхийн улс уруу дагуулан явна (Лук 16:22).

Д. Сатан

1. Сатан гэж хэн бэ?

Сатан бол оюун ухаант (2 Коринт 11:3), сэтгэл хөдлөл (Илчлэлт 12:17; Лук 22:31), сонгох чадвартай (Исаиа 14:12-14; 2 Тимот 2:26) нэгэн юм. Зарим хүмүүс Сатаныг бүтээл биш зүгээр л нэг энгийн муу юмны нөлөө гэж үздэг. Харин Есүс Христ Сатан өөрийнхөө үйлдлийн хариуг хүртэж, хэзээ нэг өдөр Галт нуурт унаж шийтгэгдэх болно гэж хэлсэн (Матай 25:41). Нөлөөг шийтгэх ямар ч боломж байдаггүй. Тиймээс Сатаныг бүтээл гэж үл хүлээн зөвшөөрөх нь Есүс Христийн үнэнд эргэлзэх сэтгэл төрүүлдэг. Сатан Еден цэцэрлэгээс эхлэн хүн төрөлхтнийг Бурханы үгэнд эргэлзүүлэх аргыг хэрэглэж эхэлсэн (Эхлэл 3:1-5).

2. Юу болсон бэ?

Сатан бол төгс бүтээгдэж, дараа нь гэмд унасан хамгийн өндөр дээд хэргэмтэй Херуб байсан (Езекиел 28:12-15) Энд “Тирийн Хаан”-аар Сатанд юу тохиолдсоныг бидэнд жишээ болгон харуулсан. Тирийн хаан үзэсгэлэнт цэцэрлэгтэй байсан боловч энэ нь Еден цэцэрлэг байгаагүй. Түүнийг үнэт чулуугаар бүрхсэн байсан (28:13) боловч “тэр ариун газрыг бузарласан” (28:18) гэж бичсэн нь түүнийг тэргүүн тахилч тэнгэр элч байнсыг харуулж байна. Тэр тэргүүн тахилч байсан бөгөөд “их наймаагаараа” (Энэ нь түүний өөрийгөө дөвийлгөснийг илэрхийлж байна) тэр тэнгэр элч нарын гуравны нэгийг өөртөө урвуулсан (Илчлэлт 12:4).

Сатан Бурханыг унагахаар шийдсэн. Энэ нь Исаиа 14:12-14 ишлэлд гарч буй түүний үгээс илт харагдаж байна. Түүний гэм нүгэл нь бардам зан байсан (1 Тимот 3:6) бөгөөд Исаиа номд гарч буй гэм нүгэл нь түүний өөрийнхөө хүслийг илэрхийлсэн 5 өгүүлбэрт байдал (Бурхан юу хүсэх нь хамаагүй, миний хүсэл чухал). Сатан гэм нүглийг бий болгосон (Езекиел 28:15) тул үүнийхээ хариуг хүртэх болно (Матай 25:41). Гэм нүгэл нь түүний зүрх сэтгэлээс гарсан (Исаиа 14:13).

Сатаны өөрийнхөө хүслийг илэрхийлсэн анхны уг нь “*Би тэнгэр уруу гарна*” юм. Энэ нь Өөрийгөө Бурханы эрх тэгш болгох гэсэн санаа юм. Хоёр дахь нь “*Би Бурханы оддын дээр сэнтийээ босгено.*” Энэ нь тэнгэрээс тэнгэр элч нарыг удирдах гэсэн түүний хүслийг харуулж байна. Гурав дахь нь “*Би умардын хамгийн чанадад чуулганы уулан дээр заларна.*” Энэ нь вавилончуудын бүх ертөнцийг удирддаг гэж итгэдэг Вавилоны бурхдын байрладаг газрыг илэрхийлдэг. Түүний дөрөв дэх уг нь “*Би үүлсийн орой дээр гарна.*” Энэ нь Бурханы алдрыг өөртөө хүртэх гэсэн санаа юм. Тав дахь нь “*Би өөрийгөө Хамгийн Дээд Нэгэн шиг болгоно.*” Энэ нь Бурханы оронд эрх мэдэл хүч чадлыг нь булаан авах гэсэн түүний санаа юм.

Сатаны энэхүү гэм нүглийг судалсны дараа бид яагаад бидэнд “*Юуг ч өрсөлдөх сэтгэлээр, эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруугаар бие биеөөсөө дээр гэж үзэж...*” гэж хэлснийг бид хялбархан ойлгодог (Филиппой 2:3). Хэрэв бидэнд бардамнаж, өөрийн хүслийг дээгүүр тавьж эхэлбэл Сатаныг даган дуурайж байна гэсэн уг.

3. Сатаны нэр ба хэргэм зэрэг

Сатаны нэр, хэргэм зэрэг нь бидэнд түүний зан чанарыг сайтар илчилдэг. Түүнийг “Үүрийн цолмон” гэж нэрлэсэн байдал (Исаиа 14:12). Энэ нь “тэрэлтэгч” гэсэн утгатай бөгөөд латинаар “Лусифэр” гэдэг. Есүс Христ бол жинхэнэ “Үүрийн цолмон” (Илчлэлт 22:16) бөгөөд энэ нь Сатан гэмд унаснаасаа хойш Христийн дайсан байнсыг харуулж байна.

Түүнийг Сатан гэдэг. Түүнийг еврей хэлээр “Сатан” гэж хэлдэг учраас бид үсэгчлэн буулгасан. Энэ нь “эсэргүүцэгч” гэсэн утгатай (Тооллого 22:22, 32; 1 Самуел 29:4; 2 Самуэл 19:22; Хаадын

дээд 5:4; 11:14, 23, 25; Шастирын дээд 21:1; Иов 1:6, 7, 8, 9, 12; 2:1, 2, 3, 4, 6, 7; Дуулал 109:6; Зехария 3:1, 2; Матай 4:10; 12:26; 16:23; Марк 1:13; 3:23, 36; 4:15; 8:33; Лук 10:18; 11:18; 13:16; 22:3, 31; Иохан 13:27; Уйлс 5:3; 26:18; Ром 16:20; 1 Коринт 5:5; 7:5; 2 Коринт 2:11; 11:14; 12:7; 1 Тесалоник 2:18; 2 Тесалоник 2:9; 1 Тимот 1:20; 5:15; Илчлэлт 2:9, 13, 24; 3:9; 12:9; 20:2, 7). Сатан итгэгчдийг үргэлж буруутгадаг (Илчлэлт 12:10) боловч Есүс Христ биднийг өмгөөлдөг (1 Иохан 2:1-2). Сатан хүмүүсийг гэмд уруу татдаг (Эхлэл 3:1-5, Матай 4:3, 1 Тесалоник 3:5, Уйлс 5:3, 1 Коринт 7:5).

Түүнийг диавол гэж бас нэрлэдэг. Энэ нь “диаволос” гэдэг грек үгээс гаралтай бөгөөд “худалч” гэсэн утгатай (хэн нэгэнд хэн нэгний талаар худал хэлэх).(Матай 4:1, 5, 8, 11; 13:39; 25:41; Лук 4:2, 3, 6, 13; 8:12; Иохан 6:10; 8:44; 13:2; Уйлс 10:38; 13:10; Ефес 4:27; 6:11; 1 Тимот 3:6, 7; 2 Тимот 2:26; Еврей 2:14; Иаков 4:7; 1 Петр 5:8; 1 Иохан 3:8, 10; Иуда 1:9; Илчлэлт 2:10; 12:9, 12; 20:2, 10).

Түүнийг эртний могой гэж нэрлэдэг бөгөөд энэ нь түүний хуурамч дүр төрх, мэхлэлтийг илэрхийлдэг (Эхлэл 3:1, 2, 4, 13, 14; 2 Коринт 11:3; Илчлэлт 12:9, 14, 15; 20:2).

Мөн Сатаныг “улаан Луу” гэдэг. Энэ нь түүний дайн тулаанд илэрдэг хэрцгий мөн чанарыг илэрхийлдэг (Илчлэлт 12:3, 4, 7, 9, 13, 16, 17; 13:2, 4, 11; 16:13; 20:2).

Түүнийг бас Беелзебул гэдэг. Энэ нь “эсэргүүцэгчдийн эзэн”¹⁰⁴ гэсэн утгатай. Иудейчүүд энэ нэрийг чөтгөрүүдийн удирдагчид өгсөн (Матай 10:25; 12:24, 27; Марк 3:22; Лук 11:15, 18, 19).

Элч Паул түүнийг нэгэнтээ Белиал гэж нэрлэхдээ түүний зохисгүй, бузар чанарыг илэрхийлсэн (2 Коринт 6:15).

Сатаныг “энэ дэлхийн захирагч” (Иохан 12:31), “энэ ертөнцийн бурхан”(2 Коринт 4:4), “агаарын хүчний ноёрхогч”(Ефес 2:2), “эдүгээ дуулгаваргүй хөвгүүд дотор ажиллаж буй сүнс”(Ефес 2:2) гэж нэрлэдэг. Эдгээр бүх нэр нь Сатан Бурханыг бүрэн эсэргүүцдэг гэдгийг харуулж байна.

4. Түүний онөөгийн хийдэг ажлууд

Сатан Бурханы төлөвлөгөөг үгүй хийхийн тулд Бурханы төлөвлөгөө рүү үргэлж дайрдаг. Ингэснээр тэр өөрийнхөө зорилгод хүрэх боломжтой болдог (Исаиа 14:12-14). Сатаны төлөвлөгөө бол Бурханы төлөвлөгөөг булаан авч Бурханыг гадна үлдээх явдал юм. Тэрээр чөтгөр гэж нэрлэгддэг өөрийнхөө элч нар (1 Тимот 4:1) болон “өөрсдийгөө зөвт байдлын зарц нар болгон хувиргадаг” хүмүүсийг ашиглаж боломжит бүх аргыг хэрэглэдэг (2 Коринт 11:13-15).

Сатаны Бурханы төлөвлөгөө рүү хийх дайралтанд өөрийнх нь удирдсан Бурханы эсрэг чиглэдэг бүхэл бүтэн дэс дараалал бүхий систем байдаг. Энэхүү дэс дараалал бүхий системийг грекээр “дэлхий” буюу “КОСМОС” гэдэг. “КОСМОС” гэдэг үгийн гол утга нь “дэс дараа” юм.¹⁰⁵

Сатан өөрийнхөө төлөвлөгөөг биелүүлэхийн тулд эхлээд хүмүүсийн “бодол санааг сохолдог” (2 Коринт 4:4). Ингэснээр үл итгэгчид Есүс Христийн сайн мэдээг хүлээж авдагтүй бөгөөд Эзэний тухай сонссон үнэний үгийг өөрсдөөсөө зайлцуулах гэж оролдог (Лук 8:12). Үл итгэгчдийн “бодол санааг сохлохын” тулд Сатан “бурханлаг байдлын дүртэй байх боловч түүний хүчийг нь үгүйсгэдэг” Христэд итгэгчдийг дуурайгчидыг ихэвчлэн ашигладаг (2 Тимот 3:5). Гадна талдаа “христитгэгч” юм шиг харагддаг боловч дотор талд нь Сатан ажиллаж байдаг (Матай 23:25-26). Энэхүү дуураймал христитгэгчдийн систем нь янз бүрийн хэлбэртэй байдаг бөгөөд зарим нь өөрсдийгөө үгүйсгэдэг (Колоссай 2:16-23), зарим гэм нүглийг хүлээн зөвшөөрч өөрсдөө үйлддэг (Ром 1:32; Илчлэлт 2:24). Сатан хэн нэгнийг Бурханы хаант улсад оруулахгүйн тулд бүхнийг хийдэг (Колоссай 1:13; 1 Иохан 2:15-17).

Хүн Есүс Христийг аврагч Эзэнээ болгон хүлээн авах үед Сатаны байгуулсан тэрхүү систем болох дэлхийг ялан дийлдэг (1 Иохан 5:4-5). Хэдий тийм боловч Сатан тэр аврагдсан хүнийг зүгээр орхихгүй. Тэрээр “хулгайлж, алж, устгахын” тулд “хулгайч” мэт ирдэг (Иохан 10:10). Учир нь тэр

хүн төрөлхтнийг үзэн яддаг (Дуулал 69:1-4; Матай 10:22).

Түүний устахыг хүсдэг хамгийн чухал бай бол жинхэнэ Христэд итгэгч гэрчлэгч юм. Ингэснээр бусад хүмүүс Бурханы хаанчлалд орох хүсэлгүй болно. Тэрээр итгэгчдийг энэ дэлхийн шаардлагын дагуу, дэлхийн мөн чанараар амьдруулах гэж сорьдог (1 Тесалоник 3:5; 1 Иохан 2:15-17). Мөн итгэгчдийг өөрийнхөө аминч үзлийг нуух хэрэгтэй гэж ятгадаг (Үйлс 5:1-3). Мэдээж тэднийг ёс бус зүйлсийг үйлдэхэд уруу татдаг (1 Коринт 7:5).

Сatan “*хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг*” (1 Петр 5:8). Энэ нь тэрээр өөрийнх нь уруу татлагад амархан автах хүнийг эрэн хайж ингэснээр “ах дүүсийг буруутгах” гэж оролддог (Илчлэлт 12:10). Тэрээр итгэгч хүнд маш их дарамт шахалтыг үзүүлж, тэр хүнийг Эзэний дагалдагчаас болиулах гэж оролддог (Лук 22:31).

Сatan өөрийнхөө мөн чанарын улмаас (Иохан 8:44) аливаад шударгаар ханддаггүй гэдгийг сайн санах хэрэгтэй. Тэр өөрийнхөө зорилгод хүрэхийн тулд хэнийг ч, юуг ч ашиглана.

E. Сатаны элчүүд

Сатаны элчүүд бол түүнийг дагахаар шийдсэн тэнгэр элч нар бөгөөд бүх тэнгэр элч нарын гуравны нэг юм (Илчлэлт 12:4). Эдгээр тэнгэр элч нарыг “чөтгөр,” “бузар сүнс” гэж нэрлэдэг. Эдгээр нь Сатантай хамт бослого гаргасан бүтээлүүд бөгөөд Сатан тэдний “ханхүү” юм (Матай 12:24). Чөтгөр гэж орчуулагдсан грек үг нь харийн шашны шүтээнийг илэрхийлсэн үг ажээ. Харин “бузар сүнс” гэдэг үг нь гэм ба бузар үйлд оролцсон сүнслэг биетийг нэрлэдэг аж. Бид дээр өгүүлсэнчлэн тэд Сатаны засаг захиргаанд янз бүрийн байр суурь, эрх мэдэлтэй байдаг. Чөтгөр ихэвчлэн хүчтэй байдаг (Марк 5:3; Үйлс 19:16) бөгөөд өөрийнхөө хүч чадлаар олон зүйлийг гүйцэлдүүлж чадна.

Тэдний Есүсийг таньснаас (Марк 1:24), мөн өөрсдийнхөө шийтгэлийг мэддэг (Матай 8:29), өөрсдийн онолыг бий болгож, тараан түгээж байгааг (1 Тимот 4:1-3) харвал Сатаны элч нар мэргэн ухаантай болох нь харагдаж байна. Тэд хэдийгээр авралын төлөвлөгөөг мэддэг боловч хүлээж авах боломжгүй (Иаков 2:19).

Сатаны элч нар Бурханыг эсэргүүцсэн бүх юуг ч байсан хийдэг. Тэд Түүний илчилсэн хүслийг гүйвуулж, бүх сайн сайхны төлөө хүртэх Эзэний гавьяя шагналыг өөрсөддөө булаан авдаг.

Чөтгөрүүд төрөл бүрийн шүтээн, ид шидийн урлагт оролцдог (Үйлс 16:16). Хүн амьд Бурхан болон өөрсдийнхөө хооронд хэн нэгнийг, эсвэл ямар нэгэн юмыг тавих шүтээн шүтэх явдал юм. Тэр шүтээн нь мод чулуугаар хийсэн, эсвэл антихрист хүнийг шүтэх явдал ч байж болно (Илчлэлт 13:15). Хүн төрөлхтөн өөрсдийн оюун ухааныг шүтэх боломжтой (Иохан 5:39-40). Чөтгөрүүд амьд Бурханаас өөр бусад зүйлсийг шүтүүлэхийн тулд хүмүүсийг уруу татдаг.

Чөтгөрүүд мөн худал шашныг дэмждэг. Худал шашин нь худал “аврагчийг” (1 Иохан 4:1-4), үйлсээр аврагдах тухай (1 Тимот 4:3-4 уд.харьц. Ефес 2:8-9), бузар муу нь сайн гэж үзээд янз бүрийн бузар зүйлс үйлдэх хэрэгтэй (Илчлэлт 2:20-24 уд.харьц. Галат 5:13, Ром 6:1) гэж тунхагладаг итгэлийн нэг төрлийн систем юм.

Чөтгөр хүний махан биеийг өвчлүүлэх (Матай 9:33), оюун санааны өвчтэй болгох (Марк 5:4-5) чадвартай. Хэдий тийм боловч БҮХ махан биеийн өвчин нь Сатаны үйл ажиллагааны үр дүн БИШ юм. Учир нь Библи Сатаны өвчин ба энгийн өвчний талаар тодорхой зааг байдаг тухай өгүүлдэг (Матай 4:24; Марк 1:32, 34; Лук 7:21; 9:1).

Чөтгөр мөн хүмүүст (Лук 8:28-31), амьтанд (Лук 8:32-33) шүглэх боломжтой. “Шүглэх” гэдэг нь тухайн хүний дотор нь орж тэр хүний махан биеийг удирдах гэсэн утгатай. Нэгэнт Библи бидэнд “*та нарын дотор байгаа Тэр (Ариун Сүнс) бол дэлхийд байгч нэгнээс аугаа*” (1 Иохан 4:4) гэж хэлсэн тул итгэгч хүнд Сатан шүглэх ямар ч боломжгүй. Итгэгч хүн чөтгөрийн нөлөөнд хэт автах боломжтой бөгөөд энэ нь чөтгөр шүглэсэн мэт харагдаж болох юм. Чөтгөрт эзэмдүүлсэн хүмүүс янз бүрийн авир

гаргадаг ч (Лук 8:28-31) Сатан өөрийгөө “гэрлийн тэнгэр элч” (2 Коринт 11:13-15) мэт хувиргаж чаддагыг ч марталгүй байцгаая. Аль сүнснээс вэ гэдгийг нь ялгах хамгийн чухал хүчин зүйл бол Есүс Христийн тухай юу ярьж байгаа нь юм (1 Иохан 4:1-4).

Итгэгчдийг Сатан “залгидаг” арга замуудаас бид суралцах нь их чухал юм (2 Коринт 2:11). Тэр бидэнд алдар нэр (хүмүүсийн анхаарал), аз (мөнгө, янз бүрийн эд хөрөнгө), хүч (эрх мэдэл), махан биеийн таашаал өгдөг. Түүний нэг арга бол Бурханы бидэнд аль хэдийн өгсөн зүйлсийг амлах явдал юм. Бурхан бидэнд аль хэдийн “нэр алдрыг” өгсөн. Учир нь бид Бурханы хүүхдүүд болсон (1 Иохан 3:1). Бурхан бидэнд “аз” өгсөн. Учир нь бид бидэнд Бурхан мөнх амийг өгч тэнгэрийн улсын иргэн болгосон (Ефес 2:19-20). Тэр бидэнд “хүч”-ийг өгсөн. Учир нь бид Эзэн Бурхантай өөртэй нь нэгдсэн (Ром 8:1-2). Тэр бидэнд “таашаал” өгсөн. Учир нь тэр бидэнд *“бүх оюун ухаанаас дээгүүрх амар тайван”*-ыг өгсөн (Филиппой 4:7).

Бид Сатаны арга замыг судлахдаа болгоомжтой байх хэрэгтэй. Учир нь тэр биднийг Бурханы системийг биш өөрийнх нь системийг судлахад түлхүү анхааруулбал тэр яллаа гэсэн үг. Тэрээр өөрийнхөө системийг хэдэн мянган жилийн турш хөгжүүлсээр ирсэн бөгөөд хэдэн зуун мянган худал дуурайгчдыг бэлтгэн гаргасан. Эдгээр худал дуурайгчдыг ялгах нэг арга бол жинхэнэ үнэнийг сайтар мэдэх явдал бөгөөд тэр даруй бид тэднийг илчиж чадах болно.

Хэрэв бид Сатан болон түүний чөтгөрүүдийг өөрсдийнхөө амьдралд нээн харж чадахгүй бол Бурхан уу, эсвэл Сатан уу гэдгийг мэдэхгүй самгардах болно. Элч Паул бидэнд маш тодорхой ингэж анхааруулсан.

Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг бии, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчинүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчиний эсрэг билээ. Тиймээс бүхнийг хийсний дараа, бузар муу өдөрт эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг ав. (Ефес 6:12-13)

Хувийн Судлал: 6-р бүлэг, 2-р хэсэг

1. **Дараах ишлэлүүдийг уншаад, тэнгэр элч нар ямар шинж чанартайг бич.**
 - A. 1 Петр 1:12
 - B. Лук 2:13
 - C. Иуда 6
2. **Лук 24:4-ийг унш. Тэнгэр элч нар хүний төрхөөр хувирч чадах уу?**
3. **Еврей 2:6-7 ишлэлийг унш. Хүн төрөлхтөн дээд зэрэглэлийн биет үү, эсвэл доод зэрэглэлийнх үү?**
4. **Дуулал 148:2-5 ишлэлийг унш. Хэн тэнгэр элч нарыг бүтээсэн бэ**
5. **Лук 20:35-ыг унш. Тэд хүүхэдтэй юу?**
6. **Ефес 6:12-ыг унш. Сатаны элч нар зохион байгуулалтын хувьд хэргэм зэрэгтэй юу?**
7. **Илчлэлт 12:7-г унш. Бурханы армийг удирдагч нь ямар тэнгэр элч вэ?**
8. **Херуб, Сераф хоёрын аль Библид олон удаа гардаг вэ?**
9. **Еврей 1:14-ийг унш. Тэнгэр элч нарын үндсэн үүрэг юу вэ?**
10. **Илчлэлт 12:7-9 ишлэлийг унш. Сатан гэж хэн бэ?**

11. Матай 25:41-ийг унш. Сатаны төгсгөл ямар байх вэ?
12. Исаиа 14:12-14 ишлэлийг унш. Сатаны хамгийн анхны гэм нүгэл юу вэ?
13. “Сатан” гэдэг нь юу гэсэн утгатай үг вэ?
14. “Чөтгөр” гэдэг нь ямар утгатай үг вэ?
15. Сатаныг яагаад “могой” гэж нэрлэсэн бэ?
16. 2 Коринт 11:13-15 ишлэлийг унш. Сатан болон түүний ажилчид хууран мэхлэхийн тулд юу ашигладаг вэ?
17. 2 Коринт 4:4-ийг унш. Сатан болон түүний ажилчид юуг гүйцэлдүүлэх гэж оролддог вэ?
18. Сатаны тэнгэр элч нарыг ихэвчлэн ямар хоёр нэрээр нэрлэдэг вэ?
19. 1 Иохан 4:1-4-ийг унш. Сүнсийг ялгах чухал хүчин зүйл юу вэ?
20. Ефес 6:12-13 ишлэлийг унш. Итгэгч хүний хэний эсрэг жинхэнээсээ дайтах хэрэгтэй вэ?

З-р хэсэг

Хүн (Хүн Судлал)

A. Хүнийг бүтээсэн нь

Бурхан Эцэг, Хүү, Ариун Сүнсний төлөвлөгөө ёсоор хүн бүтээгдсэн (хамтдаа нэг Бурхан). Энэ төлөвлөгөөг бид дараах ишлэлээс харж болно: “**Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгөө адилхан хүнийг бүтээж ...**” (Эхлэл 1:26). Хүнийг бүтээхэд Бурханы Гурвал хамтдаа оролцсон.

Энэ төлөвлөгөөний нэг зорилго нь хүнийг Бурханы “дүр төрх”-өөр, Түүнтэй “адилхан”-аар бүтээх явдал байсан. “Дүр төрх” гэсэн утгатай еврей үг “ТСЕЛЕМ”, харин грек үг “ЭЙКОН” нь хүний бие махбодын материаллаг талыг, харин “адилхан” гэсэн утгатай “ДЕМУТ” гэх еврей үг, мөн “ХОМОЙСОСИС” гэх грек үг нь хүний оюун санааны талыг үндсэндээ илэрхийлдэг аж. Эдгээр ойлголт нь нэлээд өргөн хүрээг хамарсан ерөнхий ойлголт учраас хэт явцуу хүрээнд авч хэрэглэж болохгүй. Бурхан хүнийг материаллаг болон оюун санааны хувьд бүрэн бүтээхээр төлөвлөсөн. Түүний төлөвлөгөө ёсоор хүн амьтай, оюун ухаантай, ёс суртахуунтай байхын зэрэгцээ Бурхан шиг шийдвэр гаргах чадвартай, гэхдээ Бурхан биш байх ёстой байлаа. Тэгснээр, тэр Бурхантай нөхөрлөх боломжтой болох байлаа.

Анхны хүн Адамыг Бурхан Өөрийн гараар бүтээсэн. “**Эзэн Бурхан тоос шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч болжээ**” (Эхлэл 2:7) гэж Библи бидэнд хэлдэг. “Амьд оршигч” хэмээн орчуулагдсан “НЕФЕШ” хэмээх еврей үг нь “сэтгэл, сүнс” гэсэн утгыг илэрхийлдэг. Бурхан хүний материаллаг хэсэг болох биеийг өмнө нь Өөрийн бүтээсэн байсан материаллаг зүйл болох газар шорооноос бүтээсэн. Харин хүний сүнсийг (хүний биеийн материаллаг бус тал) юунаас ч аваагүй (Эхлэл 1:27). Дараа нь Тэр дээрх хоёр хэсгийг хооронд нь нэгтгэж, “хүн” хэмээх нэгэн зүйлийг бий болгосон.

Адам онцгой бүтээл байсан гэдгийг санах хэрэгтэй. Тэр бусад бүх хүн шиг эхийн хэвлийгээс төрөөгүй. Түүнийг нас биед хүрсэн, оюун ухаантай эр хүн чигээр нь бүтээсэн. Бурхан түүнийг Еден цэцэрлэгт авчирч тавиад, бүх амьтдад нэр өгөх зөвшөөрлийг өгчээ (Эхлэл 2:8, 19).

“**Хүн ганцаараа байх нь сайн биши**” (Эхлэл 2:18) гэж Бурхан үзсэн учраас Адамд тохирох туслагчийг бүтээхээр шийдсэн. Түүнийг эр хүнээс гаргаж авсан (Эхлэл 2:18-23) тул “эмэгтэй” хэмээн дуудах болж, “**амьд бүхний эх**” (Эхлэл 3:20) болсон учраас “Ева” гэдэг нэр өгчээ. Бурхан эмэгтэй хүнийг өмнө байсан материалаас (Адамын “хавирга”) бүтээж, эмэгтэй хүний бие галбиртай болгоод, улмаар амийг өгсөн гэж бичсэн байдаг (Эхлэл 2:21-23). Эрэгтэй, эмэгтэй хүн хоёулаа Бурханы гараар бүтээгдсэн, онцгой бүтээл юм. Тэд бүтээлийн доод хэв шинжээс дээд хэв шинж руу хувьсан өөрчлөгдсөн юм биш.

Түүнчлэн, Бурхан “**шороогоор**” ан амьтдыг бүтээж, тэдэнд мөн амь амьдралыг өгсөн (Эхлэл 2:19). Гэхдээ амьтдыг “Бурханы дүр төрх”-өөр бүтээсэн гэж хэлсэн ишлэл нэг ч байдаггүй. Тэднийг амьтай гэдэгтэй маргах хүн мэдээж нэг ч байхгүй, харин зарим амьтан тодорхой хэмжээний ой ухаантай байдаг гэж маргах хүмүүс мэр сэр гардаг. Гэсэн ч ёс суртахууны шийдвэр гаргах (зөв, бурууг ялгах) чадвартай нэг ч амьлан байхгүй (2 Петр 2:12; Иуда 1:10).

B. Хүн гэмд унасан нь

Бурхан эрэгтэй, эмэгтэй (Адам, Ева) хүнийг бүтээгээд Еден цэцэрлэгт авчирч тавьсан (Эхлэл 2:10, 15). Эрэгтэй хүн тэр цэцэрлэгийг арчилж сахих ёстой байсан (Эхлэл 2:15). Бурхан түүнд “Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно. Харин чи **сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй**” (Эхлэл 2:16) гэж хэлжээ. Хэрэв сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идвлэл “зайлшгүй үхнэ” (Эхлэл 2:17) гэж анхааруулсан нь Бурханы Үгийг зөрчсөн хүн бие махбод болон сүнс гарцаагүй үүнийхээ шийтгэлийг хүртэх болно гэсэн санааг илтгэж байна.

“Могой” (Сатан, Илчлэлт 12:9) эмэгтэй хүнээр дамжуулан эрэгтэйд хүрсэн. Тэр Еваг мэхэлж (2 Коринт

11:3; 1 Тимот 2:14), хориотой жимснээс идүүлсэн. Дараа нь Ева жисмийг Адамд өгснөөр Адам ч бас Бурханы тушаалыг зөрчсөн (Эхлэл 3:6).

Хүн төрөлхтнийг уналтад хүргэсэн үйл явдлуудыг жаахан дэлгэрүүлэн авч үзэцгээе. Эмэгтэйг эрэгтэйгээс хол байх үед могой түүнд ойртон очсоныг анзаараарай. Еден цэцэрлэгийг эр хүн арчижл “сахих” (хамгаалах) ёстой байсан (Эхлэл 2:15) учраас тэнд эр хүн эрх мэдэлтэй байсан. Бурхан тэр хоёрт нэг модыг заагаад, жимсийг нь идэхийг хориглосон (Эхлэл 3:1). Могой эмэгтэйг өөрийнх нь урхинд амархан орно гэж бодсон учраас түүн уруу ойртож очсон.

Сатан эмэгтэйтэй яриа өдөж, Бурханы тушааснаас эсрэг зүйлсийг илтгэсэн асуултуудыг тавьж эхэлсэн. “Энэ цэцэрлэгт байгаа бүх модны жимснээс идэж болохгүй гэж Бурхан та наарт үнэхээр хэлсэн үү?” (Эхлэл 3:1) гэж могой асуусан. Үнэндээ энэ нь ямар ч утгагүй асуулт байсан юм. Яагаад гэвэл, хэрэв тэднийг уг цэцэрлэгийн бүх модноос жимс идэж болохгүй гэж хориглосон байсан бол тэд хоол хүнс олж идэхийн тулд цэцэрлэгийг орхин явах шаардлагатай болох байсан. Сатан энэ асуултаар Бурханы сайн сайхан уруу довтолж эхэлсэн. Түүнчлэн эмэгтэйн мэдэж байгаа зүйлийг болон тэрээр Бурханы тушаалуудад хэр ул суурьтай хандаж байгааг мэдэхийн тулд энэ асуултыг ашиглажээ.

Эмэгтэй могоид хэрхэн хариулсан тухай маш тодорхой бичсэн байдаг (Эхлэл 3:2-3). Тэрээр могойн асуултад хариулахдаа түүний хэлснийг залруулахыг хичээсэн боловч Бурханы тушаалд хэлэгдээгүй, “түүнд бүү хүр” гэсэн үгийг нэмж хэлсэнд асуудал оршдог. Магадгүй, Адам Бурханы тушаалыг Евад дамжуулахдаа үүнийг нэмж хэлсэн байх гэж зарим хүн боддог. Гэхдээ энэ хэсгийг хэн нэмсэн нь чухал биш. Тэд хоёулаа Бурханы Үгэн дээр өөрсдийн дураар үг нэмэх болж, улмаар түүнд эргэлзэж эхэлсэн. Сатан энэ үгийг ашиглан Бурханы шийтгэл (Эхлэл 3:4) болон хандлагад (Эхлэл 3:5) эргэлзүүлэхийг хичээсэн. Тэрээр “сайн мууг мэддэг” болох тухай ярихдаа тэдэнд маш их ач тустай зүйлийг Бурхан нуун дарагдуулж байгаа мэтээр тайлбарласан.

Бурхан зөвхөн “сайхан” зүйлийг бүтээдэг гэдгийг мартаж болохгүй (Эхлэл 1:4, 10, 12, 18, 21, 25, 31; 2:9, 12). Гэхдээ Бурханаас биш сайн сайхан зүйл ч байж болно. Өөрөөр хэлбэл, сайн юм болгоныг Бурханаас гэж хэлж бас болохгүй юм. Гэхдээ, хэдийгээр ийм зүйлсэд Бурханы гар оролцоогүй ч эдгээр нь бусдад хор хөнөөл учруулдаггүй. Жишээ нь, хэн нэгэн хүн ам нь цангасан хүнд ус авчирч өгөхдөө Бурханы хүслийг гүйцэлдүүлэхийн (Марк 9:41) тулд биш, харин бусдаас сайшаал хүртэх зорилготой байж болох юм. Ийм “сайн” үйлс нь Бурханыг шахан зайлцуулдаг. Бидний дээр үзсэнчлэн, Сатан энэ дэлхий дээр өөрийн хаанчлалыг тогтоож, Бурханыг шахан зайлцуулахыг хүсдэг.

Могой эмэгтэй хүний аливааг харах нүд, оюун ухаан уруу хандсан (Эхлэл 3:6). Яг энэ мөчид тэр итгэлээр алхахаа больсон. Тэрээр Бурханд биш, харин өөртөө итгэж эхэлсэн. Бурхан шиг ухаантай болж болно гэж Сатан эмэгтэйд хэлсэн (Эхлэл 3:5). Хэрэв Бурхан шиг ухаантай болчихвол амьдралынхаа төлөө цаашид Бурханд найдах шаардлагагүй болж, улмаар өөрийнхөө дүрэм журмыг тогтоож болж гэж түүнд ойлгуулжээ. Тийнхүү Сатан өөрийнхөө үхэн хатан зүтгэдэг Бурхан болох хүслийг (Исаиа 14:12-14) эмэгтэйн дотор өдөөж санасандаа хүрчээ. “*Итгэлгүйгээр таалагдана гэж боломжгүй*” (Еврей 11:6) гэдгийг бид мэднэ. Эмэгтэй хориотой модны жимснээс идэх үедээ Бурханд итгээгүй. Сатан эмэгтэйг мэхлэн, Бурхан үнэндээ сайн биш учраас түүнд Бурханы шаардлага байхгүй бөгөөд итгэлгүйгээр амьдралын сайхныг мэдэрч болдог гэж ойлгуулсан (2 Коринт 11:3). Тийнхүү эмэгтэй тэрхүү жимснээс идсэн.

“Тэр бас өөртэйгээ хамт байсан нөхөртөө өгч, тэр ч иджээ” (Эхлэл 3:6) гэж Сударт бичсэн байдаг. Адамыг жимснээс идэхийн өмнө эхнэр нөхөр хооронд ямар яриа болж өнгөрсөн нь бидэнд тодорхойгүй. Мөн (1 Тимот 2:14) Адам өөрийгөө могоид мэхлэгдээгүй гэхээс өөр юу бодож байсныг бид мэдэхгүй. Адам зориудаар гэм үйлдсэн. “Тэр иджээ” (Эхлэл 3:6) гэснээс өөр зүйл Сударт тэмдэглэгдээгүй байдаг. Тэд хоёулаа гэм үйлдсэн боловч өөр өөр шийтгэлийг авсан.

Адам, Ева хоёр тэр даруйдаа Бурханы тушаалыг зөрчсөнөө ойлгож, ихэд айсан. Тэд нүцгэн байгаагаа мэдээд (Эхлэл 2:25-ыг 3:7-той харьцуул), навчсыг хооронд нь холбож, өөрсдөдөө бэлхэмж хийн өмсөн

(Эхлэл 3:7) ичгүүрээсээ гарагыг хичээв. Дараа нь тэд Бурханаас нуугдах гэж оролдсон (Эхлэл 3:8). Хүн өөрийгөө аврах гэсэн анхны оролдлого энэ байлаа.

В. Нүгэлд унасных нь төлөө хүнд оноосон шийтгэл

Эхлээд могойг шийтгэсэн. Тэр үлдсэн бүх амьдралаа тоос шороо идэж өнгөрөөх болсон (Эхлэл 3:14). Могой Сатан байсан юм биш, харин Сатан мөгий болж ирсэн юм (Сатан газар дэлхий дээгүүр хэрэн тэнүүчлэхийн [Иов 1:6; 2:1] зэрэгцээ ах дүүсийг буруутгахын тулд тэнгэрт ч хүрэх чадалтай [Илчлэлт 12:10]). Сатаны зэмсэг болсных нь төлөө Бурхан мөгийг харааж, газар дэлхий дээрх хамгийн аймшигтай, зэвүүцмээр амьтан болгожээ (Эхлэл 3:14).

Могойд ярих чадвар өгснийхөө төлөө Сатан бас шийтгэгдсэн. “Тэр эмэгтэйн үр хүүхэд” болон түүний хооронд байнгын тэмцэлтэй байх болно (Эхлэл 3:15). Мессиагийн тухай өгүүлсэн Библийн хамгийн анхны ишлэл энэ юм. Эрэгтэй хүнээс салбарласан үр удмыг ихэнхдээ “үр хүүхэд” гэж хэлдэг (Эхлэл 12:7; 22:17, 18 ба бусад) учраас энэ ишлэл нь Түүний онцгой төрөлтийн мөн чанарыг дүгнэдэг. Мессия онгон бүсгүйгээс төрнө гэж Сударт хожим маш тодорхой хэлсэн байдаг (Исаиа 7:14). Мессиагийн тухай бусад бүх эш үзүүллэгүүд энэ эш үзүүллэгтэй холбогддог (уд.харьц. Илчлэлт 12:4-5). Могой Мессиагийн өсгийг няцалж (загалмайн дүрслэл), харин Мессия түүний толгойг няцлах (ялалт) болно.

Нүглийн төлөөх эхний шийтгэл нь гэм буруугийн талаарх мэдрэмж (Эхлэл 3:7, “нуцгэн байгаагаа мэдээд”) болон нөхөрлөлөө алдах явдал байсан (Эхлэл 3:8).

“Би чиний жирэмсний зовлонг үлээмж ихэсгэх ... болно” (Эхлэл 3:16) гэж Бурхан эмэгтэйд хэлсэн. Түүнчлэн эмэгтэй нөхрөө захирахыг, бас нөхөртөө захирагдахыг хүсэх болно. Энэ нь Ева (нөхөртөө жимс өгөхдөө) нэг талаас нөхрөө удирдахыг хүсэж байсан, гэхдээ нөгөө талаас нөхрөө өөрийг нь болиулахыг хүсэж байсантай яг адилхан зүйл юм.

Дараа нь Эзэн эмэгтэйг буруутгасан Адамын буруутгалд хариулсан (Эхлэл 3:17). Адам эмэгтэйг сонсох ёсгүй байсан гэдэг нь тодорхой зүйл юм. Гэхдээ энэ ишлэлийг бүрэн ойлгоогүй хүн эхнэрийнхээ үгийг хэзээ ч сонсож, хүлээн авах ёсгүй юм байна гэж бодоход хүрч болох юм. Энэ бол буруу ойлголт, учир нь Бурхан нэгэн удаа Абрахамыг эхнэр Сарагийнхаа үгийг сонсож, хүлээн ав гэж хэлж байсан (Эхлэл 21:22). Хэн нэгний үгийг хүлээж авах хэм хэмжээ нь Бурханы хэлсэн зүйл дээр үргэлж суурилж байх ёстой. Адамын гэм нүгэл нь эхнэрийнхээ үгийг сонссонд биш, харин хориглосон жимсийг идсэн түүний сонголт дээр үндэслэж байв. Адамыг хараасан хараалд хоолоо олж идэхийн тулд хүнд хүчир ажил хөдөлмөр эрхлэх шаардлага багтдаг (Эхлэл 3:17-19).

Хориглосон жимсийг идэх үед оногдох болно гэж хэлсэн анхны шийтгэл хүчингүй болоогүй. Адам нүгэл үйлдэх үедээ Бурхантай нөхөрлөх нөхөрлөлийг алдаж, сүнсээр үхсэн юм. Харин түүний бие махбод 930 жилийн дараа үхсэн (Эхлэл 5:5). Бурхан Адам Ева хоёрт нигүүлслээ үзүүлж, тэднийг амьтны арьсаар хувцасласан (Эхлэл 3:21). Амьтны арьстай болохын тулд гэм зэмгүй амьтныг тахил болгон алах шаардлагатай байв. Энэ бол гэм нүглийн төлөөсөнд тахил шаардлагатай гэдгийг тодорхой харуулсан зураглал бөгөөд энэ нь Мессия дотор бүрэн төгс биелсэн юм (Еврей 10:10, 12).

Эзэн Адам Ева хоёрыг хувцасласныхаа дараа тэднийг Еден цэцэрлэгээс гаргаж явуулсан (Эхлэл 3:22-24). **“Тэр одоо гарaa сунган, бас амийн модны жимснээс авч идээд, мөнх наслах вий”** гэсэн учир тэднийг ийн хөөж явуулжээ. Хараал дор буй гэм нүгэлт хүн ийм байдалтайгаа мөнх амьдрах нь сайн зүйл биш гэдгийг ойлговол Бурхан яагаад үүнийг хийсэн бэ гэдгийг ойлгоход тийм ч хэцүү биш байх болно. Итгэгчдийн хувьд үхэл бол сайн зүйл байх болно, учир нь тэд Мессия Есүс Христтэй адилхан цэвэр ариун, төгс шинэ бие дотор үхлээс амилж (1 Иохан 3:2), ямар ч хараал байхгүй, харин Амийн мод байгаа тэнгэрт очих болно (Илчлэлт 22:2-3).

Г. Хүмүүний мөн чанар

1. Бие

Бурхан Өөрийн дүр төрхөөр Адамыг тоос шорооноос бүтээх үед хүний “бие” анх бий болсон (Эхлэл 1:26) бөгөөд дараа нь Адамаас Еваг бүтээсэн (Эхлэл 2:7, 21). Адам, Ева хоёр бэлгийн

харьцаанд орж, үр хүүхэдтэй болсон. Эхнийх нь Кайн, Абел хоёр байв (Эхлэл 4:1, 2). Бусад хүн төрөлхтөн Адам, Ева хоёроос үссэн. Ева гэдэг нэр нь үнэндээ “*амьд бүхний эх*” (Эхлэл 3:20) гэсэн утгатай.

Бие бол хүний материаллаг хэсэг юм. Энэ нь харах, хүрэх, сонсох, амтлах, үнэртэх мэдрэхүйтэй. Бидний биеийн өөр өөр хэсгүүд нь, толгой, гар, хөл гээд бүгд маш адилхан. Гэхдээ эдгээр нь бүгд адилхан үүрэгтэй байдаггүй гэдгийг анхаарах нь чухал юм. Бид гараараа алхаж, эсвэл хөлөөрөө хоол иддэггүй. Бидний бие нь “Чуулган”, “Христийн бие” гэж нэрлэгддэг сүнслэг биеийн талаар бидэнд заахаар зохион бүтээгдсэн (Ром 12:4-5). Итгэгч хүн бүхэн сүнслэг биеийн нэгэн хэсэг бөгөөд тэрхүү бие дотор бүгд маш чухал агаад өөр өөр үүрэгтэй (1 Коринт 12).

Бие бол хүний материаллаг бус хэсгийн орон гэр байхаар Бурханаар бүтээгдсэн маш гайхалтай организм юм. Эзэн газар дэлхий дээрх Өөрийн биеийг бидний гэм нүглийн төлөөх тахил болгон өргөж (1 Коринт 11:24), тийнхүү биднийг “*ариун, өөр сэвгүй бөгөөд гэмгүй*” болгож, Эцэгтэй эвлэрүүлсэн (Колоссай 1:21-22). Эзэн бидний гэм нүглийн төлөөсийг Өөрийн биеэр төлсөн (1 Петр 2:24).

“Христийг дуурайгчид” (1 Коринт 11:1) бид өөрсдийн биеийг Эзэнд амьд тахил болгон өргөдөг бөгөөд ингэснээрээ Тэр үүнийг Өөрийн хүслийн дагуу ашигладаг (Ром 12:1-2). Христ бидний бие дотор, амьдралын бүхий л хэсгээр тэр ч байтугай үхлээр хүртэл алдаршдаг (Филиппой 1:20).

Бид энэхүү бие дотор байхдаа хийсэн үйлсийнхээ төлөө нэгэн өдөр Эзэний өмнө шүүгдэх болно (2 Коринт 5:10) гэдгийг ойлгож, өөрсдийн биеийг үйлчлэлд бэлэн байлгахын тулд өөрсдийн зүгээс хийх ёстой зүйлээ хийдэг байх хэрэгтэй (1 Коринт 9:27). Хэдийгээр хэл нь бидний биеийн жижигхэн хэсэг боловч уг яриаг маань бас удирдаж байдаг (Иаков 3:2-5). Бидний гэм нүглийн төлөөх Есүс Христийн үхлийн мэдээг бид биедээ тээж явдаг бөгөөд ингэснээрээ мөн Есүсийн амь бидний бие дотор илэрхийлдэх юм (2 Коринт 4:10).

Нэгэн өдөр энэ дэлхийн бие маань шинэ биеэр солигдож, цаашид үхлийн шийтгэл дор байхaa болино (1 Коринт 15:40-44). Энэ шинэ бие нь Есүс Христийн амилж, алдаршуулагдсан биетэй адилхан байх болно. (Филиппой 3:20-21). Энэ нь биднийг Эзэн Есүс Христтэй бүрэн дүүрэн, төгс харилцаатай болгох юм (2 Коринт 5:6-8).

2. Сэтгэл

Сэтгэл бол хүн төрөлхтний материаллаг бус хэсэг. Үүнийг харж, хүрч, сонсож, амталж, эсвэл үнэртэж болдоггүй. Хүний бие сэтгэлгүйгээр амьдарч чаддаггүй (Эхлэл 35:18) учир “НЕФЕШ” гэдэг еврей уг, “ПСУХЕ” гэдэг грек үгийг зөвхөн “сэтгэл” гэж орчуулаад зогсохгүй, “амь”, “хүн” гэж орчуулах нь олонтаа байдаг.

Адамыг бүтээх үед “*ЭЗЭН Бурхан тоос шорооноос хүнийг бутээж, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч (сэтгэл) болжээ*” гэдгийг Библид хэлсэн байдаг (Эхлэл 2:7; 1 Коринт 15:45). Энэ хичээлээр бид амийг илэрхийлэхэд ашиглагддаг бүхий л үгсийг янз бүрийн утгатай нь хамт судалж үзэхийг зориогүй. Харин Бурхан амьсгалаараа дамжуулан Адам, Ева хоёрт сэтгэлийг өгсөн төдийгүй хүн төрөлхтний бусад бүх гишүүдэд сэтгэлийг өгдөг гэдэгт зүгээр л итгэцгээ (Египетээс гарсан нь 1:5). Түүнчлэн “НЕФЕШ” гэдэг уг нь амьтдын амийг хэлэхэд бас хэрэглэгддэг (Эхлэл 1:20, 21, 24, 30; 2:19).

Бие дотор сэтгэл юу хийдэг вэ гэдгийг тодорхойлохын тулд бид эхлээд Бурханд сэтгэл байдаг гэдгийг (Матай 12:18; Еврей 10:38), мөн хүн төрөлхтөн Түүний дүр төрхөөр бүтээгдсэн гэдгийг ойлгох ёстой (Эхлэл 1:26-27).

Хүний сэтгэлд ёс суртахууны шийдвэр гаргах (зөв бурууг ялгах, сонголт хийх) чадвар ордог гэдгийг бид ойлгох ёстой. Энэ нь сонголт хийхээс өмнө бодож үздэг хувилбарууд бүхий газар сэтгэл дотор байдаг гэсэн утгатай юм. Сонгох чадварыг хүсэл гэж нэрлэдэг. Нэгэнт сэтгэл нь ёс

суртахууны шийдвэр гаргадаг газар юм бол сэтгэлд аврал хэрэгтэй (Дуулал 33:18-19; Ййлс 2:41; Еврей 10:39; Иаков 1:21; 1 Петр 1:8-9) бөгөөд гэм нүглээс эдгэрэх ёстой (Дуулал 41:4) гэсэн дүгнэлтэнд бид хүрч байна. Хүн төрөлхтнийг зольж авахын тулд Есүс зөвхөн Өөрийн биеийг төдийгүй бас сэтгэлээ өгсөн (Матай 20:28; Марк 3:4; Иохан 10:11, 15, 17; 15:13), тийнхүү Тэр бидний “**сэтгэлийн ... Хоньчин болон Харгалзагч**” (1 Петр 2:25) болсон. Итгэлгүй байдлаас болоод сэтгэл аврагдаагүй бол тамд очих болно (Матай 10:28; 16:26).

Хүн төрөлхтний зайлшгүй шийдэх ёстой зарим шийдвэрт Бурханыг хайрлах (Дэд хууль 6:5; 10:12-13; 30:6), зөвийг үйлдэхдээ биднийг Бүтээгчид өөрсдийгүй даатгах (1 Петр 4:19), ах дүүсийнхээ төлөө өөрсдийн амьдралыг (сэтгэлийг) золиослох (1 Иохан 3:16) зэрэг ордог. Хүний сэтгэл бол ёс суртахуунгүй байдалтай дайн хийдэг (1 Петр 2:11), хуурамч багш нарын сүнслэг тогтвортгүй байдалд уруу татагдаг тэр газар юм (2 Петр 2:12-14).

Шийдвэр гаргадаг газар гэдгээс гадна сэтгэл нь бас сэтгэл хөдлөл үүсэж байдаг газар юм. Сэтгэл нь энэрэнгүй (Иов 30:25), өшиж хорссон (Хаадын дэд 4:27), маш их уй гашуу амссан (Дуулал 43:5; Иеремиа 13:17; Матай 26:38), сүлбэгдсэн (Лук 2:35), цөхөрсөн (Ром 2:9), үзэн ядсан (2 Самуел 5:8) байж болно. Энэ нь бас хайрлаж (Соломоны дуун 1:7; 3:1-4), Эзэний хүндэлж (Лук 1:46), баар баясгалантай байж чаддаг (Лук 12:19).

3. **Хүмүүний сүнс**

Сүнс гэдэг еврей үг нь “РУАХ”, грек үг нь “ФНЕУМА” юм. Энэ нь Бичээсээс судлахад хамгийн хүнд сэдэв бөгөөд энэ хоёр үг нь хоёулаа маш олон хэрэглэгддэг төдийгүй тухайн үгийн хам сэдвээс хамаарч салхи, амьсгал, Ариун Сүнс, бузар сүнс, хүмүүний сүнс зэргийг хэлж болдог.

Хүмүүний сүнс нь сүнслэг амьдралын хүч бөгөөд хүмүүний материаллаг бус хэсгийн нэг юм. Энэ нь Бурханаар буюу онцгойлон Ариун Сүнсээр бүтээгдсэн (Иохан 3:6; 6:63) агаад Түүнээс үүдэлтэй (Номлогчийн үгс 12:6-7; Зехариа 12:1; Еврей 12:9). Хүн амьд байхын тулд сүнс зайлшгүй шаардлагатай (Лук 8:55; Иаков 2:26).

Өмнөх хичээл дээр тайллын зарчмуудыг үзэж байхдаа бид тодорхой багцлалуудыг авч, хүмүүний сүнсний талаарх зарим үндсэн баримтуудыг тодорхойлоход ашиглаж байсан. Бид хүний сүнсний онцлог шинжүүдийг авч үзвэл хүний сүнс, сэтгэл (өмнөх сэдэв), зүрхний (бидний үзэх дараагийн сэдэв) онцлог шинжүүдээс олонх нь яг адилхан байгааг харж болно. Гэхдээ бид хүний сүнс нь хүний сэтгэл, зүрхээс өөр гэдгийг Бурханы үгэнд хэлсэн байгааг анхаарах ёстой (Еврей 4:12).

Бид хүмүүний сүнстэй холбоотой ишлэлүүдийг судалж байхдаа энэ нь дөрвөн үүрэгтэй гэдгийг харсан:

a. **Мэдээллийг хүлээн авах**

Сүнс нь нигүүлсэл (Галат 6:18; Филемон 1:25), ёс суртахууны үнэн (Малахи 2:15-16), илчлэлт (Ефес 1:16-17) зэрэг өөрт ирж буй мэдээллийг хүлээн авдаг. Түүнчлэн энэ нь эгдүүцдэг (Ййлс 17:16), мөн хөдөлгөгддөг (1 Шастир 5:26; Езра 1:1, 5).

б. **Мэдээллийг үнэлж цэгнэх**

Хүний сүнс нь бас хүлээж авсан мэдээллээ үнэлж цэгнэж чаддаг. Энэ нь үйл явдлыг мэдэрч (Иов 6:4), бидний бодол санааг мэдэж (1 Коринт 2:11), тунгаан бодож (Дуулал 77:6), ойлгож (Иов 20:3; 32:8), дүгнэж цэгнэсэн зүйлдээ ухаалаг байж (Египетээс гарсан нь 28:3; Дэд хууль 34:9; Ефес 1:16-17) чаддаг.

в. **Шийдвэр гаргах**

Хүний сүнс мэдээллийг хүлээн авч, дүгнэж цэгнээд ямар үйлдэл хийхээ шийддэг. Энэ нь Ариун Сүнсээр үргэлж удирдуулах (Ййлс 20:22-23), Бурханд өөрийг зориулах (Дуулал 31:5), итгэлтэй байх (2 Коринт 4:13-14), гэмшдэг байх (Исаиа 57:15; 66:2), эсвэл Бурханы эсрэг болох (Иов 15:13), Түүнд үнэнч биш байх (Дуулал 78:8) зэргийг сонгох чадвартай.

г. **Хариу үйлдэл хийх**

Нөхцөл байдлыг ухаарч ойлгон, үнэлж цэгнээд, шийдвэр гаргасан хүмүүний сүнс нь олон арга замаар (үүнд бузар муу арга зам ч гэсэн ордог) хариу үйлдэл хийдэг.

Хүмүүний сүнсийг олон хэлбэрээр дүрслэн хэлсэн байдаг. Энэ нь:

- уурлаж хилэгнэдэг. Шүүгчид 8:3; Номлогчийн үгс 7:9; 10:4
- түргэн уурладаг. Сургаалт үгс 14:29
- шаналдаг. Иов 7:11
- ихэмсэг болдог. Дуулал 76:12; Сургаалт үгс 16:18; Ecclesiastes 7:8
- эмтэрдэг. Дуулал 51:17; Сургаалт үгс 15:13; 17:22; 18:14; Исаиа 65:14
- уужуу тайван байдаг. Сургаалт үгс 17:27
- лбаддаг. Иов 32:18
- гэмшдэг. Дуулал 34:18; Сургаалт үгс 15:4
- заль мэхтэй. Дуулал 32:2
- бузартдаг. 2 Коринт 7:1
- гомддог. Египетээс гарсан нь 6:9 (Цөхрөл гутрал бол “сүнсний зовлон шаналал” юм.)
- мэдэрдэг. 1 Коринт 5:3-5; Колоссай 2:5
- алдаа гаргадаг. Исаиа 29:24
- Эзэний оршихуйд байдаг. 2Тимот 4:22
- өөрийгөө илэрхийлдэг. Сургаалт үгс 29:11 (Түргэн зан нь “хүний сүнснээс гардаг”)
- сульддаг. Дуулал 77:3; 143:7; Исаиа 57:16; 61:3; Езезиел 21:7
- хүнд итгэмжит байж чаддаг. Сургаалт үгс 11:13 (итгэмжит байдал “итгэмжит сүнс”)
- гал цогтой. Уйлс 18:25; Ром 12:10-11
- тэнэглэдэг. Езекиел 13:3
- дөлгөөн байж чаддаг. 1 Коринт 4:21; Галат 6:1; 1 Петр 3:4
- Эзэнд өөрийгөө өгдөг. Уйлс 7:59
- гашууддаг. Исаиа 54:6
- хатуурдаг. Дэд хууль 2:30
- ариун байж чаддаг. 1 Коринт 7:34
- нэр хүндтэй. 2 Коринт 12:18
- даруу байж чаддаг. Сургаалт үгс 16:19; 29:23
- атаархдаг. Тооллого 5:14
- Бурханы хүсэл дотор амьдардаг. 1 Петр 4:6
- үнэнч шударга байж чаддаг. Тооллого 14:24
- төлөвшдөг. Еврей 12:23
- хүмүүсийг өдөөж, хөдөлгөдөг. Египетээс гарсан нь 35:21; Сургаалт үгс 16:2; Илчлэлт 19:10
- хөдөлдөг. Иохан 11:33
- шинэ болгогддог. Езекиел 11:19; 18:31; 36:26
- шаналдаг. 1 Самуел 1:15
- сульддаг. Дуулал 142:3; 143:4
- төлөвлөдөг. Уйлс 19:21
- ядуу байдаг. Матай 5:3
- залбирдаг. 1 Коринт 14:14-16
- тэсэж тэвчдэг. Иов 10:12; 1 Тесалоник 5:23
- чимээгүй байдаг. 1 Петр 3:4
- үндэстэн ястны онцлогтой байдаг. Исаиа 19:3; Иеремиа 51:11
- сэргэдэг. 2 Коринт 7:13

- баярладаг. Лук 1:47
- шинэчлэгддэг. Ефес 4:21-24
- амрах хэрэгтэй болдог. 2 Коринт 2:13
- сэргэдэг. Эхлэл 45:27; 1 Самуел 30:12
- өөрийгөө удирддаг. Сургаалт үгс 16:32
- уйтгарлаж, гуньдаг. Хаадын дээд 21:5
- Эзэнийг эрэлхийлдэг. Исаиа 26:9
- үйлчилдг. Ром 1:9
- өвчнийг тэсвэрлэдэг. Сургаалт үгс 18:14
- санаа алддаг. Марк 8:12
- тууштай байдаг. Дуулал 51:10
- хүчтэй байдаг. Лук 1:80
- бусдад захирагддаг. 1 Коринт 14:31-32
- захирагдан амьдардаг. Еврей 12:9
- айдаг. 2 Тимот 1:7
- тавгүйтдэг. Эхлэл 41:8; Иов 21:4; Даниел 2:1-3; Иохан 13:18-21
- хяналтгүй болдог. Сургаалт үгс 25:28
- Эзэнтэй нэгддэг. 1 Коринт 6:17
- бусад итгэгчидтэй нэгддэг. Филиппой 1:27
- сул дорой болдог. Иошуа 2:11; Шүүгчид 15:19; Хаадын дээд 10:4-5
- хүсэж тэмүүлдэг. Дуулал 51:10-12
- мөргөл өргөдөг. Иохан 4:23
- бидний авралыг гэрчилдэг. Ром 8:16

4. Зүрх

Хүний “зүрх” бол Библийн турш үргэлж гарч байдаг сэдэв юм. “ЛЕБ” гэдэг еврей үг, “КАРДИА” гэдэг грек үг хамтдаа бараг 1000 удаа гардаг. Эдгээр үгс нь хүний бие махбод дотор байдаг артери болон венийн судсаар дамжуулан цусыг шахаж байдаг эрхтнийг хэлэхэд бараг хэрэглэгддэггүй (2 Самуел 18:14; Хаадын дэд 9:24). Харин энэ үг нь дотор хүний үйл ажиллагааны төв гэсэн утгаар ихэвчлэн хэрэглэгддэг.

Библид гардаг “зүрх” гэдэг үгийн өөр өөр хэлбэрийг авч үзвэл дараах дөрвөн өөр утга санаа гарч ирдэг. Үүнд:

a. Оюун ухааны төв

Зүрх нь оюун ухааны төв гэдэг санааг илэрхийлдэг. Энэ нь дүгнэж цэгнэх чадвартай (Дэд хууль 8:5), үнэлж үздэг (Дуулал 119:11), мөн толевлөдөг (Еврей 4:12). Зүрх нь бас бузар муу бодол санаа, үйл хэргийн эх үндэс байж болдог (Матай 15:19-20).

б. Сэтгэл хөдлөлийн төв

Зүрх нь сэтгэл хөдлөлийн төв гэсэн утгаар хэрэглэгддэг. Энэ нь хайлрлаж (Дэд хууль 6:5), хүсэж (Дуулал 37:4), баярлаж баходдаг (Дуулал 104:15; Исаиа 30:29; Колоссай 3:16). Зүрх нь бас гуниглаж (Нехемиа 2:2; Ром 9:2), өширхөж (Дуулал 73:21), өөрийгөө зэмлэдэг (Иов 27:6).

в. Хүсэл тэмүүлийн төв

Зүрх бол хүсэл тэмүүлийн төв юм. Энэ нь Бурханы эрэлхийлж (Дэд хууль 4:29), өөрчлөгдж (Египетээс гарсан нь 14:5) эсвэл бүүр Бурханы өмнө хатуурдаг (Египетээс гарсан нь 8:15; Еврей 4:7).

г. Сүнслэг амьдралын төв

Зүрх бол сүнслэг амьдралын төв. Бурханы үгэнд “хүн зүрхээрээ итгэвэл зөвт байдал хүрдэг (Ром 10:9-10)” гэж хэлсэн байдаг. Итгэгч хүний хувьд зүрх бол Хүүгийн (1 Петр 3:15; Ефес

3:17) болон Ариун Сүнсний (2 Коринт 1:22) орших газар юм.

5. Мөс чанар

“Мөс чанар” гэдэг үг нь зөвхөн Шинэ гэрээнд гардаг. Мөс чанар гэдэг үгийн үүрэг нь Хуучин гэрээн дэх “зүрх” гэдэг үгтэй дүйцдэг (1 Самуел 24:5; Иов 27:6). “СҮНЕИДЕСИС” гэдэг грек үг нь үгчилбэл “мэддэг байх”, “өөрийнхөө талаар мэдлэгтэй байх” гэсэн утгатай. Энэ нь хувь хүний зөв буруугийн тухай ойлголтыг хэлдэг. Мөс чанар нь хүний зөв гэж заалгасан зүйлээ хийхэд өдөөж өгч байдаг хүмүүний нэгэн хэсэг юм. Мөс чанар нь бидэнд юу нь зөв, юу нь бурууг заадаггүй. Хүн алдаатай мэдээллээс болж буруу зүйлийг “зөв” мөс чанараар хийж болдог.

Аврагдаагүй хүний хувьд, хэрвээ түүнд зөв, буруугийн талаарх Бурханы хэм хэмжээг зааж сургасан бол тэр хүний мөс чанар нь сайн чиглүүлэгч болж болох юм (Иохан 8:9; Ром 2:15). Хүн Бурханы хэм хэмжээг үргэлж эсэргүүцэх үед, мөс чанар нь “*халуун төмрөөр тамгалагдах*” (1 Тимот 4:2) болдог. Хүн Бурханы хэм хэмжээг зөрчих үед мөс чанар нь “бузартдаг” (Titus 1:15), гэхдээ мөс чанар нь бузар муугаас цэвэрлэгдэж болно (Еврей 10:22).

Ариун Сүнсний ятгагч үйлчлэлээр дамжуулан Христитгэгч хүний мөс чанар нь түүнийг амьдралын янз бүрийн харилцаан дотор зөв зүйл хийхийг шаарддаг. Мөс чанар нь хүнийг амьдарч буй улс орныхоо засаг захиргаанд дуулгавартай байх (Ром 13:5), шударга бус ажил олгогчийн дор тэсвэр тэвчээртэй байх (1 Петр 2:19), сул дорой ах дүүгийнхээ мөс чанарыг сэвтээхгүй байх (1 Коринт 8:7, 10, 12) зэргийг шаардах ёстой.

6. Оюун ухаан

“НОУС” гэдэг нь “оюун ухаан” гэсэн грек үг юм. Оюун ухаан гэдэг нь бүхий л мэдрэхүй, сэтгэл хөдлөл, ой ухааныг хамтад нь дүгнэж цэгнэдэг газар юм. Энэ нэр томьёонд хүний тархи болон сэтгэлийн хийдэг бүх зүйл ордог, тиймээс энэ нь хүний материаллаг болон материаллаг бус хэсгүүдийн уулзах газар юм. В.Е.Вайнес ийн хэлсэн байдал:

“Оюун ухаан” бол мөс чанарын тусгал, мэдэрч ойлгох чадварыг агуулагч бөгөөд мэдэрч, шүүж, тодорхойлдог. Холбогдох грек үгс нь “бодож тунгаах” гэсэн утгатай “ДИАНОИА” гэдэг үг, мөн “бодол, санаа, зорилго” гэсэн утгатай “ЕННОИА” гэдэг үг юм. Хэдийгээр зүрх сэтгэл болон оюун ухаан нь хоорондоо маш ойр холбоотой боловч ялгаатай зүйлс юм (Еврей 8:10, 16).¹⁰⁶

Хэдийгээр “оюун ухааны” талаарх ойлголт Хуучин гэрээнд гардаг боловч яг үүнийг илэрхийлсэн еврей үг байдаггүй. Энэ нь нэг бол зүрх, эсвэл сэтгэл, сүнс гэсэн нэр томьёогоор илэрхийлэгдсэн байдал. Тиймээс бид оюун ухааны талаарх ойлголтоо грек үгнийх нь хэрэглээнээс гаргаж ирэх болно.

Аврагдсан болон аврагдаагүй хүмүүсийн аль алинд нь оюун ухаан бий (Ром 14:5). Бурханы тухайн хүнд өгсөн оюун ухааныг хэрхэн ашиглаж, юу бодож санаж байгаа нь Бурханд их чухал байдал (Ефес 4:17-18; Еврей 4:12 энд ЕННОИА-г хэрэглэсэн бөгөөд “бодол” гэж орчуулсан). Эзэнд “оюун ухаан” байдал учир бид үүнийг мэдэхээр эрэлхийлдэг (Ром 11:34; 1 Коринт 2:16), мөн Тэр бидэнд Түүнийг хайлрах (Матай 22:37; Марк 12:30; Лук 10:27), ойлгох (Лук 24:45) оюун ухааныг өгсөн. Христитгэгч хүний оюун ухаан нь Эцэг болон Хүү дотор байдаг үнэнийг мэдэхээр бүтээгдсэн юм (1 Иохан 5:20, энд ДИАНОИА нь “ухаан” гэж орчуулагдсан).

Эзэний бидэнд өгсөн оюун ухаан нь зүй тогтлын дагуу учир шалтгааныг олж чаддаг. Энэ нь математикийн томьёог бодож тооцоолж (Илчлэлт 13:18), зүй тогтол бүхий бодол санааны үр дүнг ойлгож (Илчлэлт 17:9) чадаж байгаагаас харагддаг. Энэхүү чадвар, ойлголтоор дамжуулан аль хэм хэмжээ нь өөрийнх нь чиглүүлэгч болох вэ гэдгийг оюун ухаан тодорхойлж, тийнхүү өөрийнхөө мөс чанарыг бий болгодог (Ром 7:23, 25). Хувь хүний ийм өсөлт хөгжилт нь бусдад зааж сургах чадвартай болгож (1 Коринт 14:19), Христийн бисийн нэгдлийг барьж байгуулах чадвартай болж төлөвшихд хүргэдэг (1 Коринт 1:10). Оюун ухаан нь өөртөө, Бурханд болон бусдад шударга байх

хэрэгтэй (2 Петр 3:1). Оюун ухаан бол энэ бүх хүрээнд хүмүүний сүнстэй хамт ажиллахаар бүтээгдсэн (1 Коринт 14:15).

Оюун ухаан Бурханд үйлчлэхэд ашиглагдаж болдог шиг (Марк 12:30), энэ нь бас Бурханы эсрэг байх, “заврах” (энэ нь Бурханы хэм хэмжээг дагахгүй байх гэсэн утгатай) зэргийг сонгож болно (Ром 1:28; 1 Тимот 6:5; 2 Тимот 3:8). Тэр ч байтугай, энэ нь Бурханы эсрэг дайсагнаж (Колоссай 1:21) болно. Тиймээс оюун ухаан нь бузартаж бохирдох боломжтой юм (Тит 1:15).

Түүнчлэн итгэгч хүний оюун ухаан ч гэсэн ихэмсэг байдлаар хувия хичээж, зөвхөн махан биеийн юмыг бодох үед (Лук 1:51; Ефес 2:3; Колоссай 2:18) үр жимсгүй болж болно (1 Коринт 14:14). Бас хуурамч үзэл баримтлалыг үнэн гэж итгэх үед оюун ухаан ганхаж дайвж болно (2 Тесалоник 2:2, энд НОУС гэдгийг “ухаан бодол” гэж орчуулсан).

Гэвч Бурханы хүслийг мэдэж (Ром 12:2), гэм нүгэлт замаасаа эргэж (Ефес 4:22-24), аливааг хийхэд (1 Петр 1:13) болон зохисгүй зовлонг тэсэж тэвчихэд (1 Петр 4:1, энд ЕННОИА гэдгийг “зорилго” гэж орчуулсан) бэлэн байж, Бурханы амар тайвнаар удирдуулах үед (Филиппой 4:7) бидний оюун ухаан шинэчлэгдэж болдог нь үнэхээр талархууштай сайхан зүйл юм.

7. Махан бие

“Махан бие” гэдэг үг нь заримдаа амьд биетийн материаллаг мөн чанарыг буюу биеийг нь бүрхэж буй эд эсийг (Эхлэл 2:21; Египетээс гарсан нь 12:8; Лук 24:39), эсвэл материаллаг оршихуйг нь бүхэлд нь (Эхлэл 6:17, 19; 1 Коринт 15:39; Еврей 5:7) хэлдэг. Библийн дагуу, “махан бие” гэдэг үг нь хүний материаллаг болон материаллаг бус хэсгүүд холбогдож байгааг харуулахад хэрэглэгддэг.

Бурхан Давидын удам болох (Ром 1:3; 9:5) Есүс Христийн бодгаль дотор махан бие болсон (Иохан 1:1, 14; 1 Тимот 3:16). Энэ нь Бурхан жинхэнэ хүмүүн чанартай болсон гэсэн утгатай. Тэрээр гэм нүгэлт махан биетэй адилхан биетэй болсон боловч Түүний махан бие гэм нүгэлгүй байсан (Ром 8:3). Тэр Давидын “Эзэн”, үүний зэрэгцээ бас Давидын “Хүү” байсан (Матай 22:45). Есүс хүн төрөлхтөн болон Бурханы хооронд амар тайвныг тогтоож (Ефес 2:14-15; Колоссай 1:22-23), диаволын хүчийг устгахын (Еврей 2:14) тулд, бидний нүглийг үүрэхээр ирсэн. Есүс үнэндээ махан биеэр ирээгүй гэж заадаг хуурамч багш нар гарч ирэх болно гэж Бурханы үгэнд хэлсэн байдаг (1 Иохан 4:2; 2 Иохан 1:7).

Бурханы хувьд махан бие дотор ирэх хэрэгтэй байсан гэдгийг Хуучин гэрээнд зураглан харуулсан байдаг. Асар болон Сүмийн “хөшиг” нь Есүсийн махан бие хүн төрөлхтөнд Бурхантай мөнхөд хамт амьдрах амьдралыг нээх болно гэдгийн билэг тэмдэг болж байсан (Еврей 10:19-20; Матай 27:51). Иудейчүүдийг цөлд дөчин жилийн турш хооллож байсан “манна” нь Христийн махан биеэр дамжуулан өгөгддөг аврал, хангалтын билэг тэмдэг байсан (Египетээс гарсан нь 16:31-35; Иохан 6:51-56). Давидын нэгэн дуулалд Мессиагийн махан бие ялзрахгүй гэдгийг бас хэлж байсан бөгөөд энэ нь Түүнийг үхлээс амилах болно гэдгийг (Дуулал 16:10; Ййлс 2:31), мөн Бурхан Түүний залбиралд хариулна гэдгийг илтгэж байв (Еврей 5:7).

Христийн махан биеийн зорилго, амссан зовлон зэрэг нь хүн төрөлхтний хувьд даган дуурайх загвар болсон юм (1 Петр 4:1-2). Библид ихэнх тохиолдолд хүн төрөлхтний махан биеийг гэм нүглийн бат цайз бөгөөд Ариун Сүнсий үргэлж тэмцэж байдаг гэж үздэг (Галат 5:16-17). Ариун Сүнсний үүрэг ролийн нэгэн хэсэг бол гэм нүглийн асуудал, үүний үр дагаврыг хэлж мэдүүлэх явдал юм (Иохан 16:8-11).

Бурханы үгэнд махан биеийн хэд хэдэн онцлог шинж чанарыг дурдсан байдаг. Сүнс үгүй бол махан бие нь үхмэл (Иохан 6:63) бөгөөд махан бие нь зөвхөн махан биеийг төрүүлж чаддаг учир амийг бий болгохын тулд Ариун Сүнс махан биед сүнсийг өгөх ёстой (Иохан 3:6). Бид махан биеэ хайлрлаж, тэжээн тэтгэдэг (Ефес 5:28-29) бөгөөд махан бие нь зарим мэргэн ухааныг эзэмшиж болно (1 Коринт 1:26-29).

Хүн аврагдахаас өмнө махан бие нь уруу таталтад сул дорой байдаг (Матай 26:41) бөгөөд махан биеийн хувьд эрх дураараа байх нь хүн төрөлхтний энгийн амьдралын хэв маяг юм (Ефес 2:3). Тиймээс махан бие нь оюун ухааны бодож сэтгэх арга хэлбэрт нөлөөлдөг (Колоссай 2:18). Махан биеийн ялзарсан хүсэл, эрх дураараа байдал нь эрх мэдлийг үл тоомсорлоход хүргэдэг (2 Петр 2:9-10), тиймээс Христитгэгчид өөрсдийнхөө махан биеийн эрх мэдэлтнүүдэд захирагдаж, тэдэнд үйлчилж сурах хэрэгтэй (Ефес 6:5). Махан бие Бурханы хуулийн хэм хэмжээг идэвхтэйгээр эсэргүүцдэг тул эрх мэдлийг хүлээн зөвшөөрөх гэдэг нь тэмцэл юм (Ром 7:5).

Хэдийгээр бид бусад хүмүүсийг махан биеийнх нь дагуу шүүж болохгүй боловч махан бие дэх бидний амьдрал бусад хүмүүсээр шүүгдэх болно (Иохан 8:15). Бид бусдыг махан биеийн үйлс дээр үндэслэн үнэлж хүндэлдэг (2 Коринт 5:16), эсвэл гарал үүсэл, иргэншил, ёс заншил, үйл хөдлөл болон ил харагдах зөвт байдал зэрэг дээр итгэл найдвараа тавьж болохгүй (Филиппой 3:2-7). Махан бие дотор байх бидний цаг хугацаа бол Бурханы хүслийн дагуу амьдрах амьдрал юм (1 Петр 4:6).

Махан бие нь олон сул талтай. Энэ нь гэм нүглийг эсэргүүцэхдээ муу (Ром 6:19) бөгөөд ертөнц гэм нүгэлт хүслийг махан биед төрүүлдэг (1 Иохан 2:16). Махан бие олон гэм нүглийг үйлдэж, эцэстээ гэм нүгэлтэн мөнхийн ерөлөөр унийг нь төлөхөд хүрдэг (Галат 5:19-21). Махан биеийн хувия хичээсэн үйлс нь махан биеийг завхрахад хүргэдэг (Галат 6:8). Эцэст нь махан бие гандаж хатах болно (1 Петр 1:24-25). Хуурамч багш нар махан биеийн хүслүүдийг өөгшүүлж, дагалдагч нарыг өөртөө татдаг (2 Петр 2:18-19).

Махан бие нь бас бэлгийн харилцааны тал дээр сул дорой юм. Эрэгтэй эмэгтэй хүн гэрлэлтээр дамжуулан нэгдэж, нэгэн бие болдог. Тиймээс өөр “гаднын” махан биетэй явалдах, түүнчлэн ижил хүйстэнтэй бэлгийн харыцаатай байх, амьтантай хурьцах зэрэг нь махан биеийн хүсэл тачаал юм (Марк 10:8; Иуда 1:7). Санаатай үйлдсэн нүгэл нь махан биеийг сүйрэхэд хүргэдэг (1 Коринт 5:5).

Өөр нэг сул тал бол, махан бие итгэгч хүний амьдралыг тогтвортгүй байдалд хүргэж чадах маш хурдан, мөн өргөн хэмжээний өөрчлөлтүүдэд нээлттэй байдаг (2 Коринт 1:17). Хэрвээ бид тухайн цаг мөчийн шахалт нөлөөнөөс болж бодол санаагаа байнга өөрчилдөг бол маш хурдан эргэлзэж тээнгэлздэг, сэтгэл түгшдэг болох болно.

Махан бие нь бас хэмжээ хязгаартай. Махан биед хийсэн зүйл нь (хөвч хөндөх ёслол гэх мэт) сүнслэг байдлыг илэрхийлдэггүй (Ром 2:28). Аливаа ёслол нь махан биеийн хязгаарлагдмал, сул дорой байдлыг шийдвэрлэж чадахгүй (Колоссай 2:23; 1 Петр 3:21).

Махан бие Хуулийг сахиснаараа зөвт болж чадахгүй (Ром 3:19-20) төдийгүй махан бие дангаараа сайныг бүтээж чаддаггүй (Ром 7:18). Бурханы ерөл энгийн махан бие, цусны төлөө бүтээгдээгүй юм (1 Коринт 15:50). Махан биед Бурханаас өгөгддөг ойлголт ухаарал хэрэгтэй байдаг (Матай 16:17).

Түүнчлэн итгэгч хүний амьдралд махан биетэй тэмцэх тэмцэл явагдаж байдаг. Хүн Есүс Христэд итгэх үедээ Есүс өөрийнх нь махан биеийн нүглийн төлөөсийг төлөхийн тулд нас барсан гэдгийг ойлгодог (Галат 5:24). Итгэгч хүн сүнсээр өсөж байж, энэхүү үнэнд талархан баярладаг болдог. Төлөвшөөгүй итгэгч хүн Бурханы мутарт мөнхөд аюулгүй байх болно гэдгээ (Иохан 10:27-30), мөн Есүс Христээр чөлөөлөгдсөн гэдгээ (Галат 5:1) ойлгож болох авч, махан биеийн хүсэл тачаалаа дагахыг хүсэж, алдаа гаргаж болох юм. Гэхдээ энэ аюулгүй байдал, эрх чөлөө нь махан биеийн төлөөх таатай боломж болохоор бүтээгдээгүй (Галат 5:13). Энэ бол тэмцэл тулааны нэгэн хэсэг юм.

Тулааны өөр нэгэн хэсэг бол махан биед хүсэл тэмүүлэл байдаг (Иохан 1:12-13) бөгөөд гэм нүгэл үйлдэх хандлага бүхий махан бие оюун ухаантай (Ром 7:25), мөн Ариун Сүнсний (Галат 5:16) тэмцдэг. Итгэгч хүн махан биеийн гэм нүглүүдээ дагах уу, эсвэл Ариун Сүнсний зүйлсийг дагах уу гэдгээ сонгох ёстой (Ром 8:3-13). Зөвхөн Ариун Сүнснээр хүчээр л махан биеийн хүслийг

гүйцэлдүүлэхгүй байж чадна (Галат 3:3; 5:16). Гэхдээ бидний жинхэнэ сүнслэг тулаан бол бусад хүний махан биетэй бус (2 Коринт 10:2-3), харин Сатан болон түүний хүчинүүдтэй хийх тулаан юм (Ефес 6:12).

Бидний сүнслэг амьдралын нэгэн хэсэг бол махан биеийн бүхий л бузар муу зүйлсээс цэвэрлэгдэж, ариун болох юм (2 Коринт 7:1). Бид өөрсдийн амьдралд Есүс Христийг оруулж, махан биеийнхээ хүсэл тачаалыг зайлцуулахыг хичээх ёстой (Ром 13:14), ингэснээр Есүс бидний махан биеэр дамжин илэрхийлэгдэж чадна (2 Коринт 4:11). Энэ нь зөвхөн Есүс Христэд итгэсэн итгэлийн амьдралаар дамжуулан хийгддэг зүйл (Галат 2:20) бөгөөд тийнхүү бидний махан бие Христийн Биед өөрсдийгөө бүрэн зориулах боломжтой болдог (Колоссай 1:24).

Бурхан бидэнд хайртай бөгөөд биднийг өөрсдийгөө бардамнан өргөмжилдөг болгохгүйн тулд “махан биед маань өргөс” өгч болно гэдгийг ойлгоорой (2 Коринт 12:7).

8. Нүгэлт мөн чанар

Адамын гэм нүгэл хүн төрөлхтний гишүүн нэг бүрд дамжсан гэдэг үнэнийг “нүгэлт мөн чанар” гэдэг нэр томъёогоор илэрхийлдэг. Энэ нь хүн төрөлхтөн бүгдээрээ (Есүс Христээс бусад бүх хүн, учир нь Тэр махан биеийн эцэггүй байсан) Адамын нүгэлт мөн чанарыг хүлээн авч, улмаар ялд унасан гэсэн үг юм (Ром 5:12-14; 18-19).

Энэхүү “нүгэлт мөн чанар” нь махан биеийн хэсэг бөгөөд хувь хүний амьдралд буй гэм нүглийг өдөөж байдаг. Бид “Бурханы төлөвлөгөө” гэсэн дараагийн хэсэгт хүний нүгэлт мөн чанарын тухай үзэх болно.

9. Хүсэл

Хүний хүслийг илэрхийлэхдээ үндсэндээ хоёр грек үгийг хэрэглэдэг. Эхний үг болох “ТЕЛЕМА” нь хүслийг, хоёр дахь үг нь буюу “БОУЛЕМА” нь төлөвлөгөө, загвар гэсэн утгыг илэрхийлдэг. Энэ хоёр үг хоёулаа ихэвчлэн Бурханы хүсэл буюу төлөвлөгөөг тунхаглахын тулд хэрэглэгддэг, гэхдээ хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учир (энэ нь хүнд ч гэсэн бас “хүсэл” байдаг гэдгийг харуулдаг) эдгээр үгс нь бас хүний хүсэл, төлөвлөгөөг хэлэхэд бас хэрэглэгддэг.

Хүний хүсэл маш хүчтэй байж болно. Хүн Бурханы төлөөх зүйлийг сонгож чаддаг шигээ, Түүний эсрэг зүйлийг сонгож чаддаг (Иошуа 24:15) бөгөөд “махан бие болон санаа бодлын хүслүүдээ өөгшиүүлдэг” (Ефес 2:3). Хүний хүсэл бол дотроо байгаа нүгэлт мөн чанарыг өөрөө дийлж чадахуйц хангалттай хүчтэй зүйл биш юм (Ром 7:15-21). Христээр дамжуулан “бүгдийг хийх” (Филиппий 4:13) хүчийг Ариун Сүнс өгдөг.

Хүний хүсэл хичнээн хүчтэй байсан ч тухайн хүнийг аварч чадахгүй (Иохан 1:12-13). Хүн Есүс Христийн нэрд итгэж, Түүний бэлгийг хүлээн авах ёстой (Иохан 1:12-13; Уйлс 4:12). Хүн Бурханы Үүх Есүс Христэд итгэвэл мөнх амьтай болох бөгөөд хэзээ ч алдагдахгүй (Иохан 6:39-40).

Хүний хүсэл тэмүүлэл Өөрийнхтэй нь адил байхыг Бурхан хүсдэг. Есүс Христ Өөрөө энэ үнэнийг зааж, үүний дагуу амьдарсан (Иохан 5:30; 6:38, 39). Хэдийгээр Давид хэд хэдэн удаа маш том алдаа гаргаж байсан боловч Бурханы хүслийг гүйцэлдүүлэхийг хүсдэг байсан. Тийм ч учраас түүнийг “Бурханы зүрх сэтгэлийн дагуух хүн” (Уйлс 13:22) гэж нэрлэх болсон.

Бурханы хүслийг гүйцэлдүүлэх хүсэлтэй энэ талаарх бидний ойлголт салшгүй холбоотой (Иохан 7:17). Бурхан бидний Өөрийнх нь хүслийн талаар онолын мэдлэгтэй болохыг бус, харин амьдрал маань өөрчлөгдөхийг хүсдэг. Бурханы үгийг судалж буй хүн үүнийг зөвхөн мэддэг, харин үйлдэггүй байх аваас энэ байдал нь хүнийг амьдралын тухай гажуудсан үзэл санаатай болоход хүргэдэг.

Хүн өөрийгөө хамгаалах (Матай 1:19), хуулийн асуудлыг шийдвэрлэх (Матай 5:40), бусдаас юм зээлдэх (Матай 5:42) зэрэг олон зүйлд өөрийн хүслийг илэрхийлдэг гэдгийг Бурханы үгэнд хэлсэн

байдаг. Түүнчлэн хүн Христийг дагах (Матай 16:24-25), агуу нэгэн болох (Матай 20:26-27), Христ дотор бурханлаг амьдралаар амьдрах (2 Тимот 3:12), бусад хүмүүсийг өөрт нь тодорхой хэлбэрээр хандахыг хүсдэг байх (Матай 7:12) гэх мэт зүйлсийг хүсдэг гэдгийг бид харж болно.

“Хүсэл” нэг алхам цаашилбал “төлөвлөгөө” болдог. “БОУЛЕМА” гэдэг грек үг нь хүсэл тэмүүлэл нь төлөвлөгөө болох гэсэн утгатай. Энэ үгийг хэд хэдэн өөр үгээр орчуулдаг хэдий ч эдгээр нь бүгд хүсэл зорилго бүхий төлөвлөгөөтэй холбоотой утгыг илэрхийлдэг. Бурханд хүсэл байдаг бөгөөд энэ нь төлөвлөгөөн (Ром 9:19). Энэ төлөвлөгөөнд Хүү онцгой байр суурийг эзэлдэг (Матай 11:27).

Төлөвлөгөөнүүд нь бусдыг хамгаалах (Үйлс 27:43), эсвэл бусдад хор учруулах (Иохан 11:53; 12:10; Үйлс 5:33), түүнчлэн хэн нэгнийг аврах (Үйлс 27:39) хүслээс үүдэн гарсан байж болно. Мөн аялах (Үйлс 15:37), үнэнийг олж мэдэх (Үйлс 23:8), тэмцэж тулалдах (Лук 14:31) тэр ч байтугай гэм нүгэл үйлдэх (1 Петр 4:3) төлөвлөгөө боловсруулж болдог. Төлөвлөгөө нь Бурханаас, эсвэл бидний махан биеэс үүдэлтэй байж болно (2 Коринт 1:17).

Хувийн Судлалд: 6-р бүлэг, 3-р хэсэг

1. Эхлэл 1:26-г уншина уу. Хүн хэний дүр төрхөөр бүтээгдсэн бэ?
2. Эхлэл 2:7-г уншина уу. Бурханы амьсгалаар дамжуулан хүн юу болсон бэ?
3. Эхлэл 2:18-ыг уншина уу. Яагаад эмэгтэй хүнийг бүтээсэн бэ?
4. 2 Петр 2:12, Иуда 1:10-ыг уншина уу. Амьтдын хийдэггүй ямар зүйлийг хүн хийдэг вэ?
5. Эхлэл 2:16-17-г уншина уу. Адамыг юу хийхийг хориглосон байсан бэ?
6. Эхлэл 2:17-г уншина уу. Шийтгэл нь юу байсан бэ?
7. Эхлэл 3:8-19-ийг уншина уу. Бурханы тушаалыг зөрчсөний дараа эрэгтэй, эмэгтэй хүний амьдралд ямар өөрчлөлт гарсан бэ?
8. Дараах багцлалуудыг уншаад хүний мөн чанарын чухал элементүүдийг нэрлэнэ үү.
 - А. Эхлэл 2:7
 - Б. Иаков 2:26
 - В. Ром 10:9-10
 - Г. 1Тимот 4:2
 - Д. Ром 12:2
 - Е. Эхлэл 2:21
 - Ё. Ром 5:12-14
 - Ж. Иохан 1:12-13

4-р хэсэг

Тэнгэр Элч Нарын Зөрчилдөөн

Энэ хичээлийг үзэж байх явцад Бурхан болон Сатаны хоорондох дайны тухай хэд хэдэн удаа дурдсан. Энэ дайныг “Тэнгэр элч нарын зөрчилдөөн” гэж нэрлэдэг. Энэ зөрчилдөөний талаарх нарийн мэдээлэл энэ хөтөлбөрийн цар хүрээнд багтахааргүй, маш өргөн хүрээг хамардаг. Гэхдээ үүний тоймыг өгөх нь чухал бөгөөд “Хүн төрөлхтөн яагаад энд байгаа юм бэ?” гэсэн мөнхийн асуултад хариулахад тус болдог.

Хүнийг бүтээхээс өмнө, нэгэн цагт Бурхан өөр нэг төрлийн оршихуйг бүтээхээр сонгосон. Энэ оршихуйг “тэнгэр элч” гэдэг. Тэргүүн тэнгэр элч нь Люсифер байсан бөгөөд тэрээр Бурханы байр суурийг эзлэх гэж оролдсон (Исаиа 14:12-14). Люсифер нүгэл үйлдэж (Езекиел 28:11-19), диавол, Сатан гэж нэрлэгдэх болсон (Илчлэлт 12:9). Сатан мөнхийн галд орох шийтгэлийг хүртсэн бөгөөд энэ гал нь түүнд болон түүнийг дагасан тэнгэр элч нарт зориулж бэлтгэгдсэн юм (Матай 25:41).

Шийтгэлийг хараахан гүйцэтгээгүй байгаа тул Сатан Бурханаас шийдвэрээ өөрчлөхийг гүйсан. Энэ шийтгэлийг Есүс Христийн 1000 жилийн хаанчлалын дараа гүйцэтгэх болно (Илчлэлт 20:14). Хүн дунд нь байдаг учир Бурхан болон Сатаны хоорондох энэхүү зөрчилдөөний шийдэл юм.

Энэхүү зөрчилдөөн итгэгчдийн амьдралд нөлөөлдөг гэдгийг элч Паул тодорхой хэлсэн байдаг. Тэрээр Ефес 6:12-д “Учир нь бидний тэмцэл бол махран бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй өртөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ” хэмээн хэлсэн. Итгэгчдийн хувьд жинхэнэ зөрчилдөөн бол бусад хүмүүстэй биш, харин Сатан болон түүний хүчнүүдтэй тэмцэх тэмцэл юм. Энэ тэмцэлд оролцохын тулд бид “бүхнийг хийсний дараа, бузар муу одорт эсргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг авах” хэрэгтэй (Ефес 6:13).

Энэхүү зөрчил тэмцлийн талаарх бүхий л нарийн ширийн зүйлс болон бидний чухал үүрэг ролийн талаар бид одоо бүрэн гүйцэд ойлгож чадахгүй боловч нэгэн өдөр бид үүнийг бүрэн мэдэх болно (1 Коринт 13:12). Одоогоор бидний мэдэж буй зүйл нь хангалттай бөгөөд бид итгэлээр алхаж (Еврей 11:6), Бурханыг болон бие биенээ хайрладаг (Марк 12:29-31).

Хувийн Судлалд: 6-р бүлэг, 4-р хэсэг

1. **Исаиа 14:12-14-ийг уншина уу. Сатаны хамгийн анхны нүгэл юу байсан бэ?**
2. **Езекиел 28:11-19-ийг уншина уу. Сатан анх ямар байр суурьтай байсан бэ?**
3. **Матай 25:41-ийг уншина уу. Галт нуур ямар зорилгоор бүтээгдсэн бэ?**
4. **Илчлэлт 20:14-ийг уншина уу. Сатан болон түүний тэнгэр элч нар хэзээ галт нууранд хаягдах вэ?**
5. **Иохан 16:11-ийг уншина уу. Сатанд аль хэдийнээ юу тохиолдсон бэ?**
6. **Сатан аль хэдийнээ шүүгдэж, шийтгэл нь зарлагдсан боловч шийтгэлийг хараахан гүйцэтгээгүй байгаа гэдгээс бид ямар дүгнэлт хийж болох вэ?**
7. **Адам, Ева хоёрыг уруу татахдаа Сатан аль хэдийнээ уналтанд орчихсон байсан гэдгээс Сатаны уналтын цаг хугацааны талаар ямар дүгнэлт хийж болох вэ?**
8. **Хүн Сатаны шүүлт болон шийтгэлийн дунд байгаа гэдгээс хүний оршин тогтонохуйн талаар ямар дүгнэлт хийж болох вэ?**
9. **Ефес 6:10-18-ыг уншина уу. Сатаны заль мэхтэй тулалдахын тулд христитгэлт хүн юу хийдэг вэ?**

Долдугаар Бүлэг

**Бурханы Төлөвлөгөөний
Тухай Онол**

1-р хэсэг

Илчлэлт: Библи (Библиологи)

Өөрийгөө хүн төрөлхтөнд илчилсэн Бурханы илчлэлтийн бичигдсэн хэсгийг нь Библи гэдэг. Үүнээс гадна Бурхан бүтээлээрээ дамжуулан Өөрийгөө илчилсэн байдаг (Ром 1:20). “Илчлэлт” гэдэг үг нь далдлагдсан, нууцлагдсан байгаа зүйлийг ил гаргах, үзүүлэх гэсэн утгыг илэрхийлдэг. Бурхан түүхийн туршид янз бүрийн хүмүүст Өөрийн санаа зоригийг илэрхийлж, тэднээр дамжуулан Өөрийгөө илчлэн бичүүлсэн байна. Үүнийг “онгод оруулах” гэж нэрлэдэг.

Бурхан Өөрөө энэхүү илчлэлтийг өгч, онгод оруулсан тул бичигдсэн Бичээсийн анхдагч хувилбар нь ямар ч алдаа мадаггүй буусан байна. Тиймээс Бурханы Үг болох Библи нь Бурханы эрх мэдлийг агуулдаг гэж бид үзэж, сүнслэг алив хэрэг явдалд удирдамжаа болгох учиртай юм.

МЭӨ 1450-400 онд Бурхан хэд хэдэн хүнд онгод оруулан 39 ном бичүүлснийг эмхтгэн Хуучин гэрээ хэмээн нэрлэжээ. Мөн МЭ 46-96 онд Тэр өөр хэд хэдэн хүмүүсээр 27 ном нэмж бичүүлснийг нь Шинэ гэрээ гэдэг. Энэ хоёр хэсгийг нийлүүлээд Сударын Канон гэж нэрлэдэг. Бурхан эрх мэдэл бүхий Бичээсийг хүн төрөлхтөнд үлдээхийн тулд Өөрийгөө тэдэнд илчлэх зорилгоор тодорхой хүмүүст онгод оруулан Каноны номуудыг бичүүлсэн учраас энэ нь Түүний хүссэн зүйл мөн гэдгийг Үгийг судалж байгаа хүн ойлгох хэрэгтэй.

Хувийн Судлал: 7-р бүлэг, 1-р хэсэг

- 1. Ром 1:20-ийг унш. Бүтээлээс Бурханы юу илэрхий харагддаг вэ?**
- 2. “Илчлэлт” гэдэг үгийн утгыг тодорхойл.**
- 3. “Онгод оруулах” гэдгийг тодорхойлж хэл.**
- 4. Бурханы Үг болох Библи гэж юу вэ?**
- 5. Бидний сүнслэг амьдралын жолоо юу вэ?**
- 6. Шинэ, Хуучин гэрээнүүдийг нийлүүлээд юу гэж нэрлэдэг вэ?**
- 7. Иохан 17:17-г унш. Бурханы Үг гэж юу вэ?**
- 8. Дуулал 119-ийг уншаад, Бурханы Үгийн тухай хэсгүүдийг тунгаан бод.**

2-р хэсэг

Асуудал: Нүгэл (Хармартологи)

A. Танилцуулга

Бурханы тогтоосон жишгүүдийг зөрчихийг гэм нүгэл гэж үздэг. Нүгэлд зориулж Бурханы тогтоосон жишиг заавал байх ёстой гэдгийг Библид тодорхой хэлдэг. Хэрэв Бурхан ийм жишгийг тогтоогоогүй байсан бол нүглийн тухай ойлголт байхгүй байх байсан (Ром 4:15, 5:13). Нүглийг илэрхийлдэг еврей, грек үгс нь (ХАТА ба ХАМАРТИА) хоёулаа “байгаа онохгүй байх” гэсэн утгыг илэрхийлдэг. Тавьсан сум байндаа тусахгүй байхтай адилхан юм. Буудлагын үед байныхаа яг голд биш, өчүүхэн бага хэмжээгээр алдаж буудахад л таныг “байгаа оноогүйд” тооцдог.

B. Бурханы Үгэнд гурван төрлийн нүглийн талаар өгүүлдэг

1. Тохоогдсон нүгэл

Хүн бүр төрөхдөө л Адамын үйлдсэн анхны нүглийн хариуцлага ба шийтгэлийг хамтран хуваалцагч болдог. Өөрөөр хэлбэл, бид Адамын үр удам учраас түүний үйлдсэн нүглийн буруутгал бидэн дээр ирдэг гэсэн үг. Ром 5:12 “*Нэг хүнээр (Адам) ертөнцөө нүгэл нь ирсний адил нүглээр үхэл нь ирсэн. Тиймээс бүгд нүгэл үйлдсэн тул үхэл нь бүх хүнд иржээ*” гэсэн байдаг. Мөн Ром 5:18-19 ишлэлд “*Тиймээс нэг алдаа зөрчлөөс болж бүх хүн ялд унасны адил, ийнхүү нэг зөвт үйлээс болж бүх хүмүүс амийн зөвтгөлд хүрэв. Учир нь ганц хүний дуулгаваргүй байдлаас болж олон хүн нүгэлтэн болгогдсоны адил түүнчлэн ганц Хүний дуулгавартай байдлаар олон хүн зөвт болгогдоно*” гэжээ. Адамын нүгэл болон үүнээс улбаалсан шийтгэл нь Адамаас авахуулаад бүх хүн төрөлхтөнд дамжин үлдсэн байна.

Энэ нүгэл нь бидний махан биеийн эцгээс дамжин ирдэг гэдгийг анхаарах нь чухал. Харин Есүст махан биеийн эцэг байгаагүй учраас Түүнд Адамын нүгэл дамжаагүй юм.

2. Төрөлх нүгэл

Дээрх нүглийн улмаас нүгэлд уруу татагдах, улмаар түүнийг үйлдэхэд бэлэн мөн чанар хүн бүрд өвлөгджээ. Үүнийг “нүгэлт мөн чанар” буюу “хуучин хүн” гэж нэрлэдэг. Хэдийгээр Адамын нүглийн үр дагавар буюу шийтгэлийг хүчингүй болгосон ч гэсэн (Ром 6:6; 8:1) хүний нүгэлт мөн чанар түүнийг үхэн үхтэл түүнтэй хамт байдаг.

Элч Паул энэхүү нүгэлт мөн чанартай хэрхэн тэмцдэг тухайгаа Ром 7:16-18 ишлэлд: “*Хэрэв би өөрийн хүсдээгүй зүйлээ хийдэг юм бол, Хуулийг сайн гэдгийг өөрөө зөвшөөрч буй юм. Харин эдүгээ цаашид би биш, харин миний дотор оршин байгч нүгэл нь үүнийг үйлдээг юм. Учир нь миний дотор буюу миний махан биед ямар ч сайн зүйл байдаггүй би мэддэг. Учир нь хүсэл нь миний дотор байвч, харин сайныг хийх нь угүй*” хэмээн бичсэн байдаг. Паул хүртэл нүгэлт мөн чанартайгаа тэмцэхдээ алдаж эндэж явсныг бид энэ багцлааас дүгнэх боломжтой юм. Үнэндээ махан бие нь Ариун Сүнктэй тэмцэлддэг бөгөөд (Галат 5:16-17) итгэгчид “хуучин хүнээ тайлах”-ын (Ефес 4:20-22) тулд бүхнийг хийх хэрэгтэй.

Есүст дээрх хоёр нүглийн аль нь ч байгаагүй гэдэгт анхаарлаа хандуулаарай.

3. Хувь хүний нүгэл

Бурханы тогтоосон жишгүүдийг зөрчих нь хувь хүний нүгэл юм. Хэдийгээр бид Мосегийн хуулийн дэг жаягуудыг дагах хэрэггүй болсон ч түүний ёс суртахууны зарчмууд өдгөө ч хүчинтэй хэвээр. 1 Тимот 1:8-10 ишлэлд Паул “*Хэрэв хэн нэгэн үүнийг ёсоор нь хэрэглэвэл Хууль нь сайн гэдгийг бид мэднэ. Хууль нь зөв хүнд зориулагдаагүй, харин хүүльгүй болон тэрслүү хүмүүс, бурханлаг бус нүгэлтнүүд, ариун бус болон бузар хүмүүс, эцэг эхээ алдаг хүмүүс, алуурчид, садар самуун хүмүүс, ижил хүйстэнтэйгээ явалдагчид, хүний хулгайч наар, худалч хүмүүс, тангаргаасаа няцааг хүмүүс болон эрүүл сургаалын эсрэг байгч алив бүхэнд зориулагджээ*” гэж хэлсэн. “*Махан биеийн үйлс*” гэж нэрлэгдсэн бусад нүглийн талаар Галат 5:19-21 ишлэлд “*Эдүгээ*

махан биеийн уйлс нь илэрхий юм. Эдгээр нь завхайрал, бузар байдал, тачаангуй байдал, шутээн шутэх, идшид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, орсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа, атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх зэрэг нь юм. Би урьд нь та нарт сануулж байсанчлан урьдчилан сануулъя. Ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй” гэсэн байдаг.

В. Хувь хүний нүглийг дараах гурван төрөлд хуваадаг

1. Бодол санаагаар үйлдэх нүгэл

Хувь хүний нүглийн эхний ангилал нь хүний бодол санаатай холбоотой. Матай 5:28-д Есүс “*эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм*” гэж хэлсэн. Нүгэл нь бидний бодол санаанд урган төрөх боломжтой. Ариун бус бодол санаанууд маань нүгэлд тооцогддог. “*Би ариун учраас та нар ариун байгтуун*” гэж Бурхан бидэнд тушаасан (1 Петр 1:16). Мосгийн хуулийн 10 дахь тушаалд “*бүү шунахайр*” (Египетээс гарсан нь 20:17) гэсэн байдаг бөгөөд ийм шунахай сэдэл хүний бодол санаанд төрдөг гэм нүгэл юм.

Бодол санаагаар үйлдэгдэг нүгэл нь бусад нүглийн адил хайрын хуулийг зөрчдөг. Жишээ нь, хүнийг алагчилж үзэх гэм нүглийн тухай Иаков 2:8-9 ишлэлд “*Хэрэв та нар хаан хууль болох ‘Чи хөриөө өөрийн адил хайрла’ гэснийг Сударын дагуу биелүүлж байвал та нар сайныг үйлдэж байна. Харин та нар хүнийг алаг үзвэл, та нар нүгэл үйлдэж хэрэгтэн мэт хуулиар яллагдах болно*” гэсэн байдаг. Бодол санаанд үүссэн нүгэл биеэр үйлдэгдэх нь элбэг байдаг.

2. Хэл яриагаар үйлдэх нүгэл

Хүмүүний үйлдэг нүглийн удаах ангилалд хүний хэлж ярьж байгаа зүйлстэй холбоотой. Иаков номд хүний хэл яриа ямар бузар булаг болох талаар нэлээд дэлгэрэнгүй бичсэн байдаг (3:1-10). Хэл яриагаар үйлдэг нүглийг 10 тушаалын есдүгээрт ийнхүү бичсэн байдаг: “*Чи хөрийнхөө эсрэг худал бүү гэрчил*” (Египетээс гарсан нь 20:16). Диавол (“түтгэгч” гэсэн утгатай) буюу Сатан (“дайсан” гэсэн утгатай) нь хэл яриаг ашиглан бусдыг хөнөөхдөө гаралгай юм. Бурханыг болон бусдыг хайрлахгүй ярьж байгаа юм бүхэн нь хэл яриагаар үйлдэгдэх гэм нүглийн гол шинж юм.

3. Биеэр үйлдэх нүгэл

Хүмүүний үйлдэг нүглийн гурав дахь ангилалд биеэр үйлдэх нүгэл ордог. Энэ нь үндсэндээ хүний үйлс юм. Энэ нүглийн илэрхий гурван жишээг Бурханы 6, 7, 8-р тушаалаас харж болно:

- 1) “*Чи хүн бүү а,*”
- 2) “*Чи бүү захай.*”
- 3) “*Чи бүү хулгайл.*”

Иаков 4:17-д “*Зөв юмыг үйлдэхийг мэддэг хэрнээ үл үйлдэг хүнд энэ нь нүгэл юм*” гэсэн байдаг.

Зарим нүгэлд дээрх гурван төрөл бүгдээрээ агуулагддаг гэдгийг мартаж болохгүй. Хүнийг бодол санаандаа алж болохоос гадна үг хэлээрээ, мөн бодит үйлдлээрээ алж, амийг нь таслах боломжтой гэж Есүс маш тодорхой заасан байдаг (Матай 5:21-23).

Есүс Христ нэг ч нүгэл үйлдээгүй (1 Петр 2:22).

Хувийн Судлал: 7-р бүлэг, 2-р хэсэг

- 1. Ром 4:15, 5:13-ыг унш. Нүгэл нь нүгэл гэж тооцогдохын тулд юу байх ёстой вэ?**
- 2. Ром 5:12, 5:18-19 ишлэлийг унш. Адамын анхны нүглийн үр дагавар юу вэ, яагаад?**
- 3. Ром 7:16-18 ишлэлийг унш. Нүгэлт чанар хаана оршдог вэ?**
- 4. Галат 5:19-21 ишлэлийг унш. Хүний үйлдэг нүгэл гэж юуг хэлэх вэ?**

5. Матай 5:28-ыг унш. Энд ямар төрлийн нүглийн тухай өгүүлсэн бэ?
6. Иаков 3:1-10 ишлэлийг унш. Энэ хэсэгт ямар төрлийн нүглийн тухай ярьсан бэ?
7. Египетээс гарсан нь 20:13-15 ишлэлийг унш. Эдгээр ишлэлд ямар төрлийн нүглийг өгүүлж байна вэ?
8. Галат 5:19-21 ишлэлд яиз бүрийн нүглийг жагсаан бичсэн байдаг. Эдгээр нь оюун санаа, хэл яриа эсвэл биеийн алинаар нь үйлдэгддэг болохыг хэлнэ үү. Зарим нь аль алинаар нь үйлдэгддэг байж болно. Шаардлагатай гэж үзсэн зарим үгийн ард хаалтад нэмэлт тайлбарыг өгсөн байгаа:
 - A. Завхайрал
 - B. Бузар байдал (шашны зан үйлээр бузартах)
 - C. Тачаангуй байдал (бэлгийн гаж дон)
 - D. Шүтээн шүтэх
 - E. Ид шид
 - F. Дайсагнал (эрх мэдэлд дурлах)
 - G. Маргаан
 - H. Хардалт (өөрийнхийг хэт өмчлөх)
 - I. Уур хилэн
 - J. Өрсөлдөөн (өөрийн ашиг сонирхлыг эрэлхийлэх)
 - K. Хагарал (талцах, эв найрамдалгүй байх)
 - L. Тээрс үзэл санаа (хуурамч сургаалаас болж хагаралдах)
 - M. Атаархал (бусдынхад шунахайрах)
 - N. Архидалт
 - O. Утга учиргүй наргиж цэнгэх (найр наадам хэсэж согтуурах)

З-р хэсэг

Шийдэл: Аврал (Сотериологи)

A. Танилцуулга

Есүсээс бусад бүх хүн төрөлхтөн нүглийн асуудалтай тулгарсан тул тэдэнд нүглийн үр дагавраас аврагдах хэрэгцээ гарч ирсэн. Тиймээс Бурхан Өөрийн дээд эрх мэдэл болон бүхнийг мэдэгч мөн чанаарынхаа дагуу хүн төрөлхтнийг аврах төлөвлөгөөг боловсруулжээ. Энэ төлөвлөгөө нь Есүсийн амины үнэ цэнэтэй байв. Өөр хэний ч төлж чадахгүй тэрхүү үнийг Есүс төлснөөрөө Эцэгийнхээ Шударга, Зөвт байдлыг хангасан. Энэ бол нүглийн төлөөх төлөөс байсан юм. Харин хүн төрөлхтөн итгэлээрээ дамжуулан Есүсийн өргөсөн тахилыг хуваалцах эрхтэй болно (2 Коринт 8:9).

B. Сайн мэдээ

Товчхондоо, энэ бол авралын сайн мэдээ юм. Өөрөөр хэлбэл, аврал нь “зөвхөн Христэд итгэх итгэл”-ээр ирнэ гэсэн мэдээ юм. Ромын шоронгийн хуяг Паулаас “Аврагдахын тулд би юу хийх ёстой вэ?” гэж асуухад, тэрээр “Эзэн Есүст итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь ч аврагдана” гэж хариулсан тухай Үйлс 16:30-д өгүүлдэг (Үйлс 16:31). Авралыг хүлээн авахад шаардлагатай цорын ганц зүйл бол Есүс Христэд итгэх явдал гэдгийг тодорхой хэлсэн байдаг (Иохан 3:16, 18, 36). Хүмүүнийг аварч чадах өөр нэр хүн төрөлхтөнд өгөгдөөгүй юм (Үйлс 4:12).

Бурхан бүх хүнийг аврагдаасай гэж хүсдэг (1 Тимот 2:4; 2 Петр 3:9). Тийм ч учраас Есүс Христ бүх ертөнцийн өмнөөс нүглийн төлөөсийг төлсөн (1 Иохан 2:2). Ингэж Тэрээр бүх хүн төрөлхтнийг Өөр рүүгээ татахаар болсон билээ (Иохан 12:32). Ариун Сүнс ертөнцийг гэм нүглийнх нь улмаас зэмлэж, Есүс Христээр дамжуулан энэ асуудлаа шийдвэрлэх боломжтой гэдгийг илчилдэг (Иохан 16:7-15).

Есүс Христ бол хүмүүн болсон Бурхан байсан (Иохан 1:1, 14) бөгөөд бидний нүглийн төлөөсийг төлөхөөр нас барж, оршуулагдаад (Тэр үнэхээр нас барсан гэдгийг харуулдаг), гурав дахь өдөр нь үхэгсдээс амилуулагдсан (1 Коринт 15:3-5) гэдэгт хүн бүр итгэж, энэ үнэнийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

C. Нигүүлсэл

Нигүүлсэл гэдэг нь бидний өөрийнхөө хүчээр авч чадахгүй, эсвэл хүртэх зохисгүй зүйлийг бидэнд өгсөн гэсэн утгыг илэрхийлдэг. Хэрэв бид ямар нэгэн зүйл хийгээд оронд нь юм авбал үүнийг хөдөлмөрийн “хөлс, шан” гэж тооцон, авах ёстой зүйлээ авлаа гэж үздэг. Харин авралаар бидний хүргэж байгаа нигүүлсэл бол Бурханаас өгөгддөг бэлэг юм. **“Учир нь нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш, харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно”** (Ефес 2:8-9). Бурханы нигүүлсэл нь бидэнд авралыг бэлэглэдэг бөгөөд бид энэхүү авралыг итгэлээрээ хүлээж авдаг. Сайн мэдээг Бурханы нигүүлсэл хэмээн дүрсэлсэн байдаг (Үйлс 20:24).

Есүс Христ Өөрөө хүн төрөлхтөнд зориулсан нигүүлслийн загвар байсан юм (Иохан 1:14-17).

Г. Итгэл

Итгэл нь найдвар юм. Итгэж байгаа хүн нь гавьяатай биш, харин юунд итгэж байна вэ гэдэг нь үнэ цэнэтэй юм. Тэгэхээр Есүс Христийг хүлээн авах нь авралд багтдаг. Итгэл нь ажил биш юм.

Хүмүүс бид авралыг өөрсдийн хүч хөдөлмөөр олж авахыг хүсдэг бөгөөд Бурханы нигүүлслээр өгөгддөг энэ бэлгийг зүгээр л хүлээн авахын оронд түүний төлөө хөдөлмөрлөх ёстой гэж буруу ойлгодог хүн олон байдаг. Бурхан **“биднийг сайн үйлсийн толоо”** бүтээсэн нь үнэн (Ефес 2:10) хэдий ч бид сайн үйлсийг аврагдахын тулд бус, харин аврагдсан учраас үйлдэх ёстой юм.

Христ үйлчлэлийнхээ үеэр нэгэн удаа мөнх амийн тухай, Тэрээр энэ амийг хүмүүст бэлэглэхийг хүсдэг тухайгаа ярьсан байдаг (Иохан 6:26-27). Хүмүүс Есүсээс **“Бид Бурханы ажлуудыг хийхийн**

түлд юу хийх вэ?” (Иохан 6:28) гэж асуухад, Есүс “**Та нар Бурханы илгээсэн Нэгэнд итгэх нь Түүний ажил мөн**” гэж хариулсан (Иохан 6:29). Өөрөөр хэлбэл, та нар аврагдахын тулд ямар нэгэн сайн үйлс хийх ёстой гэж итгэдэг бол итгэлийг ажил гэж үзэж байгаа хэрэг мөн гэсэн санааг Тэр илэрхийлжээ. Хэрэв бидний итгэл “ажил” (үнэндээ ажил биш) байсан юм бол тэр “ажил” нь Бурханы авралын ажлын дэргэд юу ч биш агаад, үнэндээ ямар ч үнэ цэнэгүй байхсан.

Бурхан хүн бүрд сонголт хийх болон итгэх чадварыг өгсөн. **“Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн”** (Эхлэл 1:26-27) гэдэг нь юу болохын зах цухыг эндээс харж болно. Хэдийгээр сонголт хийх чадвар хүнд өгөгдсөн ч гэсэн энэ нь хүн үргэлж зөв сонголт хийдэг гэсэн уг биш юм. Сонголт хийх чадвар нь хүн бүрийг гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх үүрэгтэй болгодог. Хүн болгон сонголт хийх эрх чөлөөтэй учраас Христийг сонгоогүй хүмүүс Түүнийг эсэргүүцэх сонголтыг хийж буй хэрэг юм (Матай 12:30; Иохан 3:18). Христийг сонгох нь аврал болон диваажинд амьдрах мөнх амийг авчирдаг. Харин Христийг үл сонгох нь мөхлийг хийгээд мөнхийн тамд хүргэдэг (Иохан 3:36).

Д. Гэмшил

Гэмших гэдэг нь “оюун бодлоо өөрчлөх” гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, нэг итгэл нөгөөгөөр солигдоно гэсэн уг. Итгэгч бус хүмүүс мөхөхгүйн тулд Есүс Христийн талаарх оюун бодлоо өөрчлөхийг Эзэн хүсдэг (2 Петр 3:9; Үйлс 20:21). Өөрсдийнхөө нүглийн төлөөсийг тэд өөрсдөө төлж чадахгүй, харин Есүс Христ үүнийг нь төлсөн (Лук 24:45-47) гэдгийг ухаарах нь гэмшилийн нэг хэсэг юм. “Оюун бодлын энэ өөрчлөлт” нь христитгэгчдийн шинэ амьдралын үндэс суурь юм (Еврей 6:1).

Итгэгч хүн зөв гэж бодож байсан зүйл нь буруу байсныг (2 Тимот 2:24-25), эсвэл гэм нүгэл биш гэж итгэж байсан зарим зүйл нь гэм нүгэл мөн (2 Коринт 7:9-10) байсныг ойлгох үедээ оюун бодлоо өөрчлөх хэрэгтэй. Бид ийм нүглээ (бусад бүх нүглээ) Бурханы өмнө улайлх ёстой (1 Иохан 1:9).

Е. Зөвтгөл

Зөвтгөл гэдэг нь хүнийг зөвт хэмээн тунхаглах гэсэн утгатай. Нүгэлт хүн Ариун Бурхантай нөхөрлөх хэмжээнд хүртэл зөвт байж чадахгүй (Исаиа 64:6; Ром 3:20). Энэ нь хүн төрөлхтнийг: Хүн Бурханы оршихуйд орохын тулд хэрхэн зөвт болох вэ? гэсэн ноцтой асуудлын өмнө авчирдаг. Үүний хариултыг бид дараах үзэл баримтлалаас олж болно.

Библийн дараах хэсгүүдээс түлхүүр багцлалыг харах боломжтой: Ром 3:19-4:5 ишлэлүүдэд: (1) нэг ч хүн хуулийн үйлсээр зөвтгөгдөж чадахгүй (3:20-ыг Галат 2:16; 3:24-тэй харьцуул); (2) Бурханы шаарддаг зөвт байдал болон зөв шударгыг (3:24) Есүс Христ гүйцэлдүүлж (аргадах), нүглийн төлөөх өрийг төлсөн (зольсон) учраас зөвтгөл бол нигүүлслэйн бэлэг мөн; (3) хүн Есүс Христэд итгэх итгэлээр (3:26) зөвтгөгдөг хэмээн өгүүлдэг. Есүс Христэд итгэсэн хүн Түүний зөв байдлыг хүлээн авч, зөвт хэмээн тунхаглагддаг.

Есүс Христэд итгэлээр дамжуулан нигүүлслээр өгөгддөг энэхүү зөвт байдал нь биднийг Бурхантай эвлэрүүлдэг (Ром 5:1) бөгөөд тийхүү бид Бурханы зөвт байдал болон зөв шударгын үр дүнд Түүний уур хилэнгээс аврагддаг (Ром 5:9). Түүнчлэн энэ нь нүгэлт мөн чанараасаа болж бидний авах ёстой байсан ял шийтгэлээс биднийг чөлөөлж (Ром 6:7), Христтэй хамт өв залгамжлах эрхийг өгдөг (Тит 3:4-7).

Ё. Ариусгал

Ариусгал гэдэг нь биднийг ариун хэмээн “тусгаарлах” гэсэн утгатай. Ариун байдал нь Бурханы зөвт байдал болон зөв шударгаар хэмжигддэг. Хүн Есүс Христэд итгэлээр дамжуулан нигүүлслээр зөвтгөгдөх үедээ Түүний нэг удаа бүгдийн төлөө өргөсөн тахилаар (Еврей 10:10-14; 13:12) дамжуулан, Христээр (Үйлс 26:18; Еврей 2:11) болон Ариун Сүнсээр (2 Тесалоник 2:13; 1 Петр 1:2) дамжуулж ариусгагддаг. Бид итгэгч болсон даруйдаа энэ ариусгалыг бусадтай хуваалцах ёстой (Еврей 12:14).

Энэхүү эхний ариусгал нь итгэгч хүн амьдралдаа нүгэл үйлдэхгүй гэсэн баталгаа болж чадахгүй. Коринт чуулганыхан Есүс Христ дотор ариусгагдсан, “арийн хүмүүс” байсан боловч тэдний амьдралын бараг бүх талбар зүсэн бүрийн алдаа дутагдлаар дүүрэн байсан (1 Коринт 1:2, 30; 6:9-12).

Итгэгчид Христийг өөрсдийн амьдрал дахь ариун байдлын жишиг хэмээн үзэх хэрэгтэй (1 Тесалоник 4:3, 4, 7; Ефес 5:25-26; 1 Петр 3:15). Авралыг хүлээн авах агшинд авдаг ариусгалын дараа явагддаг ариусгах үйл явц үүнд багтдаг (Ром 6:19; 1 Тесалоник 5:23). Энэ үйл явц нь Бурханы Үгийн үнэнд итгэх итгэлээр боловсронгуй болж гүйцэлддэг (Иохан 17:17-19) бөгөөд үүний дараагаар итгэгч хүн алив сайн үйлд ашиглагдахын тулд өөрийнхөө амьдралыг Эзэнд захируулдаг (2 Тимот 2:21). Зөвхөн энэ үед л итгэгчдийн өргөл Ариун Сүнсээр Христ уруу тусгаарлагдах болно (Ром 15:15-16). Үүний дагуу үйлдэггүй хүмүүс Бурханы нигүүлслийг доромжилж буй хэрэг бөгөөд Эзэнээс хүнд шийтгэлийг хүлээн авах болно (Еврей 10:29).

Ж. Уучлал

Уучлал гэдэг нь “илгээж явуулах” гэсэн утгатай. Энэ нь “АФИЕМИ” гэдэг грек үгээс гаралтай бөгөөд ихэвчлэн “орхих” (Матай 4:20, 22; 5:24) гэж орчуулагддаг. Хүн нэг газрыг орхиж өөр газар уруу явдагчлан гэм нүглээ ардаа орхидог гэсэн санааг үүгээр илэрхийлжээ. Тийнхүү гэм нүгэл нь цаашид ачаа болохоосоо өнгөрдөг (Еврей 12:2). Есүс Христийг загалмайд цовдлогдохоос өмнөх гэм нүгэл болон алдаа зөрчлүүд нь “далдлагсан” байсан. Өөрөөр хэлбэл, энэ бүхэн байсаар байсан боловч шийтгэл нь хойшлуулагдан хуримтлагдаар байжээ (Дуулал 31:1 уд.харьц. Ром 4:7). Цагаатгал гэдэг үг нь “далдлах” гэсэн утгатай. Есүс Христ загалмайд цовдлогдоноор нүглийн учал ирсэн (Матай 26:27-28). Нүглийн учал нь баптист хүртээгч Иохан (Лук 3:3-4) болон Есүс Христийн (Лук 4:18-19; Үйлс 5:31) аль алиных нь номлолын чухал хэсэг байсан. Энэ учал нь бидний өрийг (Матай 6:12-15), гэм нүглийг (Матай 9:2-6), мөн бидний зүрхний бодлыг (Үйлс 8:22) учлах учал байж болно.

Авралыг авахад нүглийн учал маш чухал (Лук 1:77). Нүгэлт хүмүүсийн өрийг төлсөн Есүс Христийн тахил нь Түүний учалын үндэс байсан (Ефес 1:7; Колоссай 1:13-14; Еврей 9:22). Хүн Есүс Христэд итгэхэд нүгэл нь учлагддаг (Үйлс 10:43; 26:18). Есүс Христ нүглийн өрийг төлсөн учраас цаашид нүглийг “далдлах” өргөл хэрэггүй болсон (Еврей 10:17-18).

Уучлал нь гэм нүглээ ардаа орхих боломжийг бидэнд өгдөг нигүүлслийн бодит үйлдэл мөн боловч Бурхан үүнээс илүү гайхамшигтай зүйлийг хийдэг. Хэрэв бид хувцас гэх мэт ямар нэг зүйлээ орхисон бол хэсэг хугацааны дараа эргэж ирээд, түүнийгээ авах боломжтой. Харин Бурхан бидний нүглийг ардаа зөвхөн орхиод зогсоогүй, мөн Тэр түүнийг арилгаж “цэвэрлэсэн.” Энэ тухай бидэнд *“Та нар гэм нүглүүд болон махан биеийн хөвч хөндөх ёслолоосоо болж үхсэн байхад Тэр бидний бүх гэм нүглийг учлаад, та нарыг Түүнтэй хамт амьд болгосон бөгөөд бидний эсрэг зарлигуудаас бүрдсэн, бидэнд дайсагнаж байсан өрийн дансыг хүчингүй болгов* (грек үгийн утга нь “арилгах”). *Тэр үүнийг загалмайд хадаж, замаасаа зайлцуулжээ*” (Колоссай 2:13-14) гэж хэлсэн. Бидний нүгэл зөвхөн “ард орхигдоод” зогсоогүй түүнээс юу ч үлдээгүй гэдэг үнэн нь биднийг Эзэний оршихуй дотор сэргээгдэхэд хөтөлдөг (Үйлс 3:19).

Итгэгч хүн бүр Бурхан (Ефес 5:1) болон Есүс Христтэй адил (1 Коринт 11:1) учлах сэтгэлтэй байх хэрэгтэй гэдгийг бидэнд тодорхой заадаг (Матай 18:21-22). Нүглийн учал нь агуу захирамжийн нэг хэсэг учраас христитгэгчид хүмүүсийг училдаг байх нь маш чухал (Лук 24:46-47; Үйлс 10:43; 13:38). Бид суралцаж байгаа зүйлийнхээ дагуу амьдрахад бэлэн байх ёстой.

Хэрэв итгэгчид нүгэл үйлдвэл Бурханы өмнө түүнийгээ улайж, учал ба ариусгалыг хүсэх учиртай (1 Иохан 1:6-10). Тэгснээр хүн христэч амьдралдаа илүү өсөх боломжтой болно. Есүс загалмай дээр бүх нүглийн өрийг төлсөн учраас бид хэдийнээ учлагдсан билээ. Итгэгч хүн нүглээ Бурханы өмнө улайх үедээ өөрийнх нь өр аль хэдийн төлөгдсөн гэдгийг мэддэг.

3. Үл учлагдах нүгэл (Ариун Сүнсийг доромжлох)

Уучлагдахгүй нэг нүгэл байдаг нь Ариун Сүнсийг доромжлох нүгэл юм (Матай 12:31-32). Бурханыг байгаагаас нь өөрөөр ярьж, тунхаглах нь Түүнийг доромжилж буй хэрэг юм. Хүн Бурханы төгс мөн чанарын аль нэг хэсэг уруу халдаж, түүнийг нь худлаа хэмээн тунхаглах нь тэрээр Бурханыг доромжилж буй юм. Үнэний Сүнс болох Ариун Сүнс (Иохан 14:17) нь Есүс бол Мессия гэдгийг илчилдэг (Иохан 14:6; 16:13). Тиймээс, хэрэв хүн Есүсийг Мессия хэмээн хүлээж авахаас татгалзаж байгаа бол тэрээр Есүсийн тухай гэрчилсэн Бурханыг худалч болгож байгаа юм (1 Иохан 5:10).

Есүсийг Мессиа гэж хүлээн авах боломж хүн бүрд байдаг гэдгийг та бүхэн ойлгосон байх хэмээн найдаж байна. Тэгэхлээр “Ариун Сүнсийг доромжлох” гэдэг нь хүн үхэн үхтлээ Есүс Христийн талаар илчилсэн Түүний илчлэлд үл итгэн, үүгээрээ Түүнийг худалч болгож байгаа явдал гэж бид үзэх ёстай. Энэ нь Бурханыг бүдүүлэг үгээр дайрч доромжлох тухай бус (Матай 26:74-д Петр Есүсийг угүйсгэсэнтэй харьцуул), харин насан туршдаа итгэхгүй байх гэм нүглийг хэлж байгаа юм. Энэ нүгэл нь Есүс Христийн авралын ажлыг хүлээж авахаас зөрүүдлэн татгалздаг агаад үүний үр дагавар нь мөнхийн там юм.

Хувийн Судлал: 7-р бүлэг, 3-р хэсэг

1. Иохан 3:16, 18, 36-р ишлэлүүдийг унш. Аврал авахад юу хийх шаардлагатай вэ?
2. Иохан 1:1, 14; 1 Коринт 15:3-5 ишлэлийг унш. Хүн Есүс Христийн талаар юу гэж итгэх ёстай вэ?
3. 1Тимот 2:4; 2 Петр 3:9-ийг унш. Хүний авралын талаар Бурхан юуг хүсдэг вэ?
4. Ефес 2:8-9 ишлэлийг унш. Хүн хэрхэн аврагдсан бэ?
5. Итгэл гэж юу вэ? Түүний үнэ цэнэ юунд оршдог вэ?
6. 2 Тимот 2:24-25 ишлэлийг унш. Буруу бодлоо өөрчлөхөд юу шаардлагатай вэ?
7. Ром 3:20; Галат 2:16; 3:24-ийг унш. Биднийг Бурханы өмнө юу зөвт (зөвтгөх) хэмээн тунхаглаж, харин юу тийнхүү тунхагладагтүй вэ?
8. 2 Тесалоник 2:13; 1 Петр 1:2-ыг унш. Есүс Христэд итгэсэн хүнийг хэн ариусгадаг вэ?
9. Ефес 1:7; Колоссай 1:13-14 ишлэлийг унш. Яагаад итгэгч хүн уучлагддаг вэ?
10. Матай 12:31-32; Иохан 14:17; Иохан 16:13; 1 Иохан 5:10 ишлэлүүдийг унш. “Ариун Сүнсийг доромжлох” гэж юуг хэлдэг вэ?

4-р ХЭСЭГ

Аюулгүй Байдал: Бурханы Амлалтууд

A. Танилцуулга

Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан авралыг авсан хүмүүст “бид авралаа алдаж болох уу?” гэх мэтчилэн хэд хэдэн асуулт аяндаа урган гарч ирдэг. Хэрэв бид аврагдсаныхаа дараа нүгэл үйлдвэл дахиад аврагдах хэрэгтэй юу? Бид христэч амьдрал дотор хэрхэн амьдрах ёстой вэ? Бурханы хайран доторх аюулгүй байдалдаа итгэлтэй амьдрах уу, эсвэл авралаа алдана гэсэн айдас дотор амьдрах уу? Бид мөнх амийг авсан гэдэгтээ хэрхэн бат итгэлтэй байх вэ? (1 Иохан 5:13) Энэ хичээлээр бид авралтай холбоотой итгэгчдийн эдгээр асуултад хариулахыг хичээх болно.

B. Урьдаас мэдэх болон урьдаас товлох

Урьдаас мэдэх гэдэг нь “эртнээс мэдэх” гэсэн утгатай юм. Есүс ертөнц бүтээгдэхээс өмнө урьдаас мэдэгдсэн (1 Петр 1:20). Урьдаас товлох гэдэг нь “эртнээс сонгож авах” гэсэн утгатай “ПРООРИДКО” (PROORIDZO) гэдэг грек үгээс гаралтай.

Бурханы урьдаас мэдэх мэдлэг нь үйл явдлуудыг урьдчилан товлох Түүний урьдчилсан товлолттой холбоотой гэдгийг Бурханы Үгээс тодорхой харж болно (Ром 8:29-30; 1 Петр 1:1-2). Бурханы бүхнийг мэдэгч төгс мөн чанар нь зөвхөн хийх гэж байгаа шийдвэр болон болох гэж байгаа үйл явдлуудыг бүгдийг нь мэдээд зогсохгүй бүх боломжуудыг бас мэдсэн юм. Бурхан Өөрийнхөө бүтээл болох хүн ба тэнгэр элчүүдэд шийдвэр гаргах чадварыг өгч, үүнийгээ төлөвлөгөөндөө тусгаад, зогсохгүй Өөрийнхөө төлөвлөгөөг гүйцэлдүүлсээр байгаагаа Түүний агуу байдал тодорхой харагддаг.

Бурханы Үгэн дэх эш үзүүллэгүүд нь Түүний урьдаас мэдэх мэдлэгийн зарим хэсгийг илчлэх зорилгоор өгөгдсөн байdag (2 Петр 3:17). Бид Бурханы талд зогсох уу, эсвэл Сатаны талд зогсох уу гэдгийг шийдэх чадвартай байхын тулд ирээдүйд болох зарим үйл явдлуудыг эртнээс мэдэх боломжтой юм.

C. Гэрээнүүд

“Тайллын үндсэн зарчмууд”-ын найм дахь зарчимд Бурханы хүнтэй хийсэн есөн өөр гэрээний талаар авч үздэг. Тэдгээрийн зарим нь хүний дуулгавартай байдал дээр үндэслэгдсэн болзолт гэрээ байсан. Бусад нь зөвхөн Бурханы шийдвэр дээр үндэслэгдсэн болзолт бус гэрээ байлаа. Эдгээр гэрээнд христитгэгчдийн тулгамдсан болон мөнхийн аюулгүй байдлыг батлан даасан Бурханы амлалтууд багтсан байdag. Бурханы үгийг судалж байгаа хүн эдгээр гэрээний талаарх мэдээллүүдийг сэргээн харж, Бурханы амлалтууд дээр суурилсан аюулгүй байдлыг авч үзэх хэрэгтэй.

Г. Мөнхийн аюулгүй байдал

Мөнхийн аюулгүй байдал гэдэг нь аврал алдагдахгүй гэсэн утгатай юм. Бид өмнө сурсан зарчмуудаа ашиглан энэ санааг үргэлжлүүлэн батлах болно. Энэ сэдвийг судлахдаа ерөнхийгөөс хэсэгчлэн задлан шинжлэх аргыг (дедукцийн арга) хэрэглэх нь чухал гэдгийг санах хэрэгтэй. Хэрэв бид Бурханы Үгээс мөнхийн авралаа алдагдахгүй гэсэн нийтлэг баталгааг олж харахын сацуу Бичээст үүнээс өөр онцгой тохиолдол байгааг олж хараагүй бол энэхүү баталгааг үнэн хэмээн хүлээж авах ёстой. Хэрэв Библи ямар зүйлийг батлан хэлсэн бол түүнд хамаарагдахгүй онцгой тохиолдлыг мөн л Библи гаргах эрх мэдэлтэй байdag. Жишээ нь, Ром 3:23-д “**Бүх хүн нүгэл үйлдээнээр Бурханы алдарт хүрдэггүй**” гэж хэлдэг. Гэхдээ, үүнд Есүс Христ хамаарагдаж гэдгийг “**Тэр нүгэл үйлдээгүй**” (1 Петр 2:22) хэмээн Судар өөрөө тодруулсан байdag. Ерөнхийгөөс хэсэгчлэн задлах энэ аргыг бид дедукцийн арга гэдэг. Дедукцийн аргын дагуу “Хэрэв Есүс Христээс бусад бүх хүн нүгэлтэй юм бол би ч гэсэн гэм нүгэлтэй гэсэн үг” гэсэн зөв зүйтэй ойлголт уруу хөтөлдөг. Харин нөгөө талаар, индуksийн арга нь хэсгээс ерөнхий уруу дүгнэн шинжилдэг (би гэм нүгэлтэй учраас бусад бүх хүмүүс гэм нүгэлтэй). Индуksийн энэ арга нь ихэвчлэн зөв байdag боловч Есүс Христийн хувьд таарахгүй байгаа нь түүний илэрхий хязгаарлагдмал байдлыг харуулж байна. Хэрэв бүхэл юмны ямар нэг хэсгийг орхигдуулбал ерөнхий алдаа гарах боломжтой байdag.

Бидний мөнхийн аюулгүй байдлыг дараах дөрвөн аргаар баталж болно.

1. Логик арга

Мөнхийн аюулгүй байдлыг батлах логик аргын гурван жишээг одоо авч үзье. 1-рт, аврал нь сайн үйлсээр бус, харин итгэлээр дамжуулан нигүүлслээр өгөгддөг тул гэм нүгэл гэх мэт үйлсээс болж алдагдах боломжгүй (Ефес 2:8-9). 2-рт, “шинэ төрөлт” нь биднийг “Бурханы хүүхэд” болгодог учраас бидний алдаа дутагдал Эцэгийг маань өөрчилж чадахгүй (Иохан 1:12-13; 2Тимот 2:13). 3-рт, биднийг Өөрийнх нь дайсан байхад хүртэл авралаа соёрхож, бидний төлөө бүхнийг хийсэн Бурхан тэр тусмаа одоо биднийг хэзээ ч орхихгүй (Ром 5:9-10).

2. Байршилын арга

Мөнхийн аюулгүй байдлыг байршилаар батлах арга нь итгэгч хүн Есүс Христийн “дотор” байх ёстой бөгөөд Христийн дотор байдаг хүнд ял байхгүй (Ром 8:1) гэсэн бодит үнэн дээр үндэслэгддэг. Христ дотор байх үед Эцэг биднийг Өөрийн Хүүг хайрладаг тэр хайраараа хайрладаг. Учир нь бид ч мөн Түүний хүүхдүүд болсон (Иохан 1:12-13; Ром 8:38-39; Галат 3:26; Ефес 1:5-8). Үнэндээ, бид үхлийг ялан дийлсэн Христийн амилалтын хуваалцагчид хэдийнээ болсон билээ (Ефес 2:6). “Толгой” нь биеийнхээ эрхтнүүдийг тастаж хаяад хэзээ ч бүрэн бүтэн биетэй байж чадахгүй (1 Коринт 12:13). Бид үргэлж Түүний биеийн эрхтнүүд байх болно.

3. Хамгаалалтын арга

Мөнхийн аюулгүй байдлыг батлах хамгаалалтын арга нь Бурханы баруун гарт залран, биднийг Сatanы эсрэг тэмцэхэд хамгаалж байдаг Есүс Христийн байр суурь дээр тулгуурлагддаг (1 Иохан 2:1-2; Илчлэлт 12:10). Тэр бол хүн төрөлхтөнд илүү сайн гэрээг авчран, Бурхан ба хүний хоорондох Зууч юм (Галат 3:20; 1Тимот 2:5; Еврей 8:6; 9:15; 12:24). Одоо ч Тэр Өөрийн сонгосон хүмүүсийг хамгаалж, аюулгүй байлгахын тулд zuучлан залбирдаг (Ром 8:31-39). “Түүний хонин сүргийг Түүний гараас булаах” гэж оролдсон хэн ч болов Эцэг ба Хүүгийн бүхнийг чадагч мөн чанарыг эсэргүүцэж буй хэрэг юм (Иохан 10:27-29). (Зохиогчийн нэмэлт тэмдэглэл: Энэ нь надад илүү аюулгүй мэт санагдаж байна.)

4. Сүнслэг арга

Мөнхийн аюулгүй байдлыг батлах сүнслэг арга нь Ариун Сүнсний ажил болон бодгальтай харилцах бидний харилцаан дээр үндэслэгддэг. “Муудах үр”-ээс махан биед төрсөн, аврал аваагүй нэгнийг Ариун Сүнс Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан “үл муудах үр”-ээс дахин төрүүлдэг. Тиймээс бид дахиж үхэх боломжгүй юм (1 Коринт 15:42, 52; 1 Петр 1:22-25; Иохан 11:25-26). Биднийг аврагдах үед Ариун Сүнс бидэнд сүнслэг бэлгүүдийг эргэлт буцалтгүйгээр, бялхам дүүрнээр өгдөг (Ром 11:29). Авралыг хүлээн авах тэр агшинд Ариун Сүнс итгэгч хүний дотор нутаглаж, түүний дахин амилалтын баталгаа болдог (Ром 8:9; 1 Иохан 2:27; 2 Коринт 1:22). Түүнчлэн, Ариун Сүнс итгэгчдийг Есүс Христтэй нэгдэх нэгдэл уруу баптисм хүртээж (Ром 8:9; 1 Иохан 2:27), золилтын өдрийг хүртэл түүнийг тамгалдаг (2 Коринт 1:21-22; Ефес 1:13, 14; 4:30).

Г. Үрчлэл

Есүс Христ бол Бурханы цорын ганц хайртай Хүү (Иохан 3:16). Бид итгэлээрээ Есүс Христтэй нэгдэх үед Бурхан биднийг Өөрийнхөө “үрчилж авсан” хүүхдүүд гэж хардаг. Энэхүү үрчлэл нь бүх Израилийн төлөө зориулагдсан байсан боловч тэдний ихэнх нь өөрсдийн Мессиаг эсэргүүцсэн (Ром 9:3-4).

Өнөөдөр итгэгчид өөрсдийгөө Христийн өв залгамжлагчид (Ром 8:15-17; Галат 4:4-7) болсон гэдгээ ойлгож, Бурхантай хүүхдүүд нь юм шиг ойр дотно харилцаатай байх боломжтой юм. Энэ үрчлэлийн ерөөлүүдийг бүрэн дүүрнээр мэдэх өдөр бидэнд ирэх болно (Ром 8:22-23).

Хувийн Судлал: 7-р бүлэг, 4-р хэсэг

1. **1 Иохан 5:13-ыг унш. Хүн аврагдсан гэдгээ баталгаатай мэдэх боломжтой юу?**
2. **Ром 8:29-30; 1 Петр 1:1-2 ишлэлүүдийг унш. Бурхан үйл явдлуудыг урьдчилан товлодгийн үндсэн элемент юу вэ?**
3. **Иохан 10:27-29 ишлэлийг унш. Есүс “хонин сүрэг”-тээ юуг амласан бэ?**
4. **Ефес 2:8-9; Ром 11:29-ийг унш. Аврал нь бэлэг юм бол Бурхан энэ бэлгээ буцааж авах уу?**
5. **Иохан 1:12-13; 2 Тимот 2:13-ыг унш. Хэрэв итгэгч хүн итгэмжтэй байж чадахгүй бол Бурханы хүүхэд байхаа болих уу?**
6. **Ром 5:9-10; Лук 6:31-36 ишлэлийг унш. Бурхан биднийг Өөрийнх нь дайсан байх үед аварсан уу? Хайрыг хамгийн ихээр харуулдаг зүйл юу вэ?**
7. **Бурхан биднийг Өөрийнх нь дайснууд байхад аварч, Өөрийн хүүхдүүд болгосон атлаа одоо биднийг орхино гэж үү?**
8. **Ром 8:1-ийг унш. Христ доторх өөрсдийн байр суурь дээрээ үндэслэн хэлбэл, цаашид юу байхгүй вэ?**
9. **Ром 8:35-39 ишлэлийг унш. Итгэгч хүнийг Христийн хайраас юу салгаж чадах вэ?**
10. **1 Петр 1:22-25 ишлэлийг унш. Бид Ариун Сүнсээр өгөгдсон “Үл муудах үр”-ээс дахин төрсөн учраас бид дахиж үхэх үү?**
11. **Ром 8:15-17 ишлэлийг унш. Итгэгч хүн Бурхантай ямар харилцаатай болсон бэ?**

5-р хэсэг

Ирээдүй: Эш Үзүүллэг (Эсхатологи)

A. Танилцуулга

Бурхан Өөрийн нигүүлслээр эрин үеүдэд зориулсан төлөвлөгөөг боловсруулжээ. Тэрээр ирээдүйд болох түүхэн чухал үйл явдлуудын талаар мэдээллийг бидэнд өгсөн. Зарим тохиолдолд Бурхан бидэнд маш дэлгэрэнгүй мэдээллийг өгсөн байдаг. Харин заримдаа маш цөөн зүйлийг хэлдэг. Бурхан бидний маргаашийг Өөрийнхөө мутарт барьж байдаг гэдэгт бид итгэж болно.

Эш үзүүллэг бол Бурханы үгийн гол сэдэв юм. Библийн 1189 бүлгийн 271-д нь эш үзүүллэгтэй холбоотой сэдэв байдаг. Энэ нь Библийн бараг дөрөвний нэгтэй тэнцэх хэсэг юм. Түүнчлэн бусад номуудад ч гэсэн эш үзүүллэгийн тухай олон нэмэлт ишлэлүүд байдаг. Тиймээс эш үзүүллэгийн талаар судлах нь маш чухал юм.

Бид эш үзүүллэгийг судлахдаа эхлээд хараахан болоогүй байгаа гол үйл явдлуудыг олж тогтоох хэрэгтэй юм. Энэ нь бидний Библи судлалыг удирдан чиглүүлэх загвар болж өгнө. Зарим эш үзүүллэгүүд хэдийнээ биелсэн байхад зарим нь хараахан биелэгүй байдаг тухай бид 4-р бүлгийн “Тайллын үндсэн зарчмууд” хичээлийн 15 дахь зарчмаас үзсэнээ санаарай.

Харин одоо бид ирээдүйд болох үйл явдлуудыг тодорхойлоход хэрэглэгддэг хэд хэдэн нэр томьёог ойлгох шаардлагатай байна.

B. Диспенсац

Эш үзүүллэг нь диспенсацийн судлалтай холбоотой. Юуны түрүүнд оюутан “Тайллын үндсэн зарчмууд”-ын 13 дахь зарчмыг дахин эргэж харах нь зүйтэй юм. Яагаад гэвэл, энэ нь диспенсацтай холбоотой.

Диспенсац гэж Бурхан Өөрийнхөө ард түмэнд өөр өөр үүрэг хариуцлагыг хүлээлгэж байсан түүхэн үеудийг хэлдэг. Тахилчийн үүрэг өөрчлөгдхөд хууль ч өөрчлөгдөх байдал гарч ирдэг нь диспенсацийн өөрчлөлтийг харуулдаг (Еврей 7:12).

Адамын уналтаас авахуулаад израильчууд Египетээс гарах хүртэл үргэлжилсэн Харь үндэстний эрин үе дуусгавар болсон. Харин Израилийн эрин үе нь израильчуудыг Египетээс гарахад (хууль өгөгдсөн үе) эхлээд, Пентекостын өдөр дууссан. Энэ үе нь “Зовлонгийн үе” буюу “Даниелын дал дахь долоо хоног”-ийг (Даниел 9:24-27) оруулахгүйгээр дууссан байдаг.

Өнөөдөр бид Чуулганы эрин үед амьдарч байна. Энэ үе нь Пентекостын өдрөөс эхлээд Чуулган дээш авагдах хүртэл үргэлжилнэ.

Харин мянган жилийн хаанчлалын эрин үе нь Есүс Христ мянган жилийн хаанчлалаа тогтоохоор хоёр дахь удаагаа ирэх үед эхлээд, Сатаны сүүлчийн эсэргүүцэл хүртэл үргэлжилнэ.

B. Чуулганы дээш авагдалт

“Чуулганы дээш авагдалт” гэдэг нь “РАПЕРЕ” хэмээх латин үгээс гаралтай бөгөөд Библийг латин хэл уруу орчуулахдаа 1 Тесалоник 4:17 ишлэлд байсан “ХАРПАДЗО” гэсэн грек үгийг хөрвүүлэхдээ үүнийг ашиглажээ. Монгол хэлнээ “дээш авагдалт” гэж орчуулагддаг.

Дээш авагдалтын үед Эзэн үхсэн итгэгчдийг амилуулж, амьд итгэгчдийн хамт дээш өргөн, агаар мандалд тэдэнтэй уулзах болно (1 Тесалоник 4:14-17). Энэ өөрчлөлт агшин зуурт болно (1 Коринт 15:51-52).

Энэхүү дээш авагдалтаар Чуулганы эрин үе төгсөж, Зовлонгийн үе эхэлнэ.

Г. Зовлон

“Зовлон” гэдэг үг нь усан үзмийг хөлөөрөө няцлахад үүсдэгтэй адил, тийм “даралт”-ыг илэрхийлдэг грек (ТЛИПСИС) үгээс гаралтай. Энэ бол дэлхий өртөнц урьд хожид үзэж хараагүй, тийм зовлонгийн үе юм. Зовлонгийн эрин үед болох үйл явдлуудын талаар бид Илчлэлт 6–19 бүлгүүдээс харж болно.

Зовлонгийн энэ эрин үе нь долоон жил үргэлжлэх бөгөөд үүнийг “Даниелын дал дахь долоо хоног” (Даниел 9:24-27) гэдгээр нь бид мэддэг. Бурхан Өөрийн ард түмэн болох иудейчүүдэд хандан эш үзүүлэгч Даниелээр дамжуулан эш үзүүлэхдээ 70 долоо хоногийн талаарх илчлэлтийг өгсөн байдаг. Есүс Христ цовдлогдохоосоо долоо хоногийн өмнө Иерусалим уруу илжиг унан орох үед эхний 69 долоо хоног дууссан. Харин 70 дахь долоо хоног нь Чуулганы дээш авагдалтаас Есүс Христийн хоёр дахь ирэлт хүртэл үргэлжлэх Израилийн эрин үеийн сүүлчийн долоон жил байх болно.

Д. Хоёр дахь ирэлт

Зовлонгийн долоон жил дуусангүүт Христ буцаж ирэх бөгөөд үүнийг Христийн хоёр дахь ирэлт гэж хэлдэг (Матай 24:29). Энэ нь Ййлс 1:11-д Есүс үүлэн дунд дээш өргөгдсөн шигээ тийнхүү бууж ирнэ гэснээс ялгаатай юм. Харин энэ удаа Есүс Христ хөлөөрөө газар дээр бууж ирэх болно (Зехария 14:1-6).

Энэ удаа Тэр Өөрийн бүх дайснуудыг ялж, мянган жилийн хаанчлал эхлэх болно (Илчлэлт 19:20–20:6). Христ эхлээд Чидун уулан дээр гишгэхэд, уул голоороо хуваагдах бөгөөд Тэрээр Израилийн үлдэгэдийг чөлөөлөх болно (Зехария 14:1-6). Тэр амнаасаа хурц сэлэм гарган өрнийн хааныг устгаад (2 Тесалоник 2:8; Илчлэлт 19:15), дараа нь өмнөдийн хааныг устгаад байсан (Даниел 11:40-44) умардын хааныг тэнгэрээс галаар устах болно (Езекиел 38–39). Тэгээд Тэр дорнын хаадтай тулалдах болно (Исаиа 63:1-6; Илчлэлт 14:20).

Д. Мянган жилийн хаанчлал

Мянган жилийн хаанчлал гэдэг нь Есүс Христ газар дэлхий дээр 1000 жил хаанчлахыг хэлдэг (Илчлэлт 20:6). Энэ хаанчлалын онцлог шинжүүдийг илэрхийлсэн олон багцлал байдаг.

Мянган жилийн хаанчлал нь Абрахам болон Давидын гэрээ, мөн Шинэ гэрээний биелэл байх юм. Түүнчлэн энэ нь Едений хараалыг арилгах болно (Эхлэл 3:17-19).

Энэ хаанчлалын бодит шинжүүд нь: (1) Дайн дажин байхгүй (Исаиа 2:4; Мика 4:3); (2) догшин араатан үгүй (Исаиа 11:6-9; 35:9; 65:25); (3) өвчин зовлон, эрэмдэг зэрэмдэг байдал үгүй болж, амьдрах хугацаа уртасна (Исаиа 29:17-19); (4) нийгэм, улс төр, эдийн засгийн дарангуйлал үгүй болно (Исаиа 14:3-6); (5) хүн амын өсөлт (Иеремиа 30:20); (6) ажил хөдөлмөр (Иеремиа 31:5; Исаиа 62:8-9; 65:21, 23); (7) эдийн засгийн хөгжил цэцэглэлт (Исаиа 35:1, 2, 7); (8) Эзэний гэрэл (Зехария 14:6-7). Зовлонгийн эрин үеийг “хонин сүрэг” (Матай 25:31-46) мэт даван туулсан иудейчүүд болон харь үндэстнүүд мянган жилийн хаанчлалын үед амьдрах бөгөөд тиймээс, тэнд нүгэлт мөн чанартай хүмүүс ч бас байх юм. Тэдний үр хүүхдүүдэд мөн аврал хэрэгтэй байх болно.

Мянган жилийн хаанчлалын сүнслэг шинжүүд: (1) зөвт байдал (Малахи 4:2; Дуулал 89:14); (2) Бурханы талаарх бүрэн мэдлэг (Исаиа 11:9); (3) Ариун Сүнсээр дүүрэн байдал (Иоел 2:28-29); (4) баяр хөөр (Исаиа 9:3-4); (5) шударга байдал (Исаиа 9:7; 11:5; 32:16; 42:1-4; 65:25).

Христ бүх засаг захиргааг нэгтгэж (Езекиел 37:24-28), дэлхий өртөнцийг бүхэлд нь захирах болно (Даниел 7:14; Мика 4:1-2; Зефения 3:9-10; Дуулал 72:8). Гэмт хэрэг бүрмөсөн үгүй болно (Дуулал 72:1-4; Илчлэлт 19:15). Иерусалим нь бүх засаг захиргааны төв болж (Исаиа 2:2-4; Иеремиа 31:6; Мика 4:1; Зефения 2:10-11), Бүхнийг Чадагч Бурханы хамгаалалтан дор орно (Исаиа 11:9). Иерусалим уруу ороход хялбар болох (Исаиа 35:8-9) бөгөөд тийнхүү энэ хот өргөжин тэлнэ (Иеремиа 31:38-40; Езекиел 48:30; Зехария 14:10). Түүнчлэн Иерусалим нь мөргөлийн гол төв (Иеремиа 30:16-21; 31:6, 23; Иоел 3:17; Зехария 8:8, 20) болох ба тэнд Мянган жилийн хаанчлалын сүм байрлана (Езекиел 40:1–46:24). Тэрхүү сүмийг Задокийн удмын тахилч нар удирдана (Езекиел 43:19; 44:15).

Е. Цагаан өнгөтэй агуу их сэнтийн шүүлт хүртэл

Мянган жилийн хаанчлалын дараа, Сатан түр хугацаагаар суллагдах үед Цагаан өнгөтэй агуу их сэнтийн шүүлт болно. Энэ үед үндэстнүүдийг болон “Гог, Магог”-ийг мэхэлж, тэмцэлд босгохыг Сатанд зөвшөөрөх аж (Илчлэлт 20:7-8). Мянган жилийн хаанчлалын үед аврагдаагүй хүмүүс түүний хохирогчид байх болно. Энэ үед Эзэн Сатаны бүх эсэргүүцлийг эцэс болгож, тэнгэрээс гал буулган, түүний хуурамч эш үзүүлэгч болон араатны хамт галт нуурт хаяна (Илчлэлт 20:9-10).

Энэ бүх үйл явдлын дараа итгэгч бус хүмүүс амилуулагдаж, “Цагаан өнгөтэй агуу их сэнтийн” өмнө шүүгдэнэ. Дараа нь тэднийг галт нуурт хаях болно (Илчлэлт 20:11-15).

Ё. Мөнхийн улс

Мөнхийн улсыг “Бурханы өдөр” гэж бас нэрлэдэг (2 Петр 3:12). Цагаан өнгөтэй агуу их сэнтийн шүүлтийн дараа одоогийн тэнгэр, газар устаж, шинэ тэнгэр газар бий болоход мөнхийн амьдрал эхэлнэ (Исаиа 65:17; 66:22; 2 Петр 3:12-13; Илчлэлт 21:1). Шинэ газар дээр шинэ Иерусалим байрлаж, (Илчлэлт 21:2-5) Израилийн арван хоёр овог болон арван хоёр элчийн дурсгал болон сүндэрлэнэ. Шинэ Иерусалимын сүм нь Хурга болох Есүс Христ Өөрөө байх учраас тэнд сүм гэж байхгүй. Мөн түүний гэрэл нь энэ Хурга байх учраас тэнд нар ч байхгүй, сар ч байхгүй (Илчлэлт 21:22-23). Хурганы сэнтийнээс дүүрэн урсгалт “амийн ус”-ны гол ундран урсах бөгөөд голын хоёр талд арван хоёр төрлийн үр жимс угтуулан, сар бүр үр жимсээ боловсруулж буй “амийн мод” энэ голоос тэжээгдэх болно (Илчлэлт 22:1-2).

Мөнхийн улсад нүгэл байгүй болно (Илчлэлт 21:24-27). Есүс Христэд итгээгүй, нүглийнхээ төлөө учлалыг аваагүй хүмүүс шинэ тэнгэр газар болон шинэ Иерусалимд орж чадахгүй. Тэд мөнхөд галт нуурт хаягдана (Илчлэлт 21:8). Зөвхөн “ялагчид” л Амьд Бурханы мөнхийн баяр баясгаланд орж чадна. “*Ертөнцийг дийлсэн ялалт нь итгэл болой!*” Бурханд талархья (1 Иохан 5:4-5).

Илчлэлт 21:8 ишлэлд бичигдсэн гэм нүглүүд нь хүнийг диваажинд ороход саад болдоггүй, харин Есүс Христэд итгэхгүй, мөн эдгээр гэм нүглийнхээ төлөө Бурханаас учлалыг хүлээн авахгүй байх нь саад болдог гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хувийн Судлал: 7-р бүлэг, 5-р хэсэг

- 1. Еврей 7:12-ыг унши. “Диспенсац” өөрчлөгдөхөд юу болдог вэ?**
- 2. 1 Тесалоник 4:14-17 ишлэлийг унши. Дээш авалтын үед итгэгчид Есүстэй хаанаа уулзах вэ?**
- 3. 1 Коринт 15:51-52 ишлэлийг унши. Чуулганы дээш авагдалт хэр хурдан болох вэ?**
- 4. Иохан 14:1-3 ишлэлийг унши. Дээш авагдалтын дараа Чуулган хаанаа байх вэ?**
- 5. Даниел 9:24-27 ишлэлийг унши. 7 жилийг агуулсан 70 дахь долоо хоног бүрэн дуусаагүй. Үүнийг ямар эрин үе гэж нэрлэдэг вэ?**
- 6. Илчлэлт 19:11-16; Матай 24:29-30, Зехария 14:1-6 ишлэлүүдийг унши. Зовлонгийн жилийн дараа Христ юу хийх вэ?**
- 7. Байршилтай нь холбож үзвэл, дээш авагдалт болон болон хоёр дахь ирэлтийн гол ялгаа юу вэ?**
- 8. Илчлэлт 19:20; 20:10-ийг унши. Хоёр дахь ирэлтийн үед хэн галт нуурт хаягдах вэ?**
- 9. Илчлэлт 20:1-3 ишлэлийг унши. Хоёр дахь ирэлтийн үед хэн ёроолгүй гүнд хаягдах вэ?**
- 10. Илчлэлт 20:4-6 ишлэлийг унши. Есүс Христ газар дээр хэр удаан хаанчлах вэ?**

11. Илчлэлт 20:7-10 ишлэлийг унш. Мянган жилийн хаанчлалын дараа Сатан хэсэг хугацаагаар суллагдаж, хүмүүсийг тэмцэлд удирдах болно. Тэр дахин ялагдахад түүний төгсгөл хаана байх вэ?
12. Илчлэлт 20:11-15 ишлэлийг унш. “Амийн ном”-д нэр нь бичигдээгүй хүмүүс Цагаан өнгөтэй агуу их сэнтийн шүүлтийн дараа хаана хаягдах вэ?
13. 2 Петр 3:10-13; Илчлэлт 21:1-ийг унш. Цагаан өнгөтэй агуу их сэнтийн шүүлтийн дараа юу болох вэ?

Наймдугаар Бүлэг

**Бурханы Зорилгын
Тухай Онол**

1-р ХЭСЭГ

Итгэгч Хүний Хувийн Амьдрал (Ходологи)

A. Танилцуулга

Итгэгч хүн бүрийг Бурхан Өөрийн Хүү, Есүс Христийн дүр төрхтэй адилхан болж өөрчлөгдөөсэй гэж зорьдог (Ром 8:29). Бурхан хүний амьдралд өөрчлөлтүүдийг гаргах Зорилгоо хэрэгжүүлэх гурван үе шатыг тавьсан байгаа. Бид энэ гурван үе шатыг: 1-р үе шат, 2-р үе шат, 3-р үе шат гэж хуваана.

1-р үе шат нь итгэдэггүй хүн Есүс Христэд итгэх тэр мөчид тохионо (Үйлс 16:31). Энэ бол тухайн хүний мөнх авралын эхэн юм.

2-р үе шат нь тухайн хүнийг нас барах хүртэл, эсвэл Чуулган дээш авагдах хүртэл түүний дотор үргэлжлэх процесс юм.

3-р үе шат нь уг итгэгч хүн нас барахад, эсвэл Итгэгч хүн дээш авагдахад эхлээд мөнхөд үргэлжлэх болно.

Есүс Христтэй адил болж өөрчлөгдөхийг хичнээн хүслээ ч тэр нь биднийг 3-р үе шатанд ортол бүрэн дүүрэн гүйцэлдэхгүй. Гэвч Итгэгч хүн аврал авах мөчид өөрчлөгдөж эхэлдэг (2 Коринт 3:18). Есүс Христийн дүрээр өөрчлөгдөнө гэдэг маань хувна хичээдэггүй, даруу төлөв, өөрийгөө бусдын төлөө зориулсан Түүнтэй адил (Филиппой 2:5-8) хандлага, зан чанартай болохыг хэлж байгаа юм. Энэ өөрчлөлт нь хэрхэн бидний “*дүүдагдсан тэрхүү дуудлагадаа зүй зохистой явах*” –ын нэгээхэн хэсэг нь болдог (Ефес 4:1-3).

Итгэгч хүний амьдралд ийм үе шатууд байдгийг мэдэх нь Бурханы үгийг ойлгоход бидэнд тустай юм. Бид “хэн” гэдэг асуултыг тавихдаа Бурхан итгэгчдэд хандан ярьж байна уу, эсвэл үл итгэгчдэд хандан ярьж байна уу гэдгийг ялгах хэрэгтэй болдог. Тэгвэл уг судалж байгаа Библийн багцлалыг зөв ойлгож чаддаг. Сүнслэг амьдралын тухай судлах явцад үүнийг санаж байгаарай.

B. Христэд итгэгч хүний амьдрал дахь 13 элемент

1. Итгэл

Товчондоо, итгэл гэдэг бол хэн нэгэнд юмуу ямар нэгэн зүйлд итгэл өгч, найдахыг хэлж байгаа юм. Тэр хүн эсвэл, юм таны хүслийг, хэрэгцээг хангаж өгнө гэсэн итгэл. Итгэлд өөрт нь хүч байхгүй, харин хэнд итгэлээ өгч байна гэдэг чинь чухал асуудал. Жишээ нь, нэг хүн өөр шинэ тэнгэр газрыг бүтээе гэж бодлоо, бүр чадна гэж итгэсэн байлаа ч гэсэн, хүний дотор тийм бүтээл гаргаж ирэх хүч чадал эрх мэдэл байхгүй. Тэгэхээр тийм итгэл байлаа ч утгагүй болох юм.

Харин өгөгдсөн нөхцөлд тухайн зүйлийг гүйцэлдүүлэх мэдлэгтэй, чадалтай нэгэнд итгэл өгөх аваас, тийм итгэл л үнэ цэнэтэй, утга учиртай болох аж. Тэнгэр газрыг бүтээсэн Бурханд бид итгэлээ өгсөн, учир нь Түүнд тэр хүч чадал, мэдлэг оюун ухаан, хүсэл бий. “*Итгэл бол бидний найдал зүйлсийн бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн. Учир нь урьдын хүмүүс түүгээр гэрчлэлийг хүлээн авсан аж. Бурханы үгээр өртөнц бүтээгдсэн бөгөөд тийнхүү харагдах зүйлс нь үзэгдэх зүйлсээс бий болгогдоогүйг бид итгэлээр ойлгодог*” гэж Сударт хэлдэг (Еврей 11:1-3).

Есүс Христэд итгэх итгэл бол зөвтгөгдөх (зөвт хэмээн тооцогдох) суурь бөгөөд Христэд итгэгчдэд өгсөн нигүүлсэлд орох алхам билээ (Ром 5:1-2). Тэгэхээр 1-р үе шатанд итгэл бол үл итгэгч хүн итгэгч болоход амин чухал. Энэ итгэл мөн бидний Ариун Сүнслэг харилцааг эхлүүлдэг (Галат 3:2-3, 14).

Итгэл бол христэч итгэлийн амьдралд (2-р үе шат) маш чухал, учир нь итгэлгүйгээр Бурханд таалагдах боломжгүй (Еврей 11:6; 2 Коринт 5:7). Бидний дотор итгэл байгааг хараахдаа Тэр

баярладаг (Матай 8:5-10). Итгэлээр л бид Сатаны тогтолцоо, ертөнцийг ялж гардаг (1 Иохан 5:4-5). Христэд итгэгчдийн итгэл байнга шалгагдаж, тэгснээрээ бид нялх хүүхэд шиг байхаа болж насанд хүрсэн итгэгч болдог (Иаков 1:3). Итгэлээр тогтмол ёсөх нь Ариун Сүнстэй бидний тогтоосон харилцааг улам хүчтэй болгож өгдөг (Галат 3:4-5). Итгэл бол христэч амьдралд суурь болж өгдөг билээ (2 Петр 1:5-9).

Бид амилсан биетэйгээр Христтэй хамт мөнхөд байх тэр үед итгэл хэрэггүй болно. Яагаад гэвэл бид Түүнийг байгаагаар харах болно (1 Иохан 3:2).

2. Сүнсний амьдрал

Сүнсний амьдрал гэдгээр бид Бурхан-Ариун Сүнстэй тогтоосон харилцааг хэлж байгаа юм. Тэгэхээр энэ нь итгэгч хүн өөрийн амьдрал дахь Ариун Сүнсэнд байнга түшиглэн амьдрахтай холбоотой. Үл итгэгч нь Ариун Сүнстэй ямар ч холбоогүй (1 Коринт 2:14) тул сүнсний амьдрал гэдэг зүйл огт байхгүй гэсэн үг.

a. Дотор орших

Чуулганы Үеийн итгэгч бол өмнөх үеүдэд байсан итгэгчдээс ялгаатай. Яагаад гэвэл өмнөх үеүдэд Ариун Сүнс итгэгчдийн дээр ажиллаж байлаа. Харин одоо Тэр итгэгчдийн дотор ажиллаж байгаа гэж Есүс хэлсэн байдаг (Иохан 14:17). Ариун Сүнс итгэгч хүний дотор оршиж байгаа нь авралын баталгаа болдог (Ром 8:9).

Ариун Сүнс бидний дотор оршино гэдэг бол авралаар өгөгдсөн бэлэг (Ром 5:5; Үйлс 11:16-17; 1 Коринт 2:12) бөгөөд бэлгийг буцааж болохгүй (Ром 11:29). Тиймээс хүн нүгэл үйлдлээ гээд Ариун Сүнс алга болчихгүй. Үүний баталгааг тухайн үед Коринтын чуулганд “махан бие”-ийн дагуу явагсад (1 Коринт 3:3), нүгэлд унасан (1 Коринт 5:5) хүн байсан боловч, бүгд Ариун Сүнсний орших сүм болсоор байсан гэдгээс үзэж болно (1 Коринт 3:16; 6:19).

6. Дүүргэлт

“Сүнсний амьдрал” гэдэг үг Ариун Сүнстэй тогтоосон бидний харилцааны түвшинг заадаг бол “Ариун Сүнсний дүүргэлт” гэдэг нь бидний “сүнсний амьдрал”-ын эхлэл нь болж өгдөг. Бид үргэлж Ариун Сүнсээр дүүрэн байж, хүчирхэгжихийг эрмэлзэх аваас Тэр биднээр дамжуулан “үр жимс” гаргадаг (Галат 5:22-23).

Ариун Сүнсээр дүүрэх гэдгийг Сударт анхандаа хэн нэгэн хүнийг онцгой даалгавар биелүүлүүлэхээр тусгайлан хүчирхэгжүүлэх гэсэн утгаар гардаг байсан бол одоо цагт энэ нь өдөр тутмын христитгэгч хүний амьдралын салшгүй нэг хэсэг болсон байдаг. Христэч амьдрал дахь Ариун Сүнсний дүүрэн байдлын ач холбогдлыг бид хамгийн түрүүнд Стефаны амьдралаас олж хардаг. Стефан бол бэлэвсэн эмэгтэйчүүдэд туслахаар сонгогдсон хүн байлаа (Үйлс 6:5). Ийнхүү утга санаа нь улам бүр тэлсээр байгааг бид ойлгож болно, яагаад гэвэл Чуулган “нялх хүүхэд” шиг эхлээд, улмаар эрийн цээнд хүрэх учиртайг Паул хэлсэн байдаг (Ефес 4:11-16).

Ариун Сүнсний дүүргэлтийн талаар Сайн мэдээний номууд болон Үйлс номоос гадна ганцхан газар дурдсан байдаг нь Паулын “*Дарсанд бүг согтуур. Ингэвэл дураараа дургих байдалд автагдана. Харин Сүнсээр дүүрэн бай ...*” гэж хэлсэн үгс юм (Ефес 5:18). Яагаад ийм харьцуулалт хийв? Хүн дарс уухдаа гэнэт согтдоггүй, түүнтэй адилаар Ариун Сүнсээр дүүрэн гэдэг бол гэнэтийн тохиолдол биш, харин процесс гэдгийг харуулж байна. Паулын өмнө нь Ефес 1:23, 3:19, 4:10-т ашигласан “дүүрэх” гэсэн үгийн (грекээр ПЛЕРОО) цаанаа процесс – явц гэсэн утга агуулагдсан байдаг. Паулын энэ тушаалуудад Ариун Сүнсээр ямагт дүүрэн байхын ач холбогдлыг өгүүлсэн байдаг нь цаг үргэлж гэм нүглээ хүлээн зөвшөөрч, гэмшиж улайж, Бурханы учлалд итгэж байх явдал билээ. Тогтмол дүүрэн байхын ач холбогдол нь бидний “Сүнслэг амьдрал”-тай шууд холбоотой гэдгийг зааж байгаа билээ.

Жинхэнэ сүнслэг амьдрал нигүүлсэл ба итгэл дээр тогтдог. “*Тиймээс та нар Эзэн Христ Есүсийг хүлээн авсан шигээ Түүн дотор алхахдаа, заалгаж байснаараа Түүн дотор бат үндэслэгдэн, байгуулагдаж, итгэл дотороо баталгаажин, талархлаар бялхагтун*” гэж

бидэнд хэлсэн (Колоссай 2:6-7). Бид Түүнийг итгэлээрээ нигүүлслээр хүлээж авсан (Ефес 2:8-9). Христэч төлөвшилтийг бий болгодог Сүнсний амьдрал нь итгэлээр алхаж амьдрах дээр тогтдог гэдгийг бидэнд тодорхой зааж өгсөн төдийгүй (Галат 3:2-3), итгэлгүйгээр Эзэнд таалагдана гэдэг боломжгүй гэсэн (Еврей 11:6).

Дүгнээд хэлэхэд, Ариун Сүнсний дүүргэлт нь итгэгчдийг хучирхэгжүүлснээр тэд Христ Есүс дотор улам бүр төлөвшдөг юм.

в. Шаналах, бөхөөх

Итгэгч хүн нүгэл үйлдэхээр Ариун Сүнс “гомддог”, шаналдаг (Ефес 4:30). Итгэгч хүн нүглээ улайхгүй, гэмшихгүй удаан хадгалах тусам Ариун Сүнс бүр илүү шаналдаг. Энэ үг итгэгч хувь хүний дотор юу болж байгааг харуулдаг.

Итгэгч хүн гал унтраахтай адилаар Ариун Сүнсийг “бөхөөнө” гэдэг нь өөрийнхөө болон бусдын сүнслэг амьдрал, үр жимст хор хөнөөл учруулахыг хэлж байгаа юм (1 Тесалоник 5:19). Бид бусад итгэгчдийн дотор хийгдэж буй Ариун Сүнсний ажлыг зогсоохыг оролдож болохгүй.

3. Нүглээ улайх

Бид авралыг хүлээн авах үед бидний гэм нүглүүд учлагдсан гэдгийг, мөн бид итгэгч болсон ч нүгэл үйлдэг гэдгийг Бурханы Үгэнд тодорхой хэлсэн байдаг (Ром 7:14-25). Ийнхүү нүгэл нь бидний авралд саад болохоосоо өнгөрч, харин христэч амьдралын маань асуудал хэвээр үлддэг. Итгэгч хүний амьдрал дахь нүгэл нь Бурхан ба бусад хүнтэй харилцах түүний харилцаанд сэв суулгадаг боловч үүнийг устгадаггүй. Тиймээс, нүгэл нь нөхөрлөлд асуудал учруулдаг зүйл аж.

Хамгийн энгийнээр, нөхөрлөл гэдэг нь хүмүүс бие биетэйгээ ямар нэг зүйлээ хуваалцахыг хэлдэг. Энэ нь магадгүй цаг хугацаа, эд зүйлс, үйл явдал, хүмүүс байж болох юм. Үл итгэгчид хамтдаа нүгэл үйлдэж байгаа нь хүртэл нөхөрлөл юм. Итгэгч ч бай, үл итгэгч ч бай, хэрэв тэд нөхөрлөлийн дүрэм журмыг сахиагүй бол нэг нэгэнтэйгээ харилцах таарамжтай харилцаагаа алддаг. Христитгэгчид бид Бурхантай болон нэг нэгэнтэйгээ нөхөрлөх ёстой бөгөөд энэ нөхөрлөл маань Бурханы хүүхдүүд гэсэн бидний шинэ байр суурин дээр үндэслэгддэг. Ийм учраас энэ нөхөрлөл нь Бурханы тогтоосон зөвт жишгүүд дээр суурилагддаг.

Бурхантай болон бусад христитгэгчидтэй нөхөрлөлөө хэрхэн сэргээж болох тухай 1 Иохан 1:5-10 ишлэлд дурдсан байна:

5-р ишлэлд нөхөрлөлийн жишгийг ийнхүү тогтоожээ: **“Бурхан бол гэрэл, мөн Түүний дотор харанхуй огт байхгүй гэдэг нь бидний Түүнээс сонссон мэдээ бөгөөд та нарт тунхаглаж байна.”** Энэ жишиг нь гэм нүглийн талаарх Бурханы үнэнийг илэрхийлсэн Бурханы гэрэл юм.

6-р ишлэлд нөхөрлөлийн шалгуурыг тогтоосон байна. **“Хэрэв бид Бурхантай нөхөрлөөдөг гэж яриад, харанхуй дотор алхаж байвал бид худал хэлж, үнэнийг үйлдээгүй ажээ.”** Бид бодол санаа, үг яриа болон үйл хөдлөлөө (алхаа) Бурханы гэрэлд шалгах ёстой гэсэн санааг энэ ишлэлд илэрхийлж байна.

7-р ишлэлд нөхөрлөлд зориулсан нөхцөлийг тодорхойлжээ. **“Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс цэвэрлэдэг ажээ.”** Бидний христэч бодол санаа, үг яриа болон үйл хөдлөл нь бие биетэйгээ нөхөрлөх нөхөрлөлийг сайжруулж, гэм нүглээс цэвэрлэгдэхэд тусалдаг.

8-р ишлэлд нүглийн заль мэхийг илчилсэн байна. **“Хэрэв бид нүгэлгүй гэж хэлбэл өөрсдийгүү мэхэлжс байгаа бөгөөд бидний дотор үнэн алга.”** Энэ ишлэлд, “бид” гэдэгт итгэгчдийг багтаасан байж таарна. Учир нь Иохан өөрийгөө үүнд оруулан хэлсэн аж. Хэрэв хүн өөрийгөө ямар ч нүгэлгүй төгс болсон гэж бодож байгаа бол тэрээр өөрийгөө мэхэлж буй хэрэг юм.

9-р ишлэлээр нүглийн шийдлийг өгчээ. “Хэрэв бид нүглээн хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжсит, зөвт бөгөөд бидний нүглийг училж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.” “Хүлээн зөвшөөрөх” (ХОМОЛОГЕО) гэж орчуулагдсан грек үг нь хүний болол санаа, үг яриа болон үйл хөдлөл нь үнэхээр гэмтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, улмаар энэ тал дээр Бурхантай санал нийлэх гэсэн утгыг илэрхийлдэг. Гэхдээ энэ нь зүрх сэтгэлдээ гэмшээгүй хэрнээ Бурханаас нүглийн учлалыг олж авах “жор” биш гэдгийг анхаарах хэрэгтэй. Бурхан элэг доог болохгүй (Галат 6:7). Бурхан гэм нүглийг училж чадах бөгөөд учлах болно гэсэн итгэл байгаа учраас хүн амьд Бурханы өмнө ирж, нүглээн хүлээн зөвшөөрч, улайдаг. Энэ ишлэл бол Бурханы амлалт бөгөөд христитгэгчид үүнийг мэдэж, үүнд итгэж, амьдралдаа хэрэглэх ёстой.

10-р ишлэлд гэм нүглээн хүлээн зөвшөөрдөггүй хүмүүсийн тухай: “Хэрэв бид нүгэл үйлдээгүй гэж хэлбэл, бид Түүнийг худалч болгож байгаа хэрэг бөгөөд бидний дотор Түүний уг алга” хэмээн өгүүлжээ. Хэрэв бид Христэд итгэснийхээ дараа өөрсдийн маань амьдралд нүгэл байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол бид Бурханыг худалч болгож байгаа хэрэг бөгөөд Түүний угийг ойлгоогүй байна гэсэн уг гэж энэ ишлэлд хэлж байна.

Нүгэл нь Бурхантай (и.6) болон бусад итгэгчидтэй (и.7) нөхөрлөх сүнслэг нөхөрлөлийг сэвтээдэг болохыг бид эдгээр ишлэлээс харж байна. Бид Бурханы учлалыг хүртэж, сэвтсэн харилцаагаа сэргээхийн тулд Бурханы өмнө нүглээн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй (и.9 – Бурхан бол итгэмжит, зөвт билээ).

Бидний нүглийн мөнхийн үр дагавар хэдийнээ учлагдсан гэдгийг анхаарах хэрэгтэй. Гэхдээ итгэгч хүний амьдралд нүглийн үр дагавар нөлөөлөх боломжтой юм. Адам, Ева хоёр учлагдсан ч гэсэн Еден цэцэрлэгээс хөөгдсөнийг санана уу.

4. Сүнслэг бэлгүүд

Сүнслэг бэлгүүд бол Христийн бие доторх янз бүрийн үйлчлэлд үйлчлэх Бурханаас өгөгдсөн чадвар юм. Энэ нэр томьёо нь “нигүүлслийн улмаас өгөгдсөн” (КАРИСМА) гэсэн утгатай грек үг, эс гаралтай аж. Сүнслэг бэлэг нь хүмүүний төрөлх авьяас бэлэг буюу чадвараас ондоо зүйл бөгөөд үүнийг Есүс Христ тогтоож (Ефес 4:11), авралын үед Ариун Сүнс дээд эрх мэдлийнхээ дагуу Христийн бүхэл биед (Ефес 2:20) хуваарилан өгдөг (1 Коринт 12:11, 18). Хүн бүрд бүх бэлэг өгөгдөггүй (эс бөгөөс тэд өөрөө өөрсдөдөө бие болох байсан, уд.харьц. (1 Коринт 12), харин хамгийн багадаа нэг бэлэг (1 Петр 4:10) өгөгдсөн байдаг.

Бүх бэлэг хайраар ажиллах ёстой (1 Коринт 13) бөгөөд бусдын төлөө үйлчлэхэд (1 Петр 4:10) зориулагдсан гэдгийг ойлгох нь маш чухал. Хэдийгээр эдгээр сүнслэг бэлэг нь Ариун Сүнсээр өгөгдсөн боловч хүмүүс түүнийг бусдын анхаарлыг өөртөө татах, эсвэл ихэрхэх гэх мэт махан биесийн зорилгоор ашиглах боломжтой гэж 1 Коринт номд элч Паул хэлсэн байдаг (1 Коринт 12). Сүнслэг бэлгүүдийг чуулганыг хагалан бутаргаж, самууруулахын тулд бус, харин босгон байгуулахыг тулд ашиглах ёстой (1 Коринт 14:12, 33).

Шинэ гэрээнд сүнслэг бэлгүүдийг нэрээр нь нэрлэсэн таван багцлал байдаг. **1 Коринт 12:8-10** ишлэлээс бид мэргэн ухааны үг, мэдлэгийн үг, итгэл, эдгээх болон гайхамшигудыг үйлдэх, эш үзүүлэх, сүнснүүдийг ялгах чадвар, олон янзын хэлээр ярих чадвар, хэлүүдийг тайлбарлах бэлгүүдийг хардаг. **1 Коринт 12:28**-аас элч байх, эш үзүүлэх, багшлах, гайхамшигийг үйлдэх, эдгээх, туслах, удирдах ба олон хэлээр ярих бэлгүүдийг олж харна. **Ефес 4:11**-ээс элч байх, эш үзүүлэх, сайн мэдээг тунхаглах, хоньчлох ба багшлах бэлэг авьяасыг харж болно. Харин **1 Петр 4:11**-д үг яриа ба үйлчлэлийг сүнслэг бэлгүүдийн хоёр үндсэн ангилал болгон өгсөн байдаг. **Ром 12:6-8** ишлэл зарим нэг онцгой бэлгүүдийг жагсаасан байдаг.

Сүнслэг бэлгүүд нь Пентекостын өдөр Чуулганд өгөгдсөн гэдгийг ойлгох хэрэгтэй (Үйлс 2). Зарим бэлэг нь Чуулганы суурийг тавьж (Ефес 2:20), улмаар босгон байгуулагдаж, хүчирхэгжүүлэхэд (1 Коринт 14:40) зориулагдан өгөгдсөн. Эдгээр бэлгийг “тэмдэг” гэж нэрлэсэн бөгөөд энэ нь Судрыг бичиж дуусах хүрэл итгэгч биш хүмүүст сайн мэдээг түгээх болон шинэ итгэгчдийн итгэлийг

батжуулах зорилготой байсан (1 Коринт 14:20-22). Эдгээр нь түр зуурын бэлэг байсан ба анхны чуулганы үед хэрэгцээтэй байсан үүргээ гүйцэтгэсний дараа алга болсон байна (1 Коринт 13:8-10).

Дараах хүснэгтэд чуулганы эрин үед хэрэглэгдэж байсан түр зуурын сүнслэг бэлгүүдийг үзүүлэв:

Чуулганы эрин үед өгөгдсөн түр зуурын сүнслэг бэлгүүд	
Мэргэн ухааны үг (1 Коринт 12:8)	Үнэнийг Чуулганы эрин үед хэрэгжүүлэхэд зориулсан ёс бусын зааварчилгаанууд
Итгэлийн бэлэг (1 Коринт 12:9)	Боломжгүй мэт харагдах нөхцөл байдлын дунд Эзэнд итгэх ёс бусын агуу итгэл (1 Коринт 13:2 уд.харьц. Үйлс 12:1-19)
Мэдлэгийн үг (1 Коринт 12:8)	Шинэ гэрээ бүрэн бичигдэж дуусах хүртэл чуулганыг мэдээллээр хангах ер бусын хангалт. (Эш үзүүлэгийн чанартай биш)
Эдгээх бэлэг (1 Коринт 12:9, 28)	Янз бүрийн өвчтэй хүмүүсийг ер бусын байдлаар, агшин зуурт, бүрэн дүүрэн эдгээх.
Гайхамшиггуудыг үйлдэх (1 Коринт 12:10, 28)	Байгалийн ердийн хуулиас ангид ер бусын зүйлийг үйлдэх. Үүнийг эдгээх болон чөтгөрүүдийг зайлзуулах чадвартай холбож үздэг байсан (Үйлс 19:11-12).
Эш үзүүлэх (1 Коринт 12:10, 28; Ром 12:6; Ефес 4:11)	Ойрын болон холын ирээдүйд болох үйл явдлыг чуулганд урьдчилан хэлэх ер бусын чадвар (Үйлс 11:27-28).
Сүнснүүдийг ялгах чадвар (1 Коринт 12:10)	Хуурамч багш нар болон хуурамч эш үзүүлэгчдийг үнэлж цэгнэх ер бусын чадвар (1 Коринт 14:32).
Хэлээр ярих чадвар (1 Коринт 12:10, 28)	Огт мэддэггүй харь хэлээр ярих ер бусын чадвар
Хэлийг тайлбарлах чадвар (1 Коринт 12:10)	Өмнө нь сурч байгаагүй харь хэлийг орчуулан тайлбарлах ер бусын чадвар.
Элч (1 Коринт 12:28; Ефес 4:11)	Есүсийн сонгосон (Лук 6:13-16; Үйлс 9:15; Галат 1:1) арван хоёр хүнд (Илчлэлт 21:14) л өгөгдсөн сүнслэг бэлэг.

“Мэдлэгийн үг”, “эш үзүүлэх” болон “хэлээр ярих” бэлгүүд нь “төгс юм” ирэх үед үгүй болно гэж бичигдсэн байdag (1 Коринт 13:8-10). Дээрх бэлгүүд алга болсноор “сүнснүүдийг ялгах чадвар” болон “хэлүүдийг тайлбарлах чадвар” бас алга болно. Учир нь эдгээр нь өмнөх бэлгүүдтэй хамтдаа ажилладаг. Түүнчлэн мэргэн ухааны болон итгэлийн бэлгүүд ч гэсэн “үгүй болсон” гэх бусад бэлгүүдтэй нэгдмэлээр ажилладаг аж. Энэ бүх бэлгүүд бүгд уг яриа, харилцаатай холбоотой байгааг анзаараарай. Илчлэлт ном бичигдэж дуусах үед Чуулганы эрин үеийн эш үзүүллэг мөн хаагдсан байна (Илчлэлт 22:18-19). Тэгэхлээр “төгс юм” гэдэг нь Бурханы амьсгалснаар бичигдсэн, Түүний бүрэн гүйцэд Үг байж таарна. Чуулганд өөр илүү шинэ мэдээлэл шаардлагагүй юм. Үүнээс хойш заах бэлгүүд нь Бурханы бичигдсэн уг буюу Шинэ гэрээнд илчлэгдсэн зүйлсийн уг яриа, харилцаагаар дамжуулан бусад хүргэхэд голлон анхаарах болжээ.

Ердөө арван хоёр элч байсан гэж Илчлэлт 21:14-т хэлсэн байdag. Хэдийгээр өөр хүмүүс “элч”-ийн үүргийг гүйцэтгэж байсан боловч энэ нь тэдэнд элчийн бэлэг авьяас байсан гэсэн уг биш юм (Галат 1:19; Эзэний дүү анхны арван хоёрын нэг байгаагүй). Энэхүү сүнслэг бэлэг нь бас түр зуурынх гэдэг нь тодорхой.

“Эдгээх” болон “гайхамшигийг үйлдэх” бэлгүүд нь мөн л түр зуурынх байсан гэдгийг Шинэ гэрээн дэх түүний түүхэн хэрэглээ харуулдаг. Бурхан одоо ч гэсэн хүмүүсийг эдгээж, гайхамшиггуудыг үйлдэх боломжтой, гэхдээ хувь хүнд өгөгдсөн сүнслэг бэлгүүдээр биш. Эзэн одоо ч гэсэн залбираалд хариулдаг (Иаков 5:16), тэгэхдээ эдгээр бэлэг нь түүнийг эзэмшигчийн шийдвэр дээр үндэслэгддэг. Эдгээх бэлэгтэй хүмүүс Эзэнийг дуудах үед эдгэрэл явагддаг (Үйлс 3:6-8; 5:12-16; 9:34). Анхны чуулганы үед амилсан Христийн тухай мэдээ жинхэнэ гэдгийг нь нотлохын тулд эдгээр бэлгийг ашиглаж байсан (Үйлс 8:1-8, 39; 13:4-12; 14:1-4; 19:11-12). Итгэгчдийн нэг нэгнээ гэсэн хайр нь Есүс Христийн мэдээнд бусдын анхаарлыг хандуулах илүү боловсронгуй арга зам юм (Иохан 13:34-35).

Элч Паул эдгээх бэлэгтэй байсныг бид мэднэ (Үйлс 20:8-12; 28:8). Гэвч хожим тэр өөрийн сайн нийз Епафродитыг ч (Филиппой 2:25-27), өөрийгөө ч эдгээж чадаагүй (2 Коринт 12:7-9). Аххны Чуулганы гол хүмүүсийн нэг болох элч Паулаас энэ бэлэг авьяас аажим аажмаар угүй болсон учраас бусад хүмүүсээс ч гэсэн алга болох учиртай байжээ.

Бусад бэлгүүд нь “балчир” үеэ өнгөрөөсөн чуулганы үйл ажиллагаанд зориулагдсан байсан (1 Коринт 13:10-13) бөгөөд тийм учраас тэдгээр нь байнгынх юм. Ийм бэлгүүдэд Бурханы үгийг дамжуулах болон бусад үйлчлэх бэлгүүд ордог (1 Петр 4:10-11).

Өнөөг хүртэл хэрэглэгдэж байгаа байнгын сүнслэг бэлгүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Чуулганы эрин үед зориулагдсан байнгын сүнслэг бэлгүүд	
Заах бэлэг (1 Коринт 12:28; Ром 12:7)	Бурханы Үгийг бусад дамжуулах ер бусын чадвар.
Туслах бэлэг (1 Коринт 12:28)	Бусад өгөгдсөн бэлгүүдтэй ер бусын байдлаар хамтран ажилладаг бэлэг. Энэ бэлэг нь янз бүрийн хүрээнд ажилладаг. Жишээ нь, бусдыгаа бэлэг авьяасаа бүрэн дүүрэн ашиглах боломжийг бүрдүүлэхийн тулд тэдэнд зориулан хоол хүнс бэлдэх, хандив цуглуулах гэх мэт (Үйлс 6:1-6).
Үдирдах (1 Коринт 12:28)	Өөрийнхөө Чуулганд Бурханы өгсөн нөөц бололцоонуудыг зохион байгуулах, захиран зарцуулах ер бусын чадвар.
Үйлчлэх (Ром 12:7; 1 Петр 4:11)	Практик үйлчлэлийг гүйцэлдүүлэх ер бусын чадвар.
Өгөх (Ром 12:8)	Өөрт байгаа нөөц бололцоогоо бусадтайгаа хуваалцах ер бусын чадвар. Энэхүү сэтгэл нь өгч байгаа зүйлийн хэмжээгээр бус, харин өгөөмөр сэтгэлээр хэмжигддэг.
Тэргүүлэх (Ром 12:8)	Чуулганы үйлчлэлийг гүйцэлдүүлэхийн тулд хувь хүмүүсийг удирдан чиглүүлэх ер бусын чадвар.
Оршөөл үзүүлэх (Ром 12:8)	Сүнслэг болон материалыг хэрэгцээ шаардлагатай байгаа хүмүүсийн хэрэгцээн мэдрэг байж туслах.
Сайн мэдээг тунхаглагч (Ефес 4:11)	Есүс Христийн сайн мэдээг хувь хүн болон бүлэг хүмүүст ойлгомжтойгоор таниулах ер бусын чадвар.
Хоньчин ба багш (Ефес 4:11)	Бурханы Үгийг зааж, хэрэгжүүлэх замаар Түүний хонин сүргийг хариулах ер бусын чадвар.

5. Зөвт байдал

Бидний Есүс Христэд итгэх үед Бурхан бидэнд зөвт байдлыг өгдөг тухай бид өмнөх хэсэгт үзсэн. Үүнийг Зөвтгөл гэж нэрлэдэг. Үүний дараа шинэ итгэгч өөрийнхөө амьдралыг өөрчилж, зөв болон буруугийн талаарх Бурханы жишигт бүрэн түшиглэх хэрэгтэй болдог. Итгэгч хүний амьдрал дахь зөвт байдал нь Бурханы тогтоосон жишигүүдийг дагах явдал дээр суурилагддаг байна.

Зөвт байдлын хамгийн чухал хоёр жишиг бол бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчээрээ Бурханыг хайрлахын сацуу, хөршөө өөр шигээ хайрлах явдал юм (Марк 12:29-31). Зөвт байдал гэдэг нь зөвхөн нүгэл үйлдэхгүй байгаад зогсохгүй, мөн оюун санаа болон хандлагаа Бурханы үгийн дагуу өөрчлөх явдал юм (Филиппой 2:5-8). Жишээ нь, “*та нарын Эцэг оршионгүй. Түүнчлэн оршионгүй байгтуун*” гэсний дагуу бид бусад өршөөнгүй хандах ёстой. Тэр ч байтугай бид өөрсдийн дайсныг хүртэл хайрлах ёстой (Лук 6:36-40). Бид ядууст өгөөмрөөр тусалж, үүгээрээ зөвт байдлын үр жимсийг ургуулдаг байх хэрэгтэй (2 Коринт 9:8-10). Бурханы хүслийн дагуу үйлдэх нь мөн энэ зөвт байдлын нэг хэсэг юм (Еврей 11:32-33).

Итгэгч хүн зөвт байдлыг мөшгөх ёстой (1 Тимот 6:11; 2 Тимот 2:22-23). Зөвт байдлыг ойлгоход Бурханы уг нэг бүр маш чухал (2 Тимот 3:16-17). Тийм ч учраас шинэ итгэгчдийн хувьд үүнийг ойлгож, хүлээж авахад хэцүү байдаг (Еврей 5:12-14).

Бурханы жишгүүдийг (зөвт байдал) дуулгавартай дагана гэдэг нь хүмүүст сайхан сэтгэгдэл төрүүлэх зорилгоор Бурханы тушаалуудыг сахих явдал биш юм (Матай 6:1). Фарисайчууд өөрсдийгээ бусдад анзааруулахын тулд “зөвт байдал”-ыг харуулдаг байсан. Мен тэд өөрсдийн ёс заншлыг Судартай энэ тэнцүүд тооцон, түүнийгээ бас сахидаг байсан (Марк 7:1-8). Хүн Бурханы үгээс холдож, өөрийнхөө зөвт байдлын жишгүүдийг тогтоож эхлэхийг “лигализм” (бид өмнө энэ талаар ярилцсан) гэж нэрлэгдэг бөгөөд энэ нь Бурханы бидэнд хүсдэг зөвт байдал биш юм.

Зөвт байдал үгүй хүн нэг бүрийг Ариун Сүнс зэмлэдэг (Иохан 16:8-10). Зөвт байдал байхгүй учраас ариун Бурхантай харилцахад нь саад болж байгааг Ариун Сүнс итгэгч бус хүмүүст илчлэн харуулдаг. Тэд Есүс Христэд итгэх итгэлээр аврагдаж (Ефес 2:8-9), улмаар зөвт хэмээн тооцогдсоноор Бурхантай нехөрлөх боломжтой болдог. Амьдралд нь буй нүглийн улмаас Ариун Сүнс итгэгч хүнийг зэмлэж, Бурхантай тогтоосон харилцаагаа сэргээхийн тулд тэрхүү гэм нүглээ улайх хэрэгтэй гэдгийг зааж өгдөг (1 Иохан 1:6-10). Итгэгчдийн эрж хайх ёстой зөвт байдал нь Ариун Сүнсээр өгөгдсөн зөвт байдал бөгөөд энэ нь Бурханы хаанчлал доторх амьдралын чухал хэсэг юм (Ром 14:16-17). Энэхүү зөвт байдал нь Бурханы жишгүүдийг сахин төгс амьдарсан Есүс Христийн гэрлийн үр жимс юм (Ефес 5:6-10).

Хэрэв бид зөвт байдлын төлөө өлсөж цангах аваас Бурхан биднийг ерөөх болно гэж Есүс хэлсэн (Матай 5:6). Зөвт байдал нь бидний сүнсийг үхлээс амилуулсан Нэгэнийг алдаршуулдаг учраас бид үүнийг хүсэн тэмүүлэх ёстой юм (Ром 6:12-13). Итгэгч бус хүмүүс Христийг өөрсдийн Аврагчаар хүлээн авах хүртлээ сүнсний хувьд үхмэл байдаг (Ром 6:23). Бид тэдний адил бүгд нүглийн боол байсан бол одоо зөвт байдлын боол болсон (Ром 6:16-19).

Сатан болон түүний хүчинүүд итгэгчдийг хууран мэхэлж, төөрөлдүүлэхийн тулд зөвт байдлын үйлчлэгчидтэй адил болон зүсээ хувиргадаг (2 Коринт 11:13-15). Тэдний хэрэглэдэг нэг арга нь бол жинхэнээр зөвт амьдардаг хүмүүсийг хавчих явдал юм (Матай 5:10; 1 Петр 3:14). Жинхэнэ зөвт амьдрааар амьдрах нь үнэхээр хүнд тэмцэл боловч ингэж амьдарсан хүн шагналын титмийг мөнхөд авах болно (2 Тимот 4:6-8). Энэхүү тэмцлийн явцад Эзэн биднийг сургаж, бидний зүр сэтгэлд жинхэнэ амар тайвныг өгөх болтугай (Еврей 12:11).

6. Залбирал

Залбирал бол Бурхантай харилцах харилцаа юм. Залбирахгүй атлаа зүгээр л залбирлын талаар судлах, мэдэх, бодох нь ямар ч утгагүй, ямар ч үнэ цэнэгүй юм. Бурханд хандан ярьж, Түүнээс хариугаа хүлээхэд залбирын утга учир оршдог. Залбирал нь бидэнд олгогдсон онцгой эрх юм. Яагаад гэвэл үүгээр дамжуулан бид Бурханы хаан ширээнд ойртон очдог (Еврей 4:16).

Амьдралдаа Бурханы хүслийг эрж хайдаг хүмүүсийн онцлог шинж бол тууштай залбирал юм. Анхны чуулганд энэ нь тод харагдаж байсан (Үйлс 2:42). Хэрхэн залбирахыг зааж сургах хэрэгцээ шавь нарт нь байгааг Есүс хараад (Лук 11:1), тэдэнд “Эзэний залбирал”-ыг зааж өгсөн (Лук 11:2-4). Залбирал нь Бурханаар өөрийнхөө хүслийг гүйцэлдүүлэхийг хичээсэн, гоё сайхан үгсийн цуглуулга биш, харин Түүний хүсэлтэй нэгдэх цаг юм (1 Иохан 5:14). Залбирал бол тэнгэр элч нарын зөрчилдөөн дэх таны хамгийн чухал хэрэгсэл юм (Ефес 6:18).

Бурханы үгэнд залбирын тухай хэлэхдээ, Ариун Сүнсний хүч чадлаар (Ефес 6:18) Эцэгт хандан (Ефес 5:20; Матай 6:9; 1 Петр 1:17) залбираад, Хүүгийн нэр дээр төгсгөх ёстой гэсэн байдаг (Иохан 14:13; 15:16).

Залбирын үндсэн таван элемент байдаг. Эхнийх нь нүглээ улайх (Дуулал 66:18-20; Исаиа 59:2; Матай 6:14; 1 Иохан 1:9). Бурхантай нехөрлөх харилцаанд маань саад болж байгаа ямар нэгэн зүйл байгаа бол энэ элемент түүнийг тодорхойлж өгдөг. Хоёр дахь элемент бол магтаал юм (Матай 21:16; Лук 19:37; Ром 14:11; 15:11; Ефес 1:6, 12, 14; Еврей 13:15). Магтаал нь Бурханы мөн чанарыг ойлгож, түүнд талархал өргөж буй явдал юм. Гурав дахь элемент нь талархал буюу Бурханы хийсэн зүйлд талархал өргөх явдал (Ефес 5:20; 1 Тесалоник 5:18). Дөрөв дэх элемент нь

зуучлан залбирал буюу бусдын төлөө залбирах (Ефес 6:18; Еврей 7:25). Тав дахь нь шалан гүйх буюу өөрийнхөө төлөө залбирах (Еврей 4:16).

Та ямар ч үед илүү дутуу залбиралгүйгээр өөрийнхөө нүглийг улайх боломжтой. Мөн та хүссэн үедээ Түүнд талархал магтаалыг өргөж, өөрийнхөө юмуу бусдын төлөө гүйлт хүсэлтээ мэдүүлж болно.

7. Өсөлт

Бид энэ дэлхийд нярай хүүхэд болон төрсөн шигээ Есүс Христэд итгэхдээ “дахин төрсөн” (Иохан 3:1-16) бөгөөд балчир хүүхэд өсөж томорсоор насанд хүрдэг шиг бид христэч амьдрал дотроо өсөж төлөвших ёстой. Биднийг төлөвшил уруу дууддаг, тэгэхдээ тэнгэрлэг Эцэг шигээ төгс бай хэмээн тушаасан (Матай 5:48). Тиймээс бид энэ дэлхий дээр байх хугацаандаа ийм байдалд хэзээ ч хүрч чадахгүй (Филиппой 3:12-15) боловч түүн рүү тэмүүлэх ёстой юм.

Бидний өсөлт дэх хамгийн гол асуудал бол бид өөрсдийгөө Бурханы өмнө “амьд, ариун тахил” болгон өргөхөд, өөрөөр хэлбэл, Түүнд үйлчлэхэд амьдралаа зориулахад бэлэн байна уу, үгүй юу гэдэгт оршдог (Ром 12:1-2). Биднийг “насанд хүрэх”-д туслахын тулд Эцэг маань бидний амьдралд янз бүрийн сорилтыг зөвшөөрдөг (Иаков 1:2-4). Энэ нь Түүнд итгэх бидний итгэлийн шалгуур юм. Түүнчлэн Бурхан бидний өсөж төлөвших үйл явцад туслахын тулд чуулганд олон янзын сүнслэг бэлгүүдийг өгсөн (Ефес 4:11-14).

Төлөвшлийг “*хүүхэд насныхаа занг орхих*” гэж энгийнээр дүрсэлсэн байдаг (1 Коринт 13:11). Төлөвшен хүний үйлдэл (Матай 19:21), үг яриа (Иаков 3:1-2) болон бодол санаа (1 Коринт 14:20) насанд хүрсэн байдаг. Эдгээр талбарт бид хэр тогтвортой байна вэ гэдэг дээр үндэслэн бид өөрсдийнхөө төлөвшилтийг үнэлж болно. Хүүхэд шиг аашлах (хувия хичээх), хөнөөлт үг яриа ярих (хов жив), нүгэлт бодол санаа тээх (бардам зан) маань ямар нэг хэмжээгээр багассан уу? Хэрэв багасаагүй бол бид төлөвшөөгүй байна гэсэн гэсэн үг юм.

Төлөвшлийг илэрхийлэх олон шинж чанарыг Сударт өгсөн байдаг. Амиа бодлогүй (Матай 19:21), даруу төлөв (Филиппой 3:12-15) зан чанар болон сайн мэдээг тунхаглах нь хүсэл (Колоссай 1:28) нь төлөвшен хүний шинж юм. Төлөвшен хүн сүнслэг эрх чөлөөгөө ухаалгаар ашиглан, өөрийн зорилгын төлөө биш (Иаков 1:25; Галат 5:1, 13), харин бусдын төлөө (Колоссай 4:12) зуучлан залбирдаг. Бурханы зөвт байдлын жишгүүдэд талархал талархалдаа хэрхэн өссенийг төлөвшил нь илтгэн харуулдаг (Еврей 5:12-14). Төлөвшен хүн нь аливаа сайн бүхэн Бурханы нигүүлслээс ирдэг гэдгийг ойлгон, түүнд (2 Коринт 12:9) найдаж сурдаг (Иаков 1:17). Бурхантай харилцах бидний хайрын харилцаа хэр өсөж байгаа дээр тулгуурлан бид өөрсдийн амьдралын төлөвшил ямар түвшинд байгааг харах боломжтой. Хэрэв Бурхантай харилцах бидний харилцаа амьдралаас маань элдэв айдсыг хөөн зайлцуулах хэмжээнд хүрсэн бол энэхүү харилцаа маань төлөвшилд ойрхон очсон байна гэсэн үг юм (1 Иохан 4:17-19).

8. Хайр

Хайр бол христэч амьдралын хамгийн чухал нэг хэсэг гэдгийг Есүс Христ хэлсэн. Маркийн Сайн мэдээнд Есүс Дэд хууль 6:4-5-аас иш татаж, агуу тушаалын тунхагласан байдаг. Тэрээр, “*Эхний нь ‘Сонс, Израиль аа! Бидний Бурхан Эзэн бол ганц Эзэн мөн. Чи Өөрийн Бурхан Эзэнийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчээрээ хайрлагтун*” гэсэн нь юм” (Марк 12:29-30) гэж хэлсэн. Дараа нь Есүс Левит 19:18-ын хэсгээс иш татаж, хоёр дахь агуу тушаалаа тунхагласан. Тэр, “*Чи хөршиөө өөр шигээ хайрла*” гэсэн нь хоёр дахь нь юм. Эдгээрээс илүү өөр агуу тушаал байхгүй” (Марк 12:31) гэсэн. Эхлээд Тэр биднийг хайрласан учир бид Түүнийг хайрлах ёстой (1 Иохан 4:19). Хэрэв бид үнэхээр Бурханыг хайрладаг бол ах дүүгээ мөн хайрлах болно (1 Иохан 4:20-21). Энэ хайр бол хүмүүсийн бие хайрладаг өрдийн хайр биш, харин Ариун Сүнснээс ирдэг хайр юм (Галат 5:22). Хэдийгээр энэ хайранд сэтгэл хөдлөл агуулагддаг боловч зөвхөн түүгээр өдөөгддөггүй аж.

Бурханы Үгэнд хайрыг тодорхойлооосоо илүүтэй дүрслэн өгүүлсэн байдаг. 1 Коринт 13-д хайрын тухай үнэхээр гайхамшигтай багцлал байдаг бөгөөд энэхүү багцлалын эхэнд хайр ямар чухал болохыг заадаг. Бидэнд ямар сүнслэг бэлэг байгаагаас юмуу бид ямар сайн үйлс хийснээс, эсвэл бид ямар тахил өргөснөөс үл хамааран, хэрэв энэ бүхэн хайраар үйлдэгдээгүй бол бид христэч амьдралын мөн чанарыг орхигдуулж буй хэрэг юм (1 Коринт 13:1-3). Паул элч хайрын арван зургаан шинж чанарыг гаргаж тавьсан байдаг (13:4-8). “Би тэвчээртэй юу?” гэх мэт энд жагсаасан бүх чанаруудыг өөрөөсөө асуух нь хүн өөрийнхөө христэч хайрыг шалгах сайн шалгуур болдог. Хэрэв хариулт нь “үгүй” байх юм бол түүний амьдралд хайр дулимаг байна гэсэн үг юм. Хайрын өөр олон чанар болон илрэлийг Ром 12:9-21 ишлэлд өгүүлсэн байдаг.

Бурханы биднээс хүсдэг хайрын дайсан бол “ертөнц” юм. Биднийг Бурханы хүслээс холдуулахын тулд Сатаны ашигладаг зүйлийг “ертөнц”-өөр илэрхийлэн харуулдаг. Хэрэв бид ертөнцийн санал болгодог зүйлсийг хайлравал Бурханыг бүрэн дүүрэн хайлаж чадахгүй (1 Иохан 2:15).

9. Зовлон

Зовлон гэдэг нь өвчин шаналтыг амсах гэсэн үг юм. Энэ нь бие махбодийн болон оюун санааны өвдөлт байж болно. Есүс Христ бидний гэмийн төлөөсийг загалмай дээр үүрэхдээ хүн төрөлхтний хамгийн аймшигт зовлонг эдэлснийг бид олж хардаг (1 Петр 2:21-24; 4:1; 5:1). Есүс энэ л зорилгын төлөө ирж (Лук 9:22; 22:15), шударга бус хүмүүсийн гарг зовлон эдэлсэн (1 Петр 2:21-24). Тиймээс, шударга бус зовлонтой хэрхэн нүүр тулахын үлгэр жишээг бид Түүнээс хардаг (1 Петр 2:21).

Христэч амьдралын төлөвшлийн талаарх ойлголттой бид өмнө нь танилцсан. Шударга бусаар зовох нь төлөвшийн явцдаа бидний туулах ёстой шалгуурын нэг хэсэг юм (1 Петр 5:10). Бурхан бидний гэрчлэл болон тэсвэр тэвчээрийн төлөө мөнхийн шагналыг өгөх болно (1 Петр 2:19-20; 2 Коринт 4:17). Амсах ёсгүй зовлонг эдлэх үедээ Түүнд найдах бидний итгэл найдвар дээр гэрчлэл маань тулгуурлах ёстой (1 Петр 4:19).

Христ бол үнэхээр бидний Эзэн гэдгийг ухаарч, шударга зөвийн төлөө зовох нь ерөөл юм (1 Петр 3:14-17; 4:14). Христийг дагаж байгаа хүмүүсийг үзэн яддаг эрх мэдэлтнүүдээс болж итгэгч хүн шударга бусаар зовох нь олонтаа байдаг. Христитгэгч хүн бүр ямар нэг хэмжээгээр туулах ёстой зүйлийн нэг энэ юм (Филиппой 1:27-30).

Есүс Христ загалмай дээр хэрхэн зовж шаналж байсныг нүдээрээ харсан элч Петр (1 Петр 5:1) Түүний зовлонгуудыг хуваалцаж байгаадаа баярлах хэрэгтэй гэж хэлсэн (1 Петр 4:13-16). Энэ ертөнц Есүс Христийг үзэн яддаг учраас Түүний дагалдагчдыг ч мөн үзэх ядах болно гэдгийг Петр ийнхүү хэлжээ (Иохан 15:18-20; 1 Петр 4:12). Бидний зовлон биш, харин зөвхөн Христийн зовлон л бидний нүглийн үнийг төлсөн. Харин Есүсийн зовлонг хуваалцсанаараа бид, бидний төлөө Түүний эдэлсэн өвчин шаналтыг мэддэг. Ийм зовлон амсаж байгаадаа бид ичих ёсгүй (1 Петр 4:16) агаад бусад христитгэгчид ч мөн ийнхүү зовж шаналж байгаа гэдгийг ухаарч (1 Петр 5:9), өөрсдийгөө Бурханы хаанчлалд орох зохистой нэгэн гэдгээ харуулах (2 Тесалоник 1:5) хэрэгтэй. Бид ийм зовлонгоос айх ёсгүй юм (Илчлэлт 2:10).

Хэрэв бид үйлдсэн нүглийнхээ улмаас зовж байгаа бол энэ нь зүйн хэрэг агаад христэч амьдралд хүсээд байхаар зүйл биш гэдгийг Петр бидэнд сэрэмжлүүлж байна (1 Петр 4:15). Ямар ч нүгэл их зовлонг дагуулдаг (Лук 13:1-5).

10. Сахилгажуулалт

“Сахилгажуулалт” гэдэг үг нь (грек хэлний ΠΑΙΔΕΟ) аливаа хүний зан байдлыг өөрчилж, хүссэн хэмжээндээ хүртэл сургах явцад түүнд мэдрэгддэг өвдөлт гэсэн утгыг илэрхийлдэг. Жишээ нь, Лук 23:16-22 ишлэлд нэгэн хоригдлыг (тэр “хоригдол” нь Эзэн Есүс байсан бөгөөд Пилат Түүнийг “цээрлүүлээд” \сахилгажуулаад\, дараа нь суллахыг хүссэн) өөрчлөхийн тулд түүнийг шавхуурдаж байгааг дүрслэхдээ энэ үгийг ашигласан байдаг. Түүнчлэн энэ үгэнд боловсрол олгох, хүмүүжүүлэх гэсэн санаа бас агуулагддаг (Уйлс 7:22; 22:3). Эзэн Чуулганы эрин үсийн итгэгчдийг

бусдыг сургах байр сууринд тавихдаа энэ үүргийг хайраар гүйцэтгэхийг анхааруулсан (2 Тимот 2:24-26).

Сахилгажуулалт нь өвдөлтийг мэдэрдгээрээ зовлонтой адилхан. Зовлон нь амсах ёстой болон ёсгүй өвдөлтийг агуулдаг бол сахилгажуулалт нь сургах зорилготой өвдөлт байдаг. Бидний сургалт нь зан чанарыг босгон байгуулах зорилго бүхий, бидний амсах ёсгүй зовлон юмуу, эсвэл биднийг итгэлээсээ холдох үед (1 Тимот 1:18-20) бидний оюун бодол болон нүгэлт үйлдлийг өөрчлөх зорилготой, бидний амсах ёстой зовлонг аль алийг нь агуулах ёстой.

Бурханы сахилгажуулалт нь хүүгээ сургаж буй эцгийнхтэй адил зан чанарыг нь төлөвшүүлэн засах зорилготой байдаг (Ефес 6:4; Еврей 12:7). Түүнчлэн энэ нь зөв шударга үйлсийг байнгын зүйл болгоход чиглэгддэг бөгөөд энэ зорилгыг гүйцэлдүүлэхэд Бурханы үг үнэлж баршгүй ач тустай (2 Тимот 3:16-17). Сахилгажуулалтыг амсаж байх үед бидэнд мэдээж баяртай сайхан байдаггүй, харин түүний үр дүнд бидэнд үнэхээр үнэ цэнэтэй, чухал байдаг (Еврей 12:11). Бидний нүглийн төлөө төлөгдсөн үнийн улмаас бид энэ сургалт, сахилгажуулалтын ач холбогдлыг ойлгох учиртай юм (Тит 2:11-12).

Махан биеийн эцгүүд маань магадгүй уур хилэнгийнхээ улмаас биднийг сахилгажуулдаг бол тэнгэрлэг Эцэг маань хайрынхаа улмаас биднийг сахилгажуулдаг (Илчлэлт 3:19). Хэрэв Бурхан биднийг сургаж байгаа бол энэ нь Түүний хайраас гарч байгаа учраас бид үүнд сэтгэлээр унаж, урам хугарах ёсгүй юм (Еврей 12:5). Биднийг энэ ертөнцтэй бүү нийцээсэй гэсэндээ Бурхан биднийг сахилгажуулдаг (1 Коринт 11:31-32). Тиймээс итгэгч бид Эзэний сахилгажуулалтыг баяртайгаар хүлээн авах ёстой юм (Еврей 12:8).

11. Библи судлал

Бурхан үгийг судлахын ач холбогдлыг хэт онцолж болохгүй. Энэ бол Бурхан биднийг Өөртэйгөө харилцаатай байлгахын тулд өгсөн гарын авлага юм (1 Коринт 2:16). Энэхүү судлал нь бүхэлдээ Бурханы үгийн ач холбогдол дээр үндэслэгдсэн бөгөөд тиймээс бид хэт нарийвчлан тайлбарлахгүй. Түүнийг өдөр бүр судлах хэрэгтэй юм.

12. Мөргөл

Мөргөл нь Есүс Христийг алдаршуулж, Түүнд магтаалыг өргөх ёстой. Есүсийн мөн чанар болон Түүний хийсэн зүйлийн төлөө бид магтаалыг өргөдөг. Магтаал хүндлэлийг авах зохистой цорын ганц Нэгэн бол Есүс (Илчлэлт 5:1-7) бөгөөд тэнгэр нь Эзэнд өргөсөн мөргөлөөрөө танигдах болно (Илчлэлт 4:9-11).

Итгэдэггүй хүмүүс Бүтээгчээс илүү бүтээлд нь мөргөн, зарагдах хандлагатай байдаг (Ром 1:25). Сатан биднийг өөртөө мөргүүлэхийг хүсдэг (Лук 4:7), харин бид зөвхөн Бурханд л ёстой (Лук 4:8). Зарим хүмүүс Бурханы өөр нэг бүтээл болох тэнгэр элч нарт мөргөдөг (Колоссай 2:18). Бүтээлд мөргөх хүслээсээ болоод хүмүүс Бурханы үгээс ангид өөрсдийн гаргасан тушаал зааварт мөргөх болсон (Марк 7:7). Түүнчлэн тэд магтаалыг авах зохистой Нэгэнд биш, харин мөргөлийн газарт нь мөргөдөг болжээ (Иохан 4:20-22).

Жинхэнэ мөргөл нь бидний амьдралд ажиллаж буй Ариун Сүнснээс ирдэг бөгөөд биднийг Есүс Христийг магтах боломжтой байлгахын тулд Түүний үнэ цэнийг илчилдэг (Иохан 4:23-24; Филиппой 3:2-3). Есүсийн үгийг итгэлээр хүлээн авч, үйлчлэлийн төлөө Түүнд өөрсдийн биеийг өргөснөөр бид Түүнд алдрыг өргөдөг (Еврей 11:21).

Мөргөлийн олон хэв маяг байдаг ч, чухам ямар байрлалаар юмуу үйлдлээр мөргөх ёстой талаар тодорхой заавар тушаал Сударт байдаггүй. Тухайн хүний сүнслэг байдал болон төлөвшилтийг мөргөлийнх нь хэв маягаар шүүхийг легализм буюу хуулийг хэт баримтлах явдал гэж үздэг.

13. Дагалдагч бэлтгэх

Есүс шавь нартаа хандан Агуу Захирамждаа “*Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун*” хэмээн тушаасан (Матай 28:18). Дагалдагч гэдэг нь Эзэн Есүс Христийг дагахаар шийдэн, Бурханы үгийг судалж буй нэгэн юм. Дагалдагч гэж зөвхөн авралыг хүлээн аваад зогсохгүй, бас Бурханы үгийн дагуу амьдрахын тулд түүнээс суралцаж буй хүмүүсийг хэлдэг (Иохан 7:17).

Хувийн Судлал: 8-р бүлэг, 1-р хэсэг

1. Христэч амьдралын үе шатуудын тухай:

- A. Үйлс 16:30-31 ишлэлийг унш. Есүс Христэд итгэх нь христэч амьдралын ямар үе шат вэ?
- B. 2 Коринт 3:18-ыг унш. Итгэгч хүн Христийн дүр төрх уруу өөрчлөгдөх нь хувь хүний христэч амьдралын ямар үе шат вэ?
- B. 1 Иохан 3:2-ыг унш. Бид Христийг байгаагаар нь харах үед хувь хүний христэч амьдралын ямар үе шат вэ?

2. Еврей 11:6-г унш. Бурханд таалагдахын тулд итгэгч хүнд юу байх ёстой вэ?

3. 1 Коринт 2:14-15 ишлэлийг унш. Сүнслэг зүйлсийг ойлгоход юу шаардлагатай вэ?

- A. Иохан 14:17-г унш. Ариун Сүнс хаана оршдог вэ?
- B. Галат 3:2-3 ишлэлийг унш. Сүнсний амьдралын амин чухал зүйл нь юу вэ?
- B. Ефес 4:30, 1 Тесалоник 5:19-ийг унш. Итгэгч хүний амьдрал дахь гэм нүглээс болж ямар хоёр зүйл тохиолдож болох вэ?

4. 1 Иохан 1:5-10 ишлэлийг унш. Итгэгч хүн нүгэл үйлдэх боломжтой юу? Хэрэв үйлдсэн бол тэр юу хийх ёстой вэ?

5. 1 Петр 4:10-ыг унш. Итгэгч хүн бүр юуг хүлээн авдаг вэ?

- A. 1 Коринт 13:1-3 ишлэлийг унш. Сүнслэг бэлгүүдээ хэрэглэхдээ юуг харуулах ёстой вэ?
- B. 1 Коринт 13:8-11 ишлэлийг унш. Зарим бэлгүүдэд юу тохиолдоно гэж энд хэлсэн байна вэ?
- B. Иохан 13:34-35, 1 Петр 4:10-ыг унш. “Бие биенээ хайрлах”-ын гол зорилгыг бидэнд сүнслэг бэлгүүдийг өгсөн учир шалтгаантай харьцуул.

6. Ром 6:16-19 ишлэлийг унш. Бид юуны боолууд болох ёстой вэ?

7. Залбирлын таван гол элементийн тухай:

- A. 1 Иохан 1:9-ийг унш. Энд ямар элементийг өгсөн байна вэ?
- B. Ром 14:11, 15:11-ийг унш. Эдгээр багцлалд ямар элементийн тухай өгүүлсэн байна вэ?
- B. 1 Тесалоник 5:18-ыг унш. Энд ямар элементийг өгсөн байна вэ?
- G. Ефес 6:18-ыг унш. Энд ямар элементийг өгсөн байна вэ?
- D. Еврей 4:16-г унш. Энд ямар элементийг өгсөн байна вэ?

8. 1 Петр 2:2, 2 Петр 3:18-ыг унш. Христитгэгч хүн авралыг хүлээн авсныхаа дараа юу хийх ёстой вэ?

9. Марк 12:29-31 ишлэлийг унш. Бурханы хамгийн чухал хоёр тушаал юу вэ?

10. 1 Петр 2:19-20, 1 Петр 5:10-ыг унш. Итгэгч хүн юуг тэвчих ёстой вэ?

11. Еврей 12:6-7 ишлэлийг унш. Бурхан биднийг хэрхэн сургадаг вэ?

12. 2 Тимот 3:16-17 ишлэлийг унш. Бурханы үгийн судлах нь үр ашигтай юу?

13. Иохан 4:23-24, Филиппой 3:2-3 ишлэлүүдийг унш. Бид Бурханд хэрхэн мөргөх ёстой вэ?

14. Матай 28:18-20 ишлэлийг унш. Христийн шавь нар юу хийх ёстой вэ?

2-р хэсэг

Христитгэгчийн Нэгдмэл Амьдрал (Чуулганы Амьдрал Буюу Экклесиологи)

A. Заах сургах

Есүс Агуу Захирамжийг өгөхдөө “*Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелийн эхийг тэдэнд заа*” хэмээн тушаасан байдаг (Матай 28:20). Есүс багш байсан (Матай 4:23; 5:2; 7:29; 9:35; 11:1; 13:54; 21:23; 22:16; 26:55; 28:15; Ўйлс 1:1). Есүсийн дагалдагч нар Түүний тушаасан зүйлийг хийхийн сацуу бусдад зааж сургаж эхэлсэн (Ўйлс 4:2, 18; 5:21, 25, 28, 42; 11:26; 15:1, 35; 18:11, 25; 20:20; 21:21, 28).

Тунхаглал нь уриалгыг өгдөг бол сургаал нь заавар тушаалыг өгдөг (Колоссай 1:28; 3:16). Эдгээр нь хоёулаа чуулганд чухал юм.

Бусдад заах чадвартай хүмүүсийг бий болгохын тулд хүмүүст зааж сурга гэж элч Паул Тимотод тушаасан (1 Тимот 4:11; 6:2; 2 Тимот 2:2). Ийм замаар Бурханы уг үеэс үед дамжих юм.

Хэдийгээр заах бэлэг авьяас тодорхой хүмүүст өгөгддөг ч (Ром 12:7) итгэгч хүмүүс бүгдээрээ бусдыг зааж сургахад дуудагдсан юм (Еврей 5:12-14).

B. Нөхөрлөл

Нөхөрлөл нь анхны чуулганы нэг чухал хэсэг байсан (Ўйлс 2:42). Нөхөрлөл гэж хэн нэгэнтэй материалыг зүйлсээ (Ром 15:26; 2 Коринт 8:4; 9:13; Еврей 13:16) төдийгүй сүнслэг зүйлсээ (1 Иохан 1:3, 7) ч бас хуваалцахыг хэлдэг аж. Энэ бүлгийн 1-р хэсэгт өгүүлсэн хамтын мөргөл нь нөхөрлөлд багтдаг. Бусадтай хамтдаа Эзэнд мөргөх нь хувь хүний мөргөлийн өсөлтийг батлан харуулдаг.

Бусад итгэгчидтэй нөхөрлөх сүнслэг нөхөрлөл нь (2 Коринт 6:14) Есүс Христтэй нөхөрлөх бидний нөхөрлөл дээр суурилж (1 Иохан 1:7), Ариун Сүнктэй нөхөрлөх нөхөрлөлөөр (2 Коринт 13:14) ирдэг. Энэ нь итгэл дээр суурилагдаж (Филимон 1:6), Христийн бие дотор нэгдмэл байдлыг авчирдаг (Филиппой 2:1-2). Бид энэхүү нөхөрлөлд дуудагдсан (1 Коринт 1:9) бөгөөд харанхуй дотор алхаж буйхүнд энэ нөхөрлөл нь боломжгүй юм (1 Иохан 1:6).

Бидний нөхөрлөлийн үндэс суурь нь Есүсийн бодгаль болон ажлыг бидэнд сануулдаг Эзэний зоог буюу Эзэний ширээ юм (1 Коринт 10:16). Энэхүү нөхөрлөл нь Есүсийн зовлонг бидэнд сануулдаг (Филиппой 3:10).

Итгэгч бид Сайн мэдээг тараах үйлсэд хамтран үйлчилж (Филиппой 1:5) байхдаа, мөн тулгарсан зөрчилдөөнийг шийдвэрлэснийхээ дараа (Галат 2:9) хамтдаа нөхөрлөдөг. Нөхөрлөл бол христитгэгчид хоорондоо хайран дээр үндэслэн ойртож дотносож хэрэгсэл юм.

Христэч амьдралд хайр ямар чухал болохыг бид өмнө нь үзсэн билээ. Бид Бурханыг болон бусдыг хайрлах ёстой. Хөршөө хайрлана гэж чухам юу болох талаар Шинэ гэрээ маш олон зүйлийг дагалдагчдад өгүүлсэн байдаг. Хөршөө хайрлах хайр нь Бурханыг хайрлах хайраас ундран гардаг (1 Иохан 4:20). Хөршөө өөр шигээ хайрла гэсэн тушаалыг “Хаан хууль” гэж нэрлэдэг (Иаков 2:8). Үнэндээ, итгэгч бид өөрсдийн дайснуудыг хүртэл хайрлах ёстой учраас хөршөө хайрлах нь биднээс шаардагдах наад захын зүйл юм (Лук 6:35). Бид хүмүүсийг өөрсдөдөө хэрхэн хандаасай гэж хүсдэг, түүн шигээ бусдад хандах ёстой (Матай 7:12).

Дараах зарчмууд нь бидний бие биетэйгээ харилцаа илэрхийлдэг. Тэдгээр нь гэрлэлтийн харилцаанаас эхлээд, улмаар бидний гэр бүл, чуулганы гэр бүл буюу Бурханы гэр бүл, тэр ч байтугай авралыг хүлээн аваагүй хүнд хүртэл хамаатай байдаг. Харилцааг босгон байгуулах олон зарчим Шинэ гэрээнд байдаг. Төлөвшөөгүй итгэгч хүн эдгээр зарчмыг бусад хүн дагахгүй байсан ч гэсэн өөрөө дагах үүрэгтэй гэж бодохын оронд бусад хүмүүс тэдгээрийг ашиглахыг харж хүлээдэг. Харин

төлөвшсөн итгэгч хүн эдгээр зарчмыг зөв гэж үздэг учраас дагадаг бөгөөд хэзээ ч өөрийнхөө ашиг сонирхлын төлөө ашиглах гэж оролдогтгүй.

Одоо бүгдээрээ “бие биетэйгээ” харилцах зарчмуудыг авч үзэцгээс:

- Нэг нэгнээ **хайрлах** тухай тушаал Шинэ гэрээний олон ишлэлд байдаг (Иохан 13:34, 35; 15:12, 17; Ром 13:8; 1 Тесалоник 3:12; 4:9; 2 Тесалоник 1:3; 1 Петр 1:22; 1 Иохан 3:11, 23; 4:7, 11, 12; 2 Иохан 1:5). Энэ нь бид 1 Коринт 13:4-8, Ром 12:9-21 ишлэлд өгөгдсөн зарчмуудын дагуу амьдрах ёстой гэсэн үг юм.
- Бид бол нэг нэгэндээ **эрхтийүүд** юм. Өөрөөр хэлбэл, бид Христийн биеийн нэг хэсэг учраас хэдийнээ хоорондоо харилцаа холбоотой болсон (Ром 12:5; Ефес 4:25)
- Бид нэг нэгэндээ **зориулагдсан** байх ёстой (Ром 12:10). Өөрөөр хэлбэл, бид бусдын сайн сайхны төлөө санаа тавьж, бие биедээ энэрэнгүй зөвлөн хандах учиртай юм.
- Бид нэг нэгнээ **хүндлэх ёстой**. Өөрөөр хэлбэл, бусад маань Бурханы өмнө ямар үнэ цэнэтэйг ойлгох ёстой юм (Ром 12:10).
- Бид өөр хоорондоо **нэг санаатай байх** ёстой. Өөрөөр хэлбэл, бусад маань бидний адил Бурханы нигүүслийг хүлээн авсан гэдгийг ухаарах ёстой (Ром 12:16; 15:5).
- Христ биднийг Өөрийнх нь нигүүсэл хэрэгтэй бүтээл хэмээн хүлээн авсны адил бид нэг нэгнээ байгаагаар нь **хүлээн авах** ёстой (Ром 15:7).
- Сүнслэг аюул ойрхон байгааг харах үедээ бид нэг нэгнээ **сэрэмжлүүлэх** ёстой (Ром 15:14).
- Бид “ариун үнсэлт”-ээр нэг нэгэнтэйгээ **мэндчилэх** ёстой (Ром 16:16; 1 Коринт 16:20; 2 Коринт 13:12; 1 Петр 5:14). Энэ нь бие биенээ Бурханы өмнө үнэ цэнэтэй хэмээн хүндэлж буй хэрэг юм.
- Бид нэг нэгэндээ **үйлчлэх** ёстой. Үүнийг нэг нэгнийхээ хөлийг угаах явдлаар дурслэн харуулдаг (Иохан 13:14; Галат 5:13).
- Бид **бие биеөөсөө дээр гэж үзх ёстой** (Филиппой 2:3).
- Бид нэг нэгнийхээ **ачаанаас үүрэлцэх** ёстой (Галат 6:2). Өөрөөр хэлбэл, бид тэдэнд амьдралдаа байгаа гэм нүглийн асуудлыг шийдэхэд нь туслах хэрэгтэй юм.
- Бид нэг нэгнийгээ **хүлцэн тэвчих** ёстой. Өөрөөр хэлбэл, бид бие биедээ тэвчээртэй хандах ёстой юм (Ефес 4:2; Колоссай 3:13).
- Бид нэг нэгэндээ **захирагдах**, буюу юуны түрүүнд бусдын хэрэгцээг ойлгох ёстой (Ефес 5:21).
- Бид нэг нэгнийгээ **зоригжуулах** ёстой. Сүнсний хувьд унасан нэгэндээ туслах нь үүнд багтана (Ром 1:12; 1 Тесалоник 4:18; 5:11; Еврей 3:13; 10:25).
- Бид нэг нэгэнтэйгээ **эвтэй байх** ёстой юм (Марк 9:50). Өөрөөр хэлбэл, бид бодол санаа, ааш авиаараа бусдад төвөг учруулахгүй байх ёстой гэсэн үг.
- Бид нэг нэгнийхээ өмнө **нүглээ хүлээн зөвшөөрөх** ёстой (Иаков 5:16). Хэн нэгэнд буруу зүйл хийсэн бол түүнээс учлалт гүйх хэрэгтэй. Хэн нэгэнтэй эвдэрсэн харилцаагаа сэргээхийн тулд ийнхүү нүглээ хүлээн зөвшөөрч, гэмшиг нь чухал юм.
- Бид нэг нэгнийхээ төлөө **залбирах** ёстой (Иаков 5:16).
- Эзэн биднийг уучилсны адил бид нэг нэгнээ **уучлах** ёстой (Колоссай 3:13).
- Бид нэг нэгэндээ **сайныг хүсэх** ёстой. Өөрөөр хэлбэл, хүн бүр Бурхантай ойр дотно харилцаатай байгаасай гэж бид хүсэх ёстой (1 Тесалоник 5:15).
- Бид **нэг нэгнийгээ хайр болон сайн үйлсэд хөхүүлэн урамшуулах** ёстой (Еврей 10:24). Бусдад хэрхэн тусалж, хийж буй зүйлийг нь хөхүүлэн дэмжиж болох талаар тунгаан бodoх нь үүнд багтана.
- Бид нэг нэгнээ **хүсэн хүлээх** ёстой (1 Коринт 11:33). Өөрөөр хэлбэл, бид бусад итгэгчидтэй хамтдаа баярлан баясах ёстой гэсэн үг юм.
- Бид нэг нэгэндээ **уян зөвлөн сэтгэлээр хандах** ёстой. Хорсол, уур хилэн болон бусдыг хохироох хүслээ үгүй хийх ёстой (Ефес 4:31-32).

- Бид нэг нэгнээ **халамжлах** ёстай (1 Коринт 12:25). Өөрөөр хэлбэл, бид Христийн биеийн бусад эрхтнүүдийн төлөө санаа тавих ёстай гэсэн үг юм.
- Бид нэг нэгнийхээ үйлчлэлийг **хүлээн зөвшөөрөх** ёстай (Лук 7:32). Бид хүнд хүлээн зөвшөөрөгдхөн зорилгоор үйлчлэх ёсгүй. Харин Бурханы гэр бүлийн дотор нэг нэгнийхээ үйлчлэлийг хундлэх ёстай.
- Бид нэг нэгэндээ **зочломтгой байх** ёстай юм (1 Петр 4:9). Өөрөөр хэлбэл, бид гаднын хүмүүсийг өөрийн чуулганд найрсгаар хүлээн авах ёстай.
- Бид нэг нэгэндээ **даруу байдлаар хандах** ёстай. Энэ нь бусдад хандах бидний хандлагыг харуулдаг (1 Петр 5:5).
- Бид нэг нэгэнтэйгээ **нохорлөх** ёстай (1 Иохан 1:7).
- Бид нэг нэгнийгээ **босгон байгуулах** ёстай (Ром 14:19; 1 Тесалоник 5:11). Бусдыгаа урамшуулан зоригжуулах, бусдадаа заавар зөвлөгөө өгөх нь үүнд багтдаг.

В. Сайн мэдээ тараах

Энэ нь Есүс Христийн тухай Сайн мэдээ тараах тухай юм. Өөрөөр хэлбэл, Есүс Христ бол энэ ертөнцийн нүглийн төлөөсийг төлөхийн тулд нас барж (1 Иохан 2:1-2), улмаар Өөрт нь итгэсэн хүнд мөнх амийг өгөхийн (Иохан 3:16) тулд дахин амилуулагдахаар (1 Коринт 15:1-3) энэ дэлхийд хүн болж (Иохан 1:14) ирсэн Бурхан мөн (Иохан 1:1) гэсэн сайн мэдээг тунхаглах нь Сайн мэдээг тарааж буй явдал юм. Бид бүгд нүгэлтэн гэдэг нь сайн мэдээ биш (Ром 3:23), харин бидний нүглийн өр (Ром 6:23) төлөгдсөн (Галат 3:13) гэдэг нь Сайн мэдээ юм.

Даяар болон нутгийн чуулган аль аль нь Сайн мэдээг бусдад хүргэх хүсэлтэй байх ёстай. Бидэнд өгөгдсөн гэрэл хийгээд үнэнийг бид нуух учиргүй юм (Матай 5:14; Ром 1:16).

Бурхан бидэнд Сайн мэдээ түгээх аргаа сонгох эрх чөлөөг өгсөн. Сайн мэдээг нэг хүнд хувьчлан хүргэхээс гадна (Үйлс 8) бүлэг хүмүүст хүргэж болно (Үйлс 2). Чуулган Бурханы Үгийг түгээхдээ Түүний хаанчлалд нэгдэх Түүний урилгыг танилцуулах нь чухал юм. Сайн мэдээг тунхаглахад нь зориулан хүмүүст өгсөн хамгийн үр нөлөөтэй хэрэгсэл бол нэг нэгнээ хайрлах хайр юм (Иохан 13:34-35).

Г. Үйлчлэл

Үйлчлэл гэдэг нь бусдад туслах зорилгоор тэдний сүнслэг болон бие махбодын, мөн сэтгэл санааны хэрэгцээг ойлгох явдал юм (Үйлс 11:29; 2 Коринт 8:3-5). Төөрөлдөн мөхөж байгаа энэ дэлхийг Бурхантай эвлэрүүлэх мэдээг түгээх нь Есүс Христийн элчин сайд нарын үүрэг юм (2 Коринт 5:18-21). Хэрэв хүн Бурхантай эвлэрч чадвал энэ дэлхийн хуулиудаас мөн чөлөөлөгдөж чадна. Тиймээс энэхүү үйлчлэл нь мөн эрх чөлөөний мэдээг түгээх үйлчлэл юм (1 Тимот 4:4-6). Бид итгэгч болохдоо эрх чөлөөтэй болж (Галат 5:1), түүнийгээ бусдад үйлчлэхийн тулд ашигладаг (Галат 5:13).

Үйлчлэгч хүн удирдагчаа хэрхэн даган дуурайдгийн (Иохан 12:24-26) үлгэр жишээг Есүс Христ Өөрийн биеэр харуулсан (Матай 20:28). Христэч үйлчлэл нь чуулган дахь хэн нэгний байр суурийг биш, харин сүнслэг агуу байдлын жинхэнэ тэмдгийг харуулдаг (Матай 20:26-28; 23:10-12). Бид итгэгч болохынхоо хувьд аврал дахь Бурханы бидэнд үзүүлсэн өршөөлийг ямагт санаж байх ёстай. Тэгснээр бид бардам болохгүй, зүрх алдахгүй байж чадна (2 Коринт 4:1-2). Бурхан биднийг бусдад хандсан хамгийн жижиг үйлчлэлийг ч хэзээ ч мартахгүй гэж амласан (Еврей 6:10-12).

Үйлчлэх боломжуудыг Эзэн өгдөг (Үйлс 20:24; 1 Коринт 12:4-6). Итгэгч хүмүүс нэг нэгэндээ үйлчлэх Бурханаар өгөгдсөн бэлэг авьяас болон нөөц баялгийг ашиглахын тулд эдгээр боломжийг хүлээн авах ёстай. Тэгэхлээр, үйлчлэл нь христэч амьдралын нэг чухал хэсэг (1 Петр 4:10-11) бөгөөд бид үүнд байнга оролцох хэрэгтэй юм (Ром 12:7). Тэгэхдээ бид энэхүү үйлчлэл болон Эзэн Есүс Христийн нэрийг гутаахгүй байхад анхаарах хэрэгтэй (2 Коринт 6:3).

Үйлчлэгчид хамтран ажиллаж сурах ёстой. Чуулганд илүү үр нөлөөтэй үйлчлэл хэрэгтэй байсан учраас үйлчлэгчдийг сонгох шаардлага гарч ирсэн. Элч нар дангаараа чуулганы бүх хэрэгцээг хангаж чадахгүй гэдгээ ойлгосон учраас бэлэвсэн эмэгтэйчүүдэд санаа тавих хүмүүсийг сонгохыг цуглаанд санал болгосон (Үйлс 6:1-6). Хамтран ажиллаж байгаа янз бүрийн үйлчлэгчид хүмүүсийн хэрэгцээг хангахад тустай байсан.

Эзэн хүмүүсийг чуулганы үйлчлэгч болоход нь туслах зорилгоор чуулганд удирдлагын үйлчлэлүүдийг бий болгосон. Элч Паул:

Тэр заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайн мэдээг тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгожээ. Эдгээр нь ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэжс, Христийн биеийг байгуулахын тулд юм. Бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл, төлөвшисөн хүн болтол, Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд хүртэл ингэх ажээ (Ефес 4:11-13) хэмээн бичсэн байdag.

Чуулганы удирдлагын үүрэг бол бусад хүмүүсийн төлөө үйлчлэхэд нь итгэгчдийг сүнс, бие махбод хийгээд сэтгэл зүйн тал дээр бэлтгэх, тэгснээр хүмүүс тэднээс Сайн мэдээг сонсож, улмаар Эзэн Есүстэй харилцах хувьчилсан харилцаагар дамжуулан төлөвшиг боломжтой болох явдал юм. Хайраас ундрان гарсан үйлчлэл нь Сайн мэдээг тунхаглах, чуулганд өгөгдсөн хамгийн хүчтэй арга хэрэгсэл юм (Иохан 13:1-35).

Д. Нэгдмэл байдал

Чуулганууд Христийн бие дотор нэгдмэл байхыг зорилго болгох ёстой (Ефес 4:13). Есүс Христ загалмайд цовдлогдохынхоо өмнөх шөнө дагалдагч нарынхаа нэгдмэл байдлын төлөө ийнхүү залбирсан байdag:

Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гүйж байна. Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт өртөнцийг итгүүлэхийн тулд билээ. Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Таны Надад огсон сүр жавхланг Би тэдэнд огсон билээ. Би тэдний дотор, Та Миний дотор байдал. Ингэснээр тэд тогс нэгдэн, Таны Намайг илгээснийг болон Намайг хайрласны адил тэднийг хайрласныг өртөнц мэдэх болно (Иохан 17:20-23)

Есүс Христэд итгэх мөчид Ариун Сүнс итгэгч хүн бүрийн дотор нутагладаг учраас нэгдмэл байдал нь энэхүү цорын ганц Сүнснээс анхлан ирдэг (Ефес 4:4) бөгөөд бидний бүгдийнх нь дотор энэ Сүнс нутагладаг (Ариун Сүнсний нутаглал гэсэн хэсгийг үз). Өөрсдийн дуудлагад зүй зохистой байснаар Ариун Сүнсний энэхүү нэгдмэл байдлыг хадгалах ёстой гэж элч Паул бидэнд заасан (Ефес 4:1-3). Өөрөөр хэлбэл, бидний алхам бүр нигүүлслээр дүүрэн агаад итгэл дээр суурилсан байх ёстой гэсэн юм (Ефес 8-9). Хэдийгээр Христ доторх бидний байр суурь нийтлэг нэг аврал дээр суурилагддаг боловч бид бүгдээрээ Христийн бие дотор хайран дээр үндэслэгдсэн нэгдмэл байдлыг эрэлхийлэх ёстой бөгөөд тэгснээр итгэдэггүй бүх хүн биднийг Есүс Христийн дагалдагч гэдгийг олж харах болно (Иохан 13:34-35).

Хувийн Судлал: 8-р бүлэг, 2-р хэсэг

- 1. 2 Тимот 2:2-ыг унш. Чуулганд юу чухал вэ?**
- 2. 1 Тимот 6:3-ыг унш. Эрүүл сургаалыг хэрхэн үнэлэх ёстой вэ?**
- 3. Еврей 5:12-ыг унш. Итгээд олон жил болсон хүн юу хийх чадвартай байх ёстой вэ?**

4. **1 Иохан 1:3, 7-г унш. Юуг чуулганы хувьд чухал гэж үзсэн бэ?**
5. **Дараах багцлалуудад нөхөрлөлийн ямар зарчмуудыг зааж байна вэ?**
 - А. Иохан 13:34-35
 - Б. Ром 12:10
 - В. Ром 15:7
 - Г. Галат 5:13
 - Д. Филиппой 2:3
 - Е. Галат 6:2
 - Ё. Еврей 3:13; 10:25
 - Ж. Колоссай 3:13
 - З. Ефес 4:31-32
 - И. 1 Петр 4:9
 - К. Ром 14:19
6. **Матай 5:14; Ром 1:16-г унш. Чуулган юу хийх ёстой вэ?**
7. **Галат 5:1; 5:13-ыг унш. Бид ямар шалтгааны улмаас чөлөөлөгдсөн бэ?**
8. **Ефес 4:13-ыг унш. Нутгийн чуулган бүр юунд зорих ёстой вэ?**
9. **Иохан 17:20-23 ишлэлийг унш. Есүс шавь нарынхаа төлөө юуг хүссэн бэ?**

Есдүгээр Бүлэг

Хэрэгжүүлэлт

Танилцуулга

Энэ хэсэг Библийн хичээл бэлдэх практик аргыг танилцуулах болно. Энэ арга нь олон багш нар Бурханы үгийг маш үр дүнтэй заахдаа ашигладаг зарчим дээр үндэслэсэн. Хэдийгээр хичээл бэлдэх арга нь өөр өөр байж болох ч 4-р бүлэгт үзсэн тайлбарлах үндсэн зарчмыг дагах хэрэгтэй.

Энэ хичээлийг бэлдэхдээ сургалтын дасгалжуулалтын чухлыг сайн ойлгох хэрэгтэй бөгөөд сургалтын дасгалжуулалт нь Ариун Сүнсний заах үйлчлэлийн байр суурийг эзлэх буюу булаан авах ёсгүй гэдгийг анхаараарай. Ариун Сүнс бодгаль өөрөө биднийг “*бүх үнэн рүү удирддаг*” (Иохан 16:13). Хүний зохион бүтээсэн ямар ч арга үүнийг орлож чадахгүй.

Бурханы Угийг бид хэр их мэдэж болохоос (Колоссай 2:6) үл шалтгаалан бид үргэлж итгэлээр алхах ёстай. Бидний христитгэлийн төлөвшилт махан биеийг хүслийг дагаснаар ирдэггүй, харин итгэлээр ирдэг (Галат 3:2-5). Сatan биднийг Ариун Сүнсэнд итгэхээс илүү өөрсдийнхөө арга болон мэдлэгэд найдуулах гэж үргэлж дайрч байдаг (Иохан 5:39-47). Хэдий тийм боловч ямар ч Христэд итгэгчдийн хайр байхгүй мэдлэг нь биеэ тоосон байдалд хүргэдэг бөгөөд энэ нь үл төлөвшилтийн нэг шинж юм (1 Коринт 8:1).

Христэд итгэгчид бид өөрсдийнхөө амьдралд юу ч хийсэн үргэлж залбирлаар эхлэх хэрэгтэй. Ингэхдээ эхлээд гэм нүглээ улайж (1 Коринт 11:31, Сургаалт үгс 28:13, 1 Иохан 1:9) дараа нь үргэлжлүүлэн залбирах хэрэгтэй. Бид ямар нэг хичээл үзэхээсээ өмнө илүү анхаарлаа төвлөрүүлж, ойлгож, сурсан зүйлээ мартахгүй байхын төлөө залбирах хэрэгтэй.

1-р ХЭСЭГ

Номтой Танилцах Нь

A. Танилцуулга

Бид ямар нэгэн номыг судлахаар сонгон аваад, эхлээд ямар нэгэн сонины нийтлэл юмуу, эсвэл өөр нэг ном уншиж байгаа мэт хэд хэдэн удаа давтан унших хэрэгтэй. Энэ алхам нь тухай номны үндсэн агуулгатай танилцуулахад зориулагдсан болохоос биш теологийн нарийн асуултад хариулахын тулд зориулагдаагүй.

Номыг хэд хэдэн удаа гүйлгэн унших нь гол сэдвүүд болон агуулгыг хэрхэн бичсэнийг олж хараад туслах болно. Бид тухайн хэсгийн хамгийн ойрын, мөн дундын болон шууд бус хам сэдвийг анхаарч тайлбарлахаа бодолцох хэрэгтэй. Номыг ишлэл ишлэлээр судлах нь хамгийн ойрын болон дундын хам сэдвийг ойлгох цорын ганц арга юм.

Мөн Библийн янз бурийн номнуудын түүх болон газарзүйг сайтар мэдэх хэрэгтэй. Бид 1 Тесалоник номыг үзнэ. Оюутнуудад туслахын тулд бид Тесалоник хотын тухай зарим мэдээлүүдийг багтаалаа. Энэ төрлийн мэдээллийг Библиз гадуурх эх сурвалжаас олж авах хэрэгтэй. Энэ мэдээллийн эх сурвалж нь Библийн толь бичиг, Библийн танилцуулга гэх мэт номнууд байж болно.

B. Тесалоникийн түүх болон газарзүй

Тесалоник хот нь орчин үеийн Грекийн Айгийн тэнгисийн баруун хойд хэсэгт орших Термайкийн тохойн усан боомт хот байсан. Энэ нь Македонийн Ромын дүүрэгт оршдог байсан бөгөөд халуун рашаан, том усан онгоцны зогсоол зэргээрээ алдартай байсан. Тухайн үеийн Македонийн хамгийн том, цэцэглэн хөгжсөн хот байсан.

Тесалоник хотыг Их Александр хааныг МЭӨ 323 онд нас барсны дөнгөж дараахан МЭӨ 315 онд Антипатрын хүү Кассандэр байгуулсан. Александр хааныг нас барсны дараа эрх мэдлийн төлөөх тэмцэл газар авсан. Антипатр нь хааны гэр бүлд үнэнч зүтгэсэн хэвээр үлдсэн бөгөөд хотыг өөрийнхөө хүү Кассандэрийн эхнэр, буюу Их Александрын эгч Тесалоникийн нэрээр нэрлэсэн.

Тесалоник нь ихэвчлэн Грек хүмүүс оршин суудаг худалдааны хот байсан боловч Иудейчүүд ихээхэн нөлөөтэй байсан. Өнөөдөр энэ Салоникийн Грек хот гэдэг нэртэй.

B. Сүмийн түүхэн нөхцөл байдал: Үйлс 17:1-9

Энд Паул Македонид ирж туслаач гэсэн үзэгдэл үзсэний дагуу сайн мэдээ тараах 2-р аяныхаа үеэр сүм байгуулсан (Үйлс 16:9). Паул Силас (Энэ нь түүний Еврей нэр ба Ром нэр нь Силуан байсан), Тимот, Лук нартай хамт явсан. Зүүнийг баруунтай холбодог Игнатын Замын дагуу тэд аялсан. Тэд нар Филип, Амфиполис, Аполлон зэрэг хотуудыг дайран гарч Тесалоникт хүрэлцэн ирсэн (Үйлс 17:1).

Паул гурван Амралтын өдөр синагогт сургаал заасан (Үйлс 17:2) ба Есүс Хуучин Гэрээний эш үзүүллэгүүдийг биелүүлсэн тул Мессия мөн гэж тунхагласан (Үйлс 17:3). Түүний тунхагласан үгээс болж олон хүмүүс Есүст итгэсэн (Үйлс 17:4).

Паул шинээр итгэсэн хүмүүст хичээл заасан. Хэр удаан заасан нь тодорхойгүй. Үүнд үл итгэгч Иудейчүүд хорсож, хэсэг бүлэг хүмүүс тэр сайн мэдээний багийн араас мөрдсөн (Үйлс 17:5). Тэд Паулыг барихын тулд Иасоны гэрт очсон боловч тэр тэнд байгаагүй (Үйлс 17:6). Тэд Иасоныг хотын эрх баригчдын өмнө чирч авчран Есүсийн тухай Паулын сургаалыг гүйвуулсан (Үйлс 17:7). Энэ эсэргүүцэл маш аюултай болж эхэлсэн тул Паул болон түүний нөхөд Берой руу зугтажаас өөр аргагүй болсон (Үйлс 17:8-10).

Г. Бичигдсэн цаг хугацаа болон шалтгаан

Паул Антиохт хичээл заасныхаа дараа МЭ 49 онд сайн мэдээний 2-р аяндаа гарсан. Тесалоникаас гарч явсныхаа дараа Паул Беройд хэсэг зуур сургаал заасан бөгөөд дараа нь Коринт руу явахаасаа өмнө

Афинд очоод 18 сар тэнд байсан (Үйлс 18:11). Паул шинээр байгуулагдсан чуулган ямар байгааг мэдэхээр Тимотыг буцаасан (1 Тесалоник 3:2). Тимот тэдний тухай сайн мэдээ авчирсан бөгөөд үүний үр дүнд энэ ном бий болсон. Энэ нь Тесалоник ном МЭ 50 оны үед бичигдсэнийг харуулж байна. Энэ бол Паулын бичсэн 2 дахь захидал байсан. (Эхнийх нь Галат ном байв).

Хувийн Судлал: 9-р бүлэг 1-р хэсэг

3-р бүлэгт 2-р Тесалоник номын тухай бичсэн мэдээллийг унши.

2-р хэсэг

Номыг Тоймлох Нь

Бид номыг илүү нарийн судлахад бэлэн болсон үедээ номыг тоймлох хэрэгтэй. Бид хамгийн эхлээд том дүр зургыг гаргаж ирснийхээ дараа тэрхүү том дүр зургийн жижиг хэсгүүдэд задлан шинжилгээ хийх хэрэгтэй. Мэдээж хэрэг тэрхүү зургийг хамгийн ойроос хэр удаан ажиглана төдий чинээ нарийн ширийн зүйлсийг ойлгож ухаарах болно. Бурханы үг бол үүнтэй маш их төстэй. Тэрхүү том дүр зураг бол Есүс Христ Өөрөө юм. Харин бичмэл хэлбэрээр байгаа Үг бол Амьд Үгийн илчлэлт юм (Иохан 5:39-47). Бид улам бүр ойроос харах тусам төдий чинээ Христийг сайн таньж мэдэх болно.

Бид том дүр зургийн хам сэдвийг орхигдуулж, нарийн ширийн зүйлд орооцолдох хэрэггүй. Ингэвэл бид “Шумуулыг шүүгээд тэмээг залгичихдаг сохор газарчид” (Матай 23:24) болно. Энэ нь хамгийн чухал зүйлсийг орхигдуулах гэсэн утгатай үг юм.

Номыг тоймлох бидний хамгийн эн тэргүүний ажил бол тухайн ном зүйл зүйлээр хэрхэн бичигдсэнийг мэдэх явдал юм. Библийн олон орчуулгууд номны эдгээр хэсгүүдийг ялгах өөр өөр арга хэрэглэдэг. Гэвч ихэвчлэн ихэнх орчуулгууд зүйлийн эхний ишлэлийн өмнөх дугаарыг тод хараар бичсэн байдаг. Аль нэг Библийн орчуулгын танилцуулгыг уншаад орчуулагчид зүйлийг хэрхэн тэмдэглэсэнийг олж мэдэх хэрэгтэй. Хэрэв тийм маягаар зүйлээр хуваагаагүй бол сэдэв аль хэсэгт өөрчлөгдж байгааг сайн ажиглаарай.

Жишээ нь: 1 Тесалоник номын зүйл нь дараах хэлбэрээр хуваагдсан байдаг.

1. 1:1
2. 1:2-10
3. 2:1-12
4. 2:13-16
5. 2:17-20
6. 3:1-10
7. 3:11-13
8. 4:1-8
9. 4:9-12
10. 4:13-18
11. 5:1-11
12. 5:12-22
13. 5:23-28

Дараа нь зүйл бүрт нэр өгөх хэрэгтэй. Бид номыг улам гүн гүнзгий судлах үед, агуулгаасаа шалтгаалан бидний хийсэн тойм өөрчлөгдж болно. Бид илүү их мэдээлэл багтаах хэрэгтэй ч аль болох энгийн байх нь чухал юм.

1. 1:1 Мэндчилгээ ба ерөөл
2. 1:2-10 Тэдний жишээнд талархсан нь
3. 2:1-12 Паулын байр суурь
4. 2:13-16 Тэдний хичээнгүй байдалд талархсан нь
5. 2:17-20 Тэдэнтэй уулзах гэсэн Паулын хүсэл
6. 3:1-10 Тэдний үйл явцын талаар мэдэх гэсэн Паулын хүсэл
7. 3:11-13 Тэд сүнсний өсөлтийн төлөөх Паулын найдвар
8. 4:1-8 Тэд ариусгалын төлөөх Паулын хүсэл
9. 4:9-12 Тэдний хайрын тухай Паулын заавар
10. 4:13-18 Христ дотор үхсэн нь
11. 5:1-11 Эзэний Өдөр
12. 5:12-22 Хэрэгжүүлэх тушаал
13. 5:23-28 Салах ёс гүйцэтгэсэн нь

Хувийн Судлал: 9-р бүлэг, 2-р хэсэг

Дараах ишлэлүүдэд үндэслэн 2 Тесalonик номыг тоймыг гарга.

1. 1:1-2
2. 1:3-12
3. 2:1-17
 - A. 2:1-12
 - B. 2:13-15
 - C. 2:16-17
4. 3:1-15
 - A. 3:1-5
 - B. 3:6-13
 - C. 3:14-15

З-р хэсэг

Судалгаагаа Улам Бүх Гүнзгийрүүлэх Нь

Эндээс эхлэн бид зүйл зүйлээр нь судалж эхэлнэ. Жишээ болгож 1 Тесалоник номын 1-р бүлгийн эхний 2 зүйлийг харцгаая.

A. Мэндчилгээ ба ерөөл – 1 Тесалоник 1:1

1:1 Паул би болон Силуан, Тимот нар Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христ доторх тесалоникчуудын чуулганд илгээв. Нигүүлсэл ба амар тайван нь та нарт байх болтугай.

Хамгийн эхний энэ ишлэл бидэнд тулгардаг зарим асуултуудад хариулт өгч байна. “Хэн” энэ захиаг бичсэн бэ гэдэг асуултанд Паул, Силуан, Тимот нар бичсэн гэж хариулж байна. Харин захидалын хүлээн авагчид нь Тесалоник дахь чуулганы итгэгчид ажээ. Тэгэхлээр бид захиаг “хэнд” хандаж бичсэнийг мэдэж чадлаа.

Паул чуулганыг Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христ “доторх” гэж бичсэнийг анхаараарай. Энэ нь итгэгчид ба Бурханы хоорондох ойр дотно харилцааг илэрхийлж байна.

Паул мөн тэдний төлөө залбирчээ. Тэр тэдэнд нигүүлсэл ба амар тайван байгаасай гэж хүсчээ.

Биднийг ийнхүү эхлэхэд туслахын тулд 1-р ишлэлд дараах гурван зарчим байгааг ажиглаарай:

1. Бурханы агуу хүмүүс бусад хүмүүс Түүнтэй харилцаа өсөөсэй гэж хүсдэг.
2. Бурханы агуу хүмүүс бусдыг өсөхөд нь урам зориг өгч хамтдаа ажиллаж чаддаг.
3. Бурханы агуу хүмүүс өөрсөддөө байгаа зүйлсээ бусадтай хуваалцахыг хүсдэг.

Судалгаагаа улам бүр гүнзгийрүүлэхийн тулд бид 2-р зүйлд гарч буй ишлэлүүдийг одоо судлах болно.

B. Тэдний жишээнд талархсан нь – 1 Тесалоник 1:2-10

1. Эхлээд энэ 2 дахь зүйлийг хэд хэдэн удаа унш.

1:2 Бид та бүгдийн төлөө Бурханд үргэлж талархал өргөдөг. Ингэхдээ та нарыг залбиралдаа дурсан

1:3 бид өөрсдийн Бурхан ба Эцэгийн өмнө Эзэн Есүс Христэд итгэх та нарын итгэлийн үйл, хайрын хөдөлмөр хийгээд найдварын тууштай байдлыг чинь байнга санадаг.

1:4 Бурханаар хайллагдсан ах дүү нар аа, та нарын сонгогдсоныг бид мэддэг

1:5 Учир нь бидний сайн мэдээ та нарт зөвхөн үгээр очоогүй, мөн хүч ба Ариун Сүнс дотор бүрэн баталгаагаар очсон юм. Тэрчлэн бид та нарын төлөө дунд чинь ямар байсныг та нар мэднэ.

1:6 Бас та нар үлэмж зовлон гамишиг дотор Ариун Сүнсний баяр хөөртэйгөөр үгийг хүлээж аван биднийг болон Эзэнийг дуурайгчид болсон.

1:7 Ингэж та нар Македони болон Ахай дахь бүх итгэгчдэд үлгэр дуурайл болов.

1:8 Учир нь Эзэний үг та нараас гарч зөвхөн Македони болон Ахайд ч сонсогдсон төдийгүй Бурханд итгэсэн та нарын итгэл хaa сайгүй тарсан билээ. Тиймд ямар нэгэн юм ярих хэрэг бидэнд алга.

1:9 Учир нь тэд өөрсдөө та нарын дунд бид хэрхэн орсныг болон амьд бөгөөд үнэн Бурханд үйлчлэхийн тулд та нар хэрхэн шүтээнүүдээсээ эргэж Бурханд хандсан тухай,

1:10 ирэх уур хилэнгээс биднийг гэтэлгэдэг Есүсийг Тэр үхэгсдээс амилуулсан бөгөөд Түүний Хүүг тэнгэрээс ирэхийг хүлээх тухай мэдүүлэв.

2. Ишлэл бүрт нэр өг

1:2 Залбиран талархал өргөсөн нь

Бид та бүгдийн төлөө Бурханд үргэлж талархал өргөдөг. Ингэхдээ та нарыг залбирайдалаа дурсан

1:3 Яагаад талархал өргөсөн бэ? Итгэл, Найдвар, Хайр

бид өөрсдийн Бурхан ба Эцэгийн өмнө Эзэн Есүс Христэд итгэх та нарын итгэлийн үйл, хайрын хөдөлмөр хийгээд найдварын тууштай байдлыг чинь байнга санадаг.

1:4 Бурханаар дуудагдсан дуудлагын дагуу амьдрах нь

Бурханаар хайлрагдсан ах дүү нар аа, та нарын сонгогдсоныг бид мэддэг

1:5 Тэдний сайн мэдээний үндэс угсаа

Учир нь бидний сайн мэдээ та нарт зөвхөн үгээр очоогүй, мөн хүч ба Ариун Сүнс дотор бүрэн баталгаагаар очсон юм. Тэрчлэн бид та нарын төлөө дунд чинь ямар байсныг та нар мэднэ.

1:6 Сайн мэдээний хийсэн өөрчлөлт

Бас та нар үлэмж зовлон гамшиг дотор Ариун Сүнсний баяр хөөртэйгөөр үгийг хүлээж аван биднийг болон Эзэнийг дуурайгчид болсон.

1:7 Өөрчлөлтийн эхний үр дүн бол жишээ болох явдал юм

Ингэж та нар Македони болон Ахай дахь бүх итгэгчдэд үлгэр дуурайл болов.

1:8 Өөрчлөлтийн хоёр дахь үр дүн бол нөлөө юм

Учир нь Эзэний үг та нараас гарч зөвхөн Македони болон Ахайд ч сонсогдсон төдийгүй Бурханд итгэсэн та нарын итгэл хaa сайгүй тарсан билээ. Тиймд ямар нэгэн юм ярих хэрэг бидэнд алга.

1:9 Шүтээнээс эргэх нь өөрчлөлтийн суурь юм

Учир нь тэд өөрсдөө та нарын дунд бид хэрхэн орсныг болон амьд бөгөөд үнэн Бурханд үйлчлэхийн тулд та нар хэрхэн шүтээнүүдээсээ эргэж Бурханд хандсан тухай,

1:10 Бурханлаг амьдралаар амьдрах нь өөрчлөлтийн суурь юм

ирэх уур хилэнгээс биднийг гэтэлгэдэг Есүсийг Тэр үхэгсдээс амилуулсан бөгөөд Түүний Хүүг тэнгэрээс ирэхийг хүлээх тухай мэдүүлэв.

Хувийн Судлал: 9-р бүлэг, 3-р хэсэг

1. 2 Тесalonик номын 1:1-12 ишлэлийг хэд хэдэн удаа унш.

2. Ишлэл бүрт нэр өг.

4-р хэсэг

Хоорондох Уялдааг Нь Гаргаж Ирэх Нь

А. Ямар нэг давтагдан гарч байгаа зүйл бий эсэхийг тэмдэглэ.

1 Тесалоник номын 2 догол мөрний ишлэл бүрийн нэрийг хараад бид давтагдан гарч байгаа зүйлсийг хялбархан олж болно.

- 1:2 Залбиран талархал өргөсөн нь
- 1:3 Яагаад талархал өргөсөн бэ? Итгэл, Найдвар, Хайр
- 1:4 Бурханаар дуудагдсан дуудлагын дагуу амьдрах нь
- 1:5 Тэдний сайн мэдээний үндэс угсаа
- 1:6 Сайн мэдээний хийсэн өөрчлөлт
- 1:7 Өөрчлөлтийн эхний үр дүн бол жишээ болох явдал юм
- 1:8 Өөрчлөлтийн хоёр дахь үр дүн бол нөлөө юм
- 1:9 Шүтээнээс эргэх нь өөрчлөлтийн суурь юм
- 1:10 Бурханлаг амьдралаар амьдрах нь өөрчлөлтийн суурь юм

Бид талархал болон тэдний амьдралыг сайн мэдээ хэрхэн өөрчилсөн тухай зүйлс хэрхэн давтагдан гарч байгааг амархан мэдэж чадлаа.

Б. Ишлэлийг илүү сайн ажигла. Ажиглалтаа тэмдэглэ.

- 1:2 Залбиран талархал өргөсөн нь
Бид та бүгдийн төлөө Бурханд үргэлж талархал өргөдөг. Ингэхдээ та нарыг залбираадаа дурсан

Энэ ишлэлд Паул бидэнд өөрийнхөө юу хийдэг (талархал өргөж байгаа) болон хэрхэн хийж (залбиран) байгаа тухайгаа хэлжээ.

- 1:3 Яагаад талархал өргөсөн бэ? Итгэл, Найдвар, Хайр
бид өөрсдийн Бурхан ба Эцэгийн өмнө Эзэн Есүс Христэд итгэх та нарын итгэлийн үйл, хайрын хөдөлмөр хийгээд найдварын тууштай байдлыг чинь байнга санадаг.

Энэ ишлэлд талархал өргөж байгаа гурван учир шалтгаанаа бичжээ:

1. Тэдний итгэлийн үйл
2. Тэдний хайрын хөдөлмөр
3. Тэдний найдварын тууштай байдал

Тэдний итгэл, найдвар, хайр гурав нь мөн гурван зүйл дээр үндэслэжээ:

1. Тэдний Эзэн Есүс Христтэй харилцах харилцаа
2. Тэдний Эцэгтэй харилцах ойр дотно харилцаа
3. Тэдний Бурханаас ирсэн дуудлага (4-р ишлэл)

- 1:4 Бурханаар дуудагдсан дуудлагын дагуу амьдрах нь
Бурханаар хайрлагдсан ах дүү нар аа, та нарын сонгогдсоныг бид мэддэг
- 1:5 Тэдний сайн мэдээний үндэс угсаа
Учир нь бидний сайн мэдээ та нарт зөвхөн үгээр очоогүй, мөн хүч ба Ариун Сүнс дотор бүрэн баталгаагаар очсон юм. Тэрчлэн бид та нарын төлөө дунд чинь ямар байсныг та нар мэднэ.
Тэдэнд дараах байдлаар ирсэн сайн мэдээг тэд хүлээн авчээ:
1. Үгээр
2. Хүч чадлаар
3. Ариун Сүнсээр
4. Бүрэн баталгаагаар
5. Сайн мөс чанартай хүмүүсээр
- 1:6 Сайн мэдээний хийсэн өөрчлөлт
Бас та нар үзэмж зовлон гамишиг дотор Ариун Сүнсний баяр хөөртэйгөөр үгийг хүлээж аван биднийг болон Эзэнийг дуурайгчид болсон.
Сайн Мэдээ өөрчлөлтийг авчирчээ. Тэдгээр хүмүүс улам бүр төлөвшиж, Паул болон түүний нөхдийг төдийгүй Эзэнийг хүртэл дуурайсан хүмүүс болжээ. Тэд зовлон бэрхшээлийн дунд сайн мэдээг баяр хөөртэйгээр хүлээн авсан байна.
- 1:7 Өөрчлөлтийн эхний үр дүн бол жишээ болох явдал юм
Ингэж та нар Македони болон Ахай дахь бүх итгэгчдэд үлгэр дуурайл болов.
Тесalonикчууд хөрш зэргэлдээ сүмүүдэд үлгэр дуурайлал болсон нь Сайн мэдээний хийсэн өөрчлөлтийн эхний үр дүн юм.
- 1:8 Өөрчлөлтийн хоёр дахь үр дүн бол нөлөө юм
Учир нь Эзэний уг та нараас гарч зөвхөн Македони болон Ахайд ч сонсогдсон төдийгүй Бурханд итгэсэн та нарын итгэл хаа сайгүй тарсан билээ. Тиймд ямар нэгэн юм ярих хэрэг бидэнд алга.
Тэдний итгэл бүр өргөн хүрээгээр тархсан нь хоёр дахь үр дүн юм.
- 1:9 Шүтээнээс эргэх нь өөрчлөлтийн суурь юм
Учир нь тэд өөрсдөө та нарын дунд бид хэрхэн орсныг болон амьд бөгөөд үнэн Бурханд үйлчлэхийн тулд та нар хэрхэн шүтээнүүдээсээ эргэж Бурханд хандсан тухай,
Хүмүүс хиймэл шүтээнүүдээс эргэсэн нь өөрчлөлтийн эхний суурь ажээ.
- 1:10 Бурханлаг амьдралаар амьдрах нь өөрчлөлтийн суурь юм
ирэх уур хилэнгээс биднийг гэтэлгэдэг Есүсийг Тэр үхэгсдээс амилуулсан бөгөөд Түүний Хүүг тэнгэрээс ирэхийг хүлээх тухай мэдүүлэв.
Тесalonикчууд Эзэний дахин ирэлтийг тэсэн ядан хүлээж байгаа нь өөрчлөлтийн хоёр дахь суурь юм.
Эзэн үхлээс амилсан (1) бөгөөд ирэх уур хилэнгээс биднийг чөлөөлөх (2) болно.

В. Илүү дэлгэрэнгүй болгосон тойм дараах байдалтай харагдана:

1. Талархал 2-р ишлэл
2. Яагаад талархал өргөсөн бэ? 3-4-р ишлэл
 - а. Итгэлийн үйл
 - б. Хайрын хөдөлмөр
 - в. Найдварын тууштай байдал
 - 1) Эзэн Есүс Христ дотор
 - 2) Бидний Эцэг Бурханы оршихуйд
 - 3) Тэдний тэнгэрлэг дуудлага
3. Тэд сайн мэдээг хүлээн авсан нь 5-р ишлэл
 - а. Үгээр
 - б. Хүчээр
 - в. Ариун Сүнсээр
 - г. Бүрэн баталгаагаар
 - д. Сайн мөс чанартай хүмүүсээр
4. Сайн мэдээний хийсэн хоёр өөрчлөлт 6-р ишлэл
 - а. Паулын хүмүүсийг болон Эзэн даган дуурайсан
 - б. Зовлон бэрхшээлийн дунд сүнслэг баяр хөөрийг өгсөн
5. Өөрчлөлтийн хоёр үр дүн 7-8-р ишлэл
 - а. Хөрш зэргэлдээ сүмүүдэд үлгэр дуурайл болсон
 - б. Тэдний итгэл өргөн хүрээгээр тархсан
6. Өөрчлөлтийн хоёр суурь 9-10-р ишлэл
 - а. Хиймэл шүтээнүүдээс эргэсэн
 - б. Эзэний дахин ирэлтийг хүлээж байгаа
 - 1) Үхлээс амилсан Нэгэн
 - 2) Ирэх уур хилэнгээс биднийг гэтэлгэдэг Нэгэн

Энэ бүлэгт Паул Тесалоник байдаг сүмийг үнэхээр гайхамшигтайгаар магтан сайшааж байгааг бид тэмдэглэх хэрэгтэй. Үнэндээ тэднийг “үлгэр жишээч” “загвар” болсон чуулган гэж нэрлэж байна. Тиймээс бид “загвар” чуулганд ямар шинж чанар байдгыг эндээс сурч болно.

Хувийн Судлал: 9-р бүлэг, 4-р хэсэг

1. Өөрийнхөө ишлэлийн нэрийг хараад юу давтагдаж байгааг олж хар.
2. Ишлэлүүдийг илүү нарийн ажиглаад, ажигласан зүйлсээ тэмдэглэ.
3. 2 Тесалоник 1:1-12 ишлэлийн дэлгэрэнгүй тоймыг гарга.

5-р хэсэг

Шууд Бус Хам Сэдэвт Задлан Шинжилгээ Хийх

Одоо бид Библийг Библитэй харьцуулан шууд бус хам сэдэвт задлан шинжилгээ хийж болно. Үүнийг хийх хамгийн амархан арга бол өгөгдсөн үг хаана хаана байгааг жагсаан бичсэн конкорданс ашиглах явдал юм. Тэдгээр үг хаана хэрэглэгдснийг хөөн харах нь Библийн бусад хэсэгт буй адилхан сэдэв рүү биднийг хөтлөн аваачдаг.

Конкордансууд хоорондоо харилцан адилгүй байдаг. Аль нэг нь хэрхэн хэрэглэгдэж болохыг олж мэдэх нь шууд бус хам сэдвийг судлах эхний бөгөөд хамгийн чухал алхам болдог. Хамгийн алдартай, хамгийн их тус болох хоёр конкорданс бол Англи хүний Грек Конкорданс, Англи хүний Еврей ба Калдее Конкорданс хоёр юм. Эдгээр конкордансууд Грек болон Еврей үгээр толгойлсон байдаг. Тиймээс КАЛОС буюу “сайн” гэх үтгэй холбоотой бүх үг энэ толгой үгийн дор байх жишээтэй.

Стронгийн бүрэн хэмжээний конкорданс бол хамгийн энгийн бөгөөд бүх үгийг Англи хэлээр жагсаан бичсэн конкорданс юм. Жишээ нь, “сайн” гэх англи үгийг агуулсан бүх ишлэлийг жагсаан бичжээ. Хэдий тийм боловч англи хэлээр “сайн” гэж орчуулагддаг хэд хэдн Грек, Еврей үгс байдаг бөгөөд тэдгээр нь ерөнхийдөө “сайн” гэсэн утгатай ч өөрийн гэсэн өнгө төрх, утга аястай байдаг.

Бид Библи улам бүр нарийвчлан судлахдаа ямар үгийг “сайн” гэж орчуулсныг мэдэх нь хамгийн чухал юм. Энэ зорилгын үүднээс Стронг Библид хэрэглэгдсэн бүх Грек болон Еврей үтнүүдийг дугаарласан байна. Жишээ нь, “Сайн” гэх англи үг орсон бүх ишлэлийг жагсаан бичсэнээс гадна тэнд хэрэглэгдсэн Грек болон Еврей үгийн дугаарыг давхар бичсэн байдаг. (Тухайн Грек болон Еврей үгийг конкордансын арталд лавлах маягаар бичсэн). Дараах байдлаар харагддаг:

САЙН:

Матай 3:10 сайн үр жимс ургуулдаггүй (2570)

Матай 5:45 хорон муу болоод сайн хүмүүс дээр мандуулж (18)

“Сайн” гэдэг үг Матай 3:10-т бичигдсэн (лавлах дугаар 2570) бөгөөд Грекээр КАЛОС гэдэг үг юм. Энэ нь “үгийн сайн,” “төрөлхийн сайн” гэсэн утгатай. Нөгөө талаар Матай 5:45-д “сайн” гэдэг үг хэрэглэгдсэн (лавлах дугаар 18) бөгөөд энэ нь АГАТОС гэдэг Грек үг юм. Үүнийг Грекчүүд “сайн болсон” гэсэн утгаар хэрэглэдэг.

Грек болон Еврей үгийн бүрэн хэмжээний тайлбарыг “Лэксикон” буюу утгын толь бичгийн номноос олж болно. Эдгээр номнуудыг ашиглах нь гүнзгийрүүлсэн Библи судлалд маш их ач холбогдолтой.

Одоо 1 Тесалоник 1:6-р ишлэлд буй “даган дуурайгч” гэдэг үгийг хар. “МИМЭТЭС” гэх Грек үгийг зарим Библийн орчуулгад “даган дуурайгч” гэхийн оронд “дагалдагч” (Хаан Жеймсийн орчуулга) гэж орчуулжээ. Энэ Грек үг нь дуурайх, хөдөлгөөн дуурайх гэсэн утгатай үг бөгөөд Шинэ Гэрээнд 6 удаа хэрэглэгдсэн. Дараах ишлэлүүдэд хэрэглэгдсэн байна:

1 Коринт 4:16 “Тиймээс та нараас гүйя. Намайг дуурайгсад бай.”

1 Коринт 11:1 “Би Христийг дуурайдаг шиг намайг дуурайцгаа.”

Ефес 5:1 “Тиймээс хайрлагдсан хүүхдүүд адил Бурханыг дуурайгчид болцгоо.”

1 Тесалоник 1:6 “Бас та нар үлэмж зовлон гамишиг дотор Ариун Сүнсний баяр хөөртэйгөөр үгийг хүлээж аван биднийг болон Эзэнийг дуурайгчид болсон.”

1 Тесалоник 2:14 “Ах дүү нар аа, та нар Иудей дэх Христ Есүсийн доторх Бурханы чуулгануудыг дуурайгчид болов. Учир нь тэд иудейчүүдээс зовлонг амссан шиг, та нар ч мөн оорийн нутаг нэгт хүмүүсийн гарти адилхан зовлонг эдэлсэн ажээ.”

Еврей 6:12 “хойрго байлгүй, харин итгэл ба тэвчээрээр амлалтуудыг өвлөдөг хүмүүсийг дуурайгсад байцгаа.”

“Дуурайх” гэдэг үг орсон хэд хэдэн ишлэлийг судласны үндсэн дээр бид даган дуурайх тухай сэдвийн шууд бус хам сэдвийн талаар тодорхой ойлголттой болж байна. Хамгийн чухал санаануудыг дараах байдлаар бичиж болно:

- 1 Коринт 4:16-р ишлэлээс бид Паул Коринт чуулганы итгэгчдээс түүнийг даган дуурайхыг хүсчээ. Энэ ишлэлийн хамгийн ойрын хам сэдвээс (14-15-р ишлэл) харвал энэ нь хүүхдүүд аавыгаа дуурайдаг шиг тэд түүнийг тийнхүү дуурайхыг тэр хүсчээ.
- 1 Коринт 11:1-р ишлэлээс бид Паулыг даган дуурайхын тулд тодорхой хэмжээнд хүрсэн байх ёстойг оллоо. Бид түүний гэм болон муу зуршлыг дуурайлгүй (Хэрэв бид Ром 7-р бүлгийг харвал Паул гэм нүгэлтэйгээ хэрхэн тэмцэж байгаа тухайгаа бичсэн байдал), харин Паул хэрхэн Есүс Христийг дуурайсан шиг түүнийг дуурайх хэрэгтэй гэжээ.
- Ефес 5:1-р ишлэлд хүү нь аавыгаа дуурайдаг шиг Бурханыг дуурайх тухай бичжээ.
- Тесалоникийн сүм Паул болон Эзэнийг дуурайсан. 1 Тесалоник 1:6.
- Тесалоникийн сүм зовлон бэрхшээлийг хэрхэн даван туулж байгаагаараа Иудейн сүмүүдийг даган дуурайжээ (1 Тесалоник 2:14). Энэ ишлэл өмнөхтэй адил нэг номд бичигдсэн учир бид хамгийн ойрын хам сэдвийг давхар харах нь зүйтэй.
- Энэ дуурайлалын нэг чухал хэсэг бол үйлчлэл юм. Еврей 6:9-12.

Хэрэв бид эдгээр бүх ишлэлүүдийг хамтатгавал Библии биднийг дараах гурван зүйлийг хийгээсэй хэмээн урамшуулж буйг олж харах болно.

1. Бурханыг, Есүс Христийг, Паулыг даган дуурай.
2. Хэдий зовлон бэрхшээл дунд байсан ч хүү нь аавыгаа дуурайж байгаа мэт даган дуурай.
3. Бусдад үйлчилснээр тэднийг даган дуурай.

Тэгэхээр бид одоо 1 Тесалоник 1:6-р ишлэлд гарч буй даган дуурайх гэдэг үгийн тухай өргөн ойлголттой боллоо. Учир нь бид Библид энэ тухай онцгойлон юу өгүүлдэгийг мэдэж авсан. Паул Тесалоник хотын хүмүүст түүний болон түүний хүмүүсийг даган дуурайхыг хүсэхдээ өөрийнхөө сул дорой, гэм нүглийг (Ром 7-р бүлэгтэй харьцуул) бус харин би Есүс Христийг дуурайдаг шиг гэсэн утгаар хэлжээ.

Хэрэгжүүлэхийн тулд бид Эцэг ба Хүүгийн даган дуурайх хэрэгтэй зарим чанаруудыг мэдэх хэрэгтэй. Жишээлбэл, бид зан чанар ямар чухал болохыг, амлалтаа биелүүлэх нь ямар хэрэгтэй болохыг, эсвэл үнэнээр амьдрах нь яагаад чухал болохыг нэрлэж болно. (Эзэний тухай ярьвал бид төгсөөшгүй олон чанарын тухай ярих боломжтой). Бурханы үгийг улам бүр гүнзгийрүүлэн дэлгэрүүлж ярихдаа бид үргэлж, тогтмол залбирах хэрэгтэй. Бурханы үгийг заах багш нар бид шинэ, төлөвшөөгүй итгэгчдийг теологийн нарийн ширийн зүйлийг ойлгоно гэж бодох ч хэрэгтүй, бас зааж болохгүй (Еврей 5:11-14). Биднийг сонсч буй хүмүүсийн төлөвшлийн түвшинг сайтар мэдэх хэрэгтэй бөгөөд тэдэнд тааруулж үгийг заах хэрэгтэй.

Бид үргэлж эхэлсэн тэр хам сэдэв рүүгээ эргэн орж байх хэрэгтэй. Ингэвэл бид тэр бүлгийн эсвэл зүйлийн гол утгыг орхигдуулахгүй. Тесалоник чуулганы итгэгчид Паулыг болон Эзэнийг дуурайсан. Тэд бусад итгэгчдийн даган дуурайх хэмжээний итгэгчид болсон.

Шууд хам сэдвийг харвал бид загвар болсон чуулган ямар байх ёстойг харж болно. Паул гурван зүйлийн төлөө Тесалоникийн итгэгчдэд талархсан (2-р ишлэл):

1. Тэдний итгэлийн үйл
2. Тэдний хайрын хөдөлмөр
3. Тэдний найдварын тууштай байдал

Шинэ Гэрээнд, ажил (173), итгэл (246), хөдөлмөр (19), хайр (115), тууштай байдал (32), болон найдварын (56) тухай маш их олон зүйлийг өгүүлсэн байдаг. Эдгээрийн сэдвийн аль нэгийг бүтэн 7 хоногийн турш судалж, бас заах боломжтой. Хаалтанд буй тоо бол тэр нэр үг хэд гарч буйг харуулсан тоо юм. Үүнээс гадна эдгээр үгтэй холбоотой маш олон үйл үг бий. Жинхэнэ загвар чуулган гэж ямар чуулган байдгыг ойлгохын тулд эдгээр үг маш их чухал үүрэгтэй.

Хувийн Судлал: 9-р бүлэг, 5-р хэсэг

5, 6-р хэсгүүд хоорондоо холбоотой. Оюутан бүрэн судалгаа хийхэд конкорданс хэрэгтэй. Төлөөлж буй ишлэлүүдийг анхааралтай ажиглаад 2 Тесалоник 1-р бүлгийн ишлэлтэй ямар холбоотой болохыг хар.

6-р хэсэг

Судалгаагаа Өргөжүүлэх Нь

Библийн багш хүн Бурханы үгийг заахаасаа өмнө хэр их гүн гүнзгий судлах нь Ариун Сүнсний удирдлага ба үгийг сонсогчдын хэр их төлөвшөнөөс шалтгаалдаг. Хэдий тийм боловч хувьчилсан Библи судлал Бурханыг илүү гүн гүнзгий судлахад чиглэх хэрэгтэй. Ариун Сүнсний Христэд итгэгчид бид 1 Коринт 2:9-10-т хэлсэнчлэн эдгээр үнэт зүйлсэд хүрэх боломжтой.

Гэвч “Нүдэнд үзэгдээгүй, чихэнд сонсогдоогүй, Хүний санаанд ороогүй юмыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ”¹⁰ Гэвч Бурхан үүнийг Сүнсээр бидэнд илчилсэн юм. Учир нь Сүнс бүх зүйлийг, тэр байтугай Бурханы гүн юмыг ч гэсэн нэвтэлдэг ажгуу.

Энэ чухал санааг хамгийн сайн илэрхийлэх арга бол зүйрлэл ашиглах явдал юм. Тиймээс бид 1 Тесалоник 1:3 ишлэлийг өргөжүүлэхийн тулд гол Грек үг болон түүний тодорхойлолтыг үзнэ. Энэ ишлэлд

бид өөрсдийн Бурхан ба Эцэгийн өмнө (ЭМПРОСТЭН – нүүрний өмнө) Эзэн Есүс Христэд итгэх та нарын (олон тоо) итгэлийн (ПИСТИС – итгэх, үнэмших) үйл (ЭРГОС – бизнес, хэн нэгэнд ажил олгох), хайрын (АГАПЭ – дургүй байсан ч гэсэн зөв зүйлийг үйлдэх) хөдөлмөр (КОПОС – хүнд нөхцөлд ажиллах) хийгээд найдварын (ЭЛПИС - үргэлж найдан хүлээх) түүштэй байдлыг (ХУПОМОНЕ – дор байх, ямар ч нөхцөл байдалд тэвчээртэй байх) чинь байнга (АДИАЛЕЙПО – ямар нэгэн саадгүй) санадаг (МНЕМОНЕУ – санах, дурсах).

Хам сэдвийн зарчим: Хүмүүст яагаад тэдний төлөө бид Бурханд талархдагийг хэл (2-р ишлэлтэй харьцуул).

Гол санаа: Нэгэнт энэ чуулган загвар чуулган (7-р ишлэл), загвар чуулганыг итгэл, найдвар, хайраар нь дүгнэдэг болохыг бид мэдлээ.

A. Зарим ажиглалт

1. Бичсэн хүнээс нь үл шалтгаалан Шинэ Гэрээний бүх захицуудад эдгээр чанаруудын нэг буюу түүнээс олон чанар дандаа байдаг.
2. Энд “үйлстэй итгэл,” “хөдөлмөрлөж буй хайр,” “тэвчээртэй найдвар”-ын тухай өгүүлснийг анзаарапай.
3. Тиймээс эдгээр гурван чанар хоорондоо хамааралтай бөгөөд идэвхитэй шинжийг харуулж байна.
4. Эдгээр бүх чанарууд өсөх боломжтой.
 - a. Итгэл (2 Тесалоник 1:3)
 - b. Найдвар (Ром 15:13)
 - c. Хайр (2 Тесалоник 1:3)
5. **Бурхан биднийг эдгээр чанартай амьдраасай, бусдад харуулаасай гэж өгсөн.**
 - a. Итгэл (Еврей 11:1)
 - b. Найдвар (Ром 8:24)
 - c. Хайр (Ефес 3:16-19)
6. **Хэрэв хэн нэг нь сүнсээр сул дорой, хүйтэн болох үед тэдний үйл явц нурах боломжтой. (Илчлэлт 3:14-20).**
7. **Паул бидэнд эдгээрээс хамгийн агуу нь хайр гэж хэлсэн. Хэрэв танд хайр байхгүй бол юу ч байхгүй. (1 Коринт 13:1-3, 13).**
8. **Хэрэв чуулганд эдгээрээс аль нь ч байхгүй бол Галат чуулган шиг хууль дүрэмд баригдсан, Коринт чуулган шиг эрх мэдлээр хийх гэсэн эсвэл хууль дүрэм ба эрх мэдлээр дүүрэн тийм чуулганолж хувирна.**

Б. Та судалгаагаа өргөжүүлэхийн тулд дараах З зарчимд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

1. Итгэлийн үйл

- a. Итгэлийн үйл гэдэг нь итгэл бидний ажил болсон гэсэн үг. Ингэснээр бидний амьдралын хэв загвар үүн дээр суурилсан.
- b. Грекээр үгчилбэл “итгэлээр үйлдэх” гэсэн үг бөгөөд энэ нь ямар ч нөхцөл байдалд Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр хариу үйлдэнэ гэсэн үг юм.
- c. Зарим хүмүүс “итгэлийн үйл” гэдгийг Есүс Христийн сайн мэдээ тархах гэж үздэг.
- d. “Итгэлийн үйл”-ээр бид аврагдах зөвтгел ирдэггүй (Ром 3:27-28, Галат 2:16)
- e. Үйлс биш харин итгэл нүгэлтнийг зөвтгөдөг (Ром 4:5).
- ë. Үйлсээр аврагдахыг хүсэгч нэг нь Их Эзэн Есүс Христэд тээглэн ойчих болно (Ром 9:32).
- ж. Итгэлтэй агуу удирдагчид өөрсдийгээ дарангуйлагч бус харин хамтран зүтгэгч гэж үздэг (2 Коринт 1:24).
- з. Хүн аврагдаж, итгэлээр зөвтгөгдсөний дараа Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл нь нигуулслийн үйлсийг дагуулдаг (2 Коринт 8:7).
- и. Итгэгч хүн үйлсээр Ариун Сүнсийг хүлээн авдаггүй. Гэвч үйлс бол сүнсээр өссөний үр дунд бий болдог (Галат 3:2-5).
- й. Найдвар байгаа учир сүнслэг хайраар дамжуулан итгэл ажилладаг (Галат 5:5-6).
- к. Гэвч Сatan итгэлийг зогсоож, үүнийг хууль дүрэм гэх мэт хүний бий болгосон зүйлээр солихыг хүсдэг (Галат 5:7, 13).
- л. Бид өөрсөддөө итгэх бус харин бидний дотор ажиллаж буй Бурханд итгэх хэрэгтэй (Колоссай 2:12, Филиппой 2:12-16).
- м. Бусад итгэгчид хүчирхэг итгэлийн үйлстэй хүмүүс байгаасай гэж бид залбирах хэрэгтэй (2 Тесалоник 1:11, Иаков 2:14-16).

Зарчим: Загвар чуулган бол Бурхан тэдиээр дамжуулан ажиллахыг зөвшөөрч, итгэл нь бусдад харагддаг тийм чуулган юм.

2. Хайрын хөдөлмөр

- a. Шинэ Гэрээний зөвхөн энэ хэсэгт эдгээр хоёр үгийг (хайр ба хөдөлмөр) хамтад нь бичсэн.
- b. Хүний амьдралын нэг сайхан зүйл бол ажил хөдөлмөрөөрөө дамжуулан өөрийнхөө хайртай хүнтэйгээ сайхан амьдрах явдал юм (Номлогчийн үгс 9:9).
- v. Хөдөлмөр гэдэг энэ үг бол ядарч, сөхөрч унатлаа хөдөлмөрлөх гэсэн утгатай.
- g. Энэ хөдөлмөр нь бусдын төлөө юм (Иохан 4: 37-38).
- d. Энэ хөдөлмөр нь Бурханы хайрын бизнестэй хамтрах хэрэгтэй (1 Коринт 3:6-9).
- e. Бурхан ажлын төлөө ийнхүү зовж хөдөлмөрлөх нь дэмий хоосон зүйл биш юм (1 Коринт 15:58).
- ë. Өөр хүний хийсэн хөдөлмөрөөр өөртөө гавьяа авах ёсгүй (2 Коринт 10:14-1).
- ж. Хууран мэхлэгч ажилчид их хөдөлмөрлөсөн мэт харагдахыг хүсдэг (2 Коринт 11:23-27).
- з. Бурханы ажилчид шинэ итгэгчдэд ачаа үүрүүлэхгүй тулд шаардлагатай бол сөхөрч унатлаа ажиллахад бэлэн байх ёстой.(1 Тесалоник 2:9, 2 Тесалоник 3:8).
- и. Хэн ч өөрийнхөө ажлыг дэмий хоосон байгаасай гэж хүсдэггүй (1 Тесалоник 3:5).
- й. Хайр угүй хөдөлмөр чуулганыг угүй хийх аюултай (Илчлэлт 2:2-7).
- к. Энэ хайр бол АГАПЭ (Грек) хайр бөгөөд энэ нь дургүй байсан ч гэсэн хамгийн зөв зүйлийг, хамгийн сайнаар хийх гэсэн утгатай.
- л. Тиймээс “хайрын хөдөлмөр” гэдэг бол хүн хэдий дургүй байсан ч гэсэн зөв, сайн гэсэн зүйлийг бусдын төлөө сөхөрч унатлаа үйлдэх гэсэн үг юм.
- м. Энэ хөдөлмөрийн цаана маш чухал зорилго бий.
- н. Энэ нь өөрийн биеийг амьд, ариун тахил болгон өргөж (Ром 12:1), бусдыг өөрсдөөсөө илүү дээр гэж үзэж (Филиппой 2:3), хамгийн агуу хоёр тушаалыг (Марк 12:29-31) биелүүлэх хүсэл тэмүүлэлтэй байна гэсэн үг юм.

Зарчим: Загвар чуулган Бурхан болон бусдын толөө сөхөрч унатлаа хайраар хөдөлмөрлөдөг.

Зарчим: Энэ бол зөвхөн пасторт бус харин бүхэл чуулганы хүмүүст байх ёстой чанар гэдгийг анхаараарай.

3. Найдварын тууштай байдал /тэвчээр/

- a. “Найдварын тууштай байдал” бол ямар ч нөхцөл байдалд найдварын улмаас тэвчээртэй байх гэсэн үг юм.
- b. “Найдвар” гэж орчуулагдсан Грек үг ЭЛПИС нь ирээдүйг итгэл найдвараар хүлээх гэсэн утгатай
- c. Найдварын эх суурь нь Есүс Христэд юм (1 Тимот 1:1).
- d. Христ таны дотор улам бүр төрхөө олбол, төдий чинээ та Түүний алдрын баялгийг харах болно (Колоссай 1:27).
- e. Итгэл, найдвар, хайр гурав нь Есүс Христийн амилалттай шууд холбоотой (1 Петр 1:20-22).
- f. Есүс Христэд бэхлэгдсэн найдвар нь сүнсний ариун байдал руу хөтөлдөг (1 Иохан 3:1-3).
- g. Тэвчээртэйгээр үр жимс ургуулагчид нь сайн мэдээний агуу байдлыг харуулдаг (Лук 8:15)
- h. Сайн үйлийг тэвчээртэйгээр үргэлжлүүлэн хийгчид нь мөнхийн амия бэхжүүлнэ (Ром 2:5-11).
- i. Тэвчээртэй байдал бол найдвар батжих нэг чухал нэгж юм (Ром 5:1-5).
- j. Найдвар бол одоо бий болдог зүйл бус, харин найдан хүлээх тэвчээр юм (Ром 8:23-26).
- k. Бурханы үгээр ирдэг тэвчээр ба урамшуулалт нь найдварыг бататгадаг 2 нэгж юм (Ром 15:4).
- l. Бурхан энэ тэвчээр ба урамшуулалтыг өгдөг бөгөөд Тэрээр энэ нь бидний бие биентэйгээ харилцаа харилцаанд зэрэггээр нөлөөлөөсэй гэж хүсдэг (Ром 15:5-7).
- m. Бурханы хүслийн мэдлэг нь биднийг тэвчээрт сургахад зориулагдсан (Колоссай 1:9-14).
- n. Сүм чуулган тэвчээрийг харуулахад бусад Христийн биеийнхэн үүгээр зоригждог (2 Тесалоник 1:4, 3:5).
- o. Тэвчээр бол Бурханлаг хүний чанар мөн (1 Тимот 6:11-12).
- p. Бид бүгдэд үлгэр жишээч тэвчээртэй хүмүүс хэрэгтэй (2 Тимот 3:10-13).
- q. Наастай хүмүүс тэвчээрийн үлгэр жишээ байх ёстой (Тит 2:2).
- r. Итгэлд үндэслэсэн тэвчээр нь Бурханы амласан бүхнийг хүлээн авахад маш чухал хэрэгтэй (Еврей 10:36-39).
- s. Тэвчээр бол бидний уралдааны нэг хэсэг юм (Еврей 12:1-3).
- t. Тэвчээр бол итгэгчийн төловшилтийг харуулдаг нэгж юм (Иаков 1:2-4).
- u. Тэвчээр бол хамгийн агуу хоёр тушаалыг биелүүлэх нэгж юм (2 Петр 1:5-7).
- v. Тэвчээртэй боловч хайр үгүй чуулган аюултай байдалд байна гэсэн үг (Илчлэлт 2:2-4).
- w. Хайлладаг, итгэдэг, үйлчилдэг, тэвчээртэй боловч бузар мууг зайлцуулдаггүй чуулган мөн адил аюулд байна гэсэн үг (Илчлэлт 2:19-20).
- x. Загалмайг тэвчсэн Есүс Христийн тэвчээр Итгэгчдийг гай гамшгаас зайлцуулах үндэс болдог (Илчлэлт 3:10-11).

Хувийн Судлал: 9-р бүлэг, 6-р хэсэг

Энэ хэсгийг 5-р хэсэгтэй хамтатгасан.

7-р хэсэг

Гол Санааг Гаргах Нь

Бурханы үгийн багшийн хувьд та таныг сонсогчдын ойлгож, санаж байгаагаас илүү их мэдээлэлтэй байх болно. Мэдээж та бусдыг сургаалыг ойлгож, үргэлж санаасай гэж хүснэ. Хэдий хэр их зөв байсан ч гэсэн хэт их олон баримт дурдвал ихэвчлэн хүмүүс самуурч эхэлдэг. Тиймээс сургаалыг энгийн, практик байлгах нь хамгийн сайн юм.

Хамгийн чухал нэг санааг гаргаж ирэхэд анхаарлаа хандуул. Энэ зарчмыг хэрэгжүүлэх нэг арга бол зүйрлэл ашиглах явдал юм. Жишээ нь, хэрэв бид тэрхүү чухал санааг хадаас гэж үзвэл хадаасыг модонд хадаж буй алхны цохилт бүр хадаасыг модонд бүрэн ортол бага багаар хадсаар байх болно. Хүссэн зорилгодоо хүрэхийн тулд зүйрлэл бүр адилхан санааг гаргах хэрэгтэй.

Бид Бурханы үгийг судлахын тулд ямар арга хэрэглэсэнийг анхаараарай. Бид эхлээд том дүр зургыг хардаг. Дараа нь илүү нарийн ширийн зүйлс рүү ордог бөгөөд тэгээд тэр нарийн ширийн зүйлсийг том дүр зурагт хэрхэн тааруулахаа шийддэг.

1 Тесалоник 1:2-р ишлэлд бид Паул итгэлээр өсч буй хүмүүсийн өмнөөс талархал өргөж байгааг уншсан. Үүнээс бид “**Бүх зүйлд талархалаа өргө**” гэсэн сургаал дамжуулж болно. Иймэрхүү сургаал үнэхээр хэрэгтэй. Учир нь төлөвшөөгүй итгэгчид өөрсөддөө анхаарч тэдэнд байгаа зүйлсэд талархахаас илүү, байхгүй зүйлдээ анхаарал хандуулдаг.

Нэгэн удаа Эзэн Есүс 5 талх, 2 загас аваад үүний төлөө Эцэгтээ талархан залбирсан. Хэдийгээр хангалттай хоол хүнс байхгүй байсан боловч ихийг өгөөч гэж гүйлгүй харин байгаа зүйлдээ талархал өргөсөн. Тэгээд гайхамшиг бий болсон.

Бид энэ түүхийг сайн мэдээний 4 номноос уншиж болно (Матай 14:15-21, Марк 6:37-44, Лук 9:13-17, Иохан 6:5-13). Эзэн Есүс Эцгээсээ тэдгээр талх ба загасыг “үржүүлээч” гэж залбирсан тухай эдгээр номны алинд нь ч бичээгүй. Харин сайн мэдээний 4 номны аль алинд нь Есүс талархал өргөсөн. Тиймээс бид сонсогчдийг уриалж ийнхүү асууж болно. “Та ихэнх цагаа талархаж өнгөрүүлдэг үү эсвэл гомдоллож өнгөрүүлдэг үү?” Бид маш жаахан эд хөрөнгөтэй мөртлөө байгаа бүхэндээ Бурханд талархалтай амьдардаг хүмүүсийг жишээ болгон авч болох юм. Энэ сургаалыг сонссон хүмүүс Бурханд талархал өргөх нь яагаад чухал болохыг ойлгоно. Талархах гэдгийг Грекээр ЭУХАРИСТИА гэдэг. Энэ үг нь “ЭУ,” “ХАРИС” гэдэг хоёр үгээс бүтжээ. “ЭУ” гэдэг нь “сайн” гэсэн үг. “ХАРИС” гэдэг нь “нигүүлсэл” гэсэн үг юм. Тиймээс талархал өргөнө гэдэг бол Бурханы нигүүлслийн баялагыг таньж мэднэ гэсэн утгатай. Талархал өргөлгүй амьдардаг хүмүүс нь нигүүлсэлд баярладаггүй хүмүүс ажээ.

Библийг тайлбарлахдаа зүйрлэл ашиглавал маш их тустай. Хамгийн сайн зүйрлэл номноос бус харин амьдралыг ажигласны үндсэнд бий болдог. Сургаал зааж байгаа хүн Брухан түүнд болон түүний эргэн тойронд юу хийж байгааг сайтар ухаардаг хүн байх хэрэгтэй.

Хувийн Судлал: 9-р бүлэг, 7-р хэсэг

2 Тесалоник 1-р бүлгийн хам сэдэвт үндэслэн Эзэн Есүс Христийг алдаршуулахтай холбоотой сэдвээр сургаал бэлд.

Эрхлэн Гаргагчдын Зүгээс

Бид таныг Эзэн Есүс Христтэй хамт цаашид алхаж амьдраасай хэмээн хүсье. Итгэлийн суурь ном таны Библийн мэдлэгт урагшлах нэгэн алхам болж, Эзэн Есүс Христийн нигүүлсэл ба мэдлэг дотор цаашид өссөөр байх болно гэдэгт итгэлтэй байна (2 Петр 3:18). Бид таныг Итгэлийн суурь номоос сурсан зүйлсээ амьдрал, үйлчлэлдээ цаашид хэрэгжүүлээрэй гэж захих байна. Есүс Христтэй хамт алхаж амьдарч, үүнийгээ бусадтай хуваалцаж амьдрахаас илүү чухал зүйл гэж амьдралд байхгүй. Библийн үнэн зөв ойлголтыг авч, Бичигдсэн Үгийг амьдралдаа Амьд Үг болгон хэрэгжүүлэх явц зөвхөн Есүстэй ойр дотно байснаар л гүйцэлдэх боломжтой билээ.

Бурханы Үгийн зөв тайлж, сайн шавь байхад тань хэрэг болох үндсэн гэж үзсэн араг замуудыг Итгэлийн суурь сургалт танд олгохыг зорьсон юм. Та сурсан зүйлээ бусад итгэгчдэд зааж сургаарай. Та үнэнийг даган явахдаа, Сударын үнэнийг, энгийн ойлгомжтой байдлыг нь хуурамч үзэл сургаалаараа гажуудуулах гэсэн хуурамч багш нартай учрах болно гэдгийг мэдээрэй (Филиппой 3:2). Гаж буруу сургаалаас хамгаалагдахын тулд Беройчууд юу үйлдсэн лугаа адил үйлдэж (Үйлс 17:11), чихээр сонсож нүдээр үзсэнээ шалгаж, алив сургаал бүр Библийн утга санаатай нийцэж байгаа эсэхийг нягтлан мэдэх хүртлээ даган хуйларч болохгүй шүү гэдгийг сануулмаар байна.

Та итгэл ба үйлчлэлийн аянаа үргэлжлүүлэх болтугай хэмээн бид залбирч байна. Хорвоо дэлхий уужим бидний хийж буй зүйл заримдаа өчүүхэн жоохон, ач холбогдолгүй мэт санагдах ч, Бурханы мастер төлөвлөгөөнд бидний хийж буй бүхэн Түүний чуулганыг барихад зориулагдсан гэдгийг бүү мартаарай. Христийн Биеийн эрхтэн болохынхoo хувьд, нэгэн үйлчлэлийн багийнхан болохынхoo хувьд Есүсийн захиж үлдээсэн ёсоор бид дагалдаж бэлтгэж, итгэлийн мэдээг гэрчилсээр байх ёстой гэдгээ ухамсарлаж байна. Диваажиннд очсон тэр үедээ бид хамт зэрэгцэн сууж Эзэн Өөрийнхөө алдрын төлөө биднийг хэрэглэсэн тэр л бүхнээр бид хамт баясан цэнгэх болно. Бурхан таныг алив үйлдэл бүрт чинь ивээж адислаж, та ч үргэлжлүүлэн суралцаж, ичих явдалгүйгээр Бурханы сайшаал хүртсэн уран дархан болохоо батлан харуулаарай (2 Тимот 2:15).

Виллэж Министрис Интэрнешнл

VILLAGE MINISTRIES INTERNATIONAL

ХАРИУЛТ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1-р хэсэг

Хувийн Бэлтгэл

1-р бүлэг, 1-р хэсэг

1. Аврагдаагүй байгаа итгэгч бус хүнийг хэлжээ (1 Коринт 15:44, 46). Атаархуу, хувия хичээгч, бардамнагч, худалч хүнийг дурслэхэд энэ үгийг хэрэглэдэг (Иаков 3:14-15). Мөн эцсийн өдрүүд гарч ирэх хуурамч багш нарыг мөн ингэж хэлдэг (Иуда 1:18-19).
2. Бурханы үг нь (1) заахад; (2) зэмлэхэд; (3) залруулахад; (4) зөвт байдал дотор чиглүүлэхэд ашиг тустай. Энэ нь хүн “аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд” юм.
3. Гүйсан хүнд Бурхан өгнө.
4. Бид өөрсдийгөө ичих явдалгүй ажилчин гэж Бурханд сайшаалган харуулахыг хичээх хэрэгтэй. Бидний зорилго бол “үнэний угийг зөв заагч” байх явдал юм.
5. Биднийг училж, цэвэрлэнэ гэсэн.
6. Бурханы хүслийг үйлдэхийг хүсэх ёстой.
7. Бид нигүүсэл дотор итгэлээр алхах ёстой. Өөрөөр хэлбэл, авралыг авах үед бидэнд өгөгдсөн нигүүлсэлд талархаж, бусад эелдэг хандах нь бидний христэч амьдралыг тодорхойлдог. Түүнчлэн, бид өөрсдийн авралын (итгэл) төлөө Бурханд найддаг учраас бидний амьдралыг хангана хэмээн Түүнд мөн итгэдэг.
8. Амар тайван дотор болон толбогүй бөгөөд гэм зэмгүйгээр Түүнд олдохыг хичээх нь бидний зорилго юм. Бидний Эзэн Есүс Христийн (1) нигүүсэл болон (2) мэдлэг дотор өсөх ёстой.
9. (1) Гэрэл дотор алхах (2) өөрсдийн нүглийг хүлээн зөвшөөрөх ёстой.
10. Бидний жинхэнэ дайсан бол Сатан болон түүний хүчнүүд юм. Бид түүнтэй тэмцэхдээ Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсөх ёстой.
11. (1) Бурханы Хүүг мэдэх үнэний мэдлэгт тулгуурлсан итгэлийн нэгдэлд хүрэх (2) Христэч төлөвшөн хүн болох (3) Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд хүрэх.

2-р хэсэг

Библи

1-р бүлэг, 2-р хэсэг

1. Тахил өргөгчдийг төгс болгож (и.1), мөн нүглүүдийг зайлцуулж чадахгүй (и.3)
2. Есүс Христийн бодгалийг илчлэх.
3. (1) Заахад, (2) Зэмлэхэд, (3) Залруулахад, (4) Зөвт байдалд чиглүүлэхэд.
4. (1) Итгэгч хүнийг төлөвшил уруу удирдан хөтгөх (2), тэднийг сайн үйлд бэлтгэх.
5. Судрын талаарх үнэн мэдлэг нь хүнийг Есүс Христийн бодгаль уруу хөтөлнө. Итгэдэг хүмүүст Тэрээр мөнх амийг өгч чадах агаад өгдөг билээ. Судар нь хүнд мөнх амийг өгч чадахгүй.
6. “Гэрээ” гэдэг нь ямар нэг зүйлийг нэг хүн нөгөөдөө санал болгож, харин нөгөөх нь энэхүү саналыг нь хүлээн зөвшөөрч буй зөвшилцөл буюу хэлэлцээр юм. Энэхүү саналд харилцааг зохицуулах амлалтууд багтдаг.
7. (1) Хууль, (2) Түүхийн номууд, (3) Яруу найргийн номууд, (4) Их эш үзүүллэгүүд, (5) Бага эш үзүүллэгүүд
8. Тийм. Энэ нэрийг хүн өгсөн.
9. (1) Түүхийн номууд, (2) Захидлууд (3) Эш үзүүллэгийн ном

3-р хэсэг

Түүхийн Тойм

1-р бүлэг, 3-р хэсэг

1. Одоогийн тэнгэр, газрыг бүтээсэн тухай ба тэдгээрийн сүйрэл, мөн шинэ тэнгэр, газрыг бүтээсэн тухай.
2. Сатаны анхны гэм нүгэл бол “би” гэсэн хувия хичээсэн хүсэл байсан (таван удаа “Би ... болно” гэснийг анзаарна уу) бөгөөд тэрээр эцэстээ галт нуурт хаягдах тавилантай.
3. Дэлхий дахин нэг удаа төгс бүтээгдэх тухай өгүүлдэг.
4. Анхны хүн Адам нүгэл үйлдсэн бол Есүс үйлдээгүй.
5. Бидний жинхэнэ дайсан бол Сатан бөгөөд түүний хүчинүүд юм. Бид түүнтэй тэмцэхдээ “Бурханы бүрэн хуяг дуулга”-ыг өмсөх ёстой.
6. Бүх хүн төрөлхтнийг нэг цагт шүүх тухай.
7. Эхнийх нь шашин шүтлэгээс урвах, удаах нь эдийн засаг.
8. Шинэ тэнгэр ба шинэ газар бүтээгдэх үед.
9. Есүс Христ эхнийхээ ирэлтийн үеэр зовлон эдэлж үхэх байсан. Харин хоёр дахь ирэлтээрээ ТэрӨөрийн дайснуудыг эзлэх болно. Түүний хоёр дахь ирэлт болохын тулд Тэр үхэгсдээс амилуулагдах ёстой байсныг анхаарах хэрэгтэй.
10. Есүс Христ бүгдэд үйлчлэхийн тулд ирсэн. Антихрист өөртөө үйлчилнэ.
11. Бүх үндэстэн дагалдагч болгох.

4-р хэсэг

Түүхэн Он Дарааллын Тойм

1-р бүлэг, 4-р хэсэг

1. Адамын уналт
Ноагийн үер
Абрахамд өгөгдсөн амлалт
Израильчууд Египетээс гарсан
Соломоны хаанчлалын дөрөв дэх жил
Умард хаант улс задран унасан
Өмнөд хаант улс задран унасан
Есүс Христ төрсөн
Есүс Христийн үхэл, оршуулга ба амилалт
Библийн сүүлийн ном
2. Эхлэл ба Иов
3. Египетээс гарсан нь – Левит – Тооллого – Дэд хууль – Иошуа – Шүүгчид – Рут – 1 Самуел – 2 Самуел – Хаадын дээд 1-5 – Дуулал – Шастирын дээд
4. Хаадын дээд 6-22 – Хаадын дэд – Шастирын дэд – Сургаалт үгс – Номлогчийн үгс – Соломоны дуун – Обадиа – Иоел – Иона – Амос – Хосеа – Мика – Исаиа – Нахум – Зефания – Хабаккук
5. Иеремиа – Иеремиагийн гашуудал – Езекиел – Даниел – Езра – Нехемиа – Зехария – Хаггаи – Малахи
6. Матай – Лук – Марк – Иохан – Ййлс
7. Иаков – Галат – 1 Тесалоник – 2 Тесалоник – 1 Коринт – 2 Коринт – Ром – Филемон – Ефес – Колоссай – Филиппой – 1 Тимот – Тит – 2 Тимот – Еврей – 1 Петр – 2 Петр – Иуда – 1 Иохан – 2 Иохан – 3 Иохан – Илчлэлт

5-р хэсэг

Библи Судлах Бэлтгэл

1-р бүлэг, 5-р хэсэг

1. Хэн = Зедекиа, Небухаднезар, түүний цэргүүд
Юу = Небухаднезар Иерусалимыг бүсэлж, хотын хэрмийг сэтэлсэн.
Хэзээ = Зедекиагийн хаанчлалын ес дэх жилийн аравдугаар сард
Хаана = Иерусалим
Яагаад = Эдгээр ишлэлд хариулаагүй, харин өөр хэсэгт хариулсан (40:2-3 ишлэлийг үз)
Хэрхэн = Небухаднезарын цэргүүд Иерусалимыг бүсэлсэн.
2. Бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчээрээ
3. Итгэл ба нэг нэгнээ гэсэн хайр

Хоёр Ба Гуравдугаар Бүлэг

2-3 бүлэгт зориулан өгсөн хариулт байдагтүй, яагаад тэдгээр ишлэлийг дүрслэх, зөв байж болох олон арга зам байдаг.

Дөрөвдүгээр Бүлэг

1-р хэсэг

Нэгдүгээр Дүрэм

4-р бүлэг, 1А хэсэг

1. Оюутнуудын хийх ажил.
2. 1 ба 2-р ишлэлд “Эзэн” гэдэг үг Түүний дээд эрх мэдлийг илтгэж байна. Түүнчлэн 4-р ишлэлд Эзэний сэntий тэнгэрт байна гэсэн нь мөн Түүний дээд эрх мэдлийг илтгэн харуулдаг. 7-р ишлэлд Эзэн бол зөв шударга хэмээн тодорхой хэлсэн. Тэрээр хорон муу хүмүүсийг шийтгэдэг тухай 6-р ишлэлд өгүүлсэн нь Түүний шулуун шударга байдлыг илтгэдэг. 1-р ишлэлд дууллыг бичигч өөрийгөө Эзэн дотор хоргоддог гэснээрээ Түүний хайрын тухай өгүүлжээ. Эзэний сэntий тэнгэрт байгаа тухай өгүүлсэн 4-р ишлэл нь Түүний мөнх амийг харуулдаг. 6-р ишлэлд Эзэн тор буулгах тухай өгүүлсэн нь Түүний бүхнийг чадагч мөн чанарыг илэрхийлдэг. 4-р ишлэлд Эзэн тэнгэрт оршихоос гадна газар дээр хүний хөвгүүдийг ажиглан харж байдаг тухай өгүүлсэн нь Түүний хaa сайгүй оршигч мөн чанарыг харуулдаг. 4 ба 5-р ишлэлд Эзэн хүний хөвгүүдийг (хүн төрөлхтнийг ерөнхийд нь ингэж нэрлэдэг) ажиглан харж, зөв шударга ба хорон муу хүмүүсийг шалгадаг гэсэн нь Тэрээр хүний доторхыг мэддэг гэсэн санааг илэрхийлдэг. Өрөөр хэлбэл, Түүний бүхнийг мэдэгч мөн чанарыг харуулдаг. 7-р ишлэлд “Эзэн зөв шударга” гэсэн нь Түүний хувиршгүй шинж чанарыг илтгэдэг. Эцэст нь, 1-р ишлэлд дууллыг бичигч Эзэн дотор хоргоддог гэснээрээ Түүнийг итгэмжтэй хэмээн итгэж, Түүнд найддагаа хэлж байна.

4-р бүлэг, 1Б хэсэг

1. Есүс Христ бол хүн болсон Бурхан юм.
2. Мосейн Хуулийн дагуу тахил болгон өргөсөн бух, ямааны цус болон шатаалт тахил нь хүний нүглийн асуудлыг шийдэж чадахгүй. Зөвхөн Есүс Христийн тахил л үүнийг хийж чадна. Эдгээр өргөл нь Есүс Христ гэж чухам хэн болохыг харуулсан сүүдэр нь байсан юм.
3. Иона нь харь үндэстнүүдэд (Ниневе нь харь үндэстэн ассиричуудын хот байсан, Иона 1:2) сайн мэдээг хүргүүлэхээр Бурханы илгээсэн нэгэн байсан бол Есүс зөвхөн иудейчүүдэд бус, мөн харь

Үнэдстнүүд уруу илгээсэн сайн мэдээ байсан юм. Иона Христийн адил бусдыг аврахын тулд өөрийгөө зориулсан (Иона 1:12). Иона аварга загасны гэдсэнд гурван өдөр, гурван шөнө байсан бол (Иона 1:17) Есүс булшинд гурван өдөр гурван шөнө болсон. Иона нь Есүс Христийн үйлчлэл, үхэл, оршуулга ба амилалтын дүр зураг юм.

4. Есүс бол Бетлемемд хүн болж төрсөн Бурхан юм. (Израилийг захирах Нэгэн нь “эртнээс хийгээд мөнхөөс үүдэлтэй” хэмээн бидэнд хэлсэн нь мэдээж Бурханы тухай юм; Мика 5:2.)
5. Оршихуйн талхны ширээ нь Есүсийг сүнслэг амьдралын тэтгэгч хэмээн дүрслэн харуулдаг. Лааны шижир алтан суурь нь Есүсийг “дэлхийн гэрэл” гэдгийг харуулдаг.
6. Есүс бол нэг удаа бүх хүн төрөлхтний төлөө Өөрийгөө өргөсөн “Бурханы Хурга” байсан юм.
7. Оюутны хувийн хариулт.

2-р хэсэг

Хоёрдугаар Дүрэм

4-р бүлэг, 2А хэсэг

1. a. Эмэгтэйн үр – Эхлэл 3:15 ба Матай 1:23
b. Абрахамын үр – Эхлэл 12:3 ба Матай 1:1
в. Исаакийн үр – Эхлэл 21:12 ба Матай 1:2
г. Иаковын үр – Эхлэл 35:10-12 ба Матай 1:2
д. Иудагийн үр удам – Эхлэл 49:8-11 ба Матай 1:2
е. Иессийн нахия – Исаиа 11:1 ба Матай 1:5-6
ё. Давидын гэр – 2 Самеул 7:12-16 ба Матай 1:6
ж. Бетлемемд төрсөн – Мика 5:2 ба Матай 2:1
з. Бурхан ба хүн – Дуулал 110:1 ба Иохан 1:1, 14
и. Иммануел гэж нэрлэгдсэн – Исаиа 7:14 ба Матай 1:23
к. Эш үзүүлэгч – Дэд хууль 18:18 ба Иохан 7:40
л. Тахилч – Дуулал 110:4 ба Еврей 5:9-10
м. Шүүгч – Исаиа 33:22 ба Иохан 5:22
н. Хаан – Иеремиа 23:5 ба Илчлэлт 19:16
о. Ариун Сүнсний онцгой тосолгоо – Исаиа 11:2 ба Матай 3:16
о. Бурханы өргөөний төлөөх хичээл зүтгэл – Дуулал 69:9 ба Иохан 2:17
2. Есүс Мессиатай холбоотой эш үзүүлэгүүдийг гүйцэлдүүлсэн.

4-р бүлэг, 2Б хэсэг

1. a. Ром 8:35-39 Бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг юу ч салгаж чадахгүй.
б. Иохан 3:16 Бурханы цорын ганц Хүүд итгэгч хэн бүхэн мөнх амьтай болно.
в. Иохан 3:18 Бурханы цорын ганц Хүүд үл итгэгч хэн бүхэн хэдийнээ яллагдсан.
г. Иохан 3:36 Хүүд итгэдэг хүн мөнх амьтай, харин итгэдэггүй хүн Бурханы уур хилэнтэй нүүр тулна.
д. Ефес 2:8-10 Аврал нь итгэлээр дамжуулан нигүүлслээр ирдэг бөгөөд тэгснээр итгэгч хүн сайн үйлс хийх боломжтой болдог.
е. 1 Иохан 2:1-2 Хэрэв итгэгч хүн нүгэл үйлдвэл бүх дэлхийн төлөө нүглийн өрийг төлсөн Есүс түүнийг өмгөөлөн хамгаална.
ё. Тит 3:5 Бид өөрсдийн сайн үйлсээр аврагдаагүй.
2. Таны хариулт.

4-р бүлэг, 2В хэсэг

1. a. Бурхан Абрахамд үндэстнийг, алдар нэрийг амлаж бусдыг ерөөхийн тулд түүнийг ерөөлийн үндэс болгоно гэж амласан.
б. Абрахамыг ерөөгчдийг ерөөнө гэж Бурхан амласан.

- в. Газар дэлхий дээрх бүх гэр бүлийг ерөөнө гэж амласан.
- 2. а. Төрсөн нутгаа орхин, Бурханы зааж өгөх газар уруу явах.
 - б. Төрөл садангaa орхих.
 - в. Эцгийнхээ гэрийг орхих.
- 3. Түүний эцэг Абрахам Эзэнд дуулгавартай байсан учраас.
- 4. Учир нь тэр Түүнд найдсан (итгэсэн).
- 5. Үгүй
- 6. Үгүй
- 7. Тийм. Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан.

4-р бүлэг, 2Г хэсэг

- 1. а. 15:1-11 Авралын сайн мэдээний гол цөм нь Христийн амилалт юм.
- б. 15:12-19 Христийн бодитоор амилсан нь бидний авралд амин чухал юм.
- в. 15:20-28 Итгэгчдийн амилалт тодорхой дэс дараалалтай явагдана.
- г. 15:29-34 Амилалт нь хувиа хичээх хандлагыг баталгаажуулсан зөвшөөрлийн бичиг биш.
- д. 15:35-49 Амилалтыг байгалийн зүйлсээр тайлбарласан нь.
- е. 15:50-58 Амилалт нь агшин зуурт явагдана.
- 2. (1) Есүс Судрыг гүүцэлдүүлэхийн төлөө үхэж, (2) оршуулагдаж, (3) үхэгсдээс гурав дахь өдөртөө амилуулагдаж (4) шавь нартаа харагдсан гэдэгт итгэх.

4-р бүлэг, 2Д хэсэг

- 1. Хүүд итгэх итгэл
- 2. Хүүд итгэх
- 3. Тийм
- 4. Тэдэнд сонгох чадвар байсан. Өөрөөр хэлбэл, тэдэнд сонгох хийх эрх чөлөө байсан.
- 5. Хүн тухайн тушаалыг дагах эсэхээ шийдэх хэрэгтэй бөгөөд үүгээрээ өөрийн эрх чөлөөг дахин харуулдаг.

4-р бүлэг, 2Е хэсэг

- 1. а. Едений гэрээ
- б. Мосегийн гэрээ
- в. Палестины гэрээ
- 2. а. Адамын гэрээн
- б. Ноагийн гэрээ
- в. Абрахамын гэрээ
- г. Давидын гэрээ
- д. Израильтай байгуулсан Шинэ гэрээ
- е. Чуулгантай байгуулсан Шинэ гэрээ
- 3. Та өөр тодорхойлолтуудыг өгч болох юм.

3-р хэсэг

Гуравдугаар Дүрэм

4-р бүлэг, 3А хэсэг

- 1. Түүний нигүүлсэл
- 2. Итгэл
- 3. Сайн үйлс
- 4. Үгүй
- 5. Үйлддэг. Иохан энд “бид” хэмээн хэлсэн нь өөрийгөө ч бас үүнд оруулж байгааг илэрхийлж байна
- 6. Нүглээ улайх ёстой
- 7. Бурханыг

8. (1) Бурханыг магтах, (2) хуваалцах
9. (1) Өрөвч зүрх, (2) энэрэл, (3) даруу байдал, (4) дөлгөөн зан, (5) тэвчээрийг өмсөх, (6) нэг нэгнээ хүлцэх, (7) бие биеэ уччлах, (8) хайрыг өмсөх, (9) Христийн үгийг зүрх сэтгэлдээ хадгалах, (10) бие биеэ зааж сургах, (11) бие биеэ сэнхрүүлэх, (12) талархлын магтууг дуулах (13) бүгдийг Эзэний нэрээр хийх.
10. Шагнал

4-р бүлэг, 3Б хэсэг

1. Бат зогсож, дахин хуулийн боолчлолд дахин орохгүй байх.
2. Бие биедээ үйлчлэхэд
3. Бүгдийг Бурханы алдрын төлөө хийх
4. Эрх чөлөөг
5. Эрх чөлөөний хууль
6. Эрх чөлөөний хуулиар шүүгдэх гэж буй хүмүүс шиг ярьж, үйлдэх ёстой
7. Бурханы зарц мэт
8. Тэд эрх чөлөөг амладаг боловч өөрсдөө ялзралын боол байdag.
9. Эрх чөлөөг бие биедээ үйлчлэх (Галат 5:13; 1 Петр 2:16) болон бүхнийг Бурханы алдрын төлөө үйлдэхэд (1 Коринт 10:28-31) ашиглах ёстой. Эрх чөлөө нь Арин Сүнснээс ирдэг (2 Коринт 3:17). Эрх чөлөө бол бидний шүүгдэх (Иаков 2:12) тэрхүү хууль (Иаков 1:25) юм. Хуурамч багш нар эрх чөлөөг амлах боловч, тэдний амлаж буй нь худал юм (2 Петр 2:1, 17-19).

4-р бүлэг, 3В хэсэг

1. Есүс Христэд итгэх итгэлээр
2. Итгэлээр дамжуулан нигүүлслээр
3. Сайн үйлс
4. Үйлсгүй итгэл нь ашиггүй (2:20) бөгөөд үхмэл (2:26) юм
5. Үгүй
6. Тийм
7. “Хэн нэгэн” хүн байж болно
8. Үгүй
9. Есүс Христэд итгэх итгэл нь хүнийг Бурханы өмнө “аварч”, бас “зөвтгөдөг.” Христэд итгэх итгэлийн үр дүн болох сайн үйлс нь бусдад илэрхий харагддаг учраас “аврагдсан” хүн ийнхүү хүмүүсийн нүдэн дээр “зөвтгөгдөж”, сайн гэрчлэлийг хүмүүст харуулдаг.

4-р бүлэг, 3Г хэсэг

1. Тийм.
2. Аврал алдагдахгүй.
3. Нүгэл үйлдэгдэс Бурханы хаанчлалыг өвлөхгүй.
4. Тийм.
5. Есүс Христэд өгсөн итгэлийнх нь улмаас итгэгч хүний аврал баталгаатай юм. Итгэгч хүн үйлдсэн сайн үйлсийнхээ төлөө янз бүрийн шагнал авах боломжтой. Хэрэв итгэгч хүн сайн үйлс хийхийн оронд гэм нүгэлтэйгээ зууралдсан хэвээр байх аваас тэрээр өөрийн “өв” буюу “шагнал”-ыг алдах болно.
6. Эзэнийг хайрлах хайрлынхаа улмаас үхэн үхтлээ сорилтыг тэсвэрлэх ёстой.
7. Бурханы хонин сүргийг сайн дураараа, хичээл зүтгэлээр, даруу сэтгэлээр хариулж, өөрсдөд нь даалгасан хүмүүстээ үлгэр дуурайл болох
8. Христийн үзэгдэхийг хүсэх (үүнд Христийн амьдрал ба эргэж ирэх нь багтана)

4-р бүлэг, 3Д хэсэг

1. Хууль
2. Гэр бүлийн удирдагч
3. Тэдний зүрх сэтгэлд бичигдсэн хууль

4. Леви овгийн Аарон ба түүний хөвгүүд
5. Мосгээр дамжуулан Бурханы өгсөн хууль
6. Итгэгч хүмүүс (“Бурханы урьдаас мэдэх мэдлэгийн дагуу, Сүнсний ариусгалаар Есүс Христэд дуулгавартай байхын тулд болон Түүний цусаар цацуулахын тулд сонгогдсон”)
7. Хайрын хууль
8. Леви овгийн Задокийн хөвгүүд
9. Эзэний тогтоосон хууль
10. Тахилын хэлбэр болон тахил өргөх аргаараа ялгаатай.

4-р бүлэг, 3Е хэсэг

1. Эш үзүүллэг илүү тодорхой.
2. Энэ нь хүний өөрийнх нь тайлбараар ирдэггүй.
3. Ариун Сүнс хүнийг хөдөлгөсөн.
4. Мессия (1) ядууст сайн мэдээг дэлгэрүүлж, (2) олзлогдогсодод эрх чөлөөг тунхаглаж, (3) сохруудад хараа оруулан, (4) дарамтад байгсыг чөлөөлөхийн сацуу (5) Эзэний тааламжит жилийг тунхаглааар ирнэ гэсэн Судрын (Исаиа) үгс биелэгдсэн.
5. Тийм
6. Тийм
7. Үгүй
8. Үгүй
9. Үгүй
10. 1 Тесалоник номын эдгээр багцлалд Чуулган Есүс өөд “дээш авагдах” тухай өгүүлдэг. Харин Зехария номд Есүсийн хоёр дахь ирэлт буюу Эзэний хөл энэ дэлхийд тавих тухай өгүүлдэг. Эдгээр нь огт өөр үйл явдал юм.
11. (1) Иудагийн овгийн Арслан, (2) Давидын Үндэс (3) Хураг

4-р хэсэг

Дөрөвдүгээр Дүрэм

4-р бүлэг, 4А хэсэг

1. (1) Гэм зэмгүй, (2) нэг эхнэрийн нөхөр, (3) биеэ барьдаг, (4) хэрсүү, (5) хүндэтгэл хүлээсэн, (6) зочломтгой, (7) заах чадвартай, (8) дарсанд шунахайрдаггүй, (9) зодоонч биш, (10) дөлгөөн, (11) хэрүүлч биш, (12) мөнгөнд дурладаггүй, (13) өөрийн гэрийг сайн захирдаг, (14) бүхий л хүндлэлтэйгээр эрхшээлд хүүхдүүдээ байлгадаг, (15) шинэ итгэгч биш, (16) гадна байгсдаас сайн гэрчлэлтэй байх ёстой
2. Хүмүүс өөр өөрийнхөө хариулах нь тодорхой.

4-р бүлэг, 4Б хэсэг

1. Мэргэн ухаан
2. Бурханы үгэнд хичээл зүтгэлтэйгээр суралцах
3. Харгалзагч хүн гэм зэмгүй байх ёстой.
4. Тийм.
5. Оюутнуудын хувийн хариулт.
6. Оюутнуудын хувийн хариулт.
7. Оюутнуудын хувийн хариулт.

4-р бүлэг, 4В хэсэг

1. Атаархал ба маргаан
2. Махан биеийн үйлс

3. Тэрээр Бурханы үгнээс үнэнийг эрэхийн оронд өөрийн үзэл бодлыг батлах зорилгоор багцлалуудыг ашиглаж болох юм.
4. Өөрсдийнхөө ойлголтод. Яагаад гэвэл, мэдлэг хүнийг ихэрхүү болгодог
5. Тийм
6. Үгүй. Учир нь бид хэсэгхэнийг мэддэг.
7. Тууштай байдал
8. Өөрийгөө шалгах ба нүглээ улайх
9. Мэргэн ухаан
10. Судалж буй багцлалынхаа хам сэдвийг мартахгүйн тулд
11. Библи бүхэлдээ Бурханы Үг мөн
12. Бурханы бодол санаа нь хүнийхээс хамаагүй дээгүүр гэдгийг.
13. Атаархал, хувия хичээсэн зорилго ба бардамнал

Тавдугаар Бүлэг

1-р хэсэг

Гурвал

5-р бүлэг, 1-р хэсэг

1. Ганц
2. Эцэг, Хүү, Ариун Сүнс
3. Эцэг төлөвлөгдөг
4. Эцэгийг биелүүл хэмээн өгсөн ажлуудыг гүйцэтгэдэг
5. Хүүг илчлэх
6. Библийс үзвэл Эцэг, Хүү, Ариун Сүнс тус бүр адил шинж чанаруудтай
7. Тийм
8. Тийм
9. Тийм
10. Тийм
11. Тийм
12. Тийм
13. Тийм
14. Тийм
15. Тийм
16. Тийм

2-р хэсэг

Бурханы Нэрс

5-р бүлэг, 2-р хэсэг

1. a. Бурхан = ЕЛОХИМ (3)
- б. Төгс хүчит Бурхан = ЕЛ ШАДДАЙ (5)
- в. Хамгийн дээд Бурхан = ЕЛ ЕЛИОН (8)
- г. Мөнхийн Бурхан = ЕЛ ОЛАМ (7)
- д. Эзэн = ЯВЭ (9)
- е. Эзэн хангана = ЯАВЭ ИРЭ (10)
- ё. Эзэн бол миний туг далбаа = ЯАВЭ НИССИ (2)
- ж. Эзэн бол амар тайван = ЯАВЭ ШАЛОМ (6)
- з. Түмэн цэргийн Эзэн = ЯАВЭ САББАОТ (1)

- и. Эзэн, Мастер, Эзэмшигч = АДОНАЙ (4)
- 2. а. Бурхан = ТЕОС (3)
 - к. Эзэн = КУРИОС (1)
 - л. Мастер = ДЕСПОТЕС (2)

3-р хэсэг

Бурхан Эцэг (Патерлоги)

5-р бүлэг, 3-р хэсэг

1. Хувьчилсан мөн чанар
2. Хамтын буюу хэсэг бүлэг хүмүүстэй харилцах харилцааг дүрслэн харуулах
3. а. Хамгийн дээд эрх мэдэл: “Эцэгийн алдар”–“Хамгийн дээд Бурхан”–“Бурханы алдар”–“Бурхдын Бурхан”–“Амар тайвны Бурхан”–“Өндөт орших Бурхан”–“Агуу, аймшигт Бурхан”–“Бүх бурхдын дээд агуу Хаан”–“Сүр жавхлангийн Хаан”–“Төгс хүчит Эзэн Бурхан”–“Амар тайван”–“Хамгийн дээд Эзэн”–“Бидний Бурхан Эзэн”–“Сүр жавхлант Алдар”–“Тэнгэр дэх/ дээр байгч Сүр жавхлант Нэгэн”–“Сүр жавхлант Нэгэн”–“Хагийн Дээд Нэгэн”–“Миний дуу”–“Үнэн Бурхан”
 б. Зөвт байдал: “Ариун Нэгэн”–“Хартай, өширхөгч Бурхан”
 в. Шударга ёс: А “Итгэмжит Бурхан...шударга бус явдал үгүй”–Эмээх зохистой Нэгэн”
 г. Хайр: “Итгэмжит Бурхан”–“Энэрэл нигүүлслийн Эцэг”–“Хартай Бурхан” “Хайр”–“Энэрэл хайр”
 д. Мөнх амь: “Эртний Нэгэн”–“Мөнхийн Бурхан”–“Амьдын Бурхан”–“Амьд, үнэн Бурхан”
 е. Омнипотент: “Бүхнийг чадагч”–“Агуу хүчирхэг Бурхан”–“Төгс хүчит Эзэн Бурхан”
 ё. Омнипресент: Хaa сайгүй оршигч
 ж. Омнисиент: “Цорын ганц мэргэн Бурхан”
 з. Өөрчлөгдөшгүй: “Цорын ганц Бурхан”–“Төгс байдал”
 и. Үнэн: “Үнэн Бурхан”
4. а. Эрх мэдэлтэй: “Мөнхийн Хаан”–“Дэлхий дээрх бүх хаанчлалын Бурхан”–“Гай гамшигийг зөвлүүлэгч Бурхан”–“Тэнгэрийн Хаан”–“Эзэн”–“Бүх газар дэлхийн Эзэн”–“Тэнгэр газрын Эзэн”–“Хаадын Эзэн”–“Бидний хууль тогтоогч”–“Тэнгэр газрын Эзэмшигч”
 б. Бүтээгч: “Уран барилгачин”–“Барилгачин”–“Бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурхан”–“Бурхан бол миний Бүтээгч”–“Бүх махан биеийн Бурхан”–“Тэр тэд бүгдийн зүрхийг бүтээсэн”–“Бидний Бүтээгч Эзэн”–“Чамайг Бүтээгч”–“Бүхнийг Бүтээгч”–“Ваарчин”
 в. Өмгөөлөгч ба хамгаалагч: “Сул дорой хамгаалал”–“Эцэггүй хүний Эцэг”–“Нөхөн төлбөрийн Бурхан”–Миний өмнөөс өшөө авагч Бурхан”–“Бэлэвсний шүүгч”–“Бидний бамбай болох Эзэн”–“Миний өмгөөлөгч”–“Миний хоргodoх газар”–“Зовлон шаналтын өдөр миний хоргodoх газар”–“Миний хоргodoх газар ба хүч чадал”–“Ард түмнийхээ хоргodoх газар”–“Шуурганаас хорgodoх газар”–А “Ариун газар”–“Авралын хамгаалалт”–“Дарлагдагсдыг хамгаалах бэхлэлт”–“Бэрх цагийн бэхлэлт”–“зовлон дундах бодит тусламж”
 г. Үлгэр жишээ: “Ариун Аав”–“Тэнгэрт Эзэн”–“Зөвт Аав”
 д. Өгөгч: “Гэрлүүдийн Эцэг”–“Сүнснүүдийн Эцэг”–“Амийн усны ундрага”–“Абрахам, Исаак, Иаковын Бурхан”–“Бүх тайвшралын Бурхан”–“Миний авралын Бурхан”–“Миний хүч чадлын Бурхан”–“Тэвчээр ба урамшууллыг өгөгч Бурхан”–“Есүсийг үхэгсдээс амилуулсан Тэр”–“Чиний нүглийг дурсахгүй Нэгэн”–“Бидний Аврагч”–“Зүрхний минь хүч”
 е. Шүүгч: “Газар дэлхийн шүүгч”–“Цохигч Эзэн”–“Бидний шүүгч”–“Шударга шүүгч”
 ё. Удирдагч: “Миний гэрэл”–“Багш”
 ж. Хайрлагч: “Чиний нөхөр”–“Амьд Эцэг”–“Чиний Аврагч”–“Залбирлыг сонсдог Нэгэн”–“Хайр энэрлээ үзүүлэн, гэрээгээ сахин хадгалдаг Нэгэн”–“Энэрэнгүй ба нигүүлсэнгүй Бурхан”
 з. Бүтээгч ба Хангагч: “Усан үзэм тариалагч”–“Гүйж, бодох бүхнээс минь илүү хэмжээлшгүй бялхлаар үйлдэх чадвартай Түүнд”–“Өршөөлийн Эцэг”–The “Уучлалын Бурхан”–“Миний хүч чадлын Бурхан”–“Бидний Эцэг Бурхан”–“Эцэг Бурхан”–“Өөрийн бодлуудаа хүнд тунхагладаг”–“Эзэн хангана”–“Та нарыг ариусгагч Эзэн”–“Хүч чадал”

- и. Баттай байгч ба Тэтгэгч: “Израилийн алдар”–“Бурхан бол миний хад”–“Найдварын Бурхан”–“Хайр ба амар тайвны Бурхан”–“Бүх махан биеийн сүнснүүдийн Бурхан”–“Хардаг Бурхан”–“Өнчин хүмүүсийн туслагч”–“Тэр та нарыг Тайвшруулагч”–“Та нарын дунд буй Аиун Нэгэн”–“Эзэн миний тут”–“Эзэн миний хад”–“Та нарын эдгээгч Эзэн”–“Миний найдвар”–“Миний тусламж”–“Миний найдвар”–“Миний түшиг тулгуур”–“Бидний орших газар”–“Миний хоргодох хад”–“Миний хүч чадлын хад”–“Бидний авралын хад”–“Халуунаас халхлах сүүдэр”–“Миний авралын хүч”–“Миний сэтгэлийн тэтгэгч”

4-р хэсэг

ХҮҮ Бурхан (Христологи)

5-р бүлэг, 4-р хэсэг

1. Есүс махан биетэй болж төрөхөөсөө өмнө оршин байсан.
2. Мессия бол Бурхан ба хүмүүн хоёулаа мөн.
3. Тэр нүгэл үйлдээгүй.
4. Иессийн удмаас (11:1), онгон эмэгтэйгээс төрөх байсан (7:14) Мессия бол Бурхан мөн бөгөөд хүний талаас харагдах байдал нь сэтгэл татам биш байсан (9:6).
5. a. Бидний төлөө хараал болсон (орлуулалт)
b. Биднийг зольж авсан (нүглийн төлөө үнэ төлсөн)
c. Биднийг Бурхантай эвлэрүүлсэн
d. Тэр Бурханы зөвт, шударга байдлыг тайтргаруулсан.
6. a. Есүс Христ зүгээр унтсан эсвэл ухаан алдсан байгаагүй, харин үнэхээр үхсэн байсан. Түүнийг булшинд оршуулсан бөгөөд Иудейчүүдийн хүсэлтээр харуулаар мануулсан.
b. Түүний бие амилаад, гарч явсан гэдгийг түүний биеийг ороосон байсан маалинган даавуу харуулдаг.
c. Христийг амилсныг харсан олон хүмүүс байсан.
d. Христийн амилалт бол сайн мэдээний гол үндэс юм.
7. Тэр дээш одоод, Эцэгийн баруун гарти заларсан
8. a. Зуучлан залбираач
b. Өмгөөлөгч (өмгөөлөн хамгаалах)
c. Бидний зууч
d. Бидний тэргүүн тахилч
9. Чуулганы тэргүүн
10. Сайн хоньчин (Йохан 10:11), Агуу хоньчин (Еврей 13:20) Ахлах хоньчин (1 Петр 5:4)
11. a. Есүс өмнө нь оршин байсан: “Альфа ба Омега”–“Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч”–“Авралын Зохиогч”–“Эхлэл ба төгсгөл”–“Ереөлт бөгөөд цорын ганц хэмжээлшгүй бүрэн Эрхт”–“Мөнхийн Эцэг”–“Мөнх амь”–“Эхэн ба Эцэс”–“Бүх бүтээлийн Ууган нь”–“Чамайг Бүтээгч”
b. Бурхан-хүний нэгдэл: The “Бурханы бүтээлийн анхдагч”–“Эзэний мөчир”–“Бурханы Христ”–The “Түүний мөн чанарын бодит илэрхийлэл”–“Үл үзэгдэгч Бурханы дүр”–“Иммануел”–“Хүн нь тэнгэрээс”–“Агуу хүчирхэг Бурхан”–“Эцэгтэй хамт Нэгэн”–“Бидний Аврагч болох цорын ганц Бурхн”–“Бидний Бурхан ба Аврагч”–“Түүний алдрын туяа”–“Амьд Бурханы ХҮҮ”–“Хамгийн дээд Бурханы ХҮҮ”
v. Есүсийн төгс байдал: “Амен”–“Ариун агаад зөвт Нэгэн”–“Бурханы Ариун Нэгэн”–“Зүйрлүүлэшгүй бэлэг”–“Алдрын Эзэн”–“Эзэн”–“Бидний алдрын Эзэн”–“Шударга шүүгч”–“Зөвт Нэгэн”–“Бурханы ХҮҮ”–“Жинхэнэ Талх”–“Жинхэнэ гэрэл”–“Жинхэнэ усан үзмийн мод”–“Үнэн”–“Бидний хувьд мэргэн ухаан, зөвт байдал, ариусгал ба золилт болсон Нэгэн”–“Бурханы Үг”
g. Есүсийн төрөлт амьдрал: “Амийн талх”–“сонгогдсон чулуу, үнэт булангийн чулуу”–“Итгэмжит бөгөөд Үнэн”–“Итгэмжит бөгөөд үнэн Гэрч”–“Таны ард түмэн болох Израилийн алдар”–“Өөрийн цорын ганц ХҮҮ”–“Ариун зарц”–“Назарын Есүс”–“Сүүлчийн Адам”–“Амьд Нэгэн”–“Бурхан энэ хүнийг та нарт үзүүлсэн”–“Үй гашууны хүн”–“Назарынх”–“Давидын удам”–

- “Эцэгийн цорын ганц Хүү”–“Давидын удам ба үндэс”–“Гэрчлэл нь өөрийнхөө зохистой цагт өгөгдөв”
- д. Есүсийн үхэл: “анхилуун үнэр”–“Бидний хайлрладаг бөгөөд Өөрийнхөө цусаар биднийг нүглээс минь чөлөөлсөн”–“Авралын эвэр”–“Бурханы Хурга”–“Бидний Дээгүүр өнгөрөх баяр”–“Бүгдийн төлөөх золиос”
- е. Есүсийн амилалт: The “Итгэмжит Гэрч”–The “Үхэгсдээс анх төрсөн нь”–“Нойрсогсдоос анхны Үр жимс мөн”–“Амилалт ба амь”
- ё. Есүсийн дээш одолт, тэнгэрт заларсан нь: “Өмгөөлөгч”–“Бүх газар дэлхийн Бурхан”–“Бүгдийн дээр оршигч Бурхан”–“Сайн Хоньчин”–“Тэргүүн Тахилч”–“Бүхнийг өвлөгч”
- ж. Есүсийн үйлчлэл: “Тослогдсон Нэгэн”–“Элч”–“Бурханы талх”–“Болзоот залуу”–“Гэрэлт үүрийн цолмон”–“Ахлах Хоньчин”–“Өөрийн Эзэн Есүс Христ”–“Бидний найдвар болох Есүс Христ”–“Тэнгэрийн түмэн цэргийн жанжин”–“Израилийн тайтгарал”–“Ард түмний гэрээ”–“Үүд”–“Мөнхийн хад”–“Татвар хураагч болон нүгэлтнүүдийн анд нөхөр”–“Агуу гэрэл”–“Агуу хоньчин”–“Сайн гэрээний батлан даагч”–“Сэтгэлийн чинь харгалзагч”–“Тэргүүн”–“Харь үндэстнүүдийг захирахын тулд босох Түүнд”–“Тэр ариусгагч”–“Тэр оюун санааг хийгээд зүрхийг Нягтлагч”–“Биеийн тэргүүн”–“Чуулганы тэргүүн”–“Бүх удирдлага ба бүх эрх мэдлийн тэргүүн”–“Тэргүүн”–“Израилийн найдвар”–“Амьд, үхсэн бүх хүмүүсийн Шүүгч”–“Хаадын Хаан”–“Үндэстнүүдийн Хаан”–“Амь”–“Амь өгөгч Сүнс”–“Харь үндэстэнд илчлэлтийн гэрэл”–“Амийн гэрэл”–“Хүмүүсийн гэрэл”–“Дэлхий гэрэл”–“Амьд Чулуу”–“Эзэн”–“Эзэн бөгөөд Аврагч Есүс Христ”–“Эздийн Эзэн”–“Амар тайвны Эзэн”–“Ургацын Эзэн”–“Амралтын өдрийн Эзэн”–“Эзэн бол бидний зөв шударга”–“Шинэ гэрээний зууч”–“Өршөөнгүй, итгэмжит Тэргүүн Тахилч”–“Гэрээний элч”–“Мессия”–“Үүрийн цолмон”–“Бидний амь”–“Бидний Эзэн”–“Бидний цорын ганц Эзэгнэгч ба Эзэн”–“Бидний энх тайван”–“Бидний Аврагч”–“Эмч”–“Захирагч ба Аврагч”–“Амийн зохиолч”–“Энхийн Жонон”–“Жононгуудын Жонон”–“Эш үзүүлэгч”–“Бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл”–“Цэвэршүүлэгч”–“Газрын хаадын Захирагч”–“Ертөнцийн Аврагч”–“Хоньчин”–“Сэтгэлийн чинь Хоньчин”–“Ард түмний туг”–“Мөнх авралын эх үндэс”–“Чиний цаг хугацааны бат суурь”–“Чулуу”–“Барилгачдын голсон чулуу”–“Багш”–“Шалгагдсан чулуу”–“Зам”–“Авралын баялаг”–“Мэргэн ухаан”–“Бурханаас ирсэн мэргэн ухаан болсон Нэгэн”–“Хүмүүсийн гэрч”–“Гайхамшигт Зөвлөгч”–“Үг”–“Бурханы үг”–“Чиний нөхөр”–“Чамайг Бүтээгч”–“Чиний Аврагч”

5-р хэсэг

Ариун Сүнс (Пниуматологи)

5-р бүлэг, 5-р хэсэг

1. Оюун ухаан, мэдрэмж, хүсэл
 - a. Ариун Сүнс оюун ухаантай.
 - b. Ариун Сүнс мэдрэмжтэй.
 - c. Ариун Сүнсэнд хүсэл байдаг.
2. a. Хүн төрөлхтнийг бүтээх нь Ариун Сүнсний үүрэг юм.
- б. Хүн төрөлхтөнд илчлэлтийг мэдүүлэх нь Ариун Сүнсний үүрэг юм.
- в. Бидэнд ойлгуулах нь Ариун Сүнсний үүрэг юм.
- г. Судрыг бичихэд онгод оруулах нь Ариун Сүнсний үүрэг юм.
- д. Гайхамшигуудыг үйлдэх нь Ариун Сүнсний үүрэг юм.
- е. Есүс Христ онгон бүсгүйгээс төрөхөд Ариун Сүнс үүрэг гүйцэтгэсэн.
- ё. Гэм нүглийг буруушаах нь Ариун Сүнсний үүрэг юм.
- ж. Хүн аврагдах үед Ариун Сүнс дахин төрүүлдэг (шинэ төрөлт).
- ж. Итгэгч хүнд Ариун Сүнс баптиسم хүртээдэг.
- и. Ариун Сүнс биднийг эдгээдэг.
- й. Ариун Сүнс бидний дотор нутагладаг.
- к. Итгэгч хүмүүсийг Ариун Сүнс дүүргэдэг.
- л. Ариун Сүнс залбирахад чухал үүрэгтэй.

- м. Ариун Сүнс бидэнд өв залгамжлуулдаг.
 - н. Ариун Сүнс бидний төлөө зуучилдаг.
 - о. Ариун Сүнс бидэнд сүнслэг бэлгүүд өгдөг.
 - ө. Ариун Сүнс бидэнд заадаг.
 - п. Ариун Сүнс биднээр үр жимс ургуулдаг.
 - р. Ариун Сүнс биднээс баяр хөөрийг төрүүлдэг.
 - с. Ариун Сүнс итгэгч хүнд хайр хийгээд итгэл найдварыг авчирдаг.
 - т. Ариун Сүнс зөвт байдал, амар тайван хийгээд баяр баясгаланг авчирдаг.
 - ү. Ариун Сүнс итгэл найдвартай байх хүч чадлыг авчирдаг.
 - ү. Ариун Сүнс ариусгалыг үйчлэл хийдэг.
 - ф. Ариун Сүнс итгэгч хүмүүсийн хоорондох нөхөрлөлийг бий болгодог.
3. а. Ариун Сүнсний үүрэг: “Өөр Туслагч”–“Бэлэг”–“Туслагч”–“Барьцаа”–“Амласан”–“Үрчлэлийн Сүнс”–“Христийн Сүнс”–“Зөвлөх ба хүч чадлын Сүнс”–“Итгэлийн Сүнс”–“Нигүүслийн, гүйлтийн Сүнс”–“Өөрийн Хүүгийн Сүнс”–“Шүүлтийн Сүнс”–“Шударга Сүнс”–“Эзэнээс эмээхүй болон мэдлэгийн Сүнс”–“Амийн Сүнс”–“Эзэний Сүнс”–“Үнэний Сүнс”–“Мэргэн ухаан болон ойлголтын Сүнс”–“Мэргэн ухаан хийгээд илчлэлийн Сүнс”–“Төгс хүчит Нэгэний дуу”–“Эзэний дуу”
- б. Ариун Сүнсний бодгаль: “Төгс хүчит Нэгэний амьсгал”–“Шүүлтийн Сүнс ба шатаагч Сүнс”–“Алдын Сүнс”–“Бурханы Сүнс”–“Бурханы Сүнс”–“Ариун байдлын Сүнс”–“Бидний Бурханы Сүнс”–“Амьд Бурханы Сүнс”–“Эзэн Бурханы Сүнс”

Зургаадугаар Бүлэг

1-р хэсэг **Бүтээл (Космологи)**

6-р бүлэг, 1-р хэсэг

1. Бурхан
2. Бурхан үгээрээ харагдахгүй зүйлсээс харагддаг зүйлсийг бүтээсэн.
3. Гэрэл ба Харанхуй–Ишлэл 3-5
Огторгуй–Ишлэл 6-8
Хуурай газар ба далай–Ишлэл 9-10
Ургамал–Ишлэл 11-13
Нар, Cap, Одод–Ишлэл 14-18
Далайн бүтээлүүд, шувууд–Ишлэл 19-23
Газрын бүтээлүүд, Хүн–Ишлэл 24-31
4. Шинэ тэнгэр ба шинэ газар

2-р хэсэг **Тэнгэр Элчүүд (Тэнгэр Элч Судлал)**

6-р бүлэг, 2-р хэсэг

1. а. Оюун ухаан
б. Мэдрэмж
в. Сонгох чадвар
2. Чадна
3. Доод зэрэглэл
4. Эзэн
5. Үгүй

6. Тийм
7. Михаэл
8. Херуб
9. Итгэгч хүмүүст үйлчлэх
10. Бурханы эсэргүүцэгч тэнгэр элч нарын удирдагч
11. Галт нуур
12. Бурханы эсрэг өөрийнхөө хүслийг тавьж, Бурхантай эн зэрэгцэхийг хүссэн
13. Эсэргүүцэгч
14. Худалч
15. Тэр бол хуурамч дүр төрх, мэхлэлтийг илэрхийлдэг
16. Зүсээ хувиргадаг
17. Үл итгэгч хүмүүсийн бодол санааг сохолсон (итгэл байхгүй хүмүүс)
18. Чөтгөр болон бузар сүнс
19. Есүс Христийн тухай мэдээ авчирсан эсэх
20. Сатаны армийн эсрэг

3-р хэсэг

Хүн (Хүн Судлал)

6-р бүлэг, 3-р бүлэг

1. Бурханы
2. Амьд оршигч
3. Хүн ганцаараа байх нь сайн биш.
4. Оюун ухаанаар хийдэг
5. “Сайн мууг мэдүүлэгч мод”-оос огт идэж болохгүй.
6. Үхэл
7. Тэд хоёр Бурхантай уулзахын оронд нуугдсан (3:8, 10). Тэд өөрсдийнхөө нүцгэн байгаагаас ичсэн (3:10). Тэд өөрсдийн гарсан шийдвэрийн төлөө бусдыг буруутгасан (3:12-13). Өс хонzonтой амьдарсан (3:14-15). Эмэгтэй зовлонгойгоор хүүхэд төрүүлэх болно (3:16). Хүнд хүчир ажлыг хийж байж хоолоо идэх боломжтой болно (3:17-19).
8. а. Бие болон сэтгэл
б. Хүмүүний сүнс
в. Зүрх
г. Мөс чанар
д. Оюун ухаан
е. Махан бие
ё. Адамын нүгэлт мөн чанар
ж. Хүсэл

4-р хэсэг

Тэнгэр Элч Нарын Зөрчилдөөн

6-р бүлэг, 4-р хэсэг

1. Өөрийн хүслийг тавих
2. Бурханы хаан ширээний харгалзагч байсан.
3. Диавол болон түүний тэнгэр элч нарт
4. Есүс Христийн 1000 жилийн хаанчлалын дараа
5. Сатан шүүгдсэн.
6. Сатан шийтгэлийг өөрчлөхийг гүйсан.
7. Адам, Ева хоёроос өмнө байсан.

8. Сатаны гуйлт хүсэлтийн эсрэг хийх ямар нэгэн зүйлийг бид хийх ёстай.
9. Бурханы бүрэн хуяг дуулгыг өмсдөг.

Долдугаар Бүлэг

1-р хэсэг

Илчлэлт: Библи (Библиологи)

7-р бүлэг, 1-р хэсэг

1. Түүний үл үзэгдэх чанарууд
2. Далд нууц зүйлийг ил гаргах, үзүүлэх
3. Бурханы Өөрийгөө илчилсэн илчлэлтийг бичүүлэхээр хүмүүсийг босгогч
4. Бидний эрх мэдэл
5. Бидний удирдамж
6. Библи буюу Бичээсийн канон
7. Үнэн
8. Энд заавал хэлэх ёстай тодорхой хариулт байхгүй.

2-р хэсэг

Асуудал: Нүгэл (Хармартологи)

7-р бүлэг, 2-р хэсэг

1. Бурханы хуулийг зөрчих
2. Адамын нүгэл түүний үр удамд дамжсан учир ял шийтгэл нь бүх хүнд ирсэн.
3. Бидний махан биед
4. Махан биеийн үйлс
5. Бодол санаан дахь гэм нүгэл
6. Үг хэлээрээ хийх гэм нүгэл
7. Биеэр үйлдэх гэм нүгэл
8. a. Завхайрал – бодол санаа ба биеэр үйлдэх
б. Бузар байдал – биеэр үйлдэх
в. Тачаангуй байдал - бодол санаа ба биеэр үйлдэх
г. Шүтээн шүтэх - бодол санаа ба биеэр үйлдэх
д. Ид шид - бодол санаа ба биеэр үйлдэх
е. Дайсагнал – бодол санаа
ё. Маргаан – үг хэл
ж. Хардалт – бодол санаа
з. Уур хилэн - бодол санаа ба үг хэл
и. Өрсөлдөөн – бодол санаа
й. Хагарал - бодол санаа, үг хэл ба биеэр үйлдэх
к. Тэрс үзэл санаа – бодол санаа
л. Атаархал – бодол санаа
м. Архидалт – биеэр үйлдэх
н. Утга учиргүй наршиж цэнгэх – биеэр үйлдэх

3-р хэсэг

Шийдэл: Аврал (Сотериологи)

7-р бүлэг, 3-р хэсэг

1. Есүс Христэд итгэх
2. Есүс Христ бол хүн болсон Бурхан бөгөөд бидний гэм нүглийн төлөө нас барж, оршуулагдан, гурав дахь өдөртөө үхлээс амилсан.
3. Хүмүүсийг аврагдаасай, үнэний мэдлэг уруу ирээсэй; хэн ч мөхөлгүй, харин гэмшилд ирээсэй гэж хүсдэг.
4. Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагдсан.
5. Итгэл гэдэг нь найдвар юм. Итгэлийн үнэ цэнэ итгэж байгаа хүндээ бус, харин итгэлд өөрт нь байдаг.
6. Гэмшил гэж нэрлэгддэг оюун бодлоо өөрчлөх үйл явц
7. Христэд итгэх итгэл биднийг зөвтгөдөг, харин Хуулийн үйлс нь үгүй.
8. Ариун Сүнс
9. Бидний гэм нүглийн төлөөсийг төлж, биднийг зольж авсан.
10. Есүс бол Мессия гэсэн Ариун Сүнсний мэдээг эсэргүүцэх. Хүн нас бараахаасаа өмнө хэзээд гэмших боломжтой байдаг тул Есүс Христ бол Аврагч гэдгийг эсэргүүцсэн хэвээр нас барахыг “Ариун Сүнсийг доромжлох” нүгэл гэж бас хэлдэг.

4-р хэсэг

Аюулгүй Байдал: Бурханы Амлалтууд

7-р бүлэг, 4-р хэсэг

1. Тийм
2. Түүний урьдаас мэдэх мэдлэг
3. Тэднийг хэн ч Түүнээс болон Эцгээс булааж чадахгүй.
4. Үгүй
5. Үгүй
6. Тийм. Бид Түүний дайснууд байхад Тэр биднийг аварсан нь Түүний хайрын хамгийн агуу илэрхийлэл болдог.
7. Үгүй.
8. Ял байхгүй.
9. Юу ч салгаж чадахгүй.
10. Үгүй.
11. Бурханаар үрчлэгдсэн хүүхдүүд

5-р хэсэг

Ирээдүй: Эш Үзүүллэг (Эсхатологи)

7-р бүлэг, 5-р хэсэг

1. Тахилчлал ба хууль өөрчлөгддөг.
2. Агаар мандалд
3. Нүд ирмэхийн зуурт
4. Христтэй хамт Түүний Эцэгийн гэрт
5. Зовлонгийн үе
6. Христ буцан ирж, Чидун уулан дээр гишгэх болно.
7. Дээш авагдалтын үед Христ газар дэлхий дээр хөлөөрөө бууж ирэхгүй, харин бидэнтэй агаар мандалд уулзах болно. Хоёр дахь ирэлтийн үед Тэрээр газар дэлхий дээр бууж ирнэ.
8. Араатан ба хуурамч эш үзүүлэгч
9. Сатан

10. Мянган жил
11. Галт нуурт
12. Галт нуурт
13. Бурхан шинэ тэнгэр, шинэ газрыг бүтээх болно.

Наймдугаар Бүлэг

1-р хэсэг

Итгэгч Хүний Хувийн Амьдрал (Ходологи)

8-р бүлэг, 1-р хэсэг

1. a. 1-р үе шат – авралын
б. 2-р үе шат – төлөвших үйл явц
в. 3-р үе шат – мөнх байдал
2. Итгэл
3. Сүнслэг байдал
a. Итгэгч хүний дотор
б. Итгэл
в. Ариун Сүнсийг “томдоох”, “бөхөөх”
4. Боломжтой. Итгэгч хүн гэм нүглээ хүлээн зөвшөөрч, улайх ёстай.
5. Сүнслэг бэлэг
a. Хайр
б. Тэдний зарим нь үгүй болно.
в. “Бие биенээ хайрлах” нь үл итгэгч ертөнцөд Христийг харуулж буй хэрэг юм. Сүнслэг бэлгүүд нь бие биендээ үйлчлэхэд ашиглагддаг. Түр зуурын сүнслэг бэлгүүд нь юун түрүүнд үл итгэгч ертөнцөд Христийг харуулахад болон чуулганыг бие биенээ хайрлаж сурахад хэрэглэгдэж байсан гэдгийг анзаарна уу.
6. Зөвт байдлын
7. a. Нүглээ хүлээн зөвшөөрөх
б. Магтаал
в. Талархал
г. Бүх ариун хүмүүсийн төлөөх гүйлт буюу зуучлан залбирал
д.Өөрийнхөө төлөө залбирах буюу гүйлт
8. Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор өсөх
9. Бурханыг хайрлах, бие биенээ хайрлах
10. Шударга бусаар зовох
11. Сахилгажуулалтаар дамжуулан
12. Тийм
13. Сүнсээрээ, үнэнээр мөргөх
14. Явж, бүх үндэстнийг дагалдагч болгон, тэдэнд баптисм хүргээж, заах.

2-р хэсэг

Христитгэгчдийн Нэгдмэл Амьдрал (Экклесиологи)

8-р бүлэг, 2-р хэсэг

1. Бусдад заах чадвартай хүмүүст зааж сургах
2. Есүс Христийн үгийн жишгээр
3. Заах чадвартай
4. Бурхантай болон бие биентэйгээ нөхөрлөх

5.
 - a. Бие биенээ хайрлах
 - б. Бие биеэ өөрсдөөсөө дээгүүр дээдлэн хүндэл
 - в. Бие биеэ хүлээж ав
 - г. Бие биедээ үйлчил
 - д. Бие биеэ өөрөөсөө дээр гэж үзэх
 - е. Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц.
 - ё. Бие биеэ зоригжуул
 - ж. Бие биеэ уучил
 - з. Нэг нэгнээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд
 - и. Бие биедээ зочлюмтгой бай
 - к. Бие биеэ босгон байгуул
6. Бүхий л хүнд Есүс Христийн Сайн мэдээ болон гэрлийг тараах
7. Бусдад үйлчлэх
8. Итгэлийн нэгдэл
9. Есүс болон Эцэг нэг байдгийн адил тэд бүгдээрээ нэг байх

Есдүгээр Бүлэг

1-7-р хэсэг

Эдгээр хэсгийн хариулт нь тун олон янз байж болох тул бид энд хариуг өгөөгүй болно. Та бүхэн өөрсдөө үүнийг хийж чадахаар болсон байх учиртай.

Номзүй

The following bibliography does not attempt to include all the titles that are pertinent to our course of study, as this would take a book in itself. It does represent the main authorities and the works consulted in the writing of this book.

- Archer, Gleason L., Jr., *A Survey of Old Testament Introduction*, Moody Press, 1964.
- Archer, Gleason L., Jr., *Survey of the Old Testament*, Moody Press, Chicago, 1978.
- Chafer, Lewis Sperry, *Systematic Theology*, Vol. I-VIII, Dallas Seminary Press, 1947
- Dunnett, Walter M., *New Testament Survey*, Evangelical Teacher Training Association, Wheaton, 1967.
- Gaebelein, Frank E., General Editor, *The Expositor's Bible Commentary, New Testament*, Zondervan, Grand Rapids, 1976-1992.
- Geisler, Norman L., *A Popular Survey of the Old Testament*, Baker Book House, Grand Rapids, 1977.
- Harris, R. Laird, Gleason L. Archer, Jr. and Bruce K. Waltke, *Theological Word Book of the Old Testament*, Moody Press, Chicago, 1980.
- Harrison, Roland Kenneth, *Introduction to the Old Testament*, William B. Eerdmans Publishing Co., 1969.
- Hartill, J. Edwin, *Principles of Biblical Hermeneutics*, Zondervan Publishing House, 1947.
- Hiebert, D. Edmond, *An Introduction to the New Testament*, Vol. I-III, Moody Press, 1975.
- Hoehner, Harold W., *Chronological Aspects of the Life of Christ*, Zondervan Publishing House, 1977.
- Jensen, Irving L., *2 Kings with Chronicles, A Self-Study Guide*, Moody Press.
- Machen, J. Greshem, *The New Testament, An Introduction to Its Literature and History*, edited by W. John Cook, The Banner of Truth Trust, Edinburgh, 1976.
- Ramm, Bernard, *Protestant Biblical Interpretation*, Baker Book House, 1970.
- Ryrie, Charles C., *Basic Theology*, Victor Books, 1986.
- Tenney, Merrill C., *New Testament Survey*, William B. Eerdmans Publishing Co., 1961.
- Tenney, Merrill C., *New Testament Times*, William B. Eerdmans Publishing Co., 1965.
- Tenney, Merrill C., General Editor, *The Zondervan Pictorial Encyclopedia of the Bible*, Vol. I-V, Zondervan Publishing House, 1978.
- Thayer, Joseph Henry, *Thayer's Greek-English Lexicon of the New Testament*, Associated Publishers and Authors.
- Thiele, Edwin R., *A Chronology of the Hebrew Kings*, Zondervan Publishing House, 1977.
- Thiessen, Henry Clarence, *Introduction to the New Testament*, Eerdmans, Grand Rapids, 1943.
- Unger, Merrill F., *Introductory Guide to the Old Testament*, Zondervan Publishing House, 1951.
- Vine, W.E., Merrill F. Unger & William White, Editors, *An Expository Dictionary of Biblical Words*, Thomas Nelson, Inc., 1985.
- Walvoord John F., Roy B. Zuck, Editors, *The Bible Knowledge Commentary*, Victor Books, Wheaton, 1983, 1985, electronic media.
- Wilkinson, Bruce and Kenneth Boa, *Talk Thru the Old Testament*, Vol. I, Thomas Nelson Publishers.

Зывэр

- ¹ Adapted from J. Edwin Hartill, *Principles of Biblical Hermeneutics*, p. 9.
- ² Bruce Wilkinson and Kenneth Boa, *Talk Thru the Old Testament*, Vol. I, Thomas Nelson Publishers, 1983, p. 39.
- ³ Some of the ideas for this chart were drawn from *A Popular Survey of the Old Testament*, by Norman L. Geisler, Baker Book House, Grand Rapids, 1977, p. 83 and *Talk Thru The Bible* by Bruce Wilkinson and Kenneth Boa, Thomas Nelson Publishers, Nashville, 1983, p. 47-49.
- ⁴ Wilkinson and Boa, p. 59.
- ⁵ Notes from the *NIV Study Bible*, Zondervan, 1985, electronic version.
- ⁶ Wilkinson and Boa, p. 72.
- ⁷ Charles Caldwell Ryrie, *Ryrie Study Bible, Expanded Edition*, Moody, electronic media.
- ⁸ John F. Walvoord, Roy B. Zuck, Editors, *The Bible Knowledge Commentary*, Victor Books, Wheaton, 1983, 1985, electronic media.
- ⁹ Wilkinson and Boa, p. 84.
- ¹⁰ Irving L. Jensen, *2 Kings with Chronicles, A Self-Study Guide*, Moody, p. 20.
- ¹¹ Charles C. Ryrie, *Ryrie Study Bible, Expanded Edition*, Moody, Chicago, electronic media.
- ¹² Ibid.
- ¹³ Wilkinson and Boa, p. 100.
- ¹⁴ Ibid., p. 101.
- ¹⁵ Ibid., p. 110.
- ¹⁶ Ibid., p. 117.
- ¹⁷ Walvoord/Zuck, electronic media.
- ¹⁸ Wilkinson and Boa, p. 125.
- ¹⁹ Walvoord/Zuck, electronic media.
- ²⁰ Norman L. Geisler, *A Popular Survey of the Old Testament*, Baker, Grand Rapids, 1977, p. 180.
- ²¹ Ibid., p. 181.
- ²² Ryrie, p. 777.
- ²³ Archer, Electronic Edition.
- ²⁴ Ryrie, p. 831.
- ²⁵ Archer, Electronic Media.
- ²⁶ Adapted from Archer's *Survey of the Old Testament*, Electronic Media.
- ²⁷ Charles L. Feinberg, *Class Notes*, Dallas Theological Seminary, p. 3, 1960's.
- ²⁸ Geisler, p. 195-196.
- ²⁹ Wilkinson and Boa, p. 164.
- ³⁰ Geisler, p. 214.
- ³¹ Ryrie, p. 1032.

- ³² R. Laird Harris, L. Archer, Jr. Bruce K. Waltke, *Theological Word Book of the Old Testament*, Vol. 2, p. 544.
- ³³ Carl Laney, *Bibliotheca Sacra*, Oct.-Dec. 1981, p. 315-316.
- ³⁴ Charles C. Ryrie, *The Ryrie Study Bible, Expanded Edition*, Moody Press, 1995, p. 1151.
- ³⁵ Norman L. Geisler, *A Popular Survey of the Old Testament*, Baker, Grand Rapids, 1977, p. 227-228.
- ³⁶ Ibid., p. 228.
- ³⁷ Archer, Electronic Media.
- ³⁸ Wilkinson and Boa, p. 200.
- ³⁹ Adapted from Wilkinson and Boa, p. 209.
- ⁴⁰ Hebrew class at Dallas Theological Seminary taught by Dr. Robert Chisholm, Spring 1993.
- ⁴¹ John F. Walvoord, Roy B. Zuck, Editors, *The Bible Knowledge Commentary*, Victor Books, Wheaton, 1983,1985, electronic media.
- ⁴² Wilkinson and Boa, p. 252.
- ⁴³ Ibid., p. 263.
- ⁴⁴ Gleason Archer, Electronic Media.
- ⁴⁵ Ibid.
- ⁴⁶ Ibid.
- ⁴⁷ Wilkinson and Boa, p. 296.
- ⁴⁸ Charles C. Ryrie, *Ryrie Study Bible, Expanded Edition*, Moody, p. 1498.
- ⁴⁹ J. Greshem Machen, *The New Testament, An Introduction to Its Literature and History*, edited by W. John Cook, The Banner of Truth Trust, Edinburgh, 1976, p. 16.
- ⁵⁰ Merrill C. Tenney, *New Testament Times*, Eerdmans, Grand Rapids, 1965, p. 107-108.
- ⁵¹ Charles C. Ryrie, *Ryrie Study Bible, Expanded Edition*, by, Moody, p. 1500.
- ⁵² Ibid., p. 1498.
- ⁵³ Ibid., p. 1499.
- ⁵⁴ Bruce Wilkinson and Kenneth Boa, *Talk Thru The Bible*, Thomas Nelson, Nashville, 1983, p.
- ⁵⁵ Charles C. Ryrie, *Ryrie Study Bible, Expanded Edition*, Moody, p. 1509.
- ⁵⁶ John F. Walvoord, Roy B. Zuck, editors, *The Bible Knowledge Commentary*, Victor Books, Wheaton, 1983,1985, electronic media.
- ⁵⁷ Walter M. Dunnett, *New Testament Survey*, Evangelical Teacher Training Association, Wheaton, 1967, p. 17.
- ⁵⁸ Ryrie, p. 1574.
- ⁵⁹ Wilkinson/Boa, p. 321.
- ⁶⁰ Ibid., p. 327.
- ⁶¹ Ryrie, p. 1614.
- ⁶² Ibid., p. 1614.
- ⁶³ Wilkinson/Boa, p. 328.
- ⁶⁴ Ibid., p. 328.

- ⁶⁵ Walvoord/Zuck, electronic media.
- ⁶⁶ Ibid.
- ⁶⁷ Wilkinson/Boa, p. 338.
- ⁶⁸ Walvoord/Zuck, electronic media.
- ⁶⁹ Ibid.
- ⁷⁰ Wilkinson/Boa, p. 353.
- ⁷¹ Walter M. Dunnett, *New Testament Survey*, Evangelical Teacher Training Association, Wheaton, 1967, p. 40.
- ⁷² J. Sidlow Baxter, *Explore the Book*, p. 63-64.
- ⁷³ Ryrie, p. 1786.
- ⁷⁴ Wilkinson/Boa, p. 374.
- ⁷⁵ Henry Clarence Thiessen, *Introduction to the New Testament*, Eerdmans, Grand Rapids, 1943, pp. 202-03.
- ⁷⁶ Gaebelein, electronic media.
- ⁷⁷ Walvoord/Zuck, electronic media.
- ⁷⁸ Frank E. Gaebelein, General Editor, *The Expositor's Bible Commentary, New Testament*, Zondervan, Grand Rapids, 1976-1992, electronic media.
- ⁷⁹ Ryrie, p. 1886-1887.
- ⁸⁰ A.T. Robertson, *Paul and the Intellectuals*, Revelation. and ed. W. C. Strickland (Nashville: Broadman, 1959), p. 12.
- ⁸¹ Wilkinson/Boa, p. 413.
- ⁸² Dr. S. Lewis Johnson in *Bibliotheca Sacra, Studies in the Epistle to the Colossians*, beginning Vol. 118, # 471.
- ⁸³ Walvoord/Zuck, electronic media.
- ⁸⁴ Ryrie, p. 1939.
- ⁸⁵ Wilkinson/Boa, p. 444.
- ⁸⁶ Thiessen, p. 271.
- ⁸⁷ Wilkinson/Boa, p. 450.
- ⁸⁸ Walvoord/Zuck, electronic media.
- ⁸⁹ Ryrie, p. 1966.
- ⁹⁰ Wilkinson/Boa, p. 465.
- ⁹¹ Ryrie, p. 1966.
- ⁹² Ron Blue, *The Bible Knowledge Commentary*.
- ⁹³ The NET Bible, The Biblical Studies Press.
- ⁹⁴ Walvoord/Zuck, electronic media.
- ⁹⁵ NIV Study Bible, electronic Library.
- ⁹⁶ NET Bible, electronic media.
- ⁹⁷ Ryrie, p. 2005.
- ⁹⁸ Adapted from R.T. Ketcham, D.D.; found in J. Edwin Hartill's *Principles of Biblical Hermeneutics*.

- ⁹⁹ Charles C. Ryrie, *Basic Theology*, Victor Books, 1986, p. 295.
- ¹⁰⁰ Ibid., p. 343.
- ¹⁰¹ W.E. Vine, *Vine's Expository Dictionary of Biblical Words*, Thomas Nelson Publishers 1985.
- ¹⁰² Harris, Archer, Waltke, *Theological Wordbook of the Old Testament*, 1980, Moody Bible Institute, p. 127.
- ¹⁰³ W.E. Vine, *Vine's Expository Dictionary of Biblical Words*, 1985, Thomas Nelson Publishers, p. 51.
- ¹⁰⁴ Merrill C. Tenney, General Editor, *Zondervan Pictorial Encyclopedia of the Bible*, Zondervan Publishing House, Grand Rapids, Michigan, 1978, Vol. I p. 505.
- ¹⁰⁵ W.E. Vine, *Vine's Expository Dictionary of Biblical Words*, Thomas Nelson Publishers, 1985, p. 685.
- ¹⁰⁶ Ibid.